



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (263)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны долдугаар сарын 12 №26 (263)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

306. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-20-ны хууль) 808

307. Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-6-20-ны хууль) 808

308. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-6-27-ны хууль) 809

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

309. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 31 809

310. Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 33 810

311. Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 34 810

312. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Дугаар 35 810

313. Австри Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Дугаар 36 811

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

314. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 88 811

315. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 89 811

316. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 90 811

317. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 91 812

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

318. Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай Дугаар 89 812

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 21 дүгээрт нийтлэгдсэн Зөвсөгт хүчний тухай хуулийн 16.2-т техникийн алдааны улмаас "сум," гэсэн үг нэмэгдэж хэвлэгдсэн байх тул "сум, дүүргийн" гэснийг "дүүргийн" гэж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 20-ны өдөр — **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараахь агуулгатай 3 дахь заалт, мөн зүйлд 4, 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан."

2/ 28 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

"4. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан үндэслэлээр тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож өөрчлөн тогтоно.

5. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт 1995 оноос хойш нийгмийн даатгалын шимтгэл төлж ажил, хөдөлмөр эрхэлсэн тэтгэвэр авагчид хамаарна."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 20-ны өдөр — **Улаанбаатар хот**

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 22[1] дугаар зүйл:

"**22[1] дугаар зүйл. Соёлын хяналт**

1.Соёлын хяналтыг соёлын улсын хяналтын алба, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2.Соёлын улсын хяналтын алба нь соёлын тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилт болон соёлын байгуулламгын үйл ажиллагаанд хяналт тавина."

2/ 21 дүгээр зүйлийн 9, 10, 11, 12, 13 дахь хэсэг:

"9. Хөгжмийн том хэлбэрийн болон дурслэх урлаг, кино, ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авч байна. Шилдэг бүтээл шагнаруулан худалдан авах журмыг Засгийн газар тогтооно.

10. Монгол улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дараалалын түүхийн талаархи баримтат кино бүтээх зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.

11. Үндэсний уламжлалт, соногдог болон хүүхдэд зориулсан урлагийн бүтээл, улсын захиалгаар бүтээх уран сайхны болон баримтат киноңд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

12. Соёлын байгуулламгын улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэдийн хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөхийг хориглоно.

13. Мэргэжлийн соёл, урлагийн байгуулламгын дэргэдээ судалгаа шинжилгээ, сэргээн засварлалтын газартай байж болно."

3/ 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, номын ярмагт оролцох, онцгой ажилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгоно. Мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар тогтооно."

4/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16, 17 дахь заалт:

"16/ хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох соёл, урлагийн бүтээлийн зэрэглэл, жагсаалт, хэрэгжүүлэх журмыг тогтоох;

17/ Монгол Улсад шинээр хэвлэгдэн гарч байгаа ном, хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёроос доошгүйг шагнаруулалт хийсний үндсэн дээр улс, аймаг, нийслэлийн төв номын санд худалдан авна. Шагнаруулалт хийх, худалдан авах журмыг Засгийн газар тогтооно."

5/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-

250000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаат зогсоох."

2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж харгалзахгүйгээр бүх нийтэд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий төрийн өмчийн байгууллага нь мэргэжлийн соёл, урлагийн төв байгууллагад тооцогдоно."

2/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Улсын болон бүс нутгийн соёлын байгууллагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн соёлын байгууллагыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, ашгийн төлөө соёлын байгууллагыг тухайн нутаг дэвсгэрийн татварын алба улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно."

3/ 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгуулламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар бүхэлд нь ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно."

4/ 23 дугаар зүйлийн 1 дэх заалт:

"1/Соёлын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй соёлын үйл ажиллагаа эрхэлсэн бол иргэнийг 40000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаат зогсоох;"

5/ 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захиргааны хариуцлагыг соёлын хяналтын улсын байцаагч ногдуулна."

3 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "өөр журам тогтоосон" гэснийг "өөрөөр заасан", 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 21 зүйлийн 2 дахь хэсэгт заасан "соёлын тэргүүлэх, төв" гэснийг "улсын" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан "журамт", 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "тэргүүлэх болон төв", 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "төрийн өмчийн" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

"7.2. Импортолсон архи, тамхинд онцгой албан татварын тусгай тэмдэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан зүйл, хэсэг, заалтыг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө."

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.3. Тэмдгийн загвар, тэмдэг олгох журмыг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 31** **Улаанбаатар хот**

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.7.б-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Газрын тухай хуулийн төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд заасан химийн хорт бодис экспортлох, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх журам зөрчсөн, аюултай хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулсны улмаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэх Эрүүгийн хуулиар зохицуулагдсан байх тул уг хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 20–ны өдөр **Дугаар 33** **Улаанбаатар хот**

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул төсөл санаачлагчид нь буцаасугай.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бадам, Н.Болормаа, Ц.Дашдорж, Д.Дондог нараас 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 20–ны өдөр **Дугаар 34** **Улаанбаатар хот**

Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бадам, Н.Болормаа, Ц.Дашдорж, Д.Дондог нараас 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул төсөл санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 27–ны өдөр **Дугаар 35** **Улаанбаатар хот**

Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн орлогыг 352.746.879.0 мянган төгрөгөөр, зарлагыг 415.402.202.1 мянган төгрөгөөр батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

Австри Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: тогтоосугай.

Австри Улсын нийслэл Вена хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 6 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 88 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Ирланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэдэнжавын Сүхбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Ирланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Далрайн Даваасамбуу томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 6 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дагвын Цахилгааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандагвын Амарсанаат томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 90 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Готовдоржийн Луузанг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандоржийн Даваагивийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр — Дугаар 91 — Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Исланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэдэнжавын Сүхбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Исланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Далрайн Дааасамбуугийн Томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 8-ны өдөр — Дугаар 89 — Улаанбаатар хот

Сумын эмнэлгийн хөгжлийн Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сумын эмнэлгийн хөгжлийн Хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хөтөлберт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгах, тодорхой хэсгийг гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг, Сангийн сайд Ч.Улаан, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 11 сарын 15-ны дотор Парламентад Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ГАДААД ХЭРГИЙН САЙД — Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД — П.НЯМДАВАА

Засгийн газрын 2002 оны 89 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

СУМЫН ЭМНЭЛГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Сумын эмнэлгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хөтөлбөр боловсруулах үндэслэл

Сумдын эмнэлгээс хөдөөгийн хүн амд үзүүлж байгаа нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах асуудал нь эрүүл мэндийн салбарын тулгуур зорилтуудын нэг юм.

Манай улсын нийт эмнэлгийн орны 27,7 хувь, хэвтэн эмчлүүлэгчдийн 32,1 хувь нь тус ту сумын эмнэлэгт ногдож, нийт эхүүдийн 39,4 хув нь сумын эмнэлэгт хүүхдээ төрүүлж байна.

Хүн амын өвчлөлийн төрүүлэх тава шалтгаант өвчин хөдөөгийн хүн амын дунд жил бү нэмэгдэж /хүснэгт 1/, сүүлийн 3 жилд нас барса эхүүдийн 40,5 хувь нь сум, багт энджээ. Энэ н сум, багийн түвшинд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа харуулж байна.

Хүснэгт 1

Хүн амын өвчлөлийн байдал

Үзүүлэлт /дундаж/	Улс		Хот		Аймаг, сум	
	1996	2000	1996	2000	1996	2000
Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан /10000 хүн амд/						
Амьсгалын тогтолцооны өвчин	827.21	791.12	547.73	593.06	929.25	886.53
Хоол шингэзх эрхтний өвчин	399.28	553.61	296.52	530.96	436.80	564.52
Шээс, бэлгийн тогтолцооны өвчин	284.90	516.23	184.13	387.40	321.69	578.29
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	240.34	358.11	108.59	336.46	288.43	368.53
Бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар		274.55		632.47		102.12

Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт, 1996, 2000 он

Энэ байдалд дараахь шалтгаан, хүчин зүйлүүд нөлөөлж байна:

1. Сумын эмнэлгийн барилга, дулаан, цахилгаан, усан хангамж эрүүл ахуйн наац захын шаардлага хангахгүй байна

Сумын эмнэлгийн 370 орчим барилга байгууламжийн ашиглалтын байдалд холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас хийсэн үзлэгийн /2001 он/ дүнгээс үзэхэд ихэнх эмнэлгүүд чанар муутай баригдсан, засвар хийлгүй удсанаас эвдэрч, хуучирсан байранд, 109 эмнэлэг зориулалтын бус байранд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Сумдын эмнэлгийн 83,6 хувь нь гар хийцийн нам даралтат зуухаар эмнэлгийн барилгаа халааж, 80 хувь нь сумын дизель цахилгаан станцаас хязгаартай гэрэлтүүлэг авч, нийт эмнэлэг үйлчилгээндээ зөөврийн ус хэрэглэж, цэвэр, бохир усны системгүй ажиллаж байна.

2. Сумын эмнэлэг зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эм хэрэгслээр дутмаг байна

Сүүлийн 10 жилд сумдын эмнэлгийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажил үндсэндээ орхигдож, өнөө нь хэрэглэгдэж байсан тоног төхөөрөмжүүд хуучирч ашиглагдах болсноос нийт сумдын эмнэлгийн 92,5 хувь нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай багаж, тоног, төхөөрөмжөөр дутагдаж байна. Харин энэ хугацаанд зарим гадаад орон, олон улсын байгууллагуудын тусламжтайгаар эх барихын иж бүрдэл, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр ихэнх сумдын эмнэлгүүдийг хангах арга хэмжээ авсан юм.

Сумын эмнэлгийн түвшний эмчилгээнд 174 нэр төрлийн нэн шаардлагатай эм хэрэглэгддэг бөгөөд эдгээрийн хангамж дунджаар 30-70 хувьтай байгаа, эмийн сангийн үйлчилгээ хөдөөгийн иргэдэд хүргэх тогтолцоо алдагдсан зэргээс шалтгаалан хөдөөгийн иргэдийг чанарын баталгаатай, боломжийн үнэтэй эмээр хүртээмжтэй хангах явдал тогтворжиж чадаагүй байна.

Мөн шаардлагатай эм, тарианы үнийг орон нутгийн иргэд хувиасаа гаргах, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан ч хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлж чадахгүй байх явдал гарсаар байна.

3. Сумын эмнэлгийн боловсон хүчний хангамж хүрэлцээгүй, тэдний чадавхи нь сул байна

Сумын эмнэлэгт эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний хангамж дутагдалтай хэвээр байна / Хүснэгт 2/. Хөдөөгийн эмч, мэргэжилтнүүд төгсөлтийн дараахь сургалтад хамрагдах, шинэ мэдээлэл авах боломж хязгаарлагдмал, амьдралд нь хүрэлцэхүйц цалин хөлс, нийгмийн баталгаагаар хангагдаагүй байгаа нь тэдний тогтвор суурьшилтай ажиллах, хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны чанартай, хүртээмжтэй тусламж үзүүлэх үйл ажиллагаанд нь сергөөр нөлөөлж байна.

Хүснэгт 2

Хот, хөдөөгийн эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтын байдал

Эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо /10000 хүн амд/			
Мэргэжилтэн	Улс	Хот	Хөдөө
-Их эмч	27.3	47.6	17.5
-Бага эмч	10.4	5.9	12.5
-Сувилагч	31.1	42.3	25.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт, 2000 он

4. Сумын эмнэлгийн санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй,
төсөв хүрэлцэхгүй байх явдал гарсаар байна

Сумын эмнэлгийн санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй, төсөв нь хүрэлцэхгүйн улмаас нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, өвчтөнийг стандартын дагуу эмчлэх, эмч, ажилтангсдын цалинг хугацаанд нь олгоход байнга бэрхшээл учирч байгаа нь зарим тохиолдолд өвчтөний ар гэрээс эм авруулах, түргэн тусламжийн дуудлагын машины бензинийг ард иргэдээс гаргуулах зэрэг зохисгүй байдал даамжрах, эмнэлэг, эм хангамжийн байгууллагын хоорондын эмийн өр төлбөр нэмэгдэхэд хүргэж байна.

Сумын нэг иргэнд ногдох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нормативт зардлаар тооцсон санхүүжилт хугацаандаа бүрэн хийгдэхгүй байгаагаас сумын эмнэлгийн санхүүжилтэд үлсын хэмжээгээр 2001 оны эцэлээгдэж буй гүйцэтгэлээр 10,0 тэрбум төгрөг зарцуулсан нь эрүүл мэндийн салбарын нийт зардлын 21 хувийг эзэлж байна.

Орсн нутгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, мэргэжлийн удирдлагыг чадавхижуулах, орон нутгийн удирдах байгууллагын зохицуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр чанхаарах асуудлууд байсаар байна.

Энэ бүхнийг харгалзан, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр" боловсруулж, тэдгээрийг зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр ханган, эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, тогтвөр суурьшилтай ажилпах нөхцөл хөшүүргийг бий болгох замаар хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна гэж заасныг хэрэгжүүлэх, 2000 онд батлагдсан "Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа"-ны MNS 5082 стандартын түвшинд хүрч ажилпах нөхцөлийг сумдад бий болгох, хот, хөдөөгийн эмнэлгийн байгууллагын эмч, мэргэжилтний хангамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын ялгааг арилгах боломж бүрдүүлэхэд тус дэхөм үзүүлэх зорилгоор Засгийн газраас энэхүү хөтөлбөрийг батлан гаргаж байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго,зорилт, хүлээгдэж байгаа
үр дүн, хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хугацаа

2.1. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлэх замаар хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний түвшинг дээшлүүлэх, хүртээмж, чанарыг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. НЭГДҮГЭЭР ЗОРИЛТ:

Сумын эмнэлгийн дэд бүтцийг сайжруулж, санхүүжилтийг оновчтой болгосноор сумын эмнэлгүүд хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах.

2.3. ХҮРЭХ ҮР ДҮН

2.3.1. Сумын эмнэлгийн 82 барилгыг стандартын шаардлагын дагуу шинээр барьж, 346 барилгад их засвар хийж, 285 сумын эмнэлгийн халаалтын төхөөрөмжийг шинэчлэн, шинээр баригдах барилгыг бохир, цэвэр усны системтэй болгосон байна.

2.3.2. Сумын эмнэлгийн 70 хувийг нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаснаар сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартад хүргэсэн байна.

2.3.3. Эмнэлгийн түргэн тусламжийн машины парк шинэчлэлтийг жил бүр 33.3 хувьд хүргэж хийснээр хөдөөгийн хүн амд эмнэлгийн яаралтай тусламжийг хүртээмжтэй, хугацаа алдахгүй үзүүлэх боломж бүрдүүлсэн байна.

2.3.4. Сумын эмнэлгийн санхүүжилтийг нэг хүнд тооцсон норматив зардлаар тогтоосон хэмжээгээр, хугацаанд нь олгосноор чанартай, хүртээмжтэй эмчилгээ, үйлчилгээг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөл бүрдсэн байна.

2.3.5. Сум бүр "Эмийн эргэлтийн сан"-тай болсон байна.

2.4. ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ АРГА ХЭМЖЭЭ:

2.4.1. Хөтөлбөрийн хүрээнд сумын эмнэлгийн 82 барилгыг шинээр барих, бохир, цэвэр усны системтэй болгох, 346 барилгад их засвар хийх, 285 эмнэлгийн халаалтын төхөөрөмжийг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төвөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

2.4.2. Багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг сумын эмнэлгийн 70 хувьд хийх.

2.4.3. Хөтөлберт заасны дагуу сумын эмнэлгийн түргэн тусламжийн машины парк шинэчлэлтийг 2002-2008 онд зохион байгуулах.

2.4.4. Багийн бага эмчийг уналгаар хангах.

2.4.5. "Эмийн эргэлтийн сан"-г 2002 онд 3 аймагт, 2003 онд 3 аймагт тус тус байгуулах арга хэмжээ авах.

2.4.6. Сумын эмнэлгийн санхүүжилтийг нэг хүнд ногдох норматив зардлаар тооцож хугацаанд нь олгох асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

2.5. ХОЁРДУГААР ЗОРИЛТ:

Сумын эмнэлгийг эмч, мэргэжилтнээр бүрэн хангах, тэдний тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар боловсон хүчний хангамжийг сайжруулж, эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

2.6. ХҮРЭХ ҮР ДҮН:

2.6.1. Их эмчүй болон эмч дутагдалтай сумын эмнэлгийг эмч, дунд мэргэжилтнээр үе шаттайгаар хангасан байна.

2.6.2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эмч, мэргэжилтний мэдлэг чадавхийг тасралтгүй дээшлүүлж, алслагдсан хөдөө орон нутаг, говийн бүс, хүнд нөхцөлд ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн давтан сургалтын тогтолцоог боловсронгуй болгож шийдвэрлэсэн байна.

2.6.3. Эрүүл мэндийн суурь тусламжийн багц тодорхойлогдож, түүний дагуу тусламж үзүүлэх, санхүүжүүлэх стандарт мөрдөгдөж эхэлнэ.

2.6.4. Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын болон суурь тусламжийн сургалтад нийт сумын эмч, дунд мэргэжилтнийг үе шаттайгаар хамруулсан байна.

2.6.5. Бүх сумын эмнэлгийг шаардлагатай мэдээлэл хүргэх тогтолцоог сайжруулах арга хэмжээ авсан байна.

2.6.6. Аймаг,сумын удирдлагууд болон сумын эмнэлгийн эрхлэгч эмч нарын 80 хувийг эрүүл мэндийн менежментийн сургалтад хамруулсан байна.

2.6.7. Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламжийн чанар сайжирч, эх, нялхсын өвчлөл, эндэгдэл буурч,эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт хөдөөд сайжирсан байна.

2.7. ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ АРГА ХЭМЖЭЭ:

2.7.1. Бүх сумын эмнэлгийг их эмчээр бүрэн хангах.

2.7.2. Сумын эмнэлгийн хүний нөөцийн хангамж, байршил, хуваарилалтыг сайжруулах арга хэмжээ авах.

2.7.3. Сумын эмнэлгийн эмч, ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар холбогдох яамтай хамтран санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх.

2.7.4. Сумын эмнэлгийн эмч, дунд мэргэжилтний төгсөлтийн дараахь болон ажлын байран дахь сургалтыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд түшиглэн зохион байгуулах.

2.7.5. Сумын эмнэлгийг сар тутам шаардлагатай мэдээллээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.8. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөрийг 2002- 2008 онд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа

3.1. Төрийн захиргааны төв байгууллага:

3.1.1.Эрүүл мэндийн яам

3.1.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах.

3.1.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагч орон, хөгжлийн банк, төрийн ба төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоо, тусламж, дэмжлэгийг чиглүүлэх үйл ажиллагааг зохицуулах.

3.1.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг "Ядуурлыг бууруулах, өсөлтийн хангах", "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих", "Хүний аюулгүй байдлыг хангах сайн саглал" зэрэг бусад Үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах арга хэмжээ авах.

3.1.1.4. Төсөвт зардал, бусад санхүүгийн эх үүсвэр, зээлийн хөрөнгийг үр ашигтай хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, хэрэгжилтийн үр дүнг тайлагнах.

3.1.2. Санхүү, эдийн засгийн яам

3.1.2.1. Эрүүл мэндийн яамнаас боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн захиалга, тооцоо үндэслэлийг хянаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төлөрсөн төсөөг тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авах.

3.1.2.2. Хөтөлбөрийн санхүүгийн нөөцийг бий болгох олон улсын байгууллагын болон гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг олох талаар Эрүүл мэндийн яаманд дэмжлэг үзүүлэх.

3.1.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

3.1.3.1. Эмч, мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтыг зохион байгуулахад Эрүүл мэндийн яаманд мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.

3.1.3.2. Эрүүл мэндийн салбарт Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

3.1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

3.1.4.1. Сумын эмнэлгийн эмч, ажиллагсдын мэргэжлийн онцлог, ахуйн болон ажлын нөхцөлд нийцүүлэн тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалин, хөлсний тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар холбогдох яамдтай хамтран санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

3.2. Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга:

3.2.1. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд удирдлага, зохицуулалтаар хангах, биелэлтэд хяналт тавих, үр дүнг жил бүр тайлагнах, хэрэгжилтийн явцыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж байх.

3.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөөес хуваарилах, бусад хөрөнгийн эх үүсвэрийг олох талаар санаачилга гаргаж ажилах.

3.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөөт тусгах.

3.2.4. Орон нутгийн төсөөт сумын эмнэлгийн санхүүжилтийн тооцоог, үндэслэлийг бодитой тусгаж, хугацаанд нь бүрэн олгох, сумын эмнэлэгт эмийн болон бусад ер төлбөр үүсэхгүй байхуйцаар санхүүгийн үйл ажиллагаа нь хэвийн явагдах нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авах.

3.2.5. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд орон нутгийн холбогдох байгууллагууд, нутгийн зөвлөл, иргэд, хамт олны оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдүүлэхэд чиглэсэн удирдлага, зохицуулалтаар ханган.

3.2.6. Хөтөлбөрийг сурталчилах, олон нийтийн оролцоог дэмжин урамшуулах, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах.

3.2.7. Сумын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх, орон сууцаар ханган арга хэмжээ авах.

3.2.8. Багийн бага эмчийг уналгаар ханган.

3.2.9. Эмийн эргэлтийн сан байгуулах хөрөнгийн тодорхой хэсгийг орон нутгаас гаргах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3.3. Төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоо:

Сумын эмнэлэгт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх, эхүүдийн төрөхийн өмнөх амрах байрыг засч тохижуулах, багийн бага эмчийг уналгаар ханган, эмийн эргэлтийн сан ажиллуулахад хөрөнгө оруулах зэрэгт бодитойгоор оролцож, санаачилга, хөдөлгөөн өрнүүлж ажилах.

Дөрөв.Удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

4.1.Хөтөлбөрийн удирдлага,зохион байгуулалт:

4.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар ханган, эрүүл мэндийн салбарын бусад хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилттэй уялдуулах, салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог зохицуулах, явц, үр дүнд нь хяналт тавих, үнэлгээ өгөх үйл ажиллагаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

4.1.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4.2.Хөтөлбөрийн санхүүжилт:

Хөтөлбөрийн санхүүжилт нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын хандивлагчдын зээл, тусламж, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг сум, аймгийн Засаг даргын Тамгын газар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэж Засгийн газарт жил бүр тайлагнаж байна.

5.2. Аймгийн Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн яаманд ирүүлнэ.

5.3. Хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

№	Үзүүлэлт	2001 оны түвшин	Хүрэх түвшин	
			2004	2008
1.	Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлагыг бүрэн хангасан эмнэлгийн эзлэх хувь	4,3%	40%	80%
2.	Зориулалтын байртай сумын эмнэлгийн эзлэх хувь	11%	40%	70%
3.	Зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан сумын эмнэлгийн эзлэх хувь	7,5%	40%	70%
4.	Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийн хувь	13.3%	40%-иас доошгүй	50%-иас доошгүй
5.	Эмийн эргэлтийн сантай сумын тооны өсөлт /хувь/	31%	70%	97%
6.	Их эмчтэй сумын эзлэх хувь	98%	100%	100%
7.	Их эмчээр бүрэн хангагдсан сумын эзлэх хувь	75%	85%	95%
8.	Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын сургалтад хамрагдсан сумын эмч нарын эзлэх хувь	**	75%	90%
9.	Эрүүл мэндийн суурь туслам-жийн стандартын сургалтад хамрагдсан сумын эмч, дунд мэргэжилтний эзлэх хувь	**	70%	90%
10.	Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан сумын их эмчийн эзлэх хувь	43,2%	60%	95%
11.	100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл /сумын дундаж/	147	135	130
12.	Гэрийн төрөлтийн хувь	1.1%	0.8%	0.5%
13.	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл /сумын дундаж/	30,8%	29%	27.5%
14.	1000 амьд төрөлтөд ногдох 1-5 насны хүүхдийн эндэгдэл /сумын дундаж /	42,4%	37%	35%

** нэрлэсэн сургалт 2002 оноос эхлэн явагдана.

төгсөлтийн 2 дугаар хавсралт

СУМЫН ЭМНЭЛГИЙН ХЭЛЖИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа	Биелэгдэх хугацаа	Толгойж ажиллах байгууллага	Оролцох байгууллага
I үр дүн. Сумын эмнэлгийн дэд бүтэц саймирснаар эрүүл мэндийн суурь түслэмжийн үйлчилгээ эсхих стандартын дагуу явагдаж, чанар, хүртээмжинь дээшлэх улмаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжаар бүтэлгэжсэн байна.			
1.1. Хөтөлбөр түүний хэрэгжилт, үр дүнг сурталчилах, үйлчлүүлэгчдэс сэтгэл ханамжийн судалгаа авах	2002-2008 он	ЭМЯ	Бүх шатны Засаг дарга
1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бүр гаргаж, шаардлагатай хөрөнгийг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлж байх	2002-2008 он	ЭМЯ	Бүх шатны Засаг дарга
1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийг жил бүр Эрүүл мэндийн яамандтайлагнаж байх	2002 оноос жил бүр	Аймгийн Засаг дарга	Сумын Засаг дарга
1.4. Эмнэлгийн 82 барилын стандартын шаардлагын дагуу шинээр барих	2002-2008 он	ЭМЯ	СЭЗЯ, бүх шатны Засаг дарга
1.5. Сумын эмнэлгийн 346 барилгад их засвар хийх	2002-2008 он	ЭМЯ	СЭЗЯ,бүх шатны Засаг дарга
1.6. 285 сумын эмнэлгийн халаалтын тохеремж, бохир, цэвэр усны системийг шинэчлэх	2002-2008 он	ЭМЯ	СЭЗЯ,ДБЯ, бүх шатны Засаг дарга
1.7. Сумын эмнэлгийн 70 хувьд багаж, тоног төхеремжийн шинэчлэлт хийх	2002-2008 он	ЭМЯ	СЭЗЯ,АХБ, ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан
1.8. Эмнэлгийн түргэн түслэмжийн машины парк шинэчлэлт хийх	2002-2008 он	ЭМЯ	СЭЗЯ, ДЭМБ, АХБ

1.9. Эрүүл мэндийн суурь тусламжийн багц, тэдгээрийг үзүүлэх стандарт боловсруулах	2002–2008 он	ЭМЯ	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв
1.10. Эрүүл мэндийн суурь тусламжийг санхүүжүүлэх стандарт боловсруулах	2002–2008 он	ЭМЯ	СЭЗЯ
1.11. Сумын эмнэлэгт хийх онцлогтой, эмчилгээний стандартуудыг боловсруулах, шинэчлэх	2002–2008 он	ЭМЯ	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв
1.12. Сумын эмнэлэгт магадлан итгэмжлэл олгох, магадлан итгэмжлэгдэх сумын эмнэлгийг нийтэд мэдээлэх, удирдлагыг нь урамшуулах арга хэмжээ авах	2002-2008 он	ЭМЯ	Бүх шатны Засаг дарга
1.13. Багийн бага эмчийг унаагаар хангах	2002-2008 он	Сумын засаг дарга	Аймгийн Засаг дарга
Пүр дүн: Сумын эмнэлгийг эмч, мэргэжилтнээр хангах, тэдний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх, цалин, урамшууллыг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжсэнээр харвалтын хүч авд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ жигд, хүртээмжтэй болж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхи сайжирсан байна.			
2.1. Бүх сумын эмнэлгийн их эмнэр хангах	2002-2008 он	ЭМЯ	Бүх шатны Засаг дарга

2.2. Сумын эмнэлгийн хүчний нөөцийн хангамжийг сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын түвшинд хүргэхээр жил бүр төлөвлөж, байршил, хуваарилалтыг сайжруулах талаар уе шаттай арга хэмжээ авах	2002-2008 он	ЭМБ	БСШУЯ, НХҮЯ,бүх шатны Засаг дарга
2.3. Сумын эмч, дунд мэргэжилтний төгсөлтийн дараахь болон зайны сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг бүсийн онцлогтой, эмчилгээний төвүүдэд бүсчилэн зохион байгуулах	2002-2008 он	ЭМБ	БСШУЯ,ДЭМБ, АХБ,бүх шатны Засаг дарга
2.4. Сумын удирдах ажилтан болон сумын эмнэлгийн эрхлэгч эмч нарыг эрүүл мэндийн менежментийн сургалтад хамруулах	2002-2008 он	ЭМБ	ДЭМБ
2.5. Сумын эмнэлгийн эмч, ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх урамшуулалын тогтолцоо боловсронгуй болгох	2002-2008 он	ЭМБ	НХҮЯ, СЗЗЯ,бүх шатны Засаг дарга
2.6 Сумын эмнэлгийн мэдээллээр хангах ажлыг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2002-2008 он	ЭМБ	ДЭМБ, бүх шатны Засаг дарга
2.7. Эмийн эргэлтийн сан байгуулах	2002-2004 он	ЭМБ	Бүх шатны Засаг дарга, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 1.5 ☎ 329487





ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (264)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Газрын тухай*
- *Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай*
- *Чөлөөт бүсийн тухай*
- *"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны долдугаар сарын 19 №27 (264)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

319. Газрын тухай (2002-6-7-ны хууль) 840
320. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-6-7-ны хууль) 858
321. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-6-7-ны хууль) 859
322. Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-6-7-ны хууль) 859
323. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-7-ны хууль) 859
324. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-7-ны хууль) 859
325. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-7-ны хууль) 860
326. Банкны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай (2002-6-7-ны хууль) 860
327. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай (2002-6-28-ны хууль) 860
328. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2002-6-28-ны хууль) 871
329. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-6-28-ны хууль) 871
330. Чөлөөт бүсийн тухай (2002-6-28-ны хууль) 872
331. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай (2002-6-28-ны хууль) 876
332. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-28-ны хууль) 876
333. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-28-ны хууль) 877

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

334. Газрын тухай хууль хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах тухай Дугаар 28 877
335. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 37 877

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 21 дүгээрт нийтлэгдсэн "Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 4 дүгээр зүйлд **" Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд;"** гэснийг " **Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;**" гэж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

336. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс байгуулах тухай Дугаар 38 878
337. Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 40 878
338. Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 44 879
339. Газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл байгуулах тухай Дугаар 45 879
340. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 46 879
341. 2002 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Дугаар 48 880
342. Байгтын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 49 881
343. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 50 881
344. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай Дугаар 51 881
345. Нөхөн сонгууль зарлах тухай Дугаар 53 882
346. Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай Дугаар 54 882
347. Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргыг томилох тухай Дугаар 57 882

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Газрын тухай хууль тогтоомж

2.1. Газрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2. Газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "газар" гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг;

3.1.2. "газар өмчлөх" гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;

3.1.3. "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;

3.1.4. "газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг;

3.1.5. "газрыг чөлөөлөх" гэж тухайн газрыг эзэмших, ашиглах эрх дуусгавар болох, түүнчлэн газрыг зөвшөөрөлгүй ашигласан бол үүгээр дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх, газрыг засаж тохижуулах зэргээр хууль болон гэрээнд зааснаар газрыг өмчлөгчид нь эргүүлэн өгөхөд саадгүй болгохыг;

3.1.6. "бэлчээр" гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт

хамааруулсан газрыг;

3.1.7. "газар эзэмших эрхийн гэрчилгээ" гэж энэ хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичгийг;

3.1.8. "газар ашиглах эрхийн гэрчилгээ" гэж энэ хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын харьяатгүй аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүний газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг.

4 дүгээр зүйл. Төрөөс газрын талаар баримтлах зарчим

4.1. Төрөөс газрын талаар дараахь зарчмыг баримтална:

4.1.1. Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх;

4.1.2. газар төрийн хяналт, хамгаалалтад байх;

4.1.3. газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

4.1.4. газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндэсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

4.1.5. хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх.

5 дугаар зүйл. Газар өмчлөгч

5.1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.

5.2. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн бэлэн улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

5.3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Газар эзэмшигч, ашиглагч

6.1. Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана.

6.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана:

6.2.1. бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар;

6.2.2. хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар;

6.2.3. зам, шугам сүлжээний газар;

6.2.4. ойн сан бүхий газар;

6.2.5. усны сан бүхий газар.

6.3. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын харьяатгүй аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.

7 дугаар зүйл. Газрын төлбөр

7.1. Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө.

7.2. Газрын төлбөрийн хэмжээ, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, зарцуулах журмыг хуулиар тогтооно.

8 дугаар зүйл. Хилийн цэс, газар усны нэр, газар усны нэрийн болон газрын сангийн зураг

8.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хилийн цэс, газар усны нэрийн болон газрын сангийн зурагтай байна.

8.2. Хилийн цэс, газар усны нэрийг Улсын Их Хурал, газрын сангийн зургийг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага /цаашид "Засгийн газрын эрх бүхий байгууллага" гэнэ/ тус тус батална.

8.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг тухайн шатны Засаг дарга, улсын хэмжээний иж бүрэн хувийг Засгийн газрын эрх бүхий байгууллага тус тус хадгална.

8.4. Хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах журмыг Засгийн газрын эрх бүхий байгууллага тогтооно.

8.5. Газар усны албан ёсны нэрийг зөвхөн Улсын Их Хурал өөрчилнө.

8.6. Албан ёсны баримт бичиг болон арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэх, газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын газрын нэгдмэл сан, түүний үндсэн ангилал

9 дүгээр зүйл. Газрын нэгдмэл сан

9.1. Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн.

9.2. Газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан ангилна.

10 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал

10.1. Монгол Улсын газрын нэгдмэл санг дараахь байдлаар ангилна:

10.1.1. хөдөө аж ахуйн газар;

10.1.2. хот, тосгон, бусад суурины газар;

10.1.3. зам, шугам сүлжээний газар;

10.1.4. ойн сан бүхий газар;

10.1.5. усны сан бүхий газар;

10.1.6. тусгай хэрэгцээний газар.

11 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн газар

11.1. Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.

12 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурины газар

12.1. Хот, тосгон, бусад суурины газарт хот, тосгон, бусад суурины барилга, байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр болон нийтийн эдэлбэрийн газар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар хамаарна.

12.2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

13 дугаар зүйл. Зам, шугам сүлжээний газар

13.1. Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.

14 дүгээр зүйл. Ойн сан бүхий газар

14.1. Ойн сан бүхий газарт ой мод, заггай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газар хамаарна.

15 дугаар зүйл. Усны сан бүхий газар

15.1. Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, мөрөн, гол, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газар хамаарна.

16 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар

16.1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

16.1.1. улсын тусгай хамгаалалттай газар;

16.1.2. улсын хилийн зурвас газар;

16.1.3. улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалттаар олгосон газар;

16.1.4. гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;

16.1.5. шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;

16.1.6. аймаг дундын отрын бэлчээр;

16.1.7. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай.

16.1.8. бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай;

16.1.9. чөлөөт бүсийн газар.

16.2. Аймаг, нийслэл, сум энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

16.3. Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Газрын харилцааны талаархи төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

17 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

17.1. Улсын Их Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлох;

17.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах;

17.1.3. энэ хуулийн 16.1.1-16.1.4, 16.1.9-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох;

17.1.4. бүс нутгийг хамарсан олон улсын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоох.

18 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

18.1. Засгийн газар газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж хангах;

18.1.2. энэ хуулийн 16.1.5-16.1.8-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг, ашиглах журмыг тогтоох, эрх бүхий байгууллагын мэдэлд шилжүүлэх;

18.1.3. улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох;

18.1.4. газрын бирж байгуулах, ажиллах журмыг тогтоох;

18.1.5. газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх болон газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх, журмыг тогтоох;

18.1.6. энэ хуулийн 17.1.2-т заасан газрын зааг, ашиглах журмыг тогтоох;

18.1.7. улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлах.

19 дүгээр зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

19.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1. газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

19.1.2. газрын нэгдмэл сангийн тайланг Засгийн газарт танилцуулах;

19.1.3. газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, заавыг батлан мөрдүүлэх, үйл ажиллагааны нь хяналт тавих, дүгнэлт өгөх;

19.1.4. газар зохион байгуулалт, газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

19.1.5. газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох арга чилээг батлах;

19.1.6. энэ хуулийн 16.1-д заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох саналаа Засгийн газарт оруулах;

19.1.7. газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/ -ний сүлжээ ажиллуулах;

19.1.8. газрын төлөв байдал, нөөц, чанарын өөрчлөлтийг тодорхойлох, газар зэзмшигч, ашиглагчийн бүртгэлийг эрхлэх зорилго бүхий газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан, сүлжээг орчин үеийн техник, технологид тулгуурлан бий болгох;

19.1.9. газрын элэгдэл, эвдрэлийн зэрэглэл, цөлжилтийн төрөл, ангиллыг тогтоох, тэдгээртэй тэмцэх, нөхөн сэргээх арга чилал, заавар, журмыг боловсруулж мөрдүүлэх.

20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрх

20.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны

талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1. газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;

20.1.2. тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

20.1.3. тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох;

20.1.4. бусдын эзэмшил газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан гэрээний хугацаа дуусахаас өмнө газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр нөхөн олговор олгох шийдвэр гаргах.

20.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.2.1. нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах;

20.2.2. газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;

20.2.3. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

20.2.4. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн газрын нэгдмэл сангийн тайланг жил бүр хянан нэгтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, дээд шатны Засаг дарга, Засгийн газрын эрх бүхий байгууллагад тайлагнах;

20.2.5. газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар зээмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

20.2.6. газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

20.2.7. газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

20.2.8. тухайн шатны газрын албаны дарга болон газрын даамлыг томилох, чөлөөлөх асуудлаар эрх бүхий байгууллагад санал өгөх;

20.2.9. газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалттүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа тухай ирсэн, эх авхйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ Засгийн газрын эрх бүхий байгууллагад гаргах.

21 дүгээр зүйл. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

21.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. Засаг даргын өргөн мэдүүлсэн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл болон нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дүүрэг бүрийн хуваарьтайгаар хэлэлцэн батлах.

21.2. Нийслэлийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1. хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл болон нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг дүүрэг бүрээр боловсруулж, дүүргийн Засаг даргын санал, Засгийн газрын эрх бүхий байгууллагын дүгнэлтийн хамт нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

21.2.2. батлагдсан төлөвлөгөөний дагуу тухайн жилд зээмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох;

21.2.3. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу хотын суурьшлын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий болон

сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд холбогдох дүүргийн Засаг даргын саналыг авсан байна;

21.2.4. хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны тусгал болон тухайн жилийн газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу энэ хуулийн 21.2.3-т заасан газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах.

21.3. Аймгийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.3.1. сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тусгал чиглэл өгөх;

21.3.2. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.

21.4. Сумын Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.4.1. аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тусгал санал өгөх;

21.4.2. аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

21.4.3. энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах.

21.5. Дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.5.1. хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны тусгал, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний тусгал санал өгөх;

21.5.2. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны тусгал, газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

21.5.3. энэ хуулийн 21.2.3-т зааснаас бусад газрыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу энэ хуулийн 21.2.2-т заасныг баримтлан, дүүргийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах.

22 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

22.1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. нийтийн эдэлбэрийн газрын ашиглалтыг зохион байгуулах;

22.1.2. баг, хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газрын эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах;

22.1.3. газар ашиглалт, хамгаалалтын талаархи Засаг даргын тайланг хэлэлцэх, дүгнэх.

22.2. Баг, хорооны Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.2.1. газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаархи нийтлэг шаардлагын биелэлтийг хангуулах;

22.2.2. дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас газрын ашиглалт, хамгаалалтын талаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

22.2.3. нутаг дэвсгэртээ нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцах.

23 дугаар зүйл. Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын тогтолцоо, эрх хэмжээ

23.1. Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага нь аймаг, нийслэл,

дүүрэгт газрын асуудал эрхэлсэн алба, сумд газрын даамалтай байна.

23.2. Засгийн газрын эрх бүхий байгууллага дараахь эрх хэмжээтэй байна:

23.2.1. газрын талаар Засгийн газраас баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;

23.2.2. газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тоглоох болон газрыг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх саналыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;

23.2.3. улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;

23.2.4. улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;

23.2.5. газрын тайланг жил бүр нэгтгэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хэлэлцүүлэх;

23.2.6. тухайн шатны Засаг даргын саналыг авсны үндсэн дээр аймаг, нийслэлийн газрын албаны даргыг томилох, чөлөөлөх;

23.2.7. газрын биржийн үйл ажиллагаог зохих журмын дагуу зохион байгуулах;

23.2.8. улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагаог эрхлэх;

23.2.9. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

23.2.10. газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

23.2.11. газрын талаархи хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг тухайн шатны Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

23.2.12. газар зохион байгуулалтын талаархи мэргэжлийн боловсон хүчний бодлогыг эрхлэх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаог мэргэжлийн удирдлагаар хангах;

23.2.13. газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг батлах;

23.2.14. улсын хэмжээнд газрын кадастрын үйл ажиллагаог удирдах, зохион байгуулах, газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;

23.2.15. газар зохион байгуулалт, газрын кадастрын судалгаа, шинжилгээний ажил эрхлэх;

23.2.16. энэ хуулийн 20.2.9-д заасны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шалгалт хийж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах.

23.3. Аймаг, нийслэлийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна:

23.3.1. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулах;

23.3.2. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн хилийн цэсийг тодотгох, өөрчлөлт оруулах талаар гарсан саналыг зохих журмын дагуу боловсруулах;

23.3.3. газрын кадастр эрхлэх, аймаг, нийслэлийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх;

23.3.4. газрын тайланг зохих журмын дагуу гаргаж Засаг даргад тайлагнах;

23.3.5. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлыг зохион байгуулах;

23.3.6. тухайн шатны Засаг даргын саналыг авсны үндсэн дээр сумын газрын даамал, дүүргийн газрын албаны даргыг томилох, чөлөөлөх;

23.3.7. Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох;

23.3.8. газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж хураах.

23.4. Сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна:

23.4.1. сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах;

23.4.2. Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох;

23.4.3. эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн

кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх;

23.4.4. газрын мэдээллийн санг эрхлэх;

23.4.5. газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж хураах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Газар зохион байгуулалт, газрын кадастр, газрын нэгдмэл сангийн тайлан

24 дүгээр зүйл. Газар зохион байгуулалт, түүний санхүүжилт

24.1. Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн.

24.2. Газар зохион байгуулалтын арга хэмжээг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

24.3. Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээг Засгийн газар тогтооно.

24.4. Газар зохион байгуулалт хийх тухай Засгийн газар, түүний эрх бүхий байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

24.5. Газар зохион байгуулалтын үйл ажиллагааг дараахь журмаар санхүүжүүлнэ:

24.5.1. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс тогтоох, өөрчлөх, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс нутгийн хөгжлийн төлөвийг тодорхойлохтой холбогдсон газар зохион байгуулалтын үйл ажиллагааны шаардлагатай зардлыг улсын төвлөрсөн төсвөөс;

24.5.2. аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот, тосгон, бусад суурины газар зохион байгуулалтын үйл ажиллагааны шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс;

24.5.3. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшиж, ашиглаж байгаа газартаа хийлгэх газар зохион байгуулалтын үйл ажиллагааны шаардлагатай зардлыг өөрийн хөрөнгөөр.

25 дугаар зүйл. Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгүүд,тэдгээрт тавигдах шаардлага

25.1. Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгүүд нь дор дурдсан зүйлээс бүрдэнэ:

25.1.1. улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

25.1.2. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

25.1.3. хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл;

25.1.4. нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

25.1.5. шинээр хот суурин байгуулах, атар газар эзэмших, тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгох, томоохон үйлдвэр, уурхай, зам, шугам сүлжээ, бүс нутгийг хамарсан олон улсын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газар болон чөлөөт бүс байгуулахтай холбогдсон схем, техник эдийн засгийн үндэслэл, газар зохион байгуулалтын зураг, төслүүд;

25.1.6. газрын кадастрын зураг, бүртгэл, судалгаа, үнэлгээний материал.

25.2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхид зохицон газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хэтийн чиглэлийн баримжаатай зураг төслийн баримт бичиг байна.

25.3. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

25.4. Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг

тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

25.5. Газрын кадастрын зураг, бүртгэл, судалгаа, үнэлгээний материалууд нь холбогдох хуулийн шаардлагыг хангасан байна.

26 дугаар зүйл. Газрын кадастр, газрын нэгдмэл сангийн тайлан

26.1. Газрын кадастр нь газар зохион байгуулалтын арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг мөн.

26.2. Газрын кадастрт энэ хуулийн 9-16 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газрын улсын бүртгэл, газрын тоо бүртгэл, чанар, үнэлгээ, төлбөр, шилжилт хөдөлгөөн, газар хамгаалах талаар авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр тусгасан байна.

26.3. Газрын нэгдмэл сангийн тайланд газрын хуваарилалт, газрын улсын бүртгэл, ашиглалт, хамгаалалтын байдлыг аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр тусгаж, тэдгээрийн хөдөлгөөнийг харуулсан зургийг хавсаргасан байна.

26.4. Газрын нэгдмэл сангийн тайлангийн маягтыг Засгийн газар батална.

26.5. Газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн тайланг Засаг дарга тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тасалбар болгон гаргаж, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад; газрын нэгдмэл сангийн аймаг, нийслэлийн тайланг Засаг дарга дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын эрх бүхий байгууллагад тус тус гаргаж өгнө.

26.6. Засгийн газрын эрх бүхий байгууллага тухайн оны газрын нэгдмэл сангийн тайланг дараа оны 3 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулна.

26.7. Газрын кадастрын үр дүнг үндэслэн газрын нэгдмэл сангийн тайланг гаргана.

26.8. Газрын кадастртай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Газар эзэмшүүлэх, ашиглуулах

27 дугаар зүйл. Газар эзэмшүүлэх

27.1. Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндэсэн дээр эвлэн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.

27.2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

27.3. Нэгж талбар бүр эрхийн гэрчилгээтэй байна.

27.4. Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно.

27.5. Хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн газрыг эзэмшүүлж болно.

27.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр байгуулсан хиймэл нуур, цөөрөм, усан сан, есгэж үржүүлсэн ан амьтан, тарьж ургуулсан ойн төгөл, аж ахуйн ашигт ургамлын доорх газрыг багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн давуу эрхээр эзэмшүүлж болно.

28 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээний төрөл

28.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ нь дор дурдсан төрөлтэй байна:

28.1.1. гэр бүлийн хамтын хэрэглээний;

28.1.2. терийн байгууллагын;

28.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын.

29 дүгээр зүйл. Эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

29.1. Иргэнд гэр бүлийн нь хамтын хэрэглээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна.

29.2. Энэ хуулийн 29.1-д зааснаас гадна гэр бүлийнх нь хамтын хэрэглээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал үргамал тарих зориулалтаар иргэнд 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно.

29.3. Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэглээнд зориулан Засгийн газраас тогтоосон жүрмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна.

29.4. Иргэнд энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнд багтаан газамшүүлэх газрын дээд хэмжээ, байршлыг хүн амын нягралд, газрын нөөцийг харгалзан тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

29.5. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих талбай нь хувийн гэр, орон сууцны хашааны газрын зэргэлдээ, эсхүл үүрийлалтаар тусгайлан тогтоогдсон газарт байж болно.

29.6. Аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулан газамшүүлэх газрын дээд хэмжээг Засгийн газар тогтоно.

30 дугаар зүйл. Газар газамшүүлэх хугацаа

30.1. Газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар газамшүүлэх болно. Газар газамшиг эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна.

30.2. Газар газамшигч нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсоноо тооцогдсон тохиолдолд уг иргэний хууль ёсны өв залгамлагч нь хүсвэл газар газамшиг эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр шилжүүлэх, анхдагч гэрээнд заасан газар газамшиг хугацаа дуустал газрыг үргэлжлүүлэн газамшиж болно.

31 дүгээр зүйл. Газар газамшүүлэхэд тавигдах шаардлага

31.1. Газар газамших хүсэлт гаргагч нь газвхэн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна.

31.2. Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газамшүүлж болохоор заагдсан байна.

31.3. Хүсэлт гаргасан газар нь бусдын газамшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.

32 дугаар зүйл. Газар газамших тухай хүсэлт гаргах

32.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар газамших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад Засгийн газрын эрх бүхий байгууллагаас батлагдсан загварын дагуу гаргана.

32.2. Иргэн энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

32.2.1. овог, нэр, байнга оршин суугаа хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар;

32.2.2. газамших газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг;

32.2.3. газар газамших зориулалт хугацаа.

32.3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

32.3.1. аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, харьяалал, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

32.3.2. тухайн аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг;

32.3.3. газар газамших зориулалт хугацаа.

32.4. Энэ хуулийн 32.2, 32.3-т заасан баримт бичгийг хавсаргасан хүсэлтийг хүлээн авмагцаа сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба Засгийн газрын эрх бүхий байгууллагаас батлагдсан жүрмын дагуу бүртгэнэ. Бүртгэлд хүсэлтийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг минутаар тэмдэглэх бөгөөд энэ тухай тодорхойлотыг хүсэлт гаргасан этгээдэд гаргаж өгнө.

32.5. Хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг сумын газрын даамал, аймаг, нийслэл дүүргийн газрын алба нягтлан хянаж, шаардлага хангаагүй бол энэ талаарх үндэслэлийг хүсэлт гаргагч этгээдэд мэдэгдлээр өгч, бүртгэлээс хасна.

33 дугаар зүйл. Газар газамшүүлэх шийдвэр гаргах

33.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар газамшүүлэх асуудлыг дараахь жүрмыг баримтлан шийдвэрлэнэ:

33.1.1. энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг газамшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;

33.1.2. энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар газамших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар газамшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах жүрмыг Засгийн газар тогтооно.

33.2. Энэ хуулийн 33.1.2-т заасан шийдвэрийн дагуу газар газамших эрх авсан этгээд нь заасан хугацаанд газар газамших эрхийн гэрчилгээний үнийг төлөөгүй бол уг эрхийн гэрчилгээг дахин дуудлага худалдаанд оруулна.

33.3. Эрхийн гэрчилгээгээр газар эзэмшүүлэх шийдвэрийн талаар үүссэн маргааныг энэ хуулийн 60.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

33.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно.

34 дүгээр зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам

34.1. Энэ хуулийн 33.1-д заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.

34.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.

34.3. Хэрэв тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийн гэрчилгээгээр эзэмших газарт хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр сөрөг дүнэлт гарсан бол эрхийн гэрчилгээг олгоосоо татгалзаж, дуудлага худалдааны үнийг бүүвэн олгоно.

34.4. Дуудлага худалдаанд оролцсон бүх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа бол энэ хуулийн дагуу дуудлага худалдааг дахин явуулна.

34.5. Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг түүгээр зориулалт бүхий хавсралттай байна.

34.6. Газар эзэмших гэрээнд дараахь зүйлийг тусгана:

34.6.1. газар эзэмшүүлэх үндэслэл /зохих шийдвэр/;

34.6.2. газар эзэмших зориулалт;

34.6.3. газрын хэмжээ, байршил, заагийг харуулсан зураг;

34.6.4. газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт;

34.6.5. газар эзэмшүүлэх хугацаа;

34.6.6. газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

34.6.7. гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага;

34.6.8. газар эзэмших эрх дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай тохиролцоо;

34.6.9. эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах нөхцөл, журам;

34.6.10. газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажил;

34.6.11. шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

34.7. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно.

34.8. Газар эзэмших гэрээ нь эрхийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ.

34.9. Газрыг дундаа эзэмшиж байгаа тохиолдолд газар эзэмших нэг гэрээтэй байж болно.

34.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тухайн газар дээрх тэдгээрийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно.

35 дугаар зүйл. Газар эзэмшигчийн эрх, үүрэг

35.1. Газар эзэмшигч дараахь эрхтэй:

35.1.1. гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

35.1.2. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа газар өмчлөгчөөс гаргуулж авах;

35.1.3. газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон жүрмын дагуу нөхөн төлүүлэх;

35.1.4. газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн эвөшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

35.1.5. газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацаагүй сунгуулах;

35.1.6. газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн эвөшөөрөлтэйгээр тухайн газраа бүрдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

35.2. Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй.

35.3. Газр эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

35.3.1. газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

35.3.2. газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан

тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

35.3.3. газрын төлберийг тогтоосон хугацаанд төлөх;
35.3.4. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат тогтоосон журмын дагуу хийлгэж байх;

35.3.5. бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

35.3.6. энэ хуульд заасны дагуу эрхийн гэрчилгээгээ барьцаалах, шилжүүлэх тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх.

36 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны үнэ, үйлчилгээний хураамж

36.1. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батална агрегчпалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.

36.2. Дуудлагын худалдаагаар тогтоогдсон үнэ нь эрхийн гэрчилгээний бодит үнэ байна.

36.3. Эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулахад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамж төлнө.

36.4. Эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх тохиолдолд төлөх хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

36.5. Эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсний болон хугацаа сунгуулсны үйлчилгээний хураамжийг газар хамгаалах, нөхөн сэргээх санд төвлөрүүлнэ.

37 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаат сунгах

37.1. Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах бөгөөд дараахь баримт бичгүүдийг хавсаргана:

37.1.1. газар эзэмших эрхийн гэрчилгээ;

37.1.2. газрын төлберийг төлсөн тухай баримт;

37.1.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр гарсан дүгнэлтийг хэрэгжүүлсэн талаарх тодорхойлолт.

37.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана. Үг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба бүртгэнэ.

38 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх

38.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана.

38.2. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг талууд гаргах бөгөөд дараахь баримт бичгийг хавсаргана:

38.2.1. нотариатчаар гэрчлүүлсэн гэрээ;

38.2.2. эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай нотолгоо;

38.2.3. хураамж төлсөн тухай баримт.

38.3. Эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч дараахь зүйлүүдийг тодруулна:

38.3.1. энэ хуулийн 38.2-т заасан шаардлагыг хангасан эсэх;

38.3.2. шилжүүлэхийг хүссэн эрхийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх;

38.3.3. эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг эзэмших эрхтэй эсэх.

38.4. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргана. Үг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлснээр эрхийн гэрчилгээг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болно.

38.5. Энэ хуулийн 35.1.4-т заасан зөвшөөрөлтэйгөөр газар эзэмшигч нь эрхийн гэрчилгээгээ Иргэний хуульд нийцүүлэн барьцаалж болох бөгөөд энэ тохиолдолд сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэнэ.

39 дүгээр зүйл. Газар эзэмших эрх дуусгавар болох

39.1. Газар эзэмших эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

39.1.1. газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газар эзэмших гэрээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлт гаргаагүй;

39.1.2. газар эзэмшигч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон бөгөөд түүний хүүль ёсны өв залгамжлагч байхгүй нь тогтоогдсон, газар эзэмшигч

аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан;

39.1.3. эзэмшигч газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасан;

39.1.4. газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон;

39.1.5. газрыг тусгай хэрэгцээнд авч нөхөх олговрыг газар эзэмшигчид бүрэн төлсөн.

40 дүгээр зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох

40.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:

40.1.1. эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

40.1.2. газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

40.1.3. шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

40.1.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

40.1.5. эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

40.1.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан үндэслэл тогтоогдвол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон захирамж гаргаж, энэ тухайгаа эрхийн гэрчилгээ эзэмших байсан буюу түүнийг барьцаалсан этгээдэд мэдэгдэнэ.

40.3. Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

40.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ Засгийн газрын эрх бүхий байгууллагад мэдэгдэж улсын бүртгэлд тусгуулна.

40.5. Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаалагч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гартал тухайн газрыг эзэмших эрхийн гэрчилгээ шинээр олгохгүй.

41 дүгээр зүйл. Газар эзэмших эрх дуусгавар болоход газрыг чөлөөлөх

41.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх дуусгавар болоход хууль болон газар эзэмших гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор уг газрыг чөлөөлж аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

41.2. Энэ хуулийн 39.1.1 - 39.1.4-т заасан үндэслэлийн дагуу газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.

41.3. Эзэмшлийн газар нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулд нэрвэгдэж, цаашид тухайн зориулалтаар ашиглах боломжгүй болсон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн газар эзэмшигч газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасан бол уг газрыг засаж тохижуулах зардлыг шаардлагатай тохиолдолд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно. Харин уг газар дээрх барилга, байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.

41.4. Энэ хуулийн 41.1-д заасан хугацааны газраа чөлөөлөөгүй бол тухайн шатны Засаг дарга албадан нүүлгэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

42 дугаар зүйл. Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авах

42.1. Засгийн газрын эрх бүхий байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын түсгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.

42.2. Засгийн газар нь бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай Засгийн газрын эрх бүхий байгууллагын санал, газар эзэмшигчтэй түүний хийсэн урьдчилсан тохиролцоог харгалзан зохих шийдвэр гаргана.

42.3. Энэ хуулийн 42.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна.

42.4. Хувийн гэр, орон суучны хашааны газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд түүнийг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийнэ.

42.5. Бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахтай холбогдон үүсэх маргааныг энэ хуулийн 60.1.1, 60.1.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

43 дугаар зүйл. Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад нөхөх олговор олгох

43.1. Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж,

байгууллага нь энэ хуулийн 42.3-т заасан гэрээ байгуулсны дараа хууль болон уг гэрээнд өөрөөр заагаагүй бол ийнхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 90 хоногийн дотор холбогдох газрыг чөлөөлж, тухайн шатны Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

43.2. Бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрт газар эзэмшигчтэй урьдчилан хийсэн тохиролцоог харгалзан уг газраас салгаж үл болох барилга байгууламж, бусад зүйл хөрөнгийг тухайн үеийн хэншаар үнэлсэн үнэ, газрыг чөлөөлөх зардлыг тусгана.

43.3. Газар эзэмшигчид олгох нөхөх олговрыг энэ хуулийн 42.3-т заасан гэрээг байгуулахад улсын төвлөрсөн төсвөөс тухайн шатны Засаг даргын мэдэлд шилжүүлсэн байна.

43.4. Энэ хуулийн 42.3-т заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн шатны Засаг дарга уг гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор нөхөх олговрыг уг газрыг эзэмшиж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

43.5. Энэ хуулийн 42.3-т заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол газар эзэмшигч өөрт нь нөхөх олговор бүрэн телсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор уг газрыг чөлөөлнө.

43.6. Нөхөх олговор нь газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарахгүй.

44 дүгээр зүйл. Газар ашиглуулах

44.1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээдэд газар ашиглуулах асуудлыг энэ хуулийн 17.1.2, 18.1.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

44.2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт ашиглуулах газрын болон төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай гэж үзвэл тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтална.

44.3. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт газар ашиглуулах нөхцөл, жүрмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтооно.

44.4. Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

44.5. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацаа Засгийн газар тогтооно.

44.6. Энэ хуулийн 44.4-т заасан иргэнд хувийн гэр, орон сууцны хашааны зориулалтаар ашиглуулах газрын хэмжээ 0,05 га-гаас, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих зориулалтаар олгох газрын хэмжээ 0,1 га-гаас тус тус илүүгүй байна. Газрыг 5 жил хүртэл хугацаагаар гэрээгээр ашиглуулах бөгөөд гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

44.7. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргахын өмнө гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас тодорхойлолт авсан байна.

44.8. Газар ашиглах тухай хүсэлт гаргах, түүнийг хянаж шийдвэрлэх, газар ашиглах гэрээний агуулгыг тогтоох, түүнийг байгуулахад энэ хуулийн 32, 33.1.2, 33.2, 34.1-34.5, 34.6.1 - 34.6.8, 34.6.10, 34.6.11, 34.7-34.10-д заасан жүрмыг баримтална.

44.9. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд газар ашиглуулсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг цуцалж, ашиглалтын явцад учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

45 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг

45.1. Газар ашиглагч нь энэ хуулийн 35.1.1, 35.1.2, 35.1.5, 35.3.1-35.3.5-д заасан болон бусад хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

46 дугаар зүйл. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд ашиглах

46.1. Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндэсэн дүгээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбертэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно.

46.2. Засгийн газар нийгмийн зайлшгүй шаардлагыг үндэслэн бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг уг шаардлага арилтал захиргааны журмаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбертэй буюу төлбөргүйгээр ашиглах тухай шийдвэр гаргаж болно.

47 дугаар зүйл. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрх дуусгавар болох

47.1. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

47.2. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн газрыг эзэмшиж, ашиглаж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгуллага газрыг нөхөн сэргээж, сайжруулсан байна.

47.3. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх барилга байгууламж, бусад эд

эрэнгийн талаар үүссэн маргааныг энэ хуулийн 60.1.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

48 дугаар зүйл. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах, уг газарт нэвтрэх, дайран өнгөрөх

48.1. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалаагүй бол хэн боловч тухайн газарт дохирол учруулахгүйгээр нэвтэрч, дайран өнгөрч болно.

Хориглох дохио тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага тогтоно.

48.2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь эд хөрөнгөө ашиглах, хамгаалах зорилгоор бусдын газраар дайран өнгөрөх зам, цахилгаан, холбооны болон инженерийн шугам татах, гарц гаргах болон бусад зориулалтаар бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахыг шаардах эрхтэй.

48.3. Газар эзэмшигч, ашиглагч болон уг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахаар шаардаж буй этгээдийн хооронд хэлэлцэн тохиролцсоны үндэсэн дээр газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх үүснэ.

Тухайн газрыг эзэмших, ашиглах эрх өөр этгээдэд шилжихэд газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах бусдын эрх хадгалагдана.

48.4. Газар эзэмшигч, ашиглагч нь газраа бусдад хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулснаас уг газрыг зориулалтын дагуу ашиглах боломжгүй болбол тийнхүү ашиглахыг зогсоохыг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглаж байгаа этгээдээс ашардах эрхтэй.

48.5. Энэ хуулийн 48.2-т заасан эд хөрөнгийг өмчлөгч бус этгээдэд газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх шилжүүлэхийг хориглоно.

48.6. Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахтай холбогдон үүссэн маргааныг энэ хуулийн 60.1.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

48.7. Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

49 дүгээр зүйл. Зарим этгээдийн газар ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрх дуусгавар болох

49.1. Энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан этгээдийн газар ашиглах эрх дуусгавар болоход хуульд өөрөөр заагаагүй бол уг этгээдийн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн төрөөгүй эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах

50 дугаар зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага

50.1. Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:

50.1.1. газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим бурах, газрын үргамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;

50.1.2. ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаас эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээх, засаж тохижуулж байх;

50.1.3. газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

50.1.4. ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;

50.1.5. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөрөгөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.

51 дүгээр зүйл. Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага

51.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглахтай холбогдолтой зураг төсөл боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх, Монгол Улсад өмнө нь сорьж, шалгаагүй химийн бодис, бордоог газарт хэрэглэхдээ мэргэжлийн эрх бүхий байгууллагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэнэ.

51.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, үргамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

51.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 51.2-т заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны Засаг даргад урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлэн, уг газрын зааг ийг тэмдэгжүүлж, сэрэмжлүүлэх байгүй дохио тэмдэгтүүд өөрийн хөрөнгөөр байрлуулна.

52 дугаар зүйл. Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах

52.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, өтрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.

52.2. Зуслан, намаржаа болон өтрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацаог сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мердэж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг булгээр ашиглуулж болно.

52.3. Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.

52.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож болно.

52.5. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх боловсон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор хашсан бэлчээрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

52.6. Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон жүрмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

52.7. Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.

52.8. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.

52.9. Ган, зуд болон бусад байгалийн гамшиг тохиолдсон үед ашиглах сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг дундын отрын нөөц нутаг, түүний заагийг орон нутгийн удирдлагын хүсэлтийг харгалзан Засгийн газар тогтооно.

52.10. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Энэ тохиролцон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

53 дугаар зүйл. Хадлангийн талбай зохистой ашиглах, хамгаалах

53.1. Сум, дүүргийн Засаг дарга мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хамтран хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч түүний хэрэгжилтийг хангана.

53.2. Сум, дүүргийн Засаг дарга хадлан авах болоцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ашиглуулахаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн хуваарилж түүний хэрэгжилтийг зохион байгуулна.

53.3. Газрын нэгдмэл сангийн ангилалд буртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно.

53.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн зохих үргэлжлэл хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно. Энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд буртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй.

53.5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, үргэлжлүүлэн тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сумын Засаг дарга уг талбайг нь хэзээшүүлж болно.

54 дүгээр зүйл. Тариалангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах

54.1. Энэ хуулийн 29.2, 29.3, 29.5-д зааснаас бусад тохиолдолд шинээр тариалангийн талбай бий болгох асуудлыг Засгийн газрын эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

54.2. Тариалангийн зориулалтаар газар зээмшиж, ашиглаж байгаа этгээд хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг бууруулахгүй байх арга хэмжээ байнга авч, хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу тухайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат хийлгүүлнэ.

54.3. Мал, амьтан бэлчээхэд тусгайлан зориулснаас бусад тохиолдолд тариалангийн талбайд үр суулгаснаас ургац хураах дуусах хүртэл хугацаанд мал, амьтан бэлчээхийг хориглоно.

54.4. Тариалангийн газрыг зээмшүүлэх, ашиглуулах асуудлыг багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.

55 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах

55.1. Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

55.2. Газрын хэвлий ашиглагч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна.

55.3. Газрын хэвлийг ашиглагч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх.

55.4. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, түүнд үндэслэсэн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаар батлагаажуулна.

55.5. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгүдийн Хурлаар хэлэлцүүлэх, дүгнүүлнэ.

56 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах

56.1. Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсругдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.

56.2. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зохиогдоогүй хот, тосгон, бусад сууринд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг тухайн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн энэ хуульд заасны дагуу шийдэрлэнэ.

56.3. Хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулахад дэд бүтцийн хангамж, хөгжлийн чиглэл, ариун цэвэр, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын шаардлага, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөг үндэслэнэ.

56.4. Хот, тосгон бусад суурины доторх бүсдын эзэмшил, ашиглалтад олгогдоогүй газрыг тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын орциулалт, ашиглаж эхлэх хугацаа бусад нөхцөл шаардлагүудыг бичсэн дохио, санамж тавих, хашаа, хайс татах, сахиул ажилуулах зэргээр хамгаалалтад авна.

56.5. Газар эзэмших, ашиглах хугацаа дуусан, тэрчлэн зохих эзэшээрэлгүй барилга байгуулламж бүрсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар нөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар нөлөөлөх үүрэгтэй.

56.6. Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгуулламжтай байлгана.

57 дугаар зүйл. Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих

57.1. Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, Засгийн газрын эрх бүхий байгуллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгүдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.

57.2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгаль орчны хяналтын газар болон үргамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхайн зэрэг мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

57.3. Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга үг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө.

57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга үг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.

57.5. Энэ хуулийн 57.4-т заасанаар газрыг чөлөөлөөгүй бол үг барилга, байгууламжийг шаардлагатай гэж үзвэл төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

58 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хяналт батлагаа, түүнийг гаргах

58.1. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахыг газрын төлөв байдал, чанарын улсын хяналт батлагаа гэнэ.

58.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хяналт батлагаар дараахь үзүүлэлтээр гаргана:

58.2.1. хөрсний үржил шимт үе давхаргын зузаан;

58.2.2. хөрсний ялзмагийн агууламж;

58.2.3. хөрсний бохирдолт, хордолт;

58.2.4. газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт;

58.2.5. ургамлын ургац, бүрхэвчийн өөрчлөлт;

58.2.6. бэлчээр, хадлангийн талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт.

58.3. Энэ хуулийн 58.2-т заасан үзүүлэлт дээр тухайн газрын онцлогийг харгалзан нэмж хэрэглэх үзүүлэлтийг Засгийн газар, газрын төлөв байдал, чанарын улсын хяналт батлагааны үзүүлэлтийг тодорхойлох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий

байгууллага тус тус тогтооно.

58.4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаагаар эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргана.

58.5. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшиг, ашиглах эрх дуусгавар болохоо энэхүү баталгаагаар гаргана.

58.6. Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг Засгийн газрын эрх бүхий байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна.

58.7. Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын төвлөрсөн бүюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

58.8. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээг Засгийн газар тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

59 дүгээр зүйл. Газрын харилцааны талаархи цагдаагийн байгуулагын үүрэг

59.1. Газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд цагдаагийн байгуулага дараахь үүрэгтэй:

59.1.1. хууль, гэрээнд заасан үндэслэлээр газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газар эзэмшсэн, ашигласан бол албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах;

59.1.2. газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцэн бол зохих журмын дагуу арга хэмжээ авах.

60 дугаар зүйл. Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх

60.1. Газартай холбогдон үүссэн дараахь маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

60.1.1. газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны Засаг дарга;

60.1.2. газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга;

60.1.3. газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу тухайн шатны Засаг дарга;

60.1.4. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах талаар болон газартай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг шүүх.

60.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газартай холбогдон үүссэн маргааны талаар энэ хуулийн 60.1.1, 60.1.2, 60.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг тэдгээрийн дээд шатны албан тушаалтан, байгууллага, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

60.3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ашиглаж буй газартай холбогдон үүссэн маргааныг талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

61 дүгээр зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох

61.1. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрээ буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно.

62 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

62.1. Газарт хохирол учруулсан гэм буруутай этгээд нь эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үнэтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна.

62.2. Газарт учирсан хохирол мэдэгдэж байхад уг газрыг эзэмшилдээ шилжүүлэн авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.

63 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

63.1. Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтэл оногдуулна:

63.1.1. энэ хуулийн 8.6-д заасан журмыг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.2. энэ хуулийн 48.1-д заасан журмыг зөрчиж тухайн газарт нэвтэрсэн буюу дайран енгөрсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.3. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх бүхий этгээдэд энэ хуулийн 48.2-т заасан зориулалтаар уг газрыг ашиглахад нь санаатайгаар саад учруулсан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.4. энэ хуулийн 41.1, 43.1, 43.5, 56.5-д заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван хоёроос хорь дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг дөчөөс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, албадан нүүлгэх;

63.1.5. энэ хуулийн 35.3.6, 38.1-д заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс арав дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, газар эзэмших, ашиглах гэрээг цуцлах;

63.1.6. энэ хуулийн 35.3.4-т заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арван хоёроос хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.7. эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шинээр тариалангийн талбай бий болгосон бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг дөчөөс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

63.1.8. энэ хуулийн 52.2, 53.3, 54.3-т заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

63.1.9. энэ хуулийн 50, 51 дүгээр зүйлд заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, газар эзэмших, ашиглах гэрээг цуцлах;

63.1.10. улсын тусгай хэрэгцээний газарт зохих зөвшөөрөлгүйгээр дур мэдэн үйл ажиллагаа явуулсан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг дөчөөс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

63.1.11. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг дөчөөс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

63.1.12. энэ хуулийн 33.4-д заасан журмыг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь хүчингүй болгон, хохирлыг нөхөн төлүүлэх;

63.1.13. энэ хуулийн 47.2-т заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс найм дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.14. энэ хуулийн 56.6-д заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

63.1.15. энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй нь тогтоогдсон бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван хоёроос хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь хүчингүй болгон, хохирлыг нь нөхөн төлүүлэх.

64 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

64.1. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлсан Газрын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлсан Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 37 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт" гэснийг "Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт" гэж, 38 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд" гэснийг "Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд" гэж, 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3; 2 дахь хэсгийн 1, 2-т" гэснийг "Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт" гэснийг "Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт" гэж, 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд" гэснийг "Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "төлөвлөгөө нь" гэсний дараа "харъяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Банкны тухай" гэсний дараа "болон Газрын тухай" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7–ны өдөр Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан заалтыг нэмсүгэй.

1/ 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт:

"3/ газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ."

2/ 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:

"9/ газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 7–ны өдөр Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28–ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомж

2.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Газрын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд Монгол Улсад газар өмчлөхтэй холбогдсон харилцааны талаар энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол Монгол Улсын Үндсэн хуулийг үндэслэн энэхүү хуулийн заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "газар" гэж газрын гадаргуу, түүний хөрс, ургамал бүхий орон зайн давхаргыг;

3.1.2. "иргэнд газар өмчлүүлэх" гэж Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор заасан газраас энэ хуульд заасан хэмжээ, болзол, шаардлага, журам,

[1] *Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн*

[2] *Иргэний хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн*

нөхцөлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг.

4 дүгээр зүйл. Иргэнд өмчлүүлэх газрын зориулалт

4.1. Иргэнд газрыг дараахь зориулалтаар өмчлүүлнэ:

4.1.1. гэр бүлийн хэрэгцээний;

4.1.2. аж ахуйн зориулалтаар.

5 дугаар зүйл. Иргэнд газар өмчлүүлэхэд баримтлах зарчим, үндэслэл

5.1. Иргэнд газар өмчлүүлэхэд дараахь зарчим, үндэслэлийг баримтална:

5.1.1. газар өмчлүүлэх арга хэмжээг газар өмчлөн авахыг хүссэн иргэний сайн дурын үндэсэн дээр эвлэн энэ хуульд заасан зориулалтаар тэр, олон нийтийн хэрэгцээ эсвэл төрөөс төлөвлөгөөнд тусгагдсан, сумын төв, тосгоны тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчлөх авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох;

5.1.2. иргэнд газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэхдээ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймгийн төвийн болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан, сумын төв, тосгоны тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчлөх авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох;

5.1.3. иргэнд газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэхдээ тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн газар тариалан хөгжүүлэх хэтийн болон тухайн жилийн төлөвлөгөөнд заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчилж авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох;

5.1.4. иргэн, түүний гэр бүлийн гишүүн-Монгол Улсын иргэнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх;

5.1.5. иргэнд энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар газрыг өмчлүүлэхдээ:

5.1.5.1. Газрын тухай хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг түүнд өмчлүүлэх;

5.1.5.2. Газрын тухай хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан төлөвлөгөө, шийдвэрт тусгагдсан, иргэдэд өмчлүүлэх газарт хамааралгүй бөгөөд тухайн иргэн газар өмчилж авах хүсэлт гаргасан тохиолдолд энэ хуулийн 5.1.2-т заасан төлөвлөгөө, шийдвэрт иргэдэд өмчлүүлэхээр тусгагдсан бөгөөд бусад эзгээдийн эзэмших, ашиглах эрх үүсэгүй байгаа газраас тэргүүн ээлжинд түүнд өмчлүүлэх;

5.1.6. иргэнд газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар газрыг өмчлүүлэхдээ:

5.1.6.1. иргэний хувийн хөрөнгөөр барьж байгуулсан, барьж байгаа буюу хувьчилж авсан, түүнчлэн Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай[3] хуульд заасан журмын дагуу өөрийн өмчлөлд шилжүүлж авсан барилга байгууламжид зориулан газрын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр зохих гэрээ байгуулж эзэмшүүлсэн газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг худалдаж түүнд өмчлүүлэх;

5.1.6.2. иргэний хувийн хөрөнгөөр шинээр барьж байгуулах, хууль заасан журмаар хувьчилж авах, түүнчлэн Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журмын дагуу өөрийн өмчлөлд шилжүүлж авах барилга байгууламжид зориулан өмчлөх газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа тохиолдолд дуудлага худалдаа явуулах замаар өмчлүүлэх.

5.1.7. газар тариалангийн зориулалтаар газар дээр газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхэлж байгаа иргэдэд дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хэлбэрээр өмчлүүлэх;

5.1.8. иргэнд газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэхдээ:

5.1.8.1. Газрын тухай хуульд заасны дагуу иргэний эзэмшсэн тариалангийн газар нь энэ хуулийн 5.1.3-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг давуу эрхээр үнээр нь худалдаж түүнд өмчлүүлэх;

[3] *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн*

5.1.8.2. Газрын тухай хуульд заасны дагуу тариалангийн газар эзэмшээгүй иргэн тариалангийн газар өмчилж авах хүсэлт гаргасан тохиолдолд уг газар нь энэ хуулийн 5.1.3-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байвал уг газрыг дуудлага худалдааны журмаар өмчлүүлэх.

5.2. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрх эдлэхгүй.

6 дугаар зүйл. Иргэнд өмчлүүлэх газар

6.1. Иргэнд газар тариалангийнхаас бусад зориулалтаар дараахь газрыг өмчлүүлнэ:

6.1.1. хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар / гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг/ , бэлчээр, ойн болон усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар, зам, шугам сүлжээний газраас бусад газарт;

6.2. Иргэнд газар тариалангийн зориулалтаар дараахь газрыг өмчлүүлнэ:

6.2.1. тариалангийн талбай болон аташрсан газарт.

7 дугаар зүйл. Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ

7.1. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран дор дурдсан хэмжээтэй байна:

Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын		
байршил		хэмжээ /га/
1	Нийслэлд	0.07 хүртэл га
2	Аймгийн төвд	0.35 хүртэл га
3	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га

7.2. Газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар иргэнд өмчлүүлэх газар нь дор дурдсан хэмжээтэй байна:

7.2.1. энэ хуулийн 5.1.6.1-д заасан газар нь түүний байршил, зориулалтаас хамааран тухайн барилга байгууламжид зориулан эзэмшүүлсэн газартай тэнцэх хүртэл хэмжээтэй;

7.2.2. энэ хуулийн 5.1.6.2-т заасан газар нь тухайн дуудлага худалдаагаар худалдсан газартай тэнцэх хэмжээтэй.

7.3. Газар тариалангийн зориулалтаар тухайн иргэнд өмчлүүлэх газар нь дор дурдсан хэмжээтэй байна:

7.3.1. энэ хуулийн 5.1.8.1-д заасан газар нь түүний байршил, үржил шимээс хамааран тухайн иргэнд эзэмшүүлсэн газартай тэнцэх хэмжээтэй;

7.3.2. энэ хуулийн 5.1.8.2-т заасан газар нь тухайн дуудлага худалдаагаар худалдагдсан газартай тэнцэх хэмжээтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэдэд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцаог зохицуулах талаархи төрийн байгууллага, нутгийн удирдлагын бүрэн эрх

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1. Улсын Их Хурал Үндсэн хуульд заасны дагуу иргэдэд өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааны талаархи төрийн нэгдсэн бодлогыг тодорхойлно.

9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1. Засгийн газар дараахь бүрэн эрхтэй:

9.1.1. иргэдэд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааны талаархи төрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

9.1.2. аймаг, нийслэлийн саналыг үндэслэн тухайн жилд улсын хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох;

9.1.3. иргэнд өмчлүүлэх газрын суурь үнэлгээ, аргачлалыг батлах;

9.1.4. иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах шийдвэр гаргах;

9.1.5. иргэнд өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх

журмыг батлах;

9.1.6. иргэний өмчийн газрын үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбогдсон үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;

9.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхтэй:

10.1.1. иргэдэд газар өмчлүүлэх талаархи төрийн нэгдсэн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх;

10.1.2. иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд нь бүх шатны Засаг даргыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах;

10.1.3. иргэдэд өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг нэгтгэх, өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ, заагийг сум, дүүрэг тус бүрээр нэгтгэн бүртгэх;

10.1.4. иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах асуудлыг Засгийн газрын нэрийн өмнөөс тухайн газар өмчлөгчтэй урьдчилан тохиролцох;

10.1.5. газар өмчилж авах тухай хүсэлт гаргах өргөдлийн загварыг батлах;

10.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

11.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

11.1.1. нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;

11.1.2. тухайн жилд аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг сум, дүүрэг тус бүрээр хэлэлцэх;

11.1.3. газар өмчлүүлэх ажлын явцад хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл энэ асуудлаар тухайн шатны Засаг даргын тайланг хэлэлцэх;

11.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

12.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

12.1.1. иргэдэд газар өмчлүүлэх талаархи төрийн нэгдсэн бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.1.2. сум, дүүргийн Засаг даргын саналыг хянаж нэгтгэн тухайн жилд аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээний тухай саналыг сум, дүүрэг бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт тус бүрээр боловсруулж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

12.1.3. аймгийн төвийн сумын Засаг дарга болон нийслэлийн дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэний газар өмчлүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах;

12.1.4. аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газар өмчилж авсан иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

12.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

13.1. Сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

13.1.1.нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэх;

13.1.2. сум, дүүргийн Засаг даргаас тухайн жилд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээний талаар ирүүлсэн саналыг хэлэлцэх;

13.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

14.1. Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

14.1.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

14.1.2. сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн жилд иргэдэд өмчлүүлэх газрын байршил, нийт хэмжээний тухай саналыг дүүргийн хувьд хороо бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт тус бүрээр, сумын хувьд баг, тосгон бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт бүрээр тус тус боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

14.1.3. аймгийн төвийн сумын болон нийслэлийн дүүргийн Засаг дарга иргэдийн газар өмчлөх хүсэлтийг хүлээн авч аймаг, нийслэлийн Засаг даргад уламжлах, бусад сумын Засаг дарга уг өргөдлийг хүлээн авч тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах;

14.1.4 өмчийнхөө газрыг бусдад эзэмшүүлэх, ашиглуулахаар гаргасан иргэний хүсэлтийг хүлээн авч бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох;

14.1.5. иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан сумын Засаг дарга газрыг нь хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах саналыг уламжлах;

14.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх

15.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

15.1.1.нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэхэн хэрэгжүүлж байгаа тухай баг, хорооны Засаг даргын мэдээллийг сонсох;

15.1.2. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

16 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

16.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

16.1.1. дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас иргэдийн газар өмчлөлийн асуудлаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

16.1.2. нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

16.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Иргэнд газар өмчлүүлэх

17 дугаар зүйл.Иргэнд өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа

17.1.Иргэнд газар өмчлүүлэхдээ тухайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийнэ.

17.2.Иргэнд өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага газрын хууль хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэж дүгнэлт гаргана.

17.3.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт нь газар өмчилж авсан иргэнд эрх бүхий байгууллагаас олгосон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний салшгүй хэсэг байна.

17.4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үзүүлэлт, арга члалтай холбогдсон асуудлыг Газрын тухай хуулийн 58 зүйлээр зохицуулна.

18 дугаар зүйл. Иргэнд өмчлүүлэх газрын үнийг тогтоох, түүнийг төлөх хугацаа, журам

18.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын үнийг газрын суурь үнэ, газрын үнэлгээний арга члалыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга тогтоно.

18.2. Иргэн энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалтаар өмчилж авсан газрын үнийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийн өмнө сум, дүүргийн төсөвт төлсөн байна.

19 дүгээр зүйл. Газар өмчлөн авах иргэний эрх, үүрэг

19.1.Газар өмчлөн авах эрх бүхий иргэн дараахь эрхтэй:

19.1.1.энэ хуульд иргэдэд өмчлүүлж болохоор заасан газраас өмчилж авах тухай өргөдлийг сум, дүүргийн Засаг даргад гаргах;

19.1.2. энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчилж авах;

19.1.3. энэ хуулийн 5.1.5.2-т заасан газрыг тэргүүн эзлэжинд үнэгүй өмчилж авах;

19.1.4. Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшээгүй иргэний энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар өмчилж авахыг хүссэн газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарагдаж байгаа бөгөөд уг газарт бусдын эзэмшил, ашиглах эрх үүсээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг даргад хүсэлт гаргасан дараалларын дагуу үнэгүй өмчилж авах;

19.1.5. энэ хуулийн 5.1.6.1-д заасан газрыг үнээр нь худалдан авах;

19.1.6. энэ хуулийн 5.1.8.1-д заасан газрыг давуу эрхээр үнээр нь худалдан авах;

19.1.7. энэ хуулийн 5.1.6.2, 5.1.8.2-т заасан газрыг дуудлага худалдаагаар өмчилж авах.

19.2.Газар өмчилж авах эрх бүхий иргэн дараахь үүрэгтэй:

19.2.1.Кадастрын зураглалын ба газрын кадастрын тухай[1] хуульд заасны дагуу газрын улсын бүртгэлийн кадастрын зураг хийлгүүлэх;

19.2.2.өмчлөлийн газрынхаа заагийг газар дээр тэмдэгжүүлүүлэх;

19.2.3.өмчилж авах газартаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх;

19.2.4. газар өмчилж авахтай холбогдсон энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх.

20 дугаар зүйл.Газар өмчилж авах тухай өргөдөл гаргах, түүнийг хянах

20.1.Иргэн газар өмчилж авах тухай өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

20.1.1.гэр бүлийн гишүүн бүрийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар;

20.1.2.оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, өмчилж авах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал;

20.1.3.өмчилж авах газрын зориулалт, хэмжээ;

20.1.4. энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалтаар өмчилж авах газрыг иргэд дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх бол энэ тухай хүсэлт;

20.2. Өргөдөлд өргөдөл гаргасан он, сар, өдрийг бичиж 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн бүр гарын үсэг зурсан байна.

20.3. Иргэн газар өмчилж авах тухай өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

20.3.1. гэр бүлийн 16 нас хүрээгүй гишүүний төрсний гэрчилгээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

20.3.2. гэр бүлийн ам бүлийн байдлын тухай баг, хорооны Засаг дарга /тосгоны захирагч/-ын тодорхойлолт;

20.3.3. Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшиж байгаа бол газар эзэмшил эрхийн гэрчилгээ, газар эзэмшил гэрээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

20.3.4. хүсэлт гаргасан газрын байршил, хэмжээг харуулсан тойм зураг /хэрэв

[1] *Кадастрын зураглалын ба газрын кадастрын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 1 дүгээрт нийтлэгдсэн*

газрыг дундаа хэсгээр өмчлөх бол өмчлөгч бүрийн хувьд оногдох газрын хэмжээ, байршил, заагийн тойм зураг/.

20.4. Сум, дүүрэгийн Засаг дарга өргөдлийг хүлээн аваад түүнд хүлээж авсан дараалал, он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэж гарын үсэг зурна.

20.5. Тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас иргэдэд өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээний талаарх зохих шийдвэр гарсны дараа иргэдээс газар өмчилж авах тухай хүсэлтийг хүлээн авна.

20.6. Иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг дарга газар өмчилж авах тухай иргэний гаргасан өргөдлийг хүлээж авсан өдрөөс хойш 3 сарын дотор хянан шийдвэрлэнэ.

21 дүгээр зүйл. Газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах

21.1. Иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг дарга иргэний гаргасан өргөдөл, тухайн иргэн энэ хууль заасны дагуу газрыг өмчилж авах эрх бүхий этгээд болохыг нотолсон үндэсэн дээр түүнд газар өмчлүүлэх тухай захирамж гаргана.

21.2. Захирамжид өмчлүүлэх газрын байршил, заагт, зориулалт, өмчлөгч /өмчлөгчид/-ийн овог, эцэг /эх/-ийнх нь болон өөрийнх нь нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, 16 нас хүрээгүй гэр бүлийн гишүүний хувьд төрсний гэрчилгээний дугаар, газрын үнэ, газар тариалангийн зориулалтаар газрыг дундаа хэгээр өмчилж авах бол дундаа хэсгээр өмчлөгч бүрт оногдох газрын хэмжээ, өмчлөгч бүрийн газрын заагийг тусгана.

22 дугаар зүйл. Иргэний газар өмчлөх эрхийг баталгаажуулах

22.1. Иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг даргын гаргасан шийдвэрийг үндэслэн иргэнд өмчлүүлсэн газрыг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгэж тухайн иргэн уг газрын хууль ёсны өмчлөгч мөн болохыг баталгаажуулсан Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ / цаашид "Улсын бүртгэлийн гэрчилгээ" гэх/-г үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагаас олгоно.

23 дугаар зүйл. Газар зохион байгуулалт хийж газрыг иргэний өмчид хүлээлгэн өгөх

23.1. Иргэнд өмчлүүлэх газарт кадастр хийсэн байна.

23.2. Иргэнд өмчлүүлэх газарт кадастр хийх, зохих шийдвэрийг үндэслэн газрыг өмчлөгчид нь хүлээлгэж өгөх, заагийг тогтоох, тэмдэглэх, бүртгэх ажилагаар сумын газрын даамал, дүүргийн газрын алба тус тус хариуцан гүйцэтгэнэ.

24 дүгээр зүйл. Иргэний газар өмчлөх эрхийн болон газар өмчлөх эрхтэй холбогдсон хөдөлгөөний бүртгэл

24.1. Иргэний газар өмчлөх эрхтэй холбогдсон хөдөлгөөний бүртгэлийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай[1] хууль заасан журмын дагуу хөтөлнө.

24.2. Иргэний хувийн өмчийн газрын заагийг газар дээр нь тогтоох, тэмдэглэх, заагийн өөрчлөлтийг бүртгэд тусгах, хянах үйл ажиллагааг сумын газрын даамал, дүүргийн газрын алба тус тус хариуцан гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл. Иргэний газар өмчлөх эрх үүсэх

25.1. Иргэнд өмчлүүлсэн газрыг энэ хуулийн 22.1-д заасны дагуу бүртгэснээр тухайн иргэний газар өмчлөх эрх үүснэ.

26 дугаар зүйл. Иргэний газар өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах

26.1.Иргэний газар өмчлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг Иргэний хууль, онцлог харилцааг энэ хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Иргэний газар өмчлөх харилцааны онцлог зохицуулалт

27 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэний эрх, үүрэг

27.1. Газар өмчлөгч иргэн дараахь эрхтэй:

27.1.1.бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр хуулиар олгогдсон хэмжээ, хязгаарын дотор өмчийнхөө газрыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

27.1.2.өмчийн газраа энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу бусдад эзэмшүүлэх, ашиглуулах;

27.1.3.өмчийнхөө газрыг зохих журмын дагуу иргэнд худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах;

27.1.4.өмчийн газрыг нийтийн эдэлбэр, тусгай хэрэгцээнд түр ашиглуулахад харилцан тохиролцсоны дагуу зохих төлбөр авах;

27.1.5.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн газрынхаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг гэр бүлийнхээ хэрэгцээнд ашиглах, уг газарт худаг гаргаж усыг нь ашиглах;

[1] *Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 3 дугаарт нийтлэгдсэн*

27.1.6. холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлагдсан стандарт, дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн өмчийнхөө газарт барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, ашиглах;

27.1.7. өмчийнх нь газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлж авсан тохиолдолд энэ хуульд заасны дагуу нөхөх олговор авах;

27.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, давуу эрх.

27.2. Газар өмчлөгч иргэн дараахь үүрэг хүлээнэ:

27.2.1.Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

27.2.2. газар тариалангийн газраа зориулалтаар нь ашиглах;

27.2.3. өмчилж авсан газраа кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд, өмчийн газраа бусад иргэдийн өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон бодлого бүртгүүлэх;

27.2.4.өмчийн газар дээр нь байрлуулсан заагийн болон геодезийн цэг, тэмдэгтийг хамгаалах, бүрэн бүтэн байлгах;

27.2.5. газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бусад этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироох, өмчийн газар дээрээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;

27.2.6.газрын төлөв байдал, чанарыг дордуулахгүй байх;

27.2.7.өмчийнхөө газрыг ашиглах явцад барилгын, экологийн, ариун цэврийн, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын болон бусад холбогдох стандарт, дүрэм, журам, шаардлагыг сахиж мөрдөх;

27.2.8.өмчийн газрынхаа газрын төлөв байдал, чанарын улсын хяналт баталгаат өөрийн зардлаар 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгүүлж байх;

27.2.9. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

28 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэнд хориглох зүйл

28.1.Газар өмчлөгч иргэнд дараахь зүйлийг хориглоно:

28.1.1.өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх;

28.1.2.өмчийн газраа энэ хуулийн 29.1-д заасан зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулах;

28.1.3.өмчийн газраа хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглах;

28.1.4. газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашиглах.

29 дүгээр зүйл. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах

29.1.Иргэн өмчийн газраа зориулалтаар нь, тодорхой хугацаагаар сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.

29.2. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл авах тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад бичгээр гаргана.

29.3. Энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтэд өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зориулалт, хугацаа зэргийг заажи, 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн бүр буюу бусад хамтран дундаа эзэмшигч бүр гарын үсэг зурна.

29.4.Энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтэд иргэний өмчийн газраа эзэмшүүлэх, ашиглуулах талаар тухайн газрыг эзэмших, ашиглах этгээдтэй байгуулсан, нотариатчаар гэрчлүүлсэн гэрээний эх хувийг хавсаргана.

29.5. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор зөвшөөрөл өгөх эсэхийг шийдвэрлэнэ.

29.6. Иргэний өмчийн газрыг эзэмших, ашиглах этгээд нь энэ хууль, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай[1], Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай[2], Байгаль орчныг хамгаалах тухай хууль[3] зэрчиж байсан бол, түүнчлэн тухайн газарт хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулж болзошгүй нь тогтоогдвол сум, дүүргийн Засаг дарга зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.

29.7. Иргэний өмчийн газрыг эзэмших, ашиглаж буй этгээд нь энэ хууль, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг зөрчсөн, түүнчлэн тухайн газарт хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулбал сум, дүүргийн Засаг дарга

[1] Газрын төлбөрийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны дугаарт нийтлэгдсэн
[2] Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 45 дугаарт нийтлэгдсэн
[3] Байгаль орчныг хамгаалах тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн

олгосон зөвшөөрлөө хүчингүй болгоно.

29.8. Сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөл олгохтой холбогдсон гомдлыг шүүх шийдвэрлэнэ.

29.9.Иргэний өмчийн газрыг гэрээний үндэсэн дээр хөлсөлж, түрээсэлх байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно.

30 дугаар зүйл. Иргэн өмчийн газраа нийтийн эдэлбэр, тусгай хэрэгцээнд түр ашиглуулах

30.1.Иргэн өмчийн газраа Засгийн газар, аймаг, нийслэл, сумын Засаг даргатай урьдчилан тохиролцсоны үндэсэн дээр гэрээ байгуулан тодорхой хугацаагаар нийтийн эдэлбэр болон улсын, аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд түр ашиглуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Газар өмчлөх эрх дуусгавар болох, газар өмчлөгчийн эрхийг хязгаарлах

31 дүгээр зүйл. Иргэний газар өмчлөх эрх дуусгавар болох

31.1.Иргэний газар өмчлөх эрх дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

31.1.1.өмчийн газраа бусад иргэний өмчлөлд шилжүүлснээр;

31.1.2.газар өмчлөх эрхээсээ татгалзсанаар;

31.1.3.газар өмчлөгч иргэн Монгол Улсын харьяатаас гарсанаар,

31.1.4.хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

32 дугаар зүйл. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах

32.1. Улсын дор дурдсан тусгай хэрэгцээг үндэслэн иргэний өмчийн газрыг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авч болно:

32.1.1.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах;

32.1.2.шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай байгуулах;

32.1.3. улсын чанартай зам, шугам сүлжээ, барилга байгууламж барих.

32.2.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана.

32.3. Иргэний өмчийн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрт газрыг зайлшгүй солих, эргүүлэн авах болсон зориулалт, үндэслэлийг тодорхой заана.

32.4. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргахаас нэгээс доошгүй жилийн өмнө газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар өмчлөгчтэй энэ тухай урьдчилан тохиролцох байна.

32.5. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад газар өмчлөгч болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь асуудлыг урьдчилан тохиролцоно:

32.5.1. газрын үнэ;

32.5.2. тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэ;

32.5.3. өмчлөгчөөс уг газарт зарцуулсан хөрөнгө, газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авснаас өмчлөгчид учрах хохирлын хэмжээ;

32.5.4.улсын тусгай хэрэгцээнд авах газрын хэмжээ;

32.5.5.улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг сольж олгох газрын байршил, хэмжээ, төлөв байдал, чанар;

. . . . . .

32.5.6.газрыг чөлөөлөх нөхцөл, хугацаа;

32.5.7.газрыг чөлөөлөхтэй холбогдон талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

32.5.8.нөхөх олговрын хэмжээ, түүнийг төлөх журам, хугацаа.

32.6. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авахад газар өмчлөгчид олгох нөхөх олговрыг улсын төсөвөөс гаргана.

32.7.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай асуудлыг энэ хуулийн 32.4, 32.5-д заасны дагуу тохиролцож чадаагүй бол маргааныг шүүх шийдвэрлэнэ.

33 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэний эрхийг хязгаарлах эрх /сервитут/

33.1.Сум, дүүргийн Засаг дарга улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэнд өмчлүүлсэн газарт дор дурдсан нийтийн сервитут тогтоож болно:

33.1.1.уг газраар дамжин өнгөрөх;

33.1.2.уг газарт газрын зааглийн болон геодезийн байгнын цэг, тэмдэгт тавих;

33.1.3. намагжилтыг багасгах ажил гүйцэтгэх;

33.1.4.газар зохион байгуулалтын

бусад арга хэмжээ хэрэгжүүлэх.

33.2.Нийтийн сервитут нь байгуйн буюу түр байж болно.

33.3.Нийтийн сервитут нь газар өмчлөгч иргэнд аль болох бэрхшээл учруулахааргүй байна.

33.4.Өмчийн газарт нь нийтийн сервитут тогтоосноос газар өмчлөгч иргэн газраа ашиглах боломжгүй буюу ашиглахад хүндрэл бэрхшээлтэй болох тохиолдолд газар өмчлөгч иргэн нь уг газрыг худалдан авахыг, мөн түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх болон уг хүндрэл бэрхшээлтэй дүйцэхүйц хэмжээний хөлс төлөхийг нийтийн сервитут тогтоосон эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

33.5.Өмчийн газарт нь нийтийн сервитут тогтоосноос болж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь энэ хуулийн 33.3, 33.4-т зааснаар хөндөгдсөн газар өмчлөгч иргэн шүүхээр өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулж болно.

33.6.Газар өмчлөгч иргэн өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч бусад иргэний эрхийг хязгаарлах /хувийн сервитут/-тай холбогдсон харилцааг Иргэний хууль тогтоомжоор зохицуулна.

33.7.Иргэний газар өмчлөлтэй холбогдсон хувийн, нийтийн сервитутийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэнэ.

33.8. Хувийн сервитут Иргэний хууль тогтоомжид заасан үндэслэлээр дуусгавар болно.

33.9.Нийтийн сервитут тогтоогдсон шаардлага хэрэгцээгүй болсон бол түүнийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэрээр дуусгавар болно.

34 дүгээр зүйл. Иргэний өмчийн газрыг дайчлан авах

34.1.Олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулахуйц газар хөдлөлт, хүчтэй салхи, ган зуд, үер болсон, түймэр, хүн, мал амьтны гоц халдварт өвчин гарсан зэрэг байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон, үйлдвэрийн томоохон осол гарсан, цацраг идэвхит болон химийн хорт бодис алдагдсан зэрэг гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд түүний аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг хамгаалах, аврах, хор уршгийг нь арилгах арга хэмжээнд зориулан иргэний өмчийн газрыг хуульд заасан журмын дагуу нийслэл, аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр түр хугацаагаар дайчлан авч болно.

34.2. Дайчлан авсны үлмаас газар өмчлөгч иргэнд учирсан хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

34.3.Дайчлан авсан газрыг эргүүлэн өгөх боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчид нь уг газрын үнэ, хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх буюу дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлнө.

34.4. Дайчлан авсан иргэний өмчийн газрын үнэ, газар өмчлөгч иргэнд учирсан хохирлын хэмжээг тогтоохтой холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл. Иргэний өмчийн газрыг хураах

35.1.Газар өмчлөгч иргэн буюу түүний газрыг энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу зээмшиж, ашиглаж байгаа этгээд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол шүүхийн жүрмаар түүний газрыг хураан авч болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Иргэний газар өмчлөх эрхийн баталгаа

36 дугаар зүйл. Иргэний газар өмчлөх зөрчигдсөн эрхийг сэргээх

36.1.Иргэний газар өмчлөх эрх зөрчигдсөн бол түүнийг шүүхийн жүрмаар сэргээн тогтооно.

36.2.Иргэний газар өмчлөх эрхийг сэргээн тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэр нь уг газрыг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгэх, эрх нь сэргээгдсэн иргэнд улсын бүртгэлийн гэрчилгээ олгох хууль зүйн үндэслэл болно.

36.3.Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль тогтоомжид нийцээгүй, иргэний газар өмчлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан байгууллага нөхөн төлнө.

36.4.Газар өмчлөх эрхийг нь зөрчсөн этгээд иргэнд учруулсан хохирлыг түүний дотор олох байсан орлогыг нь оролцуулан иргэний хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

37 дугаар зүйл. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах үед иргэний газар өмчлөх эрхийн баталгаа хангах

37.1.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах ажлыг дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа гүйцэтгэнэ:

37.1.1.өмчийн газрыг нь сольж байгаа тохиолдолд иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байсан газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй газар түүнд өмчлүүлэх;

37.1.2.газрыг нь эргүүлэн авч байгаа тохиолдолд газрынх нь үнийг төлөх;

37.1.3.иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх;

37.1.4.өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх;

37.1.5.газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авснаас өмчлөгчид учруулах хохирлыг иргэний хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх.

37.2.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргахаас нэг жилээс доошгүй хугацааны өмнө газар өмчлөгчид бичгээр мэдэгдэнэ.

37.3.Энэ хуулийн 37.2-т заасан мэдэгдлийг газар өмчлөгч хүлээн авснаас хойш нэг жил болсон, энэ хуулийн 37.1-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа улсын тусгай хэрэгцээг үндэслэн иргэний өмчийн газрыг солих буюу эргүүлэн авна.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш барьж байгуулсан үл хөдлөх эд хөрөнгө, газрын үнийг мэдэгдэхүйц өсгөсөн бусад арга хэмжээний зардлыг нөхөн олгохгүй.

38 дугаар зүйл. Газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох

38.1.Иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бусад этгээд аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно.

39 дүгээр зүйл. Гомдол гаргах

39.1. Иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, албан тушаалтан хууль бусаар саад учруулсан гэж үзвэл тухайн байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргана.

39.2. Гомдлыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж иргэнд бичгээр хариу өгнө.

39.3. Иргэн энэ хуулийн 39.2-т заасан хугацаанд хариу аваагүй бол гомдлоо шүүхэд гаргана.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

40 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч буюу газрын хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

40.1.1. энэ хуулийн 19.2, 27.2.1-д заасныг зөрчсөн иргэнийг 10 000 – 20 000 төгрөгөөр торгох;

40.1.2. энэ хуулийн 27.2.3, 27.2.4, 27.2.6-д заасныг зөрчсөн иргэнийг 30 000 – 50 000 төгрөгөөр торгох;

40.1.3. энэ хуулийн 27.2.7, 27.2.8-д заасныг зөрчсөн иргэнийг 20 000 – 30 000 төгрөгөөр торгох.

40.2. Энэ хуулийн 38 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтанд шүүгч 50 000 – 60 000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

41 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

41.1. Энэ хуулийг 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

41.2. Энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх тухай энэхүү хуулийн 19.1.2, 19.1.3, 19.1.4 дэх заалтыг 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2005 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийнхээ хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилж авах Монгол Улсын иргэдийн гэр бүлийн бүртгэлийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг баталсан өдрөөр тооцно.

2 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсан өдөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн захиргаанд бүртгэлгүй иргэд холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэний бүртгэлийн асуудлаа шийдвэрлүүлсний үндсэн дээр гэр бүлийнхээ хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлөн авах эрхээ эдэлнэ.

3 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19.1.2-т заасны дагуу Монгол Улсын иргэнд нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх газрын байршлыг тогтоох асуудлыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

1/ нийслэлд бүртгэлтэй иргэн нийслэлд буюу аль ч аймаг, сумын газарт;

2/ Дархан, Эрдэнэт хотод бүртгэлтэй иргэн тухайн хотдоо буюу нийслэлээс бусад аль ч аймаг, сумын газарт;

3/ энэ зүйлийн 1, 2 дахь заалтад зааснаас бусад иргэд нийслэл, Дархан, Эрдэнэтээс бусад аль ч аймаг, сумын газарт.

4 дүгээр зүйл. Иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх арга хэмжээг 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2 жилд хэрэгжүүлж дуусгавар болгоно.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Иргэний хууль" гэсний дараа "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу иргэн гэр бүлийнхээ хэрэгцээний зориулалтаар өмчлөн авсан газрыг анхны удаа үл хөдлөх эд хөрөнгийн байгуулагад бүртгүүлэхэд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө".

2/ 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалт:

"3/ өмчийн газрын кадастрын зураг."

3 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн дугаарыг 4, 5 гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж

2.1.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид зааснаас бусад харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Чөлөөт бүс, түүний хэлбэр

3.1."Чөлөөт бүс" гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.

3.2.Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна.

3.3.Худалдааны чөлөөт бүсэд бараа, бүтээгдэхүүний мөн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав баглаа, боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

3.4. Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд тэргүүний, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

3.5. Хөдөө аж ахуйн чөлөөт бүсэд газар тариалан, мал аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

3.6.Аялал жуулчлал-үйлчилгээний чөлөөт бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээ эрхэлнэ.

3.7. Эдийн засгийн чөлөөт бүсэд энэ хуулийн 3.3-3.6-д заасан үйл ажиллагаагаас хосолсон бүюу нэгтгэсэн байдлаар эрхэлнэ.

4 дүгээр зүйл. Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэм

4.1.Чөлөөт бүсэд татварын хөнгөлөлттэй нөхцөл, аж ахуйн нэгжийн бүртгэлийн хөнгөвчилсөн журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим үйлчилнэ.

4.2. Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг чөлөөт бүсэд зөвхөн гаалийн хяналт бүхий гарцаар нэвтрүүлнэ. Чөлөөт бүсэд гаалийн хяналт тавих журмыг гаалийн удирдах төв байгууллага батална.

4.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараог чөлөөт бүсэд нэвтрүүлэхийг хоригломо .

4.4. Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифийн бус хязгаарлалт тогтоохгүй.

4.5.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар хийнэ. Чөлөөт бүсэд валютын зохицуулалтын тусгай журам үйлчилнэ. Валютын зохицуулалтын журмыг Монголбанк тогтооно.

5 дугаар зүйл. Чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах

5.1.Монгол Улсад чөлөөт бүс байгуулах түүний хэлбэр, байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн заагийг тогтоох, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

[1] *Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Чөлөөт бүсийн удирдлага

6 дугаар зүйл. Чөлөөт бүсийн захирагч

6.1.Чөлөөт бүсийн захирагч нь чөлөөт бүсэд төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.

6.2. Чөлөөт бүсийн захирагчийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

6.3.Чөлөөт бүсийн захирагч ажлаа Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө хариуцна.

6.4.Чөлөөт бүсийн захирагч ажлын албатай байна. Ажлын албаны орон тоо, цалингийн санг чөлөөт бүсийн үйл ажиллагааны хүрээ, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан Засгийн газар тогтооно.

6.5.Чөлөөт бүсийн захирагч тогтоосон загварын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7 дугаар зүйл. Чөлөөт бүсийн захирагчийн бүрэн эрх

7.1.Чөлөөт бүсийн захирагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар чөлөөт бүсийг төлөөлөх, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах;

7.1.2.чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, тесвийн төслийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.3.чөлөөт бүсэд хөрөнгө оруулах, үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх;

7.1.4.чөлөөт бүсийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх

7.1.5.чөлөөт бүсийн ажиллах хүчний болон хөдөлмөр зохицлтийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

7.1.6.чөлөөт бүсэд ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх хүсэлтийг хянан шийдвэрлэх;

7.1.7.хууль тогтоомжийн дагуу чөлөөт бүсэд олгосон газар, төрийн өмчийн барилга, байгууламжийг ашиглуулах тухай шийдвэр гаргаж, тэдгээрийн ашиглалтад тавих хяналтыг хэрэгжүүлэх;

7.1.8.чөлөөт бүс дэх мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагаат уялдуулан зохицуулах;

7.1.9.чөлөөт бүсийн ерөнхий менежер, ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;

7.1.10.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох;

7.1.11.чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдын зөвлөл, хувийн хэвшлийн байгуллагатай идэвхтэй хамтран ажиллах,

7.2.Чөлөөт бүсийн захирагч энэ хуулийн 7.1.3-т заасан чиг үүргээ аж ахуйн нэгжээр гэрээний үндэсэн дээр гүйцэтгүүлж болно.

7.3. Чөлөөт бүсийн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээнд, хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана. Чөлөөт бүсийн захирагчийн захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл Ерөнхий сайд өөрчлөх буюу хүчингүй болгоно.

8 дугаар зүйл. Чөлөөт бүсийн ерөнхий менежер

8.1.Чөлөөт бүсийн ерөнхий менежер нь чөлөөт бүсэд аж ахуйн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан мөн.

8.2.Чөлөөт бүсийн ерөнхий менежер нь чөлөөт бүсийн нийгэм, соёл, ахуйн үйлчилгээ, хот тохижилт, газар зохион байгуулалтын асуудлыг харицуулах бөгөөд эдгээр арга хэмжээг хөрөнгө оруулагчдын зөвлөл, нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндэсэн дээр хэрэгжүүлнэ.

8.3.Чөлөөт бүсийн ерөнхий менежер ажлаа чөлөөт бүсийн захирагчид тайлагнаж, чөлөөт бүс дэх хөрөнгө оруулагчдын зөвлөлд дараахь чиглэлээр танилцуулна:

8.3.1.чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, түүний хэрэгжилт;

8.3.2. хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт;

8.3.3.чөлөөт бүсийн гадаад хамтын ажиллагааны зарим асуудал.

8.4.Чөлөөт бүсийн ерөнхий менежер тогтоосон загварын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9 дүгээр зүйл. Чөлөөт бүс дэх мэргэжлийн хяналтын алба

9.1.Чөлөөт бүсэд мэргэжлийн хяналтын бие даасан алба ажиллана. Мэргэжлийн хяналтын албаны орон тоо, зохион байгуулалтыг чөлөөт бүсийн хэлбэр, байршил, үйл ажиллагааны онцлогоос хамааруулан Засгийн газар тогтоно.

10 дугаар зүйл. Чөлөөт бүс дэх хөрөнгө оруулагчдын зөвлөл

10.1.Чөлөөт бүс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтыг татах, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн хөрөнгө оруулагчдын зөвлөл /цаашид "чөлөөт бүсийн зөвлөл" гэх/-тэй байж болно.

10.2.Чөлөөт бүсийн эзэмшлийн хугацаа батлагдсан дүрмээр тогтоно.

11 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн төсөв

11.1.Чөлөөт бүсийн төсвийг Засгийн газраас ерөнхий мэдүүлснийг үндэслэн төвлөрсөн төсвийн төсөвт оруулна.

11.2.Чөлөөт бүсийн төсвийг Засгийн газраас ерөнхий мэдүүлснийг дагуу улсын төвлөрсөн төсвийн төсөвт зүйл бүлгөн Улсын Их Хурал батална.

11.3.Чөлөөт бүсийн төсвийн орлого дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

11.3.1.чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж;

11.3.2.чөлөөт бүсийн эзэмшлийн газар, байгалийн баялаг, төрийн өмчийн барилга, байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;

11.3.3.чөлөөт бүс байгууллахад зориулж улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс чөлөөт бүсийн төсөвт хуваарилсан төсвийн санхүүжилт;

11.3.4.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тусламж, хандив;

11.3.5.чөлөөт бүсийн төсөвт орох бусад орлого.

11.4.Чөлөөт бүсийн төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлнэ.

11.4.1.урсгал зардал;

11.4.2.бусдад үзүүлэх үйлчилгээний зардал;

11.4.3.чөлөөт бүсийн харуул хамгаалалтын зардал;

11.4.4.мэргэжлийн хяналтын албаны зардал.

11.5.Чөлөөт бүсийн төсвийн ерөнхийлөн захирагч нь чөлөөт бүсийн захирагч байна.

12 дугаар зүйл. Чөлөөт бүсийн захирагчаас орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,Засаг даргатай харилцах

12.1.Чөлөөт бүсийн захирагч нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэжүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлж, дараахь чиглэлээр хамтран ажиллана:

12.1.1.иргэний бүртгэл мэдээлэл, шилжих хөдөлгөөнийг зохицуулах;

12.1.2.орон нутгийн нийгэм, соёл, аюйн үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.3.орон нутгийн хүн амын хөдөлмөр зохицлыг, амьжиргааны түвшинг дээшлүүлэх;

12.1.4.газрын төлбөрийн орлогын тодорхой хэгийг орон нутгийн төсөвт оруулах. Чөлөөт бүсийн төсөөс орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээг Засгийн газар тогтоно.

12.1.5.газар, түүний баялаг, түүх, соёлын дурсгалт зүйлсийг зохистой ашиглах, хамгаалах;

12.1.6.чөлөөт бүс, аймаг, орон нутгийн нийтлэг ач холбогдолтой үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Чөлөөт бүсэд аж ахуй эрхлэх

13 дугаар зүйл. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг бүртгэх

13.1.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж бүртгүүлэхдээ дараахь шаардлагыг хангасан байна:

13.1.1. чөлөөт бүсэд эрхлэх, татварын хөнгөлөлтөд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ нь тухайн чөлөөт бүсийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлд нийцэх;

13.1.2.чөлөөт бүсэд эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь үндэсний болон олон улсын стандартад нийцсэн дэвшилтэт арга, технологи эзэмшиж;

13.1.3.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулах.

13.2.Чөлөөт бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлэхээр холбогдох бичиг баримтыг өгнө:

13.2.1.аж ахуйн нэгжийн зохион байгуулалтын хэлбэр, оноосон нэр, оршин байх газар, улсын харьяалал, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, хэмжээ, хөрөнгө оруулах үндсэн чиглэл, эрхлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэрэжүүлэх хугацаа, үе шатыг заасан эрх бүхий этгээдийн өгөгдөл;

13.2.2.үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

13.2.3.үүсгэн байгуулагч нь иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, товч намтар;

13.2.4.шаардлагатай бол аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл;

13.2.4.гэрээ, дүрэм;

13.2.5.шинээр байгуулах аж ахуйн нэгжийн хувьд онооосон нэрийн зөвшөөрөл."

13.3.Чөлөөт бүсийн захирагч ерөгдлийг хүлээн авч хянан үзээд хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл тухайн аж ахуйн нэгжийн ерөгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.

14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийг бүртгэх

асуудлаар бүсийн захирагчийн бүрэн эрх

14.1.Чөлөөт бүсийн захирагч аж ахуйн нэгжийн бүртгэлтэй холбогдсон асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.аж ахуйн нэгжийг хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулсан эсэхийг хянах;

14.1.2.бүртгүүлсэн өдрөөс нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, эсхүл түүнтэй холбогдсон бэлтгэл ажлаа эхлээгүй, үйл ажиллагаагаа эхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар ажиллагаа нь тасалдсан тохиолдолд улсын бүртгэлээс хасах;

14.1.3.дараахь үндэслэл байвал аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж болно:

14.1.3.1. хуульд заасан журмын дагуу гэрээ, дүрмээ батлаагүй;

14.1.3.2.үйл ажиллагаа нь чөлөөт бүсийн хэлбэрт тохироогүй;

14.1.3.3. оносон нэр давхардсан;

14.1.3.4. үүсгэн байгуулагч иргэн эрх зүйн чадамжгүй.

15 дугаар зүйл. Чөлөөт бүсэд эрхлэх аж ахуйн үйл ажиллагаа

15.1.Чөлөөт бүсэд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагаар эрхэлж болно. Чөлөөт бүсэд, түүний хэлбэрээс үл шалтгаалан үйлдвэрлэл, нийгэм, зах зээлийн дэд бүтцийн бүх төрлийн үйлчилгээ явуулж болно.

15.2. Хуулиар хориглосон аж ахуйн үйл ажиллагааг чөлөөт бүсэд эрхлэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Газрын харилцаа

16.1.Чөлөөт бүсэд олгох газрын хэмжээ, хилийн заагийг тогтоох асуудлыг Засгийн газар тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөж, холбогдох төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

16.2.Газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн захирагч гарган түүний ажлын алба газар эзэмшигч буюу ашиглагчтай гэрээ байгуулна. Шийдвэрт эзэмших, ашиглах газрын хэмжээ, хугацаа тогтооно.

16.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулсны төлбөрийг Газрын төлбөрийн тухай Монгол Улсын хууль[2]-д заасан бүүрь үнэлгээг үндэслэн, чөлөөт бүс тус бүрт түүний байршил, үйл ажиллагааны төрлөөс хамааруулан Засгийн газар тогтоож болно.

17 дугаар зүйл. Чөлөөт бүсэд татвар ногдуулах, татвараас чөлөөлөх

17.1.Чөлөөт бүсэд бараа оруулахад дараахь албан татварыг ногдуулах болон татвараас өлөөлнө:

17.1.1. Чөлөөт бүсэд бараг хилийн чанадаас оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;

17.1.2. импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан бараг чөлөөт бүсэд оруулахад экспортын гаалийн албан татвар ногдуулахгүй.

17.1.3. монголын бараг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгоно. .

17.2. Чөлөөт бүсээс бараа гаргахад дараахь албан татварыг ногдуулах болон албан татвараас чөлөөлнө:

17.2.1.бараг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн, онцгой албан татвар ногдуулна;

17.2.2.энэ хуулийн 17.1.2-т заасан бараг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй.

17.2.3.монголын бараг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад импортын гаалийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Энэ тохиолдолд экспортын гаалийн татварыг буцаан олгож, нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулна.

17.2.4.чөлөөт бүсээс бараг хилийн чанадад гаргахад экспортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Хуулиар тусгайлан ногдуулсан бол экспортын албан татвар ногдуулна.

17.3. Энэ хуулийн 17.1, 17.2-т зааснаас бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх асуудлыг чөлөөт бүсийн байршил, хэлбэрийг харгалзан хуулиар тогтооно.

17.4. Чөлөөт бүсэд газар ашиглах, эзэмших гэрээ байгуулсан дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, эзэмших, хамгаалах талаар хүлээсэн үүргэ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлөх буюу чөлөөлж болно.

17.6.Газрын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх хугацаа, хувь хэмжээ тогтоох асуудлыг Засгийн газрын санал болгосноор Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл. Чөлөөт бүсийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх

18.1. Чөлөөт бүс нь улсын онцгой объектод хамаарна.

18.2.Чөлөөт бүсийн харуул хамгаалалт, чөлөөт бүсэд шалган нэвтрүүлэх үүргийг дотоодын цэрэг гүйцэтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

Газрын төлбөрийн тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 5 дугаарт нийтлэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28–ны өдөр **Улаанбаатар хот**

"АЛТАНБУЛАГ" ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс (цаашид "Алтанбулаг" бүс гэх)-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. "Алтанбулаг" бүсийн тухай хууль тогтоомж

2.1."Алтанбулаг" бүсийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, энэ хууль болон здгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. "Алтанбулаг" бүсийн нутаг дэвсгэр

3.1."Алтанбулаг" бүс нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Их Хурлаас тогтоосон хилийн заагт бүхий газар нутагтай байна.

4 дүгээр зүйл. Орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх, албан татвараас чөлөөлөх

4.1. "Алтанбулаг" бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.

4.2."Алтанбулаг" бүсэд агуулахын аж ахуй, ачих буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

4.3."Алтанбулаг" бүсэд бараа, бүтээгдэхүүний хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа, 10 болон түүнээс дээш жил ажилласхаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

4.4."Алтанбулаг" бүсийн захирагчийн ажлын албанд бүртүүлэн чөлөөт бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлнө.

4.5. "Алтанбулаг" бүсийн захирагчийн ажлын албанд бүртүүлэн бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа үл хөдлөх эд хөрөнгийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд худалдан борлуулсан тохиолдолд ногдох орлогын албан татвараас чөлөөлнө.

5 дугаар зүйл. Газрын төлбөрийн хөнгөлөлт

5.1."Алтанбулаг" бүсэд дараахь чиглэлээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ:

5.1.1.худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 3 жилд газрын төлбөрөөс чөлөөлөх, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө;

5.1.2.Энэ хуулийн 4.1, 4.2-т заасан "Алтанбулаг" бүсийн үндсэн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С. ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28–ны өдөр **Улаанбаатар хот**

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтын дараа ""Чөлөөт бүсийн харилцааг зохицуулсан хуульд энэ заалт хамаарахгүй" гэсэн өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр — Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллаганы тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд дараахь агуулгатай 8.2 дахь заалт нэмсүгэй:

"8.2. Энэ хуулийн 8.1.3 дахь заалт нь чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид хамаарахгүй."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр — Дугаар 28 — Улаанбаатар хот

Газрын тухай хууль хэрэгжүүлэх бэлтгэлийг ханган тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган зорилгоор дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ Газрын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг ханган хүрээнд тодорхой үе шаттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;

2/ холбогдох эрх зүйн актыг Газрын тухай хуульд нийцүүлэн 2002 онд багтаан шинэчлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо /Ш.Гунгаадорж/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 37 — Улаанбаатар хот

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг ханган зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхэд шаардагдах газрын кадастрын зураглал болон газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат бэлтгэх, газрын нэгдмэл сангийн бүртгэл, судалгаат шинэчлэх, холбогдох газар зохион байгуулалтын арга хэмжээг авах, түүнчлэн Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээ, иргэдийн бүртгэл, судалгаа бүхий бэлтгэл ханган тодорхой үе шаттай төлөвлөгөөг аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр гаргаж хэрэгжүүлэх;

2/газар, үл эд хөдлөх хөрөнгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тэдгээрийн эрхлэх ажил, чиг үүргийг шинэчлэх асуудлыг шийдвэрлүүлэх;

3/ холбогдох журам, дүрэм, маягт, загварыг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нийцүүлэн 2002 онд багтаан батлан гаргах, шинэчлэх;

4/ одоогоор газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшиж, ашиглах эрх, түрээс хүчин төгөлдөр байгаа эсэхийг нэгбүрчлэн шалгаж

тогтоох, холбогдох хууль тогтоомж зөрчиж зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан, газрыг зориулалт бусаар буюу тогтоосон хэмжээнээс илүү газрыг эзэмшиж, ашиглаж байгаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн асуудлыг цэгцлэх, хохирлыг нөхөн төлүүлэх болон газрыг чөлөөлүүлэх асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

5/ үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл болон улсын газрын мэдээллийн санг бэхжүүлэх, нэгдсэн сүлжээнд хамруулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, газар өмчлүүлэх ажлын бэлтгэл болон түүний хэрэгжилтийн талаарх газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөлийн тайланг хагас жил бүр хэлэлцэж байхыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо /Ш.Гунгаадорж/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 38** **Улаанбаатар хот**

"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс байгуулах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 5.1-ийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт Монгол Улсын Их Хурлын 1996 оны 66 дугаар тогтоолоор хилийн зэргийг тогтоосон 500 га газарт "Алтан булаг" худалдааны чөлөөт бүс байгуулахаар тогтоосугай.

2."Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг ханган хатгахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/ -т даалгасугай:

1/бүсийн хөгжлийн ерөнхий төсөл / мастер төлөвлөгөө/ боловсруулж энэхий зэлжинд хэрэгжүүлэх төслүүдийг сонгох;

2/эхний ээлжийн төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж эхлэх;

3/эхний ээлжинд хэрэгжүүлэх төслийн талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хийх;

4/ үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтцийг бүрдүүлэх эхний ээлжийн арга хэмжээг 2002 онд багтаан хэрэгжүүлж эхлэх;

5/ "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын албыг 2002 оны III улиралд багтаан эмхлэн байгуулах;

6/ гадаад улсын чөлөөт бүсийн туршлага судлах, мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэх тодорхой арга хэмжээ авах;

7/чөлөөт бүсийн асуудлаар ҮХҮ, БНХАУ-ын Засгийн газрын холбогдох байгууллагадтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах.

3.Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эргэтгэж Сүхбаатар-Алтанбулагийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, холбогдох саналаа Улсын Их Хуралд хэлэлцүүлэхийг шийдвэрлүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо/Т.Очирхүү/-нд даалгасугай

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4-ны өдөр **Дугаар 40** **Улаанбаатар хот**

Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

Монгол Улсын Засгийн газраас 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр | Дугаар 44 | Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтын 11 дүгээр бүлгийн 11.01, 11.02 дахь заалтын "8-р сарын 1" гэснийг "7 дугаар сарын 1" гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2002 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4–ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

Газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Газар өмчлүүлэх ажлын бэлтгэл хангах, энэхүү ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан дараахь гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- Байгаль орчны сайд,
- Санхүү, эдийн засгийн сайд,
- Үйлдвэр, худалдааны сайд,
- Хүнс, хөдөө аж ахуйн сайд,
- Дэд бүтцийн дэд сайд,
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд,
- Үндэсний статистикийн газрын дарга,
- Төрийн өмчийн хорооны дарга,
- Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга,
- Нийслэлийн Засаг дарга.

2.Аймаг, нийслэлийн хэмжээнд ажиллах салбар зөвлөлийг тухайн шатны Засаг даргаар ахлуулан ажиллуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд газар өмчлөгч иргэн буюу түүний газрыг эзэмшиж, ашиглаж байгаа этгээд тухайн газрыг газаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан тохиолдолд түүний газрыг хураах асуудлыг шүүхэд нэхэмжлэл гаргаж иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар зохицуулахаар заасантай зөрчилдөж байгаар үндэслэн тухайн хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 48** **Улаанбаатар хот**

2002 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2002 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ Монгол Улсын 2003 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл;

2/ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/ Байгаль орчны төлөв байдлын 2001 оны тайлан;

5/ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/ Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Газрын төлбөрийн тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төсөл;

8/ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдааг зохицуулах хуулийн болон Аж ахуйн үйл ажиллагааны туслай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай хуулийн төсөл;

9/ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл;

10/. Арбитрын тухай хуулийн төсөл;

11/ Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн төсөл;

12/ Мансуурлын хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн төсөл;

13/ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

14/ Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

15/ зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

16/ бусад.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр төсөл санаачлагчдаас санал болгосон болон шаардлагатай гэж үзсэн бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2002 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлбэл энэ оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

3. Улсын Их Хурлын 2002 оны намрын чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Д.Батбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Б.Шаравсамбуугийн хүсэлтийг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос чөлөөлж, Төсвийн байнгын хорооны гишүүнээр батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн захиргааны албаны орон тооны гишүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж байгаатай холбогдуулан Халтарын Шаандарыг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

тооны гишүүнээр Багаажавын Өнөбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Дугаар 53 Улаанбаатар хот

Нөхөн сонгууль зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 36 дугаар тойрог дахь нөхөн сонгуулийг 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 36 дугаар тойрог дахь нөхөн сонгуулийн санал хураалтыг 2002 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Дугаар 54 Улаанбаатар хот

Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хороонооос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 36 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийг улсын төвөрсөн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 8324686 төгрөгөөр тогтоож, сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөцөөс санхүүжүүлэхийг Засгийн газар /Энхбаярт/-т даалгасугай.

2. Энэ тогтоолыг 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргыг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Жамбын Норовсамбуу Монгол Улсын

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 5.2 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (265)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай*
- *Төрийн албаны тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны долдугаар сарын 26 №28 (265)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

348. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай (2002-7-4-ний хууль) 886
349. Төрийн албаны тухай (2002-7-4-ний хууль) 903
350. Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2002-7-4-ний хууль) 915
351. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 915
352. Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 915
353. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 915
354. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 916
355. Орон сууц хувьчлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 916
356. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 916
357. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 917
358. Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 918
359. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 918
360. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 918
361. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 918
362. Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 919
363. Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 919
364. Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 919
365. Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 919
366. Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 920
367. Үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 920
368. Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 920
369. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 920

370. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 921
371. Вексельийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 921
372. Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 921
373. Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 921
374. Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 922
375. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 922
376. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 922
377. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 922
378. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 923
379. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 923
380. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-7-4-ний хууль) 923
381. Нөхөрлөл, компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2002-7-4-ний хууль) 924
382. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-4-ний хууль) 924
383. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2002-7-5-ны хууль) 924
384. Гэрээ соёрхон батлах тухай (2002-7-5-ны хууль) 924
385. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 925
386. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 927
387. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 927
388. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 927
389. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 928
390. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 928
391. Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 928

392. Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 928
393. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 929
394. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 929
395. Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай (2002-7-10-ны хууль) 929
396. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 930
397. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 930
398. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 930
399. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 930
400. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 930
401. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай (2002-7-10-ны хууль) 931
402. Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 931
403. Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 931
404. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай (2002-7-10-ны хууль) 932
405. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай (2002-7-10-ны хууль) 932

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

406. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Дугаар 39 932
407. Үндэсний хөтөлбөр, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг
батлах тухай Дугаар 41 933
408. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн
тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 42 938
409. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай
хуулийг дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийн төслийг
бүцаах тухай Дугаар 43 939
410. Эд хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах тухай Дугаар 52 939
411. Жагсаалтад нэмэлт оруулах тухай Дугаар 55 939
412. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх
үндсэн чиглэл батлах тухай Дугаар 56 940
413. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн
ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Дугаар 58 945

2002 оны 6 дугаар сарын 27–ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, төсвийн хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж

2.1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндэсн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой (хөрөнгийн 51 буюу түүнээс дээш хувьтай) хуулийн этгээдэд хамаарна.

3.2. Энэ хуулийн ерөнхий менежер, үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн, гэрээнээс гадуур бүтээгдэхүүн хуудалдах тухай харилцаат зохицуулж буй зүйл, хэсэг, заалт нь улсын аюулгүй байдлыг ханган байгууллага, түүнчлэн хуульд заасны дагуу гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Монгол Улсын нэгдсэн төсөв" гэж улсын болон орон нутгийн төсвийн бүрдлийг;

4.1.2. "улсын төсөв" гэж Улсын Их Хурлаас батална, Засгийн газрын бүрдүүлж зарцуулах төсөв болон орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийн нийлбэрийг;

4.1.3. "орон нутгийн төсөв" гэж орон нутгийн орлого, улсын төсөөс олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн хөрөнгөөр хуудалдан авах бүтээгдэхүүний санхүүжилтийн нийлбэрийг;

4.1.4. «төсвийн байгууллага» гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг улсын буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг байгууллагыг;

4.1.5. «хэтийн зорилт» гэж Засгийн газар болон төсвийн байгууллагаас дэвшүүлсэн дунд, урт хугацааны зорилт, хүрэх түвшинг;

4.1.6. «төсвийн хүрээний мэдэгдэл» гэж дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж Улсын Их Хурлаа зөвшөөрсөн баримт бичгийг;

4.1.7. «төсвийн төсөл» гэж төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан улсын төсвийн орлого зарлага, түүний дотор төсвийн төлөвлөгөөни ангилал тус бүрийн талаар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн саналыг;

4.1.8. «төсвийн ерөнхийлө захирагч» гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээн төсвийн байгууллага болон бусад этгээдээ нийлүүлэх бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойло гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтныг;

4.1.9. «ерөнхий менежер» гэ төсвийн ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулсн үндэсн дээр төсвийн байгууллагыг өдөр тутмы удирдлагаар ханган хүрэх бүхий албан тушаалтны

4.1.10. «бүтээгдэхүүн» гэж төсвий байгууллага болон бусад этгээдээс нийлүүлэх т хэмжээ, хугацаа, чанар, зардал зэрэг гэрээн тусгасан шалгуур үзүүлэлтээр тодорхойлогд ажил, үйлчилгээг;

4.1.11. «бүтээгдэхүүний анги» г төсөв хуваарилах зорилгоор нэгтгэсэн ижил төст бүтээгдэхүүний бүлэглэлийг;

4.1.12. «зорилтын санал» г төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчи оролцоотой (хөрөнгийн 51 буюу түүнээс дээ хувьтай) хуулийн этгээдийн ирэх 3 жилийн зорил үйл ажиллагааны төлөвлөгөөг;

4.1.13. «бусад этгээд» гэж улсы болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хуудалд авах энэ хуулийн 4.1.10-т заасан бүтээгдэхүүни гэрээгээр нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллаг

[1] *Монгол Улсын Үндэсн хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн*

иргэнийг;

4.1.14. «аккруэл суурь» гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг;

4.1.15. «өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх» гэж Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу Засгийн газар төсвийн хөрөнгийг захиран зарцуулагчийн хувьд төсвийн байгуллага өөрийн чиг үүргийн үйл ажиллагаанд үр өгөөжтэй, тасралтгүй явуулж байх хүний нөөц, эд хөрөнгө болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, учирч болох эрсдэлийг удирдах арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэхийг.

5 дугаар зүйл. Удирдлага, санхүүжилтийн зарчим

5.1. Төсвийн байгууллага, албан тушаалтан нь удирдлага, санхүүжилтийн талаар дараахь зарчмыг баримтална:

5.1.1. жилийн эхэнд үйл ажиллагааныхаа зорилтыг тогтоож, хүрэх үр дүнг тодорхой болгох;

5.1.2. санхүүгийн жилд бүтээгдэхүүнээ гэрээний үндсэн дээр нийлүүлж, төсвийн санхүүжилт авах;

5.1.3. албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн үр чадварын үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох, ажлын үр дүнг нь бодитойгоор үнэлэх;

5.1.4. санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

5.2. Засгийн газар төсвийн талаар дараахь зарчмыг баримтална:

5.2.1. төсвийг дунд хугацаагаар төлөвлөж, удирдах;

5.2.2. ирэх 3 жилийн улсын төсвийн урсгал зардлын дундаж нь урсгал орлогын дундаж хэтрэхгүй байх;

5.2.3. жил бүрийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ илүүдэлтэй байх;

5.2.4. гадаад хуудалдааны нөхцөл эерэг байх жилд мөнгөн гүйлгээний илүүдэл нь 3 жилийн дундажаас дээгүүр байх;

5.2.5. Улсын Их Хурлаас зөвшөөрсний дагуу Засгийн газрын зээлийн зохистой түвшинг жил бүр тогтоож, мөрдөх;

5.2.6. татварын түвшин болон татварын тогтолцооны тогтвортой байдлыг хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тасвийн байгууллага, албан тушаалтны төсвийн удирдлагын талаархи бүрэн эрх

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Улсын Их Хурал нь дараахь бүрэн эрхтэй:

6.1.1. Засгийн газрын өргөн мэдүүлснээр улсын төсвийн орлого, төрийн чиг үүргээ хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилт, дэлгэрэнгүй задаргаатай санхүүжилтийг хэлэлцэж батлах;

6.1.2. төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн зөвшөөрөх;

6.1.3. төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулсан эсэхийг шийдэх;

6.1.4. төсвийн байгууллага төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, үр дүнг нь дээшлэгнах тогтолцоог бүрдүүлэх;

6.1.5. нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх, Засгийн газрын санхүүгийн тайлан болон улсын төсвийн гүйцэтгэлийг батлах.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1. Засгийн газар нь дараахь бүрэн эрхтэй:

7.1.1. төсвийн удирдлагыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх;

7.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон энэ хуулийн 5.2-т заасан төсвийн удирдлагын зарчимд нийцүүлэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсвийн төслийн жил бүрийн болон дунд хугацааны үндсэн үзүүлэлтийг боловсруулах;

7.1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төслийг боловсруулах;

7.1.4. улсын төсвийн байгууллагын үндсэн чиг үүргэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилтийг тодорхойлох;

7.1.5. Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Засгийн газрын үнэт цаас гаргах;

7.1.6. төсвийн хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын шаардлагыг хангуулах;

7.1.7. улсын төсвийн байгууллагын ажлын үр дүнг төсвийн санхүүжилттэй уялдуулан дүгнэх.

7.2. Засгийн газар агентлаг байгуулах саналыг дараахь тохиолдолд Улсын Их Хуралд гаргана:

7.2.1. тухайн агентлагийн нийлүүлэх бүтээгдэхүүн нь төрийн чиг үүрэгт хамаарч байгаа;

7.2.2. хуульд заасан болон үүнтэй адилтгах бусад тохиолдолд.

8 дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

8.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхтэй:

8.1.1. улсын санхүүгийн байдал, төсвийн үйл ажиллагааны үр дүнг хариуцаж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн удирдлага, санхүүжилтийн зарчмыг сахиулах;

8.1.2. эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, тооцоо, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

8.1.3. төсвийн удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгох санал боловсруулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

8.1.4. санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах;

8.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний нөхцөлийг хангасан төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүний санхүүжилтийг олгох;

8.1.6. төрийн өмч, улсын төсвийн хөрөнгө, эрсдэлийг удирдах үр ашигтай тогтолцоо бий болгох;

8.1.7. Засгийн газраас эрх олгосноор Засгийн газрын нэрийн өмнөөс зээл авах буюу зээл авах зөвшөөрөл олгох;

8.1.8. Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх, зээл төлөх санал боловсруулах;

8.1.9. зээл, тусламжийн удирдлагыг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрээр зээлийн баталгаа гаргах;

8.1.10. улсын төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын өрийн удирдлагыг хэрэгжүүлэх;

8.1.11. энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллага, бусад этгээдээс гаргуулж авах.

9 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхтэй:

9.1.1. төсвийн байгууллагын бүртгэлийн бодлогыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.2. шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллагаас гаргуулж авах;

9.1.3. төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхэд хамаарах улсын төсвийн байгууллагын бүтээгдэхүүний нийлүүлэлт болон улсын төсвийн хөрөнгөөр орон нутгийн байгууллагаас худалдан авах бүтээгдэхүүний нийлүүлэлтийн явцад хяналт тавих;

9.1.4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төсөл, түүнийг тодотгох тухай Засгийн газрын саналыг боловсруулах, тооцоо, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

9.1.5. Засгийн газрын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах;

9.1.6. нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах;

9.1.7. энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу улсын төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх;

9.1.8. улсын төсвийн орлого, зарлагын төлбөрийг гүйцэтгэх банкны данснаас бүртгэлийг хөтлөх;

9.1.9. улсын төсвийн байгууллагад банкинд данс нээх зөвшөөрөл олгох;

9.1.10. улсын төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтыг бүрэлдэхүүн хэсэг болох Засгийн газрын дансуудыг удирдах.

9.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн тогтоомжид заасан улсын төсвийн орлого, зарлагын гүйлгээг энэ чиглэлийн үүрэг бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

10 дугаар зүйл. Мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтад тавих шаардлага

10.1. Улсын төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтад дараах шаардлага тавина:

10.1.1. улсын төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийнхөө хэрэгцээг зөв төлөвлөх, ажиллах, урсгал төсвөө оновчтой ашиглах, сонирхлыг төрүүлэхүйц байх;

10.1.2. улсын төсвийн байгууллагын дансны цэвэр үлдэгдлийг байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг алдагдуулахгүйгээр үр ашигтай удирдах.

11 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч

11.1. Дараахь албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:

11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ерөнхийлөгчийн төсвийн;

11.1.2.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын төсвийн;

11.1.3.Ерөнхий сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн;

11.1.4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын төсөв, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөв болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

11.1.5.Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

11.1.6.Үндсэн хуулийн цэцийн дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

11.1.7.Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн төсвийн;

11.1.8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн;

11.1.9.Улсын ерөнхий прокурор Прокурорын байгууллагын төсвийн;

11.1.10.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга тус зөвлөлийн;

11.1.11. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн;

11.1.12. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн дарга тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төсвийн;

11.1.13. нийслэлийн Засаг дарга нийслэлийн төсөв болон нийслэлийн Захирагчийн ажлын албаны төсвийн;

11.1.14.аймгийн Засаг дарга аймгийн төсвийн;

11.1.15. сум, дүүргийн Засаг дарга сум, дүүргийн төсвийн.

12 дугаар зүйл. Төсвийн талаархи төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх

12.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараахь бүрэн эрхтэй:

12.1.1. эрхлэх асуудлынхаа хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого, зарцуулахтай холбогдсон гэрээ, худалдан авах ажиллагаатай холбогдсон шийдвэр гаргах;

12.1.2. төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэлийг хангуулах;

12.1.3. Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд мэдээлэл өгөх;

12.1.4. дэвшүүлсэн хэтийн зорилтоо хэрэгжүүлэхэд төрийн зохицуулалт шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад санал оруулах;

12.1.5. эрхлэх асуудлын хүрээнийагентлаг, төсвийн бусад байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;

12.1.6. эрхлэх асуудлын хүрээнийтөсвийн байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах;

12.1.7. эрхлэх асуудлын хүрээнийтөсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний нийлүүлэлт, санхүүгийн үр дүнг хянаж дүгнэх;

12.1.8. төрийн албаны төв байгууллагаас энэ хуулийн 45.1-д заасан албан тушаалд нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонголт хийж, эрх бүхий байгууллагад санал оруулах;

12.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 12.1-д заасан зарим эрхээ ерөнхий менежерт бичгээр шилжүүлж болох бөгөөд иймхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

12.3. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээнийтөсвийн байгууллагын ерөнхий менежерт хуулиар олгогдсон эрх мэдлийг хязгаарлах буюу өөртөө шилжүүлэн авахыг хориглоно.

13 дугаар зүйл. Улсын төсвийн байгууллагын бүрэн эрх

13.1. Улсын төсвийн байгууллага төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг бүтээгдэхүүний хэлбэрээр нийлүүлж, түүнийхээ төлөө санхүүжилт авна.

13.2. Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна.

13.3. Улсын төсвийн байгууллага үйл ажиллагаанаа хэтийн төлөвлөгөөндөө тусгасны үндсэн дээр төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнээс гадуур өөрийн бүтээгдэхүүнээ худалдаж нэмэлт орлого олж болно.

13.4. Дараахь шаардлагыг хангасан тохиолдолд улсын төсвийн байгууллага үндсэн бус үйл ажиллагаа явуулан орлого олж болно:

13.4.1. төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн, уг үйл ажиллагаанаас алдагдал учирвал нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх;

13.4.2. санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан;

13.4.3. байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар ашиглаагүй, ажилтныг үүрэгт ажлаас нь хөндийрүүлэгүй.

13.5. Улсын төсвийн байгууллага

ашиглагдаагүй мөнгөн хөрөнгөө мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтын хүрээнд хүүтэй хадгалуулж болно. Хадгаламжийн хүүгийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн банктай зөвшилцөн тогтооно.

13.6. Улсын төсвийн байгууллага өөрт байгаа төрийн өмчийн зөрөнгө ашиглаһы төлбөрийг жил бүр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр төлнө.

13.7. Улсын төсвийн байгууллага нь хөрөнгийн төлбөр болон үйл ажилллагааны зардлын хэмнэлтийг ажилтнаа сургах, давтан сургах, урамшуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангахад зарцуулж болно. Энэ нь тухайн байгууллагын дараа оны төсвийг батлахад бууруулж тооцох үндэслэл болохгүй.

14 дүгээр зүйл. Улсын төсвийн байгууллагад хориглох зүйл

14.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд улсын төсвийн байгууллага, албан тушаалтанд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

14.1.1. зээл авах, зээл олгох, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргах;

14.1.2. мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтаас гадуур банкинд данс нээх;

14.1.3. санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;

14.1.4. хуульд зааснаас бусад тохиолдолд төлбөр, хураамж авах, энэ хуульд заасныг зөрчиж нэмэлт бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг аливаа хэлбэрээр орлого олох;

14.1.5. энэ хуульд заасныг зөрчиж тєсвөөс гадуур зардал гаргах;

14.1.6. мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтын хадгаламжаас өөр хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх;

14.1.7. үндсэн хөрөнгө борлуулсны орлогыг урсгал зардлыг санхүүжүүлэхэд ашиглах;

14.1.8. ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халах, энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг зөрчих.

15 дугаар зүйл. Улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөр

15.1. Улсын төсвийн байгууллагаар дамжин төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тайланд тусгана.

Улсын төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар тогтооно.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасан орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэн улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн дансанд бүртгэнэ.

15.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь эрхлэх асуудлынхаа хүрээний улсын төсвийн байгууллагуудын энэ хуулийн 15.1-д заасан тайлан болон улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

15.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 15.3-д заасан үүргийг ерөнхий менежерт, байгууллах үр дүнгийн гэрээнд ерөнхий менежерийн нийлүүлэх бүтээгдэхүүний хэлбэрээр тусган өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгүүлж болох бөгөөд иймхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16 дугаар зүйл. Ерөнхий менежер

16.1. Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагаат үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий ерөнхий менежертэй байна.

16.2. Дараахь албан тушаалтан төсвийн ерөнхий менежер байна:

16.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн;

16.2.2.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч Улсын Их Хурлын төсвийн;

16.2.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ерөнхий сайдын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн;

16.2.4.төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тус байгууллагын төсвийн;

16.2.5.агентлагийн дарга тус агентлагийн төсвийн;

16.2.6.Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

16.2.7.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга тус зөвлөлийн төсвийн;

16.2.8.Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга тус шүүхийн төсвийн;

16.2.9. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн нарийн бичгийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийн;

16.2.10. аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн тамгын хэлтсийн дарга тухайн шатны шүүхийн төсвийн;

16.2.11.Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга прокурорын байгууллагын төсвийн;

16.2.12.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төрүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;

16.2.13.аймаг, нийслэл, сум

дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн;

16.2.14.төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн.

16.3.Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх албан тушаалтныг Улсын Их Хурал тогтооно.

16.4. Ерөнхий менежер өөрийн эрхэд хамаарах зарим эрхээ холбогдох албан тушаалтанд бичгээр шилжүүлж болох бөгөөд иймхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

17 дугаар зүйл. Ерөнхий менежерийн бүрэн эрх

17.1. Ерөнхий менежер дараахь бүрэн эрхтэй:

17.1.1. батлагдсан төсөв, түүтэзгэхүүн нийлүүлэх гэрээний хүрээнд зардал гаргах;

17.1.2.Засгийн газраас тогтоосон үүрэнд багтаан көрөнгө оруулалт хийх;

17.1.3. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төөвшөөрснөөр байгууллагын нэр дээр банкинд данс нээж ашиглах;

17.1.4. байгууллагын балансад байгаа хөрөнгийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасны дагуу захиран зарцуулах;

17.1.5. байгууллагын орон тоо, салингийн санг тогтоох;

17.1.6.төсвийн удирдлага, зохицуулалтийг байгууллагынхаа үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхад чиглүүлэх;

17.1.7. байгууллагын төсвийн хэрэгжилтийг үр ашигтай явуулах;

17.1.8. байгууллагын санхүүгийн тайлан, тоотод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх;

17.1.9. төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай санхүүжүүлэх, шилэлтэд хяналт тавих;

17.1.10. байгууллагын санхүүгийн тайланг үнэн зөв гаргах;

17.1.11. энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;

17.1.12. ажилтныг ажилд томилох, цэрчлэх, халах, түүнд урамшуулал олгохдоо энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг баримтлах;

17.1.13. төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох заавар, журмыг сахин биелүүлэх;

17.1.14. энэ хуулд заасан бусад төрөн эрх.

18 дугаар зүйл. Ерөнхий менежерийн үүрэг

18.1. Төсвийн байгууллагын ерөнхий менежер энэ хуулийн 18.4-т заасан хугацаанд жил бүр үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

18.2. Үр дүнгийн гэрээнд байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө болон ерөнхий менежерийн ажлын үр дүнгийн зорилт, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.

18.3. Ерөнхий менежер дараахь байдлаар үр дүнгийн гэрээ байгуулна:

18.3.1. улсын төсвийн байгууллагын ерөнхий менежер нь шууд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчтай;

18.3.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр улсын төсвийн өөр байгууллагын өмнө хариуцлага хүлээдэг улсын төсвийн байгууллагын ерөнхий менежер нь тухайн байгууллагын ерөнхий менежертэй;

18.3.3. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон орон нутгийн төсвийн байгууллагын ерөнхий менежер нь тухайн шатны Засаг даргатай.

18.4. Улсын төсвийг Улсын Их Хурал батална энэ хойш 1 сарын дотор үр дүнгийн гэрээг байгуулна.

19 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө агентлагийн ерөнхий менежерийн хүлээх үүрэг

19.1. Агентлаг байгуулах шийдвэрт өөрөөр заагаагүй бол агентлагийн ерөнхий менежер төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө агентлагийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ.

19.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө агентлагийн ерөнхий менежерийн хүлээх үүрэг нь санхүүгийн үр дүн, өмчлөлийн асуудлаар хязгаарлагдана.

19.3. Төсвийн ерөнхийлөн захирагч агентлагийн нийлүүлэх бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлно.

19.4. Төсвийн ерөнхийлөн захирагч илүү үр ашигтай гэж үзсэн тохиолдолд холбогдох агентлагийн ерөнхий менежер эвшөөрсний үндэсэн дээр тухайн агентлагийн ерөнхий менежер төрийн захиргааны төв байгууллагын буюу өөр агентлагийн ерөнхий менежерийн өмнө хариуцлага хүлээж болно.

19.5. Энэ хуулийн 19.4-т заасны дагуу өөрт нь өөр агентлагийн ерөнхий менежер ажлаа тайлагнадаг төрийн захиргааны төв байгууллагын буюу агентлагийн ерөнхий менежер дараахь үүрэгтэй:

19.5.1. энэ хуулийн 18.3-т заасны дагуу жил бүр үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах;

19.5.2. агентлагийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг

хангах, төсвийг зарцуулах;

19.5.3. агентлагаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тавигдаж байгаа хүрэх үр дүн болон хэтийн зорилттой уялдуулах;

19.5.4. агентлагийн санхүүгийн болон өмчлөгчийн ашиг сонирхлыг хөндсөн бусад үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;

19.5.5. агентлаг болон түүний ерөнхий менежерийн жилийн ажлын үр дүнг бүгнэх.

19.6. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээний агентлагийн өмнөөс энэ хуулийн 19.5-д заасан асуудлаар Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээнэ.

20 дугаар зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд

20.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийтийн эрх ашгийн үүднээс зайлшгүй төрийн өмчийн байгууллага гүйцэтгэх шаардлагатай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлнэ.

20.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн энэ хуулиар зохицуулагүй бусад харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай[1] болон Компанийн тухай[2] хуулиар зохицуулна.

20.3. Төр ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаанд эвэхэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэлбэрээр явуулна.

20.4. Улсын төсвийн байгууллага зах зээлд борлуулах болоцлоотой бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бөгөөд энэ чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагад шилжүүлэх шаардлагагүй бол Засгийн газар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болгон өөрчлөн байгуулах, эсхүл чиг үүргийг нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд шилжүүлнэ.

21 дүгээр зүйл. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл

21.1. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараахь үүрэгтэй:

21.1.1. ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах;

21.1.2. ерөнхий менежерийн ажлын үр дүнг хянах;

21.1.3. үйл ажиллагааныхаа талаархи бодлогын асуудлыг шийдвэрлэх.

21.2. Төрийн өмчийн хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилоходоо төрийн албаны төв байгууллагаас энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж санал болгосон, дараахь болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно:

21.2.1. тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай;

21.2.2. тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй.

21.3. Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуульд заасан тайлан, бусад мэдээллийг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

21.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснээс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно.

21.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуульд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөлийг хэрэгжүүлэх

22.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагуудын санхүүгийн байдал, мөнгөн хөрөнгийн гүйлгээнд үзүүлэх нөлөөнд, Төрийн өмчийн хороо нь эдгээр хуулийн этгээдийн ажлын үр дүнд хяналт тавина.

22.2. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа этгээд нь хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлтэй үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянаж дүгнэхээс бусад хэлбэрээр тэдгээрийн өдөр тутмын удирдлагын ажилд оролцох эрхгүй.

22.3. Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газрын шийдвэргүйгээр төрийн мэдлийн хувьцааны хэмжээг өөрчилж болохгүй.

22.4. Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох нөгөлөл ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана.

23 дугаар зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хуулидлан авах болон нийлүүлэх бүтээгдэхүүн

23.1. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх

[1] *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн*

[2] *Компанийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн*

асуудлынхаа хүрээнд шаардагдах бүтээгдэхүүний хэрэгцээгээ бодитой тодорхойлж, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээд, бусад этгээдээс гэрээгээр худалдан авч болно. Гэрээнд бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөл, төсвийн санхүүжилтийг тусгана.

23.2. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчдаа дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

23.2.1. бодлогын асуудал, зохицуулалтын ажил, үйлчилгээ;

23.2.2. Улсын Их Хуралд шаардлагатай бөгөөд төсөөт нь туссан бусад ажил, үйлчилгээ.

23.3. Төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчдаа дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

23.3.1. бодлогын асуудал, зохицуулалтын ажил, үйлчилгээ;

23.3.2. Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, бусад байгууллагатай байгуулах үр дүнгийн гэрээний талаар зөвлөх, холбогдох талтай хамтран гэрээний төслийг боловсруулах, гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүний санхүүгийн үр дүнгийн биелэлтийг хянаж дүгнэх;

23.3.3. төрийн захиргааны төв байгууллагад хамаарах бусад бүтээгдэхүүн.

23.4. Агентлаг өөрийн чиг үүргийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид бүтээгдэхүүн нийлүүлнэ.

23.5. Төсвийн ерөнхийлөн захирагч бусад этгээдээс бүтээгдэхүүн худалдан авахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл. Төсвийн байгууллага эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

24.1. Төсвийн байгууллага эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай[1] хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын төсөв боловсруулах, батлахтай холбогдсон харилцаа

25 дугаар зүйл. Улсын Их Хуралд төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн мэдүүлэх, түүнийг зөвшөөрөх

25.1. Засгийн газар дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдлийг 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

25.2. Төсвийн хүрээний мэдэгдэлд дараахь зүйлийг тусгана:

25.2.1. Засгийн газрын дунд хугацааны зорилтууд;

25.2.2. Засгийн газраас тухайн жилд төлөвлөсөн төсвийн урсгал зардал болон орлогын хэмжээ, хөрөнгө оруулалт, нийт болон урсгал тэнцэл, төсөвлөсөн баланс, мөнгөн гүйлгээ, тэдгээрийн талаар дараагийн 2 жилд тавих зорилт;

25.2.3. макро эдийн засгийн болон энэ хуулийн 25.2.2-т заасан үзүүлэлтийн тооцоо, танилцуулга;

25.2.4. төсвийн хүрээний үзүүлэлтүүд нь энэ хуульд заасан төсвийн удирдлагын зарчимд нийцэж байгаа тухай дүгнэлт.

25.3. Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг хаврын чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө

26.1. Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын төсөв боловсруулах үндэслэл болно.

26.2. Төлөвлөгөөнд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараахь зүйлийг тусгана:

26.2.1. байгууллагын 3 жилийн хэтийн зорилтууд;

26.2.2. дараагийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, өртөг;

26.2.3. жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй ижил үзүүлэлтээр боловсруулсан байгууллагын төсөв;

26.2.4. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад асуудал.

26.3. Улсын төсвийн байгууллагын бүтээгдэхүүний ерттийг түүнийг нийлүүлэхэд гарах бүртгэлийн аккруэл сууриар тооцсон бодит зардлын хэмжээгээр буюу удирдлагын зардал, хөрөнгийн төлбөрийг оролцуулан тогтооно.

27 дугаар зүйл. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хүргүүлэх

27.1. Улсын төсвийн байгууллага өөрийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний төслийг төсвийн ерөнхийлөн захирагчид 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор, төсвийн ерөнхийлөн захирагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

[1] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2000 оны 17 дугаарт нийтлэгдсэн

байгууллагад 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

28 дугаар зүйл. Зорилтын санал

28.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүр 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал (цаашид «зорилтын санал» гэх)-ын төслийг Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

28.2. Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараахь зүйлийг тусгана:

28.2.1. байгууллагын 3 жилийн хэтийн зорилтууд;

28.2.2. үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ;

28.2.3. нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримтлсан бодлогын тухай тайлбар;

28.2.4. санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг;

28.2.5. төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг;

28.2.6. төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт.

28.3. Төрийн өмчийн хороо төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг хянаж нэгтгэн, санал дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

28.4. Төрийн өмчийн хороо нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг тусган, тухайн хуулийн этгээдийн удирдлагатай 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор тохиролцоно.

28.5. Төрийн өмчийн хороо төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

28.6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газар болон Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд зорилтын саналыг танилцуулна.

29 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл

29.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл нь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг үндэслэсэн байна.

29.2. Улсын төсвийн төсөлд төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг тусгасан байна.

29.3. Төсвөөс санхүүжих байгаа бүх байгууллагын төсөв аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамрагдсан байна.

30 дугаар зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд тавих шаардлага

30.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл дараахь шаардлагыг хангасан байна:

30.1.1. улсын төсвийн төсөлтэй уялдсан байх;

30.1.2. эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газраас дэвшүүлж байгаа бодлого болон дунд хугацааны хэтийн зорилтуудыг тусгах;

30.1.3. хуваарилагдсан төсвийг захиран зарцуулах этгээдийг заах;

30.1.4. эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бүтээгдэхүүний анги тус бүрээр тодорхойлж, нийлүүлэх байгууллага, худалдан авахад гарах зардлыг заах;

30.1.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн нийцэж байгаа тухай тайлбарласан байх;

30.1.6. эрхлэх асуудлын хүрээнд төсөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад шилжүүлгийн төрөл тус бүрийн хэмжээг тусгах;

30.1.7. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлын төрөл тус бүрийн хэмжээг тогтоосон байх;

30.1.8. эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээг тодорхойлсон байх;

30.1.9. бүтээгдэхүүн худалдан авахаас бусад төсвийн зорилго, ач холбогдлыг тайлбарласан байх;

30.1.10. эрхлэх асуудлын хүрээнд төсөвт оруулах нийт орлогын урьдчилсан хэмжээ, тэдгээрийн ангиллыг тогтоосон байх;

30.1.11. шаардлагатай бол өмнөх жилийн төсөвт дээрх зүйл тус бүрт төсөвлөсөн санхүүжилт, түүний биелэлтийг харьцуулсан байх.

31 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг Засгийн газарт мэдүүлэх

31.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг нэгтгэн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт мэдүүлнэ.

31.2. Засгийн газар төсвийн төслийг ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ.

32 дугаар зүйл. Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

32.1. Засгийн газар 10 дугаар сарын 1-ний өдрийн өмнө улсын төсвийн дараахь баримт бичгийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

32.1.1. эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл;

32.1.2. улсын төсвийн төсөл, түүний тухай илтгэл;

32.1.3. төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төсөл.

32.2. Улсын төсвийн төсөлд Засгийн газраас дэвшүүлсэн санхүүгийн зорилтыг дараахь үзүүлэлтээр тодорхойлсон байна:

32.2.1. төсвийн үндирдлагын зарчмын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд;

32.2.2. тухайн санхүүгийн жил болон түүний дараахь 2 жилээр тооцсон улсын төсвийн орлого, зарлага, улсын төсвийн хөрөнгө, өр төлбөр, мөнгөн гүйлгээний үзүүлэлтийг багтаасан санхүүгийн үзүүлэлтүүд;

32.2.3. төсөвт тусгагдаагүй боловч Засгийн газрын урьд гаргасан шийдвэрийн улмаас гарч болзошгүй өр төлбөр, нэмэлт зардал, орлогын дутагдал зэрэг улсын төсөвт учирч болох эрсдлийн тухай мэдэгдэл;

32.2.4. төсвийн төслийн үзүүлэлтүүд төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэж байгааг нотолсон буюу зөрүүг тайлбарласан мэдэгдэл.

32.3. Энэ хуулийн 32.2-т заасан улсын төсвийн орлогын ангилал болон улсын бө орон нутгийн төсөвтэй харьцах заагийг хуулиар тогтооно.

32.4. Улсын төсвийн зарлагын ангилал нь энэ хуулийн 33.2-т заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн ангилалтай нийцсэн байна.

33 дугаар зүйл. Улсын төсөв батлах

33.1. Улсын Их Хурал энэ хуулийн 32.1-д заасан төсвийн баримт бичиг, хуулийн төслийг хэлэлцэн батална.

32.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөөт дараахь зүйлийг тусгана:

33.2.1. улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, бусад этгээдээс худалдаж авах бүтээгдэхүүний анги бүрээр;

33.2.2. улсын төсөөс төлөх тэтгэвэр, тэтгэмж, бусад зардлыг төрөл, анги бүрээр;

33.2.3. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад зардлыг зардлын төрөл бүрээр;

33.2.4. улсын төсөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын төсөл бүрээр.

33.3. Улсын Их Хурал улсын төсөв батлахдаа зайлшгүй нөхцөлийн улмаас гарсан том хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд нэгэнт зөвшөөрсөн төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байх зарчмыг баримтална.

33.4. Улсын Их Хурлаас төсвийн баримт бичигт өөрчлөлт оруулахдаа татварын тогтолцоог тогтвортой байлгах зарчмыг баримтална.

33.5. Улсын Их Хурал улсын төсвийг 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэн батална.

34 дүгээр зүйл. Санхүүгийн жил

34.1 Санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

35 дугаар зүйл. Улсын төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрх хүчин төгөлдөр байх хугацаа

35.1. Улсын Их Хурлаас олгосон тухайн жилийн төсвийг зарцуулах төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх санхүүгийн жил дуусснаар дуусгавар болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Улсын төсвийг зарцуулах, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах

36 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх мэдэгдэл

36.1. Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар Улсын Их Хурал олон нийтэд мэдээлнэ. Энэхүү мэдээлэлд дараахь зүйлийг тусгасан байна:

36.1.1. улсын эдийн засгийн гол үзүүлэлт:

36.1.1.1.хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн үзүүлэлт;

36.1.1.2.тэтгэвэр, тэтгэмж, төсвийн байгууллагад ажиллагсадын хөдөлмөрийн хөлсний дундаж түвшин;

36.1.1.3.дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өөрчлөлтийг харуулах үзүүлэлт;

36.1.1.4.хэрэглээний үнийн индекс;

36.1.1.5.төгрөгийн 1 америк

доллартай харьцах ханш болон нийт мөнгөн хөрөнгийн тооцоо, эргэцийг харуулах үзүүлэлтүүд;

36.1.6.хөрөнгө оруулалт;

36.1.7.гадаад валютын цэвэр нөөц болон нийт орлого, зарлагын үзүүлэлт;

36.1.1.8.гадаад худалдааны тэнцэл, ерийн үзүүлэлт.

36.1.2. Улсын Их Хурлын сонгууль болох оны жилийн эцсийн санхүүгийн төлөв;

36.1.3. санхүүгийн төлөвт тусгагдаагүй боловч Засгийн газрын урьд гаргасан шийдвэрийн улмаас гарч болзошгүй өр төлбөр, нэмэлт зардал, орлогын дутагдлын талаарх төсвийн эрсдэл, төсвийн болон эдийн засгийн төлөвт нөлөөлж болох бусад хүчин зүйлийн тухай тайлбар.

37 дугаар зүйл. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах журам

37.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

37.2. Тайлан дараахь зүйлээс бүрдэнэ:

37.2.1. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

37.2.2. баланс;

37.2.3. мөнгөн гүйлгээний тайлан.

37.2.4. өмчийн өөрчлөлтийн тайлан.

37.3. Тайланд дараахь нэмэлт тодруулгыг хавсаргана:

37.3.1. тооцоо нийлсэн ер төлбөрийн тухай мэдэгдэл;

37.3.2. учирч болзошгүй өр төлбөрийн тухай мэдэгдэл;

37.3.3. төсөвлөгдөөгүй зардлын тухай мэдэгдэл;

37.3.4. нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримталсан бодлогын тухай тайлбар;

37.3.5. тайлан бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлж Ерөнхий сайд, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гарын үсэг зурсан мэдэгдэл;

37.3.6. жилийн эцсийн санхүүгийн тайлан болон жилийн төсвийн үзүүлэлтүүдийг харьцуулсан тайлбар;

37.3.7. энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргасан тайлангийн дүн.

37.4. Засгийн газар энэ хуулийн 38.1-д заасан аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

37.5. Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэрэн чүүлганаараа хэлэлцэж улсын төсвийн гүйцэтгэлийг батална.

38 дугаар зүйл. Аудитын дүгнэлт

38.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор аудитын дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын төв байгууллагад хүргүүлнэ. Төрийн аудитын төв байгууллага тайланг хүлээн авснаас хойш 1 сарын дотор тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргана.

38.2. Улсын төсвийн байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлнэ. Төрийн аудитын төв байгууллага тайланг хүлээн авснаас хойш 1 сарын дотор тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргана.

38.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайландаа дараа жилийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор аудитын дүгнэлт хийлгэнэ.

38.4. Засаг дарга орон нутгийн жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллага 1 сарын дотор аудитын дүгнэлт гаргана.

38.5. Аудитын үйлчилгээний хөлсийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн жишээ тооцож аудит хийлгэсэн байгууллага төлнө. Аудитын төлбөрийн орлогыг улсын буюу орон нутгийн төсөвт оруулна.

39 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч тайлагнах журам

39.1. Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн жилийн эцэст өөрийн үйл ажиллагаанд үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн биелэлт, эн хуулийн 38 дугаар зүйлд заасан төрийн аудитын төв байгууллагын аудитын дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

39.2. Төсвийн ерөнхийлөн захирагч тайландаа дараахь зүйлийг тусгана:

39.2.1. эрхлэх асуудлын хүрээнэ хэтийн зорилт, тэдгээрийн хэрэгжилт;

39.2.2. худалдан авса бүтээгдэхүүний анги, түүний өртөг, батлагдса төсөөс зөрүүтэй бол түүний шалтгаан;

39.2.3. тэтгэвэр, тэтгэмж, буса шилжүүлэг, тэдгээрийн зардал, төсөөс зөрүүтэ бол түүний шалтгаан;

39.2.4. өмчлөгчийн эрхий хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан зардал, төсөө зөрүүтэй бол түүний шалтгаан;

39.2.5. хөрөнгө оруулалты хэрэгжилт, тэдгээрийн зардал, төсөөс зөрүүтэ бол түүний шалтгаан;

39.2.6. эрхлэх асуудлын хүрээнэ байгууллагуудаас оруулсан орлого, төсөө зөрүүтэй бол түүний шалтгаан.

40 дүгээр зүйл. Улсын төсвийн айгууллага тайлагнах журам

40.1. Улсын төсвийн байгууллага хагас, үтэн жилээр санхүүгийн тайлан гаргана.

40.2. Улсын төсвийн байгууллагын анхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн пон улсын стандартын дагуу гаргасан дараахь үйлээс бүрдэнэ:

40.2.1. байгууллагын хөрөнгө, өр элбэрийн тайлан;

40.2.2. байгууллагын тухайн оны рлого, зарлагыг харуулсан санхүүгийн үйл жиллагааны үр дүнгийн тайлан;

40.2.3. байгууллагын тухайн оны йл ажиллагаа, хөрөнгө оруулалт болон анхүүжилтийн хөдөлгөөнийг харуулсан мөнгөн йлгээний тайлан;

40.2.4. байгууллагын өмчийн эрчлэлтийн тайлан.

40.3. Улсын төсвийн байгууллагын анхүүгийн тайланд дараахь нэмэлт тодруулгыг авсаргана:

40.3.1. байгууллагын тооцоо ийлсэн өр төлбөр;

40.3.2. баталгаа, хохирлыг нөхөн элэх үүрэг зэрэг тухайн байгууллагын үчирх олзошгүй өр төлбөрийн тухай мэдэгдэл;

40.3.3. батлагдсан төсөөс гадуур үюу хэтрүүлж гаргасан зарлагын тухай мэдэгдэл;

40.3.4. батлагдсан төсвийн зүйл үрээр гаргасан зардлын дүн;

40.3.5. нягтлан бодох бүртгэлийг этлөн явуулахад баримтлсан бодлогын тухай айлбар;

40.3.6. тухайн жилийн санхүүгийн йл ажиллагааны дүн, жилийн эцсийн санхүүгийн айдлыг үнэн зөв илэрхийлэхэд шаардлагатай усад мэдээллэл;

40.3.7. холбогдох тайлан болон эдэгдэлд заасан, үйл ажиллагааны хэтийн элөвлөгөөний үзүүлэлтэд хүрсэн байдал;

40.3.8. холбогдох тайлан болон эдэгдэл бүрээр өмнөх санхүүгийн жилд хүрсэн үвшин;

40.3.9. санхүүгийн тайлангийнүнэн в болохыг тодорхойлж ерөнхий менежер, ерөнхий ягтлан бодогчийн гарын үсэг зурсан мэдэгдэл.

40.4. Улсын төсвийн байгууллага хагас, бүтэн жилээр бүтээгдэхүүний анги төрөөр тоо хэмжээ, чанар, өртөг болон хугацааны биелэлтийг тусгасан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг гаргана.

40.5. Улсын төсвийн байгууллага жилийн эцсийн тайлангаа энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан төрийн аудитын төв байгууллагын аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад хүргүүлнэ.

41 дүгээр зүйл. Улсын төсвийн байгууллагын улирлын болон сарын тайлан

41.1. Ерөнхий менежер сар бүрийн эцэст санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид, улирал бүрийн эцэст бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад хүргүүлнэ.

41.2. Энэ хуулийн 41.1-д заасан тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан маягтын дагуу гаргана.

41.3.Улирлын тайланд дараахь зүйлийг тусгана:

41.3.1.тухайн байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн явц;

41.3.2. ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийн явцыг дүгнэхэд шаардлагатай бусад мэдээллэл.

42 дугаар зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тайлан

42.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай[1] болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана.

42.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна.

42.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор тайлангаа аудитын дүгнэлтийн хамт Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албаны төв байгууллага болон төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого

43 дугаар зүйл. Төрийн албаны төв йгууллага

43.1. Төрийн албаны төв байгууллага нь төсвийн байгууллагын удирдах албан тушаалтныг

[1] Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 1 дугаарт нийтлэгдсэн

энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг баримтлан сонгоно.

43.2. Төрийн албаны төв байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааг Төрийн албаны тухай[1] хуулиар зохицуулна.

44 дүгээр зүйл. Төрийн албаны төв байгууллагын бүрэн эрх

44.1. Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны тухай хууль зааснаас гадна дараахь бүрэн эрхтэй:

44.1.1. улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явцад хяналт тавих;

44.1.2.улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүлээн авах, гаргуулж авах;

44.1.3. энэ хуулийн 45.1-д заасан албан тушаалд нэр дэвшүүлэх;

44.1.4. улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хангуулах;

44.1.5. энэ хуулийн 45.1-д заасан албан тушаал болон улсын ба орон нутгийн төсвийн байгууллагад ажиллах чадвартай хүмүүсийн судалгаа, бүртгэлийг эрхэлж, төсвийн байгууллагыг мэдээллээр хангах.

44.2. Төрийн албаны төв байгууллага нь ажлын албатай байна.

45 дугаар зүйл. Төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх журам

45.1. Төрийн албаны төв байгууллага нь дараахь албан тушаалд 3-5 хүний нэрийг дэвшүүлж, түүнийг томилох эрх бүхий этгээдэд санал болгоно:

45.1.1. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга,

45.1.2. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

45.1.3. төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

45.1.4. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ерөнхий менежер;

45.1.5.агентлагийн ерөнхий менежер;

45.1.6. Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга;

45.1.7. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

45.1.8. төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн.

45.2. Төрийн албаны төв байгууллага нь сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө тухайн албан тушаалын талаар нийтэд мэдээлнэ.

45.3. Энэ хуулийн 45.1-д заасан албан тушаалтныг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхэд улс төрийн хүчин, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс төрийн албаны төв байгууллагад нөлөө үзүүлэхийг хориглоно.

45.4. Төрийн албаны төв байгууллага нь албан тушаалд нэр дэвшигчдийг төсвийн ерөнхийлөн захирагч буюу төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, хэрэгэн сонгосноо, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын хамт нийтэд мэдээлнэ.

45.5. Төсвийн ерөнхийлөн захирагч төрийн албаны төв байгууллагын ерөнхий менежерт санал болгосон нэр дэвшигчдээс нэг хүнийг сонгож томилно.

45.6. Төсвийн ерөнхийлөн захирагч төрийн албаны төв байгууллагын санал болгосон нэр дэвшигчдийг сонгож томилохоос 1 удаа татгалзаж эрхтэй.

45.7. Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, агентлагийн ерөнхий менежерийг 3 жилийн хугацаагаар томилно. Тэдгээрийн ажлын үр дүнг харгалзан бүрэн эрхийнь хугацааг тухай бүр 2 жилээр сунгаж болно.

46 дугаар зүйл. Төрийн албаны төв байгууллага санал гаргах

46.1. Төрийн албаны төв байгууллага нь энэ хуулийн 45.1-д заасан албан тушаалтны цалин хөлсний талаар дараахь этгээдэд санал гаргана:

46.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, дэд даргын талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

46.1.2. төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн ерөнхий менежерийн талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

46.1.3. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ерөнхий менежерийн талаар холбогдох Байнгын хороотой зөвлөлдөн Улсын Их Хуралд;

46.1.4. Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга, дэд даргын талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

46.1.5. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, дэд даргын талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад.

46.2.Төрийн албаны төв байгууллага нь удирдах албан тушаалтны цалин хөлсний талаар санал боловсруулахдаа албан тушаалаас гадна ажлын үр дүнгээс хамаарах чиглэлийг баримтлан дараахь шаардлагыг харгалзана:

[1] *Төрийн албаны тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн*

46.2.1. адил албан тушаалд адил
эмжээний цалин хөлс тогтоох;
46.2.2. тухайн албан тушаалын
ариуцлагын түвшин;
46.2.3. тухайн албан тушаалын
үргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар.
46.3. Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн
ерөнхий менежерийн цалин хөлсний хэмжээг
огтоохдоо төрийн албаны төв байгууллагын
аналыг харгалзаж үр дүнгийн гэрээнийг
эрэгжилтийг үндэслэнэ.
46.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн
жилтах нөхцөл, баталгаа нь Төрийн албаны тухай
ууль болон энэ хуульд заасан зарчмаар хэрэгжинэ.

47 дугаар зүйл. Үр дүнгийн гэрээг дүгнэх

47.1. Төрийн албаны төв байгууллага нь
өсвийн ерөнхийлөн захирагч холбогдох удирдах
албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн
байгууллагын албан хаагчтай байгуулах үр дүнгийн
эрээ, түүнийг дүгнэх заавар, журмыг батална,
иелэлтэд нь хяналт тавина.
47.2. Ерөнхий менежерийн үр дүнгийн
эрээний биелэлт, ажлын үр дүнг тухайн
байгууллагын улирал, жилийн тайлан болон санхүү,
өсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв
байгууллага, төрийн албаны төв байгууллагын
үгнэлтэд тулгуурлан төсвийн ерөнхийлөн захирагч
нэлнэ.
47.3. Ерөнхий менежер нь энэ хуулийн 47.2-
заасан үнэлгээнд хангалттүй үнэлэлт авсан бол
өсвийн ерөнхийлөн захирагч түүнийг халах тухай
ийдвэр гаргах бүрэн эрх бүхий байгууллагад энэ
ухай саналаа гаргаж болно.

48 дугаар зүйл. Албан хаагчийг томилох

48.1. Улсын болон орон нутгийн төсвийн
байгууллагын ерөнхий менежер албан хаагчийг
томилохдоо тухайн ажлын байранд тавигдах
шаардлагын дагуу мэдлэг, боловсрол, мэргэжил,
туршлага, мэргэшлийн үр чадварыг нь үндэслэх
зарчмыг баримтална.
48.2. Ерөнхий менежер нь өөрийн
байгууллагын удирдах албан тушаалтныг ямар
шалгуураар томилсон тухайгаа төрийн албаны төв
байгууллагад бичгээр мэдэгдэнэ. Төрийн албаны
төв байгууллага нь сонирхсон байгууллага, хувь
хүмүүсийг уг мэдээлэлтэй танилцах боломжоор
хангана.
48.3. Ерөнхий менежер хүний нөөцийн
асуудлаар хуулиар олгогдсон бүрэн эрхээ
хэрэгжүүлэхээд төрийн албаны төв байгууллага
хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

49 дүгээр зүйл. Албан хаагчид урамшуулал олгох

49.1. Ерөнхий менежер тухайн байгууллагын
албан хаагчид ажлын үр дүнгээр нь урамшуулал
олгох эрхтэй.
49.2. Урамшуулал олгохоос дараахь зүйлийг
харгалзана:
49.2.1. бүтээгдэхүүн нийлүүлэх,
өөрийн бүюу удирдаж байгаа ажилтнуудынхаа
ажлын үр дүнг сайжруулахад түхайн албан хаагчийн
оруулсан хувь нэмэр;
49.2.2. байгууллагын үйл
ажиллагааны санхүүгийн үр дүн болон урсгал
зардлын хэмнэлтийн хэмжээ.
49.3. Урамшуулын хэмжээ, хэлбэрийг
ерөнхий менежер тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Орон нутаг дахь төсвийн удирдлага, санхүүжилт

50 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн урлын төсвийн удирдлага, санхүүжилтийн алаархи бүрэн эрх

50.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн
ргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутаг дахь
өсвийг удирдлага, санхүүжилтийн талаар дараахь
үрэн эрхтэй:
50.1.1.Засаг даргын үйл
жиллагааны хөтөлбөр, хэтийн төлөвлөгөөг
элэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
50.1.2.тухайн жилийн орон нутгийн
өсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хянах;
50.1.3. орон нутгийн төсвөөс
анхүүжүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоож
атлах, бүтээгдэхүүн нийлүүлэх талаар Засаг
ргатай гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах;
50.1.4. Засаг даргын улсын төсвийн
ерөнгөөр бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний
өлэлтэй урьдчилан танилцаж, бүтээгдэхүүний тоо
мжээ, зардал, гэрээг дүгнэх болзол, журмын
лаар санал, дүгнэлт гаргах.
50.2. Засаг даргатай байгуулах гэрээг
ргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
рга Хурлаа төлөөлж байгуулна.

50.3. Аймаг, нийслэлийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 52.2-т заасан
бүтээгдэхүүн нийлүүлэх үүргийг аймаг, сум болон
нийслэл, дүүрэгт 4 жилийн хугацаатайгаар заагласн
тогтооно.
50.4. Орон нутгийн өмчит болон орон нутгийн
өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага,
санхүүжилтийн харилцаат зохицуулах журмыг энэ
хуулийн 22, 28.1, 42 дугаар зүйлд заасныг жишиг
болгон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурал тогтооно.
50.5. Орон нутгийн өмчит болон орон нутгийн
өмчийн оролцоотой хуулийн этгээдийн энэ хуулиар
зохицуулагүй бусад харилцаат Төрийн болон орон
нутгийн өмчийн түхай хуулиар зохицуулна.
50.6. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн
төсөвтэй байна.

51 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

51.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг
дарга дараахь бүрэн эрхтэй:
51.1.1. үйл ажиллагааны хөтөлбөр

болон үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах;

51.1.2. тєсвийн тєсєл боловсруулах;

51.1.3. тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдан үйл ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд нийцүүлэн орон нутгийн төсвийн байгуулагын үйл ажиллагааг чиглүүлэх;

51.1.4. орон нутгийн төсвийн байгуулага, бусад этгээдээс худалдаж авах бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлж, гэрээ байгуулах;

51.1.5. орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах;

51.1.6. орон нутгийн төсвийн байгуулага, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өрөнхий менежерийг улсын төсвийн байгуулага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өрөнхий менежерийг томилдог зарчимтай ижил зарчмаар шалгаруулан томилох, үр дүнгийн гэрээ байгуулах;

51.1.7. үр дүнгийн гэрээнд заасан орон нутгийн төсвийн байгуулага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, санхүүгийн үр дүнд хяналт тавих;

51.1.8. улсын төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн асуудлыг эрхэлсэн төсвийн өрөнхийлөн захирагчтай, бусад шатны Засаг дарга дээд шатны Засаг даргатай гэрээ байгуулах;

51.1.9. орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар ирэгдийн Төлөөлөгчдийн Хуралтай гэрээ байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

51.1.10. энэ хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн эх үүсвэрээс бүрдүүлэх.

52 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын үүрэг

52.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 51.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

52.1.1. аймаг, нийслэлийн төсвийн татварын болон татварын бус орлого, улсын төсвөөс олгох шилжилтийн хугацааны санхүүгийн дэмжлэгт багтаан энэ хуулийн 52.2-т заасан бүтээгдэхүүнийг нийлүүлэх;

52.1.2. Засгийн газрын худалдан авах бүтээгдэхүүн (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад)-ийг улсын төсвийн хөрөнгөөр гэрээний дагуу нийлүүлэх.

52.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хэрэгцээт дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

52.2.1.нийтийн ариун цэврийг хангах, хог зайлуулах, хадгалах, устгах;

52.2.2. орон нутгаас эрхлэх байгаль хамгаалах арга хэмжээ, тохижилт, цэцэрлэгжилт, түүний өргөтгөл, шинэтгэл, арчилгаа;

52.2.4. хортон амьтан устгах;

52.2.5. орон нутгийн замын засвар, арчилгаа;

52.2.6. усан хангамж, цэвэрлэх байгуулламжийн хэвийн үйл ажиллагаа хангах;

52.2.7. үерийн хамгаалалт хийх, хөрсний элэгдэлтэй тэмцэх;

52.2.8. гал түймрээс хамгаалах арга хэмжээ;

52.2.9. орон нутгийн өмчийн дэд бүтэц;

52.2.10. мал, амьтны болон малаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

52.2.11. бусад.

52.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга орлогоосоо хэтэрсэн зарлага гаргаж алдагдалд орох, харилцах данс нь ертэй байх, гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүний санхүүжилтэд олгосон хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

53 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын үүрэг

53.1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 51.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараахь үүрэгтэй:

53.1.1. сум, дүүргийн төсвийн татварын болон татварын бус орлого, аймаг, нийслэлийн төсвөөс олгох татаост багтаан энэ хуулийн 52.2-т заасан сум, дүүргийн хариуцах бүтээгдэхүүнийг нийлүүлэх;

53.1.2. энэ хуулийн 52.1.2-т заасан Засгийн газар худалдан авах бүтээгдэхүүн (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад)-ийг аймаг, нийслэлийн Засаг даргатай хийсэн гэрээнийг үндэсн дээр нийлүүлэх.

54 дүгээр зүйл. Орон нутгийн төсвийг удирдах

54.1. Орон нутгийн төсвийн байгуулагад энэ хуулийн 13.1-13.4, 13.7 дахь хэсэг, 14, 15, 17, 26, 27, 40, 47 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

55 дугаар зүйл. Орон нутгийн өмч болон орон нутаг дахь төрийн өмчийг эзэмших, ашиглах

55.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгуулага үндэсн бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг тухайн нэгжийн балансад бүртэнэ.

55.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгуулага өөрийн балансад байгаа эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хариуцна.

55.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгуулагын өрөнхий менежер байгуулагын балансад байгаа эд хөрөнгийг бүрэн эрхийнхээ хүрээнд зэзмшиж ашиглана.

55.4. Орон нутгийн төсвийн байгуулага өөр байгаа орон нутгийн өмчийн эд хөрөнгө ашигласнь

төлбөрийг жил бүр орон нутгийн төсөвт төлнө.

56 дугаар зүйл. Орон нутаг зээл авах

56.1. Аймаг, нийслэлийн хэрэгцээнд зориулан Засаг дарга улсын төсвөөс зээл авч болно.

57 дугаар зүйл. Улсын болон орон нутгийн төсвийн харилцаа

57.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал улсын төсөөс орон нутгийн төсөвт олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн орлогын нэгэн адил хуваарилж батална.

57.2. Засгийн газар орон нутгийн төсвийн байгууллагаас гэрээний үндэсэн дээр бүтээгдэхүүн худалдаж авч болно. Энэ тохиолдолд санхүүжилтийн эх үүсвэрийг нь Засгийн газар шийдвэрлэнэ.

57.3. Орон нутгийн төсөв хүрэлцэхгүй бол Засгийн газар хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

57.4. Засгийн газар улсын төсөөс санхүүжүүлэх зарим бүтээгдэхүүний нийлүүлэлтийг орон нутагт шилжүүлж болно.

58 дугаар зүйл. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлах

58.1. Засаг дарга дараа жилийн төсвийн төслийг 12 дугаар сарын 1-ний өдрийн өмнө тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

58.2. Орон нутгийн төсвийн төсөлд дараахь зүйлийг тусгана:

58.2.1. орон нутгийн удирдлагын богино болон дунд хугацааны хэтийн зорилтууд;

58.2.2. худалдан авах бүтээгдэхүүний анги, нийлүүлэх байгууллага, худалдан авах зардал;

58.2.3. хөрөнгө оруулалтын төлөвлөгөө;

58.2.4. эд хөрөнгө, санхүүгийн болон хүний нөөцийн ашиглалт зэрэг өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зорилтууд;

58.2.5. жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй жил үзүүлэлтээр боловсруулсан дараа жилийн төсөвлөсөн санхүүгийн тайлан;

58.2.6. Засаг даргын худалдаж авах бүтээгдэхүүний анги нь түүний хэтийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа тухай тайлбар;

58.2.7. өмнөх жилийн төсөв болон төсвийн гүйцэтгэлийг харьцуулсан дүн.

58.3. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн тєслийг 1 сарын дотор хэлэлцэж батална.

58.4. Аймаг, нийслэлийн төсвийг батласнаас хойш 7 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

59 дүгээр зүйл. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах журам

59.1. Засаг дарга санхүүгийн жил дуусснаас хойш 20 хоногийн дотор орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг энэ хуулийн 37, 38 дугаар зүйлд заасны дагуу тайлагнана.

59.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан үнэн зөв болохыг тодорхойлж Засаг дарга, орон нутгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурна.

59.3. Засаг дарга энэ хуулийн 38.4-т заасан аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор жилийн эцсийн санхүүгийн тайланг орон нутгийн төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлттийн хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ. Тайлан батлагдсанаас хойш 7 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хяналт

60 дугаар зүйл. Төрийн аудитын төв байгууллагын бүрэн эрх

60.1. Төрийн аудитын төв байгууллага нь Төрийн хяналт, шалгалтын тухай[1] хуульд зааснаас гадна төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулна.

60.2. Энэ хуулийн 60.1-д заасан байгууллага, аж ахуйн нэгж аудит хийхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

61 дүгээр зүйл. Монгол Улсын ерөнхий аудиторын үүрэг

61.1. Төрийн аудитын төв байгууллагын дарга Монгол Улсын ерөнхий аудитор байна.

61.2.Монгол Улсын ерөнхий аудитор дараахь үүрэг зүгээнэ:

61.2.1. төсвийн байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх, холбогдох стандарт, журмыг батална, аудит нь олон улсын стандартад нийцсэн байх зарчмыг хангуулах;

61.2.2. аудитор нь аудит хийлгэж байгаа байгууллагаас харааг бус байх зарчмыг мөрдүүлэх;

61.2.3. аудитыг мэргэжлийн өндөр

[1] *Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 4 дүгээрт нийтлэгдсэн*

тушинд зохих журмын дагуу хийх нөхцлийг хангах;

61.2.4. Улсын Их Хурлын өмнө аудитын дүгнэлтийн үнэн зөв байдлыг хариуцах.

62 дугаар зүйл. Аудитыг гэрээгээр гүйцэтгэх

62.1. Төрийн аудитын төв байгууллага тогтоосон хүрээнд аудит хийж, дүгнэлт гаргах ажлыг бусад аудитын байгууллагаар гэрээнийг үндэсэн дээр гүйцэтгүүлж болно.

62.2. Төрийн аудитын төв байгууллага аудитын бусад байгууллагын гэрээгээр гүйцэтгэсэн ажлын чанарыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

63 дугаар зүйл. Төрийн аудитын төв байгууллагад аудит хийх

63.1. Төрийн аудитын төв байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг тухай бүр сонгон шалгаруулж Улсын Их Хурлын дарга томилсон хараат бус мэргэжлийн аудитор шалгаж, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна.

64 дүгээр зүйл. Засгийн газрын санхүүгийн дотоод хяналт

64.1. Засгийн газар нь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагад санхүүгийн хяналт, шалгалт хийнэ.

64.2. Засгийн газрын санхүүгийн дотоод хяналт, шалгалтыг тухайн асуудлыг эрхэлсэн хяналт, шалгалтын алба, төрийн захиргааны төв байгууллагуудын дотоод хяналтын албад хэрэгжүүлнэ.

64.3. Санхүүгийн хяналт, шалгалтад төрийн захиргааны болон Засгийн газраас байгуулдаг бусад байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдана.

64.4. Санхүүгийн хяналт, шалгалтыг дор дурдсан чиглэлээр хийнэ:

64.4.1. санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;

64.4.2. тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төлөвөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт;

64.4.3. өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт;

64.4.4. санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;

64.4.5. төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;

64.4.6. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан;

64.4.7. гадаад улс орон, олон улсын байгууллага, Засгийн газрын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;

64.4.8. улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;

64.4.9. дээд шатны төсөвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;

64.4.10. байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

64.5. Санхүүгийн хяналт, шалгалтыг байгууллагын хүсэлт, дээд шатны байгууллагын шийдвэрээр хийж болно.

64.6. Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч нь шалгуулсан байгууллагын үйлдвэрлэл, эдийн засгийн үйл ажиллагаа, төсөвт хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, санхүү, бүртэлийн ажилд үнэлэлт дүгнэлт өгнө.

64.7. Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч нь шалгалтаар тогтоогдсон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон нэгдсэн акт, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт бичнэ.

65 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

65.1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг байгууллага, хувь хүн нотлох баримтын хамт төрийн албаны төв байгууллагад ирүүлж болно.

65.2. Төрийн албаны төв байгууллага нь энэ хуулийн 65.1-д заасан мэдээллийн дагуу шалгаж эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь арга хэмжээ авна:

65.2.1. илэрсэн зөрчлийг арилгуулах;

65.2.2. шаардлагатай бол ерөнхий менежерийг албан тушаалаас чөлөөлөх тухай саналаа эрх бүхий байгууллагад тавих;

65.2.3. ерөнхий менежерийн ажлыг дүгнэх, урамшуулахад зөрчлийг харгалзан үзэх;

65.2.4. төсвийн байгууллагын ерөнхий менежерээс бусад албан тушаалтан хуульзөрчсөн бол түүнд арга хэмжээг авахуулахаар тухайн байгууллагын удирдлагад санал болгох.

65.3. Энэ хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн нь тухайн албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болно.

66 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

66.1. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн албаг /цаашид "төрийн албаг" гэх/-ны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн албаг хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хууль тогтоомж

2.1. Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төрийн албаг, түүний ангилал

3.1. Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн албаг гэнэ.

3.2. Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

3.3. Төрийн албыг дор дурдсанаар ангилна:

3.3.1. төрийн улс төрийн албаг;
3.3.2. төрийн захиргааны албаг;
3.3.3. төрийн тусгай албаг;
3.3.4. төрийн үйлчилгээний албаг.

3.4. Энэ зүйлийн 3.3.2, 3.3.3-т заасан албыг төрийн жинхэнэ албаг гэнэ.

4 дүгээр зүйл.Төрийн албаны зарчим

4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.

4.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараахь зарчмыг баримтална:

4.2.1. захирах, захиргадах ёс;
4.2.2. ил тод байх;
4.2.3. ард түмэнд үйлчлэх;
4.2.4. иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх;
4.2.5. төрийн албаг мэргэшсэн, тогтвортой байх;
4.2.6. төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;
4.2.7. хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төрийн албан тушаал

5 дугаар зүйл.Төрийн албан тушаалын ангилал, төрөл

5.1. Төрийн албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

5.1.1. төрийн улс төрийн;
5.1.2. төрийн захиргааны;
5.1.3. төрийн тусгай;
5.1.4. төрийн үйлчилгээний.

5.2. Энэ зүйлийн 5.1.2, 5.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ.

5.3. Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна.

5.4. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг Улсын Их Хурал тогтооно.

6 дугаар зүйл.Төрийн улс төрийн албан тушаал

6.1.Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогдог болон уг сонгуулийн үр дүнд томилогдын

Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" мхтэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд еөрт нь үйлчлэх орон тооны дараахь албан тушаал хамаарна:

6.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
6.1.2. Монгол Улсын Их Хурлын дарга;
6.1.3. Монгол Улсын Ерөнхий сайд;
6.1.4. Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;
6.1.5. Монгол Улсын Засгийн газрын гишүүн;
6.1.6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
6.1.7. дэд сайд;
6.1.8. Ерөнхий сайдын зөвлөх;
6.1.9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
6.1.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх;
6.1.11. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
6.1.12. бүх шатны Засаг дарга;
6.1.13. Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн;

6.1.14. улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн еөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;

6.1.15. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал;

6.1.16. хуульд заасан бусад албан тушаал.

6.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэх болно.

6.3. Энэ зүйлийн 6.1.14-т заасан албан тушаал эрхэлдэг ажилтан нь улс төрийн тухайн албан тушаалтанд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд холбогдох төрийн байгууллагын ажлын албанд харьяалагдана.

6.4. Улс төрийн албан тушаалтан хуульд заасан үндэслэлээр уг албан тушаалаас өөрчлөгдвөл энэ зүйлийн 6.1.14-т заасан ажилтан чөлөөлөгдөнө. Гэхдээ шинээр сонгогдсон буюу томилогдсон төрийн улс төрийн албан тушаалтан хүсвэл уг ажилтныг еөрт нь үйлчлэх орон тооны ажилтнаар үргэлжлүүлэн ажиллуулж болно.

7 дугаар зүйл.Төрийн захиргааны албан тушаал, түүний ангилал

7.1. Төрийн захиргааны албан тушаалд дараахь албан тушаал хамаарна:

7.1.1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.2. Сонгуулийн еөрөнхий хорооны ажлын албаны албан тушаал;

7.1.3. энэ хуулийн 8.1.2-т зааснаас бусад Монголбанк, Үнэт цаасны хорооны болон Үндэсний статистикийн газрын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.5. Төрийн хяналт шалгах хорооны ажлын албаны гүйцэтгэх албан тушаал;

7.1.6. Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.7. Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, хуульд еөрөөр заагаагүй бол тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.8. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн;

7.1.9. Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.10. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.11. хуульд заасан бусад албан тушаал.

7.2. Төрийн захиргааны албан тушаалыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын гэж бүлэглэнэ.

7.3. Төрийн захиргааны албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

7.3.1. тэргүүн түшмэл;
7.3.2. эрхэлсэн түшмэл;
7.3.3. ахлах түшмэл;
7.3.4. дэс түшмэл;
7.3.5. туслах түшмэл.

7.4. Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.5. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, түүний орлогч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.6. Ахлах түшмэлийн албан тушаалд яамны хэлтэс, тасгийн дарга, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.7. Дэс түшмэлийн албан тушаалд яамны байцаагч, мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.8. Туслах түшмэлийн албан тушаалд

яамны туслах байцаагч, туслах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.9. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газрын ажлын албаны удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг Улсын Их Хурал тогтооно.

7.10. Хуульд өөрөөр заагаагүй бол яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл.Төрийн тусгай албан тушаал

8.1.Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна:

8.1.1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

8.1.2. Монголбанкны Ерөнхийлөгч, тэрүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга, Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;

8.1.3. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Төрийн хянан шалгах хорооны дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, хянан байцаагч;

8.1.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;

8.1.5. дипломат ажилтан;

8.1.6. зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг буртгэх, мерген байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч;

8.1.7. хуульд заасан бусад албан тушаал.

8.2. Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

9 дүгээр зүйл.Төрийн үйлчилгээний албан тушаал

9.1. Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахаар хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч ажиллуулах дараахь албан тушаал хамаарна:

9.1.1. төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаг хангахад туслах албан тушаал;

9.1.2. боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал;

9.1.3. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллага болон хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

9.1.4. яам, тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал.

9.2. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.

10 дугаар зүйл.Төрийн албан тушаалд тавих шаардлага

10.1. Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх явдал мөн.

10.2. Энэ хуулийн 5.1.1-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.

10.3. Энэ хуулийн 5.1.3-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.

10.4. Засгийн газар шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоож болно.

10.5. Төрийн үйлчилгээний албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагч

11 дүгээр зүйл.Төрийн албан хаагч

11.1. Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ.

11.2. Энэ хуулийн 5.1.2, 5.1.3-т заасан албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ.

11.3. Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар

тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

11.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

11.5. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль[1], энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

11.6. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг

12.1. Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх ороходоо: "Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангаргалгаа. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" хэмээн тангараг өргөнө.

12.2. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын жүрмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

13 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг

13.1. Төрийн жинхэнэ албан хаагч нь дараахь нийтлэг үүргээ хүлээнэ:

13.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

13.1.2. өргөсөн тангарагтаа үнэнч байх;

13.1.3.эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;

13.1.4. харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

13.1.5. төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

13.1.6. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэшлээ дээшлүүлэх;

13.1.7. албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах;

13.1.8. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөл автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

13.1.9. албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

13.1.10. төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх;

13.1.11. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх

14.1. Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг эрх эдэлнэ:

14.1.1. төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;

14.1.2. үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн талаар харьяалах дээд шатны удирдах ажилтны үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

14.1.3. цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих;

14.1.4. өөрийн хувийн хэрэг болон түүнд оруулах ажил байдлын тодорхойлолт зэрэг материалтай танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгттээ нэмэлт тайлбар хийх;

14.1.5. өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах;

14.1.6. мэргэжлийн зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

14.1.7. хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалыхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагаа өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх эрэгээ орлого олох;

14.1.8. төрийн албанаа чөлөөлөгдөх;

14.1.9. хууль тогтоомжид зааса бусад эрх.

[1] *Хөдөлмөрийн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.*

15 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

15.1. Төрийн жинхэнэ албан хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

15.1.1. албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;

15.1.2. ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

15.1.3. албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

15.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;

15.1.5. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснээс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэнийг зардлаар гадаад, дотоодод зорчих;

15.1.6. албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, ээлэл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

15.1.7. албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;

15.1.8. нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

15.1.9. аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдад зуучлах;

15.1.10. хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн удирдах зөвлөлийн болон захираганы гишүүн байх;

15.1.11. албан тушаал эрхэлдэг төрийн байгууллагад, эсхүл шууд удирдлага, хяналтад нь ажиллаж байгууллагад гурав дахь этгээдийн төлөөлөгч буюу итгэмжлэгдсэн этгээд байх;

15.1.12. хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авах;

15.1.13. хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага зөвшөөрснээс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн дотор сүүлийн 5 жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаалынхаа дагуу шууд холбоотой ажилладаг байсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид албан тушаал эрхлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам

16 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол

16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлахыг үл болно.

16.2. Төрийн жинхэнэ албан тушаалд дараахь тохиолдолд авч ажилуулахыг хориглоно:

16.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол Эрүүгийн хуульд[1] заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй;

16.2.2. төрийн жинхэнэ албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй;

16.2.3. хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

16.2.4. гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

16.2.5. хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

16.3. Энэ зүйлийн 16.2, мөн хуулийн 17.1, 17.4, 25 дугаар зүйлд заасныг зөрчиж иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүйд тооцож, буруутай албан

[1] *Эрүүгийн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.*

тушаалтанд энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

17 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах

17.1. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг эр нь сонгон шалгаруулах замаар үр орон тоог нөхнө.

17.2. Энэ хуулийн 10.1, 10.3, 10.4-т заасан шаардлага, мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаалд орох эрхтэй.

17.3. Төрийн жинхэнэ албан тушаалд орох хүсэлтэй, энэ хуулийн 10.1, 10.3, 10.4-т заасан шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид "мэргэшлийн шалгалт" гэх/ авч онооны дэс дараалlaар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ.

17.4. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авна.

17.5. Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

17.6. Мэргэшлийн шалгаруулалтаар шалгарсан иргэнийг зохих албан тушаалд томилсон тухай төрийн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж батлагаажуулна.

17.7. Энэ хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас халагдсан хүмүүс төрийн жинхэнэ албанд эргэж ороход энэ зүйлд заасан журмын дагуу мэргэшлийн шалгалт өгнө.

17.8. Төрийн захиргааны болон түсгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах болзол, журам, түүнчлэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журмыг төрийн албаны төв байгууллага тогтоно.

18 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албаны туршилтын хугацаа

18.1.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орсон албан хаагчид туршилтын хугацааг 1 жил хүртэл хугацаагаар тогтоож болно.

18.2. Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журмыг төрийн албаны төв байгууллага тогтоно.

19 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх

19.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ.

19.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

19.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага тогтоно

20 дугаар зүйл.Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв

20.1. Төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь түс бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

20.2. Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч; эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд; ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын сайд, төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

20.3. Зэрэг дэв олгохдоо төрийн албанд ажилласан бүсүү тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзана.

20.4. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

20.5. Төрийн албаны зарим онцлог салбарын албан тушаалын зэрэг дэвийг хуулиар тогтоож болно.

21 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх

21.1. Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцэх эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно.

21.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан

хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

22.1. Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.

22.2. Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгуллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгуллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацаог 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

22.3. Энэ зүйлийн 22.2-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.

23 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас нь бууруулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх

23.1. Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар албан тушаал бууруулж болно:

23.1.1.албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалттүй биелүүлсэн;

23.1.2. үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь төрийн тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон.

23.2. Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших болсон бол хуульд заасан нэр дэвших ажлыг эхлэх өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

23.3. Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар төрийн албанаас түр чөлөөлнө:

23.3.1. хуульд өөрөөр заагаагүй бол иеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс ээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр мчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;

23.3.2. гурван сараас дээш угацааны сургалтаар бэлтгэгдэх болсон;

23.3.3. цэргийн жинхэнэ алба хаах олсон.

23.4. Төрийн жинхэнэ албан хаагч төрийн улс өрийн албан тушаалд сонгогдон буюу томилогдон ажиллах болсон, эсхүл төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллах болсон бол түүнийг төрийн жинхэнэ албанаас чөлөөлнө.

23.5. Энэ зүйлийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, мөн зүйлийн 23.2, 23.4-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийг нөөцөд байгаад тооцно.

24 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх

24.1. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө:

24.1.1. тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

24.1.2. төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

24.1.3. өөрийн саналчилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

24.2. Төрийн захиргааны албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх эсэх тухай хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал, хүсэлт зэргийг харгалзан авч үзсэний үндсэн дээр ёсоор болгох, эсхүл түүнийг төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэнэ.

24.3. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.

24.4. Төрийн захиргааны албан хаагч нь төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

24.5. Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн захиргааны албан хаагч үргэлжлүүлэн ажиллах хүсэлтээ гаргавал байгууллагын шийдвэрээр ажиллах хугацааг 5 хүртэл жилээр сунгаж болно.

25 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас халах

25.1. Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас хална:

25.1.1. удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалттүй биелүүлсэн;

25.1.2. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

25.1.3. Монгол Улсын харьяатаас гарсан.

26 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан

хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

26.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаг зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

26.1.1. сануулах;

26.1.2. албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

26.1.3. төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

26.2. Энэ зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.

26.3. Төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон төрийн байгуулагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

26.4. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гарсаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

26.5. Нэг төрлийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.

26.6. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрээс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүй тооцно.

26.7. Энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

26.8. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрээс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгуллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

26.9. Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд төрийн дээд шатны байгуллагад гомдол гаргах журмыг Засгийн газар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа

27 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн баталгаа

27.1. Төрийн албан хаагч дараахь баталгаагаар хангагдана:

27.1.1. төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах;

27.1.2. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

27.1.3. гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;

27.1.4. албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гутгэх болон бусад хуульд бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн нь тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллагаар хамгаалуулах;

27.1.5. төрөөс орон байраар хангагдах;

27.1.6. Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон зэгжийн амралт эдлэх;

27.1.7. төрийн албэ хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах;

27.1.8. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах;

27.1.9. төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах;

27.1.10. гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхдийнх нь сургалтын зардлыг дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр тооцож төр хариуцах;

27.1.11. хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа.

27.2. Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нэмэгдэл баталгаагаар хангагдана:

27.2.1. энэ хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;

27.2.2. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

27.2.3. төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь

үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө буруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг түхайн байгууллагаас олгоно;

27.2.4. төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сурахад нь зориулан байгууллагаас нь хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгөх.

27.3. Энэ хуулийн 6.1.6-6.1.11-д заасан улс төрийн албан тушаалтан зээлжит сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдөн бол түүнд урьд авч байсан албан тушаалын 6 сарын хугацаанд цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

28 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн цалин хөлс

28.1. Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.

28.2. Төрийн албан хаагчийн цалин хөлс нь:

28.2.1. улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;

28.2.2. төрийн захирагааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс;

28.2.3. тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс;

28.2.4. үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, үр чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

28.3. Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

28.4. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сулжээ, жишгийг тогтооход дараахь шаардлагыг харгалзан үзнэ:

28.4.1. төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох;

28.4.2. төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь нийтийн амьжиргааны түндэж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байх;

28.4.3. төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сулжээ, жишгийг албан тушаалын ангилал, зэрэглэл болон төрийн тухайн албан тушаал эрхэлсэн хугацаанаас хамааралтайгаар төрийн албаны салбар, төрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр боловсруулж мөрдүүлэх.

28.5. Улс төрийн болон түсгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч/сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, зөвсөгч хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түсгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сулжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

28.6. Дор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сулжээ, жишгийг Засгийн газар тогтооно:

28.6.1. сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;

28.6.2. төрийн захирагааны албан хаагч;

28.6.3. зөвсөгч хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан;

28.6.4. үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч.

28.7. Улс төрийн болон энэ хуулийн 8.1.1-8.1.3-т заасан түсгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг хууль тогтоомжоор тогтоно.

28.8. Төрийн захирагааны албан хаагчийн нэмэгдэл олгох журам, хэмжээг Засгийн газар тогтоно.

28.9. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг Засгийн газар тогтооно.

29 дүгээр зүйл. Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

29.1. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаар хангах зорилгоор түүний цалин хөлснөөс төлбөл зохих бүх шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80-аас доошгүй хувийг төрийн байгууллагын төсөөс нөхөн төлнө.

29.2.Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөр олгоно:

29.2.1. албан томилолтын зардал;

29.2.2. албан ажлын хэрэгцээнд батлагдсан нормативын дагуу хувийн унаа албан ажилдаа хэрэглэсэн тохиолдолд хувиас гарсан зардал;

29.2.3. гадаад улсад болон нэг аймаг, хотоос негөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор төрийн байгууллагад ажиллахаар томилогдсон албан хаагчид унаалга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжинд нь байдаг хүмүүст унаалга, ачаа тээшийн зардал;

29.2.4. хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр.

29.3. Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

30 дугаар зүйл.Төрийн албан хаагчид олгох тусламж

30.1. Энэ хуулийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас тур чөлөөлөгдсөн, мөн хуулийн 23.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тусламж олгож болно.

30.2. Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн захиргааны албан хаагчид 12 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн бүцалтгүй тусламж олгоно.

30.3. Хуульд өөрөөр заагаагүй бол албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт 3 жилийн албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн бүцалтгүй тусламж олгоно.

30.4. Төрийн албан хаагчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжээс гадна дараахь тохиолдолд тусламж олгож болно:

30.4.1. гэр бүрийг нь дэмжих;

30.4.2. эзлэхийн аврал таарааг өөрийн бүюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох;

30.4.3. гэр бүл, төрөл, садангийн хүн нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ тэтгэх;

30.4.4. хууль тогтоомжид заасан бусад тусламж.

30.5. Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.

31 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн шагнал, урамшил

31.1. Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж өндөр амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж төрийн байгууллагын захиргаа түүнийг дараахь байдлаар шагнаж, урамшуулна:

31.1.1. мөнгөн шагнал олгох;

31.1.2. эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах;

31.1.3. Засгийн газар ба төрийн дээд байгууллагаас шагнуулахаар тодорхойлох.

31.2. Төрийн албан хаагчид энэ зүйлийн 31.1.1-д зааснаас гадна улирлын жилын үр дүнгээр болон онцгой чухал бүюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсний төлөө мөнгөн урамшил олгоно.

31.3. Төрийн албан хаагчийг энэ зүйлийн 31.1.1, 31.1.2-т заасан шагналаар шагнах болон мөн зүйлийн 31.2-т заасан мөнгөн урамшил олгох журмы Засгийн газар, энэ зүйлийн 31.1.3-т зааснаар шагнал тодорхойлох журмыг хуулиар тус тус тогтооно.

31.4. Ажлын зайлшгүй шаардлагаар эзлэхий амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргаан албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшил олгох болно.

32 дугаар зүйл. Төрийн албан хаагчий тэтгэвэр, тэтгэмж

32.1. Төрийн албан хаагчид тэтгэвэр, тэтгэмж олгох, тэтгэврийн сан байгуулах, зарцуулах журмы хуулиар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт

33 дугаар зүйл.Төрийн албаны удирдлага

33.1. Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий эвлэл, Улсын ерөнхий прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

33.2. Төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг төрийн албаны төв байгууллага хэрэгжүүлнэ.

33.3. Төрийн албан хаагчийн шуурхай удирдлагыг төрийн байгууллагын ажлын албаны эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

33.4. Төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаат хангахтай холбогдсон дараахь асуудлаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ:

33.4.1. төрийн албан хаагчийн сургалт;

33.4.2. төрийн албан хаагчийн ажлын байдал;

33.4.3. төрийн албан хаагчий нийгмийн баталгаа;

33.4.4. төрийн албан хаагчийн эрүү мэнд;

33.4.5. төрийн албан хаагчий амралт, сувилал;

33.4.6. төрийн албан хаагчий аюулгүй байдал.

34 дүгээр зүйл.Төрийн албаны төв байгууллага

34.1. Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ мөн.

34.2. Зөвлөл нь хараат бус бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

34.3. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаа

ажиллах бөгөөд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн 3 нь орон тооны, 4 нь орон тооны бус байна.

34.4. Зөвлөлийн орон тооны 3 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигч нь төрийн албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан, ял шийтэлгүй, Монгол Улсын 35 нас хүрсэн иргэн байна.

34.5. Улсын Их Хурал Зөвлөлийн орон тооны гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно.

34.6. Зөвлөлийн орон тооны гишүүнээр нэг удаа улируулан томилж болно.

34.7. Зөвлөлийн даргыг орон тооны гишүүдийн дотроос Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.

34.8. Зөвлөлийн орон тооны бус гишүүн нь дор дурдсан албан тушаалтан байна:

34.8.1. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

34.8.2. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга;

34.8.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

34.8.4. Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга;

34.9. Зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогдсон хүний намын гишүүнийг түдгэлзүүлнэ. Зөвлөлийн орон тооны 3 гишүүний дотор нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн хоёр хүн байж болохгүй.

34.10. Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Улсын Их Хурал батална.

34.11. Зөвлөлийн орон тооны гишүүн нь гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль ноцтой зөрчөн бол түүнийг уг албан тушаалаас нь эгүүлэн татах тухай асуудлыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдэрлэнэ.

34.12. Зөвлөлийн орон тооны гишүүнээр нөхөн томилогдсон хүн нь орон гарсан өмнөх хүнийхээ бүрэн эрхийн үлдсэн хугацаанд уг албыг хашина.

34.13. Зөвлөл нь салбар зөвлөл, аймгийн албатай байна. Аймгийн албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө. Аймгийн албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална.

34.14. Зөвлөлийн орон тооны гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол цалин хөлсөө буруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд урьд авч байсан цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

35 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

35.1. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1. удирдлагын үндэсний чадавхийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

35.1.2. төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг үнэлэн шийдвэрлэх;

35.1.3. хууль тогтоомжийн актад нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх, биелэлтийг нь хангах;

35.1.4. төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн албан, төрийн албан хаагчтай холбогдолтой шаардлагатай мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

35.1.5. төрийн байгууллагын ажлын албаны төрийн жинхэнэ албан хаагчийн удирдлагатай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

35.1.6. төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаарх дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгөх;

35.1.7. хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг шалгаж дүгнэлт гаргах;

35.1.8. төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

35.1.9. мэргэшлийн шалгалтаар иргэнийг төрийн жинхэнэ албанд авах болон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

35.1.10. төрийн жинхэнэ албаны ажилтны сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохицуулах;

35.1.11. төрийн байгууллагын бүтцийн ерөнхий бүдүүвч, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишиг тогтооход санал өгөх;

35.1.12. төрийн албаны үйл ажиллагаанд шинжилгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал боловсруулах, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал, хүсэлт гаргах;

35.1.13. төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн ажилтах нөхцөл, баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

35.1.14. хуульд заасан бусад бүрэн эрх.

36 дугаар зүйл.Төрийн албаны стандарт

36.1.Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, хэрэгжүүлэх, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагаог оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

36.2. Төрийн албаны стандарт нь төрийн албан хаагчаас албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, санхүү, статистикийн болон төрийн албатай холбогдсон бусад мэдээ, тайлан гаргах, төрийн байгууллага, төрийн албан хаагчаас албан хэрэг хөтлөх, ангилах, архивын баримт бичиг, нэгж бүрдүүлэх, хяналт шалгалт хийх, мэдээллээр хангах зэрэг бусад үйл ажиллагааны жүрмыг тогтооно.

36.3. Төрийн албаны стандарт боловсруулж батлах, мөрдөх журмыг Засгийн газар тогтооно.

37 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл

37.1. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг / цаашид "хувийн хэрэг" гэх/ нь төрийн албан хаагчийн тухай болон түүний төрийн албан тушаал эрхэлсэн тухай мэдээллэл агуулна.

37.2. Төрийн албан хаагчид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

37.3. Төрийн албаны төв байгууллага нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд үг бүртгэгд төрийн албан тушаал эрхэлж байгаа болон нөөцөд байгаа төрийн бүх албан хаагчийн тухай мэдээ агуулсан байна.

37.4. Хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх жүрмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

38 дугаар зүйл. Төрийн албаны санхүүжилт

38.1. Төрийн албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

38.2. Төрийн албаны зардлыг бууруулах арга хэмжээ авч төсвийн санхүүжилтийг хорогдуулах нь төрөөс олгож байгаа төрийн албан хаагчдад олгох төлбөрийг түр буюу бүрмөсөн зогсоох, тэдний цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.

38.3. Төрийн албаны санхүүжилт болон төрийн байгууллагын төсөвт хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг хууль тогтоомжид заасан жүрмын дагуу хэрэгжүүлнэ.

39 дүгээр зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх

39.1. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хоорондтөрийн албатай холбогдсон асуудлаар гарсан дараахь маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ:

39.1.1. энэ хуулийн 17.2, 19.2, 23, 25, 26 дугаар зүйлд заасан асуудлаар төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн өөрийнх нь гаргасан маргаан;

39.1.2. төрийн захиргааны албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

39.2. Төрийн жинхэнэ албан хаагч, түүнд нэр дэвшигч нь төрийн албатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэсэн тухай төрийн албаны төв байгууллагын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж болно.

39.3. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хоорондтөрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх жүрмыг Улсын Их Хурал тогтооно.

39.4. Төрийн захиргааны албан хаагчаж ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэж үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор, уг шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

40 дүгээр зүйл. Хориглох зүйл

40.1. Төрийн албан хаагч, иргэнээс мэргэшлийн шалгалт авах, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, түүнийг томилох, чөлөөлөх, албан тушаалд дэвшүүлэх, албан тушаалаас бууруулах зэрэг асуудлаар хууль тогтоомж, стандартыг зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдон шударга бус тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

40.2. Төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно.

41 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага

41.1.Төрийн албаны тухай хуулийн дараахь зүйл, заалтыг зөрчсөн этгээд, төрийн албан хаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан шийтгэлийг шүүгч ногдуулна:

41.1.1.төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд иргэнийг авч ажиллуулахдаа энэ хуулийн 17.1, 17.4, 17.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 10000-30000 хүртэл төгрөгөөр торгох;

41.1.2. энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 20000-60000 хүртэл төгрөгөөр торгох;

41.1.3. энэ хуулийн 25 дугаар зүйл, 26.1-д заасныг зөрчиж төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас халсан албан тушаалтныг 30000-60000 хүртэл төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 7.1.4-ийн "уралдаант шалгалт" гэснийг "уралдаан" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 10.4-ийн "тэргүүлэх байгууллагын оршин байгаа" гэснийг "ерөнхий захиргаа байршин байгаа" гэж, 21.1-ийн "үүргийг шинээр үүсэх компаниудад" гэснийг "үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх 2 буюу түүнээс дээш компанид" гэж, 22.1-ийн "хөрөнгө, эрхийг" гэснийг "эрх, үүрэг, хариуцлагыг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

"5.4. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаат эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

"2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "Иргэний хуулийн 77 дугаар зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд" гэж, 28 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 274 дүгээр зүйлд", мөн зүйлийн 4 дэх хэсгийн "Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт" гэснийг "Иргэний хуулийн 105 дугаар зүйлд" гэж, 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Иргэний хуулийн 162 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу нийтийн буюу хязгаарласан хэлбэрээр" гэснийг "Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу нээлттэй буюу хаалттай" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн "нийтийн" гэснийг "нээлттэй", "хязгаарласан" гэснийг "хаалттай" гэж, 43 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 162 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэгт" гэснийг "Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 20-23 дахь хэсэгт" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хуульн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууц хувьчлах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Иргэний хуулийн 94-99 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 126-130 дугаар зүйлд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Орон сууц хувьчлах тухай хуулийн 16[1] дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3 дахь заалтын "эрхийн" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хуульн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 28.2-ын "тооцооны журам" гэсний дараа "эрчим хүч дамжуулах шугам сүлжээний эзэмшлийн зааг" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 30.1-д дор дурдсан агуулгатай 12 дахь заалт нэмсүгэй:

"30.1.12. эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй."

3 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 28.1-ийн "Иргэний хуулийн 226 дугаар зүйл" гэсний "Иргэний хууль" гэж, 30.1.8-ын "аюулгүй байдлыг хангах" гэснийг "аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 29.1-ийн "Иргэний хуулийн 228 дугаар зүйл,", 30.1-ийн "Иргэний хуулийн 227 дугаар зүйлд заасна-гадна" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хуульн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр

Улаанбаатар хот

МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, БАНКНЫ ЗӨӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "банк" гэсний дараа "мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд" гэж, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хадгалалтын хугацаа" гэсний дараа "хүүгийн хэмжээ" гэж, 12 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн "банк" гэсний дараа "төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь хадгалуулагчийн мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ."

2/ 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд засан үндэслэл, жүрмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ."

3 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "банкинд" гэснийг "банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд", 1 дүгээр зүйл, 13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн гарчгийн "банкаар" гэснийг банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр", 1 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн "банкнаас" гэснийг "банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс", 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр булгийн нэр, 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "банкны" гэснийг "банк, зээлийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн", 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "банкны байгууллагаас" гэснийг "банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс", 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "банкинд" гэснийг "банк, төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд", 22 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "банкны" гэснийг "банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн", 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3 дахь заалтын "банкны байгууллагын" гэснийг "банк, эрх бүхий хуулийн этгээдийн", 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 364 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт", 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Иргэний хуулийн 365 дугаар зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 455 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт", 9 дүгээр зүйлийн "Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг" гэснийг "Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 5 дахь хэсэг", 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Иргэний хуулийн 61 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт", 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Иргэний хуулийн 184 дүгээр зүйлд" гэснийг Иргэний хуулийн 459 дүгээр зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн нэрийг "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль" гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн "Иргэний хуулийн 367 дугаар зүйл", 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 368 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С. ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "төсөл боловсруулах" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "нэг хувьтай", 4 дэх заалтын "хоёр хувьтай" гэснийг "0.5 хувьтай", 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "эд материалын гэрээнд заасан үнийг хоёр дахин нугалж төлнө" гэснийг "түүнд учирсан хохирлыг нөхөн төлнө", мөн хэсгийн 3 дахь заалтын "эд материалын гэрээнд заасан үнийг гурав дахин нугалж төлнө" гэснийг "хэрэглэгчид учирсан хохирлыг нөхөн төлнө" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 32 дугаар зүйлд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "батлан даалт", 16 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 2 дахь заалтын "батлан даалтын" гэсний урд "баталгаа," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг "Банкийг татан буулгах, түүнтэй холбогдон үүсэх нэхэмжлэлийн шаардлагыг хангахад Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасныг баримтална" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 45 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 11.1-ийн "эд хөрөнгийн бус амины эрх" гэснийг "эдийн бус хөрөнгө" гэж, 13.2.4-ийн "Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн дагуу" гэснийг "Иргэний хуулийн 15.2-т заасны дагуу" гэж, 19.7-ийн "Иргэний хуулийн 19 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн гарчиг, 8.1-8.4, 8.6, 9.1-ийн "нөхөн олговор" гэснийг "сохиолдол бүрт нийцүүлэн "нөхөн төлбөр" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн "Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт" гэснийг "Иргэний хуулийн 129.3-т" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нөхөрлөлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "удирдлагын төвийн эшин байгаа" гэснийг "еренхий захиргаа байршин айгаа" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Нөхөрлөлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "Энэ зүйл компанид нэгэн адил эмаарна" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Нөхөрлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 4.1.4-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.1.4. "даатгалын зүйл" гэдэгт эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхлыг;"

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 4.1.15, 10.1.1, 10.1.4, 10.1.8, 11.1.1, 13 дугаар зүйлийн нэр, 13.1-13.7, 13.7.1, 13.7.2, 13.7.4, 13.7.5, 13.10, 13.11, 13.13, 13.14, 13.15, 14.2, 14.3-ийн "нөхөн олговор" гэснийг "нөхөн төлбөр" гэж, 3.1, 4.1.1, 4.1.4, 4.1.5, 4.1.12, 4.1.14-ийн "эд хөрөнгийн бус" гэснийг "эдийн бус" гэж, 3.2-ын "төрлүүдийг" гэснийг "хэлбэрүүдийг"гэж, 5 дугаар зүйлийн нэрийн "хэлбэр" гэснийг "төрөл" гэж, 5.2-ын "хэлбэртэй" гэснийг "төрөлтэй" гэж, 5.3-ын "төрлүүд" гэснийг "хэлбэрүүд" гэж, 5.5, 6.2-ын "төрлийн" гэснийг "хэлбэрийн" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын "тооцоолох машины санаж байгууламжид байгаа" гэснийг "түсгай бүртгэл /ердийн болон тооцоолох машин/-д байгаа" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 9.2-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"9.2.Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйл, энэ хууль, аялал жуулчлалын байгууллага жуулчинтай байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт" гэснийг "Иргэний хуулийн 182 дугаар зүйлд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 3.1-ийн "Иргэний хуулийн 77 дугаар зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 84.3-т" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ВЕКСЕЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Вексел ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "Иргэний хуулийн 180 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу" гэснийг "Иргэний хуулийн 232.6-д заасны дагуу" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн бус байгуллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан" гэснийг "Иргэний хуулийн 36.2-т заасны дагуу" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 3.1-ийн "Материаллаг" гэснийг "Эдийн засгийн" гэж, "хувь хүмүүс" гэснийг "хэд хэдэн этгээд" гэж, "ардчилсан удирдлага" гэснийг "ардчилсан, хамтын удирдлага" гэж, "аж ахуй эрхлэх" гэснийг "үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан" гэж, 46.1-ийн "31 дүгээр" гэснийг "32 дугаар" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дампуурлын тухай хуулийн 7.1-ийн "60 дугаар зүйлд заасныг" гэснийг " 62 дугаар зүйлд заасныг " гэж, 12.1.6-ийн " 43, 44 дүгээр зүйлд заасан" гэснийг " 56-61 дүгээр зүйлд заасан" гэж, 18.4-ийн "Иргэний хуулийн 162 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2,3,4 дэх хэсэгт " гэснийг "Иргэний хуулийн 197 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39.5, 39.10, 39.11-д" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Дампуурлын тухай хуулийн 35.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 23.3-ын "Иргэний хуулийн 15.3-т" гэснийг "Иргэний хуулийн 16.3-т" гэж, 27.2-ын "Иргэний хуулийн 56.2-т" гэснийг "Иргэний хуулийн 64.2-т" гэж, 39.4-ийн "Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хуулийн 197 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2. Холбоо нь эвхэн тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулах бөгөөд хуулийн этгээдийн эрхтэй байна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "олон нийтийн байгууллага" гэснийг "ашгийн төлөө бус хуулийн этгээд" гэж, 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Иргэний хуульд гэснийг "Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд" гэж, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд"

гэснийг "Иргэний хуулийн 32 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 24.2-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"24.2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэгч нь Иргэний хуулийн 343.1-д заасны дагуу захиалагчтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх үүрэгтэй."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 3.1.3-ын "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-д" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-д" гэж, 3.1.4-ийн "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 12-д" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.13-т" гэж, 10.3-ын "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйл, Иргэний хуулийн 19, 398, 401 дүгээр зүйлд" гэснийг "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл, Иргэний хуулийн 24, 515, 518 дугаар зүйлд" гэж, 12.1-ийн "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 60 дугаар зүйлд" гэснийг "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙН ТУХАЙ БОЛОН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.8 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг "Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхийн саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгож болно." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 5–ны өдөр **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Гавана хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Куба Улсын Засгийн газар хоорондын Худалдааны Хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 5–ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацын хооронд 2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан Тогтвортой амьжиргаа төслийн Зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд дор дурдсан агуулгатай "Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал" гэсэн долдугаар бүлэг, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт нэмсүгэй :

1/ "ДОЛДУГААР БҮЛЭГ:

Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал

65[1] дүгээр зүйл.Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал

1.Нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдээс үзүүлдэг үйлчилгээ, удирдах үйл ажиллагаат төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр үйлчэтгүүлэх, нийгмийн салбарт тусламж, үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдаг төрийн өмчийн зориулалтын эд хөрөнгийг бусдад түрээсээр ашиглуулахыг өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хүрээнд хамааруулж ойлгоно.

2.Энэ хуулийн 65[2], 65[3], 65[4] дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг удирдлагын, гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх болон төрийн өмчийн эд хөрөнгийг түрээсийн гэрээгээр ашиглуулахад төрийн өмчийн аливаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх бусдад шилжихгүй.

3.Нийгмийн салбарын хувьчлалд энэ хуулийн зургадугаар бүлэгт заасан хувьчлалын эрүүдыг нэгэн адил хэрэглэж болно.

4. Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

1/ үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүй байх;

2/ үйлчилгээ, үйл ажиллагааны хүрсэн түвшинг бууруулахгүй байх;

3/ үйлчилгээнд хамрах хүрээг ргөтгөх;

4/ ил тод, нээлттэй байх;

5/ ажиллагчдад учрах эрсдэлийг йуруулах

65[2] дугаар зүйл. Нийгмийн салбарт үйл жиллагаа явуулж буй төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх

1.Нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагаагүралдаанг шалгаруулалтаар шалгарсан, төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр удирдлагын гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2. Удирдлагын гэрээгээр ажиллуулах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулна.

3.Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулах, гэрээг дүгнэх ажлыг Төрийн өмчийн хороо, тухайн хуулийн этгээдийг харьяалах салбарын төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4.Удирдлагын гэрээгээр ажиллуулах хуулийн этгээдийн жагсаалтыг Засгийн газар батална.

5.Удирдлагын гэрээ байгуулахдаа Иргэний хуулийн үүргийн ажил гүйцэтгэх тухай гэрээний заалтыг баримтлахаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

1/энэ хуулийн 58 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2, 4 –т заасан болзол;

2/тухайн хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны чанар, үр ашгийг дээшлүүлэх, төсвөөс үзүүлэх санхүүжилтийг багасгах хэмжээ, үе шат, хугацаа;

3/тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зардлаас давсан орлогоос түүнд хөрөнгө оруулалтын зориулалтаар буцаан олгох хөрөнгийн хэмжээ.

65[3] дугаар зүйл. Нийгмийн салбарын тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх

1.Төрөөс нийгмийн салбарт үзүүлдэг тусламж, үйлчилгээг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгэлийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2. Гүйцэтгэлийн гэрээгээр ажиллуулах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулна.

3. Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулах, гэрээг дүгнэх ажлыг Төрийн өмчийн хороо, тухайн тусламж, үйлчилгээний чиглэлийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4. Гүйцэтгэлийн гэрээгээр ажиллуулах хуулийн этгээдийн жагсаалтыг Засгийн газар батална.

5. Гүйцэтгэлийн гэрээ байгуулахдаа Иргэний хууль болон ажил гүйцэтгэх тухай гэрээний заалтуудыг баримтлахаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

1/энэ хуулийн 58 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2, 4 –т заасан болзол;

2/тусламж, үйлчилгээнд тавигдах мэргэжлийн стандарт,шаардлага нөхцөлийг ханган гүйцэтгэх.

6.Гүйцэтгэлийн гэрээний явцад төрийн өмчийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг ашиглах шаардлага гарвал Төрийн өмчийн хороо гүйцэтгэгчтэй төрийн өмчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг ашиглах тухай тусгаар гэрээ байгуулна.

65[4] дүгээр зүйл. Нийгмийн салбарт тусламж, үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдаг төрийн өмчийн зориулалтын эд хөрөнгийг түрээсээр ашиглуулах

1.Нийгмийн салбарын төрийн өмчийн зориулалтын эд хөрөнгийг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр түрээслэн гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

2.Түрээсийн гэрээний үндсэн дээр төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулах, гэрээг дүгнэх ажлыг Төрийн өмчийн хороо, тухайн түсгай зориулалтын эд хөрөнгийг ашиглахтай холбогдсон асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4.Нийгмийн салбарт тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэхэд энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1, 2, 3, 5 дахь хэсгийн заалт нэгэн адил хамаарана.

65[5] дугаар зүйл.Төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг бууруулж хувьчлах

1.Нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж төсвөөс авах санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хуулийн этгээд, хувь хүнд хувьчилж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хувьчлах хуулийн этгээдийн жагсаалтыг Засгийн газар батална.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалд оролцох хуулийн этгээд, хувь хүний уралдаант шалгаруулалтаар шалгаруулна.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулах, гэрээг дүгнэх ажлыг Төрийн өмчийн хороо, тухайн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн харьяалах төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн эзэмшлийг хэдэн хувиар бууруулахыг тухайн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулах гэрээнд заавал заана. "

2/ 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх хугацаа, арга хэлбэр, байгууллагын жагсаалтыг Засгийн газар, УИХ-ын Нийгмийн бодлогын болон Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн жил бүр батална".

3/ 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

8/төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хувьчлах.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2."Үндэсний ашуулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүнүүйлдвэрлэдэг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, эд хөрөнгийн талаархи бүрэн эрхийг үүсгүүлэх эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ."

3 дугаар зүйл. Төрийн өмчийн тухай хуулийн долдугаар бүлгийн дугаарыг "наймдугаар", наймдугаар бүлгийн дугаарыг "есдүгээр", есдүгээр бүлгийн дугаарыг "аравдугаар" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалтыг нэмсүгэй:

"6/ Санхүү: байгаль орчин; боловсрол, соёл, шинжлэх ухаан; дэд бүтэц; хөдөлмөр, нийгмийн хамгаалал; үйлдвэр, худалдаа; хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй; эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын асуудал."

2 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11 дэх заалтын "-эрүүл ахуй, халдвар судалын хүрээнийбодлого, хяналт;", "-эмнэлгийн үйлчилгээнд тавих улсын хяналт" гэснийг "-эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судалын хүрээнийбодлого" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7 дахь заалтаас "- дэд бүтцийн техникийн хяналтын асуудал;", мөн хэсгийн 8 дахь заалтаас "- хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн хууль тогтоомжийн улсын хяналт;" мөн хэсгийн 9 дэх заалтаас "тэнцвэрт байдал", "бодлого, зохицуулалт" гэсний дараахь "хяналт" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын" гэсний дараа "Ерөнхий сайд буюу" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр, мөн зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"2. Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх төв болон орон нутгийн байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор холбогдох сайд олгоно. Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч тус тус олгоно."

2/ 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 88.1-ийн "хөдөлмөрийн" гэсний дараа "асуудал хариуцсан" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 140.1-ийг "Хөдөлмөрийн хяналтыг улсын эмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутгийн хяналтын албад эрхлэн зохион байгуулна." гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 95.4-ийн "хөдөлмөрийн улсын хяналтын байгууллага"; 95.7, 99.1, 99.2-ын "хөдөлмөрийн хяналтын албад" гэснийг "хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжлийн хяналтын байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 137.2-ын "тохируулагч"; 139.1.1-ийн "болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн"; 139.1.2-ын "түүний" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — **Улаанбаатар хот**

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26.1-ийн "боловсролын улсын хяналтын алба, улсын байцаагч" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага, боловсролын хяналтын улсын байцаагч", 26.2-ын "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн улсын хяналтын алба, улсын байцаагч" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — **Улаанбаатар хот**

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 8.1-ийг "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага /цаашид "хяналтын алба" гэх/, орон нутагт хяналтын болон туслай албад хэрэгжүүлнэ" гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 5.1-ийн "мал, эмнэлэг, үржлийн төв" гэснийг "тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага", 5.2, 11.2-ын "мал, эмнэлэг, үржлийн төв" гэснийг "малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага", 6.2, 15.1.7-ын "мал, эмнэлэг, үржлийн төвийг" гэснийг "малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — **Улаанбаатар хот**

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 22.3-аас "Дэд бүтцийн" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.2-ыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — **Улаанбаатар хот**

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 20.4-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"20.4. Автотээврийн хяналт, шалгалтын мэргэжлийн төв, орон нутгийн хяналтын байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу олгоно."

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 20.7-ийн "улсын байцаагчийг авто тээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндсэн дээр тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө." гэснийг "улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай

хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу олгоно." гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 6.1.6, 20.3, 20.5-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"1/ улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу олгоно."

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж мэргэжлийн удирдлагаар хангана." гэснийг "мэргэжлийн хяналтын алба хэрэгжүүлнэ.", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Төрийн захиргааны төв байгууллагад" гэснийг "Мэргэжлийн хяналтын албанд" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Байгаль орчны сайдын тушаалаар" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10 дахь заалт, 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Стандарт, чанарын төрийн хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутагт хяналтын албад хэрэгжүүлнэ."

2/ 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагчийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө."

3 дугаар зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "оролцох бөгөөд энэ талаархи үйл ажиллагаат стандарт, чанарын төрийн хяналтын улсын Ерөнхий байцаагч зохицуулна." гэснийг "оролцоно." гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 13.1.3-ыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 28.1.4-өөс "хэрэгжилтэд хяналт тавих" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн гарчигийн "Цацрагийн хяналтын албанаас" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагаас", 16.1-ийн "Цацрагийн хяналтын алба" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

ХИМИЙН ХОРТ БОДИСООС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг "химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглах талаар зөвлөмж гаргах;" гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2. Хэмжилзүйн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу олгоно."

2 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтаас "хяналт" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4, 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр **Улаанбаатар хот**

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21.3-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"21.3. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу олгоно."

2 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.3-ын "арга зүй, хяналтын" гэснийг "арга зүйн" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр **Улаанбаатар хот**

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 16.1, 17.3-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"16.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр даатгалын үйл ажиллагаанд тавих хяналтыг Ерөнхий сайдын дэргэдэх Мэргэжлийн хяналтын алба хэрэгжүүлнэ. Даатгалын хяналтын дүрмийг Засгийн газар батална."

2/17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"17.3. Хяналтын албанд болон орон нутагт ажиллах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу олгоно."

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 6.2-ын "даатгалын хяналтын" гэснийг "мэргэжлийн хяналтын", 16.2.1, 19.4-ын "Сангийн сайдад" гэснийг "Ерөнхий сайдад", 17.7-ын "Сангийн сайдын" гэснийг "Ерөнхий сайдын", 19.5, 19.6-ын "Сангийн сайд" гэснийг "Ерөнхий сайд", 19.8-ын "Сангийн сайдаас" гэснийг "Ерөнхий сайдаас" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн гарчигаас болон 16.2, 16.3-аас "даатгалын" гэснийг тус тус хассугай

4 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 17.1, 17.2, 17.4-ыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр **Улаанбаатар хот**

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 5.1.5-аас "тэдгээрийн биелэлтийг хангуулах", 8.1-ээс "төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журамд заасан болзол, шалгуурыг хангасан" гэснийг, 8.4-ийн 2 дахь өгүүлбэрээс "Дүрэмт хувцасны загвар, албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тэдгээрийг хэрэглэх журмыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална." гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Авто замын тухай хуулийн 5.1.6-г хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 10–ны өдөр Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 35.1-ын "хөдөлмөр, нийгмийн хамгааллын тохируулагч байгууллага /Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Хяналтын Алба/" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 28–ны өдөр Дугаар 39 Улаанбаатар хот

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар сумын хилийн заагт орших Тужийн нарс орчмын нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар, Хөвд аймгийн Цэцэг сумын нутаг дэвсгэрт орших Мянган угалзатын нуруулыг зарим хэсгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар тус тус улсын тусгай хамгаалалтад авахаар тогтоосугай:

2. Тужийн нарсны Байгалийн цогцолборт газар, Мянган угалзатын нуруулы байгалийн цогцолборт газрын хилийн заагийг хавсралтын ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2002 оны 39 дүгээр тогтоолын хавсралт

ТУЖИЙН НАРСНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР, МЯНГАН УГАЛЗАТЫН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Нэг.Тужийн нарсны Байгалийн цогцолборт газар

Баруун хойт захын цэг нь 693,0 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш орших 722.0 тоот өндөрлөг, түүнээс зүүн урагш орших /106° 23' 40'', 50° 11' 02'' / солбилцлын цэг, түүнээс зүүн хойш орших /106° 25' 08'', 50° 11' 00''/ солбилцлын цэг, түүнээс хойш орших 656.0 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш орших 681.0, 666.0 тоот өндөрлөгүүд, 666 тоот өндөрлөгөөс зүүн урагш орших /106° 30' 10'', 50° 09' 15''/ солбилцлын цэг, түүнээс зүүн тийш орших /106° 31' 25'', 50° 09' 15''/, түүнээс зүүн хойш орших /106° 32' 22'', 50° 10' 25''/, түүнээс баруун хойш орших /106° 31' 40'', 50° 14' 19''/, түүнээс зүүн урагш орших /106° 35' 20'', 50° 13' 48'' /, /106° 35' 30'', 50° 12' 15''/ солбилцлын цэгүүд, Хяраан гол дахь 688.0 тоот, тэндээсээ мөн голоо өгссөөр Ивцэг, Хяраан, Бөхлөө голын уулзвар, тэндээсээ Ивцэг голыг даган өгссөөр Ивцэг, Хангай голын уулзвар хүрч тэндээсээ Хангай голыг өгссөөр Цагаан давааг / 990.0/, түүнээс баруун хойш орших Дэлгэрхаан уул /1553.8/, 970.6 тоот өндөрлөг, Хөглөн уул /1025.0/ , Хөх чулуу /954.9/, Хөх чулуу уулаас зүүн хойш

орших 1069.9 тоот өндөрлөг, түүнээс зүүн урагш орших Хөх чулуутын даваа, түүнээс зүүн хойш орших /106º 20′ 10″, 50º 01′ 10″/ дахь солбилцлын цэг, 1087,1 тоот өндөрлөг, уг өндөрлөгөөс баруун хойш орших Өнчин цагаан толгой, /106º 19′ 10″, 50º 04′ 05″/, /106º 17′ 30″, 50º 04′ 19″/ солбилцлын цэгүүд, түүнээс баруун урагш орших 742,7 тоот өндөрлөг, /106º 14′ 30″, 50º 01′ 38″/ солбилцлын цэг, мөн цэгээс хойш орших /106º 14′ 30″, 50º 06′ 50″/ солбилцлын цэг, түүнээс зүүн хойш орших Тэмээн хүзүү /769.8/, 693,0 тоот өндөрлөг.

Хоёр. Мянган угалзатын нуруууны байгалийн цогцолборт газар

Баруун хойт захын цэг нь 3065,0 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш орших Жинстийн орой /2563,0/, түүнээс зүүн тийш орших 2323,0 тоот өндөрлөг, түүнээс урагш орших 2742,0 тоот, Шаврын гол дахь 2510,0 тоот өндөрлөгүүд, 2510.0 тоот өндөрлөгөөс мөн голоо уруудсаар 2379,0 тоот өндөрлөг, түүнээс урагш Баянгол дахь 2333 тоот өндөрлөг, түүнээс баруун урагш орших Нам давaа /2790,0/, түүнээс баруун тийш орших 3185,0 тоот өндөрлөг, түүнээс баруун хойш орших 2665,0 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш орших 3065.0 тоот өндөрлөг.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр **Дугаар 41** **Улаанбаатар хот**

Үндэсний хөтөлбөр, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нэгдүгээр, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

2.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Үндэсний зөвлөл Ж.Бямбадорж/-д даалгасугай.

3.Нийгэм, эдийн засаг, соёл, хүмүүжлийн аливаа асуудлыг төлөвлөх, шийдвэрлэх, хэрэгжүүлэхдээ авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг заавал хамт авч үзэж байхыг Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, яам, агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Засгийн газар /Н.Энхбаярт/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

АВИЛГАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндэслэл

1.Авилгал нь улс орнуудын хөгжилд саад тотгор учруулж, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах, үндэсний эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж байгаа дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, томоохон улс орон, нэр хүнд бүхий олон улсын байгууллага, улс төрчид түүний эсрэг тэмцэлд идэвхтэй оролцох болсон.

2.1996 онд Авилгалын эсрэг хууль батлагдсан боловч түүний хэрэгжилт хангалттүй байгаа бөгөөд шинэ нөхцөл байдалд тохирсон төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ төлөвшөөгүй байна.

3.Монгол Улсад авилгал бодитойгоор оршиж төрд итгэх олон түмний итгэлийг алдагдуулан улс төр, эдийн засгийн шинэтгэлд бэрхшээл учруулж улмаар үндэсний аюулгүй байдалд заналхийлэхэд хүргэж болзошгүй байна.

4.Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурийн асуудлаар Улаанбаатар хот, 9 аймагт 1999 оны 6-7 сард явуулсан судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн нийгэмд авилгал түгээмэл байна гэж судалгаанд оролцогдьш 73,0 хувь нь үзжээ.

5.Манай орны төрийн болон бизнесийн байгууллагуудаас хамгийн их авилгалд автсан нь дээр дурдсан судалгаанд оролцогчдын үнэлгээгээр гааль, банк, шүүх, боловсролын байгууллага, Улсын Их Хурал, татварын алба, улс төрийн намууд, цагдаа, эмнэлгийн байгууллага, яам, агентлаг, прокурорын байгууллага гэж нэрлэсэн байна.

6.Авилгалын цар хүрээ, уг сурвалж, үр дагаврын талаар бодитой судалгаа хийж, үнэлэлт өгч байгаагүй байна.

7.Авилгалтай хийх тэмцэл эвхэн цуу яриа, хэвлэлийн шуугиан төдийгөөр хязгаарлагдаж байгаа нь энэ үзэгдэлд нийтээр дасах хандлага бий болгож болзошгүй байна.

8.Авилгалын эсрэг тэмцэх, түүнийг бууруулах ажлыг туушгай зохион байгуулан амжилтад хүргэхэд иргэний нийгэм, иргэдийн идэвхтэй оролцоо, тэдний дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай юм.

9.Ийм учраас төр засаг, иргэний нийгмийн хүч боломжийг нэгтгэн авилгалын эсрэг тэмцэхэд чиглэсэн урт хугацааны бодлого болгон энэхүү Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

10.Дэлхий нийтээр хүлээн эввшөөрсөн "Сайн төр бол авилгалгүй төр" гэсэн үзэл санааны дагуу авилгалын эсрэг тэмцлийг төр засаг өөрөөсөө эхэлж байна.

Хоёр.Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүн

1.Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид "Үндэсний хөтөлбөр" гэх/-ийн зорилго нь Монгол Улсад авилгалтай тэмцэх нөхцөл бүрдүүлэх, нийгэмд авилгалыг үл тэвчих уур амьсгалыг бий болгох, төр, засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндэсэн дээр авилгалаас урьдчилан сэргийлэх, улмаар түүний үүсч буй шалтгаан, нөхцөлийг хязгаарлах, арилгахад оршино.

2.Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд дор дурдсан зорилтыг шийдвэрлэнэ:

1/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэх, тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

2/авилгалтай тэмцэх асуудлыг эрхэлсэн байгууллагын бүтцийг боловсронгуй болгох;

3/хэвлэл, мэдээлэл, төрийн бус байгуулага, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, иргэдэд авилгалын хор уршгийн талаар цэгцтэй мэдээлэл өгөх;

4/хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх шатны байгууллагын шинэтгэлийг түргэтгэж, тэдгээрийн авилгалтай тэмцэх болон түүнээс урьдчилан сэргийлэх үүргийг тодорхой болгон үйл ажиллагаат нь уялдуулах;

5/төрийн албан хаагчдын нийгмийн баталгаат сайжруулах;

6/олон улсын байгуулага, гадаад орнуудтай хамтран ажиллах.

3.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангах, олон нийтэд ил тод байх, бусад улс, олон улсын байгуулагын дэвшилтэт арга, туршлагыг харгалзах зарчмыг баримтална.

4.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хүчин зүйлд тулгуурлана:

1/улс төрийн хүчнүүдийн хооронд болон төрийн эрх мэдлийн дээд шатны байгууллагуудын нэгдсэн хүсэл эрмэлзлэл;

2/иргэд, олон нийтийн дэмжлэг, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх;

3/авилгалын эсрэг хууль тогтоомжийг батлан гаргаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4/авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг тасралтгүй өрнүүлэх;

5/төрийн албан хаагчдын цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлэн, тэдний ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тогтоож мөрдүүлэх.

5.Үндэсний хөтөлбөрийг 2002 -2010 онд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2002.07.01 - 2005 он
Хоёрдугаар үе шат: 2006-2010 он

6.Үндэсний хөтөлбөрийн үр дүн:

1/Ойрын үр дүн / 2002.07.01 - 2005 он/:

а/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь зайлшгүй чухал болох талаар улс төрийн бүх хүчин, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар нэгдмэл байр суурьтай болж, энэ ажилд бүх нийтээр хүчээ нэгтгэх эхлэл тавих;

б/авилгалтай тэмцэх ажлын эрх зүйн орчныг шинэ нөхцөлд нийцүүлэх;

в/төр, засгийн байгууллагуудын шинэтгэлийг түргэтгэх;

г/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын өөрийн орны онцлог, тохирсон шинэ загвар бий болгон хэрэгжүүлэх, авилгалыг саруулж, түүнийг үл тэсвэрлэх уур амьсгалын эхлэл тавих.

2/Хэтийн үр дүн /2006-2010 он/

а/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэх талаар эхний шатанд хүрсэн олоотоо улам бататгах;

б/авилгалыг үл тэсвэрлэх нийгмийн уур амьсгал бий болгох, авилгалтай холбоотой хэргийн илрүүлэлтийг сайжруулж, иргэд олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх;

в/төө, иргэний хоорондын итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд мэдээдэхүйц ахиц өөрчлөлт гаргах.

Гурав.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.Үндэсний хөтөлбөрийг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

1/ Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

а/авилгалтай холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аливаа сонгуульд нэр дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохыг хориглох ;

б/сонгуульд оролцох улс төрийн намууд сонгуулийн зардал, хандивын талаар сонгууль болохоос өмнө Сонгуулийн ерөнхий хороонд танилцуулж, ниитэд мэдээлдэг журам тогтоох;

в/иргэн, хуулийн этгээдээс сонгуулийн сурталчилгаанд өгч байгаа хандивын хэмжээнд хязгаар тогтоох;

г/Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн болон төрийн бусад өндөр албан тушаалд томилогдсон, сонгогдсон хүн тангараг өргөхийн өмнө болон бүрэн эрхийнхээ хугацаанд жил бүр хөрөнгө, орлогынхоо тухай ниитэд зарладаг журам тогтоох.

2/ Авилгалаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр:

а/авилгал үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг тусгайлан судалж, санал дүгнэлт гаргах;

б/авилгалтай тэмцэх байгууллагын бүтцийг боловсронгуй болгож, үйл ажиллагаат нь жигдрүүлэх, авилгалтай холбоотой хэргийн илрүүлэлтийг сайжруулах;

в/авилгалтай тэмцэх талаар төрийн бүх шатны байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хүлээх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг чангатгах;

г/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа иргэд, олон ниийт, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүргийг хүчтэй болгох хөшүүрэг, механизмыг бий болгох;

д/хууль тогтоомж, шийдвэрийг эдийн засгийн бүлэглэлүүдийн эрх ашигт нийцүүлэн гаргах боломжийг таслан зогсоох, үүнд эрх зүй, эдийн засгийн арга хэрэгслиг ашиглах;

е/ Олон улсын бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдах явдалтай тэмцэх тухай 1997 оны 12 дугаар сарын 17-ны Конвенц зэрэг баримт бичигт Монгол Улс нэгдэн орох эсэх асуудлыг шийдвэрлүүлэх.

3/ Төрийн албыг боловсронгуй болгох чиглэлээр:

а/төрийн өндөр албан тушаалтны болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр буюу шинэчлэн батална, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих иж бүрэн тогтолцоог бий болгох;

б/хууль тогтоох, шүүх эрх мэдлийн болон хуулийн байгууллага, Засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад хяналт, шалгалтыг сулруулснаас буюу удирдлагын алдаанаас шалтгаалж хэзээ хахууль, авилгал гарсан тохиолдолд шуурхай шалгах, дарга нь ёс зүйн хариуцлага хүлээдэг журам тогтоох;

в/төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилохдоо ил тод, шударгаар өрсөлдүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

г/төрийн бүх шатны байгууллагын ажилд хүнд суртал, шат дамжлагыг багасгах, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох;

д/төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэн амьдралын баталгаат сайжруулах дэс дараатай арга хэмжээ авах үндэсэн дээр тэдний тогтвор суурьшилтай ажиллуулах;

е/ төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, түүнд хяналт тавих механизмыг улам боловсронгуй болгох;

ж/төрийн албан хаагчнь цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос давсан их хэмжээний хөрөнгөтэй болсон, үүнийгээ хэрхэн олсон тухай тайлбарлаагүй буюу үнэн зөв тайлбар өгөөгүй бол холбогдох эрх бүхий байгууллагаас шалгадаг байх;

з/мэдээллийн орчин үеийн технологид суурилсан, үйл ажиллагаагаа олон ниийтэд ил тод явуулах чиглэлээр төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх;

и/Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаа, ёс зүйн талаар гарсан гомдлыг тухай бүр шийдвэрлэж, нийтэд ил тод мэдээлж байх;

к/төрийн бүх шатны байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах;

л/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгууллага болон гадаад оронтой хамтын ажиллагаа тогтоож, үр ашигтай ажиллахад анхаарал тавих, гадаадын зөвл туслажмийн хуваарилалт, ашиглалтад тавих хяналтыг эрс чангатгах.

4/Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах чиглэлээр:

а/хуулийн байгууллагуудын бүтэц, тогтолцооны шинэтгэлийг иж бүрэн, харилцан уялдаатай хийх, захиргааны болон бусад дагнасан

шүүхийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, хуульч мэргэжилтнийг сонгон шалгаруулах журмыг боловсронгуй болгох;

б/шүүгчийн сахилгын болон мэргэшлийн хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах;

в/шүүгчийн ёс зүйд хяналт тавих үүрэг бүхий нэр хүндтэй иргэдээс бүрдсэн хөндлөнгийн хараат бус хяналтын тогтолоог шинээр бий болгох;

г/шүүхийн үйл ажиллагааны талаар иргэнээс гаргасан гомдлыг нягтлан үзэх, түүнийг шийдвэрлэх журмыг боловсронгуй болгож байх;

д/шүүх эрх мэдлийн байгууллагыг өндөр мэргэшлийн, чадварлаг, үнэнч шударга ажилтнаар бэхжүүлэх, ёс зүйд нь хатуу хяналт тавих;

е/хуульчдыг авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд тусгайлан сургаж дадлагажуулах;

ж/шүүх, прокурор, цагдаа, төрийн хяналтын болон хууль сахиулах бусад байгууллагуудын ажилтны цалинг үе шаттайгаар нэмэх;

з/шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын аюулгүй байдлыг хангах байгууллагад үнэнч шударга ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдсөн хүнд ахуйн нөхцөлөө сайжруулахад хүрэлцэхүйц хэмжээтэй тэтгэмж нэг удаа олгодог журам тогтоох;

и/авилгалын холбогдолтой хууль тогтоомжийг шүүхийн практикт нэг мөр хэрэглэж байгаа байдал, энэ төрлийн хэрэг, түүний бүтэц, хандлага, урьдчилан сэргийлэх асуудлыг судлан тэдгээртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шинжлэх ухааны үндсийг дээшлүүлэх;

к/бүх шатны шүүх, прокурорын байгууллагын ажлын тайланг ниітэд мэдээлэх зохистой журам тогтоох;

л/иргэний ниігмийн зүгээс шүүх, прокурорын ажлын талаар сонирхсон асуудлаар мэдээлэл авах бололцоог нэмэгдүүлэх;

м/цагдаагийн байгуулагын ажлын тайланг баг, хорооны иргэдээр хэлэлцүүлдэг журам тогтоох;

н/цагдаагийн байгуулагын ажилд иргэдийг идэвхтэй оролцуулж, тэдгээрт олгодог урамшууллыг нэмэгдүүлэх.

5/ Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудас авах арга хэмжээ:

1.Засгийн газар, яам, агентлаг :

а/аливаа асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэхдээ авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч үзэж байх;

б/яам, агентлаг, аймаг, нийслэлд авилгал, хээл хахуультай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг эрхэлсэн зөвлөл байгуулан, төлөвлөгөө, чиглэлтэй ажиллуулах;

в/яам, агентлаг, аймаг, нийслэл, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжид хяналт хийх, тэдгээрийн ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх, шалгаж урамшуулах зэрэгт авилгалтай тэмцэх талаар төрөөс тогтоосон хэм хэмжээг хэрхэн биелүүлж байгааг гол шалгуур үзүүлэлтийн нэг болгож байх;

г/гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллагын албан хаагчийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, үйл ажиллагаа, ёс зүйд тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцох, тогтвор суурьшилтай ажилуулах тогтолцоог төлөвшүүлэхэд бүхий а нхаарах;

д/төрөөс олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор ил тод, нээлттэй болгох, төрийн өмч, тєсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг чангатгах.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн захирга, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд :

а/нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр төлөвлөхдөө энэхүү Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх асуудлыг бие даасан хэсэг болгон авч үзэж, нутаг дэвсгэрийнхэмжээнд тодорхой зорилт дэвшүүлэн ажилах;

б/нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан авилгалтай холбоотой болон, хээл хахуулийн хэрэг, зөрчилийн шалтгаан, нөхцөлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах;

в/нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагад авилгалыг төрүүлэгч буюу өдөөгч хүчин зүйл бий болгохгүй байхад байнга анхаарч авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй ажлын явцыг тогтмол шалгах туслах;

г/авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг өргөн оролцуулж, идэвх зүтгэлтэй ажиллаж буй төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийн урамшуулж байх;

д/ орон нутгаас олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагаа ил тод нээлттэй болгох, төрийн өмч, тєсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг чангатгах;

е/авилгалын эсрэг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт жил тутам

хүрэлцэх хэмжээгээр тусган тухай бүр санхүүжүүлж байх.

6/Эдийн засгийг либералчлах чиглэлээр:

а/төрийн эдийн засгийн бодлого боловсруулахдаа авилгал үүсэх бодит шалтгаан, түүний эрэлтийг багасгах чиглэлийг баримтлах, тухайлбал үнэ чөлөөлөх, гадаад худалдааг либералчлах, экспорт, импортод элдэв хязгаарлалт, хориг, кот тогтоохгүй байх, ерөнхөөнийг дэмжих, татаас, дэмжлэг, тусламжийг багасгах;

б/санхүүгийн менежментийг сайжруулах цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх;

в/гадаадын зээл, тусламжийн хуваарилалт, ашиглалт, түүнд төрийн хяналт тавих эрх зүйн орчинг бий болгох;

г/төрөөс аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зохицуулахдаа "Боломжийн бага оролцоо" зарчмыг баримтлах;

д/төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах, зарцуулах үйл ажиллагаа ил тод, олон нийтийн хяналттай байх, төсвийн зарцуулалтын тайланд хяналт тавих механизм бүрдүүлэх;

е/төсвийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд хөрөнгийг тендерийн журмаар худалдан авдаг байх;

ж/татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд боловсронгуй болгох;

з/татварын байгууллага бүрт харилцагчдын тухай мэдээллийн сан байгуулах;

и/аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тогтолцоог цэгцлэх;

к/өмч хувьчлалыг ил тод, олон нийтийн хяналтын дор явуулах;

л/төрийн өмчийн эзэмшил, хувьчлалтай холбоотой асуудлаар эрх мэдэл бүхий албан тушаалтан төрийн өмчийн объектыг хуулиас гадуур ерөнхөөнгүйгээр хувьчилсан бол авилгал үүссэн эсэхийг шалгаж байх;

м/төрийн өмчийн аж ахуй нэгжийг зохиомол нөхцөлөөр дампууруулсан тохиолдолд авилгал үүссэн эсэхийг шалгаж байх;

н/төрийн өмчийг хувьчилж авах сонирхлоо илэрхийлсэн хуулийн этгээдийн хөрөнгийн баталгааг татварын болон банкны байгууллагаас мэдлагаа өгч, хууль ёсоор бүрдүүлсэн өмч хөрөнгө мөн эсэхийг тогтоосны дараа өмч хувьчлалын үйл ажиллагаанд оролцуулдаг журам тогтоох;

о/өмч хувьчлалын үйл ажиллагаанд хэвлэл, мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шалгалтын дүн, шийдвэрийн талаар нийтэд байнга мэдээлж байх;

ө/гаалийн үзлэг, шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх;

п/гаалийн байгууллагатай харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдээлэл олж авах тогтолцоог хялбаршуулах, гаалийн байгууллагын ажлын явцын тухай үлирал, жил тутам нийтэд мэдээлж байх.

8/Авилгалтай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр:

а/авилгалын аливаа хэлбэрийг үл тэвчих сэтгэл зүйн орчин төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг чиглүүлэн, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх;

б/авилгалтай холбоотой хэргийн шалтгаан, нөхцөл, тэдгээрийг арилгах арга замын тухай цуврал нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэж байх;

в/хэвлэл, мэдээллийн байгууллага төрийн байгууллагаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, хэвлэл, мэдээллэлд үнэн зөв мэдээлэл өгдөг тогтолцоо бий болгох;

г/авилгалаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллага, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;

д/авилгалын чиглэлээр хандивлагч орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээнд тодорхой асуудлаар төсөл хэрэгжүүлэх;

е/авилгалын асуудлаар улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүрээнд иргэд, олон нийтийг хамарсан зөвлөлгөөн, семинар, сургалт зохион байгуулах;

ж/авилгалын асуудлаар олон нийтийн санал, хандлагыг хоёр жил тутам судлан дүгнэлт хийж байх журам тогтоох;

з/эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчлэх;

и/сургууль, эмнэлгийн байгууллагад иргэний нийгмийн хөндлөнгийн магадлан шалгалт хийж байх журам тогтоон хэрэгжүүлэх;

к/авилгалтай холбоотой гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн иргэний аюулгүй байдлын баталгааг хангах.

9/Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт:

а/Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний

зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Их Хурлаас батална.

б/Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

в/Үндэсний зөвлөлөөс Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих бөгөөд гэрээтэлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг жил бүр нэгтгэн дүгнэж, Улсын Их Хуралд танилцуулж байна.

г/Үндэсний зөвлөлийн үүргийг орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гүйцэтгэнэ.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:
-Улсын Их Хурлын ажлаар
Дэд дарга: -Улсын Их Хурлын үлэлэх зүйн байнгын хорооны даргаар
Гишүүдэд: -Улсын Их Хурлын Тамгын газрын байнгын хорооны даргаар
-Улсын дээд шүүхэн Ерөнхий шүүгч
-Улсын ерөнхий прокурор
-Төрийн хяналт шалгах хорооны дарга
-Төрийн албаны зөвлөлийн дарга
-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
-Ерөнхийлөгчийн хүний эрхийн бодлогын зөвлөх
-Үндэсний статистикийн газрын дарга
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
-Санхүү, эдийн засгийн сайд
-Цагдаагийн ерөнхий газрын дарга
-Тагнуулын ерөнхий газрын дарга
-Сонгуулийн ерөнхий хорооны дарга
-Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч
-Зориг сангийн тэргүүн /тохиролцсоноор/
-Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөний тэргүүн /тохиролцсоноор/
-Монголын хэвлэлийн хүрээлэнгийн захирал /тохиролцсоноор/
-Монголын хуралдаа, аж үйлдвэрийн танхимын дарга /тохиролцсоноор/

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:
-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын чуулганы дэгийн 23.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль этгээдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/төвлөрсөн болон оронтуйн нутгийн төсөөс санхүүгийн төсвийн нийт байгууллагын үйл ажиллагаат төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд 2003 оны төсвийн жилд багтаан шилжүүлэх;

2/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль этгээдсантай холбогдуулан шаардлагатай бусад хууль, эмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ оны 9 дүгээр сарын 15-нд өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/шинэ тогтолцоонд шилжих тодорхой төлөвлөгөөний дагуу бэлтгэл ханган төсвийн байгууллагад мэдээ дүрэм, журам, заавруудыг шинэчлэн боловсруулж, 2003 оноос эхлэн мөрдүүлэх.

2.Төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Улсын Их Хурлаас хамааралтай асуудлыг шийдвэрлүүлэх, зохицуулах арга хэмжээ авч ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны /Н.Баярцайхан/, Хууль зүйн байнгын хорооны /Ц.Шаравдорж/, Төрийн байгууллалтын байнгын хорооны /Д.Дэмбэрэл/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилттэй тухай хуулийг дагаж мөрдөхөд шилжих туузй хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас 2001 оны 12 дугаар 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны оролцсон гишүүдийн олонхи нь хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

Эд хөрөнгешилжүүлэх, хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчлөлөөс аймаг, нийслэлийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор батлуулсугай.

2. Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдэлд байгаа 36 айлын орон сууцны 11 дүгээр байрны 1, 4 дүгээр орцыг зохих журмын дагуу төрийн өмчлөлд хүлээн авахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

3. Зөвшөөрөгдсөн хүчний 137 дугаар ангийн орон сууцны хотхоонд ашиглалттай холбоотой төсөв, бусад зардлыг батлан хамгаалах арга хэмжээний төсөвөөс нийслэлийн төсөвт шилжүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Жагсаалаанд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралтын 5 дахь хэсэгт дор дурдсан нэмэлт оруулсугай:

"4. Монгол Улсын их сургууль
5. Шинжлэх ухаан, технологийн их сургууль
6. Анагаах ухааны их сургууль
7. Улсын багшийн их сургууль
8. Соёл, урлагийн их сургууль
9. Хөдөө аж ахуйн их сургууль
10. Сонгодог урлагийн академик театр
11. Үндэсний жүжгийн академик театр
12. Улсын ардын дуу бүжгийн чуулга
13. Хүүхэлдэйн театр
14. Улсын төв номын сан
15. Соёлын өвийн төв
16. Үндэсний түүхийн музей
17. Байгалийн түүхийн музей
18. Дүүлэх урлагийн музей
19. Боомхаанды ордон музей
20. Чоойин ламын сүм музей
21. Хөдөлмөр бүжгийн коллеж
22. Сүүкийдийн төрийн өмчийн барилга байгууламж
23. Цаазагайн академи
24. Байгаль хамгаалахын их сургууль
25. Хийн цэргийн дээд сургууль
26. Тагнуулын дээд сургууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын байнгын хороо /Т.Ганди/, Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/ -нд даалгасугай.

1.Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг хавсралтаар батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолын хавсралт

НИЙГМИЙН САЛБАРТ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ, ХУВЬЧЛАЛ ХИЙХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн зорилго

Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн зорилго нь нийгмийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмжийг сайжруулахад оршино.

1.2. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх зорилт:

1/удирдлагын төвлөрлийг сааруулах, чадавхийг дээшлүүлэх;

2/нийгмийн салбарын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

3/байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлэх;

4/үйлчилгээнд шинжлэх ухааны ололт, тэргүүний техник, технологи, дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;

5/зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжихийн зэрэгцээ төрийн зохицуулалтыг оновчтой болгох;

6/өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын оновчтой арга, хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх.

1.3.Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх зарчим:

1/ил тод, нээлттэй, шударга байх;

2/үйлчилгээ, үйл ажиллагааны хүрсэн төвшинг бууруулахгүй байх, сайжруулах;

3/үйл ажиллагааны чиглэл, зориулалтыг өөрчлөхгүй байх;

4/үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх;

5/ажиллагчдад учрах эрсдэлийг бууруулах,

1.4.Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалыг хэрэгжүүлэх арга хэлбэр

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан аргуудын зэрэгцээ удирдлагын гэрээ, гүйцэтгэлийн гэрээ, түрээсийн гэрээ, төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хувьчлах зэрэг арга хэлбэрийг тухайн ажил ахуйн нэгж, байгууллагын онцлогт тохируулан дангаар буюу хослуулан хэрэглэнэ.

Өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалд хамрагдах нийгмийн салбарын байгууллага, тусламж, үйлчилгээний жагсаалт, хувьчлах арга хэлбэрийг Засгийн газраас батална.

Удирдлагын, гүйцэтгэлийн, түрээсийн гэрээгээр ажиллуулах журмыг Төрийн өмчийн хороо холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн баталж, хэрэгжилтэд хамтран хяналт тавина.

1.5.Өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хамрах хүрээ

Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийхэд дараахь төрийн өмчийн байгууллага, тусламж, үйлчилгээ хамрагдана:

1.5.1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:

1/бүх шатны сургууль, цэцэрлэг;

2/эрдэм шинжилгээний хүрээлэн,шинжлэх ухаан, технологи

үйлдвэрлэлийн нэгдэл (корпораци);

3/соёл, урлагийн байгууллагууд;

1.5.2. Эрүүл мэндийн салбарт:

1/төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төв;

2/аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо, эмчилгээний төв;

3/анхан шатны тусламж үзүүлдэг өрхийн болон сумын эмнэлэг, төв;

4/биеийн тамир, спортын байгууллагууд;

5/рашаан, сувилал.

1.5.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

1/аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний төвийн тусламж, үйлчилгээ;

2/асрамжийн газар, амралт, сувилал;

3/хүүхдийн ордон, зуслан;

4/хөдөлмөр эрхлэлтийн албадын ажил, үйлчилгээ;

5/нийгмийн даатгалын зарим байгууллага;

6/тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын төв.

1.5.4. Төрийн өмчөөс хувьчилж үл болох нийгмийн салбарын байгууллага, тусламж, үйлчилгээний жагсаалтыг Улсын Их Хурлаас батална.

Хоёр: Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх хүрээнд авах арга хэмжээ

2.1.Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:

2.1.1. Өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийхтэй холбогдуулан боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/бүх шатны сургуулийн дотуур байрыг үйл ажиллагааны чиглэлийг нь өөрчлөхгүй байх нөхцөлтэйгээр түрээсийн гэрээгээр ажиллуулах;

2/орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр зарим Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг өрөнхий боловсролын сургуультай нэгтгэн, мэргэжлийн сургалттай өрөнхий боловсролын сургууль байгуулж ажиллуулах;

3/орон нутгийн нөхцөл, мэргэжлийн онцлог зэргээс шалтгаалан зарим Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд гадаад, дотоодын хөрөнгө оруулах замаар компани, аж ахуйн нэгжийн сургалтын төв болгох;

4/Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн зарим төвийг удирдлагын гэрээгээр ажиллуулах;

5/үндэсний хэмжээнд үйлчилдэг мэргэжлийн сөёл, урлагийн байгууллагын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх;

6/их сургууль, коллежийн эзэмшилд газрыг тогтоон баталгаажуулж, цаашид өргөтгөн сургуулийн хотхон үүсэх нөхцөлийг бүрдүүлэх;

7/гадаадын хөрөнгө оруулалттай сургууль байгуулах, төрийн өмчийн зарим их сургууль, коллежид нэмэлт хөрөнгө оруулах замаар өндөр хөгжилтэй орны тэргүүний технологийг нэвтрүүлэх;

8/бүс нутгийн хөгжилтэй уялдуулан зарим их сургуулийн аймгууд дахь салбар сургуулийг бие даалган бүсийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулах;

9/Дүрслэх урлагийн музей, Уран зургийн галерейг нэгтгэн Үндэсний урлагийн музей болгон өргөтгөн зохион байгуулах;

10/судалгаа, шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдлийг хангах зорилгоор төрийн болон хамтарсан өмчит шинжлэх ухаан-боловсрол-үйлдвэрлэлийн цогцолборууд бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх.

2.1.2. Төрөөс хариуцах санхүүжилт:

1/өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын 50 хувь, өрөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нийт зардал;

2/өрөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангид суралцагчдын бүх зардал.

2.1.3. Багш,суралцагчдад төрөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ:

1/өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр бүх шатны сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх;

2/орон нутагт багш, эмчээр ажиллахаар гэрээ хийж, их сургууль, коллежид суралцагчийн сүүлийн 2 жилийн сургалтын төлбөр.

2.1.4. Төрөөс тогтоох үйлчилгээний үнэ, тариф:

1/цэцэрлэгийн хүүхдийн хоолны үнэ;

2/мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтын нэмэлт үйлчилгээний төлбөр;

3/Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дунд шатны сургалтад суралцагчийн сургалтын төлбөр;

4/их сургууль, коллежид суралцагчийн сургалтын төлбөрийн жишиг;

5/их сургууль, коллежийн дотуур байрны төлбөрийн жишиг.

2.1.5. Үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, нөөц бололцоогоо илүү үр дүнтэй ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчийн цэцэрлэг, бүх шатны сургууль, коллеж, соёл, шинжлэх ухааны байгууллагын дараахь зарим үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлж болно:

1/түлш бэлтгэх, татан авах үйлчилгээ;

2/хичээлийн болон дотуур байрын галлагаа;

3/мах, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх үйлчилгээ;

4/хоол, цайны газрын үйлчилгээ;

5/цагаан хэрэглэл угаах үйлчилгээ;

6/өрөө тасалгааны цэвэрлэгээ;

7/хөгжмийн зэмсэг үйлдвэрлэх;

8/уран бүтээлийн хувцас үйлдвэрлэх;

9/барилга, инженерийн байгууламжийн засвар, үйлчилгээ;

10/тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;

11/тээврийн үйлчилгээ;

12/шуудан холбоо, ном, сургалтын материалын дэлгүүр, хэвлэн олшруулах зэрэг туслах үйлчилгээ.

2.2. Эрүүл мэндийн салбарт:

2.2.1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас зайлшгүй үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:

1/халдвартай өвчтөнийг тусгаарлан эмчлэх, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл, эрүүл ахуй, халдвар судлалын үйлчилгээ;

2/эрүүл мэндийн хяналт, магадлан итгэмжлэлийн үйлчилгээ.

Эдгээр тусламж, үйлчилгээг үзүүлэхэд улс, орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгал, хувийн зэрэг бүх төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглана.

2.2.2. Төрөөс болон иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх (худалдан авах) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:

1/өрхийн болон сум, сум дундын эмнэлгээс үзүүлж байгаа эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээ;

2/тусламж, үйлчилгээний хоёр дахь шатлалын эмнэлгүүдийн (аймаг, дүүргийн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төв) үзүүлж байгаа эмнэлгийн төрөлжсөн тусламж, үйлчилгээ;

3/хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа болон нас баралтын гол шалтгаан болж байгаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ.

Иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас дээрх тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа магадлан итгэмжлэгдсэн хувийн эмнэлэгт санхүүжилт олгоно.

Улс, орон нутгийн төсөвөөс зөвхөн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын болон өрхийн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.

2.2.3.Төрийн өмчит эмнэлгийн байгууллагаас хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгэлийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тусламж, үйлчилгээ

1/эмнэлгийн туслах үйлчилгээ (эмчилгээний хоол, угаалга, цэвэрлэгээ, барилга, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ);

2/эмнэлгийн зарим оношлогоо, шинжилгээ;

3/эмнэлгийн зарим төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж;

4/сувилахуйн тусламж, үйлчилгээ;

2.2.4. Иргэн өөрөө буюу хувийн даатгалын байгууллагын санхүүжилтээр үзүүлэх тусламж, үйлчилгээ

1/төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ (иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй);

2/гоо сайхны үйлчилгээ, засал;

3/үйлчлүүлэгчийн өөрийн хүсэлтээр хийлгэж байгаа нэмэлт оношлогоо, шинжилгээ, эмчилгээ;

4/эрүүл мэндийн практикт шинээр нэвтрүүлж буй өртөг ендөртэй эмчилгээ, оношлогоо.

2.2.5. Улсын хэмжээний үйлчилгээтэй клиникийн эмнэлэг болон төрөлжсөн нарийн

мэргэжлийн төвүүдэд ажиллаж байгаа мэргэжлийн өндөр ур чадвар бүхий туршлагатай эмч нар өөрийн ажиллаж байгаа эмнэлэг, төв дотроо эмнэлгийн тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар гэрээгээр үзүүлж болно.

Дээрх тусламж, үйлчилгээг үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.2.6. Эрүүл мэндийн байгууллагын дараахь объектыг зориулалтын дагуу түрээсийн гэрээгээр ашиглуулж болно:

1/ашиглагдаагүй байр, талбай;

2/эмнэлгийн ажилтны ажлын байр;

3/зарим тоног төхөөрөмж (түрэн тусламжийн автомашин гэх мэт).

Түрээсийн гэрээгээр ажиллуулах журамд эмнэлгийн ажилтны ажлын байрыг тухайн ажилтанд ажлын бус цагаар ашиглуулах тохиолдолд түүний ажиллах цаг, олгох цалинг түрээсийн гэрээгээр ажиллах цаг, олох орлоготой нь уялдуулан тогтоох зарчмыг баримтална.

2.2.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнэ, тариф:

Дор дурдсанаас бусад тохиолдолд эмнэлгийн байгууллага тусламж, үйлчилгээнийхээ үнийг өөрөө тогтооно:

1/улс, орон нутгийн төсөв, иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авч байгаа тусламж, үйлчилгээ;

2/төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг эвэхэн тухайн эмнэлгийн байгуллага үзүүлдэг бол тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх үнийн дээд хэмжээ,

3/зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн багаж, хэрэгслийн жишиг үнэ.

Иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас төрийн өмчийн эмнэлгийн байгууллагыг урьдчилан, магадлан итгэмжлэгдсэн хувийн эмнэлгийг гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

2.3.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

2.3.1.Өөрчлөлт шинэчлэл, хувьчлал хийхтэй холбогдуулан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ

1/Нийгмийн халамжийн салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих зорилгоор иргэд, хувийн хэвшил, буяны болон төрийн бус байгууллагаас үзүүлэх халамж, асрамжийн үйл ажиллагаанд арга зүйн туслалцаа үзүүлэх, зардлын зарим хэсгийг төрөөс хариуцах;

2/Нийгмийн даатгалын хувийн хэвшлийн тогтолцоог бий болгож турших, эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3/Хөдөлмөр эрхлэлтийн сангаас ажилгүйчүүдэд мэргэжил олгох сургалтын санхүүжилтэд "Ваучерын" систем хэрэглэж эхлэх;

4/Нийгмийн халамжийн үйлчилгээний төвүүдийн эвлэгээ өгөх, халамжлах, асрамжлах зэрэг нийгэм, хамт олонд чиглэсэн болон зарим шинэ төрлийн үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх;

5/Монголын хүүхдийн ордон, олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр ажиллуулах;

6/аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай эвэшилцсэний үндсэн дээр орон нутгийн чанартай асрамжийн газар, хүүхдийн эуслан, ахмадын амралт, сувилалын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх;

7/тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын төвийн бие даасан ажиллагааг дээшлүүлэх, гадаадын тусламж дэмжлэгээр чадавхийг нь нэмэгдүүлж, удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх;

8/улс, бүсийн чанартай асрамжийн газруудын удирдлагын үйл ажиллагаа, зарим төрлийн үйлчилгээ, тусламжийг удирдлагын болон гүйцэтгэлийн гэрээгээр ажиллуулах;

9/Төрийн бус хөдөлмөр эрхлэлтийн албадын ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах.

2.3.2.Үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нөөц бололцоог ашиглах, ажлын үр дүн, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь зарим үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлж болно:

1/нийгмийн даатгалын шимтгэлийг хураах, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах үйл ажиллагаа;

2/нийгмийн халамжийн гэрийн үйлчилгээ /асрах, сувилах/;

3/барилга, инженерийн байгууламжийн засвар, үйлчилгээ;

4/тоног, төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;

5/хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлэх, мэргэжлийн сургалт, нийтийг хамарсан ажил;

6/түлш бэлтгэх, татан авах үйлчилгээ;

7/хоол, цайны газрын үйлчилгээ.

2.3.3.Төрөөс хариуцах санхүүжилт:

Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дараахь зардлуудыг төр хариуцана:

1/нэг асруулагчид ногдох хувьсах зардал /хоол, эм тариа, хувцас, цагаан хэрэглэл гэх мэт/;

2/удирдлагын гэрээгээр ажиллаж байгаа байгууллагын байр ашиглалтын зардал /их засварын зардал орно/;

3/төрийн өмчийн асрамж, халамжийн байгууллагын тусламж, үйлчилгээний нийт зардал.

2.3.4.Түрээсийн гэрээ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын байгууллагуудын дараахь объектыг зориулалтыг нь өөрчлөхгүйгээр түрээсийн гэрээгээр ашиглуулж болно:

1/ашиглагдаагүй байр талбай;

2/тоног төхөөрөмж;

3/ажлын байр /ажлын бус цагаар ажлын байраа ашиглаж үйлчилгээ, тусламж үзүүлэх/.

2.3.5.Төрөөс үзүүлэх дэмжлэг, туслалцаа:

1/өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны асрамж, халамж, хүүхдийн байгууллагын ажилтныг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах;

2/удирдлагын гэрээгээр ажиллагдыг дэмжих, урамшуулах;

3/гэрээ байгуулах байгууллага, хугацааг нарийвчлан тогтоох.

Гурав. Нийгмийн хамгаалал

Энэхүү үндсэн чиглэлийн дагуу нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын үр дүнд гарч болох эрсдэлийг тооцож, түүнтэй холбогдуулж авах нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрөөс болон хувьчлагдсан байгууллага хариуцахаар тогтоож өгнө.

3.1.Нийгмийн салбарт ажиллагчдын нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалд хамрагдсан байгууллагад ажиллагчыг нэгээс доошгүй жил ажлын байраар баталгаатай хангаж байх журамд шилжих;

2/өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын үед зайлшгүй шаардлагаар ажлаасаа чөлөөлөгдсөн ажилтанд 6 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгож, орон нутгийн хөдөлмөрийн албанд шилжүүлэх;

3/өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хүрээнд хийгдэж байгаа арга хэмжээний улмаас ажлаас чөлөөлөгдөх ажилчдыг давтан сургах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, ажлын байр бий болгох;

4/ажлын байр хомсдолтой хөдөө орон нутагт аж ахуй эрхлэхийг өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын арга хэмжээнээс олсон орлого, хөдөлмөр эрхлэлтийн сангийн хүрээнд жижиг зээлээр дэмжих.

3.2.Төрийн албанаас чөлөөлөгдсөн ажилтанд дараахь тусламж, дэмжлэг үзүүлнэ:

Өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын үед ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдын Төрийн албаны хуулийн дагуу эдэлж байсан хөнгөлөлтийг 1-3 жилийн хугацаанд олгох тусгай хөтөлбөрийг төрөөс боловсруулж хэрэгжүүлэх.

3.3.Хувьчлагдсан байгууллагын ажилтанд дараахь тусламж, дэмжлэг үзүүлнэ:

1/хувьчлагдсан компанийн удирдлагаас ажилтанд компанийхаа хувьцааг зээлэшүүлэх хөтөлбөр гарган хэрэгжүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд дэмжих;

2/хувьчлагдах үйлдвэрийн газрын ажилтныг өмч хувьчлалын зорилго, үр ашиг, хугацааны талаар үнэн зөв, найдвартай мэдээллээр хангах арга хэмжээ авах.

3.4.Тэтгэвэрт гарсан ахмадуудад үзүүлэх халамж, үйлчилгээ:

1/өөрчлөн байгуулагдсан, өмчийн хэлбэр өөрчлөгдсөн /хувьчлагдсан/ байгууллагын эрх үүргийг шилжүүлж авсан нэгж, байгууллага өмнөх байгуулага, нэгжид ажиллаж байсан ахмад настанг халамжлах арга хэмжээг авна.

Дөрөв.Бусад асуудал

4.1.Бүх төрлийн гэрээгээр ажиллаж буй бага гэрээнд заасны дагуу өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд хөрөнгийг баталгаажуулан хувьчлах үед гэрээний нөхцөлийн дагуу шийдвэрлэнэ.

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 58 Улаанбаатар хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хавсралтаар батлалсугай.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын 2002 оны батлагдсан орон тоо, төсвийг хэмнэх чиглэлээр шинэчлэн хянаж, тэдгээрийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө, албан тушаал /ажлын байр/ -ын тодорхойлолтыг энэ онд багтаан зохих журмын дагуу баталж мердүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын харьяанд	1. Тагнуулын ерөнхий газар 2. Төрийн өмчийн хороо 3. Улсын мэргэжлийн хяналтын газар	1. Радио, телевизийн хэрэг эрхлэх газар 2. Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлаг 3. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд		4. Удирдлагын академи 5. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		6. Үндэсний татварын ерөнхий газар 7. Улсын гаалийн ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4. Цагдаагийн ерөнхий газар 5. Хил хамгаалах ерөнхий газар	8. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 10. Үндэсний архивын газар 11. Гал түймэртэй тэмцэх газар 12. Оюуны өмчийн газар
Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13. Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар
Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		14. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 15. Байгаль, ой, усны нөөцийн газар

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6. Зэвсэгт хүчний Жанжин штаб 7. Иргэний хамгаалалтын газар	16. Мэдээлэл, судалгааны газар
Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17. Иргэний нисэхийн ерөнхий газар 18. Түлш, эрчим хүчний ерөнхий газар 19. Авто замын газар 20. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар 21. Аялал жуулчлалын газар 22. Тээврийн газар 23. Төмөр замын Хэрэг эрхлэх газар 24. Шуудан, цахилгаан холбооны газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		25. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар 26. Хөдөлмөр эрхлэлтийн газар 27. Улсын нийгмийн халамжийн газар 28. Хүүхдийн төлөө үндэсний газар
Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8.Стандартчилал, хэмжилзүйн төв	29. Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар 30. Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар 31. Газрын тосны Хэрэг эрхлэх газар
Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		32. Улсын мал эмнэлэг, үржлийн газар 33. Улсын нөөцийн газар
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		34. Эмнэлгийн тусламжийг удирдах газар

(Уг тогтоолын хавсралтад Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд мэдээлэл, судалгааны газрыг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай байгуулахаар заасанд Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл дээрх нь дагаж мөрдөгдөхгүй болно.)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 8 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (266)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Прокурорын байгууллагын тухай*
- *Шүүхийн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны наймдугаар сарын 2 №29 (266)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

414. Прокурорын байгууллагын тухай (2002-7-4-ний хууль) 947
415. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-7-4-ний хууль) 956
416. Шүүхийн тухай (2002-7-4-ний хууль) 957
417. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-7-4-ний хууль) 972

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

418. Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 47 973

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

419. Цэндийн бэтчулуунд Монголын Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай Дугаар 92 973
420. Гонийн Лаважавт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай Дугаар 93 973
421. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 94 973
422. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 95 974

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд[1] заасан прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцаа зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Прокурорын байгууллага

2.1.Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.

3 дугаар зүйл.Прокурорын байгууллагын тухай хууль тогтоомж

3.1.Прокурорын байгууллагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4 дүгээр зүйл.Прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчим

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны дугээрт нийтлэгдсэн.

4.1.Прокурорын үйл ажиллагаа нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх зарчимд үндэслэнэ.

5 дугаар зүйл.Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх

5.1.Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчим дараахь байдлаар хэрэгжинэ:

5.1.1.дээд шатны прокурорын шийдвэрийг доод шатны прокурор заавал биелүүлэх, дээд шатны прокурорын шийдвэр нь хуульд нийцсэн байна;

5.1.2.доод шатны прокурор нь дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцан тайлагнах;

5.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол дээд шатны прокурор нь өөрийн тодорхой бүрэн эрхийг доод шатны прокурорт шилжүүлэх;

5.1.4.дээд шатны прокурор нь доод шатны прокурорын хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, бүцаан авах;

5.1.5.дээд шатны прокурор нь доод шатны прокурорын үйл ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх.

5.2.Дээд шатны прокурор гэж Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор, аймаг, нийслэлийн, дагнасан болон дүүргийн прокурор, сум, сум дундын ахлах прокурорыг хэлнэ.

5.3.Энэ хуулийн 5.1.1-5.1.5 дахь заалтуудтодорхой хэргийн нотлох баримтыг прокурор өөрийн дотоод итгэлээр үнэлэхэд хамаарахгүй.

6 дугаар зүйл.Гадны нөлөөнд үл автах

6.1.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автан, гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгоно.

6.2.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлж болохгүй.

7 дугаар зүйл.Хуулийг нэг мөр хэрэглэх

7.1.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг өөрийн чиг үүргийн хүрээнд хангана.

8 дугаар зүйл.Прокурорын байгууллагын тогтолцоо

8.1.Прокурорын байгууллага нь:

8.1.1.Улсын ерөнхий прокурорын газар;

8.1.2.аймаг, нийслэлийн прокурорын газар;

8.1.3.сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газраас бүрдэнэ.

8.2.Прокурорын газрыг ажлын шаардлага, хүн ам, нутаг дэвсгэрийн байдлыг харгалзан Улсын Их Хурал байгуулна. Прокурорын хяналтын ажлын онцлог, Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн дагнасан прокурорын газрыг байгуулж болно.

8.3.Прокурорын газар үйл ажиллагааныхаа чиглэлээр зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан болон ажлын аппараттай байна.

8.4.Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурорын дэргэд тэдгээрийн эрх хэмжээнд хамарах асуудлаар зөвлөх эрх бүхий зөвлөл ажиллана.

9 дүгээр зүйл.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа

9.1.Прокурорын байгууллагыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилсон Улсын ерөнхий прокурор толгойлно.

9.2.Ерөнхийлөгчийн санал болгосон хүний Улсын Их Хурал дэмжихгүй бол нэг удаа өөр хүнийнэрийг дэвшүүлнэ.

9.3.Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд тэр нь Улсын ерөнхий прокурорын өмнө ажлаа хариуцна.

9.4.Улсын ерөнхий прокурорын эзгүйд түүний шийдвэрээр аль нэг орлогч бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

9.5.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийн томилсон өдрөөс эхэлж, Улсын ерөнхий прокурор түүний орлогчийг шинээр томилсноор дуусгавар болно.

9.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг зөрүүгийн хариуцлагад татахтэ холбогдуулж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхтухай асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

9.7.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрх дараахь тохиолдолдЕрөнхийлөгчийн шийдвэр гарснаар хугацаанаасөмнө дуусгавар болно:

9.7.1.өөрийнх нь зөвшөөрснөөр өө ажилд томилсон буюу сонгосон;

9.7.2.чөлөөлөгдөх тухай хүсэлтэгаргасан;

9.7.3.гэмт хэрэг үйлдсэн нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөболсон;

9.7.4.биеийн эрүүл мэндийбайдлын улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлболомжгүй болсон.

10 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба

10.1.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба /цаашид "Мөрдөн байцаах алба" гэх/ нь Эрүүгийн байцаан шийтгэх үүлиар[2] харьяалуулсан хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

10.2.Мөрдөн байцаах албанд албаны дарга, дэд дарга, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаагч ажиллана.

10.3.Улсын ерөнхий прокурор нь Мөрдөн байцаах албаны бүтэц, дүрмийг батлаж, албаны дарга, дэд дарыг томилж, чөлөөлнө.

10.4.Мөрдөн байцаах алба нь захиргааны удирдлага, аж ахуй, санхүү, боловсон хүчний хувьд бие даасан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Прокурорын эрх хэмжээ

11 дүгээр зүйл.Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт

11.1.Прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх дараахь ажиллагаанд хяналт тавина:

11.1.1.төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх талаар явуулж байгаа ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

11.1.2.захиргааны журмаар таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, түр саатуулах болон албадан саатуулах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэх;

11.1.3.түр саатуулах болон албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

11.2.Прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавихдаа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.захиргааны эрх бүхий байгууллагад ирсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянах;

11.2.2.захиргааны журмаар таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, түр саатуулах болон албадан саатуулах ажиллагааны хууль зүйн үндэслэлийг хянаж, үндэслэлгүйгээр таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол хүчингүй болгох, саатуулагдсан этгээдийг суллах;

11.2.3. түр саатуулах болон албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаа шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

11.2.4.захиргааны шийтгэл үндэслэлгүйгээр оногдуулсан бол прокурор тогтоолоороо түүнийг хүчингүй болгох, өөрчлөх, шаардлагатай бол эрүүгийн хэрэг үүсгэх, харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах;

11.2.5.захиргааны зөрчлийн хэрэг бүртэрх эрх бүхий байгууллагаас хэрэг бүртэрх ажиллагаа явуулж байгаа материалыг хянах, танилцах, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;

11.2.6.хуульд тусгайлан заасан тохиолдолд захиргааны зөрчлийн хэрэг бүртэрх эрх бүхий байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, хязгаарласан ажиллагаа явуулах үед хянаж зөвшөөрөл олгох;

11.2.7.захиргааны зөрчлийн хэрэг бүртэрх ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11.2.8.захиргааны зөрчлийн хэрэг бүртэрх ажиллагааны талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг шалгаж шийдвэрлэх.

12 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт

12.1.Прокурор эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын дараахь ажиллагаанд хяналт тавина:

12.1.1.эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад ирсэн гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

12.1.2.эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

12.1.3.эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд Эрүүгийн хуулийг[3] зөв хэрэглэж байгаа эсэх.

12.1.4.сэжигтнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ болон байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянах;

12.1.5.сэжигтнийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

12.2.Прокурор эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавихдаа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгаж шийдвэрлэх, эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянах;

12.2.2.шаардлагатай гэж үзвэл хэрэг

[2] Эрүүгийн байцаан шийтгэх хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

[3] Эрүүгийн хууль-"Төрийн мэдээлэл"эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд биечлэн оролцох, хэргийн материалтай танилцах, хэргийг хянах, байцаан шийтгэх тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар бичих;

12.2.3.хэрэгт ач холбогдол бүхий зүйл, баримт бичиг хураан авах, нэхэлгэхийн, эд хөрөнгө битүүмжлэх, шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, үзлэг хийх, цогцсыг оршуулсан газраас нь гаргаж авах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй сэжигтэн, яллагдагчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт шилжүүлэх, хэргийн материалыг нийтэд мэдээлэх, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх, эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг нь хязгаарлах зэрэг ажиллагаа явуулахад зөвшөөрөл өгөх;

12.2.4.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн буюу уг хэрэгт хувийн сонирхолтой болох нь тогтоогдвол түүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хянаж шийдвэрлэх, хэргийг өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид шилжүүлэх;

12.2.5.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хууль бус, үндэслэлгүй тогтоолыг хүчингүй болгох, өөрчлөх;

12.2.6.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичиг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, тодорхойлолт авах, албадан ирүүлэх;

12.2.7.гэмт хэргийн шинж тэмдгийг хяналтаараа илрүүлсэн бол эрүүгийн хэрэг үүсгэн, харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлэх;

12.2.8.хэрэг шалгах харьяаллыг тогтоох;

12.2.9.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд шалгах, хэргийн материал хянах явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

12.2.10.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаар гарсан гомдлыг шалгаж шийдвэрлэх;

12.2.11.баривчлах, цагдан хорих байранд ямарч цагт саадгүй нэвтрэн орох, хоригдож буй эттэгэдтэй биечлэн уулзах, хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, эсхүл хууль болон шүхэйн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа эттэгэдийг нэн даруй суллах;

12.2.12.баривчлах, цагдан хорих, шийдвэрийг биелүүлэх ажиллагаат шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

12.2.13.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хугацаат сунгах;

12.2.14.сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих буюу хорьж мөрдөх хугацаат сунгах, өөрчлөх, хүчингүй болгох, баривчлах болон энэ тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай саналыг шүүхэд гаргах;

12.2.15.эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх сэргээх, хэргийг шүүхэд шилжүүлэх;

12.2.16.эрүүгийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан хэрэгт сэжигтнийг яллагдагчаар татсан тогтоолыг батлах буюу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэрэгт яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх.

12.3.Хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хүүльд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

12.4.Энэ хуулийн 12.1, 12.2-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон түүнд нийцүүлэн Улсын ерөнхий прокурорын батална эргэнилсан заавар, журмаар тогтооно.

12.5.Эрүүгийн хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэргийн дугаар олгоно. Эрүүгийн хэргийн дугаар олгох журмыг Улсын ерөнхий прокурор тогтооно.

13 дугаар зүйл.Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт

13.1.Улсын ерөнхий прокурор, түүний туслайнан эрх олгосон прокурор гүйцэтгэх ажилд хяналт тавина.

13.2.Прокурор Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажилд хяналт тавина.

14 дүгээр зүйл.Ял эдлүүлэх шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт

14.1.Прокурор ял эдлүүлэх дараах ажиллагаанд хяналт тавина:

14.1.1. баривчлах, хорих болон буса, төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэлээр, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

14.1.2.баривчлах болон хорих ял эдлүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, дэглэм нийцэж байгаа эсэх;

14.1.3.эрүүгийн хариуцлагын буса арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх;

14.1.4.ял эдэлж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг ханган байгаа эсэх.

14.2.Прокурор энэ хуулийн 14.1-д заасан ажиллагаанд хяналт тавихдаа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1.шийтгэх тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаанд ирүүлэхийг шүүхээс шаардах;

14.2.2.баривчлах, хорих ял эдлүүлэх газарт ямар ч цагт саадгүй нэвтрэх, ял эдлүүлэх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, баримт бичгийг танилцах, ялтантай биечлэн уулзах, шаардлагатай бо

⁴ Гүйцэтгэх ажлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

тайлбар гаргуулах, тодорхойлолт авах;

14.2.3.ял эдлүүлэлтийн байдлыг шалгах, тэнцилцах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

14.2.4.шүүхийн шийдвэр гүйцэтгэх талаар хуульд тусгайлан заасан тохиолдолд дүгнэлт гаргах, шинжээч томилох;

14.2.5.баривчлах, хорих ял эдлүүлж байгаа нөхцөл, дэгийг шалгах, хууль бусаар хоригдож байгаа хүнийг нэн даруй суллах;

14.2.6.тогтоол биелүүлэхийг хойшлуулах, торгох, албадан ажил хийлгэх ялыг өөр ялаар солих, өвчний үчир ял эдлүүлэхээс чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих анги эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдааны оролцож дүгнэлт гаргах.

15 дугаар зүйл.Прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох

15.1.Прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.

15.2.Улсын яллагч хууль болон хангалттай хэмжээний нотлох баримтад тулгуурласан өөрийн дотоод итгэлийг үндэслэн дэмжиж байгаа эсэхийг гэм буруу шүүхийн өмнө нотлох үүргийг гүйцэтгэнэ.

15.3.Шүүх хуралдааны явцад шүүгдэгчийн гэм буруу нь нотлогдоогүй гэж улсын яллагч үзвэл яллахаас татгалзана. Улсын яллагч яллахаас татгалзвал энэ тухай үндэслэл бүхий дүгнэлт гаргана.

15.4.Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд харгасан анхан шатны шүүхийн тогтоолд улсын яллагч давж заалдах болон хяналтын шатны шүүхэд иссэргүүлэл бичих эрхтэй. Харин давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл прокурор хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ.

15.5.Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэлээр прокурор шүүхэд дүгнэлт гаргана.

15.6.Шүүх хуралдаанд оролцох прокурорын гарсан бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтооно.

16 дугаар зүйл.Прокурор иргэний болон захиргаа хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох

16.1.Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд захиргаа төлөөлөгчөө оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ.

16.2. Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[5] хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

16.3. Прокурор иргэний хэрэгт оролцохдоо нотлох баримтыг шаардаж авах эрхтэй.

16.4.Прокурорыг иргэний хэрэгт оролцуулах хүсэлт гаргасан тухайн төрийн байгууллага нь нотлох баримтыг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

16.5.Прокурор иргэний хэрэгт итгэмжлэлгүйгээр оролцоно.

16.6.Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос прокурор татгалзах эрхгүй.

16.7.Прокурор бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан тохиолдолд оролцож болно.

16.8.Иргэний болон бусад төрлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрт прокурор давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.

17 дугаар зүйл.Прокурорын үүрэг

17.1.Прокурор дараахь үүрэгтэй:

17.1.1.төрийн албан хаагчийн болон прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахих;

17.1.2.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

17.1.3.албан үүргэтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах.

17.2.Прокурорын ёс зүйн дүрмийг Ерөнхийлөгч батална.

18 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурорын бүрэн эрх

18.1.Улсын ерөнхий прокурор дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.прокурорын байгууллагын үйл ажиллагаат нэгтгэн зохион байгуулж, удирдах;

18.1.2.Улсын Их Хурлаас батлагдсан төсвийг хуваарилах, түүнд багтаан прокурорын газруудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог тогтоох;

18.1.3.Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилуулах, чөлөөлүүлэх тухай саналаа Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

18.1.4.харьяа прокурорыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах;

18.1.5.хуулийг хэрэгжүүлэх талаар прокурорын хяналтын болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх арга чилсан заавар, журам гаргах;

18.1.6.прокурорын байгууллагын дотоод асуудлаар тушаал гаргах;

18.1.7.гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах болон хэрэг бүртгэх, мөрдөн

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль – "Төрийн эдэлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

байцаах, эл эдлүүлэх ажиллагаар хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн заалтыг хэрэгжүүлэх заавар, журам хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж зөвшөөрөл олгох, тухайн заавар, журмыг Улсын ерөнхий прокурор хянаж зөвшөөрөөгүй бол дагаж мөрдөхгүй;

18.1.8.хуулиар тогтоосон бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл.Улсын Их Хуралтай харилцах

19.1.Улсын ерөнхий прокурор эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жилд нэгээс доошгүй удаа Улсын Их Хуралд мэдээлнэ.

19.2.Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийн талаар Улсын ерөнхий прокурор санал, дүгнэлт гаргана.

20 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчтэй харилцах

20.1.Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаар Ерөнхийлөгчид тогтмол танилцуулж байна.

20.2.Ерөнхийлөгчийн тавьсан хүсэлтийн дагуу Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар дүгнэлт гаргаж болно.

20.3.Ялтанд үзүүлэх уучлалын асуудлаар шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргана.

21 дүгээр зүйл.Засгийн газартай харилцах

21.1.Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний хүсэлтээр Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцож, санал дүгнэлт гаргаж болно.

21.2.Улсын ерөнхий прокурор шаардлагата гэж үзвэл өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаа Ерөнхий сайдтай зөвшилцөн Засгийн газры хуралдаанд асуудал оруулж болно.

22 дугаар зүйл.Үндсэн хуулийн цэцэ хүсэлт гаргах

22.1.Улсын ерөнхий прокурор Үндсэ хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасн дагуу Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянэ шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хүсэл гаргана.

22.2.Улсын ерөнхий прокурорын ийнхү гаргасан хүсэлт Үндсэн хуулийн цэцийн тухай[6] хуул заасан шаардлагыг хангасан байна.

23 дугаар зүйл.Улсын дээд шүүхтэ харилцах

23.1.Улсын ерөнхий прокурор Улсын дээ шүүхийн хяналтын журмаар эрүүгийн хэргийг хянэ шийдвэрлэсэн тогтоол хуульд харшилсан гэж үзвэ санал гаргана.

23.2. Улсын ерөнхий прокурор Үндсэн хуули бусад хуулийг зөв хэрэглэх асуудлаар тайлб гаргуулахаар Улсын дээд шүүхэд санал оруулж болн

23.3.Улсын ерөнхий прокурор Улсын дээ шүүхийн шүүгдийн хуралдаанд терийн нэрийн өмнө оролцоно.

23.4.Улсын ерөнхий прокурор бүрэн, эрх хэрэгжүүлэх явцад хууль, түүнд заасан хүний эрх, э чөлөөг зөрчсөн тухай баримт илэрвэл түүни шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхэд шилжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр

24 дүгээр зүйл.Эрх зүйн хэлбэрийн төрөл

24.1.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, мэдэгдэл, тогтоол, даалгавар, зөвшөөрөл, эсэргүүцэл гаргана.Тэдгээрийн загварыг Улсын ерөнхий прокурор батална.

24.2.Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрийн бусад төрлийг хуулиар тогтоож болно.

25 дугаар зүйл.Прокурорын шаардлага

25.1.Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль зөрчсөн зөрчил, түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар шаардлага бичнэ.

25.2.Прокурорын шаардлагыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, уг зөрчил, түүний шалтгаан, нөхцлийг нэн даруй арилгах арга хэмжээ авч, 14 хоногийн дотор прокурорт хариу мэдэгдэнэ.

26 дугаар зүйл.Прокурорын мэдэгдэл

26.1.Прокурор гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар мэдэгдэл бичнэ.

26.2.Прокурорын мэдэгдлийг хүлээн авс байгууллага, албан тушаалтан нь мэдэгдэлд дурдс шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авч, мэдэгдэ заасан хугацаанд албан ёсоор хариу өгнө.

27 дугаар зүйл.Прокурорын тогтоол

27.1.Прокурор хэрэг бүртгэлт, мөрд байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ч үүргийн дагуу хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхд өөрийн эрх хэмжээний хүрээнд тодорхой асуудл шийдвэрлэхийн тулд тогтоол гаргана.

28 дугаар зүйл.Прокурорын даалгавар

28.1.Прокурор хэрэг бүртгэлт, мөрд байцаалтын ажиллагаанд хуулийн заалтыг хангуул хуулийг зөв хэрэглэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт цаг тухайд нь бүрэн бодитой явуулах арга хэмжээн талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид бичгэ даалгавар өгнө.

29 дүгээр зүйл.Прокурорын зөвшөөрөл

29.1.Шүүхээс зөвшөөрөл авахаас бус тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эл эдлүүл

[6] *Үндсэн хуулийн цэцийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 3 дугаарт нийтлэгдсэн.*

ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгнө.

29.2.Прокурорын зөвшөөрөл энэ хуулийн 29.1-д заасан ажиллагааг явуулах албан тушаалтны шийдвэрийг батламжлах хэлбэрээр үйлдэгдэнэ.

30 дугаар зүйл.Прокурорын шийдвэрийг биелүүлэх

30.1.Хууль заасан үндэслэл, журмын дагуу гаргасан прокурорын шийдвэрийг байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

30.2.Прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

30.3.Прокурорын шийдвэрийн талаар дээд шатны прокурорт гомдол гаргасан нь түүнийг биелүүлэх явдлыг зогсоохгүй.

31 дүгээр зүйл.Прокурорын эсэргүүцэл

31.1.Прокурор шүүх хуралдаанд оролцох чиг үүргээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эсэргүүцэл бичнэ.

31.2.Доод шатны прокурорын бичсэн эсэргүүцэл үндэслэлгүй байна гэж үзвэл дээд шатны прокурор буцаан авч болно.

32 дугаар зүйл.Дээд шатны прокурооос доод шатны прокурорын шийдвэрийг заавал хянах

32.1.Доод шатны прокурорын шийдвэрийг дараахь тохиолдолд заавал хянана:

32.1.1.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гомдол, өмгөөлөгч хүсэлт гаргасан;

32.1.2.байгууллага, иргэнээс гомдол, мэдээллэл ирүүлсэн;

32.1.3.хүнд, олон хүнд хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн;

32.1.4.прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулсан;

32.1.5.дээд шатны прокурор даалгавар бичсэн;

32.1.6.ялтанг хугацааны өмнө сулласан, өвчний үчир ялаас чөлөөлсөн;

32.1.7.улсын яллагч шүүх хуралдаанд яллахаас татгалзсан ;

32.1.8.шүүхээс цагаатгах тогтоол гаргасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Прокурорын үйл ажиллагааны баталгаа

33 дугаар зүйл.Улс төрийн баталгаа

33.1.Прокурорын байгууллагад улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Прокурор нь албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнээс түдгэлзэнэ.

33.2.Прокурор хууль ёсны эрх ашгаа хамгаалах, мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн болон төрийн бус бусад байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх эдэлнэ.

33.3.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

33.4.Прокурор Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд албан тушаалаасаа чөлөөлөгдөх ба хоёр жилийн хугацаанд прокурорын албан тушаалд дахин томилогдох эрхгүй.

34 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа

34.1.Прокурорын байгууллагын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгаат тэр хангана.

34.2.Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

34.3.Прокурорын цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Прокурорын албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

34.4.Прокурорын байгууллагыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техникийн хэрэгсэл, ажилтныг орон сууцаар хангах зэрэг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны байгууллага бүх талын дэмжлэг үзүүлнэ.

34.5.Прокурорын байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан прокурорт аминдаа орон сууц барих болон амьдрахын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр сураллцах болон хүүхдээ сургахад нь зориулан төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.

34.6.Улсын ерөнхий прокурор нь Засгийн газрын гишүүний нэгэн адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

35 дугаар зүйл.Нийгмийн баталгаа

35.1.Хууль заасснаас бусад тохиолдолд прокурорыг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

35.2. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан прокурорын бие махбодид гэмтэл учруулсан бүхүү эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд прокурорт тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадварыг түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгоно.

35.3.Прокурор албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 36 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.

35.4.Энэ хуулийн 35.2, 35.3-д заасан тэтгэвэр, тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол буцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгож, хууль зүйн аливаа этгээдэд гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

35.5.Прокурор төрийн албаны талаарх зүүн тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажилтах нөхцөл, батлагаа, нэмэгдэл батлагаа, түүнд олгох цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана.

35.6.Энэ хуулийн 35.5-д заасан баталгааг прокурорт эдлүүлэхдээ ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдлийг давхардуулж олгохгүй бөгөөд сонголтыг өөрөө хийнэ.

35.7.Прокурорын тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 60 нас байна. 55 насанд хүрсэн эмэгтэй прокурор өөрийн хүсэлтээр тэтгэвэрээ тогтоолгох эрхтэй.

35.8.Прокурорын байгууллагаас тэтгэвэрт гарахад нь прокуророор 20-оос доошгүй жил ажилласан бол түүнд албан тушаалынх нь 18 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

35.9.Прокурорын амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг прокурорын байгууллагын төсөөс төлнө.

35.10.Прокурорын эзэлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн хуулиар[7] тогтоно. Прокуророор ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдэлнэ.

36 дугаар зүйл.Хууль зүйн баталгаа

36.1.Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох бариммтайгаар баривчилснаас бусад тохиолдолд Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр, бусад прокурорыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, уналга болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

36.2.Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох бариммтайгаар баривчилсан, эсхүл эрүүгийн харияцлагад татах хангалттай үндэслэл тогтоогдон бол энэ тухай Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн талаар Ерөнхийлөгчид, бусад прокурорын талаар Улсын ерөнхий прокурорт 48 цагийн дотор мэдэгдэнэ.

36.3.Ерөнхийлөгч буюу Улсын ерөнхий прокурор 10 хоногийн дотор прокурорыг эрүүгийн харияцлагад татах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

36.4.Прокурорыг эрүүгийн хариуцлагад татахтай холбогдуулан түүний бүрэн эрхийг Улсын ерөнхий прокурор түдгэлзүүлж болно.

36.5.Прокурорыг албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, уналга, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийх шаардлагатай бол энэ хуулийн 36.2, 36.3-т заасан журмын дагуу зөвшөөрөл авна.

36.6.Бусад байгууллага, албан тушаалтан прокурорын хяналтын ажлыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр шалгах буюу албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцын талаар мэдээлэл өгөхийг прокуророос шаардаж болохгүй.

36.7.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.

37 дугаар зүйл.Бусад баталгаа

37.1.Прокурор багшлах болон эрдэм шинжилгээний алба гүйцэтгэхээс бусад хүүлийн тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

37.2.Прокурор нь амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд нь шууд тулгарсан гэмт халдлагын аюулаас хамгаалахын тулд биеэ хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.

37.3.Прокурор албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

37.4.Прокурор чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан түүний өөрт нь болон гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цагдаагийн байгууллага хариуцна.

38 дугаар зүйл.Прокурорыг үл хүндэтгэгчид хүлээлгэх хариуцлага

38.1.Прокурорыг үл хүндэтгэгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Прокурорын байгууллагын боловсон хүчин

39 дүгээр зүйл.Прокурор

39.Хууль зүйн бакалаврын боловсролтой, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвараар шаардлага хангасан, хуульчийн мэргэжлээр гурваас доошгүй, эсхүл прокурорын туслах ажилтнаар хоёрөөс доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, хорих гурван нас хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророр

[7] *Хөдөлмөрийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.*

томилно.

39.2.Аймаг, нийслэлийн болон дагнасан прокуророор хуульчийн мэргэжлээр тавааг доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

39.3.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор гучин таван нас хүрсэн, хуульчийн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

40 дүгээр зүйл.Прокурорын тангараг

40.1.Прокурор албан тушаалд томилогдохдоо: "Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг чанд сахиж, прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх зарчмыг гүнээ хүндэтгэн, албаны үүргээ үнэнч шударгаар биелүүлж, прокурорын ёс зүй, нэр хүндийг өндөрт өргөж явахаа тангараглая.Хэрэв миний бие өргөсөн тангарагаасаа няцвал хуульд заасан хариуцлагыг хүлээнэ" гэж тангараг өргөнө.

40.2.Прокурорын тангараг өргөх ёслолын журмыг Ерөнхийлөгч тогтооно.

41 дүгээр зүйл.Прокурорын зэрэг дэв, бэлгэдэл, энгэрийн тэмдэг, дүрэмт хувцас

41.1.Прокурор нь төрийн хууль цаазын төрүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх, хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөхийн зэрэг дэвтэй байна.

41.2.Төрийн хууль цаазын төрүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зэрэг дэвийг Ерөнхийлөгчийн зарлигаар, бусад зэрэг дэвийг Улсын ерөнхий прокурорын тушаалаар олгоно.

41.3.Зэрэг дэв олгохдоо албан тушаалын онцлогийг, ажилласан хугацаа, мэргэшлийн түвшинг харгалзана.

41.4.Прокурорын байгууллага бэлгэдэлтэй байна.Прокурор энгэрийн тэмдэг хэрэглэнэ.

41.5.Прокурорын зэрэг дэв олгох дүрэм, бэлгэдэл, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

41.6.Прокурор дүрэмт хувцастай байна.Прокурорын дүрэмт хувцсанд прокурорын зэрэг дэвийг тусгасан ялгах тэмдэг байна.Тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

42 дугаар зүйл.Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах

42.1.Прокурорын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг шалгаж, дүгнэх Улсын ерөнхий прокурор болгойлсон орон тооны бус мэргэжлийн зөвлөл ажиллана.

42.2.Нийт прокурорын үйл ажиллагаа мэргэшлийн түвшинг гурван жилд нэг удаа шалгаж, дүгнэнэ.

42.3.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгч батална.

43 дугаар зүйл.Прокурорыг албан тушаалаас чөлөөлөх

43.1.Улсын ерөнхий прокурор дараахь үндэслэлээр прокурорыг албан тушаалаас нь чөлөөлнө:

43.1.1.өөрөө хүсэлт гаргасан;

43.1.2.өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон буюу сонгосон;

43.1.3.биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

43.1.4.энэ хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

43.1.5.мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд зөрчлэсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан.

44 дүгээр зүйл.Сахилгын шийтгэл

44.1.Прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

44.1.1.сануулах;

44.1.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

44.1.3.албан тушаал бууруулах;

44.1.4.ажлаас халах.

44.2.Прокурорын шийдвэр хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн нь түүний гэм буруугаас шалтгаалсан бол сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

44.3.Аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурор нь энэ хуулийн 44.1.1, 44.1.2-т заасан сахилгын шийтгэлийг харьяа прокурорт оногдуулж болно.

44.4.Прокурорын сахилгын дүрмийг Ерөнхийлөгч батална.

44.5.Прокурор сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш нэг сарын дотор дүүргийн прокурор оногдуулсан бол нийслэлийн прокурорт, аймаг, нийслэл болон дагнасан прокурор оногдуулсан бол Улсын ерөнхий прокурорт, Улсын ерөнхий прокурор оногдуулсан бол шүүхэд тус тус гаргана.

44.6.Прокурор гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноор Улсын ерөнхий прокурор түүнийг ажлаас нь хална.

45 дугаар зүйл.Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч

45.1.Хууль зүйн бакалаврын боловсролтой Монгол Улсын иргэнийг мөрдөн байцаагчаар томилно.

45.2.Мерден байцаах албаны даргаар хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

45.3.Мерден байцаах албаны дарга, мерден байцаагч нь цагдаагийн адилтгах алба хаагчийн адил хэмжээний цалин хангамж, цол, нэмэгдлийг эдэлнэ.

46 дугаар зүйл.Прокурорын байгууллагын албан тушаалын бүрэлдэхүүн

46.1.Улсын ерөнхий прокурорын газарт Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор ажилана.Туслах прокурор нь зохион байгуулалтын бүтцийн нэгж, албыг удирдаж болно.

46.2.Аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурорын газарт аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор ажилана.

46.3.Сум, сум дундын прокурорын газарт ахлах болон хяналтын прокурор ажиллана.

47дугаар зүйл.Прокурорын байгууллагын ажилтан

47.1.Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор Улсын ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурорын газарт прокурорын туслах ажилтан ажиллана.

47.2.Прокурорын туслах ажилтны ажиллах журмыг Улсын ерөнхий прокурор тогтооно.

47.3.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах үүрэг бүхий захиргааны болон үйлчилгээний ажилтантай байна.

47.4.Эрүүгийн хэргийн архивт архивын эрхлэгч, архивч ажиллана.

48 дугаар зүйл.Прокурорын байгууллагын боловсон хүчний сургалт

48.1.Прокурорын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг Засгийн газар эрхэлнэ.

49 дүгээр зүйл.Прокурорын байгууллагын гадаад харилцаа

49.1.Улсын ерөнхий прокурор өөрийн эрх хэмжээний хүрээнд гадаад улсын ижил төстэй байгууллага, олон улсын байгууллагатай шууд харилцаж хамтран ажиллах, тэдэнтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хэлэлцээр байгуулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

50 дугаар зүйл.Прокурорын байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

50.1.Прокурорын байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

51 дүгээр зүйл.Прокурорын байгууллагын хэвлэл, эрдэм шинжилгээний байгууллага

51.1.Прокурорын байгууллага хууль хамгаалах бусад байгууллагатай хамтарсан хэвлэл, эрдэм шинжилгээний байгууллагатай байж болно.

52 дугаар зүйл.Эрүүгийн хэргийн архив

52.1.Улсын ерөнхий прокурорын газарт эрүүгийн хэргийн төв архив, сум, сум дундын прокурорын газраас бусад прокурорын газарт түүний салбар архив ажиллана.

52.2.Эрүүгийн хэргийн архив хөтлех зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Улсын ерөнхий прокурор батална.

53 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Прокурорын байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, түүнчлэн шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбогдсон харилцаат зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Шүүхийн тухай хууль тогтоомж

2.1.Шүүхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх

3.1.Үндэсэн хуульд зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

3.2.Шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим

4 дүгээр зүйл. Шүүгч гагцхүү хуульд захирагдах

4.1.Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана.

4.2.Шүүгчийн хараат бус байдлыг Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна.

5 дугаар зүйл. Мэтгэлцэх зарчим

5.1.Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна.

5.2.Мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх журмыг байцаан шийтгэх хуулиар тогтооно.

6 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг оролцуулах

6.1.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ хуульд заасан журмын дагуу иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

6.2.Иргэдийн төлөөлөгчийг сонгогдын нэрсийн жагсаалтыг үндэслэн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу сонгон авах ажлыг тухайн шүүхийн тамгын хэлтэс зохион байгуулж, шүүх хуралдааныг оролцуулна.

6.3.Иргэдийн төлөөлөгчийн шүүхэд ажилласан хугацааны хөлсийг шүүхийн төсвөөс олгоно.

6.4.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.5.Иргэдийн төлөөлөгч ажил эрхэлдэг бол түүнийг шүүхэд ажиллах хугацаанд ажлаас нь чөлөөлж, цалинг тухайн аж ахуйн нэгж, байгууллага олгоно.

6.6.Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг хуулиар тодорхойлно.

7 дугаар зүйл. Гэм буруутайд тооцож үл болох

7.1.Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

8 дугаар зүйл. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

8.1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

9 дүгээр зүйл. Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх

9.1.Шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах, хэргийн баримт сэлттэй танилцах эрхтэй.

9.2.Шүүх энэ хуулийн 9.1-д заасан эрхийг шүүгдэгчид тайлбарлаж, энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэгтэй.

9.3.Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгдэгчийг шүүх хуралдаанд заавал биеэр оролцуулна.

9.4.Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Үг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

[1] *Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

10 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагаа явуулах хэл

10.1.Шүүн таслах ажиллагаанд монгол хэлээр явуулна.

10.2.Монгол хэл мэдэхгүй хүн хэргийн баримт сэтгийг орчуулуулан авах бүюу хэлмэрчлүүлэн бүрэн танилцах, шүүх хуралдаан дээр эх хэлээрээ үг хэлэх, орчуулагч, хэлмэрч авах эрхтэй.

11 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

11.1.Шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

11.2.Хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэг, маргааныг шүүх хуралдаанаар хаалттай хянан шийдвэрлэнэ.

11.3.Шүүх тухайн хэрэг, маргааны онцлогоос шалтгаалж шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

12 дугаар зүйл. Шүүхээс хэрэглэх хууль

12.1.Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндэсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг хэрэглэнэ.

12.2.Шүүх Үндэсэн хуульд нийцээгүй, хэрэг, маргаан гарах үед хүчин төгөлдөр болоогүй, албан ёсоор нийтлэгдээгүй хуулийг хэрэглэхгүй.

12.3.Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндэсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүх тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг тудгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхэд оруулна.

12.4.Улсын дээд шүүх энэ хуулийн 12.3-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндэсэн хуулийн цъцэд хүсэлт гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын шүүх

13 дугаар зүйл. Шүүхийн тогтолцоо

13.1.Шүүхийн үндэсэн тогтолцоо нь Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

13.2.Эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх /цаашид "дагнасан шүүх" гэх/ байгуулж болно.

14 дүгээр зүйл. Шүүх байгуулах

14.1.Монгол Улсын дээд шүүхийг Үндэсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулж, өөрчлөн байгуулна.

14.2.Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг аймаг, нийслэлийн Засаг даргатай, дагнасан шүүхийг Улсын дээд шүүхтэй тус тус зөвшилцөн гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид "Ерөнхий зөвлөл" гэх/ -ийн саналыг үндэслэн Улсын Их Хурал байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.

14.3.Шүүх байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, бүс нутаг, нутаг дэвсгэрийн онцлог, шүүхэд ирэх байгуулагчдын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг харгалзан үзнэ.

14.4.Давж заалдах шатны шүүхийг тойргийн журмаар байгуулж болно.

14.5.Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулахыг хоригдоно.

15 дугаар зүйл. Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх

15.1.Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.

15.2.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, 10 шүүгчээс бүрдэнэ.

/Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хориг тавьсан тул хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хуулийн энэ заалт хүчин төгөлдөр мөрдөгдөхгүй болно/

15.3.Улсын дээд шүүх шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, шүүхийн мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий танхимтай байна.

15.4.Шүүхийн мэргэжлийн удирдлага нь хуулийн тайлбарлах, сургалт явуулах, шүүхийн практикийн нэгтгэн судлах, зөвлөмж гаргах хэлбэртэй байна.

15.5.Улсын дээд шүүхийн танхимыг Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүний Ерөнхий шүүгч батална.

15.6.Улсын дээд шүүх дараахь бүрэн эрхийн хэрэгжүүлнэ:

15.6.1.Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх;

15.6.2.Хуулийн хүүлийн тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасны дагуу хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;

15.6.3.шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах;

15.6.4.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндэсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

15.6.5.Үндэсэн хуулиас бусад хуулийн нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар /цаашид хуулийн тайлбар гэх/ гаргах;

15.6.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр томилуулах шүүгчийг санал болгох;

15.6.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох;

15.6.8.Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнд нэр дэвшигчийг санал болгох;

15.6.9.цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх;

15.6.10.Улсын дээд шүүхийн хуралдааны дэгийг тогтоох;

15.6.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

15.7.Энэ хуулийн 15.6.3 дахь заалт нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд үл хамаарна.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн шүүх, түүний бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны шүүх мөн.

16.2.Аймаг, нийслэлийн шүүх Ерөнхий шүүгч, шүүгчээс бүрдэнэ.

16.3.Аймаг, нийслэлийн шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.3.1.сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;

16.3.2.хуулиар харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

16.3.3.сум буюу сум дундын, дүүргийн шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах;

16.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

16.4.Энэ хуулийн 16.3.3 дахь заалт нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд үл хамаарна.

16.5.Нийслэлийн шүүх шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, дүүргийн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий танхимтай байж болно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан танхимыг Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална.

17 дугаар зүйл. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүний бүрэн эрх

17.1.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх нь анхан шатны шүүх мөн.

17.2.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх Ерөнхий шүүгч, шүүгчээс бүрдэнэ.

17.3.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.3.1.Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, дагнасан шүүхэд хуулиар тусгайлан харьяалуулснаас бусад хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

17.3.2.хуульд заасан бусад бүрэн эрх.

18 дугаар зүйл. Дагнасан шүүх

18.1.Дагнасан шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр байгуулагдсан шүүх мөн.

18.2.Дагнасан шүүхийг анхан болон давж заалдах шатны шүүхийн хэлбэрээр байгуулж болно.

18.3.Дагнасан шүүх Ерөнхий шүүгч, шүүгчээс бүрдэнэ.

18.4.Дагнасан шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, огцруулах журам, түүний бүрэн эрхийг энэ хууль болон бусад хуулиар тогтооно.

18.5.Дагнасан шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.5.1.хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;

18.5.2.хуульд заасан бусад бүрэн эрх.

18.6.Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

19 дүгээр зүйл.Шүүхийн санхүүжилт

19.1.Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

19.2.Шүүхийн төсөв нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна.

19.3.Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн болон дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсөвөөс бүрдэнэ.

20 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн

20.1.Анхан шатны журмаар хэрэг, маргааныг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, хуульд тусгайлан заасан тохиолдолд шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

20.2.Давж заалдах шатны журмаар хэрэг, маргааныг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

20.3.Хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

20.4.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргавал хэрэг, маргааныг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

20.5.Улсын дээд шүүхийн шүүгчдийн хуралдаан нь нийт шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирснээр хүчинтэй тооцогдох бөгөөд хэрэг, маргааныг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар

шийдвэрлэнэ. Улсын дээд шүүхийн шүүгчдийн хуралдааны тогтоол нь тухайн хэрэг, маргааны хувьд эцсийн шийдвэр болно.

20.6.Анхан болон давж заалдах, хяналтын шатны жүрмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд урьд нь оролцон шүүгч үг хэрэг, маргааныг өөр шатны жүрмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

21 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр

21.1.Анхан шатны шүүх зөрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж шийтгэх, эсхүл цагаатгах тогтоол, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж шийдвэр, баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээ авахад шүүгч батламж, засгийн газар зөрчлийг хянан хэлэлцэж шүүгч шийтгэвэр, давж заалдах шатны шүүх магадлал, хяналтын шатны шүүх тогтоол, эдгээрээс бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж /цаашид "шүүхийн шийдвэр" гэх/ гаргана.

21.2.Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана.

21.3.Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргаж, төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудсан дээр үйлдэн, шүүх бүрэлдэхүүн бүюу шүүгч гарын үсэг зурж, тухайн шүүхийн тамга дарна.

21.4.Улсын дээд шүүхийн шийдвэрийг "Дээд шүүхийн мэдээлэл" сэтгүүлд нийтэлж болно.

22 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

22.1.Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлнэ.

22.2.Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

22.3.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно.

23 дугаар зүйл. Хуулийн тайлбар

23.1.Энэ хуулийн 15.6.5-д заасны дагуу Үндсэн хуулиас бусад хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүх гаргана.

23.2.Иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Улсын дээд шүүхэд ирүүлнэ.

23.4.Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох хуулийн заалтыг тайлбарлуулах тухай саналаа талуудын гаргасан тайлбар, үндэслэлийн хамт Улсын дээд шүүхэд ирүүлж болно.

23.5.Хуулийн тайлбарын төслийг боловсруулах, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг Улсын дээд шүүхийн шүүгч хариуцна.

23.6.Хуулийн тайлбарыг Улсын дээд шүүхийн шүүгчдийн хуралдаанд оролцогчдын гуравны хоёрын саналаар батална.

23.7.Хуулийн тайлбарыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

23.8.Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрдөнө.

24 дүгээр зүйл.Шүүхийн бэлгэ тэмдэг

24.1.Шүүх бэлгэ тэмдэгтэй байна.

24.2.Шүүхийн бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

25 дугаар зүйл. Шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

25.1.Шүүх соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байна.

25.2.Шүүх албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

26 дугаар зүйл. Шүүх хуралдааны танхим

26.1.Шүүх хуралдааныг шүүн таслах ажил явуулах шаардлага хангасан танхимд явуулна.

26.2.Шүүх хуралдааны танхимын загварыг Ерөнхий зөвлөл батална.

26.3.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхимд төрийн сүлд, төрийн далбааг байрлуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шүүгчийг сонгон шалгаруулах, томилох

27 дугаар зүйл.Сонгон шалгаруулалт зарлах

27.1.Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай зарлалыг сонгон шалгаруулалт явуулах едрээс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

28 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшүүлэх

28.1.Шүүгчид дараахь шаардлага хангасан Монгол Улсын иргэн нэрээ дэвшүүлэх эрхтэй:

28.1.1.Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлыг хангасан;

28.1.2.ял шийтгүүлж байгаагүй.

28.2.Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэр дэвшүүлнэ.

28.3.Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид шүүгчээр гурваас доошгүй жил ажилласан шүүгч нэрээ дэвшүүлэх эрхтэй.

28.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид Улсын дээд шүүхийн шүүгч нэрээ дэвшүүлэх эрхтэй.

29 дүгээр зүйл. Шүүгчид нэр дэвшигчийг бүрттэх

29.1. Шүүгчид нэр дэвшигчийг Үндсэн хууль, энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг судалсны үндсэн дээр тухайн шүүхийн тамгын хэлтэс бүртэнэ.

30 дугаар зүйл.Шүүхийн мэргэшлийн хороо

30.1.Шүүхийн мэргэшлийн хороо /цаашид "Мэргэшлийн хороо" гэх/ улсын хэмжээнд нэг байна.

30.2.Ерөнхий эрхлэл Мэргэшлийн хороог есөн гишүүний бүрэлдэхүүнтэй, гурван жилийн хугацаагаар байгуулна.

30.3.Мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хуулийн болон шүүн таслах ажлын дадлагатай шүүгч, хуульч, эрдэмтдээс бүрдэнэ.

30.4.Мэргэшлийн хорооны гишүүдийн зургаа нь шүүгч байна.

30.5.Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий эрхлэлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүн орохгүй.

30.6.Мэргэшлийн хорооны даргыг шүүгч гишүүдийнх нь дотроос гишүүдийн санал болгосноор Ерөнхий эрхлэл томилно.

30.7.Мэргэшлийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.7.1.шүүгчид нэр дэвшигчээс эрх зүйн мэдлэгийн болон ажил хэргийн чадварын талаар шалгалт авч, дүгнэлт гаргах;

30.7.2.шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийнх хувьд албан тушаалдаа тэнцэхгүй үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх тохиолдолд дүгнэлт гаргах;

30.7.3.давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий шүүгчийн хүсэлт, тухайн шүүхийн шүүгчидийн эзэлзлгөөний шийдвэрээр шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах.

30.8.Шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар гаргасан дүгнэлт нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

30.9.Мэргэшлийн хорооны дүрмийг Ерөнхий эзэлзл батална.

31 дүгээр зүйл. Ерөнхий эзэлзлийн хуралдаанаар нэр дэвшигч, шүүгчийг хэлэлцэх

31.1.Ерөнхий эзэлзл шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар гаргасан Мэргэшлийн хорооны дүгнэлт, хувийн зан суртахуун, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан нэр дэвшигч нэг бүрээр хэлэлцэн нүүдвэр санал хураах, олонхийн санал авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

31.2.Ерөнхий эзэлзл шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар гаргасан Мэргэшлийн хорооны дүгнэлтийг үндэслэн тухайн шүүгчийг албан тушаал бууруулах, чөлөөлөх эсэх асуудлыг хэлэлцэн нүүдвэр санал хураах, олонхийн санал авсан бол тухайн шүүгчийг албан тушаал бууруулах, чөлөөлөх саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

32 дугаар зүйл. Шүүгчийг томилох

32.1.Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийг Ерөнхий эзэлзлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.

32.2.Улсын дээд шүүхийн шүүгчийг Ерөнхий эзэлзлийн санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно.

32.3.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал санал хураахгүй бөгөөд асуулт тавьж, хариулт авч болно.

32.4.Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүх, дагнасан шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхий эзэлзлийн санал болгосноор Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

32.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

32.6.Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхэд нэг удаа улируулан томилж болно.

32.7.Улсын дээд шүүх, нийслэлийн шүүхийн танхимийн тэргүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Ерөнхийлөгч гурван жилийн хугацаагаар томилно.

32.8. Ерөнхий шүүгч болон шүүгчээр томилохоос Ерөнхийлөгч татгалзсан тохиолдолд Ерөнхий эзэлзл Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.

32.9.Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийг түр эзгүйд түүнийг тухайн шүүхийн шүүгч; Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг түр эзгүйд Улсын дээд шүүхийн аль нэг танхимын тэргүүн тус тус орлох ба энэ тухай шийдвэрийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гаргана. Хэрэв Ерөнхий шүүгч шийдвэр гаргаж томилох боломжгүй тохиолдолд тухайн шүүхэд хамгийн олон жил ажилласан шүүгч Ерөнхий шүүгчийг орлоно.

33 дугаар зүйл. Шүүгчийн эзрэг дэв

33.1. Шүүгч Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гүтгаар түшээ, дөтгөр түшээ, тавдугаар түшээ гэсэн эзрэг дэвтэй байна.

33.2.Шүүгчид эзрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

33.3.Шүүгчид эзрэг дэв олгохдоо албан тушаал, хуульч мэргэзлээрээ ажилласан хугацаа, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшин, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан үзнэ.

33.4.Шүүгчийн албан тушаал бууран тохиолдолд түүний эзрэг дэв нь буурахгүй.

34 дугаар зүйл. Шүүгчийн бүрэн эрх

34.1.Бүх шатны шүүхийн шүүгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.шүүх хуралдааныг даргалах буюу түүнд оролцох;

34.1.2.шүүх хуралдааныг товлон зарлаж, түүний оролцогчдыг тогтоох;

34.1.3.шүүх хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохицуулан удирдах;

34.1.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдуулж хуульд заасан бусад ажиллагаат явуулах;

34.1.5.өөрийнх нь оролцож байгаа шүүх хуралдаанаар шийдвэрлэж байгаа асуудлаар санал өгөх;

34.1.6. энэ хуулийн 32.9-д заасан тохиолдолд Ерөнхий шүүгчийг орлох;

34.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

34.2. Шүүгч албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн тэр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй.

34.3.Шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

35 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

35.1. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.Улсын дээд шүүхийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

35.1.2..Улсын дээд шүүхийн хуралдааныг товлон зарлаж даргалах;

35.1.3.нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах;

35.1.4.нийт шүүхийн шүүн таслах ажлыг уялдуулан зохицуулах;

35.1.5.бүх шатны шүүхийн шүүгчдийг төрийн дээд болон бусад шагналаар шагнаж урамшуулах саналыг Ерөнхий зөвлөлд гаргах;

35.1.6.шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Шүүхийн сахилгын, шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоох талаар гаргуулахаар Мэргэшлийн хороонд тус тус хүсэлт гаргах;

35.1.7.судалгааны төвийн захирлыг томилох, чөлөөлөх;

35.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

35.2.Энэ хуулийн 35.1.3, 35.1.4 дэх заалт нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд үл хамаарна.

35.3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч ажлын албатай байна. Ерөнхий шүүгчийн ажлын албаны бүтэц, орон тоог Ерөнхий шүүгчийн санал болгосноор Ерөнхий зөвлөл тогтооно.

35.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргана.

36 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн танхимын төрүүний бүрэн эрх

36.1. Улсын дээд шүүхийн танхимын төрүүн нь шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.танхимыг төрүүлж танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг удирдан зохицуулах;.

36.1.2.танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

36.1.3.танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр ирсэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

36.1.4.танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хооронд гарсан хэргийн харьяаллын талаархи маргааныг хянаж харьяалал тогтоох;

36.1.5.энэ хуулийн 32.9-д заасан тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг орлох;

36.1.6.хуульд заасан жүрмын дагуу шүүх хуралдааныг даргалах, шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох;

36.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

36.2.Танхимын төрүүн энэ хуулийн 36.1.4-д заасан асуудлаар захирамж гаргана.

37 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

37.1.Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.1.1. аймаг, нийслэлийн шүүхийг тэргүүлж, түүнийг төлөөлөх;

37.1.2.шүүгчийн шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтийн хугацааны байдалд хяналт тавих;

37.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

37.1.4.харьяалах нутаг дэвсгэрийнхээ шүүхийн шүүн таслах ажлыг уялдуулан зохицуулах;

37.1.5.харьяалах нутаг дэвсгэрийнхээ шүүхийн шүүгчийг төрийн дээд болон бусад шагналаар шагнаж урамшуулах саналыг Ерөнхий зөвлөлд гаргах;

37.1.6.харьяалах нутаг дэвсгэрийнхээ сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүдийн хооронд гарсан хэргийн харьяалалын талаархи маргааныг хянаж

харьяалал тогтоох;

37.1.7.шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэх хүсэлтийг Шүүхийн сахилгын, шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг талаар дүгнэлт гаргуулах хүсэлтийг Мэргэшлийн хороонд тус тус гаргах;

37.1.8.хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах, шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох;

37.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

37.2.Энэ хуулийн 37.1.3, 37.1.4 дэх заалт нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд үл хамаарна.

38 дугаар зүйл.Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

38.1.Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүн нь шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

38.1.1.танхимыг тэргүүлж танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг удирдан зохицуулах;

38.1.2.танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр дүүргийн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

38.1.3.танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

38.1.4.хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах, шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох;

38.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

38.2.Энэ хуулийн 38.1.2.дахь заалт нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд үл хамаарна

39 дүгээр зүйл. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

39.1.Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

39.1.1.шүүхийг тэргүүлж, түүнийг төлөөлөх;

39.1.2.шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг удирдан зохицуулах;

39.1.3.шүүгчийн шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтийн хугацааны байдалд хяналт тавих;

39.1.4.хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах, шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох;

39.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

40 дүгээр зүйл. Дагнасан шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн бүрэн эрх

40.1.Дагнасан шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч энэ хуульд заасан адил шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн бүрэн эрх, түүнчлэн хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

41 дүгээр зүйл.Шүүгчийн давтан сургалт

41.1.Бүх шатны шүүхийн шүүгч жил тутам 14 хоногоос доошгүй хугацаагаар мэргэшлээ дээшлүүлж, давтан сургалтад хамрагдах эрхтэй.

41.2.Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг Ерөнхий зөвлөл зохион байгуулна.

42 дугаар зүйл.Шүүгчийг сэлгэн ажиллуулах

42.1.Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийг шүүн таслах ажлын дадлага хэзээшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн боловсон хүчнийг оновчтой байршуулах зорилгоор адил шатны шүүхэд өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулж болно.

42.2.Улсын дээд шүүхийн шүүгчийг танхим хооронд нь Ерөнхий шүүгчийн шийдвэрээр сэлгэн ажиллуулж болно.

42.3.Энэ хуулийн 42.1-д зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

43 дугаар зүйл. Шүүгчийн тангараг, шүүгчийн өмсгөл

43.1.Шүүгч томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор "Шүүгч би аливаа хэрэг, маргааныг эвэхэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсыг чанд сахиж явахаа батлан тангарагласан. Хэрэв миний бие өргөсөн тангарагаасаа няцвал хуульд заасан хариуцлага хүлээхээ" гэж тангараг өргөнө.

43.2.Шүүгчийн тангараг өргөх ёслолыг нээлттэй явуулна.

43.3.Шүүгч өмсгөлтэй байна.

43.4.Шүүгчийн тангараг өргөх журам, шүүгчийн өмсгөлийн загвар, түүнийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

44 дүгээр зүйл.Шүүгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

44.1.Шүүгч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

44.1.1.албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд шүүгчийн хувьд оролцох;

44.1.2.ажил хаялт болон шүүхийн байгууллагын хэвийн үйл ажиллагаат алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

44.1.3.албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүйн үзлийн эсрэг үйлдэл хийхэд ашиглах;

44.1.4.албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас бэлэг, мөнгөн шагнал, шан харамж, хэлл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

44.1.5.албаны бус зорилгод шүүхийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглах;

44.1.6.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн болон бусад байгууллагад орон тооны болон орон тооны бус ажил албан тушаал хавсран гүйцэтгэх;

44.1.7.аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаар гардан эрхлэх, бусдад зуучлах;

44.1.8.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн нэгдлийн удирдах зөвлөлийн болон захирагааны гишүүн байх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Шүүхийн сахилгын хороо, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах

45 дугаар зүйл. Шүүгчийн ёс зүйн дүрэм

45.1.Монгол Улсын шүүхийн шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

45.2.Шүүгчийн ёс зүйн дүрмийг Шүүгчдийн зөвлөл батална.

45.3.Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

46 дугаар зүйл. Шүүхийн сахилгын хороо

46.1.Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх зөвлөл Шүүхийн сахилгын хороо /цаашид "Сахилгын хороо" гэх/ нь улсын хэмжээнд нэг байна.

46.2.Сахилгын хороо 15 гишүүнтэй байна.

46.3.Сахилгын хорооны гишүүнд Улсын ерөнхий прокурор, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөлөөс тус бүр хоёр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төрүүлэгчийн хуралдаанаас тав, Шүүгчдийн зөвлөл бүх шатны шүүхээс тус бүр хоёр хүний нэрийг дэвшүүлнэ.

46.4.Сахилгын хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална.

46.5.Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.

46.6. Сахилгын хорооны гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

46.7.Сахилгын хорооны даргыг хорооны гишүүдийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.

46.8.Сахилгын хороо нь орон тооны ажлын албатай байна. Сахилгын хорооны ажлын алба нь Ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдана.

47 дугаар зүйл.Сахилгын хорооны дарга, гишүүний эрх

47.1.Сахилгын хорооны гишүүн дараахь эрхтэй:

47.1.1.гомдол, хүсэлтийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүгээхээс татгалзах;

47.1.2.сахилгын хэргийг шалгаж шийдвэрлэхэд шаардлагатай ажиллагаа явуулах ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;

47.1.3.Сахилгын хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох.

47.2.Сахилгын хорооны дарга Сахилгын хорооны гишүүний эрхээс гадна дараахь эрхтэй:

47.2.1. Сахилгын хорооны хуралдааныг даргалах;

47.2.2. хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнийг томилох;

47.2.3. Сахилгын хорооны ажлын албыг удирдах;

47.2.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

48 дугаар зүйл.Сахилгын хорооны ажлын албаны эрх, үүрэг

48.1.Сахилгын хорооны ажлын алба дараахь эрх, үүрэгтэй :

48.1.1.гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, харьяаллын дагуу гомдол, хүсэлтийг Сахилгын хорооны гишүүнд танилцуулсны үндсэн дээр бүцаах;

48.1.2.Сахилгын хорооны дарга, гишүүний даалгасанаар гомдол, хүсэлтийг шалгах ажиллагаагаг явуулах;

48.1.3.Сахилгын хороо, түүний гишүүдэд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.

48.1.4.Сахилгын хорооны хэвийн үйл ажиллагаа ба хуралдааны бэлтгэлийг хангах, шийдвэрийг баримтжуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

49 дүгээр зүйл. Сахилгын хэрэг үүсгэх эрх

49.1.Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд гомдол, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч хүсэлт гаргах эрхтэй.

49.2.Гомдол, хүсэлт гаргасан этгээд уг гомдол, хүсэлтээ бүцаан авах эрхтэй.

49.3.Гомдол, хүсэлт бүрийг Сахилгын хороны ажлын алба хянан үзнэ.

50 дугаар зүйл. Сахилгын хэрэг үүсгэх

50.1.Сахилгын хэргийг Сахилгын хорооны гишүүн үүсгэнэ.

50.2.Сахилгын хорооны гишүүн гомдол,

хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх үндэслэлтэй эсэхийг хянаж сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана.

51 дүгээр зүйл. Сахилгын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн

51.1.Сахилгын хороо сахилгын хэргийг анхан шатны журмаар гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр олонхийн саналаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана.

51.2.Сахилгын хорооны тогтоолыг давж заалдсан гомдлыг Сахилгын хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хэлэлцэн хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж магадлал гаргана.

52 дугаар зүйл. Сахилгын хэргийг шалгаж шийдвэрлэх болон давж заалдах гомдол гаргах хугацаа

52.1.Сахилгын хэргийг үүсгэснээс хойш 30 хоногийн дотор анхан шатны журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

52.2. Гомдол, хүсэлт гаргасан этгээд, эсхүл сахилгын арга хэмжээ авагдсан шүүгч анхан шатны журмаар сахилгын хэргийг хэлэлцэн шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш арав хоногийн дотор гомдол гаргах эрхтэй.

52.3.Сахилгын хороо давж заалдах гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.
52.4.Сахилгын хэрэг үүсгүүлсэн шүүгч сахилгын хорооны хуралдаанд биечлэн оролцох эрхтэй.

52.5.ССахилгын хэрэг үүсгүүлсэн шүүгч хэргийг шалгах явцад болон Сахилгын хорооны хуралдаанд тайлбар гаргана.

53 дугаар зүйл. Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл

53.1.Сахилгын шийтгэлийг дараахь үндэслэлээр оногдуулна:

53.1.1.шүүгч энэ хуулийн 34.3, 44 дүгээр зүйлд заасан хориглосон ажил, албан тушаалыг эрхэлсэн, эсхүл үйл ажилагаа явуулсан;

53.1.2.Шүүгчийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээ зөрчсөн;

53.2.Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон байна.

54 дүгээр зүйл. Сахилгын шийтгэлийн төрөл

54.1.Сахилгын хороо шүүгчийн гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулна:

54.1.1.тухайн шүүхийн шүүгчдийн өмнө сануулах;

54.1.2.шүүгчийн зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах;

54.1.3.шүүгчээс огцруулах санал гаргах.

54.2.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гарсанаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй.

55 дугаар зүйл. Сахилгын хорооны шийдвэр

55.1.Сахилгын хороо сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

55.1.1.сахилгын шийтгэл оногдуулах;
55.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

55.1.3.шүүгчид эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

55.2.Сахилгын хорооны тогтоолыг гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэгт холбогдсон шүүгчид хүргүүлнэ.

55.3.Сахилгын хороо давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

55.3.1.давж заалдах гомдлыг хангахгүй орхиж Сахилгын хорооны тогтоолыг хэвээр үлдээх;

55.3.2. анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

55.3.3.анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолын зарим хэсгийг хүчингүй болгож бусад хэсгийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

55.3.4.Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, сахилгын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх;

55.3.5.Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон шүүгчийг цагаатгах.

55.4.Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлал эцсийнх байна.

56 дугаар зүйл. Сахилгын шийтгэлгүйд тооцох

56.1.Шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

57 дугаар зүйл. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх

57.1.Шүүгч дараахь үндэслэлээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар шүүн таслах ажил эрхлэх боломжгүй бол бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ:

57.1.1. эрдэм шинжилгээний бүтээл туурвих, эрдмийн цол, зэрэг хамгаалах;

57.1.2.удаан хугацааны сургалтад хамрагдах;

57.1.3.удаан хугацаагаар өвчлөх, гачигдал гарах;

57.1.4.цэргийн жинхэнэ албанд татагдах;

57.1.5.эрүүгийн хариуцлагад татагдах.

57.2.Энэ хуулийн 57.1.4, 57.1.5-д заасан үндэслэлээр Ерөнхийлөгч, энэ хуулийн 57.1.1- 57.1.3-т заасан үндэслэлээр Ерөнхий зөвлөл тус тус шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ.

57.3.Шүүгч энэ хуулийн 57.1.1- 57.1.3-т заасан үндэслэлээр гурван сар хүртэл хугацаагаар шүүн таслах ажил эрхлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгч чөлөө олгож болно.

58 дугаар зүйл. Шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл

58.1.Шүүгчийг дараахь үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлнө:

58.1.1.өөрөө хүсэлт гаргасан;

58.1.2.өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн өөр ажил, албан тушаалд сонгосон буюу томилсон;

58.1.3.биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

58.1.4.энэ хуулд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

58.1.5. ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийнх хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан.

58.2.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 58.1-д заасан үндэслэлээр шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчийг чөлөөлүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд урьдчилан танилцуулсан байна.

59 дүгээр зүйл. Шүүгчийг огцруулах

59.1.Шүүгчийг дараахь үндэслэлээр албан тушаалаас нь огцруулна:

59.1.1.шүүгчээс огцруулах тухай Сахилгын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон;

59.1.2.сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн;

59.1.3.шүүгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтэгх тогтоол хүчин төгөлдөр болсон.

59.2.Ерөнхий зөвлөл шүүгчийг албан тушаалаас нь огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчийг огцруулах тухай саналыг Улсын Их Хуралд урьдчилан танилцуулсан байна.

59.3.Ерөнхийлөгч шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх болон огцруулах тухай Ерөнхий зөвлөлийн саналыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор шийдвэрлэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Ерөнхий зөвлөл

60 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн чиг үүрэг

60.1.Ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага мөн.

60.2.Ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлнэ.

60.3.Ерөнхий зөвлөл соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

61 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа

61.1. Ерөнхий зөвлөл 12 гишүүнтэй байна.

61.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилсон тус бүр нэг хүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор албан тушаалаараа, Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон Улсын дээд шүүх аймаг, анхан шатны шүүхээс тус бүр хоёр нийслэлийн шүүхийн нэг шүүгч тус тус орно.

61.3.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд энэ хугацаа албан тушаалаараа Ерөнхий зөвлөлд орсон гишүүдэд үл хамаарна.

61.4.Ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байна.

61.5.Улсын Их Хурлаас томилогдох Ерөнхий зөвлөлийн гишүүнийг Улсын Их Хурлын дарга нэр дэвшүүлж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар томилно.

61.6.Ерөнхий зөвлөлийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, эсхүл хүндэтгэн үзэшгээнаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол томилогдсон гишүүнийг томилсон байгууллага бүх шатны шүүгч гишүүнийг Шүүгчдийн зөвлөл түүний чөлөө цагт Ерөнхий зөвлөлийн дарга хугацаанаас нь өмнө огцруулах, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

61.7.Ерөнхий зөвлөлийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн буюу огцорсон бол энэ хуулийн 61.6-д заасан журмын дагуу нөхөн томилно.

62 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх

62.1.Ерөнхий зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

62.1.1.зохих байгууллага, албан тушаалтантай зөвшилцөн Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршил, нутаг дэвсгэрийн харьяалалыг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

62.1.2.бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

62.1.3. шүүхийн төсвийг хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

62.1.4.шүүгчийг томилуулах, сэлгэн ажиллуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

62.1.5.шүүгчийг шилж сонгох, шалгаруулах, мэргэшлийг нь дээшлүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

62.1.6.шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг тогтоох, Мэргэшлийн хороог байгуулах;

62.1.7.шүүгч, шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төрийн дээд шагналд тодорхойлох, шүүхийн шагналын журам тогтоох;

62.1.8.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргыг томилж, чөлөөлөх;

62.1.9.тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор шүүхийн тамгын газар, хэлтсийн даргыг томилох, чөлөөлөх;

62.1.10.хууль тогтоомжийн дагуу шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын зэрэг дэвийн болон бусад нэмэгдэл тогтоох;

62.1.11.Ерөнхий зөвлөлийн ажлын албаны болон шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны ажилтан, түүнчлэн шүүгчийн туслахын орон тоог тогтоох;

62.1.12.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

62.2. Ерөнхий зөвлөл ажлын албатай байх ба түүний зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажиллах журмыг өөрөө тогтооно.

63 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн хуралдаан

63.1.Ерөнхий зөвлөл бүрэн эрхээ хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлнэ.

63.2.Ерөнхий зөвлөлийн хуралдааныг хоёр сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд Ерөнхий зөвлөлийн даргын саналаар ээлжит бус хуралдааныг явуулна.

63.3.Ерөнхий зөвлөлийн хуралдаан гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ирснээр хүчинтэйд тооцогдох бөгөөд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

63.4.Ерөнхий зөвлөлийн тогтоолд дарга, гүйцэтгэх нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тамга дарна.

63.5.Ерөнхий зөвлөл хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

64 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх

64.1.Ерөнхий зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1.Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

64.1.2.Ерөнхий зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

64.1.3.Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангуулах;

64.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

65 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх

65.1.Ерөнхий зөвлөлийн дарга Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

65.1.1.Ерөнхий зөвлөлийг тэргүүлж, түүнийг төлөөлөх;

65.1.2.Ерөнхий зөвлөлийн хуралдааныг товлох, даргалах;

65.1.3.Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

65.1.4.Сахилгын хорооны ажлын албаны ажилтныг Сахилгын хорооны даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;

65.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

65.2. Ерөнхий зөвлөлийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргана.

66 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх

66.1.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

66.1.1.Ерөнхий зөвлөлийн ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;

66.1.2.Ерөнхий зөвлөлийн ажлын албаны ажилтныг Ерөнхий зөвлөлийн даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;

66.1.3.шүүхийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвиг холбогдох журмын дагуу тогтоох;

66.1.4.Ерөнхий зөвлөлийн төсвийг захиран зарцуулах;

66.1.5.Ерөнхий зөвлөлийн хуралдааны бэлтгэл, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

66.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

66.2.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, шүүхийн ажлын дадлага туршлагатай, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

66.3.Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг Ерөнхий зөвлөлийн даргын санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

66.4.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь орон тооны байх бөгөөд Ерөнхий зөвлөл, аймаг, нийслэлийн шүүхийн тамгын хэлтсийн үйл ажиллагаг уялдуулан зохицуулна.

66.5.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана.

66.6.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлд хариуцан тайлагнана.

67 дугаар зүйл. Шүүгчдийн зөвлөл

67.1.Улсын дээд шүүхийн шүүгч, аймаг, нийслэл, дагнасан шүүхийн Ерөнхий шүүгчдээс бүрдсэн Шүүгчдийн зөвлөл ажиллана.

67.2.Шүүгчдийн зөвлөл нь жил тутам хуралдана.

67.3.Шүүгчдийн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

67.3.1.Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах;

67.3.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох;

67.3.3.Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох;

67.3.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох;

67.3.5.хуралдааныхаа дэгийг тогтоох;

67.3.6.хууль тогтоомжийн боловсронгуй болгох талаар санал гаргах.

67.4.Шүүгчдийн зөвлөлийн хуралдаан гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцогдох бөгөөд хэлэлцэх асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ.

68 дугаар зүйл.Шүүгчдийн зөвлөлгөөн

68.1.Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлгөөн /цаашид "Шүүгчдийн зөвлөлгөөн" гэх/ ажиллана.

68.2.Шүүгчдийн зөвлөлгөөнийг жил, хоёроос доошгүй удаа хийлгэнэ. Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл шүүгчдийн олонхийн саналаар зөвлөгөөнийг зарлан хийлгэх болно.

68.3.Шүүгчдийн зөвлөлгөөнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч товлон зарлаж, удирдан хуралдуулна.

68.4.Шүүгчдийн зөвлөлгөөн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.4.1.хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаанд даргалагчийг томилох хугацаатай тогтоох;

68.4.2.төр эзгүй шүүгчийн ажлыг хуваарилах;

68.4.3.шүүх хуралдаанд оролцогчдын иргэдийн төлөөлөгчийг сонгогчдын нэрсий

жагсаалтаас сонгон авах журмыг тогтоох;

68.4.4.тухайн шүүхийн шүүн таслах ажиллагааны үр дүн, тамгын газар, хэлтэс, албаны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

68.4.5.тухайн шатны Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх;

68.4.6.тухайн шүүхийн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргуулахаар Мэргэшлийн хороонд шилжүүлэх;

68.4.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

68.5.Шүүгчдийн зөвлөлгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Шүүхийн тамгын газар, хэлтэс, түүний ажилтан

69 дүгээр зүйл. Шүүхийн тамгын газар, хэлтэс

69.1.Улсын дээд шүүхэд тамгын газар, аймаг, нийслэлийн шүүх болон дагнасан шүүхэд тамгын хэлтэс, сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд тамгын алба, эсхүл тамгын хэлтсийн төлөөлөгч тус тус ажиллана.

69.2.Улсын дээд шүүхийн Тамгын газар, Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс нь үйл ажиллагааныхаа чиглэлээр албатай байж болно.

69.3.Шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны журмыг Ерөнхий зөвлөл тогтооно.

69.4.Шүүхийн тамгын газар, хэлтэс нь тухайн шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

69.5.Шүүхийн тамгын газар, хэлтэс, алба нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

69.5.1.шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах;

69.5.2.шүүхэд ирсэн хэргийг бүртгэх, шүүхийн шийдвэр болон мэдэгдэх, гүйцэтгэх хуудсыг холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлэх;

69.5.3.иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих;

69.5.4.шүүхийн статистик мэдээг гаргаж, шүүхийн практикийг судлах;

69.5.5.шүүгчийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;

69.5.6.шүүхийн төсөв, санхүүгийн асуудлыг хариуцах;

69.5.7.шүүхийн гадаад харилцааны асуудлыг хариуцах;

69.5.8. шүүхийн аж ахуйн үйл ажиллагаат хөтлөн явуулах;

69.5.9.шүүхийн техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаат хангах;

69.5.10.шүүхийн хэрэг, материал, архив, албан бичиг баримтыг хадгалах, хамгаалах, хэрэглэх журмыг тогтоох;

69.5.11.шүүхийн өдөр тутмын үйл ажиллагаат хэвийн явуулах нөхцлөөр хангах.

70 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын бүрэн эрх

70.1.Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

70.1.1.Улсын дээд шүүхийн Тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаат удирдан зохион байгуулах;

70.1.2.Улсын дээд шүүхийн Тамгын газрын болон Судалгааны төвийн ажилтныг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн томилж, чөлөөлөх;

70.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчийн туслахыг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн томилж, чөлөөлөх;

70.1.4.Улсын дээд шүүхийн төсвийг захиран зарцуулах;

70.1.5. хууль ёсаасан бусад бүрэн эрх.

70.2.Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

70.3.Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргыг Ерөнхий шүүгч, шүүгч орлох эрхгүй.

71 дүгээр зүйл.Тамгын хэлтсийн даргын бүрэн эрх

71.1.Аймаг, нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

71.1.1.тамгын хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

71.1.2.тамгын хэлтсийн ажилтныг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;

71.1.3.аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийн туслахыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;

71.1.4.тухайн шүүхийн төсвийг захиран зарцуулах;

71.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

71.2.Тамгын хэлтсийн дарга үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

71.3.Тамгын хэлтсийн даргыг Ерөнхий шүүгч, шүүгч орлохгүй.

72 дугаар зүйл.Судалгааны төв

72.1.Улсын дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад эрх зүйн онол, практикийн асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик, практикийг нэгтгэн судалж санал дүгнэлт гаргах үүрэг бүхий судалгааны төв ажиллана.

72.2.Судалгааны төвийн судлаачид мэргэшсэн байна.

73 дугаар зүйл. Шүүгчийн туслах

73.1. Бүх шатны шүүх шүүгчийн туслахтай байна.

73.2.Шүүгчийн туслах нь шүүгчээс шүүн таслах ажиллагаанд хэрэгжүүлэхэд шаардлагатай дараахь туслалцааг үзүүлнэ:

73.2.1.хэрэг, маргааны талаар судалгаа хийж танилцуулах;

73.2.2.техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

73.2.3.хуульд заасан бусад үүрэг.

73.3.Шүүгчийн туслах нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй Монгол Улсын иргэн байна.

74 дүгээр зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

74.1.Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллана.

74.2.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй Монгол Улсын иргэн байна.

75 дугаар зүйл. Шүүхийн хуяг, цагдаа, бичиг хүргэгч

75.1.Шүүх хуралдааны дэг журмыг сахиулах, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шүүх хуралдааны оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудлагаар ирэхгүй байгаа шүүгдэгч, гэрч, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, зохигчийг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

75.2.Шүүн таслах ажиллагаатай холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгч тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цагдаагийн байгууллага хариуцна.

75.3.Шүүхийн хуяг нь шүүх хуралдааны аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй цагдаагийн байгууллагын ажилтан байна.

75.4.Шүүхийн хуягийн ажиллах журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

75.5.Шүүхийн бичиг хүргэгч нь шүүхийн мэдэгдэх хуудас, зарлан дуудах хуудас болон хэрэг, бусад баримт бичиг хүргэх үүрэгтэй тамгын газар, хэлтсийн ажилтан мөн.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа

76 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс үл нөлөөлөх

76.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

77 дугаар зүйл. Шүүгчийн улс төрийн эрх

77.1.Шүүгч өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мэргэшлээ дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор мэргэжлийн олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх эдэлнэ.

77.2.Шүүгч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

77.3.Шүүх, шүүхийн байгууллагад улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

77.4.Шүүгч албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнээс түдгэлзэнэ.

77.5.Шүүгч Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр оролцох тохиолдолд албан тушаалаасаа чөлөөлөгдөх бөгөөс жилийн хугацаанд шүүгчийн албан тушаалд дахин томилогдох эрхгүй.

78 дугаар зүйл. Шүүгчийн халдашгүй байдал

78.1.Шүүгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

78.2.Шүүгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан буюу эрүүгийн хариуцлагад татах хангалттай үндэслэл тогтоогдсон бол энэ тухай Ерөнхий зөвлөлд 48 цагийн дотор мэдэгдэнэ.

78.3.Шүүгчийг эрүүгийн хариуцлагад татах хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл зөвшөөрөл авах хүсэлтийг Ерөнхий зөвлөл тав хоногийн дотор Ерөнхийлөгчид гаргана.

78.4.Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн хүсэлтийг хүлээн аваад шүүгчийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг арав хоногийн дотор шийдвэрлэнэ.

78.5.Шүүгчийг цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийх шаардлагатай бол энэ хуулийн 78.2.-78.4-д заасан журмын дагуу зөвшөөрөл авна.

79 дүгээр зүйл.Шүүгчийг өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглох

79.1.Хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

79.2.Шүүгчид хуулиар хүлээлгэсэн үүргээ нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

80 дугаар зүйл. Шүүгчийн цалин хөлс

80.1.Шүүгчийн цалин хөлс нь шүүгчийн албан тушаалын цалин болон шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.

80.2.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалын цалин Ерөнхий сайдын албан тушаалын цалинтай адил хэмжээтэй байна.

80.3.Бусад шүүгчийн албан тушаалын цалинг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалын цалинтай зохист харьцаатай хувиар тооцож тогтооно.

80.4.Шүүгчийн албан тушаалын цалин , нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

81 дүгээр зүйл.Шүүгчийн ээлжийн амралт

81.1.Шүүгчийн ээлжийн үндсэн амралтын хугацаа[2] Хөдөлмөрийн тухай хуулиар, нэмэгдэл амралтыг Хөдөлмөрийн тухай болон энэ хуулиар тус тус тогтоно.

81.2.Шүүгчээр ажилласан таван жил тутам ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.

81.3.Шүүгч ээлжийн амралтаараа байнга оршин суудаг газраасаа дотоодын амралт, сувиллын газарт ирэх, очих замын зардлыг түүнд хоёр жил тутам нэг удаа шүүхийн төсвөөс олгоно.

82 дугаар зүйл.Шүүгчийг албан дайчилгаанаас чөлөөлөх

82.1.Шүүгч албан татвараас бусад улс, орон нутгийн албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

83 дугаар зүйл. Шүүгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн баталгаа

83.1.Шүүгч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал, өвчтэй, эсхүл тахир дутуу болсон тохиолдолд түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно.

83.2.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүгчийн бие махбодид гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн

2 Хөдөлмөрийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд шүүгчид тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадварыг түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгоно.

83.3.Энэ хуулийн 83.2-т заасан шалтгаанаар хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг шүүхийн төсвөөс олгоно.

83.4.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүгчийн амь насыг хохироосон бол ар гэрт нь түүний гурван жилийн цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

83.5.Энэ хуулийн 83.2- 83.4-т заасан тэтгэвэр, тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг шүүхийн төсвөөс олгож, хуульд заасан тохиолдолд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

84 дүгээр зүйл. Шүүгчид тэтгэвэр тогтоох

84.1.Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 60 нас байна.

84.2.Тавин таван насанд хүрсэн эмэгтэй шүүгч өөрөө хүсвэл тэтгэвэрээ тогоолгож болно.

84.3.Шүүгчийг тэтгэвэрт гарахад албан тушаалынх нь 24 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

85 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн баталгаа

85.1.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дараахь баталгаагаар хангагдана:

85.1.1. бие, нэр төр, уналга, орон сууц халдашгүй дархан байх;

85.1.2.албан ёсны болон ажлын айлчлал, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлэх;

85.1.3.гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдлэх;

85.1.4.орон сууцны хөлсийг шүүхийн төсвөөс санхүүжүүлэх.

85.2.Улсын дээд шүүхийн шүүгч дараахь баталгаагаар хангагдана:

85.2.1.төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохируулан Улсын Их Хурлаас тогтоосон цалин хөлс, зайлшгүй шаардлагатай бусад хангамжтай байх;

85.2.2.энэ хуулийн 85.1.3-д заасан эрх эдлэх.

86 дугаар зүйл.Бусад баталгаа

86.1.Төрийн захиргааны болон бусад байгуулага шүүхийг байнга болон нүүдэлпэн ажилладаг байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, шүүгчийг орон байраар хангах зэрэг шүүх, шүүгч үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

86.2.Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж шүүгчид аминдаа орон сууц барих, өөрийн хүсэлтээр суралцахад нь зориулан төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгааг зохих журмын дагуу гаргаж өгнө.

86.3.Шүүгч Төрийн албаны тухай хуулийн тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана.

86.4.Шүүгчид энэ хуулийн 86.2-т заасан баталгааг эдлүүлэхдээ ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдлийг давхардуулж олгохгүй бөгөөд сонголтыг өөрөө хийнэ.

86.5.Шүүн таслах ажиллагааны явцад шүүгчийн гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.

86.6.Шүүгч өөрийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд шууд тулгарсан гэмт халдлагын аюулаас хамгаалахын тулд бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.

87 дугаар зүйл. Шүүхийг үл хүндэтгэгчийг хүлээлгэх хариуцлага

87.1.Шүүхийг үл хүндэтгэгчид хууль тогтоомжийн заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

88 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

88.1.Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4–ний өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Прокурорын байгууллагын тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/Улсын ерөнхий прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба байгуулагдсантай холбогдуулан тус албанд ажиллах мөрдөн байцаагчдыг орон тоо, төсөв, эд хөрөнгө, техник хэрэгслийн хамт 2002 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Цагдаагийн байгууллагаас Улсын ерөнхий прокурорын мэдэлд шилжүүлэх;

2/Эрүүгийн хэргийн улсын нэгдсэн архив, түүний салбар нэгжийн хэвийн ажиллагааг хангахад шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 5–ны өдөр | Дугаар 92 | Улаанбаатар хот

Цэндийн Батчулуунд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, морин хуурыг чадамгай эзэмшин тоглож, морин хуурын чуулгыг зохион байгуулах, бэжүүлэх, урын санг баяжүүлах, гадаад, дотоодын хөгжмийн зохиолчдын бүтээлүүдийг удирдан тоглуулах, монгол ардын урлагийг хөгжүүлэх үйлст оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж улсын филармонийн "Морин хуур" чуулгын уран сайхны удирдагч Цэндийн Батчулуунд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 5–ны өдөр | Дугаар 93 | Улаанбаатар хот

Гонийн Лхагважавт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай улсад эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах албыг бие даалган зохион байгуулж хөгжүүлэх, эмчилгээ үйлчилгээний дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэн олон мянган хүнийг эмчлэн эдгэрүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны их сургуулийн мэс заслын тэнхмийн багш Гонийн Лхагважавт Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 5–ны өдөр | Дугаар 94 | Улаанбаатар хот

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, шинжлэх ухаан, биеийн тамир спорт болон төрийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, улс орноо хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛООР:

Мягмарын Энхболд - Дархан-Уул аймгийн үйлдвэрлэл үйлчилгээний "Өргөө-Од" ХХК-ийн үйлдвэрийн захирал

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛООР:

Янжингийн Шархүү - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн зөвлөх архитектор

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛООР:

Рагчаагийн Оюунсүрэн - Нийслэлийн усны хайгуул, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний "Оюунбадрах" ХХК-ийн захирал

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛООР:

Сэрэнэнгийн Галсан - "Хэл судлаач" дээд сургуулийн захирал

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛООР:

Очирхүүгийн Бадамцэрэн - Клиникийн 3 дугаар эмнэлгийн зүрхний мэс заслын эмч

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛООР:

Лайхансүрэнгийн Лхасүрэн - Соёл урлагийн их сургуулийн багш

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР:

Санжийн Пүрэв - Монголын радиогийн урлаг, соёлын албаны дарга

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ЦОЛООР:

Наваанпэрэнлэйн Жанцан - Үндсэн хуулийн цэцийн дарга

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР:

Дэмбэрэлийн Дашзэвэг - ШУА-ийн Палеонтологийн төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ТАМИРЧИН ЦОЛООР:

Цэдэндамбын Баярсайхан - Улаанбаатар төмөр замын дэргэдэх бөхийн "Есөн туг" клубийн захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 95** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, байгаль орчин, биеийн тамир спорт, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дуламын Амарсанаа - Өвөрхангай аймгийн Хархорин сумын 2 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш
2. Моёобуугийн Булган - Хөгжим бүжгийн коллежийн удирдах ур зүйн багш
3. Рагчаагийн Бямбаа - "Монголэмимпекс" концернийн захирал
4. Дүлээнгийн Ламжав - Худалдаа, үйлчилгээний "Иттэлт хүлэг" ХХК-ийн Хөвсгөл аймаг дахь төлөөлөгч

5. Бэгзийн Очирбат - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга
6. Лодойдамбын Цэрэнбат - Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны Буянт-Ухаа боомт дахь Улсын байцаагч

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Донидын Алтангэрэл - Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хянан шалгах албаны дарга
2. Гомбодоржийн Алтанцэцэг - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын статистикийн товчооны мэргэжилтэн
3. Чүлтэмийн Арилдий - Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны мал үржлийн хяналтын улсын ерөнхий байцаагч
4. Аятханы Атай - Баян-Өлгий аймаг дахь Монгол Алтайн нуруувы улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны дарга
5. Галсангийн Баасан - Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга
6. Ванчинбазарын Бадамцоо - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч
7. Пүрэвийн Балдорж - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний “Дүүхээ” ХХК-ийн захирал
8. Лхагважавын Банди - Завхан айгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчны албаны дарга
9. Намбарын Бархас - “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн реле хамгаалалт, хэмжилт туршилтын албаны дарга
10. Мазаагийн Батаа - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч
11. Дамдингийн Батнасан - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
12. Жандавын Бат-Орших - “Монгол даатгал” компанийн тэргүүн дэд захирал
13. Чимэдийн Баттогтох - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт шалгалтын газрын дарга
14. Даньдайн Батчулуун - Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын газар зохион байгуулагч
15. Цанжидын Буриад - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны ахлах мэргэжилтэн
16. Алагаагийн Буянбэлгэр - Баянхонгор аймгийн “Эм хангамж” компанийн захирал
17. Даваагийн Буянням - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч
18. Цэрэндоржийн Бямбаа - Нийслэлийн авто замын “Ялгуусан” ХХК-ийн Асфальтобетон заводын найруулагч
19. Санжсүрэнгийн Вандансүрэн - Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын статистикч их эмч
20. Шархүүгийн Ганболд - “МИАТ” компанийн нислэгийн хэлтсийн В-727 онгоцны II нисгэгч
21. Намхайжавын Ганболд - Төв аймгийн Алтанбулаг сумын дунд сургуулийн захирал
22. Лувсандоржийн Гантөмөр - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч
23. Галсангийн Гаравсүрэн - Булган аймгийн Хутаг сумын “ Гурван борхууд” ХХК-ийн дэд захирал
24. Лэгшидийн Гомбожав - Улаанбаатар банкны Сонгинохайрхан дүүрэг дэх салбарын эрхлэгч
25. Дашдамбын Гунгаа - Баянхонгор аймгийн “Шаргалжуут” рашаан сувиллын их эмч
26. Дэмчигийн Гуррагчаа - Булган аймгийн Дашинчилэн сум дахь радио-релейний цехийн дарга
27. Долгорын Дагиймаа - Байгалийн түүхийн музейн чимэглэлийн мастер
28. Цэндийн Далай - ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн багш
29. Даньдиагийн Дамбийжав - Увс аймгийн Улаангом сумын 3 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
30. Долгорын Дамбийжанцан - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын орлогч
31. Далхаасүрэнгийн Дашдэндэв - ХААИС-ийн химийн тэнхмийн багш
32. Долгоржавын Дашзэвэг - МУИС-ийн биеийн тамирын тэнхмийн ахлах багш
33. Өлзийбилэгийн Долгорсүрэн - Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
34. Дэмидийн Дондогмаа - Монголын үндэсний телевизийн редактор
35. Лхамсүрэнгийн Ёндон - “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн харяа Говьсүмбэр аймаг дахь салбарын ахлах инженер
36. Цэвээгийн Жавзал - Нийслэлийн үйлдвэр, худалдааны “Өлзийт төв” ХХК-ийн дэд захирал
37. Пүрэвийн Жавзанрагчаа - Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч
38. Солийн Жагдал - Нийслэлийн Боловсролын газрын арга зүйч
39. Хавчигийн Идэш - Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч
40. Бат-Очирын Инчинхорлоо - Ховд аймгийн Жаргалант сумын иргэн, ахмад тэвэрчин
41. Батын Ишжамц - Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч

42. Даваажавын Лхагваолгор - Улсын клиникийн төв эмнэлгийн нүд судлалын клиникийн тасгийн эрхлэгч, их эмч
43. Бат-Очирын Лхагвасүрэн - Нийслэлийн ОСНАА-н "Баруун Сэлбэ-Өргөө" компанийн захирал
44. Маргарита Николаевна Григорьева - Хөгжим бүжгийн коллежийн төгөлдөр хуурын багш
45. Утхааны Мархавай - Нийслэлийн Налайх дүүргийн дулааны станцын засварын мастер
46. Шаравын Мөнхөө - Дархан-Уул аймаг дахь "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Дархан-Сэлэнгийн салбарын инженер
47. Ланжмаагийн Мэндсайхан - Үндэсний архивын газрын судалгаа, арга зүй, хяналтын хэлтсийн дарга
48. Хасбаатарын Мэргэн - Монголын үндэсний телевизийн редактор-орчуулагч
49. Дарамын Мягмаржав - Дархан-Уул аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч
50. Сэрээнэнгийн Намид - Хэнтий аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын халдвар судлагч, их эмч
51. Нямын Нармандах - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спорт сургалтын төвийн дасгалжуулагч
52. Ишдоржийн Одончимэг - "Хан гурвалжин" продакшны "Гурвалжин" театрын жүжигчин
53. Дамбадаржаагийн Онон - Төв аймгийн Сэргэлэн сумын малчин, Монгол Улсын манлай уяач
54. Түвдэнгийн Орших - Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн, санхүү, банкны ахмад ажилтан
55. Доржийн Отгон - Монгол Улсын их Хурлын тамгын газрын ажилтан
56. Увшнасангийн Очирбат - Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн, биеийн тамир спортын ахмад ажилтан
57. Сумьяагийн Оюунбилэг - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Номун далай" цогцолбор сургуулийн биологийн багш
58. Үл-Олдохын Пүрэвсүрэн - "Тушиг даатгал" ХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын захирал
59. Цэвэлийн Равданжамц - Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч
60. Тогтохын Сандуйжав - Нийслэлийн Налайх дүүргийн иргэн, санхүүгийн ахмад ажилтан
61. Намсрайцэрэнгийн Санжаадорж - Монголын морин спорт, уяачдын холбооны Хэнтий аймаг дахь салбарын тэргүүн
62. Даваажанцангийн Сарангэрэл - Монголын Үндэсний телевизийн редактор
63. Дагвын Сарантуяа - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн секторын эрхлэгч
64. Оригийн Сүхбаатар - Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
65. Авирын Сүхдорж - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "БСБ сервис" ХХК-ийн ерөнхий захирал
66. Дамдиндоржийн Сэрээтэр - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Наранбилэг" ХХК-ийн захирал
67. Цэдэнгийн Төвшинтөгс - Хүүхдийн "Сэлбэ" зуслангийн захирал
68. Чадраабалын Тунгалаг - Хөгжим бүжгийн коллежийн мэргэжлийн төгөлдөр хуурын багш
69. Сагалтайн Түсивихын - ШУА-ийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм, эдийн засгийн судалгааны төвийн секторын эрхлэгч
70. Намнангийн Хүрлээ - Төрийн хяналт шалгах хорооны газрын дарга
71. Вандандоржийн Цолмон - "Монгол шуудан" компани /ТӨҮГ/-ийн дэд захирал
72. Дондовын Цэдэн-Иш - Өвөрхангай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах албаны зөвлөх мэргэжилтэн, их эмч
73. Даваасамбуугийн Цэдэнхүү - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний их эмч
74. Батаагийн Цэрэнбалжир - "Эрэл" ХХК-ийн Дархан-Уул аймаг дахь цементийн үйлдвэрийн дарга
75. Нямаагийн Цэрэндолгор - "Орхон" их сургуулийн соёл, хүмүүжил эрхэлсэн проректор
76. Даваажавын Цэрэннадмид - Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Нийтлэг үйлчилгээний газрын орлогч дарга
77. Рэвгийн Цэрэннадмид - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 41 дүгээр дүнд сургуулийн биологийн багш
78. Будын Цэцэгмаа - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйн газрын авто баазын хэсгийн дарга
79. Жамбалын Чинбат - Соёл, гоо сайхны монголын "Хатан эрдэнэ" төвийн тэргүүн
80. Намжилын Чинбат - Оюуны өмчийн газрын дарга
81. Норовын Чогдов - Монголын Үндэсний телевизийн явуулын станцын инженер
82. Доноорагчаагийн Чойжилсүрэн - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ханбилэг" ХХК-ийн захирал
83. Балдангийн Энхгэрэл - "Эрэл" ХХК-ийн дулаан, сантехник ашиглалтын албаны дарга
84. Аюурзанын Энхжав - Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн дарга
85. Батболдын Энхтувшин - ШУА-ийн дэд ерөнхийлөгч
86. Гунгаагийн Энхцэцэг - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
87. Нэргүйн Энхээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн дарга

88. Доржийн Эрдэмбилэг - Нийслэлийн "Гүүгүр" ХЭАА-н авто курсийн захирал
89. Дамдиндоржийн Эрдэнэбат - "Скайтель" ХХК-ийн ерөнхий захирал
90. Гомбодоржийн Эрдэнэчимэг - Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын гарын боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын улсын байцаагч
91. Оригийн Ягаанцэцэг - Монголын суугаа волейболын холбооны дасгалжуулагч багш
92. Жамбалын Янжваа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
93. Бямбын Янжиндулам - Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Баянгийн Алтангэрэл - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн жолооч
2. Сандагдоржийн Алтангэрэл - Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Дэлгэр интернэшнл" ХХК-ийн сантехникч
3. Лувсандашийн Амгалан - Нийслэлийн өмчийн харилцааны газрын ахлах мэргэжилтэн
4. Тэвдийн Аюуш - "МИАТ" компанийн агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын ерөнхий инженер
5. Лхаасайн Баасанжав - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ХК-ийн дулааны хянах хэмжүүр, автоматикийн цехийн дарга
6. Лхагважавын Балдан-Очир - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжлийн хяналтын улсын байцаагч
7. Норовын Балжинням - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн бульдозерийн механикч
8. Чойжилын Баянхангай - "МИАТ" компанийн тээвэр, тусгай үйлчилгээний авто баазын жолооч
9. Галсандоржийн Баярсайхан - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Эх мэнд" хувийн эмнэлгийн их эмч
10. Долгорын Баярсайхан - Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын хорооны сантехникийн засварчин
11. Тудэвийн Бид-Ялав - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
12. Мулцангийн Билгээ - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн дэд захирал
13. Жаргалын Болдбаатар - Нийслэлийн Багануур дүүргийн Гэгээрэл хөгжмийн төвийн арга зүйч
14. Зумүүгийн Бүжинлхам - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн ахлах инженер
15. Ишдоржийн Бямбасүрэн - Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Чулуут багийн бага эмч
16. Лувсандамдингийн Бямбасүрэн - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
17. Ичинхүүгийн Даваанямбуу - Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын байгаль орчин, газрын албаны ойн улсын байцаагч
18. Дамдинсүрэнгийн Дорж - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын малчин
19. Лодойн Дэрждэрэм - Хэнтий аймгийн Галшар сумын "Буянт Оргил булаг" хоршооны жолооч
20. Содовын Дүнжаа - Байгаль орчны сайдын нарийн бичгийн дарга
21. Гүрийн Дүшиг - Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч
22. Цэвэгмэдийн Жавзан - АУИС-ийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны коллежийн сувилахуйн багш
23. Лувсангийн Жанчивдорж - Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч
24. Сангийн Жаргалсайхан - Нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн "Баруун Сэлбэ-Өргөө" компанийн засварчин
25. Одонхүүгийн Жаргалдорж - Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн морин спортын төв клубийн дасгалжуулагч
26. Төмөрийн Замбалсүрэн - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Пума" ХХК-ийн өрөгч
27. Далхаагийн Ичинноров - "МИАТ" компанийн тээвэр, тусгай үйлчилгээний авто баазын жолооч
28. Жүржгийн Лүнжээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Дарьмандал" хувийн эмнэлгийн их эмч
29. Доржийн Ихгавасүрэн - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих, хамар, хоолойн их эмч
30. Банзарын Лхамжав - Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын Тамгын газрын хүн ам зүйн байцаагч
31. Сүрэнхүүгийн Мөнхдулам - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
32. Жамсрангийн Мөнх-Очир - Нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн "Баруун хүрээ Өргөө" компанийн ерөнхий инженер
33. Доржийн Һамжилмаа - Өвөрхангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн физик эмчилгээний их эмч

34. Навааны Намсрайжав - Нийслэлийн "Автобус-1" УҮГ-ын боловсон хүчний зааварлагч
35. Данзангийн Нямаа - Монголын радиогийн албаны дарга
36. Дашийн Орломжав - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Өлзийт төв" ХХК-ийн оёдлын мастер
37. Доржийн Оюунгэрэл - Нийслэлийн Баянзүрх дүүргийн цэцэрлэг, яслийн сувиллын 10 дугаар цогцолборын багa эмч
38. Алексейн Оюунчимэг - Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын Дамжуулах байгууламжийн радио телевизийн техникийн төвийн ерөнхий нягтлан бодогч
39. Лхамхүүгийн Пионер - Нийслэлийн Баянзүрх дүүргийн цэцэрлэг, яслийн сувиллын 10 дугаар цогцолборын хүмүүжүүлэгч багш
40. Дамбадаржаагийн Пүрэвжав - Өвөрхангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн байцаагч
41. Даваасүрэнгийн Пүрэвсүрэн - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ХК-ийн ерөнхий инженерийн орлогч
42. Суурийн Сангидаансүрэн - Өвөрхангай аймгийн Биеийн тамир, спортын хорооны дарга
43. Бямбагийн Саран - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Байгаль орчны хамгаалах албаны хяналтын улсын ахлах байцаагч
44. Баатарын Сугаржав - Биеийн тамир, спортын үндэсний төвийн кино операторч
45. Гончигсамбуугийн Сумьяа - Дундговь аймгийн Луус сумын хөдөө аж ахуйн цаг уурын харуулын ажиглагч
46. Намсрайжавын Сумьяа - "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн инженер
47. Шартолгойн Сүхээ - Увс аймгийн Дулааны станцын засварчин
48. Увэнтогийн Сэлэнгэ - МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн ахлах багш
49. Увшийн Сэнгээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр дунд сургуулийн зураг, хөдөлмөрийн багш
50. Доржпаламын Тайванбаяр - "МИАТ" компанийн Техникийн газрын ахлах инженер
51. Ухнайн Тогоосүрэн - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчны албаны улсын байцаагч
52. Сэнгээгийн Тунгалаг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 97 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш
53. Банзрагчийн Туяа - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн ахлах эдийн засагч
54. Цэвзгмидийн Хорлообаатар - Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны таримал үргамлын үр сортын хяналтын улсын ерөнхий байцаагч
55. Нордовын Цэцгээ - Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Мандах багийн багa эмч
56. Намжилын Цэрэндамба - Нийслэлийн "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн мастер
57. Гомбын Цэрэнчимэд - Нийслэлийн "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн слесарьч
58. Манжилын Цэлэй - Увс аймгийн "Хүнс-Увс" ХК-ийн нягтлан бодогч
59. Сурмаагийн Чойнэм - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 111 дүгээр дунд сургуулийн биеийн тамирын багш
60. Пүрэвжавын Чулуун - Хөвсгөл аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн механикч
61. Лувсандолгорын Шаравдорж - Нийслэлийн үйлдвэр, үйлчилгээний "Эн энд Кет инженеринг" ХХК-ийн мужаан
62. Шаравын Энхболд - "Багануур" ХК-ийн автосамосвалын операторч
63. Цэдэвийн Эрдэнэцэцэг - МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн багш
64. Лувсандамбын Эрдэнэчимэг - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Далай ван" дунд сургуулийн багa англи багш
65. Хандаагийн Эрдэнээ - Ховд аймгийн Манхан сумын Зэрэг гол багийн малчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эдвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 4 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (267)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай*
- *Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны наймдугаар сарын 9 №30 (267)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

423. Дотоодын цэргийн зарим албан хаагчдыг одон, медалиар шагнах тухай Дугаар 97 979
424. К.В. Тоцкийг Цэргийн гавьяаны одонгоор шагнах тухай Дугаар 98 980
425. Л. Магсаржаламыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай Дугаар 100 980
426. Зарим хүмүүсийг шүүгчээр томилох тухай Дугаар 101 980
427. Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 102 980
428. Нгуен Тхе Дакийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 105 981
429. Д. Сандаг-Очирт хошуучийн генерал цол хүртээх тухай Дугаар 108 981
430. Төмөрийн Санжаад Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай Дугаар 109 981
431. Шунуугийн Чулуунборд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 110 981
432. Сүхбаатар аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 111 981
433. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 112 983
434. Хандсүрэнгийн Оттонд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай Дугаар 113 984
435. Гэнэмаагийн Бизьяажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 114 984
436. Хайнзангийн Чимэдэд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 115 984
437. Дундговь аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 116 984

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

438. Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай Дугаар 101 986
439. Геологи, ул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 103 987

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Дотоодын цэргийн зарим албан хаагчдыг одон, медалиар шагнах тухай

Дотоодын цэргийн албанд олон жил үр йтэлтэй ажилласан,улсын онц чухал айгууламжуудын хамгаалалтыг найдвартай ангах, нийгмийн хэв журам сахиулах,гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Бандийн Билэгүү - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн орлогч дарга, дэд хурандаа

2. Жамьянгаравын Нэргүй - Дотоодын цэргийн 816 дугаар тусгай салбарын захирагч, дэд хурандаа
3. Даваажавын Сайнбаяр - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн ахлах офицер, хошууч
4. Тогиогийн Хүрэлбаатар - Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа
5. Сэртэвийн Эрдэнэбилэг - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн ахлах офицер, дэд хурандаа

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Лхамсүрэнгийн Баярдорж - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хүн эмнэлгийн албаны ерөнхий эмч, хошууч
2. Лувсандоржийн Болдбаатар - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн ахлах офицер, хошууч
3. Гэндэнгийн Ганзориг - Дотоодын цэргийн штабын ахлах офицер, дэд хурандаа
4. Дамбадаржаагийн Мөнхтайван - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн соёлын төвийн эрхлэгч, хошууч
5. Дашийн Очирдорж - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн харуул,ахлах ахлагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Цэрэндоржийн Лхасүрэн - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн сантехникийн слесарьч
2. Сулеймений Санитар - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн тогооч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 15–ны өдөр — **Улаанбаатар хот**

Дугаар 98

К.В. Тоцкийг Цэргийн гавьяаны одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөтгөн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Холбооны хилийн албаны захирал Константин Васильевич Тоцкийг Цэргийн гавьяаны одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 17–ны өдөр — **Улаанбаатар хот**

Дугаар 100

Л. Магсаржаламыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Лувсандагдан овогтой Магсаржаламыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 17–ны өдөр — **Улаанбаатар хот**

Дугаар 101

Зарим хүмүүсийг шүүгчээр томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16,"Шүүхийн тухай "хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг баримтлан,Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дашдорж овогтой Мөнхөөг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн,Дүндэв овогтой Цаян,Шарав овогтой Баттогтох нарыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 17–ны өдөр — **Улаанбаатар хот**

Дугаар 102

Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Тэрбиш овогтой Энхтуяаг Дорнод аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 105 Улаанбаатар хот

Нгуен Тхе Дакийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс,БНСУ-ын хоорондын найрамдалт харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Нгуен Тхе Дакийг "Найрамдал"медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 108 Улаанбаатар хот

Д. Сандаг-Очирт хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Цагдаагийн ерөнхий газрын дарга бөгөөд Дотоодын цэргийн дарга Данзангийн Сандаг-Очирт хошууч генерал цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 109 Улаанбаатар хот

Төмөрийн Санжаад Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж,хамт олноо чадварлаг зохион байгуулан,ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх,үйлдвэрлэлд шинэ техник,технологи нэвтрүүлэн, орон нутгийг нүүрсээр найдвартай хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Талын гол"ХК-ийн захирал Төмөрийн Санжаад Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 110 Улаанбаатар хот

Шунуугийн Чулуунборд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачилга,үр бүтээлтэй ажиллаж, сургалтын арга зүйг боловсронгуй болгох,сурагчдад гүн бат мэдлэг олгох,өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл"цогцолбор сургуулийн захирал Шунуугийн Чулуунборд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 111 Улаанбаатар хот

Сүхбаатар аймгийн зарим хүнийг одон,медалиар шагнах тухай

Сүхбаатар аймгийн үйлдвэрлэл,үйлчилгээ, боловсрол,эрүүл мэнд,төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгууллагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Моононгийн Бишхүү - Сүхбаатар аймгийн Мал эмнэлэг,ариун цэврийн лабораторийн бага эмч
2. Цэвэгийн Дондов - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын малчин
3. Нямаарикийн Мөнхөө - Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын малчин

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Гомбодоржийн Буянжаргал - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын барилга угсралтын "Шарга" ХХК-ийн захирал
2. Өлзийн Гомбодорж - Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын малчин
3. Дамбийн Даваажав - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Эрдэнэмандал" хийдийн тэргүүн ловон,захиргааны дарга
4. Доонэрэнгийн Дамбасүрэн - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн тасгийн дарга
5. Сэдэдийн Дорж - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын эрчим хүчний салбарын дарга
6. Мятавын Мижээ - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын"Мижарс" хувийн эмнэлгийн мэдрэлийн эмч
7. Цэндсүрэнгийн Онгуу - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын малчин,Монгол Улсын манлай уяач
8. Будээгийн Очирбат - Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
9. Балжирын Хүрэл - Сүхбаатар аймгийн Холбооны газрын инженер,эдийн засагч
10. Шинэншаравын Цэнд - ХААН банкны Сүхбаатар аймаг дахь салбарын Асгат сумын тооцооны төвийн нярав

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Марайсаны Алина - ХААН банкны Сүхбаатар аймгийн аймаг дахь салбарын эдийн засагч
2. Чойдорын Алтангэрэл - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Сүхбаатар-Эрчим"/ОНӨҮГ/ компанийн монтёрч
3. Давхайн Бавуудорж - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн даатгалын улсын байцаагч
4. Галсанзундуйн Бадам - Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хүн эмнэлгийн дүн буртгэгч бага эмч
5. Төгсийн Бажуудай - Сүхбаатар аймгийн Уулбаян сумын малчин
6. Дамдингийн Банзрагч - Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
7. Шанжийн Батаа - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын дунд сургуулийн зурагч,хөдөлмөрийн багш
8. Чүлтэмийн Батбэх - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын барилга угсралтын "Шарга"ХХК-ийн мужаан
9. Лхасүрэнгийн Батнацаг - Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг дарга
10. Самбуугийн Бооёо - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэрийн улсын байцаагч
11. Мөнх-Очирын Бурмаа - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш
12. Гомбосүрэнгийн Бүлтэн - Сүхбаатар аймгийн Ус, цаг уурын орчны шинжилгээний төвийн техникч
13. Нянгаагийн Бэгзсүрэн - Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын малчин
14. Гэндэнсүрэнгийн Ганхуяг - Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэгч,эрчимт эмчилгээний эмч
15. Дугаржавын Гэлгээ - Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга
16. Чойжилсүрэнгийн Зоригтбаатар - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Илч-Сүхбаатар" /ОНӨҮГ/ компанийн зуухны механикч
17. Лувсанбалжирын Зөвөө - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Өгөөмөр буян цацрах" хоршооны дарга
18. Зэнээгийн Зэмбэ - Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын орлогч
19. Цэен-Ойдовын Жамсранжав - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Үүдэн" хувийн эмнэлгийн уламжлалт эмчилгээний эмч
20. Бат-Өлзийн Лантуу - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Илч-Сүхбаатар" /ОНӨҮГ/ компанийн инженер
21. Лундэгсамбуугийн Лхагва - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын малчин
22. Лхамжавын Мөнгөө - Монголбанкны Сүхбаатар аймаг дахь салбарын нягтлан бодогч
23. Чүлтэмийн Оюунзул - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын цэцэрлэгүүдийн нэгдсэн ажахуйн нягтлан бодогч
24. Мичиджамбын Оюунчимэг - Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын эм хангамжийн"Баруун-

Урт"компанийн мэргэжилтэн
25. Дамдингийн Өргөнчимэг - Сүхбаатар аймгийн Шүүхийн жижүүр
26. Буянтын Пүрэвдорж - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын албаны авто тээврийн хяналтын улсын байцаагч
27. Цэдэнгийн Солонго - Сүхбаатар аймгийн Мал эмнэлэг,ариун цэврийн лабораторийн бага эмч
28. Базарсадын Сүхбаатар - Сүхбаатар аймгийн Шуудан холбооны газрын жолооч
29. Доржийн Сүхбаатар - Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын малчин
30. Дамбапэлжээгийн Сэнгэдорж - Сүхбаатар аймгийн Боловсрол,соёлын төвийн захирал
31. Тангаагийн Тогоонхүү - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Автожинчин"ХК-ийн цахилгаанчин
32. Гомбын Уртнасан - Сүхбаатар аймгийн Мал эмнэлэг,ариун цэврийн лабораторийн эрхлэгч
33. Хишигтийн Цагаан - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
34. Цэвэгсүрэнгийн Цовоо - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш
35. Гомбожавын Чулуунбаатар - Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
36. Дамчаагийн Шаалуу - Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг дарга
37. Тогоочийн Энхтайван - Сүхбаатар аймгийн Онгон сумын малчин

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ишийн Бүрэнбадрах - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн сургалт, арга зүй ,хүний нөөцийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн ахмад
2. Дамдингийн Шовоохой - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 15дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 112** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, телевиз, жил амжилт гарган үр бүтээлтэй ажилласан байгаа дор төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Энхбатын Баасанжав - Завхан аймгийн Цагаанчулуут сумын малчин
2. Цэндийн Барсүрэн - Монголын Үндэсний телевизийн редактор
3. Гомбосүрэнгийн Батаа - "Зууны мэдээ"сонины албаны дарга
4. Мягмаржавын Батжаргал - Завхан аймгийн Алдархаан сумын Алдар багийн Засаг дарга
5. Жавын Билэгдэмбэрэл - Монголын эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал
6. Доёдын Буяндэлгэр - ХААИС-ийн Инженерийн сургуулийн багш
7. Долгоржавын Дашдондог - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
8. Хандын Жавхлан - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга
9. Төгөлдөрийн Лхамсүрэн - Завхан аймгийн Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч
10. Гомбожавын Одончойжав - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Дээж стар"ХХК-ийн захирал
11. Гэрдийн Одхүү - Завхан аймгийн Алдархаан сумын Засаг даргын орлогч
12. Цэрэндоржийн Содов - Авто тээврийн газрын орлогч дарга
13. Пумаагийн Төмөрөө - Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга
14. Дашдоржийн Тэрбиш - Завхан аймгийн Цагаанчулуут сумын дунд сургуулийн захирал
15. Пүрэжэгийн Цэнджав - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын орон тооны бус ажилтан

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Түвдэннямын Шугаржав - Завхан аймгийн Цагаанчулуут сумын Засаг даргын Тамгын газрын дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 113** **Улаанбаа хот**

Хандсүрэнгийн Отгонд Монгол Улсын гавья малчин цол хүртээх тухай

Мал сүргээ олон жил тогтвортой өсгөн үржүүлж, үүлдэр угсаатнь сайжруулан ашиг шимийг нь сайн ашиглаж,иргэдийг малжуулахад идэвх санаачилга гарган,мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь аймгийн Өлзийт сумын 5 дугаар багийн малчин Хандсүрэнгийн Отгонд Монгол Ул гавьяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 114** **Улаанба хот**

Гэнэмаагийн Бизъяажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуулийн захирлаар олон жил үр бүтээлтэй ажиллаж,сургагдын сурах таатай нөхцөлийг хангаж,сургалтыг амьдралтай холбож хөдөлмөрийн хүмүүжил олгох, залуу багш нарыг ажилд нь дадлагажуулах,өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зөв багш Гэнэмаагийн Бизъяажавт Монгол Ул гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 115** **Улаанба хот**

Хайнзангийн Чимэдэд Монгол Улсын хүнд гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн анхан шатны байгуулагад олон жил үр бүтээлтэй ажиллаж,хариуцсан эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх,хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх,эмнэлгийн яаралтай тусламжийг хөдөөгийн хөдөлмөрчдөд шуурхай хүргэх,залуу мэргэжилтнийг ажилд нь дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын дундын эмнэлгийн ерөнхий эмч Хайнзан Чимэдэд Монгол Улсын хүний гавьяат эмч хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 7 дугаар сарын 19–ний өдөр **Дугаар 116** **Улаанба хот**

Дундговь аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Дундговь аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбар болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус а байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Цэвээн-Ойровын Бархас - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн дотрын их эмч
2. Чимэддоржийн Тамжид - Дундговь аймгийн нүүрс үйлдвэрлэлийн"Тэвшийн говь"ХК-ийн засварын механикч
3. Цэгмидийн Цэвээнжав - Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн их эмч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Санзайдоржийн Алтанцэцэг - Дундговь аймгийн Холбооны газрын залгагч
2. Базарсүрэнгийн Баасанжав - Дундговь аймгийн Адаацаг сумын 5 дугаар багийн малчин
3. Авирмэдийн Замгарав - Дундговь аймгийн Хулд сумын дунд сургуулийн захирал
4. Найдангийн Батсх - Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны орлогч дарга
5. Лхамсүрэнгийн Бирозана - Дундговь аймгийн Хулд сумын дунд сургуулийн математикийн багш
6. Хандоржийн Бүвэйбаатар - Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
7. Амаагийн Бямба - Дундговь аймгийн Мандалговь хотын захирагчийн ажлын албаны дарга
8. Ламчинсүрэнгийн Дамбийжанцан - Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч
9. Найдангийн Даваням - Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн эрхлэгч
10. Цэндийн Жигүүн - Дундговь аймгийн Хулд сумын "Дэвжин"хоршооны дарга
11. Тавхайн Ишээ - Дундговь аймгийн Сайнцагаан сумын 2 дугаар сургуулийн багш англйн багш
12. Ланганы Мөнхбаяр - Дундговь аймгийн Музейн захирал
13. Цоодолын Сүрэнов - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн орлогч дарга
14. Цэрэнжидийн Гүдэв - Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3 дугаар багийн малчин
15. Гончигийн Цэрэндорж - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
16. Монхорын Цэрэнсүрэн - Дундговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн ахмадын сувиллын их эмч
17. Тавхайн Чоёо - Дундговь аймгийн Гурвансайхан сумын Элгэн багийн малчин
18. Чойжамцын Шинэбаяр - Дундговь аймгийн Баянжаргалан сумын цэцэрлэгийн эрхлэгч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Баламын Умаахан - Дундговь аймгийн Цагдаагийн хэлтсийн замын цагдаагийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Амаржаргалы Амбасэлмаа - Дундговь аймгийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч
2. Лувсандоржийн Бадамцэцэг - Дундговь аймгийн Ус,цаг уур,орчны шинжилгээний төвийн техникч
3. Бурмаагийн Бландорж - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 1 дүгээр багийн Засаг дарга
4. Оргийн Бүжинкам - Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын дунд сургуулийн захирал
5. Чимэддуламы Ганбаатар - Дундговь аймгийн Сайнцагаан сумын 6 дугаар багийн Засаг дарга
6. Дамбын Гүнсэ - Дундговь аймгийн барилгын үйлдвэрлэл үйлчилгээний "Мандалговь - Импекс" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч
7. Балдандоржин Даваажав - Дундговь аймгийн Хулд сумын дунд сургуулийн бага англйн багш
8. Адъяагийн Дэлмаа - Дундговь аймгийн Дэрэн сумын дунд сургуулийн бага англйн багш
9. Өвгөний Дулаажав - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Холбооны салбарын эрхлэгч
10. Батсүхийн Зодоо - Дундговь аймгийн Хянан шалгах хорооны ахлах хянан байцаагч
11. Төмөрхүүгийн Мөнхцэцэг - Дундговь аймгийн Өндөршил сумын Соёлын төвийн эрхлэгч
12. Пүрэвжавын Ядагмаа - Дундговь аймгийн Төв номын сангийн номын санч
13. Баавгайн Наран - Дундговь аймгийн Өлзийт сумын 1 дүгээр багийн малчин
14. Чулууны Нацаг - Дундговь аймгийн Өлзийт сумын 2 дугаар багийн малчин
15. Сэрээнэнгийн Отгонсүрэн - Дундговь аймгийн хүнсний үйлдвэрлэлийн "Говийн тэнгэр" ХХК-ийн лаборант, чанар шалгагч
16. Амирийдоогин Оюун - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
17. Доржсүрэнгийн Сампил - Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга
18. Ёндонгийн Сүтөмөр - Дундговь аймгийн Адаацаг сумын 3 дугаар багийн малчин
19. Тавхайн Төмөчулуун - Дундговь аймгийн Хулд сумын Олдох багийн малчин
20. Самбуугийн Ыгмэд - Дундговь аймгийн Хулд сумын дунд сургуулийн бага англйн багш
21. Дондовын Цэвэгдолгор - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын бичээч-оператаоч
22. Нямдоржийн Цацэгмаа - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын орлогч
23. Уушийн Шатар - Дундговь аймгийн Гурвансайхан сумын "Давших зам"хоршооны дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 24–ний өдөр | Дугаар 101 | Улаанбаатар хот

Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцээр хэрэгжүүлж байхаар тогтоосугай.

2. Төрийн сангийн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд "-Төрийн сангийн хэлтэс" гэж, "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд "ж/Төрийн сангийн хэлтэс" гэж тус тус нэмсүгэй.

3. Аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн хэлтсийг дарга, ерөнхий нягтлан бодогч болон тухайн төсөвтэй харилцагч 20 хүртэл төсөвт байгууллага тутамд нэг нягтлан бодогч ажиллахаар тоолж зохион байгуулахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газар, аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн хэлтэс болон сумын Засаг даргын Тамгын газарт нягтлан бодох бүртгэлийн программ суурилуулж, аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн хэлтсийг Санхүү, эдийн засгийн яамны цахим сүлжээгээр холбон төрийн сангийн ажилтнуудыг системтэйгээр сургаж мэргэшүүлэх санхүүгийн үйлчилгээ, төлбөр тооцоог шуурхай болгох арга хэмжээг авсугай;

б/төрийн сангийн бүртгэлийн дансыг нээх, хаах болон мөнгөн касс ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй зохицуулж энэ ажилд хүнд суртал гаргаж үйлчилгээ саатуулсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажилласугай;

в/гадаад орон, олон улсын байгууллагаас хандивласан хөрөнгийг тухайн хандивлагчийн тавьсан нөхцөл, болзох харгалзан түр хугацаагаар төрийн сангийн дансанд байршуулж төрийн сангийн бүртгэлийн данстай хамт тайлагнаж байж зарцуулж тогтоосугай.

5. Төрийн сангийн нэгдсэн дансыг тогтолцоонд шилжих ажлын бэлтгэлийг сайн хангасны үндсэн дээр төлбөр тооцооны ажиллагааг 2002 оны 7 дугаар сарын 1-өдрөөс эхлэн төрийн сангийн бүртгэлийн дансны тогтолцоонд шилжүүлэхийг төсөв шууд, төвлөрүүлэн болон ерөнхийлөн захиран нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБ**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

002 оны 5 дугаар
арын 24–ний өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны этгөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын асгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын геологи, уул уурхайн албарыг хөгжүүлэх талаар өйрын жилүүдэд аримтлах чиглэлийг хавсралт ёсоор батална.

2. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг онгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил үрийн үндсэн чиглэл болон улсын төвлөрсөн эсвөт тусган зохион байгуулж байхыг Үйлдвэр, здалдааны сайд Ч.Ганзориг, Санхүү, эдийн засгийн айд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд нарт раг болгосугай.

3. Дээрх чиглэл батлагдсантай олбогдуулан улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр йцэтгэх геологийн ажлыг нэмэгдүүлэх талаар арга эмжээ авч ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгасугай.

4. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаанд зарцуулах жил бүрийн хөрөнгийн хэмнэлтийг геологийн судалгаа хийдэг улсын үйлдвэрийн газруудын техник, технологийг шинэчлэхэд зориулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 144 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2002 оны 103 дугаар тогтоолын хавсралт

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАЛААР ОЙРЫН ЖИЛҮҮДЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл нь Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, өөлтийг 2004 онд 6 хувьд, 2010 онд 10 хувьд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд геологи, уул уурхайн салбарын оруулах хувь эмрийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нэг. Геологийн судалгааны ажилд баримтлах чиглэл

Засгийн газраас геологийн судалгааны улын талаар тавих зорилт нь Монгол орны геологийн зүй тогтлыг тогтоох, ашигт малтмалын од, илэрцийг нээх илэрүүлэх замаар уул уурхайн албарын тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс 2004 он ртэлх хугацаанд геологийн судалгааны улсын зарцуулах хөрөнгийн хэмжээг өвөрсөн төсвөөс л бүр тогтвортой нэмэгдүүлэх замаар Монгол ны нутаг дэвсгэрийг 1:200000-ны масштабтай геологийн зураглалд бүрэн, 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд нийт нутаг дэвсгэрийн 1/5-ийг 2004 онд, 30 хувийг 2010 онд хамруулна.

Ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг хувийн хөрөнгөөр гүйцэтгэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, олон улсын мэдээллийн технологид нийцсэн геомэдээллийн сан байгуулах арга хэмжээ авна.

1.1. Геологийн судалгааны өнөөгийн байдал

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 94.1 хувь нь 1:200000-ны, 16.2 хувь нь 1:50000-ны масштабтай геологийн зураглал, эрлийн ажилд, 70 орчим хувь нь агаарын геофизикийн судалгаанд хамрагдсан байна.

Зураглал, ерөнхий эрлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг үндсэндээ хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр гүйцэтгэж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр жил бүр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд 0.8-1.0 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2001 оноос эхлэн жилд 1.3 тэрбум төгрөг, цаашид үүнийг жил бүр тогтвортой 15-20 хувиар нэмэгдүүлэн 2.0 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.

Эрэл хайгуулын ажилд 1997 онд гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүд 8.9 тэрбум төгрөг, 2000 онд 3.9 тэрбум төгрөг, 2001 онд 6.0 тэрбум төгрөг тус тус зарцуулсан бөгөөд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нийт 22.1 сая га талбайд хайгуулын лиценз эзэмшиж байгаагийн 90 орчим хувь нь алтны шороон ордын хайгуулын ажилд чиглэгдэж байна.

Эрэл хайгуулын ажилд зарцуулж байгаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт буурах хандлагатай болсныг нэгдүгээрт, алт, эзсийн дэлхийн зах зээлийн үнэ сүүлийн жилүүдэд унаж байгаа, хоёрдугаарт, сүүлийн жилүүдийн судалгааны үр дүнгээр шууд хөрөнгө оруулах объект тодийлэн илрээгүй байгаа, гуравдугаарт, 1998 оноос татварын тогтолцооны тогтворгүй байдал үүссэнтэй холбоотой.

Нөгөө талаар хувийн хөрөнгө оруулалт алтны шороон болон үндсэн орд, эзсийн орд газрын хайгуулын ажилд үндсэндээ төвлөрч бусад төрлийн ашигт малтмалын чиглэлээр болон дэд бүтэц хөгжөөгүй, алслагдсан бүс нутагт дорвитой хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна.

Геологийн судалгааны ажилд учирч байгаа хүндрэлтэй асуудлаас дурдвал:

-судалгааг эрхлэн явуулдаг аж ахуйн нэгжийн техник, технологийн чадавхи нь 1970-80-аад оны түвшинд байгаа;

-улирлаас хамааралтай ажлын хувьд геологийн судалгааны ажлын санхүүжилтийн саатлаас болж хээрийн ажлын бэлтгэл хангагдахгүй, ажил эхлэх хугацаа 1-2 сараар оройтож байгаа нь ажлын чанар, үр дүнд нөлөөлж байгаа;

-хилийн бүс болон тусгай хамгаалалттай газар нутаг, ялангуяа өмнөд хилийн бүс нутагт тусгай хамгаалалттай газрын тухай хууль тогтоомжоос шалтгаалан дорвитой судалгаа хийх боломжгүй;

-1:50000-ны масштабтай геологийн зураглал, эрлийн ажилд жилд хамруулах талбайн хэмжээг наад зах нь 2-3 дахин нэмэгдүүлж, энэ ажлын явцыг хурдасгах, эцсийн үр дүнг нь дээшлүүлэх зорилгоор зайнаас тандах судалгаа, региональ болоод эрлийн геофизикийн аргуудыг өргөн хэрэглэх, судалгааны материалын боловсруулалтад орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байгаа зэрэг болно.

1.2. Голлох төрлийн ашигт малтмалын нөөцийн байдал

2001 оны байдлаар үйлдвэрийн зэргээр тогтоогдсон алтны нөөцийн хэмжээ 146.78 тн, үүнээс үндсэн ордын нөөц 64.3 тн байна. Нөөцийн дундаж өсөлт одоогийн түвшинд байна гэж үзвэл алтны шороон ордын бэлтгэгдсэн нөөцийг 20 орчим жил ашиглах боломжтой. Өнөөгийн геологи хайгуулын ажлын үр дүн, гарч байгаа таамаглалаар алтны шороон ордын нөөцийн өсөлт цаашид буурах хандлагатай байна.

Алтны үндсэн ордын тойм судалгаа, геологийн зураглал, эрлийн ажлын явцад нийтдээ алтны үндсэн ордын тойм нөөцийг 1300 тн-оор баримжаалсны дотор Өмнөд Монголд 200 гаруй тн, Дорнод Монголд 150 гаруй тн. таамаг нөөцийг тогтоож, хайгуулын шатанд Бороо-Зуунмодны талбайд 43 тн, Тавтын ордод 4.8 тн нөөц бэлтгэгдсэн.

2001 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар Эрдэнэтийн овооны орд газрын хүдрийн нөөц 1304.9 сая тн болсон бөгөөд үүнд зэс 0.47 хувийн агуулгаар 6151.0 мянган тн, молибден 0.013 хувийн агуулгаар 176.2 мянган тн байна.

Цагаансуврагын зэсийн ордын нөөц нь 1.2 сая тн-оор батлагдсан ба хагас үйлдвэрийн туршилт хийгдэж, үндсэндээ ашиглалтад бэлтгэгдсэн.

Оюу толгойн зэсийн орд нь тойм нөөцөөрөө дээрх ордуудтай ижил байх магадлалтай бөгөөд хайгуулын ажлыг эрчимтэй гүйцэтгэн 2004 онд ордын геологийн нөөцийн өрөнхий үзүүлэлтүүд тодорхой болно.

Ашигт малтмалын бэлтгэгдсэн нөөцийг ав

үзвэл 8 сая тн орчим зэс, 0.24 сая.тн молибден, 3 сая тн орчим хар тугалга, цайрын хүдэр, 10 мян.тн цагаан тугалга, 146.8 тн алт, 10 мян.тн мөнгө, 452.8 сая тн төмөр, 50 мян.тн уран, 70 мян.тн гянтболд, 200 мян.тн бал чулуу, 18 сая тн хайлуур жонш, 2.4 тэрбум тн фосфорит, 4.8 сая тн циолит, 1.3 сая тн эрдсийн будаг, 85.9 сая м^3 барилгын чулуу, 0,4 сая тн битум болон бусад ашигт малтмал байна. Эдгээр нөөцийг үндэсндээ 1990 оноос өмнө улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бөгөөд 1990 оноос хойш алтны ордуудын нөөцийг шинээр нэмэгдүүлснийг эс тооцвол бусад ашигт малтмалын төрлөөр үйлдвэрлэлийн зэргээр нөөц бэлтгэх ажил хийгдээгүй байна. Бэлтгэгдсэн нөөцөөс алт, зэс, молибден, хайлуур жонш, гянтболд, нүүрснээс бусад нөөц аж ахуйн эргэлтэд ороогүй байна. Энэ нь ашигт малтмалын нөөц нь бэлтгэгдсэн ордууд хүрч, аж ахуйн нэгжүүдийн мэдэлд ашиглалтын болон хайгуулын лицэнз хэлбэрээр шилжсэн, ихэнх лицэнз хэмжигчид орд газрыг бие даан аж ахуйн эргэлтэд оруулах хөрөнгө санхүү, техник, хэрэгслийн чадавхигүйгээ холбоотой байна.

1.3. Геологийн судалгаа, эрэл хайгуулын талаар баримтлах чиглэл

а/геологийн региональ судалгааны талаар

1:50000-ны зураглалыг авто зам, төмөр зам, Мянганы замын дагуу болон хүдрийн бүс зангилаа газар, уул уурхайн үйлдвэрүүдийн орчим, улсын хилийн дагуухи бүс нутагт төвлөрүүлэх. 2010 он хүртэл хийх 1:50000-ны зураглалын ажлыг:

Монгол Алтайн металлогенийн бүс дэх Төгрөг-Шархоолойн хүдрийн дүүргэгт 61 мян.кв.км-т (Ховд, Говь-Алтай аймгуудад),

Өмнөд Монголын атриат тогтолцооны Цагаан-Уулын бүсэд 28 мян.кв.км-т (Өмнөговь аймагт),

Өмнөд Монголын атриат тогтолцооны Нүхэт давааны бүсэд 31 мян.кв.км-т (Дорноговь, Өмнөговь аймгуудад),

Ш Хангай-Хэнтийн атриат тогтолцооны Хархорины хөндлөн өргөгдлийн Зүүн Хангайн бүсэд 26 мян.кв.км-т (Архангай, Өвөрхангай, Булган аймгуудад),

Монгол Алтайн нуруудын бүсэд 38 мян.кв.км-т (Увс, Баян-Өлгий аймгуудад)

Эдгээр ажлыг гүйцэтгэснээр 2010 онд нийт нутаг дэвсгэрийн 30 хувьыг 1:50000-ны масштабын геологийн зураглалаар хамруулна.

- Дэлхийн зах зээл дээр үнэ өндөртэй ашигт малтмал, тухайлбал зэс, алт, ховор металл, керамикийн түүхий эдийн эрлийн ажилд түлхүү чиглүүлэх.
- Сансрын зургийн боловсруулалт, агаарын болон эрлийн геофизикийн аргыг геологийн судалгаанд өргөн хэрэглэх, судалгааны материалын боловсруулалтад орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, үүнтэй холбогдуулан геологийн судалгааны байгууллагын техникийн баазыг шинэчлэн бэхжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

б/хайгуулын ажлын талаар

- Алтны үндсэн орд, зэс, ховор металл, керамикийн түүхий эдийн нөөц бэлтгэхэд эрэл хайгуулын ажлыг чиглүүлэх.
- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх зураглал, ерөнхий эрлийн ажлын явцад гарсан ордын илэрцийг баталгаажуулахад хувийн хэвшлийн хөрөнгө хүчийг түлхүү оролцуулах механизм бүрдүүлэх, цаашдын нарийвчилсан судалгааны лицензийг тендерийн шалгаруулалтаар олгодог болох.
- Тодорхой ашигт малтмалын хайгуулын төсөөр хувьцаа гаргаж, гадаад, дотоодын биржүүдээр арилжих.
- Эрэл хайгуулын ажлын үр дүнд бий болсон мэдээллийн үнэ цэнэ, үнэмшлийг тогтоох экспертийн болон аудитын үйлчилгээний тогтолцоо бий болгох.
- Хэтийн төлөв сайтай зарим объектуудын (илрэл) хайгуулын ажлыг төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэн нөөцийг нь баталгаажуулан ашиглалт явуулах компаниудад тендерийн шалгаруулалтаар олгох.

в/хууль эрхийн зохицуулалтын талаар

- Тусгай хамгаалалттай газарт болон улсын хилийн бүсэд геологи хайгуулын ажил гүйцэтгэх нөхцөл бүрдүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах.
- Хайгуулын болон ашиглалтын лицензийг худалдах, тодорхой ашигт малтмалын хайгуулын төсөлд хувьцаа гаргаж, биржээр арилжих эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт

оруулах.

- Алт, үнэт металлын үндсэн ордын эрэл хайгуулын ажилд гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг татах зорилгоор татварын болон ашигт малтмалын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах
- Алслагдсан хил орчмын нутагт эрэл хайгуулын ажил эрхлэх аж ахуйн нэгжийг урамшуулах зорилгоор тэдгээрт татварын хөнгөлөлт үзүүлэх нөхцөл бүрдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх
- Улсын төсвийн хөрөнгөөр үйлдвэрлэлийн нөөцийг нь бэлдсэн орд газруудыг аж ахуйн эргэлтэд оруулах механизмыг Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх.

Хоёр. Уул уурхайн салбарт баримтлах чиглэл

2.1 Уул уурхайн салбарын өнөөгийн байдал

Уул уурхайн салбар 2001 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8.5 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 49.8 хувь, экспортын бүтээгдэхүүний 40.5 хувийг үйлдвэрлэж байна. Мөнгөн дүнгээр авч үзвэл 2000 онд 261.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд экспорт 171.5 сая долларт хүрсэн байна.

Экспортын 83-87 хувийг зэс, молибдены баяжмал, 10-12 хувийг хайлуур жоншны баяжмал үлдэх хувийг алт, катодын зэс болон бусад ашигт малтмал эзэлж байна.

Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг зэрэгцүүлж харуулбал:

Хүснэгт 1

Он / Бүтээгдэхүүн	1992	1995	2000	2001
Алт, кг	775.8	4504.0	11432.9	12059
Зэсийн баяжмал, мян.тн	348	346.4	457.7	487.6
Молибдений баяжмал, тн	2929.1	3906.0	2626.6	2797
Жоншны флотацийн баяжмал, мян.тн	97.2	120.4	111.4	127.3
Жоншны металлургийн баяжмал, мян.тн	42.9	13.1	87.4	76.6
Гянтболдын баяжмал,тн	3.5	-	81	92

Сүүлийн 10 жилд алт олборлолт 14.7 дахин, зэсийн хүдэр олборлолт болон баяжмал гаргалт 30.4 хувь, хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэл 14.6 хувь хүртэл өсөж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтаар тэргүүлэх байрыг эзэлж байна.

2.2 Зэс, молибдены баяжмал үйлдвэрлэлт

Хамтарсан Эрдэнэт үйлдвэрт техникийн шинэчлэл хийснээр 2001 онд хүдэр олборлолтыг 24 сая тн-д хүргэж 480 гаруй мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 6.4 хувиар өссөн байна. Гэвч дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн үналтаас үүдэн баяжмалын экспорт үнийн дүнгээр 13.9 хувиар буурав.

Үнийн үналтын гол шалтгаан нь дэлхийн зэсийн үйлдвэрлэл хэрэглээнээсээ давж бүтээгдэхүүн борлуулах өрсөлдөөн бий болсон, зэсийн голлох үйлдвэрүүд дээр хийгдсэн техникийн шинэчлэлийн үр дүнд хямд өртөг бүхий гидрометаллургийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зах зээл дээр нэмэгдэх болсон явдал юм. Одоогоос дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн 20 гаруй хувий гаргаж байгаа гидрометаллургийн технологи бүхи үйлдвэрүүдэд 1 тн зэсийн өөрийн өртөг нь 850-90 орчим ам.доллар байгаа нь Эрдэнэт үйлдвэрий өөрийн өртөөс 30 орчим хувиар хямд байна.

Дэлхийн зах зээлийн үнийг тодорхойлдо Лондонгийн металлын бирж дээр нэг тонн зэсий үнэ 2001 оны эхэнд 1790 орчим ам.доллар байса бол 2001 оны эцэст 1360 ам.доллар болж 2 хувиар буурсан нь Эрдэнэт үйлдвэрийн санхү эдийн засгийн байдалд муугаар нөлөөлж, улсы төсвийн орлогыг тасалдуулж, үйлдвэрийн хөвий ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Зэсийн шинэ ордууд: Цагаансуваргын зэ молибдены ордын нөөцийг нэгэнт тогтоосон бөгөө

гидрометаллургийн технологи бүхий үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг Монголын алт корпораци хийж байна. Энэ ордыг ашиглалтад оруулахад дэд бүтцийн буюу өндөр хүчдэлийн шугамыг 2002-2003 онд барьж байгуулах шаардлагатай болно. Ордын нөөцийг гидрогеологийн судалгаа хийж техникийн үсны эх үүсвэр олсон нь энэ ордыг ашиглалтад оруулах боломжийг нэмэгдүүлж байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойн илэрц дээрх хайгуулын ажлын урьдчилсан дүн томоохон орд бий болгох боломжтойг харуулж байна. Оюу толгойн зэс, молибден, алтны ордод ойролцоогоор 3-5 сая тн зэсийн нөөц нээгдэх төлөвтэй байгаа бөгөөд энэ хайгуулах үйлдвэрийг Цагаансуварга болон зэс хайлуулах үйлдвэрүүдтэй уялдуулан шийдвэрлэх нь дэд бүтэц болон бусад туслах байгууламжийн шаардлыг хямдруулах боломжийг бий болгоно. Уг хайгуулын ажлыг дуусган үйлдвэр байгуулах хугацаат 5-7 жил гэж урьдчилан тодорхойлоод байна.

Монголын баруун болон говийн бүс нутагт зэсийн орд шинээр нээгдэх боломжтой ч хайгуулын ажлын хөрөнгө оруулалтад зэсийн зах зээл, үнийн суудал нөлөөлөх учир олон жилийн хэрэглээний олон бусад прогнозыг гаргасан байх шаардлагатай байна.

2.3 Хайлуур жоншны хүдэр олборлолт болон боловсруулалт

Жоншны флотацийн болон металлургийн /гравитацийн/ баяжмалын үйлдвэрлэлийн хэмжээ дүйлийн жилүүдэд харьцангуй тогтвортой, жилийн дүнд олборлолтын хэмжээ нь 560-640 мян.тн байна. Бор-Өндөр далд уурхай, баяжуулах фабрик, Ирэг, Өргөн, Хамар-Ус, Адагийн 4 ил уурхай ажиллаж байна.

Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрт нийт олборлосон хүдрийн 75 орчим хувийг боловсруулан 97 хувийн CaF_2-ийн агуулгатай флотаци, 75 хувийн металлургийн баяжмал гаргаж байна.

Ашиглаж байгаа ордуудын хүдрийн агуулга буурч, уул техникийн нөхцөл хүндэрсэн болон алслагдсан районд байгаа уурхайчдын тогоны нийгэм ахуйн зардал их, баяжуулах фабрикаас алслагдсан ордуудаас хүдэр гаргаж байгаагаас тээврийн зардал өндөр зэрэг шалтгаанаас хамаарч баяжмалын өөрийн өртөг өндөр байна.

Харин 1997 оноос Бор-Өндөрийн далд уурхайд ашиглаж эхэлсэн өндөр бүтээлтэй өөрөө явагч төхөөрөмж нь далд ашиглалтын ажлын хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлэх боломж олгож байна.

ОХУ-д голлон нийлүүлдэг хайлуур жоншны баяжмалын зах зээл нь БНХАУ-аас нийлүүлж байгаа хямд бүтээгдэхүүнээр орлогдох магадлал ихтэй байдаг тул баяжмалын чанарыг дээшлүүлэх, хэлбэр, нэр төрлийг нь олшруулах шаардлага гарч байна.

Хайлуур жоншны олон ордыг ашиглахдаа нөхөн сэргээлтийн ажил бараг хийгээгүй тул ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.4. Алт олборлолт


Засгийн газрын "Алт" хөтөлбөрийг 1992 оноос хэрэгжүүлснээр 10 жилийн хугацаанд 65.56 тн алт олборлож 368.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Олборлолтын хэмжээг харуулбал:

Он	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	Дүн
Алт, тн	0.78	1.1	1.8	4.1	5.4	8.7	10.0	10.1	11.4	12.06	65.56

2001 онд 116 аж ахуйн нэгж 12 орчим тн алт олборлосон бөгөөд олборлолтын 59.1 хувийг компани гаргаж байна.

Сүүлийн 10 жилд алт олборлолтоос 120 орчим сая ам. доллартай дүйцэхүйц татварыг төсөвт оруулснаас 19.6 хувь нь нөөц ашигласны төлбөр, 57.8 хувь нь худалдааны болон нэмэгдсэн өртгийн албан татварт, 12.3 хувь нь газар, усны төлбөрт, 29.8 хувь нь орлогын албан татварт ногдох бөгөөд улсын төсвийн татварын орлогын 7-9 хувийг бүрдүүлж байна. Жил бүрийн бүтээгдэхүүний хэмжээ болон улсын төсөвт оруулсан татварын хэмжээг 1992-2001 оноор гарган зураг 1-д үзүүлэв.



Зураг 1

Алт олборлолтын өөрийн өртөг сүүлийн 4 жилд 15-21 хувиар өссөн нь ашиглаж байгаа ордуудын уул техникийн нөхцөл хүндэрч, хөрс хуулалтын ажил нэмэгдсэн, алтны агуулга буурсантай холбоотой байна.

Татварын ачаалал борлуулалтын орлогын 30 хүртэл хувийг эзэлж, үйлдвэрлэлийн цэвэр ашиг 6.0-8.4 хувь болж байна. Энэ нь ашгийн чөлөөт үлдэгдлээр алтны үйлдвэрүүд үйлдвэрлэлээ өргөтгөх болон эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж багатай байгаат харуулж байна. Татварын ачааллаас болж ашигт малтмалын нөөц нэмэгдүүлэх ашиглалтын хайгуулын ажлыг зогсоох хандлага бий болж байгаа бөгөөд энэ нь алтны үйлдвэрлэлийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Алтны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зээлээс өөр ямар нэг хөрөнгө оруулалт улсаас хийгээгүй бөгөөд олборлолтын 86.1 хувийг гаргаж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд арилжааны зээл болон гадаадын хамтрагч байгууллагуудын хөрөнгө оруулалтад түшиглэн үйлдвэрлэлээ өсгөсөн нь чухал үр дүн юм.

Сөрөг үр дагавраас дурдвал:

- 5.7 мян. га газар эвдрэлд орсон бөгөөд зөвхөн 16.3 хувьд нь нөхөн сэргээлтийн ажил хийсэн.
- Байгалийн усны механик бохирдлын хэмжээ Заамар, Ерөө зэрэг зарим районд нэмэгдсэн.
- Алтны уурхайнуудын ашиглагдсан болон нээлт хийсэн талбайд алтыг хууль бусаар, гар аргаар олборлох явдал ихсэн осол эндэгдэл нэлээд гарах болсон бөгөөд хууль бус алт олборлолттой холбогдон алтны хар зах бий болсон.

2.5. Гянтболд олборлолт

Өнөөгийн байдлаар гянтболдын хүдрийг Баян-Өлгий аймгийн Ховд гол /ил уурхайгаар/, Төв аймгийн Цагаандавваа /далд уурхайгаар/-ны ордуудаас бага хэмжээгээр /100-300 тн орчим/ олборлон ойролцоох Улаан-Уулын болон Цагаандавааны бага оврын баяжуулах фабрикт боловсруулж 60 хувь орчим WO_3-ийн агуулгатай баяжмал болгон экспортолж байна. Экспортод гаргасан баяжмалын хэмжээ нь 2000 онд 86 тн, 2001 онд 92 орчим тн байна. Баян-Өлгийн Улаан-Уул, Ховдын Цүнхэг, Сүхбаатарын Егүзэр зэрэг нөөцийг нь тогтоосон /металлаар 70 орчим мян.тн/ гянтболдын орд газруудыг ашиглах замаар гянтболдын экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болно.

2.6. Улсын төсөвт оруулж байгаа хувь нэмэр

Улсын төсөвөр гүйцэтгэсэн геологи хайгуулын зардлыг нөхөн төлүүлэх ажлыг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хэрэгжүүлэн 1998 онд 268 сая төг, 1999 онд 507.4 сая төг, 2000 онд 599 сая төг, 2001 онд 626.2 сая төгрөгийг улсын төсөвт оруулсан.

Хайгуулын болон ашиглалтын лицензийн талбайн төлбөрөөр 1997 онд 1170.9 сая төг, 1998 онд 957.2 сая төг, 1999 онд 981.9 сая төг, 2000 онд 1291.3 сая төг, 2001 онд 1145.8 сая төгрөгийг улсын төсөвт оруулав.

2001 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 3.2 тэрбум төг, газрын төлбөрт 3.3 тэрбум төг, ус ашигласны төлбөрт 189.6 сая төг, орлогын албан татварт 38.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулж нийтдээ 44.8 тэрбум төг. болсон нь төсвийн орлогын 18.6 хувь юм.

2.7. Хууль эрх зүйн орчны талаар

Уул уурхайн үйлдвэрлэлийг өргөтгөхөд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хамгаалсан эрх зүйн тогтвортой орчинг бий болгох асуудал нэн чухал байна.

Ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн 60 сүүлийн 4 жилд 2.2 дахин өсч ашиглалтын лицензийн 20, хайгуулын лицензийн 80 гаруй хувийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрүүд эзэмшиж байна. Ашигт малтмалын тухай хуульд заасан тогтвортой байдлын гэрээний тухай заалтуудыг 2001 онд хэтварын ерөнхий хууль болон Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиудад тусгаж өглөө.

Гадаадын хөрөнгө оруулалттай 3 аж ахуйн нэгж Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тогтвортой байдлын гэрээ байгуулсан байна. Мөн нэлт олборлогч аж ахуйн нэгжүүдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас бүрэн чөлөөлж, бэдгээрийн үндсэн ордын ашигт малтмал ашигласны төлбөрийг 2.5 хувь, шороон ордынхыг 1.5 хувиар тогтоосон.

Одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хууль нь үндсэндээ ашигт малтмал хайх, ашиглах лицензийн харилцааг зохицуулах хууль болсон тул эрдэс баялгийн үйлдвэрлэлийн олон талт харилцааг зохицуулсан уул уурхайн хуулийг тусад нь боловсруулах шаардлагатай байна.

Гурав. Уул уурхайн салбарт баримтлах чиглэл, цаашдын зорилт

3.1 Ойрын үед баримтлах бодлогын чиглэлүүд

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2001-2004 оны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт:

- Уул уурхайн үйлдвэрлэлээс орох экспортын орлогыг нэмэгдүүлэх,
- Эрдэнэт үйлдвэрт технологийн шинэчлэлт хийж, баяжмал боловсруулалтын түвшинг гүнзгийрүүлэн, үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Катодын эзэлхий үйлдвэрлэлийг 10-15 мян. тн-д хүргэх,
- Алт олборлолтыг 1.5 дахин нэмэгдүүлэх,
- Төмөртийн-Овооны цайр,Бороогийн алтны үндсэн орд, Тосон, Баянголын ордууд дээр ажиллах уулын үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах,
- Тавантолгойн коксжих нүүрсний орд, Тавтын алтны үндсэн орд, Цагаансуваргын зэс болон Асгатын мөнгөний ордуудыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтална:

- Шинээр уул уурхайн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах, уул уурхайн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрэх нөхцөл боломжийг бий болгоход дэмжлэг үзүүлэх,
- Татвар, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх,
- Бүсчилсэн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн алслагдсан районуудад геологи хайгуулын болон олборлолтын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг нь тогтоосон орд газруудыг ашиглалтад бүрэн оруулахад дэмжлэг үзүүлэх,
- Одоо ажиллаж байгаа уул уурхайн

үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх.

3.2. Ашиглаж байгаа ашигт малтмалын талаар баримтлах чиглэл

3.2.1. Зэс олборлолт, боловсруулалт

Эрдэнэтийн үйлдвэрт хийх технологийн шинэчлэлийг 2 чиглэлээр явуулна:

- Үндсэн дамжлагуудад хийсэн технологийн шинэчлэлийг оновчтой байдлаар дуусгах, хүхрийн хүчлийг байгаль орчинд хоргүйгээр ялган авах технологийн шийдэл бүхий пирометаллургийн зэс хайлуулах үйлдвэрийг 2005-2010 онд говийн районд, Говьсүмбэр эсвэл Дорноговь аймгийн нутагт оновчтой байрлалыг сонгон байгуулах, зэс хайлуулах үйлдвэртэй хамт эцсийн бүтээгдэхүүний цех бий болгох замаар Эрдэнэт үйлдвэрийн үр ашгийг эрс дээшлүүлэх нөхцөл бололцоог бий болгох,
- Гидрометаллургийн аргаар ядуу агуулгатай хүдрийг боловсруулах үйлдвэрийг Эрдэнэт үйлдвэрийн дэргэд байгуулан бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг эцсийн бүтээгдэхүүн /99.9 хувийн агуулгатай катодын зэс/ хэлбэрээр үйлдвэрлэх, катодын Эрдмин үйлдвэрийг өргөтгөн хүчин чадлыг нь 10-12 мян. тн-д хүргэх.

Шинээр ашиглалтад орох боломжтой ордуудад:

- Цагаансуваргын зэс, молибдений ордыг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч, уг үйлдвэрийн хөрөнгө оруулалтад 25-26 сая ам. долларын санхүүжилт хийх, энэ үйлдвэрийн дэд бүтцэд зориулж Чойр-Цагаансуварга, эсхүл Мандалговь-Цагаансуваргын чиглэлийн 220 квт-ын шугам татаж эрчим хүчээр хангах асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр 2004 онд жилд 5 мян. тн катодын зэс гаргах гидрометаллургийн үйлдвэрийг байгуулах;
- Оюу толгойн ордын хайгуулын ажлын эрчимжүүлэх, ордын нөөцийг үйлдвэрийн зэргээр тогтоох (2002-2004 он), цаашид 30 мян тн катодын зэс гаргах үйлдвэрийг 2004-2008 онд байгуулах.

3.2.2. Хайлуур жонш олборлолт боловсруулалт

- Хайлуур жоншны үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг оновчтой хэлбэрээр үргэлжлүүлэн, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин /баяжмал дахь CaF_2 ийг 97 хувиас дээш болгох/, нэр төрлийн нэмэгдүүлэх /брикетлэх, супер баяжмал гарга зэрэг/ замаар бүтээгдэхүүний зах зээл, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.
- Далд аргаар олборлох хүдрийн хэмжээ нэмэгдүүлэх /нийт олборлолтын 70 хувь хүргэх/, өртөг бууруулах арга хэмжээг өөрөө явагч техеөрөмж бүхий технологийг илүү өргө хүрээтэй нэвтрүүлэх замаар хангах. Адаг, Зүү цагаандэл зэрэг ил аргаар ашиглан тодорхо хэмжээний нөөцийг орхигдуулсан ордууды далд аргаар нээлт хийж ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Хайлуур жоншны ашиглалт явуулсан ордуу дээр хийх нөхөн сэргээлтийн ажлы эрчимжүүлэх.

3.2.3. Алт

Алт олборлолтын хэмжээг 1.5 дахи нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг Бороогийн алтны үндсэн ордыг ашиглах уу уурхайн үйлдвэрийн эхний ээлжийг 2003 оно ашиглалтад оруулан ордыг 8-10 жил ашиглана
- Төв аймгийн Заамар сумын нутагт оршдо Тосонгийн алтны шороон ордоос олборло алтны хэмжээг нэмэгдүүлэх /Уг орд дээр өндө

металл авалт бүхий драгаар жилд 500-800 кг алт олборлох үүчин чадалтайгаар 15 орчим жил ашиглана/;

- Төв аймгийн Заамар сумын нутагт оршдог Баянголын алтны шороон ордыг жилд 500 кг алт олборлохүүчин чадлаар ашиглах;
- Булган аймгийн Тэшиг сумын нутагт Тавтын алтны үндсэн ордыг ашиглах үйлдвэр байгуулах.

Ашиглагдаж дууссан алтны шороон ордуудын олборлолтын болон баяжуулалтын хаягдал 15-25 хувьд хүрч байгаа бөгөөд хаягдалд байгаа нарийн шүрхэгтэй алтыг ялгах технологи нэвтрүүлэх замаар үүсмэл ордуудаас олборлолт явуулах, ашиглагдаж байгаа ордууд дээрх технологийг боловсронгуй болгон хаягдлын хэмжээг 50 хүртэл хувиар багасгах.

Алт олборлолтын талаар ойрын жилүүдэд шийдвэрлэх асуудлууд:

- Алтны шороон ордууд дээр ажиллаж байгаа үйлдвэрүүдээс авч буй татварын хэмжээг одоогийн түвшинд байлгах, олборлож буй алтны хэмжээг буурулахгүй байх;
- Хөрөнгө оруулагчидтай тогтвортой байдлын гэрээ байгуулах замаар алтны үйлдвэрлэлд оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх;
- Олборлолтын үеийн алтны хаягдлыг багасгах, хэрэглэгдэж байгаа техник, технологийг боловсронгуй болгох замаар алтны уурхайн үр ашгийг дээшлүүлэх, их хаягдалтай олборлолт явуулдаг үйлдвэрийг түр зогсоох, ашиглагдаж байгаа нийт технологийг аттестатчилах;
- Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимтэй явуулах норм, стандартыг бий болгох, энэ талаар гадаад, дотоодын тэргүүний технологи, туршлагыг судлан суртачлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

Олборлолтын хаягдлыг бүртгэлжүүлэх, хаягдал нөөцийг үнэлэх, хаягдал ашиглах журам бий болгох.

3.2.4. Гянтболд

Гянтболдын баяжмалын экспортын хэмжээг 2004 онд 200-300 тн-д хүргэх. Энэ зорилгоор гянтболдын Цүнхэг зэрэг нөөцийг нь тогтоосон орд газруудыг ашиглалтад шинээр оруулахын зэрэгцээ одоо ашиглаж байгаа Ховд голын ордоос олборлож байгаа хүдрийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.2.5 Цайр

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төмөртийн овооны цайрын ордыг 2002-2004 онд ашиглалтад оруулах.

3.2.6. Коксжих нүүрс

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт оршдог Таван толгойн коксжих нүүрсний ордыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх. Говийн бүсэд байгуулагдах эзсийн үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах зорилгоор орд дээр 1-2 сая тн нүүрсийг эрчим хүчний зориулалтаар олборлох ил уурхайг 2008 он гэхэд ашиглалтад оруулах.

3.2.7. Мөнгө

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрладаг Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах боломжийг бүрдүүлэх ажлыг 2003 он хүртэл гүйцэтгэж 2003-2006 онд жилд 350 тн хүдэр олборлон боловсруулах үйлдвэрийг байгуулах.

Дөрөв. Шинэ төрлийн ашигт малтмалыг олборлох, боловсруулах

Монгол орны эрдэс баялгийн салбарт нэлээд их хэмжээний фосфор, төмөр, полиметалл болон бусад ашигт малтмалын бэлтгэгдсэн нөөц бий. Энэ нь тухайн төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохион байгуулах боломжийг бий болгож байна.

Ойрын ирээдүйд уул уурхайн үйлдвэр байгуулан шинээр бүтээгдэхүүн гаргах боломж бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг үүүлбэл:

Хүснэгт 2

№	Ашигт малтмалын төрөл	Үйлдвэрлэлийн зэрэгээр нөөц, сая тн	Ашиглах боломжтой ордууд ба тэдгээрийн нөөц
1	Хар тугалга, цайр	3.05	Улаан-цайр 0.8 мян.тн, хар тугалга 424.5 тн, цав-цайр 226 тн, хар тугалга 123 тн
2	Цагаан тугалга	2.2 мян.тн	Жанчивлангийн бүлэг шороон ордууд
3	Ховор металл	0.4 /худэр/	Мушгиа худгийн ордод энэ нөөц хамаарна
4	Мөнгө	0.01	Асгатын ордод тогтоогдсон нөөцийн 90 хувь хамаарна
5	Төмөр	452.8	Төмөртолгой – 25.1 сая тн, Баянгол – 132 сая тн, Төмөртэй –220 сая тн
6	Уран	0.06	Мардай-1104 тн, Гурванбулаг– 16.1 мян.тн, Дорнод- 28.9 мян.тн
7	Фосфорит	2400	Урандөш– 44.2 сая тн, Өлийн даваа–15.3 сая тн, Өнгөлөг нуур-100 сая тн, Бүрэнхаан-26 сая тн

4.1 Фосфорит

Хөвсгөл нуураас урагш 80 орчим км зайд орших Бүрэнхааны ордыг байгаль өнгөөр нь багатайгаар ашиглах асуудлыг хөрөнгө оруулагч нарт тавих. Энэ ордыг ашиглахдаа фосфоритыг Эрдэнэт үйлдвэрийн бүтээгдэхүүнийг боловсруулах зэс хайлуулах үйлдвэрийн хүхрийн хүчилтэй хамтад нь боловсруулж фосфорын бордоо үйлдвэрлэх технологитой химийн үйлдвэртэйгээр зохион байгуулах. Үйлдвэрийг жилд 60 мян.тн фосфорын бордоо үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 2005-2008 онд байгуулах.

4.2 Төмөр

Сэлэнгэ, Дарханы районд байгаа төмрийн хүдрийн ордууд дээр хүдэр олборлон ангижруулах үйлдвэрийг 2003-2006 онд байгуулан 1.5 сая тн хагас боловсруулсан төмрийн хүдрийг экспортод гаргах, ангижруулсан төмрийн хүдрийн зарим хэсгийг Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрт боловсруулах, өөрийн орны төмрийн хүдрээс төмөр эдлэл дотооддоо үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлуулахад чиглүүлэх.

4.3 Уран

- Эхний ээлжинд концессоор ашиглаж байсан Мардайн орд дээр байгаа үйлдвэрийн үйл ажиллагааг Америк, Оросын хамтрагч талуудтай тохиролцон сэргээхэд дэмжлэг үзүүлэх. Нэгэнт байгуулагдсан дэд бүтэц бусад туслах объектыг хамгаалах, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг авч хэрэгжүүлэх. Энэ үйлдвэрий гидрометаллургийн технологиор 100-200 т ураны исэл үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 2006 оноос ажиллуулах.
- Хараат, Хайрханы ураны ордуудын хайгуул газрын дор уусган баяжуулах олборлолтын технологийн туршилтын ажлыг сэргээх талаар оролцогч талууд болон сонирхогч бусад хөрөнгө оруулагчдад санал тавих /Эдгээр ордыг санал болгож байгаа технологиор ашиглахад 80-120 мян.тн хүхрийн хүчил шаардагдах бөгөөд жилд 250-500 тн уран гарга боломжтой юм. Гэвч хүхрийн хүчлийн тээврий зардлаас хамааран бүтээгдэхүүний өртөг өндөр байхаар байна. Хэрэв Мандалговь Цагаансуваргын өндөр хүчдэлийн шугам тавигдвал Хайрханы ордыг ашиглах боломж нэмэгдэнэ/.

4.4 Бусад ашигт малтмалын талаар

Цагаан тугалганы шороон ордууды ашиглалтад оруулахад лицэнз эзэмшигч компаниудын ажлыг идэвхижүүлэх, ОХУ, БНХАУ-ын энэ чиглэлийн үйлдвэрүүдтэй хамтыг ажиллагаа тогтоох, хамтран эзэмших талаар

тохиролцох зэрэг авга хэмжээ авах.

Полиметаллын Цав,Улааны ордуудыг ашиглах уурхайнуудыг баяжуулах фабриктайгаар 2004-2008 онд байгуулан нийт 35 мян.тн цайр, хар тугалганы баяжмал экспортод гаргах.

Полиметаллын Өндөрцагаан, Мөнгөн-Өндэр зэрэг ордуудын талаар хөрөнгө оруулагч нарт санал бэлдэх гадаадын зээл, тусламжийг ашиглах боломжийг судлах, ТЭЗҮ боловсруулан ашиглах ажиллах нөхцөлүүдийг нь тогтоох.

Газрын хөвөө элемент, ховор металл, хөнгөн цагаан, өнгөт чулуу, зарим төрлийн эрдэс материал /циолит зэрэг/-ын нөөц нь тогтоогдсон ордуудыг ашиглах боломжийг Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэн тусгайлан судалж үр дүнг нь хөрөнгө оруулагчдад сурталчлах, санал болгох ажлыг зохион байгуулах.

Тав. Уул уурхайн хамтарсан болон концессийн үйлдвэрүүдийн талаар

2002 он болон 2005 онд Монгол-Оросын хамтарсан Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет нэгдлийн үйл ажиллагааны тухай Засгийн газар зоорондын 1991 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хэлэлцээр дуусгавар болж байгаатай уялдуулан:

- ОХУ-ын Засгийн газартай хэлэлцээ хийж эдгээр үйлдвэрийг үндэсний үйлдвэр болгох болон Монголын талын хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох,
- Газар, ус, бусад байгалийн баялгийн болон экологийн эвдрэлийг шинэчилсэн үнэлгээгээр тооцон үйлдвэрийн дүрмийн санд тусгах,
- Үйлдвэрийн үйл ажиллагааг зах зээлийн нөхцөл болон дэлхийн ижил төстэй төргүүний уурхайнуудын жишгээр удирдлага зохион байгуулалт, менежментийн шинэ загварт оруулах,
- Үйлдвэрлэлийн үр ашгийг хүрсэн түвшингээс эрс нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох.

Монголросцветмет нэгдлийн хувьд:

- Нэгэнт бий болсон үйлдвэрлэлийн бааз, хүчин чадлаа ашиглан хайлуур жонш, алтнаас гадна өөр ашигт малтмалын төрлийг олборлож, боловсруулах шинэ үйлдвэрлэлд шилжих / Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглүүлэн төмрийн хүдэр олборлож боловсруулах, Асгатын менгөний ордыг ашиглалтад оруулах зэрэг/,
- Хайлуур жоншны олборлолтын хүрсэн түвшинг ил уурхайгаар ашигласан ордуудад төвлөрүүлэн гүний нөөцийг далд аргаар, өөрөө явагч техник, технологи хэрэглэн олборлох замаар хангах,
- Жонш, алтны ашиглагдсан ордуудын экологийг нөхөн сэргээх үйл ажиллагааг өргөжүүлэх.

Концессоор Унгарын талд эзэмшүүлж буй Цагаандавааны гянтболдын орд дээрх өмчийн маргааныг Унгарын тал шийдвэрлэсний дараа газрын болон экологийн хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нөхөн төлүүлэх хэлбэрээр концессийн хэлэлцээрийг хүчингүй болгох арга хэмжээг Унгарын талтай харилцан тохиролцох. Цаашид уул уурхайн салбарт байгуулагдах хамтарсан үйлдвэрүүдийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хэлбэрээр хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах чиглэлийг дагнах нь зүйтэй.

Зургаа. Уул уурхайн үйлдвэрлэлийг бүс нутгуудад хөгжүүлэх талаар


2010 он хүртэл бүсүүдэд байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүд, тэдгээрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөөллийг хүснэгт 3 болон зураг 2-т харуулав.

Хүснэгт 3

№	Бүсийн нэр, цогцолбор ба үйлдвэрийн нэр	Шинээр ашиглах орд газар, аймаг, сум	Ашиглалтад оруулах хугацаа	Бүтээгдэхүүний нэр, жилийн хүчин чадал	Бүтээгдэхүүн мөнгөн дүнгээр, сая доллар
1	Төвийн бүс				
1.1	Цагаансуварга-Оюу толгой-Тавантолгойн үйлдвэрийн район Цагаансуваргын катодын зэсийн үйлдвэр	Цагаан суваргын орд*, Дундговь, Мандах	2004 он	5000 тн катодын зэс	7.5
1.2	Оюу толгойн зэс, молебдины үйлдвэр	Оюу толгойн орд, Өмнөговь, Ханбогд	2008 он	30 000 тн катодын зэс	45.0
1.3	Тавантолгойн коксжих нүүрсний уурхай	Тавантолгойн орд*, Өмнөговь, Цогтцэций	2008 он	1000000 тн коксжих нүүрс	35.0
1.4	Зэс хайлуулах үйлдвэр	Дорноговь, Мандах	2010 он	100000 тн цэвэр зэс	150.0
1.5	Бие даасан үйлдвэрүүд Төмөртэйн төмрийн хүдэр олборлож боловсруулах үйлдвэр	Төмөртэйн орд, Сэлэнгэ, Ерөө	2007 он	1 500 000 тн төмрийн баяжуулсан хүдэр	50.6
1.6	Бороогийн алтны үйлдвэр	Бороогийн орд*, Сэлэнгэ, Баянгол	2005 он	1500 кг алт	15.0
1.7	Тосонгийн алтны үйлдвэр	Тосонгийн орд*, Төв, Заамар	2003 он	800 кг алт	8.0
1.8	Тавтын алтны үйлдвэр	Тавтын орд*, Булган, Тэшиг	2005 он	200-400 кг алт	3.0
2	Зүүн бүс				
2.1	Мардай–Цав-Улааны үйлдвэрийн ройон Мардайн ураны хүдэр олборлон баяжуулах үйлдвэр	Мардайн орд Дорнод, Гурванзагал	2006 он	100-200 тн ураны исэл	1.5
2.2	Цавын холимог металлын хүдэр олборлох уурхай	Цавын орд, Дорнод, Чойбалсан	2007 он	100000 тн хүдэр (15 мян.тн цайр баяжмал)	3.5
2.3	Улааны холимог металлын хүдэр олборлон баяжуулах үйлдвэр	Улааны орд, Дорнод, Гурванзагал	2008 он	25000 мян.тн цайр, хар тугалганы баяжмал	4.0
2.4	Бие даасан үйлдвэрүүд Төмөртэйн овооны цайрын хүдэр олборлон баяжуулах үйлдвэр	Төмөртэйн орд*, Сүхбаатар, Баруун-Урт	2004 он	58000 тн цайрын (50%) баяжмал	17.8
3	Хангайн бүс				
3.1	Бүрэнхааны фосфорын үйлдвэр	Бүрэнхаан, Хөвсгөл, Бүрэнтогтох	2008 он	60000 тн фосфорын бордоо	6.6
4	Баруун бүс				
4.1	Асгатын мөнгөний хүдэр олборлон баяжуулах үйлдвэр	Асгатын орд*, Баян-Өлгий, Ногооннуур	2006 он	350 тн хүдэр олборлон 102 тн мөнгө, 3051 тн зэс	25.2
	Бүтээгдэхүүний нийт дүн				**373.2**

Тайлбар :

* -Засгийн газрын үйл ажиллагааны 2001-2004 оны хэтөлбөрт тусгагдсан объектууд


2010 он хүртэл ашиглалтанд орох ордуудын байршил, төсөөлөл
Асгат
Таван Толгой
Цагаан Суврага
Оюут Толгой
Тавт
Бороо
Тосон, Баяжал
Улаан
Цав
Мардай
Төмөртэйн Овоо
Ород
Уурхай
Хот, аймгийн төв
Төмөр зам
Засмал зам
Шороон зам
Зэс хайлуулах үйлдвэр
Уул уурхайн үйлдвэрийн районууд
1- Таван Толгой - Цагаан Суврага - Оюут Толгойн
2- Мардай - Цав - Улааны

Зураг 2

Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмэгдэх хэмжээг бүсүүдээр хүснэгт 4-т харуулав

Хүснэгт 4

Бүсүүд ба бүсэд орж буй аймгууд	Онуудаар, сая доллар		Бүсийн дүн
	2005	2010	
Баруун бүс: Баян-Өлгий*, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	-	25.2	25.2
Хангайн бүс: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл	-	6.6	6.6
Төвийн бүс: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь*, Өмнөговь*, Сэлэнгэ*, Төв	33.5	280.6	314.1
Зүүн бүс: Дорнод*, Сүхбаатар*, Хэнтий	17.8	9.5	27.3

* -үйлдвэр байгуулагдах аймгууд

Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 2 хувилбарыг авч үзэв. Энд нэгдүгээр хувилбарт шинээр байгуулагдах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хүснэгт 3-ын дагуу нийт төсөөлөлд байгаа үйлдвэрүүд тухайн төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох, хоёрдугаар хувилбарт Төвийн бүсэд Төмөртэйн төмрийн хүдрийн үйлдвэр, Зүүн бүсэд Мардайн ураны үйлдвэр, Баруун бүсэ Асгатын мөнгөний үйлдвэрүүд 2010 он гэхэ ашиглалтад орох боломжгүй байхаар тооцоолов Хувилбаруудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлий нэмэгдэх хэмжээг хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5

Хувилбарууд	Бүтээгдэхүүн, сая ам.доллар	
	2005 он	2010 он
1 дүгээр хувилбар	51.3	321.9
2 дугаар хувилбар	51.3	244.6

Бүсүүдийн уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг авч үзвэл төвийн бүсэд зэс, алт, төмрийн үйлдвэрийн районыг 2004-2010 онд зэс хайлуулах үйлдвэртэйгээр төвийн бүсэд, Мардай-Цав-Улааны үйлдвэрийн районыг зүүн бүсэд 2006-2008 онд байгуулахаар тусгав. Мөн Асгатын үйлдвэрийг Баян-Өлгий аймагт 2006 онд, Төмөртэйн үйлдвэрийг Сэлэнгэ аймагт 2007 онд ашиглалтад оруулахаас гадна Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон Тавт, Бороо, Тосон баянголын үйлдвэрүүдийг 2004 онд багтаан ашиглалтад оруулна.

Газар зүйн хувьд ойр орших, шинээр байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүдийг цогцолбор хэлбэрээр авч үзэн нэгдсэн байдлаар дэд бүтцийн хангамж, нийгэм ахуйн байгууламжуудыг төвий болон зөвлөх, туслэмжийн хөрөнгөөр бий болгох н цогцолборт орох үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалть багасгах, удаан хугацаанд дэд бүтцээс шалтгаала ашиглалтад орж чадахгүй байсан орд газруудь үйлдвэрлэлийн аргаар эзэмшихэд чухал дэмжлэ болно.

Иймд Цагаансуварга-Тавантолгой-Оюу толгойн чиглэлд Чойр, Мандалговийн э үүсвэрүүдийн аль нэгээс, Асгатын чиглэлд Баян Өлгийгөөс цахилгаан хангамжийн шугамыг төвий хөрөнгөөр татах арга хэмжээг 2003-2004 он хэрэгжүүлэх.

Томоохон орд, илрэлүүдийг нээх тогтоо өндөр магадлалтай тул бага судлагдсан хилий районуудад геологи хайгуулын ажил явуулж уу уурхайн үйлдвэр байгуулах эрх зүйн орчинг 2002 2003 онд бий болгох. Алслагдсан бүсэд байгуул байгаа үйлдвэрүүдэд тусгай хөнгөлөлт, дэмжлэгий

үзүүлэх нь стратегийн ач холбогдолтой.

Долоо. Уул уурхайн үйлдвэрлэлд байгаль орчны сөрөг нөлөөг багасгах

а/хөрс хуулалт багатай давхрага хэлбэрийн ордууд дээр ажиллаж байгаа ил уурхайнуудад жилийн газрын эвдрэлийн 70 хувьд тэнцэхүйц хэмжээний талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх.

б/усны зарцуулалтын судалгаа нормативыг бий болгон усны бохирдол, зарцуулалт багатай ажилладаг үйлдвэрүүдийг урамшуулах тогтолцоонд орох;

в/хаягдал нөөцийг бүрэн төлэвүүлэх,ашигналтын металл авалтын доод түвшинг ордуудын онцлогт тохируулан бий болгох, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын ажтаар хаягдал ихтэй олборлогч үйлдвэрүүдийг нэгсоох, хаягдал багатай технологи нэвтрүүлэлтэд татварын хөнгөлөлт болон бусад урамшуулал олгох хүрэмд шилжих;

г/уул уурхайн үйлдвэрүүдийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор илүү бодитой нөлөөсрүүлах үнэлгээний ажилд тавигдах техник, технологийн шаардлагыг дээшлүүлэх замаар газрын эвдрэл, орчны бохирдлыг эрс багасгах;

д/ашиглагдаж дууссан ордуудын орчим үүссэн газрын эвдрэл, байгаль орчны бохирдлыг хаягдал нөөц болон тухайн районд байгаа бусад ашигт малтмалын нөөцийн үнэлгээнд улгуурлан нөхөн сэргээх боломжийг тодотгох, оломжгүй тохиолдолд гадаад орнуудын зээл, үсламжаар санхүүжүүлэх арга хэмжээ авах /Ийм айонд Бэрхийн уурхайн орчим болон Хайлааст, олгойтын алтны үйлдвэрүүдийн ашиглаж дуссан рдуудын байгаль орчны асуудал хамаарна/;

е/олборлолтын ажлын үед нөхөн эргээх боломжгүй ордуудын тодорхойлогдсон нөхөн сэргээлтийн ажлын төлбөрийг шилгалтын үед авч хуримтлал үүсгэн ордуудын эөц дууссан үед нөхөн сэргээлтийн ажлыг йцэтгүүлэх хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх аардлагатай. Үүнтэй уялдаатайгаар нөхөн ргээлтийн ажлын норм, үнэлгээг иж бүрдэл олбэрээр боловсруулах шаардлагатай;

ж/Монгол Улсад хэрэглэгдэж байгаа болон шинээр оруулж байгаа орчин үеийн олборлолтын аргуудын /газрын дээр ба дор уусгах арга г.м./ байгаль орчныг хамгаалах стандарт, норм, тэдгээртэй холбогдсон технологийн журам, заавар бий болгох. Энэ асуудалтай уялдан олон талт үйл ажиллагаа бүхий уул уурхайн олборлолт, боловсруулалтын ажлыг цаашид хуульчлах.

Найм. Татвар, хууль эрх зүйн орчны талаархи зорилт, авах арга хэмжээ

Төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газрын лицензэ эзэмшигчидтэй гэрээ байгуулах, хайгуулын ажилд хөрөнгө оруулагчдыг татварын тогтвортой байдлын гэрээндэ хамруулах, үндсэн ордыг ашигласан нөөц ашигласны төлбөрийг бууруулах, лицензэ эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг зохих хуулиудад тусгах. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын багц хуульд хөрөнгө оруулалт, зарим төрлийн ашигт малтмалын олборлолтыг нэмэгдүүлэх, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, дэд бүтцийн барилга байгууламжийг барих болон төвөөс алслагдсан бүс нутагт үйлдвэр байгуулахад татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх зэрэг заалтууд оруулах.

Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, тусгай хамгаалалттай газар нутагт геологи хайгуулын ажил явуулах болон ашигт малтмал ашиглах нөхцөл бүрдүүлэх, улсын хилийн дагуухи районд хайгуулын ажлыг төлөрүүлэх, газрын төлбөрийг ашигт малтмалын төрөл, геологи хайгуулын ажлын онцлогийг харгалзан тогтоодог механизмыг бүрдүүлэх.

Гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн болох алт, зэс, хайлуур жоншны үйлдвэрлэлнь эдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс ихээхэн хамаардаг тул үнийн эрсдэлээс хамгаалах тогтолцоо бий болгох. Иймд дотоодын металлын бирж байгуулах эрх зүйн актыг 2002-2003 онд боловсруулан бирж байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж эхний эолжинд Монголын экспортын бүтээгдэхүүн гаргадаг томоохон уул уурхайн компаниудыг татан оруулах асуудлыг судалж шийдвэрлэх.

Уул уурхайн үйлдвэрлэлийн харилцааг зохицуулах Уул уурхайн тухай хуулийн төсөл

болон ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох үйл ажилагааг зохицуулах хууль, эрх зүйн актыг боловсруулах.

Ес. Баримтлах чиглэлийн хэрэгжилтийн үр дүн

Нэг ба хоёрдугаар хувилбаруудаар уул уурхайн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний хэмжээ ба аж үйлдвэрийн болон дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэх төсөөллийг хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6

Хувилбарууд	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая ам. доллар						Тайлбар
	2005 он			2010 он			
	Уул уурхайн бүтээгдэхүүн	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Уул уурхайн бүтээгдэхүүн	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	Дотоодын нийт бүтээгдэхүүн	
1 дүгээр хувилбар (Уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь)	348.2	642.9 (54,1%)	1651.1 (21,1%)	669.8	1010.6 (66,3%)	2157.3 (31,0%)	1995 оны зэрэгцүүлэх үнээр
2 дугаар хувилбар (Уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь)	348.2	642.9	1651.1	592.5	933.3 (63,5%)	2080.0 (28,5%)	

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 1 дүгээр хувилбараар 2005 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 54 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 21.1 хувийг эзлэх бөгөөд 2010 онд 66.3 ба 31.0 хувьд хүргэх боломжтой юм.

2000 онтой харьцуулахад 2005, 2010 онуудад аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийн 7.9 хувь ба 36.9 хувь (П хувилбарт 31.7 хувь)-ийг, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 3.1 хувь ба 17.3 хувь (14.2)-ийг уул уурхайн шинээр байгуулагдах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнээр хангах болно.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 200 онд бага байгаа нь 2001-2004 онд барьж байгуул буй уул уурхайн үйлдвэрийн ихэнх нь 2005 оноо хойш бүрэн хүчин чадлараа ашиглалтад орохоо хамаарч байна.

* * *

Геологи, уул уурхайн салбарт баримтла энэхүү бодлогын баримт бичгийг 2010 он хүртэ хэрэгжүүлэхээр боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эрхлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 4 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (268)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Мэдээллийн технологийн үндэсний парк байгуулах тухай*
- *Хилийн боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Банкны өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны наймдугаар сарын 19 №31 (268)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

440. Жан Клод Юнкерийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 117 1003

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

441. Зарим хүнийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай Дугаар 104 1004
442. Хөтөлбөр батлах тухай Дугаар 105 1004
443. "Их тэнгэр" цогцолборыг шилжүүлэх тухай Дугаар 106 1009
444. Мэдээллийн технологийн үндэсний парк байгуулах тухай Дугаар 107 1009
445. Хилийн боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 108 1010
446. Банкны өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 109 1011
447. Баруун бүсийн цахилгаан хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 110 1012
448. Хөрөнгө гаргах тухай Дугаар 111 1013
449. О. Дашбалбарын гэр музейг байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай Дугаар 114 1013
450. Ойг тэмдэглэх тухай Дугаар 115 1014
451. Журамд нэмэлт оруулах тухай Дугаар 116 1014
452. Хөрөнгө гаргах тухай Дугаар 117 1014
453. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 118 1014

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

454. Монгол Улсын татварын тухай зарим хуулийн зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Дугаар 100 1019

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2 оны 8 дугаар
ын 1–ний өдөр

Дугаар 117

Улаанбаатар
хот

Жан Клод Юнкерийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Люксембургийн Их Вант Улсын одонгоор шагнасугай.
эсаг харилцааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь
рийг нь үнэлж Люксембургийн Их Вант Улсын
нхий сайд Жан Клод Юнкерийг "Алтан гадас"

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 29–ний өдөр **Дугаар 104** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай

Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ёндонпунцагийн Адилбишийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

2. Гадаадад ажиллах томилолтын хугацаа дууссантай холбогдуулан Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 29–ний өдөр **Дугаар 105** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. "Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт жил бүр тайлагнаж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

Засгийн газрын 2002 оны 105 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ ОРНЫ ХОВОР УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, ЗОХИСТОЙ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол орны нутаг дэвсгэр нь газрын гадаргын хэв шинж, уур амьсгалын онцлогоос хамааран хөрсөн бүрхэвч, амьтан, ургамлын зүйлийн бүрэлдэхүүнээрээ өөр хоорондоо эрс ялгаатай өндөр уул, уулын тайга, ойт хээрийн бүслүүр, хуурай хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүс гэсэн үндсэн зургаан ургамал, газар зүйн бүс, бүслүүрт хуваагддаг. Эдгээр бүс, бүслүүрийн ургамлын аймгийн зүйлийн бүрэлдэхүүн, амьдралын хэлбэр, гарал үүсэл, өсөлт, хөгжилт нь экологийн хувьд хаана ч давтагдашгүй өвөрмөц онцлогтой бөгөөд тэдгээрийн дотор зөвхөн Монгол, Төв Ази төдийгүй дэлхийн хэмжээний нэн ховор, ховор ургамал ч бий. Манай орны ургамлын аймгийн түүхэн хөгжлийн онцлог, байгаль цаг уурын өөрчлөлт, хүний олон талын зохисгүй үйл ажиллагааны улмаас ховор ургамлын тархацын хүрээ хумигдан, нөөц нь жилээс жилд хомсдож байна. Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын байгалийн ургамал ашиглах үйл ажиллагаа улам идэвхжин Улаан номонд бүртгэгдсэн эмийн ба хүнсний түүхий эдийн ургамал, бүх төрлийн жимс, жимсгэнийг байгалиас нь шууд түүж худалдан борлуулж байгаа нь ховор ургамлын нөхөн сэргэлт, хамгаалалт, ашиглалтад сергөөр нөлөөлж хууль тогтоомж зөрчигдөж байна. Ховор гоц ашигт ургамлыг зохистой ашиглах үйл ажиллагаанд холбогдох ямад, нутгийн захиргаани

Байгууллагуудаас тавих хяналт, ажлын уялдаа холбоо сул байгаагийн зэрэгцээгээр байгаль орчны төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоо хангалтгүй байна. Үүнээс шалтгаалан ургамлын нөөцөгийн унаган төрх алдагдаж, нөөц, тархац, нүүлийн бүрдэл хомсдон, нөхөн сэргэлт нь удааширсаар байна. Байгалийнхаа түүхэн гарал, нүсэл, уур амьсгал, орчин зүйгээс хамаарч унаган нутагтаа ховор тархацтай олон зүйл ургамал эрс хомсдож, улмаар устах хандлагатай боллоо.

Монгол Улсын төр, засгаас биологийн төрөл зүйлийг хамгаалах, тэдгээрийн амьдрах орчны доройтлыг хязгаарлах, нөөцийг зохистой ашиглахад чиглэгдсэн дэс дараатай арга хэмжээ авч ирсэн. Түхайлбал Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай зуулиуд 1995 оноос батлагдан мөрдөгдөж байгаа өгөөд устах аюулд орсон, ховордсон ургамлын архац нутгийн 40 орчим хувийг улсын тусгай амгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулав.

Гэвч манай улсын байгалийн ургамлын үнэ энэ улам бүр өсөн нэмэгдэж байгаа өнөө үед эдгээрийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн эргээх цэгцтэй бодлого, үйл ажиллагаа үгүйлэгдэж айна. Монгол Улс Зэрлэг амьтан ба ургамлын йгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд удалдаалах тухай Вашингтоны конвенци, иологийн төрөл зүйлийн тухай НҮБ-ын конвенциор үлээсэн үүргээ хэрэгжүүлж устах аюулд орсон а цаашид тийм заналхийлэлд ертөгдөж болзошгүй, угуул нутагтаа оршин амьдрахад харшлахаар шиглагдаж байгаа ургамлын зүйлүүдэд онцгой нхаарах шаардлагатай байна. Ховор ургамлыг эмгаалах үйлсэд байгалийн баялгаас хүртэж, ашиг рлого олдог аж ахуйн нэгжийн болон амьдралаа алгуулдаг нутгийн уугуул иргэдийн оролцоог эмэгдүүлж, ашиглагч нь хамгаалдаг зарчмыг эвтрүүлэх явдал чухал ач холбогдолтойг бусад ны туршлага харуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2000-2004 ны үйл ажиллагааны хөтөлбөрт ховор, нэн ховор мьтан, ургамлыг хамгаалах, өсгөн үржүүлэх алаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын үрээнд энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын үнэт баялаг болох ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн зорилт, арга хэмжээг тодорхойлон, биологийн төрөл зүйл хомсдох аюулаас сэргийлж, түүний шалтгааныг арилгах замаар экологийн тэнцлийг хангах, улмаар улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг хангах үүднээс дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

2.1.Ховор ургамлыг хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;

2.2.Ховор ургамлын тархац нутаг, удмын сан хамгаалах;

2.3.Ховор ургамлын бүртгэл, мэдээлэл-хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх;

2.4.Ховор ургамлыг зохистой ашиглах;

2.5.Ховор ургамлыг нөхөн сэргээх арга хэмжээ авах;

2.6.Ховор ургамлыг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Уг хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1. Ховор ургамлыг хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилтын хүрээнд:

3.1.1. байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, ховор ургамлын жагсаалтыг шинэчлэх;

3.1.2. ховор ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр

ургамал ашигласны төлбөрийг шинэчлэх;

3.1.3. ховор ургамлыг ашиглах тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн журам, дүрмийг боловсруулан мөрдүүлэх;

3.1.4. ховор ургамлыг хамгаалах харилцааг бусад холбогдох хуулиудад тусгах;

3.1.5. "Зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай" олон улсын конвенцийн шаардлагад нийцүүлэн устах аюулд орсон ховор, ховордсон төрөл зүйлийн тухай үндэсний хуулийг боловсруулах;

3.1.6. биоаюулгүй байдлыг хангах Картагений протоколд Монгол Улс нэгдэн орох.

3.2.Ховор ургамлын тархац нутаг, удмын санг хамгаалах зорилтын хүрээнд:

3.2.1. ховор ургамлын тархац нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах;

3.2.2. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд ховор ургамлын хамгаалалт, ашиглалтын асуудлыг тусгайлан оруулах;

3.2.3. ховор ургамлын тархац нутгийг иргэн, аж ахуйн нэгжид удаан хугацаагаар эзэмшүүлэн хамгаалуулах, нөөц баялгийг нь хүртээх замаар тэдгээрийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх;

3.2.4. монгол орны ховор ургамлын генийн нөөцийг тогтоох, биотехнологийн ач холбогдлыг судлах;

3.2.5.Ховор ургамлын генийн сан байгуулах.

3.3. Ховор ургамлын бүртгэл, мэдээлэл-хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх хүрээнд:

3.3.1. монгол орны ургамлын ховор, гоц ашигтай зүйлүүд, тэдгээрийн ангилал, тархалт, нөөцийг нарийвчлан тогтоох;

3.3.2. ховор ургамалд учирч буй хор хөнөөлийг судлах, түүнийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах;

3.3.4. ховордож байгаа, устаж болзошгүй зүйлүүдийн талаархи судалгааны ажлын үр дүн мэдээ баримтыг нэгтгэн дүгнэх, ном бүтээл туурвих;

3.3.5. монгол орны ховордсон ургамлын мэдээллийн сан байгуулах;

3.3.6. орчны хяналт-шинжилгээний сүлжээний хүрээнд ховор ургамлын тархалт амьдрах орчны мониторингийн хөтөлбөр боловсруулах.

3.4. Ховор ургамлыг зохистой ашиглах зорилтын хүрээнд:

3.4.1. ховор, ашиг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэх;

3.4.2. ховор ургамлыг ашиглахтай холбогдсон төслүүдийг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд бүрэн хамруулах;

3.4.3. чухал ач холбогдол бүхий нөөц багатай ховордсон ургамлыг зориудаар өсгөх үржүүлэх, ашиглах эрх зүй, эдийн засгийн урамшууллын механизмыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад нэвтрүүлэх;

3.4.4. ховор ургамлын ашиглалт хамгаалалтад тавих төр, олон нийтийн хяналтыг сайжруулах;

3.4.5. ховор ургамал, түүний гаралтай түүхий эдийг хаягдалгүй, бохирдолгүй дэвшил арга технологиор иж бүрэн боловсруулах, экологийн цэвэр үйлдвэрлэлийг дэмжих.

3.5. Ховор ургамлыг нөхөн сэргээх зорилтын хүрээнд:

3.5.1. ховор ургамлыг тарималжуулах

ориудаар өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн селекци, үршилтын ажлыг зохион байгуулж, биотехнологийн олтыг нэвтрүүлэх;

3.5.2. байгалийн нөхөн үргалтыг дэмжих амаар ховор ашигт үргамлыг амьдрах орчинд нь өхөн сэргээх;

3.5.3. гадаадын гаралтай зарим ашигт ргамлыг плантацын нөхцөлд тарьж үргуулах, алгаруулах;

3.5.4. ховор үргамлын цуглуулга хийх, енофондын зориулалттай цэцэрлэг, дендрари айгуулах;

3.5.5. ховор, ховордсон үргамлыг ой, эрийн түймэр, өвчин хортон ба элдэв хөнөөгчдөөс амгаалах арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх.

3.6.Ховор үргамлыг хамгаалахад олон йтийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.6.1. ховор ашигт үргамлыг хамгаалах, ртагчлах талаар нийтийг хамарсан өдрүүдийг ал бүр зохион байгуулж, уламжлал болгох;

3.6.2. байгалийн ховор үргамлыг таних лбарчилсан заавар, зөвлөмжийг боловсруулж, йтийн хүртээл болгох;

3.6.3. байгалийн үргамлын түүхий эдийг элтгэх, тарималжуулах агро удирдамж ловсруулах, ховор ашигт үргамлын талаар ном, део кино, өнгөт альбом хэвлүүлэх;

3.6.4. тусгай хамгаалалттай газар нутгуудыг шиглэн олон нийтэд экологийн боловсрол олгох, огалт, сурталчилгааг зохион байгуулах;

3.6.5. ховор ашигт үргамлыг хамгаалах, өхөн сэргээх, тарималжуулах үйлсэд төрийн бус йгууллага, иргэдийг татан оролцуулж, шинээр лын байр бий болгох, улмаар ядуурлыг груулахад дэмжлэг үзүүлэх;

3.6.6. иргэдийн үүсгэл санаачилга дээр гуурлан нийслэл, аймгийн төвүүдэд ховор үргамлын цэцэрлэгт хүрээлэн, үржүүлгийн газар байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг дараахь үе шатаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шатыг 2002-2005 онд
Хоёрдугаар үе шатыг 2006-2010 онд.

4.2. Монгол орны ховор үргамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд удирдан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана.

4.3. Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг улс орны нийгэм-эдийн засгийн бодлого, "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөр, "Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр" болон байгаль орчны бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан цогцолбор байдлаар хэрэгжүүлнэ.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын оролцоонд тулгуурлана.

4.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Үндэсний зөвлөл, Байгаль орчны яамны сайдын зөвлөлийн хуралдаанаар жил бүр хэлэлцэж, Засгийн газарт танилцуулж байна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1.Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

5.1.2. улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.1.3. байгаль хамгаалах сан;

5.1.4. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;

5.1.5. бусад эх үүсвэр.

Зургаа. Үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

6.1.1. монгол орны нэн ховор, ховор ашигт ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх таатай орчин бүрдэж, экологийн тэнцвэрт байдал хадгалагдана;

6.1.2. байгалийн ургамлыг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, биологийн төрөл зүйлийг хамгаалах болон бусад олон улсын конвенциор хүлээсэн үүрэг хэрэгжинэ;

6.1.3. ховор ургамлын цэцэрлэгт хүрээлэн, генийн сан байгуулагдаж, нэн ховор, ховор, улаан номонд бүртгэгдсэн ургамлаас 300 гаруй зүйлийг нөхөн сэргээж орон нутгийн болон улсын хамгаалалтад авна;

6.1.4. хуурайшилт, цөлжилт, хөрсний эвдрэлээс хамгаалах зорилгоор гадаадын болон өөрийн орны ганд тэсвэртэй, элс бэхжүүлэгч мод, сөөг, өвслег ургамлыг тарималжуулж ойн зурвасууд байгуулна;

6.1.5. ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглахад чиглэгдсэн эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн уялдаа холбоо сайжирч, судалгааны ажлын үр дүн практикт нэвтэрнэ;

6.1.6. ховор ургамлын мэдээллийн сан бүрдэж, холбогдох ном бүтээл, эвлэмж, зааварт, аргачлал, гэрэл зураг, видео кино нийтийн хүртээл болно;

6.1.7. ургамлыг хамгаалж, нөхөн сэргээж, тарималжуулж ашигласнаар айл өрхийн амьжиргааны түвшин дээшилж, ажлын байр нэмэгдэнэ;

6.1.8. ховор ашигт ургамлыг хамгаалах үйлсэд бүх нийтийн оролцоо нэмэгдэж, иргэдийн экологийн боловсрол дээшилнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд

7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуураар дүгнэнэ:

7.1.1. тухайн ургамлын нөөц, тархацын хүрээ тоо ширхэг, ургац хэр зэрэг нэмэгдсэн;

7.1.2. ховор ургамлыг хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, заавруud батлагдсан эсэх;

7.1.3. ховор ургамлын нөөц хомстсон газрыг нөхөн сэргээсэн байдал, талбайн хэмжээ, арга технологи;

7.1.4. ховор ургамлыг хамгаалах зорилгоор байгуулсан үржүүлгийн газар, цэцэрлэг хүрээлэнгийн тоо, хэмжээ;

7.1.5. ховор ургамал тархсан газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулсан хувь, хэмжээ;

7.1.6. ховор ургамлыг зохистой ашиглах тарималжуулах ажилд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн ажлын байр;

7.1.7. өмнөх үетэй харьцуулахад ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах талаар хэрэгжсэн төслүүдийн тоо, хэвлүүлсэн бүтээл гарсан үр дүн;

7.1.8. тухайн ургамлыг орон нутгийн хамгаалалтад авсан байдал;

7.1.9. иргэдийн байгальтай харьцах соёл ухамсар, мэдлэг боловсрол дээшилсэн байдал;

7.1.10. үндэсний аюулгүй байдлыг хангаж буй байдал, нийгмийн хөгжлийн хурдцад аль хэ нөлөөлсөн.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

002 оны 5 дугаар Улаанбаатар
арын 29–ний өдөр Дугаар 106 хот

"Их тэнгэр" цогцолборыг шилжүүлэх тухай

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн зраас ТОГТООХ нь:

1. Дор дурдсан объектыг 2002 оны 6 дугаар арын 15-ны өдрөөр тасалбар болгон Төрийн тусгай амгаалалтын газарт балансаас балансад шилжүүлэхийг Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг ахлэх газар /Ж.БАДРАА/-т даалгасугай:

а/"Их тэнгэр" цогцолбор /бүхэлд нь/;

б/Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг ахлэх газрын шууд харьяанд байгаа энэ тогтоолын авсралтад дурдсан объектууд.

2. Цаашид төсөв хэмнэж,зардал имдруулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц болон холбогдох бусад объектыг Богд уулын Бага тэнгэрийн аманд барьж байгуулах, хүнсний болон ахуйн хэрэглээний бусад эд зүйлийг бэлтгэн нийлүүлэх лабораторийн үйл ажиллагаат сэргээхэд шаардагдах төсөв, зардлын тооцоо, судалгаат хийж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Тагнуулын ерөнхий газар /М.БАТСАЙХАН/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2002 оны 106 дугаар тогтоолын хавсралт

ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, АЖ АХУЙГ ЭРХЛЭХ ГАЗРААС ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ ОБЪЕКТЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн өргөө (30-ийн 1 дүгээр байр).

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зуны өргөө (50-ийн 5 дугаар байр).

3. Зочид буудал (30 дугаар байр)

4. Их тэнгэр дахь 2 айлын орон сууц.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

02 оны 5 дугаар Улаанбаатар
рын 29–ний өдөр Дугаар 107 хот

Мэдээллийн технологийн үндэсний парк байгуулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 13 дугаар зүйлийн дэх хэсгийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын сгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэдээллийн орчин үеийн, өндөр хурдтай ажээ байгуулах болон шинээр үйл ажиллагаа элэн явуулж байгаа мэдээллийн компаниудад хуваторын орчин бүрдүүлэх, шинжлэх ухаан, ехнологийн мэдээллийн суурь, сан байгуулж ийлгээ үзүүлэх үүрэг бүхий Мэдээллийн технологийн үндэсний паркийг 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн байгуулж шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпорацийн хэлбэрээр ажиллуулсугай.

2. Мэдээллийн технологийн үндэсний парк байгуулсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорацийг 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, эзэмшиж байсан байр, тоног төхөөрөмж,

эд хөрөнгийг Мэдээллийн технологийн үндэсний паркийн мэдэлд шилжүүлсүгэй.

3. Мэдээллийн технологийн үндэсний паркийн дүрмийг Мэдээлэл, холбооны технологийн үндэсний хорооны саналыг авсны үндсэн дээр батална мөрдүүлэн, үйл ажиллагааг нь байгуйн хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

4. Мэдээллийн технологийн үндэсний паркийн байрны ашиглалтын зардалд зориулж 80.0 (наян) сая төгрөгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

5. Мэдээллийн технологийн үндэсний паркийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, өндөр хурдтай сүлжээ байгуулах хөрөнгө оруулалтын зардлыг гадаад орон, олон улсын байгуулагаас олгож байгаа бүцалтгүй тусламжийн хөрөнгөөс санхүүжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоолын хавсралтын "Б"-гийн 5-д "Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци" гэснийг "Мэдээллийн технологийн үндэсний парк" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 3-ны өдөр **Дугаар 108** **Улаанбаатар хот**

Хилийн боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын уялдаа холбоог хангах, хүнд суртал, чирэгдлийг багасгах зорилгоор Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн тухай хууль дээрх дагуу Монгол Улсын хилийн боомтод зөвхөн хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх алба, хилийн эрүүл ахуй, халдвар судлалын чиглэлийн алба, гаалийн байгууллагыг ажиллуулсугай.

2. Монгол Улсын хилийн боомтод хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа эрхлэх байгаа Эрүүл мэндийн улсын хяналтын алба, Мал эмнэлэг, ариун цэврийн улсын хяналтын алба, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн албад болон тэдгээрийн лабораториудыг нэгтгэн "Нэг цэгийн үйлчилгээ"-ний зарчимд шилжүүлэн журамласугай.

3. "Нэг цэгийн үйлчилгээ"-ний зарчмаар ажиллах болсонтой холбогдуулан улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээвэрийн хэрэгсэлд ногдуулж байгаа татвар, хураамжийг гаалийн байгууллагаар дамжуулан хураах, улсын төсөвт төвлөрүүлэх байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бараа тээвэрийн хэрэгсэл болон импортын барааны эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналт, стандарт, чанарын баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн талаар мөрдөж байгаа шийдвэрүүдийг 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөр хүчингүй болгохыг холбогдох сайд нарт, цаашид мөрдөх төлбөр, хураамжийн хэмжээг нэгдсэн байдлаар тогтоож мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тушаалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

килийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 3–ны өдөр | Дугаар 109 | Улаанбаатар хот

Банкны өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Банкны өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Татан буугдсан, дампуурсан банк болон Банкны өр барагдуулах газраас аж ахуйн эргэж, байгуулагдаж, иргэдийн зээлийн өрийг өлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу гарсан шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг 2002 оны 7 улиралд багтаан Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газарт шилжүүлж, тэдгээрийн дагуу барагдуулах зээлийн төлбөр тооцоо хийх, иймээс судалгаа гаргах, барагдуулсан зээлийн өрийг илсын төсөвт төвлөрүүлэх журам тогтоож ердүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, хуль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт аалгасугай.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага ээр алга болсон шүүхийн шийдвэр, гүйцэтгэх удсыг нөхөн гаргуулах талаар арга хэмжээ авахыг хуль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид аалгасугай.

3. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд аалгах нь:

а/шүүхийн шийдвэрээр үчингүй болсон 117 зээлдэгчийн 615.145.924,98 (нэг төрбум зургаан зуун арван ван сая нэг зуун дөчин таван мянга есөн зуун хорин рвөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн зээлийн ийг Банкны өр барагдуулах газрын тайлан нцлээс хасч тооцсугай;

б/нас барсан 147 элдэгчид холбогдох 629.717.588,59 (зургаан зуун хорин есөн сая долоон зуун арван долоон мянга таван зуун наян найман төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн зээлийн өр, татан буугдсан болон дампуурсан банкнаас Банкны өр барагдуулах газарт үндсэн зээлийн материалгүй жагсаалтаар шилжиж ирсэн 59 зээлдэгчийн 259.474.955,0 (хоёр зуун тавин есөн сая дөрвөн зуун далан дөрвөн мянга есөн зуун тавин таван) төгрөгийн зээлийн өрийг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлсүгэй.

4. Дарханы Хар төмөрлегийн үйлдвэрийн 836.4 (найман зуун гучин зургаан сая дөрвөн зуун мянган) сая төгрөгийн, Багахангайн Махны үйлдвэрийн 1.4 (нэг төрбум дөрвөн зуун сая) төрбум төгрөгийн, Хөтөлийн "Ган" үйлдвэрийн 13.1 (арван гурван сая нэг зуун мянган) сая төгрөгийн зээлийн өрийг Банкны өр барагдуулах газрын тайлан тэнцлээс хасч, тухайн аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн тайлан тэнцэлд нь тусгах замаар шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд үүрэг болгосугай.

5. Банкны өр барагдуулах газрын авлагын дансанд бүртгэлтэй 2.4 (хоёр төрбум дөрвөн зуун сая) төрбум төгрөгийн үнэ бүхий Ардын банкны барилгыг Банкны өр барагдуулах газрын тайлан тэнцлээс хасч Нийслэлийн өмчийн газарт холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ), Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод зөвшөөрсүгэй.

6. "Чингис хаан" зочид буудлын цогцолборын барилгатай холбоотой захиргаадалтын зээлийн өрийг хувьцаагаар солих асуудлыг судалж шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд

Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

7. Банкны өр барагдуулах газрыг 2002 оны П улиралд багтаан төрийн өмчит үйлдвэрийн газар болгон зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 110** **Улаанбаатар хот**

Баруун бүсийн цахилгаан хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн цахилгаан шугам сүлжээний газруудын хэрэглээний бүтэц өөрчлөгдсөнөөс үүссэн алдагдлын 50.0 хувь болон норматив хэмжээнд ногдох шугамын алдагдлаас шалтгаалж гарсан 2001 оны алдагдал нийт 300.6 (гурван зуун сая зургаан зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн цахилгаан шугам сүлжээний газруудын алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэхийг зогсоож, тэднийг Эрчим хүчний тухай хуулийн дагуу зах зээлийн горимоор ажиллуулах арга хэмжээ авахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

3. Цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрийг бүрэн хурааж авах, борлуулалт, төлбөр тооцооны дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах замаар техникийн бус алдагдал гаргах явдлыг багасгах арга хэмжээ авахыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн цахилгаан шугам сүлжээний газрууд болон "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалтыг оновчтой сонгож боловсронгуй болгох асуудлыг хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ), дээрх аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Эрчим хүчний салбарын ажилтнуудын одоогийн мөрдөж байгаа цалин хөлс, олговор, хөнгөлөлт, шагнал урамшууллыг Хөдөлмөрийн хууль тогтоомжийн нийцүүлэн үйлдвэрлэлийн үр ашигтай нөхцөлд уялдуулах замаар хянаж үзэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

6. Эрчим хүчний компаниудын үйл ажиллагааны тайлан, тэдгээрийн гүйцэтгэл, захиралтай байгуулсан гэрээг дүгнэхдээ үр ашгийн үзүүлэлтийг тэргүүн ээлжинд харгалзан үзэх, өөрсдийн үйл ажиллагаанаа

шалтгаалж өртөг зардал, өр авлагаа нэмэгдүүлэн алдагдалтай ажилласан компанийн удирдлагатай хариуцлага тооцож байх, Төлөөлөн удирдах болон Хяналтын зөвлөлийн ажлын үр дүнд хяналт тавьж, үйл ажиллагааг нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 111 | Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монголын ахмадын байгууллагын 4 дүгээр чуулганыг зохион байгуулах арга хэмжээнд зориулан 5.0 (таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 114 | Улаанбаатар хот

О.Дашбалбарын гэр музейг байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн шагналт яруу найрагч О.Дашбалбарын гэр музейг Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд байгуулах, түүнд зориулж эд өлгийн зүйл, үзмэр цуглуулахад шаардагдах 10.0 (арван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Цаашид гэр музейн үйл ажиллагааг ивээн этгэгч, хандивлагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламжид тулгуурлан зохион байгуулж хяналт тавин ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга Т.Дашсүрэнд үүрэг болгосугай.

3. О.Дашбалбарын бүтээлийг хэвлүүлэхэд шаардагдах 5.0 (таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч, бүтээлийг нь хэвлүүлэх ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 10–ны өдөр | **Дугаар 115** | **Улаанбаатар хот**

Ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улс ЮНЕСКО-д элссэний 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ болон ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Коичиро Мацуурагийн Монгол Улсад хийх албан ёсны айлчлалын зардалд шаардагдах 15795.4 (арван таван сая долоон зуун ерэн таван мянга дөрвөн зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 10–ны өдөр | **Дугаар 116** | **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт оруулах тухай

"Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 17 дугаар зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

өгүүлбэр, мөн журмын 1.4.4-т "Шинийн нэгний морин цагт морин хуурын хөндөгтэлийн тоглолтыг үндэсний радио, телевизээр давтан нэвтрүүлнэ" гэсэн 2 дахь хэсэг тус тус нэмсүгэй.

Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Төрийн ёслолын журам"-ын 1.4.2-т "Ерөнхийлөгчийг үг хэлсний дараа морин хуурын хөндөгтэлийн тоглолтыг нэвтрүүлнэ" гэсэн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А. ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 10–ны өдөр | **Дугаар 117** | **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Чингис хаан мэндэлсний 840 жилийн ойг 2002 онд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 217.6 (хоёр зуун арван долоон сая зургаан зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А. ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 10–ны өдөр | **Дугаар 118** | **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын

23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор батлагдсан "Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт"-т дор дурдсан нэмэлт оруулсугай:

40 Дурсгалын нэр: ЯМАНТАКА /ЖИГЖИД/
Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Танка. /Шороон будаг/
Хэмжээ: 155 x 177 см.
Фондын дугаар: 2-305

41 Дурсгалын нэр: ЦОГДОГМАРАВ /ГАНЕШ/
Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
Бүтээсэн он цаг: XIX зууны сүүлч XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Танка. /Шороон будаг/
Хэмжээ: 61 x 46 см. 154 x 168 см.
Фондын дугаар: 2-170

42 Дурсгалын нэр: ЛАМ ЛУВСАНДЭНДЭВИЙН ХӨРӨГ
Зохиогч: Б. Шарав
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Хөрөг зураг.
Хэмжээ: 59 x 81 см.
Фондын дугаар: 7-209/1/

43 Дурсгалын нэр: ЛАМ ЛУВСАНЦЭРЭНГИЙН ХӨРӨГ
Зохиогч: Б. Шарав
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Хөрөг зураг.
Хэмжээ: 59 x 81 см.
Фондын дугаар: 7-209/2/

44 Дурсгалын нэр:
ВАЖРАВАРАХИ /ДОРЖПАГМА/
Зохиогч: Хүрээний зураач Тавхай, уран хатгамалч Долгорсүрэн нар
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Зээгт наамал. /Торго, хоргой/
Хэмжээ: 200 x 370 см. 174 x 121 см.
Фондын дугаар: 3-4

45 Дурсгалын нэр:
ДАМДИНДОРЛИГ /ДАНЖИНДОРЛИГ/
Зохиогч: Нэр үл мэдэгдэх хатгамалч
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Зээгт наамал. /Торго, хоргой/
Хэмжээ: 328 x 178 см.
Фондын дугаар: 3-90

46 Дурсгалын нэр:
ХАТАН ДОНДОГДУЛАМЫН ХҮРЭМ
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Өмсгэл хувцас.
Хэмжээ: 74 x 64 см.
Фондын дугаар: 6-2

147 Дурсгалын нэр:
ХАТАН ДОНДОГДУЛАМЫН ХАНЖААР
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Өмсгэл хувцас.
Хэмжээ: 74 x 64 см.
Фондын дугаар: 6-10 /2/

148 Дурсгалын нэр: ХАТАН ДОНДОГДУЛАМЫН ДЭЭЛ
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Өмсгэл хувцас.
Хэмжээ: 143 x 73 см.
Фондын дугаар: 6-106 /1/

149 Дурсгалын нэр:
ХАТАН ДОНДОГДУЛАМЫН МАЛГАЙ /ЗҮНЬ/
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Толгойн өмсгэл.
Хэмжээ: Дм –38 см.
Фондын дугаар: 6-59

150 Дурсгалын нэр: VIII БОГДЫН ХАНТААЗ
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Өмсгэл хувцас
Хэмжээ: 62 x 64 см.
Фондын дугаар: 6-3 /31/

151 Дурсгалын нэр: VIII БОГДЫН ХАНЖААР
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гадуур өмсгэл хувцас.
Хэмжээ: 70 x 62 см.
Фондын дугаар: 6-10 /1/

152 Дурсгалын нэр: VIII БОГДЫН МОРИН ХҮРЭМ
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: 1912 он
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гадуур өмсгэл

/Алтан утастай/
Хэмжээ: 70 x 62 см.
Фондын дугаар: 6-21

153 Дурсгалын нэр: VIII БОГДЫН ДЭЭЛ
Зохиогч: Ордны уран үйлчид
Бүтээсэн он цаг: 1912 он
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гадуур өмсгөл /Хавар, намрын/
Хэмжээ: 143 x 72 см.
Фондын дугаар: 6-17

154 Дурсгалын нэр: ЗАНАБАЗАРЫН МАЛГАЙ
Зохиогч: Нэр үл мэдэгдэх
Бүтээсэн он цаг: XVII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Толгойн өмсгөл
Хэмжээ: Дм- 44 см.
Фондын дугаар: 6-61 155.156
155.156 Дурсгалын нэр: АВИД
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал
Хэмжээ: Өндөр 20 см.
Фондын дугаар: 1-94 /1/ 1-94 /2/

157. Дурсгалын нэр: ДОРЖСЭМБЭ
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал
Хэмжээ: Өндөр 40 см.
Фондын дугаар: 1-92 /1030/

158. Дурсгалын нэр: АЮУШ /Амитаюс/
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Богд хааны ордон музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал
Хэмжээ: Өндөр 24 см, өргөн 26 см.
Фондын дугаар: 1-47 /1/

159. Дурсгалын нэр: ЦАГААН ДАРЬ ЭХ
Зохиогч: Г. Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVII зуун
Хаана хадгалагдаж буй: Чойжинламын сүмийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгуур, алт шармал
Хэмжээ: 41 x 27 x 18 см.

Фондын дугаар: 72-267

160. Дурсгалын нэр: МАЙДАР /БОСОО/
Зохиогч: Г. Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVII зуун
Хаана хадгалагдаж буй: Чойжинламын сүмийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгуур, алт шармал
Хэмжээ: 73 x 22 x 22см
Фондын дугаар: 61-251

161. Дурсгалын нэр: МИНТҮГ
Зохиогч: Г.Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XҮП зуун
Хаана хадгалагдаж буй: Чойжинламын сүмийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгуур, алт шармал
Хэмжээ: 35 x 20 x 20 см
Фондын дугаар: 71-268

162. Дурсгалын нэр: БОСОО МАНЗШИР
Зохиогч: Г.Занабазар (1635-1724)
Хэдийд бүтээгдсэн: XҮП зуун
Хадгалагдаж буй газар: Дурлэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал
Хэмжээ: 58,8x19,5x19,5 см, жин-13300 гр
Дансны дугаар: 73-686

163 Дурсгалын нэр: БУРХАН БАГШ
Зохиогч: Г. Занабазар (1635-1724
Хэдийд бүтээгдсэн: XҮIII зуун
Хадгалагдаж буй газар: Дурлэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал
Хэмжээ: 22,5 x 16,5 x 12 см, жин-2900гр
Дансны дугаар: 5810-00

164. Дурсгалын нэр: АЮУШ
Зохиогч: Г. Занабазар (1635-1724)
Хэдийд бүтээгдсэн: XҮII зууны сүүл үе
Хадгалагдаж буй газар: Дурлэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Хүрэл цутгамал, алт шармал
Хэмжээ: 20,4 x 12,6 x 8,5 см, жин-1420 гр
Дансны дугаар: 1260-1078

165.166 Дурсгалын нэр: ЧАГШ ЖАНРАЙСИГ
Зохиогч: Г. Занабазар (1635-1724

Хэдийд бүтээгдсэн: XYII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Хүрэл цуттамал, алт шармал
Хэмжээ: 29,8х14,9х12 см, жин-3.6 кг 32.8 х 21.5 х 15 см жин- 6.7кг
Дансны дугаар: 1849-854 8160-2994

67. **Дурсгалын нэр:** ДУНШИГИЙН БУРХАН
Зохиогч: Г. Занабазар (1635-1724)
Хэдийд бүтээгдсэн: XYII зууны сүүл үе
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Хүрэл цуттамал, алт шармал
Хэмжээ: 14,5х 10,6х 6,5 см, жин-650 гр
Дансны дугаар: 2227-594

68. **Дурсгалын нэр:** МАНЗУШИР
Зохиогч: Г. Занабазар (1635-1724)
Хэдийд бүтээгдсэн: XYII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Гууль цуттамал, алт шармал
Хэмжээ: 20.6 х 13 х 8.6 см
Дансны дугаар: 1854-753

69. **Дурсгалын нэр:** НОГООН ДАРЬ ЭХ
Зохиогч: Г. Занабазар (1635-1724)
Хэдийд бүтээгдсэн: XYII зууны сүүл үе
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Хүрэл цуттамал, алт шармал
Хэмжээ: 203х13,2х8,7см жин-1495 гр
Дансны дугаар: 8479-3173

70. **Дурсгалын нэр:** ЗАНАБАЗАРЫН ХӨРӨГ
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх
Хэдийд бүтээгдсэн: XYII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Танка зураг. Шороон будаг.
Хэмжээ: 72 х 54,5 см
Дансны дугаар: 60-740

71. **Дурсгалын нэр:** ХАНДЖАМЦЫН ХӨРӨГ
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх
Хэдийд бүтээгдсэн: XYII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Танка зураг. Шороон будаг.
Хэмжээ: 52,5 х 38 см
Дансны дугаар: 61-741

172. **Дурсгалын нэр:** НАМСРАЙ
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд
Хэдийд бүтээгдсэн: XIX зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Танка зураг, даавуу, шороон будаг
Хэмжээ: 156,5 х 119,5 см
Дансны дугаар: 114-659

173. **Дурсгалын нэр:** НУУЦ ХАЯНХИРВАА
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд
Хэдийд бүтээгдсэн: XIX зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Даавуу, шороон будаг.
Хэмжээ: 203,7 х 152 см
Дансны дугаар: 120-670

174. **Дурсгалын нэр:** САНГИЙН БОЙПОР
Зохиогч: Ерэнтэй дархан
Хэдийд бүтээгдсэн: XIX зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Мөнгө.
Хэмжээ: 14 х 19 см
Дансны дугаар: 118-618

175. **Дурсгалын нэр:** ХЭТ ХУТГА
Зохиогч: Дэмбэрэл дархан
Хэдийд бүтээгдсэн: XIX зууны II хагас
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Төмөр /ган/, мөнгө, яс.
Дансны дугаар: 206-1404

176. **Дурсгалын нэр:** ТӨВДИЙН ЛХАС ХОТ
Зохиогч: Б. Шарав
Хэдийд бүтээгдсэн: XX зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Уран зураг /Даавуу, шороон будаг/
Хэмжээ: 166 х 126.5 см
Дансны дугаар: 190-763

177. **Дурсгалын нэр:** VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТ
Зохиогч: Б. Шарав
Хэдийд бүтээгдсэн: XX зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей

Дурсгалын шинж байдал: Уран зураг /Даавуу, шороон будаг/
Хэмжээ: 112.2 x 82.5 см
Дансны дугаар: 194-762

178. Дурсгалын нэр: ХАНД ЧОЙЖИН
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал.
Хэмжээ: 26 x 12 x 12 см.
Фондын дугаар: 1/65

179. Дурсгалын нэр: ХАЯНХИРВАА
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал.
Хэмжээ: 19.4 x 10 x 25.5 см.
Фондын дугаар: 1/11

180. Дурсгалын нэр: СУДАР БАРЬСАН ЛАМ
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал.
Хэмжээ: 22,5 x 18,7 x 12,3 см.
Фондын дугаар: 1/12

181. Дурсгалын нэр: ЖИЙЦЭГМАА
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал
Хэмжээ: 15,5 x 11,5 x 9,3 см.
Фондын дугаар: 4/33

182. Дурсгалын нэр: БОГД ЛАМ
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XIX зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал.
Хэмжээ: 20,5 x 14 x 14 см.
Фондын дугаар: 1/14

183. 184.
Дурсгалын нэр: АЮУШ
Зохиогч: Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг: XVIII зууны үе
Хаана хадгалагдаж буй: Эрдэнэ зуу музей
Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал.
Хэмжээ: 25,5 x 17,4 x 12 см.
25 x 16 x 12 см.
Фондын дугаар: 1/8 "А"
1/8 "В"

185 Дурсгалын нэр: ДОРЖӨХОДБА
Зохиогч: Дагва тэргүүтэй урчууд
Бүтээсэн он цаг: XIX зууны сүүлч үе
Хаана хадгалагдаж буй: Улсын төв номын сан
Дурсгалын шинж байдал: Сударн ном /Алт, мөнгө, сум мод/
Хэмжээ: 74,3 x 22,3 см.
Фондын дугаар: ХФ-360

186 Дурсгалын нэр: ЕСӨН ЭРДЭНИЙ ГАНЖУР /4, 7 ЭРДЭНИЙН ГАНЖУРЫН ХАМТ/
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй: Улсын төв номын сан
Дурсгалын шинж байдал: Сударн ном. /Хар цаас, өсөн эрдэнэ
Хэмжээ: 51 x 19 см, 56 x 22 см
Фондын дугаар: 1-8. 10-14. 16-144

187 Дурсгалын нэр: ЖАМБАЛЦАНЖИД
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх бүтээлч
Бүтээсэн он цаг: XVI зууны буюу 1502 о
Хаана хадгалагдаж буй: Улсын төв номын сан
Дурсгалын шинж байдал: Сударн ном /Цаас, бэх/
Хэмжээ: 25 x 9 см.
Фондын дугаар: ХФ-433

188 Дурсгалын нэр: НОГООН ДАРЬ ЭХ
Зохиогч: Эрдэмтэн Шагж
Бүтээсэн он цаг: XX зууны эхэн буюу 1914 о
Хаана хадгалагдаж буй: Улсын төв номын сан
Дурсгалын шинж байдал: Сударн ном /Цаас, шунх, бэх/
Хэмжээ: 5,5 x 5 см.
Фондын дугаар: ХФ-469

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯ**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИ**

2002 оны 3 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 100 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ТУХАЙ ЗАРИМ ХУУЛИЙН ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Татварын Ерөнхий хууль,Хүн эмын орлогын албан татварын хууль,Аж ахуйн нэгж,байгууллагын орлогын албан татварын хууль,Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль,Онцгой албан татварын хууль,Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, Татвар нөгдуулалт, өлөлтөд хяналт тавих,татвар хураах тухай хуулийн зарим зүйл,хэсэг,заалтыг нэг мөр ойлгож хэрэглэх зэргэсэн тогтолцоог бий болгож,хэрэгжүүлэх орилгоор Монгол Улсын Үндэсэн хуулийн завьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт,Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дэх хэсгийн 6 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

Нэг.Татварын нийтлэг асуудлууд

1.1 Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн зарим зүйл,хэсэг,заалтыг дараахь айдлаар тайлбарласугай.

1.1.1. Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Татвар ийн болгох, нөгдуулах, өөрчлөх, хөнгөлөх, өлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг эвхэн татварын хуулиар зохицуулна" гэдгийг уулийн 3 дугаар зүйлд тодорхойлсон татварын эгтолцоо гэсэн ойлголтод хамаарах албан атвар,хураамж,төлбөрийг бий болгох, нөгдуулах, өрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй олбогдсон аливаа харилцаг хэвхэн татварын уульд заажзохицуулна гэж ойлгож хэрэглэнэ.

1.1.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3дахь эгсийн "тусгай зориулалтын сан" гэдэг нь Засгийн ирын мэдэлд байх бөгөөд энэ нь Улсын төвлөрсөн эсвийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж ойлгоно.

1.1.3. Хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь эгсийн "сан" гэдэг нь Монгол Улсын Иргэний улийн дагуу байгуулагдсан нэг буюу хэд хэдэн сгэн байгуулагч нийгэмд ашиг тустай,нэгдмэл рилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх маар байгуулагдсан гишүүнчлэлгүй хуулийн гээдийг ойлгоно.

1.1.4. Хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь эгт заасан "Тогтоосон хугацаанд төлөөгүй татвар" дэгт тухайн татварыг төлж дуусгасан байх талаар уульд заасан буюу татварын албаны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тусгайлан тогтоосон хугацаа хамаарна.

1.1.5. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан "төлөөгүй татвар болон нөхөн ногдуулсан татвар,хүү,торгуулийг аж ахуйн нэгж,байгууллагаас үл маргах жүрмаар гаргуулна" гэдэгт татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд буюу татварын байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй татвар,хүү,торгуулийн төлбөрийг үл маргах жүрмаар төлүүлэх тухай татварын албаны даргын батална мэдэгдэх хуудсаар татвар төлөгчид урьдчилж мэдэгдсэн боловч төлбөрийг гүйцэтгээгүй бол түүний банкин дахь мөнгөн хөрөнгөөс татвар төлөгчийн эвшөөрөлгүйгээр гаргуулан авахыг, хэрэв татвар төлөгчийн банкин дахь мөнгөн хөрөнгө нь татвар,хүү, торгуулийг төлөхөд хүрэлцэхгүй байвал уг данснаас гаргах шүүхийн шийдвэртэйгээс бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож,дансанд орох орлогоос гаргуулан авахыг тус тус ойлгоно.

1.1.6. Хуулийн 10 дугаар зүйлийн 6 дугаар заалтын "аж ахуйн нэгж,байгууллага бусдад олгосон хөдлөмрийн хөлс" гэдгийг аж ахуйн нэгж,байгууллагаас бэлэн буюу бэлэн бусаар бусад этгээдэд олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад төлбөрийг ойлгоно.

1.1.7. Хуулийн 10 дугаар зүйлийн 8 дахь заалтын "ажлын 3 хоног" гэдгийг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх түсгай эвшөөрлийг төрийн захиргааны байгууллагаас авсан өдөр,цагаас хойш ажлын 4 дэх өдрийн мөн цагт багтаан татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ гэж ойлгоно.

1.1.8. Хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д заасан "Банк,санхүүгийн байгууллага татварын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үзүүлэлтийг татварын албанд гаргаж өгнө" гэдэгт Татварын албаны хүн татварын хууль тогтоомжийг зөрчсөн татвар төлөгчийн талаархи дараахь мэдээллийг банк,санхүүгийн байгууллагаас гаргуулан авахыг ойлгоно

а.татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж,байгууллагын харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл,орлого,зарлагын гүйлгээний утга, дүн;

б.хадгаламжийн хүү хүлээн авсан иргэдийн мэдээлэл:

в.тухайн банкны харилцагч аж ахуйн нэгж,байгууллага,иргэний харилцах данс,цахим картын дугаарын жагсаалт:

г.цахим карт эээмшигч иргэний цахим картын орлого,зарлагын гүйлгээний утга,дүн,төлбөр хүлээн авагч улс болон байгууллага,иргэний нэрийг хамааруулан ойлгоно. Банк дээрх үзүүлэлтийг гаргаж өгөхдөө тухайн татварын албаны даргын гарын үсэгтэй албан бичгийг үндэслэнэ.

1.1.9. Хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-ын "а" заалтын "татварын хууль тогтоомж ноцтой зөрчсөн" гэдгийг татварын хууль тогтоомжийг зөрчиж гэмт хэрэг үйлдсэн, хуурамч гэрээ хэлцэл, бичиг баримт үйлдэж татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу санаатайгаар бууруулж мэдээлсэн зөрчлийг удаа дараа үйлдсэн байх бөгөөд гаргасан зөрчилнь хор хохирол ихтэй, түүний үйл ажилгаат зогсоогоогүй тохиолдолд зөрчил үргэлжлэх үндэслэлтэй байхыг ноцтой зөрчсөнд тооцно.

1.1.10. Хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Татварын улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа" гэдэгт ажлын үндэсэн байрандаа буюу бусад газарт ажлын ба ажлын бус цагаар албан томилолт,удирдлагын даалгавраар албан үүргээ гүйцэтгэж байсан,түүнчлэн албан ажилдаа ирэх болон ажлаасаа харих хугацаа хамаарна.

Хоёр. Орлогын албан татвар

2.1 Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйл, хэсэг,заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

2.1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 4-т заасан "Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгч" гэдгийг Монгол Улсад оршин суудаггүй, өөрийн төлөөлөгч буюу хөрөнгөөрөө Монгол Улсаас ашиг олдог оршин суугч бус татвар төлөгч (аливаа иргэн, харъяалалгүй этгээд) гэж ойлгоно.

2.1.2. Хуулийн 5 дугаар зүйлийн 3-ын "д" заалтын зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлогын дүнгээр гэсэн хэсгийн "адилтгах бусад орлого" гэдгийг иргэн өөрийн хөрөнгө, мөнгө, материаллаг зүйлсийг бусдад зээлдүүлсний төлөө буусдаас авч байгаа мөнгө, материаллаг зүйл гэж ойлгоно.

2.1.3. Хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтын "их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөр" гэснийг татвар төлөгчийн төсөө буюу үрчилж авсан хүүхдийн их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч нэг буюу хэ хэдэн суралцагчийн сургалтад төлсөн бариматаа нотлогдож байгаа төлбөрийн хэмжээг ойлгоно.

2.2 Монгол Улсын Аж ахуйн нэгж байгуллагын орлогын албан татварын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

2.2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэ хэсгийн 8 дахь заалтын "бусад аж ахуйн үй ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд" гэдэг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-7- нэр заагаагүй боловч аж ахуйн үйл ажиллагаа явуул орлого олж байгаа гадаад улсын болон манай улсы хуулийн этгээд байхыг ойлгоно.

2.2.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 1-д заасан "аж ахуйн үйл ажиллагаа" гэдэг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагаанд салбарын ангилалд заасан аль нэг салбар боло хэд хэдэн салбарт орлого олох зорилготой бую зорилгоүйгээр хуулиар хориглосноос буса үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэн явуулахь хамаарууллан ойлгоно.

2.2.3. Хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэ хэсгийн 1-д заасан үндсэн болон тусла үйлдвэрлэл, ажил үйлчилгээний орлого гэдэгт "үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний орлог төлөгч татвар төлөгч хэд хэдэн чиглэл, үй ажиллагаагаар орлого олж байгаа тохиолдолд ний борлуулалтын орлого дотроос хувь хэмжээни байдлаараа зонхилж байгаа үйлдвэрлэл, ажи үйлчилгээний орлогыг ойлгоно.

2.2.4. Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 8-д зааса "эрхийн шимтгэлийн орлого" гэдэгт уран сайхн киног оролцуулан уран зохиол, урлаг, шинжлэ ухааны бүтээл, зохиогчийн эрх, патент, бараан тэмдэг, дизайн, загвар, зураг төсөл, нуу томъёолол, программ хангамж, процесс бую үйлдвэрлэл, арилжаа, шинжлэх ухааны тонө төхөөрөмж ба үйлдвэрлэл, шинжлэх ухаан туршлагатай холбоо бухий мэдээллийг ашигла эээмших эрхийг худалдах, шилжүүлэ түрээслүүлсний төлөө авч буй төлбөрий хамаарууллна.

2.2.5. Мөн зүйлийн 1 дэх хэслийн 14-т зааса "банкнаас авсан хүүгийн орлого" гэдэгт аж ахуй нэгж, байгуллага, харилцах дансныхаа тогтворто

ілдэгдэлд болон сүл чөлөөтэй мөнгөн хөрөнгө адгалуулсны төлөө банкны байгууллагаас авч буй үүгийн орлогыг ойлгоно.

2.2.6. Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх эгшгийн 1-д заасан "их засварын зардал" гэдэгт дараахь гурван шалгуурын нэгээс доошгүйг ангасан зардлыг хамаарууллна.

а/ үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг ртасгах, хүчин чадлыг дээшлүүлэх зорилгоор ийгдсэн сайжруулалт;

б/ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг айжруулах зорилгоор хийгдсэн үндсэн хөрөнгийн д анги, хэсгүүдийн чанарын сайжруулалт;

в/ үндсэн хөрөнгийг ашиглах, бий болгох, араа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний анхлан эцсон зардал, өртгийг буурулах зорилгоор йлдвэрлэлийн үйл явцад хийгдсэн техник, ехнологийн шинэчлэлтийн үр дүнд тухайн үндсэн өрөнгөд хийгдсэн сайжруулалт;

Эдгээрээс бусад засвартай холбогдон ирсан зардлыг "урсгал засварын зардал"-д тооцно.

2.2.7. Хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь эгшгийн 5 заасан "гадаадын хөрөнгө оруулалттай аж үйн нэгжид үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зуулж эхэлсэн өдөр" гэдгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эрхлэхээр эвшөөрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж ехны бүтээгдэхүүн гаргаж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн өдрийг хэлнэ. Хэрэв хэд хэдэн төрлийн йлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр бол тэдгээрийн ь нэгийг явуулж буюу үзүүлж эхэлсэн өдрөөр оцно.

2.2.8. Мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасан эдаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж йлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш вийг экспортлож байвал" гэдэгт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эрхлэхээр эвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн салбарт йлдвэрлэсэн бүтээгдэхүүний жил бүрийн орлуулалтын орлогын 50-иас дээш хувийг спортлосон бүтээгдэхүүнд орлогоос олсон байхыг лгох бөгөөд экспортлосон бүтээгдэхүүний орлого аж ахуйн нэгжийн гадаад болон дотоод банк дахь нсанд орсноор буюу түүний гэрээний дагуу пбол зохих төлбөрийг гүйцэтгэсэн баримтыг дэслэн тодорхойлно. Хэрэв хэд хэдэн тэгээдэхүүн үйлдвэрлэдэг бол тэдгээрийн йлбэрээр авч үзнэ.

2.2.9. Мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасан "ноос, ноолуур үгаах, самнах, арьс ширний анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэр" гэдэгт Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс батолсан стандартын шаардлагыг хангасан самнасан болон бөмбөгөн ноолуур боловсруулдаг үйлдвэр, угаасан ноос боловсруулдаг үйлдвэр, гандан арьс, нойтон хөх шир, нойтон цагаан шир, будсан, будаагүй, өнгө засал хийгээгүй арьс боловсруулдаг үйлдвэрийг тус тус ойлгоно.

2.2.10. Мөн зүйлийн 8 дахь хэсэгт заасан "гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоос тухайн аж ахуйн нэгжид дахин хөрөнгө оруулалт хийсэн" гэдэгт хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгөд оруулсан хөрөнгийнхөө хэмжээг нэмэгдүүлэн тайлангийн жилийн цэвэр ашгаас өмнөх онуудын алдагдлыг нөхөөд үлдэх ашгаасаа /хуримтлагдсан ашгаас/ өөрт ногдох хэсгийг тухайн аж ахуйн нэгждээ үйлдвэрлэлээ өргөтгөх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр хийгдсэн санхүүжилтийг хэлнэ.

Гурав. Хэрэглээний татвар

3.1. Онцгой албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "гэрийн нөхцөлд энгийн аргаар нэрсэн шимийн эрхэм" гэдэгт гэрийн нөхцөлд зөвхөн энгийн аргаар /уламжлалт монгол аргаар/ хувийн хэрэгцээ, өөрийн эрхэлж буй ахуйн хэрэглээнд зориулж, сүүгээр нэрсэн шимийн архийг хамаарууллан ойлгоно. Харин үйлдвэрлэлийн аргаар нэрсэн бол энэ заалтад хамаарахгүй.

3.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

3.2.1. Хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10-т заасан "нийтийн үйлчилгээний авто тээвэрээр зорчигч тээвэрлэх үйлчилгээ" гэдгийг "Авто тээврийн тухай" Монгол Улсын хуулийн 3.1.11 дэх заалтын "Нийтийн тээвэр" гэдэгтэй адилтган үзэж, нийтийн тээврийн үйлчилгээнд хамаарууллан ойлгоно.

3.2.2. Мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан "Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэрэгцээнд зориулан импортлосон бараа" гэдэгт тухайн байнга оршин суугч дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан импортлосон үг хуулийн 3.1.2 дахь хэсэгт тодорхойлсон бүх төрлийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг ойлгоно.

Дөрөв. Хөрөнгийн татвар

4.1 Монгол Улсын Үл хөдлөх эд хөрөнгийн татварын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

4.1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгө" гэдэгт газар болон газраас салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсыг хамааруулан ойлгох боловч Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх журмыг хуулиар тодорхойлох хүртэл иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын болон төрийн бус байгууллагын ашиглал, эзэмшил, өмчлөлд байгаа газар, газрын хөвлийн хэсэг, эдэлбэр ус, ой, олон наст үргамал зэрэг нь татвар ногдуулах хөрөнгөд үл хамаарна.

4.1.2. Хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "төрийн бус байгууллага" гэдэгт төрийн бус байгууллагын тухай хуулиар эрх зүйн байдал нь зохицуулагддаг байгуллага, хуулийн этгээд болон эрх зүйн байдлыг нь өөр хуулиар зохицуулдаг үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Хүдалдаа аж үйлдвэрийн танхим, эдгээртэй адилтгах байгуллага, хуулийн этгээд хамрагдах бөгөөд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна гэж ойлгоно.

Тав. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах

5.1. Монгол Улсын татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

5.1.1. Хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "татварын улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнд хангагдахгүй байгаа актын биелэлтийн талаар татварын улсын байцаагч шүүхэд нэхэмжлэл гаргана" гэдгийг татвар төлөгч татварын улсын байцаагчийн тавьсан актыг хүлээн зөвшөөрөөгүй, хуульд заасан хугацааны /14 хоногийн/ дотор Татварын маргаан таслах зөвлөлд гомдлоо гаргаагүй тохиолдолд татварын улсын байцаагч шүүхэд нэхэмжлэл гаргахыг ойлгоно.

Харин татвар төлөгч нь Татварын албаны гаргасан аливаа шийдвэрийг хүлээн зөвшөөрехгүй бол харъяалах шатны Татварын маргаан таслах зөвлөлд хуульд заасан хугацааны /14 хоногийн/ дотор гомдлоо гаргана. Харъяалах шатны Татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл татвар төлөгч Дээд шатны Татварын маргаан таслах зөвлөлд тогтоосон хугацаанд гомдлоо гаргана. Дээд шатны Татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн бол шүүхэд нэхэмжлэл гаргана.

Татвар төлөгч тогтоосон хугацаанд гомдол гаргаагүй бөгөөд энэ журмыг хэрэглэх боломжгүй болсон байвал иргэд Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болохгүйг тайлбарласугай.

Зургаа. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн дараахь тогтоол, түүний заалтыг хүчингүй болсонд тооцож, энэ тогтоол гарсан өдрөөс хойш үүссэн эрх зүйн харилцаанд үйлчлэхгүй байхаар тогтоосугай.

1. "Татварын тухай хууль тогтоомжийн зарим актын зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1993 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 49 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг,

2. "Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1995 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 246 дугаар тогтоол,

3. "Татварын хууль тогтоомжийн актуудын зарим зүйлийн заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1996 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 167 дугаар тогтоол,

4. "Дээд шүүхийн 1993 оны 49 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1997 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 427 дугаар тогтоолын 1 дэх заалт.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч.ГАНБАТ


ШҮҮГЧ А. ДОРЖГОТОВ
Д. ДАНЗАНДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 3 ☎ 329487





ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (269)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай*
- *Нийслэлийн нутаг дэвсгэрт тал аж ахуй эрхлэх талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны наймдугаар сарын 29 №32 (269)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

455. Шиничи Койбучийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 118 1023

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

456. Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Дугаар 119 1024
457. Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай Дугаар 120 1032
458. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв байгуулах тухай Дугаар 121 1036
459. Түлш, эрчим хүчний салбарын 2002-2003 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай Дугаар 125 1037
460. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 126 1037
461. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 133 1038

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

02 оны 8 дугаар
ын 2–ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

Шиничи Койбучийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын харилцаа, хамтын иллагааг өргөжүүлэх, монгол судлалыг жүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж он Улсын "Ази" их сургуулийн захирал Шиничи Койбучийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээллэл" эмхтгэлийн 2002 оны долдугаар сарын 26-ны өдрийн 28 дугаарын гарчигт "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай", "Төрийн албаны тухай", "Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай" хуулиудын батлагдсан хугацааг "2002-7-4-ний хууль" гэж эх бэлтгэгчийн бууруулсан таашаарсан тул тус дугаарт нийтлэгдсэн дээрх хуулиуд тус бүрт заасан батлагдсан хугацааг баримтлан хэрэглэнэ үү.

ЭМХТГЭЛИЙН ЗӨВЛӨЛ

2002 оны 6 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот

Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу улсын төсвийн удирдлагыг сайжруулж, төсвийн бүтэц, үзүүлэлтийн ангиллыг боловсронгуй болгох, татвар, нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, нийгмийн хөгжлийн арга хэмжээ, түүний дотор төсвийн байгууллагад ажиллагчдын цалин, иргэдийн тэтгэврийн талаар дэвшүүлсэн зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллагуудтай тохиролцсон хөтөлбөрүүдэд Монголын талын хүлээсэн үүргийг биелүүлэх үндсэн дээр ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах зориулалт бүхий гадаадын зээл, тусламжийн ашиглалтын явцыг зөрчимжүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх талаар Засгийн газрын баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор батлэсугай.

2. Төрийн албанд ажиллагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 2003-2004 онд шаардагдах санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийг дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, төрийн албаны болон нутгийн засаг захирагааны бүтэц, зохион байгуулалт, төсвийн зардлын удирдлага, тэтгэврийн даатгал, татварын тогтолцоонд шинэчлэл хийх, бүтцийн шинэчлэлийг дэмжих тусгай сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоолын 2-т заасныг удирдлага болгон төвлөрсөн хийгээд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсвийн бүх шатны байгууллага нь ажиллагчдынхаа цалинг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт заасан зорилтын хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд 2003-2004 онд нэмж шаардагдах хөрөнгийн 30-аас доошгүй хувийг өөрийн салбар, нутаг дэвсгэрийнхээ байгууллага, нэгжийн бүтэц зохион байгуулалтад шинэчлэл хийж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлсний дүнгээр төсвөөс олгох цалингийн хэмжээг тогтоосноос өмнө, 2003 оны төсвийн төсөл, 2003-2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж Улсын төсвийн тухай хуульд заасан хугацаанд зохих шатны байгууллагад оруулахыг төсвийн бүх шатны эрх зохиргч нарт даалгасугай.

4. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэмжээтэй уялдуулан улсын төсвийн 2003-2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах энэ оны 6 дугаар сард багтаан Засгийн газар оруулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

5. Бүтцийн өөрчлөлт болон цалин тэтгэврийн шинэчлэл хийх богино, урт хугацаан хөтөлбөр боловсруулж, уг хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд үүсч болзошгүй сөрөг нөлөөллөө урьдчилан сэргийлэх, нийгмийн хамгаалли нэмэлт арга хэмжээ авахад шаардагдах үүсвэрийн тооцоог гаргаж, энэ талаар аваах ар хэмжээний санал боловсруулан Засгийн газар оруулах, шаардлагатай гэж үзвэл энэ чиглэлэ бүтцийн шинэчлэлийг дэмжин тогторжуул тусгай сан байгуулах асуудлыг хандивлагч оро олон улсын санхүүгийн байгууллагуудад тав шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн засгийн са Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн са Ш.Батбаяр нарт даалгасугай.

6. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх талаа авах арга хэмжээтэй уялдан холбогдох хуу тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруул хууль, эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх асуудл судлан боловсруулж, шийдвэрлүүлэх ар хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБА

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛА

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБА

Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ЗАСГИЙН ГАЗРЫН БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Баримтлах зарчим, эрх зүйн шинэ орчин бүрдүүлэлт

Төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх асуудлыг дотоодын нийт үнэгдэхүүнийг бодит өсөлт, төсвийн зардлын хэмжээг бодлого, төрийн албаны болон нутгийн захиргааны тэдгээр, зохион байгуулалтын өөрчлөлт,нийгмийн даатгалын тогтолцоонд шинэчлэлтийг хэрэгжүүлэх, үүнтэй холбогдолтой эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг татварын тогтолцоогоор дэмжих, нийгмийн хамгаалалын бусад арга хэмжээтэй нягт уялдуулан шийдвэрлэх талаар Засгийн газар дараахь чиглэлийг баримтална:

1. Төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах болон нийгмийн хамгаалалын талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ:

- дунд хугацааны (2001-2004 он) бодит эдийн засгийн өсөлтийг хангах;
- төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлого,зарлага санхүүжилтийн тэнцвэржилтийг бататгах, төсвийн менежментийн шинэчлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- улсын санхүүгийн эх үүсвэрийн бодит нөөц, боломжийг нэмэгдүүлэх;
- татварын болон нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх;
- төрийн албаны болон төсвийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- олон улсын санхүүгийн байгууллагуудтай тохиролцон хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд монголын талын хүлээсэн үүргийг ханган биелүүлж, хандивлагчдын амласан гадаад зээл, тусламжийг тогтоосон хугацаанд нь бүрэн авч, үр ашигтай ашиглах;
- ажилгүйдэл, ядуурлыг бууруулах асуудлыг хооронд нь нягт уялдуулсан, цогц бодлогын хүрээнд шийдвэрлэх зарчим баримтална.

2. Дунд хугацаанд төсвийн гол тэнцвэрт харьцаа, түүний дотор төсвийн зардлын хязгаарлалтыг эдийн засгийн бодит өсөлттэй уялдуулан дараахь түвшинд ханган хадгалах тооцоо, жилжилийн төсвийн төлөвлөлт, төсвийн хүрээг тодорхойлон мөрдүүлнэ:

УЛСЫН ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТҮВШИН

(Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь)

Төсвийн хүрээний үзүүлэлтүүд	2001 он	2002 он	2003 он	2004 он
Нийт орлого, тусламжийн дүн	38.9	33.1	33.0	32.9
Урсгал орлого	38.0	32.4	32.0	32.3
• Татварын орлого	29.0	26.7	26.5	26.0
• Татварын бус орлого	9.0	5.7	6.9	6.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	43.3	39.9	38.2	38.1
Урсгал зардал	32.4	29.0	28.6	28.1
үнээс:				
• Цалингийн зардал	8.1	7.1	6.9	6.7
• Бараа, үйлчилгээний зардал	14.4	12.2	12.6	12.3
• Зээлийн үйлчилгээний төлбөр	1.5	1.6	1.6	1.5
• Татаас ба урсгал шилжүүлэг	8.4	8.1	7.5	7.6
Хөрөнгийн зардал	5.2	4.3	4.1	5.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	5.7	6.7	6.4	6.2
ӨСВИЙН ҮРСГАЛ	5.6	3.5	3.3	4.0
ЭНЦЭЛ НИЙТ	-4.5	-6.9	-6.6	-6.0
САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4.5	6.9	6.6	6.0
ГАДААД	6.5	8.0	6.1	5.6
ДОТООД	-2.0	-1.1	0.5	0.4

3. Төсвийн зардлын удирдлагыг сайжруулах, төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой шинэчлэл явуулах, төсвийн орлогын суурийг өргөтгөхөд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлнэ:

3.1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн болон үүнтэй уялдсан дагалдах хуулиудын төслийг Улсын Их Хурлын 2002 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэн батлуулж, төсвийн удирдлагыг сайжруулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээр ажил үүргийн давхардлыг арилгаж нягталсан сайжруулан, төрийн алба, төсвийн байгууллагыг чадавхижуулан, төрийн гүйцэтгэх зарим үүргийг бүтээгдэхүүн захиалгаар нийлүүлэн санхүүждэг, ажиллагчид нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд зохицон боломжит хөдөлмөр эрхлэлтийн зарчмаар ажилладаг шинэ зарчимд 2003 оны төсөв зохиолтоос эхлэн үе шаттай шилжүүлэх;

3.2. Нийгмийн салбарын хувьчлалын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, эрх зүйн шинэ орчин бүрдүүлснийг үндэсэн дээр эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн зэрэг нийгмийн салбарт менежментийн гэрээ, арилжааны горим нэвтрүүлэн, хувьчлалыг үе шаттайгаар явуулж, санхүүжилтийн хэв шинжийг нь өөрчлөх замаар төсвийн зардлын бүтцийг боловсронгуй болгох;

3.3. Газрын харилцааны шинэчлэлийн тухай болон Газрын төлбөрийн тухай хуулиудыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж,газрын санг эдийн засгийн идэвхтэй эргэлтэд оруулах харилцааг бий болгон төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлогын баазыг өргөтгөх;

3.4. Дотоодын боловсруулах үйлдвэр, түүний дотор экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих, хөрөнгө оруулагч, татвар төлөгчидийг татварын тогтолцоогоор дамжуулан урамшуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд, хүн амд үзүүлэх татварын ачааллыг бууруулах, түүнчлэн татварын тэгш, шударга зарчмыг алдагдуулдаг үр нөлөө муутай хөнгөлөлт, чөлөөлөлтийг арилгах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж шийдвэрлүүлэх.

Хоёр. Төсвийн зардлын удирдлагын шинэчлэлийн талаар

1. Төвлөрсөн төсөвтэй харьцдаг төсвийн байгууллагын тоог цөөрүүлж, төсвийн санхүүжилтийн салбаруудын хөгжлийн нэгдсэн болон дэд сангийн төлөвлөлтийн зарчимд шилжүүлнэ.

2. Төвлөрсөн болон орон нутгийн төсөвхооронд ын харилцаанд бүтээгдэхүүн гэрээлэлтээр санхүүжих арга хэрэглэх шилжүүлгийн аргыг улаболовсронгуй болгож ирэх оны эхнээс төсвийн санхүүжилтэд нутгийн захиргааны удирдлагын зардлын норматив, жишиг тогтоон мөрдүүлнэ.

3. Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хувийн хэвшлийнхэнтэй зэрэгцэн төрийн болон төсвийн зарим байгууллагад төрийн ижил тестэй нийгмийн үйлчилгээ эрхэлж байгаа ажиллагчдын төрийн албаны ангиллыг шинэчилж төрийн албаны эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх мөрдүүлнэ. Эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэхэрэгжүүлэхдээ дотоодын нийт бүтээгдэхүүнд төрийн албаны зардлын эзлэх хувийн жингийн зохистой түвшинг хангана:

- Төрийн албаны болон бололцоотой зарим байгууллагад төсвийн эх үүсвэрээр хийгдэх урсгал санхүүжилтийн хэмжээг бүтцийн шинэчлэлтэд тулгуурласан зардлын түвшинд 2003- 2005 он хүртэл тогтвортой байхаар төлөвлөх;
- Төсвийн байгууллагын нийт урсгал зардалд ажиллагчдын цалингийн эзлэх хувь жинг 40-өөс доошгүй хувь байх зарчим баримталж, бүтцийн шинэчлэлтийн үндсэн дээр бий болох санхүүгийн эх үүсвэрт тулгуурлах төрийн алба, төсвийн байгууллагад ажиллагчдын цалинг 2004 онд Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлберт тусгагдсан зорилтыг бүрэн хангах түвшинд нэмэгдүүлэх.

4. Төрийн шууд чиг үүргээгүй бус байгууллагын нэгжийн дотоод үйл ажиллагаанд улс, орон нутги

өсвөөр дамжуулан төрөөс оролцох оролцоог
ювчтой хязгаарлаж, нийгмийн салбарт арилжааны
рим нэвтрүүлэх, тухайн байгууллага хуулийн
үрээнд орлого олж өөрийгөө санхүүжүүлэх,
хиллагсдынхаа нийгмийн хамгааллыг бие даан
ийдвэрлэх, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн
с байгууллагын хэлбэрээр ажиллуулж, төсвөөс
ь болох хараат бус байдалд шилжүүлнэ.

Боловсрол, соёл, урлаг, амралт, рашаан
вилал, хэвлэл мэдээлэл, эрүүл мэнд, нийгмийн
аатгал, хөдөлмөр зохицолтын зөрөг нийгмийн
лчилгээний чиглэлтэй, өөрийн үйл ажиллагааны
логоо бие дааж захиран зарцуулах эрх бүхий
гийн бус байгууллага, нэгжийг 2002 онд багтаан
тцийн өөрчлөлтөд хамруулж, төрийн албаны
лон төсвийн бүтцээс чөлөөлөх.

5. Төрийн албанд ажиллагчдын цалинг
мэдүүлэхдээ дараахь зарчим баримтлах:

Төрийн албаны бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтийг тухайн жилд төрийн албан хаагчийн цалин нэмэхээс өмнө урьдчилан хийх арга хэмжээ авах, үүнтэй уялдуулан бүтцийн шинэчлэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх ажилтнуудыг цалингийн нэмэгдэлд хамруулахгүйгээр хууль тогтоомжийн дагуу олгох нөхөн олговор, хөнгөлөлтийг эдлүүлэх нь зүйтэй гэж үзэх;

Төрийн албаны ажилтны 2002 оны цалингийн нэмэгдлийг одоо мөрдөж байгаа цалингийн түвшин, албан тушаалын зэрэглэл, ажлын чиг үүрэг, онцлог, санхүүгийн эх үүсвэртэй нягт уялдуулан тогтоох чиглэл баримтлах.

6. 2003-2004 онуудад нийгмийн ігааллын, түүний дотор цалин, тэтгэврийн талаар ішүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд нэмж эрдагдах санхүүжилтийн эх үүсвэрийг дараахь а хэмжээний хүрээнд шийдвэрлэх зарчим имтална:

6.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний ттөөс бий болох төсвийн орлогын нэмэгдэл эх үүсвэрээр;

6.2. Улсыг батлан хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах болон төсвийн төвлөрүүлэн эрх захирагч бусад байгууллага, яам, агентлаг, нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээ, нийгмийн салбарт зардал хямдруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх, төрийн албаны ангиллыг шинэчлэн тогтоох замаар хийх бүтцийн шинэчлэлийн үр дүнд төсвөөс чөлөөлөгдөх хөрөнгийн эх үүсвэрээр;

6.3. Нийгмийн салбарын зарим байгууллагыг хувьчлах, тус салбарт арилжааны горим нэвтрүүлэх, төсвийн зарим байгууллагыг төрийн өмчит болон ашгийн бус аж ахуйн нэгжийн хэлбэрт шилжүүлж, санхүүжилтийн хэв шинжийг өөрчлөн төсвөөс чөлөөлөгдөх эх үүсвэрээр;

6.4. Тэтгэврийн шинэчлэл явуулах, түүний дотор нийгмийн даатгалын сангуудыг бие даасан бүтцэд үе шаттай шилжүүлэх, нийгмийн даатгалын хүрээг өргөтгөх багц асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх замаар бий болох эх үүсвэрээр;

6.5. Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх сан (Олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагчдаас дэмжлэг авах) бий болгож, тухайн сангаас тэтгэврийн шинэ тогтолцоог тогтворжуулахад үзүүлэх санхүүгийн дэмжлэгээр.

7. Бүтэц,зохион байгуулалтын шинэчлэлийн улмаас богино хугацаанд үүсч болзошгүй зарим сөрөг нөлөөллийг урьдчилан тооцож, түүнтэй холбогдуулж авах нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг нарийвчлан тогтоох, энэ талаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагын тусламж дэмжлэгийг авч ашиглах асуудлыг боловсруулан шийдвэрлүүлнэ.

Энэ асуудлын хүрээнд бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтэй холбогдон төрийн алба, төсвийн байгууллагаас чөлөөлөгдөх хүмүүст хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, төрийн албаны хуулиар эдэлж байгаа зарим нөхөн олговор, хөнгөлөлт, тухайлбал, төрийн албанд ажиллагчдын нэг

хүүхдийн сургалтын төлбөр, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн төрөөс хариуцаж байгаа хэсэг, тэдгээр хүмүүсийг давтан сургах, дахин мэргэшүүлэх сургалтад шаардагдах зардлыг төр тодорхой хугацаанд хариуцна.

8. Яам, аймаг, нийслэлийн болон төсвийн бүх шатны төсвийн эрх захирагчид 2003 оны төсвийн төсөл зохиох, 2003-2005 оны төсвийн хүрээг тодорхойлхдоо дараахь зарчмыг баримтална:

8.1. Өөрийн орлого бүхий төсвийн зарим байгууллагын санхүүжилтийн хэлбэрийг өөрчилж, төрийн өмчит аж ахуйн тооцоот нэгжийн хэлбэрт шилжүүлэх, төсвийн санхүүжилт, татаасыг үе шаттай бууруулж, өөрийгөө санхүүжүүлэх, төсвөөс аль болох хараат бус зарчмаар ажиллуулах;

8.2. Төрийн захиргааны байгууллагуудаас салбарын чиглэлээр эрхэлдэг зарим ажил үүргийг төсвийн болон Засгийн газрын бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хамтлагаар аж ахуйн тооцоо, гэрээ захиалгын аргаар гүйцэтгүүлэх асуудлыг яам, агентлагууд салбарынхаа хэмжээнд судлан 2003-2005 оны төсвийн хүрээний тооцоонд тусгах;

8.3. Цалин, тэтгэврийн талаар 2002-2004 онд Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулахын тулд төсвөөс санхүүждэг улсын секторын зардлыг бүх түвшинд дунджаар 30 хувиар хямдруулах бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийх, энэ арга хэмжээний үр дүнг төсвийн бүх шатны эрх захирагч нар 2003 оны төсөв зохиох, 2003-2005 оны төсвийн хүрээгээ тодорхойлоход тусгах, төсвийн төслийн үнэлгээний шалгуур болгон хэрэгжүүлэх.

9. Улсын төсвийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилтийг төрийн сангийн нэгдсэн дансны аргаар төсвийн санхүүжилт, бэлэн мөнгөний урсгалыг хянах шинэ тогтолцоонд шилжинэ. Төвлөрсөн төсвийн байгууллагуудыг 2002 оны сүүлийн хагасаас төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжүүлнэ.

10. Тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн шударга, тогтвортой тогтолцоонд шилжих шилжилтийн эрх зүйн шинэ орчинг бүрдүүлэхийн хамт нийгмийн даатгал, халамжийн тогтолцоонд шинэчлэлийн ойрын болон урт хугацаа (2003-2010)–ны хөтөлбөрийг нийгмийн хамгаалал хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн боловсруулж, үе шаттайгаар шийдвэрлүүлнэ:

10.1. 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүст нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэврийг улсаас хариуцах зарчим баримтлах бөгөөд энэ төрлийн тэтгэвэрт шаардагдах санхүүжилт болон төсвөөс олгох татаасын зөрүү төвлөрсөн төсвийн урт хугацааны зээлийн хэлбэрээр шилжүүлэн, түүний төлбөрийн асуудлыг 2007 оноос эхлэн нийгмийн даатгалын сан нөхөн санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

10.2. Нийгмийн даатгалын сан улсын төвлөрсөн төсвөөс олгодог татаасыг 2002 оны төсөвт тусгагдсан хэмжээнд байлгах, цаашид үе шаттай бууруулах зарчмыг дунд хугацаанд баримтлах;

10.3. Улс, орон нутгийн төсвийн бүтцээ нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг 2003 оноос эхлэн тусгаарлаж, ут санг бие даасан байдлаар шилжүүлэх дэс дараатай алхам хийж, төсвийн үзүүлэлтийн бүтэц, ангиллыг шинэчлэх;

10.4. Малчид, түүнчлэн хувираа хөдөлмөрлөх эрхэлж байгаа боловч нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдаагүй байгаа хүмүүсийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сайн дурын даатгалын хүрээг өргөжүүлэх;

10.5. Төсвийн байгууллагад ажиллагсдын болон төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, шинэчлэн тогтоож, 2003 оны эхнээс мөрдүүлэх;

10.6. Улсын нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх эдлэх насыг нийтийн хүмүүст адил тогтоох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

10.7. Улсын нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх эдлэх эхлэх наснаас өмнө тусгай хөнгөлөлттэй буюу бусад нөхцөлөөр тэтгэвэр

эгтоолгосон хүмүүс улсын нийгмийн даатгалын
энгаас өндөр настны тэтгэвэр авах нас хүртэлх
эвсрын хугацаанд ажил олгогчоос тэтгэврийн
анхүүжилт авдаг (компанийн тэтгэврийн
эгтолцооны) журамд шилжүүлэх;

10.8. Цалингийн бус орлогыг цалингийн
элбэр, бүтцэд оруулж, түүнд нийгмийн даатгалын
имтгэл ногдуулдаг хуулийн шинэ орчин
рдүүлэх;

10.9. Нийгмийн халамжийн тогтолцоог хүн
ын нөхөн үржихүйн чанарыг дэмжих, халамж,
:рамжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж,
эгэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог
мэгдүүлэх, халамжийн сангийн зарцуулалтын үр
шгийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй
элгох;

10.10. Нийгмийн даатгал,халамжийн
тгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний
юд хэмжээ, амьжиргааны доод түвшинтэй шууд
мааралгүй болгон журамлах.

Гурав. Төсвийн орлогын тогтвортой байдлыг
хангах, татварын тогтолцоог
боловсронгуй болгох талаар

Төсвийн орлого, зарлагын харилцан уялдаат
нгаж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн
ийн засгийн зохицуулалтад татварын тогтолцооны
нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг боловсруулж
йдвэрлүүлнэ.

1. Аж ахуйн нэгж, хүн амын татварын
аллыг бууруулж, үйлдвэрлэл, хөрөнгө
уулалтын өсөлтийг татварын бодлогоор дэмжин,
ийн засгийн өндөр өсөлтийг хангах нөхцөл
эдүүлнэ:

а/аж ахуйн нэгжийн орлогын албан
ітварын шатлалын дээд хязгаарыг 2003 оны 1
/гээр сарын 1-нээс эхлэн 10 пунктээр
уруулж, цаашид татварын нэгдсэн нэг шатлалд
илжүүлэх чиглэл баримтлах;

б/татвар тогтвортой төлөгч зарим
аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн
цэвэр ашгаас үндсэн үйлдвэрлэлийнхээ хүчин
чадлыг өргөтгөж, ажлын байр шинээр нэмэгдүүлсэн,
техник, технологийн шинэчлэлт хийж шинээр
хөрөнгө оруулсан хэмжээгээр татвар ногдуулах
орлогыг нь бууруулж байх зарчмыг баримтлах;

в/уул уурхайн салбарт хөрөнгө
оруулан шинээр үйл ажиллагаагаа эхэлж байгаа
дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагттай аж
ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн үндсэн
үйл ажиллагаатай холбогдож анхны жилд гарсан
алдагдлыг дараагийн 3 жилийн татвар ногдох
орлогоос нь тооцож, татварын хөнгөлөлт үзүүлэх;

г/экспортын бүтээгдэхүүн
үйлдвэрлэх чиглэлтэй орчин үеийн өндөр
технологи бүхий үйлдвэр байгуулах чиглэлээр шинэ
технологи бий болгон үйлдвэрлэлд нэвтрүүлэх
зориулалттай судалгаа, шинжилгээнд ашиглагдаж
байгаа тоног төхөөрөмжид элэгдэл, хорогдлын
шимтгэлийг эхний жилүүдэд байгуулж, уг элэгдэл,
хорогдлын хэмжээгээр татвар ногдох орлогыг нь
бууруулж шинжлэх ухаан, технологийн ололтыг
үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг
урамшуулах зарчмыг баримтлах;

д/модон хагас бэлдцийн экспортын
татварыг тэглэх;

е/гадаадын захиалагчийн
материалаар оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн
үйлдвэрлэж экспортлох зорилгоор импортолсон
технологийн хэрэгцээт материалыг гаалийн албан
татвараас чөлөөлөх;

ж/татвар төлөгч том аж ахуйн
нэгжүүд төвлөрсөн болон орон нутгийн төсвийн
орлого бүрдүүлэхэд оролцох оролцоог тогтвортой,
ил тод байлгаж, улсын санхүүд тэдгээрийн
оруулсан хувь нэмрийг хөхиүлэн дэмжих,
урамшуулах эдийн засаг, эрх зүйн шинэ орчинг
2002 онд багтаан бүрдүүлж хэрэгжүүлэх;

з/иргэд, аж ахуйн нэгж,
байгууллагуудаас гадаадад хадгалуулсан буюу гар
дээрээ хадгалж байгаа, түүнчлэн тайлан баланстаа
тусгагдаагүй мөнгөн хөрөнгөө харьяалах татварын
албанд бүртгүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр

зохион байгуулах, өргөтгөх чиглэлд хөрөнгө оруулалт хийсэн, Засгийн газрын үнэт цаас худалдаж авсан, дотоодын банкинд урт хугацаатай хадгалуулсан зэрэг тохиолдолд орлогынх нь эх үүсвэрийг үл харгалзан татварыг нөхөн ногдуулахгүй, хүү, торгууль тооцохгүй байх нэг удаагийн үүчлэл үзүүлэх;

и/хүн амын орлогын албан татварын дээд хувь хэмжээг 2003 оноос 25 хувиар бууруулж, хүн амд татвар ногдуулах шатлалыг цаашид нэг хувь хэмжээнд шилжүүлэх чиглэл баримтлах;

к/бага орлоготой иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хүн амын орлогын албан татварын жилийн хөнгөлөлт 2002 онд 48000 төгрөг байгааг 2003 онд 54000 төгрөг, 2004 онд 60000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлэх;

л/Монгол Улсад байнга оршин суугчийн хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, тэдгээртэй адилтгах бусад орлогыг татвараас чөлөөлөх арга хэмжээ авах;

м/боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор 2003 оноос эхлэн хөдөө аж ахуйн анхдагч түүхий эд ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлдэг боловсруулах үйлдвэрүүдийн төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татвараас нь хөдөө аж ахуйн анхдагч түүхий эд худалдан авсан үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээгээр хасалт хийж татварын хөнгөлөлт үзүүлж байх.

2. Татварын орлогын баазыг өргөтгөж, татвар хураах үйл ажиллагааг сайжруулна:

а/эх орны үйлдвэрийн болон импортын барааны нөгдуулж буй онцгой албан татварын нөгдуулалт, төлөлтөд тавих хяналтыг хүчтэй болгож, хураалтыг сайжруулах зорилгоор онцгой албан татварын тэмдэг хэрэглэх хүрээг өргөжүүлэн эх орны үйлдвэрийн тамхи, импортын архи, тамхийг онцгой албан татварын тэмдэгтэйгээр борлуулах ажлыг зохион байгуулах;

б/онцгой албан татварын тэмдгийн нууцлалыг сайжруулж, түүний загварыг боловсронгуй болгон хуурамч үйлдлээр татвар завших оролдлогоос сэргийлж байх;

в/нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгож, урьдчилсан бэлтгэлийг хангасны үндсэн дээр Нэмэгдсэн өртгийн албан татварын мэдээллийн автоматжуулсан системд шилжих, нэмэгдсэн өртгийн албан татварын нөгдуулалт, буцаан олголтыг уг мэдээллийн баазад тулгуурлан шийдвэрлэдэг журамд 2003 оноос шилжих;

г/татвар төлөгчдийн бүртгэлийн мэдээллийн баазыг боловсронгуй болгосноор татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэх, татварт бүрэн хамруулах замаар далд эдийн засгийн нөлөөллийг бууруулах дэс дараатай арга хэмжээ авах;

д/хувираа хөдөлмөр эрхлэгч иргэдийг орлого, татвар тодорхойлох хуудсаа татварын тооцоогоо хийх журамд өргөн хамруулах энэ арга хэмжээнд 2002 онд аймаг, орон нутгийн хөдөлмөрийн насны иргэдийн 5 хувийг, нийслэлийн 10 хувийг, 2004 онд аймаг, орон нутгийнх 7 хувийг нийслэлийн 13-аас доошгүй хувийг хамруулан цаашид жил бүр 20-30 хувиар нэмэгдүүлэх;

е/жижиг, дунд аж ахуйн нэгжүүд хувираа аж ахуй, худалдаа,үйлчилгээ эрхэлж байгаа иргэдийн хөтлөх санхүүгийн бүртгэлийг хялбаршуулсан маягт, заавryг боловсруулж батлуулан мөрдүүлэх;

ж/бүртгэлийн ажлыг сайжруулах хүрээнд орон нутагт салбартай, удирдлагын босоо тогтолцоотой төвлөрсөн журмаар татварын тооцоо хийдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын үл хөдлөх хөрөнгийн албан татвар, байгалийн нөөц /газар, ус ой, ан агнуур, ашигт малтмал гэх мэт/ ашигласнд төлбөр, хураамжийг тухайн орон нутгийн төсөв оруулах эрх зүйн үндсийг бий болгож, 2003 оноос хэрэгжүүлэн татварын оногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг чангатгах;

з/бэлэн мөнгөөр худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж

байгууллагын орлогыг бүрэн тодорхойлох, татварыг нь үнэн зөв ногдуулах зорилгоор 2003 онд дээрх төрлийн татвар төлөгчийн 50 хувьд, 2004 онд 75 хувьд кассын машин, чек тасалбар нэвтрүүлэх;

и/үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл олдагдалтай тайлан гаргасан аж ахуйн нэгжид татварын нотлох хяналт, шалгалт хийж, тэдний үйл ажиллагааны талаар хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн бодит байдлыг нь тогтоох, татвараас зайлсхийх, хууль зөрчих байдал гаргахгүй байх арга хэмжээ авах;

к/аж ахуй эрхлэгчдээс үл хамаарах шалтгаанаар үүссэн бодит хүндрэлийн улмаас 2000 оноос өмнөх жилүүдэд бий болж хуримтлагдсан татварын өр, түүний хүү, торгуулийг улсын төсөв, татвар төлөгчдөд дарамтгүй байх нөхцөлөөр охицуулан барагдуулах арга хэмжээ авах;

л/шүүхийн шийдвэр гарсан татварын төрийг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газартай хамтран барагдуулах ажлыг эрчимжүүлж, 2002 оны дүгээр сарын 1-нд байсан татварын нийт өрийн 40 хувийг 2002 онд, үлдэх хэсгийг 2003-2004 онд бүрэн барагдуулах оновчтой арга механизм бий болгон ажиллах.

3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохицуулах, тэгш, шударга зарчим хэрэгжүүлнэ:

а/аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн татвараас чөлөөлөх 7 дугаар зүйлийн дараахь хэсэг, заалтууд болон татварын тэгш, шударга зарчимд хэрхэн нийцэж байгааг хянана:

7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн хандив;

7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт: "Донорын цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнийг эмчилгээнд хэрэглэснээс олох орлого;

Хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын ижил орчин бүрдүүлэх үүднээс хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулахдаа хурдавчилсан элэгдэл байгуулах, гарсан алдагдлыг дараагийн жилүүдийн татвар ногдуулах орлогоос хасах зэрэг урамшууллын механизмуудыг хэрэглэхтэй уялдуулан хуулийн 7 дугаар зүйлийн 5-аас 12 дахь хэсэг;

Өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжийг оруулсан хөрөнгийн хэмжээгээр татвар ногдуулах орлогыг нь бууруулан тооцохтой уялдуулан 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, засвар арчлалт хийсэн аж ахуйн нэгжийн уг ажилд зарцуулсан хөрөнгийг албан татвараас хасч тооцно" гэсэн хэсэг;

б/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн татвараас чөлөөлөх 9 дүгээр зүйлийн дараахь хэсэг, заалтуудыг хянана:

9.1-ийн "з" –санхүүгийн лизинг;

9.2.13. Гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон Консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар хоорондын шугамаар болон олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашины татварын асуудал.

в/Онцгой албан татварын хуулийн татвараас чөлөөлөх 7 дугаар зүйлээс дараахь хэсгүүдийг хянана:

7 дугаар зүйлийн 7 дахь хэсэг: "Гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон Консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар хоорондын шугамаар болон олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин;"

7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг: "Хамрын тамхи";

7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг: "Эх орны үйлдвэрийн пиво, гэрийн нөхцөлд энгийн аргаар нэрсэн шимийн архи." гэснээс "Эх орны үйлдвэрийн пиво" гэсэн заалт.

г/Хүн амын орлогын албан татварын татвараас чөлөөлөх 9 дүгээр зүйлийн дараахь хэсгүүдийг хянана:

9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дугаар заалт: Монгол Улсад олон улсын гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад олон улсын бусад байгууллагад ажиллаж байгаа иргэний орлогын албан татвар;

9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14 дүгээр заалт: "Иргэдээс боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив";

д/гадаадтай хамтарсан үйлдвэрүүдийг зарим төрлийн татвараас чөлөөлж байгаа Засгийн газар хоорондын гэрээний зарим нөхцөлийг өөрчлөх үндэсэн дээр хамтарсан үйлдвэрүүдийг Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу нийтлэг жишгээр татварт хамруулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.

* * *

Засгийн газрын энэхүү чиглэлийн дагуу төсвийн зардлын удирдлагыг сайжруулах, бүтцийн өөрчлөлтийн болон энэхүү баримт бичигт дурдагдсан бусад арга хэмжээг салбаруудаар боловсруулж, хэрэгжүүлэх арга, шинэ бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлон тогтоож, хөрөнгийн тооцоог нарийвчлан гаргаж, 2003-2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгуулах ажлыг яам, аймаг, нийслэлийн болон төсвийн бүх шатны эрх захирагчид зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 120** **Улаанбаатар хот**

Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн зарлага санхүүжилтийн норм, нормативын үндэслэлийг сайжруулах талаар тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, төсөвт байгууллагын санхүүжилтийг боловсронгуй болгох, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Орон нутагт оршин суугаа 1000 хүнд ногдох удирдлагын хувьсах зардлын жишиг нормативыг дор дурдсанаар тогтоосугай:

/мянган төгрөгөөр/

Аймаг, нийслэлийн нэр	Хувьсах зардлын норматив	Үүнээс	
		Албан томилолт, тээвэр, шатахуун	Бусад хувьсах зардал
1.Улаанбаатар	3300	300	3000
2.Дархан-Уул, Орхон аймаг	4700	400	4200
3.Бусад аймаг	7600	1100	6500

2. Төрийн албан хаагчийн албан ажлын үнаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийг 1 дүгээр хавсралт ёсоор, нутгийн удирдлагын байгууллагын хувьсах зардлын хэмжээг тооцож аргачлалыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

3. Хүн амын жил бүрийн статистик мэдээний дагуу тухайн орон нутагт оршин сууж байгаа бөлэн хүн амын тоог үндэслэн нутгийн удирдлагын тухайн жилийн хувьсах зардлын хэмжээг тооцож байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН АЖЛЫН УНАА, ӨРӨӨНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ТАВИЛГА, ХЭРЭГСЛИЙН НИЙТЛЭГ ЖИШИГ

Нэг. Тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах албан тушаалтан
/Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга,Нийслэлийн Засаг даргын орлогч дарга, тэдгээртэй адилтгах албан тушаал/

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1.	Албан ажлын хэрэгцээний суудлын автомашин	Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны хувьд 100 км-т 12-13 литрээс илүүгүй шатахууны зарцуулалт бүхий 15 сая хүртэл төгрөгийн үнэтэй суудлын автомашин хэрэглэнэ.
2.	Албан ажлын хэрэгцээний гар утас	Албан ажлын хэрэгцээний гар утас хэрэглэх эрх бүхий албан тушаалтан 130 мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй гар утас хэрэглэх бөгөөд гар утасны сарын нийт хэрэглээний зардал 65 мянган төгрөгт багтана.
3.	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
4.	Шалны дэвсгэр	1
5.	Номын тавиур (ханын шүүгээ)	1
6.	Бичгийн ширээ	1
7.	Бичгийн ширээний сандал	1
8.	Компьютер (иж бүрдэл)	1
9.	Зөвлөлгөөний ширээ	1
10.	Зөвлөлгөөний ширээний сандал	10
11.	Телефон утас	1
12.	Тооны машин	1
13.	Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
14.	Компьютерийн ширээ	1

Албан ажлын өрөөний талбайн хэмжээ: 36 ам метр хүртэл.

Хоёр. Эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах албан тушаалтан
/Яамны газрын дарга, орлогч, Засгийн газрын агентлагийн дэд дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга,аймгийн Засаг даргын орлогч,аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх газрын дарга, тэдгээртэй адилтгах албан тушаал/

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1.	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2.	Шалны дэвсгэр	1
3.	Бичгийн ширээ	1
4.	Бичгийн ширээний сандал	1
5.	Компьютер (иж бүрдэл)	1
6.	Зөвлөлгөөний ширээ	1
7.	Зөвлөлгөөний ширээний сандал	10 хүртэл
8.	Телефон утас (дотоод холбооны утас орохгүй)	1
9.	Тооны машин	1
10.	Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1

11.	Компьютерийн ширээ	1
12.	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Албан ажлын өрөөний талбайн хэмжээ: 24 ам метр хүртэл.

Гурав. Ахлах түшмэл
/түүнтэй адилтгах албан тушаалтан/

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1.	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2.	Шалны дэвсгэр	1
3.	Бичгийн ширээ	1
4.	Бичгийн ширээний сандал	1
5.	Компьютер (иж бүрдэл)	1
6.	Телефон утас	1
7.	Тооны машин	1
8.	Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
9.	Компьтерийн ширээ	1
10.	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Тайлбар:

Нэг ахлах түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна.

Дөрөв. Дэс түшмэл
/түүнтэй адилтгах албан тушаалтан/

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1.	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2.	Шалны дэвсгэр	1
3.	Бичгийн ширээ	1
4.	Бичгийн ширээний сандал	1
5.	Компьютер (иж бүрдэл)	1
6.	Телефон утас	1
7.	Тооны машин	1
8.	Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
9.	Компьтерийн ширээ	1
10.	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Тайлбар:

Нэг дэс түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна.

Тав. Төрийн үйлчилгээний удирдах албан хаагч

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1.	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2.	Хивс (дэвсгэр)	1
3.	Бичгийн ширээ	1
4.	Бичгийн ширээний сандал	1
5.	Компьютер (иж бүрдэл)	1
6.	Зөвлөлгөөний ширээ	1
7.	Зөвлөлгөөний ширээний сандал	10 хүртэл
8.	Телефон утас	1
9.	Тооны машин	1
10.	Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
11.	Компьтерийн ширээ	1
12.	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Албан ажлын өрөөний талбайн хэмжээ: 24 ам метр хүртэл.

Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

НУТГИЙН УДИРДЛАГЫН ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьсах зардлын нормативыг үндэслэн нутгийн удирдлагын байгууллагын дунд хугацааны болон тухайн жилийн хувьсах зардлыг төлөвлөхдөө энэхүү аргачлалыг мөрдөнө.

2. Нутгийн удирдлагын байгууллагуудад аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын байгууллага, аймаг, нийслэлийн Төрийн өмнөх шалгах хороо, орон нутгийн Статистикийн хэлтэс, Стандартчилал, хэмжил зүйн төв, Мэргэжлийн хяналтын алба, Нийтлэг үйлчилгээний газар зэрэг байгууллагуудыг хамруулна. Нийслэлийн хувьд дээрх байгууллагуудаас гадна Дэрэг иргэний хамгаалалтын газар, Хүүхэд халуучуудын хөгжлийн газар, Архивын алба, Хот байгуулалт,газрын харилцааны газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Соёлын газар, Биеийн тамир, спортын хороо, Байгаль орчин, экологийн хяналтын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын алба зэргийг оруулан тооцно.

3. Хувьсах зардалд орон байрны ашиглалттай холбоотой дулаан, цахилгааны эрчим үч, хэрэгцээний халуун болон цэвэр, бохир усны зардал, байрны түрээсийн хөлс, хөренгө оруулалтын онапартай арга хэмжээний зардал болон орон нутгийн өсвийн ангилагдаагүй зардлаас гарах зориулалт үйхий зардлаас бусад урсгал зардал орно. Үүнд:

Хувьсах зардлын нийт хэмжээг тооцохдоо хувьсах зардлын онцлог, шууд нөлөөлөх үзүүлэлтийг аргалзан 2 ангилж тооцно.

А. Тээвэр, дотоод албан томилолт;

Б. Бусад хувьсах зардал.

Хувьсах зардлын нийт хэмжээг тооцохдоо дараахь томъёог ашиглана:

. = [На.т /тухайлбал 1100,0 мян.₮/ * К алс * S х.а (1 + К и + К у.з)]+[Нб /тухайлбал 6500,0 мян.₮/ * х.а * (1 + К и + К у.з)]

үнээс:

А – Тухайн нутгийн удирдлагын айгууллагын хувьсах зардлын нийт хэмжээ;

На.т – 1000 хүн амд ногдох албан томилолт, эвэр, шатахууны зардлын жилийн батлагдсан орматив;

К алс -нийслэлээс аймгийн төв, аймгийн төвөөс сумдын алслагдлын итгэлцүүр;

S х.а – тухайн аймгийн хүн амын тоо /мянган хүнээр/;

К и -тухайн жилд болон дунд хугацааны төсвийн хугацаанд тэр, засгаас төсвийн зардлыг хэмнэх чиглэлээр тавьсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдон хувьсах зардалд орох өөрчлөлтийн итгэлцүүр;

К у.з –тухайн жилд болон дунд хугацааны төсвийн хугацаанд тэр, засгаас удирдлагын зардлыг нэмэгдүүлэх болон бууруулах талаар авсан бодлогын чанартай арга хэмжээтэй холбогдуулан удирдлагын зардлыг нэмэгдүүлэх, бууруулах итгэлцүүр;

Нб -1000 хүн амд ногдох бусад хувьсах зардлын жилийн батлагдсан норматив;

Аргачлалын тайлбар:

Алслагдлын итгэлүүрийг дараахь байдлаар тооцно:

К алс = {[(3 н + 3 с):3040.7 буюу 321, 251] –1):10+1;

3 н -нийслэлээс аймгийн төв хүртэлх зай /километрээр/;

3 с -аймгийн төвөөс сумд хүртэлх зайны нийлбэр дүн /километрээр/;

100 -Улаанбаатар хотын алслагдлын хэмжээ;

321 -Дархан-Уул,Орхон аймгийн алслагдлын дундаж хэмжээ;

3040,7 –Бусад аймгуудын алслагдлын дундаж хэмжээ.

4. Төр, засгаас төсвийн зардлыг хэмнэх чиглэлээр тавьсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах хувьсах зардлын өөрчлөлтийн итгэлцүүрийг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн харьцаа, эдгээр зардлын үнэ, тариф, ханшийн өөрчлөлт, төсвийн боломжийг харгалзаж, харин удирдлагын зардлыг нэмэгдүүлэх, бууруулах

итгэлцүүрийг Засгийн газар болон төрийн дээд байгууллагаас тавьж байгаа зорилтуудыг харгалзан тухайн жилийн болон дунд хугацааны төсвийн теслийг боловсруулахдаа Санхүү, эдийн засгийн яам тооцно.

5. Дээрх аргачлалыг баримтлан Баянхонгор аймгийн удирдлагын байгууллагын дүнгээр хувьсах зардлын хэмжээг тооцох жишээг авч үзье:

1. З н = 630 км
2. З с = 3039 км
3. S х.а – 84,8 мянга
4. К и – 0
5. К у.з – 0 гэж үзвэл,

К алс = {[(З н + З с):3040.7] –1):10+1= {[(630+3039):3040.7] –1):10 +1 = 1,02

А = [Н а.т * К алс * S х.а * (1 + К и + К у.з)]+ [Нб * S х.а * (1 + И + К у.з)] = [1100000 ₮ * 1,02 * 84,8 *(1+0+0)] +[6500000₮*84,8* (1+0+0)] = 96,5 + 551,6 = 648,1 сая төг.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 18–ны өдөр | **Дугаар 121** | **Улаанбаатар хот**

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ,сургалт,мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв байгуулах тухай

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1997 оны 95 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хууль зүйн мэдээллийн төв, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Прокурорын давтан сургалтын төв (Улсын ерөнхий прокурортой зөвшилцсөнөөр), Цагдаагийн академийн дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэн болон Хуульчдыг давтан сургах төвийг тус тус нэгтгэж, Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

2. Тус төвийн хөвийн үйл ажиллагаа хангахын тулд холбогдох хуульд зааасан санхүүжилтийн эх үүсвэрээс гадна Хууль зүй, дотоод хэргийн яамны эрдэм шинжилгээний ажлын захиалгыг санхүүжүүлэх хэлбэрээр төсвийн санхүүжилтийг эхний 2 жил хүртэлх хугацаанд уг яамаар дамжуулан олгох, цаашид бусад эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын жишгээр санхүүжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Төвийн дүрэм, орон тоо, төсвийг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, төвийн байрны асуудлыг шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 125 | Улаанбаатар хот

Төлш, эрчим хүчний салбарын 2002-2003 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төлш, эрчим хүчний хангамж, өвлийн бэлтгэлийг хангахтай холбогдсон барилга, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн төлөвлөгөө, графикийн биелэлтэд тогтуу хяналт тавьж нүүрс, мазут нийлүүлэх, үзвэрлэх, нөөцлөх ажлыг эрчимжүүлэн энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор цахилгаан станцын өвлийн горимын хэрэгцээт түлшний нэг сараас доошгүй хэмжээний нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК, "Налайхын дулааны станц" ХК-ийн 2002 оны эхний хагас жил дууталх хугацааны эх үүсвэргүй алдагдлыг улсын төсвөөс зохицуулан санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 126 | Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдон "Аймгийн Засаг даргын замгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын үйлчилгээний шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "Санхүү, эдийн засгийн дэд сайд" гэснийг "Эдийн засаг, сангийн хэлтэс" гэснийг "Эдийн засаг, үйлдвэрлэлийн хэлтэс" гэж, "Үйлдвэр, худалдаа, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хэлтэс" гэснийг "Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хэлтэс" гэж, мөн "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Санхүүгийн бодлогын хэлтэс" гэснийг "Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс" гэж тус тус өөрчлөн 2002 оны батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 1–ний өдөр | Дугаар 133 | Улаанбаатар хот

Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Нийслэлд мал аж ахуй эрхлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, худалдах явдлыг эмх цэгцтэй болгох, хүн, малын гоц халдварт өвчнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийслэлд мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого" хөтөлбөрийг хавсралт ёсоор батална.

2. Энэхүү хөтөлбөр батлагдсантай холбогдуулан мал, амьтны гаралтай түүхий эд боловсруулах, худалдах, мал эмнэлэг, ариун цэврийн талаар гарсан журмуудад холбогдох өөрчлөлт оруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрсдийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг аль болох өргөнөөр ашиглахыг Нийслэлийн Засаг дарга М.Энхболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт тус тус даалгасугай.

4. Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод даалгах нь:

а/нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлсүгэй;

б/мал, амьтны гаралтай түүхий эд борлуулах захыг нийслэлийн суурьшсан хэсгээс гаргаж хотын өрөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлегөөтэй уялдуулан хотын баруун болон зүүн хэсэгт шилжүүлэн байршуулах арга хэмжээ авсугай;

в/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө. ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2002 оны 133 дугаар тогтоолын хавсралт

"НИЙСЛЭЛД МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийслэлд мал аж ахуй эрхлэх нөхцөл, боломж

1. Бэлчээрийн нөөц, түүний ашиглалт, хамгаалалт. Нийслэл 470.4 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд түүний дотор 327.8 мянган га бэлчээр, 110.7 мянган га ойн сан, 5.9 мянган га усан сан бүхий газартай. Бэлчээрийн даац 144.7 мянган хонин толгой малд хүрэлцээтэй байхад 2001 оны малын тооллогын дүнгээс үзвэл энэхүү үзүүлэлт нь 4.7 дахин хэтэрсэн байна. Бэлчээрийн 15.3 хувь нь хүчтэй талхлагдсан, 17.9 хувь нь дунд зэрэг талхлагдсан байна. Нийслэл нь 5453 га хадлангийн газартай байсан боловч үүний 50 гаруй хувийг суулийн жилүүдэд бэлчээрт ашигласан байна. Хадлангийн талбайгаас 4117.1 тн өвс бэлтгэх боломжтой байгаа нь хотын өнөөгийн хэрэгцээний 10 хүрэхгүй хувийг хангах юм. 2001 онд нийслэлийн хэмжээнд 35.9 мянган тн байгалийн хадлан, 423.2 тн таримал ногоон тэжээл, 68.7 тн хужир бэлтгэсэн байна.

2. Мал аж ахуйн өнөөгийн байдал. 2001 оны эцсийн байдлаар 221.4 мянган толгой мал тоологдсоны 53.9 хувь нь төвийн 6 дүүргэт, үлдэх хэсэг нь хөдөөний 3 дүүргэт байна. Хотын барилгажсан хэсэгт 20.5 мянган толгой мал байрлаж байна. Нийслэлийн хэмжээнд малтай өрх

7496 байгаагийн 3901 нь төвийн 6 дүүрэгт, 3595 нь Налайх, Багахангай, Багануур дүүрэг, Жаргалант, Гачуурт тосгонд байна. Малтай өрхийн 3976 нь 10-аас цөөн, 1606 нь 30 хүртэл, 1422 нь 100 хүртэл, 481 нь 100-500 хүртэл, 11 нь 1000 хүртэл малтай байна. Малын бүтцийг авч үзвэл хотын суурьшсан хэсэгт үхэр, хот орчимд хонь давамгайлж байна. Түүнчлэн нийслэлд 1134 гахай, 38573 шувуу үржүүлж байна.

Мал эмнэлгийн байгууллагын судалгаанаас үзвэл бруцеллёз, боом, цусан халдвар, дуут, сохор догол, балцруу зэрэг халдварт өвчний голомт байгаа бөгөөд нийслэлийн нутаг дэвсгэрт 2001 онд малын гоц халдварт шүлхий өвчин, 2002 онд боом өвчин гарснаар эрэлт хэрэгцээг, нийгмийн ихээхэн хохирол учирч ажуулгай байдал үүсч байсан юм. Шүлхий өвчин гарсан үед зөвхөн 1 сарын хорио цээр тогтооход 2.5 тэрбум төгрөгийн шууд зардал гарчээ. Иймхүү нийслэлд хорио цээрийн дэглэм тогтоох нь улсын гадаад, дотоод харилцаанд ч бэрхшээл учруулж болзошгүй бодит нөхцөлийг бий болгож байна.

3. Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэл, борлуулалтын өнөөгийн байдал. Улаанбаатар хотын хүн амын хүнсний хэрэгцээг хангахад жилд наад зах нь 59 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 147.8 мянган тонн сүү, цагаан идээ, 5.1 мянган тонн цөцгийн тос, 70.9 мян ширхэг өндөг шаардлагатай бөгөөд энэ хэмжээ 2005 оны түвшинд 1.2 дахин, 2010 оны түвшинд 1.5 дахин нэмэгдэх тооцоотой байна.

Хөдөөгийн иргэд, байгууллага үйлдвэрлэсэн малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн ихэнхийг нийслэлд борлуулан үйлдвэр, хүн амын эрэлт хэрэгцээг хангаж байна. Малын гаралтай бүтээгдэхүүнийг ариун цэвэр, зөрүүл ахуйн баталгаагүй орчинд худалдаж байгаа нь хүнсний ажуулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Улаанбаатар хотод 95 ам ахуйн нэгж мал, амьтны гаралтай түүхий эд цуглуулах, боловсруулах үйл ажиллагаа явуулж байна. Түүлийн жилүүдэд гудамж талбайд түүхий эдийн үдалдаа хийх, малыг хашаандаа нядлах явдал ч хэсэч байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

4. Мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зах зээлийн ойр дот, зам харилцаа, дэд бүтэц сайтайг нь түшиглэн Улаанбаатар хотын ойр орчимд мал аж ахуй эрхлэх болсон нь бэлчээрийн хомсдол бий болгож, газрын төрх байдал ихээхэн өөрчлөгдөж экологийн хямралт байдал үүсээд байгааг үндэслэн; хот орчимд өндөр үр ашигтай эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх шаардлагатайг харгалзан; хүн ам төвлөрсөн хот, суурин газарт мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага хангаагүй, боловсруулалт хийгдээгүй мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд оруулж ирж байгаа нь Үндэсэн хууль заасан эрх эрүүл, аюулгүй орчинд амьдрах иргэний эрх зөрчигдөхөд хүрч байгааг үндэслэн; мал, амьтны өвчлөлт нэмэгдэн гоц халдварт өвчин гарч нийслэл төдийгүй улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүйг харгалзан; хотын хэмжээнд мал, амьтны өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээг сайжруулах, мал эмнэлэг, хорио цээрийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлага зэргийг харгалзан энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Нийслэлд мал аж ахуй эрхлэх бодлого

5. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нийслэлд мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаа нийгэм, эдийн засаг, экологийн талаас нь иж бүрэн харгалзан үзэж, тодорхой хязгаарлалттайгаар бүсчилэн хөгжүүлэх зорилтыг энэхүү хөтөлбөрт дэвшүүлж байна.

6. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийг тогтоохдоо дараахь үндэсэн зарчмыг баримтална:

а/хотын ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын барилгажсан хэсэг, Салхитын амнаас цааш Шадивлан, Яргайт, Жигжид, Шаргаморьт, Мухар, Баянбулаг, Майхан толгой, Санзай, Баян, Бэлх, Сэлхи болон Гачуурт гол, Улиастайн голын адаг хэсэг, тэдгээрийн хажуугийн ам хөндийд байрлах амралт, сувиллын цогцолбор бүхий газруудд, тохилог сууц бүхий жижиг суурин, тэдгээрийн хоорондын байгалийн тэнцлийг хадгалахуйц нөгоон бүсэд мал аж ахуй эрхлэхгүй байх;

б/аялал жуулчлал, амралт, сувиллын газруудын байгаль–экологийн нөхцөл, гоо

үзэсгэлэнг алдагдуулахгүй байх;

в/Улаанбаатар хотын экологийн тэнцлийг хадгалан хотыг тойрсон хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас зааглах экологийн хязгаарлалтын бүсчилэл тогтоох;

г/Улаанбаатар хотын үндны усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зорилтыг шийдэх үүднээс хотын төвлөрсөн усан хангамжийн гүний усны эх булаг Туул голын сав, түүнийг дагалдах тодорхой хэсгийн ашиглалтыг горимлох;

д/тодорхой хуваарь, сэлгээ, зохион байгуулалтгүй ашиглаж доройтсон бэлчээр болон бусад зориулалтын газрыг нөхөн сэргээх;

е/хотын байгаль экологийн онцгой ач холбогдол бүхий ойн ландшафтыг хамгаалах, нөхөн сэргээх;

ж/техникийн аюулгүй ажиллагааг хангах хамгаалалтын зурвас газар бий болгох.

Эдгээр зарчмыг баримтлан нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хилийн зурвасыг Газрын тухай хуулийн холбогдох заалтын дагуу нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн нийслэлийн Засаг дарга тогтооно.

7. Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх бүс. Нийслэлийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг мал аж ахуйд ашиглах үүднээс тухайн нутгийн бэлчээрийн хүрэлцээ, даацад тохирсон үйл ажиллагаагаар тодорхой хязгаарлалттай явуулна. Энэхүү хязгаарлалт тогтоох үндэслэл нь тухайн газрын бэлчээрийн нөөц, бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, хотын хөгжлийн чиг хандлагаар тодорхойлогдоно. Хязгаарлалтыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэл, малын тоо толгойг зохицуулах замаар тогтооно. Нийслэлд мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх бүсэд хотын баруун болон баруун өмнөд талд Сонгинохайрхан дүүргийн 20, 21 дүгээр хороо бүхэлдээ, Хан-Уул дүүргийн 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрийн тодорхой хэсгүүд, зүүн болон зүүн өмнөд талд Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хорооны зарим хэсэг, Налайх орчмын газрууд хамрагдах бөгөөд мал аж ахуй эрхлэх бүсийг үйлдвэрлэлийн чиглэлээр нь эрчимжсэн мал аж ахуйн болон өрхийн мал аж ахуй эрхлэх гэсэн 2 дэд бүсэд хуваан хөгжүүлнэ.

8. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүс нь Сонгинохайрхан дүүргийн Жаргалант, Баянзүрх дүүргийн Гачуурт-Улиастайн сав газрууд хамрагдана. Энэ бүсэд сүү, махны чиглэлийн ашигшим өндөртэй хязгаарлагдмал тооны малыг байлгахаас гадна малын тэжээл бэлтгэх, тариалах тэжээл, төмс, хүнсний ногооны чиглэлээр газар тариаланг хөгжүүлнэ.

9. Өрхийн мал аж ахуйг эрхлэх бүс нь баруун талдаа Сонгинохайрхан, Баянцогт уулын арын ухаа гүвээт толгод, Бөхөг-Тургэний голын сав, Өлзийт, Туул хорооны орчмын нутаг, зүүн талдаа Хонхороос цаашхи Хөлийн голын дээд хэсэг, Буурлын давааны ар, Налайх орчмын газруудыг хамрагдана.

10. Нийслэлийн мал аж ахуйн салбарыг тогтвортой, үр ашигтай хөгжүүлэхэд хот орчмын хөдөө аж ахуйн газрыг бүрэн дүүрэн зөв зохистой ашиглах бодлого баримтална.

Дөрөв. Нийслэлд мал болон амьтны гаралтай түүхий эдийн худалдааны талаар баримтлах бодлого

11. Мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах төвүүдийг тээврийн сүлжээ, гадаад, дотоод зах зээлийн нөхцөл бололцоо, дэд бүтцийн хангамжийг харгалзан, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хотын баруун, зүүн захад төвлөрүүлэн байршуулж хөгжүүлнэ.

Тав. Хөтөлберийн зорилго, зорилтууд

12. Мал аж ахуйг тодорхой бүс нутагт өсгөн үржүүлэх, малын гаралтай түүхий эдийг тусгайлсан газар хүлээн авах замаар нийслэлийн нийгэм-эдийн засагт үлэмж хохирол учруулж болзошгүй мал, амьтны гоц халдварт болон халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл орчинд амьдрах баталгаат хангах байгаль-экологийн тэнцвэрийг хадгалахад энэхүү хөтөлберийн зорилго оршино.

13. Хөтөлберийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилт дэвшүүлж байна:

а/нийслэлийн нутаг дэвсгэрийн нөөц боломжид нийцүүлэн хүн амын эрүүл мэнд, хот тохижилт, ариун цэвэрт хохирол учруулахгүйгээр мал аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэх;

б/мал, амьтны гаралтай түүхий эдийг гүсгайлан тогтоосон газарт хүлээн авах, түүний эдэд тавих мал эмнэлэг, хорио цээрийн хяналтыг сайжруулах;

в/мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх арга хэмжээ авч мал, амьтны халдварт өвчин гарах нөхцөлийг хязгаарлах;

г/хот орчмын бүсэд эрчимжсэн мал аж ахуй, тэжээлийн аж ахуй эрхлэх, түүнд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг бүрдүүлэх;

д/бэлчээр ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, арга хэмжээ

14. "Нийслэлд мал аж ахуйн талаар баримтлах бодлого" хөтөлбөр нь 2002-2010 оныг хамрах бөгөөд дараахь үе шаттай байна:

I үе шат - 2002-2003 он;
II үе шат - 2004-2005 он;
III үе шат - 2006-2010 он.

15. Хөтөлбөр хэрэгжүүлэх I үе шатанд хотын хүн ам төвлөрсөн төвийн суурьшсан хэсгээс гаралтай өрхийг нүүлгэн шилжүүлэх бэлтгэлийг ханган улмаар зөвшөөрсөн бүсэд суурьшуулах, мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах, орилжих, мал нядлах үйл ажиллагааг хотын захад төвлөрүүлэх бэлтгэлийг ханган эхлүүлэх, мал эмнэлэг, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог үрдүүлэх арга хэмжээ авна.

16. Хөтөлбөр хэрэгжүүлэх II үе шатанд хот орчмын ногоон бүсээс мал бүхий өрхийг нүүлгэн шилжүүлж зөвшөөрсөн бүсэд суурьшуулах болон мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах зэгийг хотоос гарган байршуулж дуусгах, шилэлийн малыг эрүүлжүүлэх иж бүрэн арга хэмжээ авч гэрчилгээжүүлэх, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн хяналтын лаборатори байгуулах, түүхий эдийн захыг тохижуулах зэрэг ажлыг хийнэ.

17. Хөтөлбөр хэрэгжүүлэх III үе шатанд хөтөлбөрийн I, II үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг баталгаажуулан, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ. Мал аж ахуй эрхлэгчдийг нарийн хуваарьт эдлэнтэй болгон, эрчимжсэн аж ахуйд бэлчээр, хадлан, тариалангийн газрыг зээмшүүлж, бэлчээрийн менежментийг боловсронгуй болгоно. Талхлагдсан бэлчээр, хадлангийн талбайг нөхөн сэргээх, таримал бэлчээр, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлнэ. Эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг хөгжүүлнэ. Түүхий эдийг хадгалах, худалдах, боловсруулах технологийг боловсронгуй болгоно.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

18. Мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх, суурьшуулах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нүүн шилжихгүй иргэдийн малыг худалдан борлуулах, дэд бүтэц бий болгох, бэлчээр усжуулах, тэжээл бэлтгэх, хашаа саравч барих, малын үүлдэр угсаат сайжруулахад нь туслах, зарим газарт зам засах, шинээр тавих, хүн, мал эмнэлгийн үйлчилгээг өргөтгөх, түүхий эдийн захыг хотоос гаргах, чөлөөлөгдсөн газрыг нөхөн сэргээх зэрэг ажилд эхний 3 жилд 3 тэрбум 969.6 сая төгрөгийн зардлыг төсвөөс зарцуулна.

Найм. Гарах үр дүн, шалгуур, үзүүлэлт

19. Гарах үр ашиг:

а/нийслэлийн бэлчээрийн газрын зохион байгуулалтыг боловсронгуй болгон малыг оновчтой байршуулснаар бэлчээрийн талхлагдлыг багасгаж, байгаль орчныг хамгаалах боломж бүрдэнэ;

б/байгаль-экологийн тэнцлийг хангасанаар нийслэлийн нутаг дэвсгэрт тогтвортой хөгжлийг баталгаажуулна.

20. Эдийн засгийн үр ашиг:

а/малыг ус, бэлчээрийн таатай нутагт шилжүүлснээр ашиг шим нь нэмэгдэж, мал эмнэлэг, үржлийн албаны ажил, үйлчилгээ сайжирч өвчний гаралт багасна;

б/бэлчээр ашиглалтыг эдийн засгийн аргаар зохицуулах боломж бүрдэж, хотын төсөвт хуримтлалын эх үүсвэр бий болно;

в/эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлснээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

21. Нийгмийн үр ашиг:

а/хотын иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөл, боломж баталгаажина;

б/хүнсний аюулгүй байдал хангагдана;

в/мал, амьтнаас хүнд халдварлах өвчнөөс ард иргэдээ хамгаалж, Улаанбаатар хот мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр ажил, үйлчилгээ явуулдаг цэг, салбарын хог хаягдлаас цэвэршихээс гадна хотын суурьшлын хэсгийн хэт ачааллыг багасгана;

г/мал эмнэлгийн болон үржлийн ажил, үйлчилгээ тогтворжин малын хөдөлгөөнд хяналт тавих боломж бүрдэнэ.

22. Технологийн үр ашиг. Хот орчимд уламжлалт мал аж ахуйг хязгаарлан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлснээр малын ашиг шимийг бүрэн ашиглах хаягдалгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

23. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуураар үнэлнэ:

1. Мал бүхий өрх болон мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах, арилжих цэгийг хотоос нүүлгэн шилжүүлсэн байх.

2. Мал аж ахуй, мал, амьтны гаралтай түүхий эдийг хүлээн авах цэгийг зөвшөөрсөн бүс нутагт байршуулж иргэдийн ажиллах, амьдрах нийгмийн нөхцөлийг бүрдүүлсэн байх.

3. Бэлчээрийн ашиглалт сайжирч бэлчээр, тэжээлийн талбайг нөхөн сэргээх арга хэмжээ авсан байх.

4. Мал, амьтны халдварт, паразит өвчний гаралтыг тогтвортой бууруулсан байх.

24. Хөтөлбөрийн шалгуурыг хэмжих үзүүлэлт. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуурыг дараахь үзүүлэлтэр хэмжинэ:

а/1 дүгээр шалгуурыг-нүүлгэн шилжүүлсэн өрх, мал, түүхий эд хүлээн авах цэгийн тоо, түүний одоогийн байдалтай харьцуулсан хувь, хотын зөвшөөрөөгүй нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхэлж байгаа эсэх, мөн зөвшөөрөөгүй газарт мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах үйл ажиллагаа явагдаж байгаа эсэх, эдгээр үйл ажиллагааг зохицуулахаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн заалт нэг бүрээр хэмжинэ;

б/2 дугаар шалгуурыг-мал аж ахуй эрхлэх болон мал, амьтны гаралтай түүхий эд хүлээн авах бүс нутагт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт, бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг болон иргэдийн санал, гомдлын байдлаар хэмжинэ;

в/3 дугаар шалгуурыг-бэлчээрийг эзэмшүүлсэн байдал, нөхөн сэргээсэн болон тариалжуулсан талбай, талхлагдсан газрын багасалт, газрыг нөхөн сэргээх, сайжруулахад оруулсан хөрөнгө оруулалтын үр ашиг, газрын төлөв байдлын чанарын үзүүлэлтээр хэмжинэ;

г/4 дүгээр шалгуурыг-малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал, оруулсан хөрөнгө оруулалтын үр ашиг, эпидемиологийн холбогдлын хувьд халдварт өвчний гаралт, өвчлөл, хорогдлын бууралт, гоц халдварт болон халдварт өвчний улмаас эдийн засаг, нийгэмд учирсан хохирлын хэмжээ зэрэг үзүүлэлтээр хэмжинэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2.5 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (270)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай*
- *Гэрээ соёрхон батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны есдүгээр сарын 7 №33 (270)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

462. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-8-30-ны хууль) 1044
463. Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай (2002-8-30-ны хууль) 1045
464. Гэрээ соёрхон батлах тухай (2002-8-30-ны хууль) 1045

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

465. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 59 1045
466. Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 60 1045
467. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 61 1046
468. Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 62 1046

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

469. Элчин сайдыг томилох тухай Дугаар 119 1046
470. Геннадий Матвеевич Фадеевийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 120 1046
471. Чой Ен Чхөрийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 121 1047
472. Шожи Куног "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 122 1047
473. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 123 1047
474. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 124 1047

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

475. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 129 1048
476. "МИАТ" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 134 1069
477. Журам батлах тухай Дугаар 135 1069

2002 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН 2002 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан улсын төвлөрсөн төсвийн орлогын дараахь нэр төрлийн дүнг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

/мянган төгрөгөөр/

1.1.ОРЛОГО-БҮГД	**12,882,175.8**
1.1.1.в. онцгой албан татвар	551,525.5
1.1.1.г. автобензин, дизелийн түлшний албан татвар	228,000.0
1.1.1.е. бусад албан татвар	9,713,939.9
1.1.2. Татварын бус орлого	**20,723,817.2**
1.1.2. б. бусад орлого	105,000.0
1.1.2. д. төсөвт байгууллагын өөрийн орлого	20,618,817.2

2 дугаар зүйл. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан улсын төвлөрсөн төсвийн орлогын дараахь нэр төрлийн дүнг дор дурдсанаар хорогдуулсугай:

1.1.1. Албан татварын орлого	**7,841,641.4**
1.1.1.а. орлогын албан татвар	11,056,643.3
1.1.1.б. нэмэгдсэн өртөгийн албан татвар	6,579,077.3
1.1.1.д. гаалийн албан татвар	559,400.0
1.1.1.ж. нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	139,986.2

3 дугаар зүйл. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан улсын төвлөрсөн төсвийн 2002 оны зарлагын хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

2.1.ЗАРЛАГА-БҮГД	**5,788,076.5**
2.1.1. Цалингийн сан	11,021,939.9
2.1.3. Батлан хамгаалах арга хэмжээний зардал	34,971.6
2.1.9. Улсын дээд шүүхийн төсөв	83.3
2.1.10. Орон нутгийн шүүхийн төсөв	3,249.1
2.1.11. Прокурорын байгууллагуудын нэгдсэн төсөв	2,292.8
2.1.12. Тагнуулын ерөнхий газрын төсөв	142,444.2

4 дүгээр зүйл. Монгол Улсын 2002 он төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл заасан улсын төвлөрсөн төсвөөс аймгуудын төсө олгох санхүүжилтийн дээд хэмжээг дор дурдсана нэмэгдүүлсүгэй:

3.1. САНХҮҮЖИЛТИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ	**405,509.8**
3.1.2. Баян-Өлгий	28,288.5
3.1.3. Баянхонгор	136,664.9
3.1.5. Говь-Алтай	54,964.5
3.1.7. Дорнод	33,791.2
3.1.11. Өмнөговь	136,474.8
3.1.13. Сэлэнгэ	57,381.8
3.1.15. Увс	16,435.0
3.1.16. Ховд	25,263.2
3.1.18. Хэнтий	32,826.7
3.1.19. Дархан-Уул	42,920.5
3.1.20. Говь-Сүмбэр	6,047.5

5 дугаар зүйл. Монгол Улсын 2002 он төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүй заасан улсын төвлөрсөн төсвөөс дараа аймгуудын төсөвт олгох санхүүжилтийн дэ хэмжээг дор дурдсанаар хорогдуулсугай:

3.1.1. Архангай	34,703.8
3.1.4. Булган	2,650.8
3.1.6. Дорноговь	14,969.8
3.1.8. Дундговь	47,786.0
3.1.9. Завхан	3,750.0
3.1.10. Өвөрхангай	10,199.3
3.1.12. Сүхбаатар	22,938.2
3.1.14. Төв	3,758.8
3.1.17. Хөвсгөл	24,792.2

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

02 оны 8 дугаар
рын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 7 дугаар сарын 4-ий өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн "лсын дээд шүүх, түүний бүрэн эрх" гэсэн 15 гаар зүйлийн 15.2 дахь хэсгийн дагаж мөрдөх гацаас 2002 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ртэл хойшлуулсугай.

2 дугаар зүйл. 1993 оны 2 дугаар сарын 4-ий өдрийн Шүүхийн тухай хуулийн "Улсын дээд үүх, түүний бүрэн эрх" гэсэн 24 дүгээр зүйлийн 2 ах хэсгийн заалтыг энэ хуулийн 1 дүгээр зүйлд асан хугацааанд хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

3 дугаар зүйл. 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө анхан шатны журмаар аймаг, нийслэлийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийг Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

02 оны 8 дугаар
рын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн нк хооронд 2002 оны 8 дугаар сарын 26-ны өдөр йгуулсан Боловсролын салбарын хөгжлийн ёрдугаар төслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

02 оны 8 дугаар
рын 29-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы ралдааны дэгийн 14.3-т заасныг үндэслэн нгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын толцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэх тлах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар гтоолын хавсралтад Батлан хамгаалахын йдын эрхлэх асуудлын хүрээнд Мэдээлэл, далгааны газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн эрхтэй байгуулахаар заасан нь Батлан хамгаалах тухай, Тагнуулын байгууллагын тухай, Зэвсэгт хүчний тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилтэй болсон байх тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

02 оны 8 дугаар
рын 29-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы алдааны дэгийн 14.4-т заасныг үндэслэн Монгол сын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын толцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэх лах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тоолын хавсралтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнийн "16.Мэдээлэл, судалгааны газар" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 29-ны өдөр **Дугаар 61** **Улаанбаатар хот**

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурал 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн зарим заалтад Монгол Улсын Ерөнхийлөгчий тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй гэ үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 30-ний өдөр **Дугаар 62** **Улаанбаатар хот**

Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.13-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсантай холбогдуулан 2002 оны 10 дугаар сарын 15-ны дотор Улсын дээд шүүхийн шүүгчдийг сонгон шалгаруулж, шүүгчээр томилуулах тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавь ажиллахыг Хууль зүйн байнгын хоро /Ц.Шаравдорж/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2002 оны 9 дүгээр сары 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 8 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 119** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Лихтенштейний Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаа Хасбазарын Бэхбатыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 8 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 120** **Улаанбаатар хот**

Геннадий Матвеевич Фадеевийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ хоорондын төмөр замын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Зам харилцааны сайд Г.М. Фадеевийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 8 дугаар
арын 13-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар
хот

Чой Ен Чхөрийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ хоорондын найрсаг арилцаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эдийн асаг, хүмүүнлэгийн салбар дахь хамтын жиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулсан хувь эмрийг нь үнэлж БНСУ-аас Монгол Улсад суугаа

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чой Ен Чхөрийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 8 дугаар
арын 26-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар
хот

Шожи Куног "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын харилцаа, хамтын жиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа увь нэмрийг нь үнэлж Япон, Монголын Соёлын ийгэмлэгийн гүйцэтгэх захирал Шожи Куног

"Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 8 дугаар
арын 26-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, өнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар йлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох:

1. Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улс, олбооны Бүгд Найрамдах Бразил Улсад суугаа нц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Балжингийн Нямааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улс, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Пэрэнлэйн Үржинлхүндэвийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 8 дугаар
арын 26-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин равдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, өнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар йлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лодойдамбын Галбадрахыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Пэрэнлэйн Үржинлхүндэвийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 129 | Улаанбаатар хот

Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, Монгол Улсад мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх, дотоод эх үүсвэрээс шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Зохих бэлтгэлийг хангаж Монгол Улсад мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг 2003 оноос мөрдөхөөр тогтоосугай.

4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дархлалын үндэсний хөтөлбөр, вакцинжуулалтын товлолын тухай" Засгийн газрын 1993 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 149 дүгээр тогтоол, "Хүн, мал, амьтны бруцеллёз өвчинтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 119 дүгээр тогтоол, "Тогтоолын заалтад зарим өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 7 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2002 оны 129 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Халдварт өвчнөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудал манай төр, засгийн анхааралд байнга оршиж, энэ талаар зохион байгуулсан олон талт, шат дараалсан арга хэмжээний үрэвр цагаанбурхан, бөөсний хижиг, полиомиелит өвчнийг устгаж, сахуу, хөхүүл ханиад, улаанбурхан, менингококкт халдварын өвчлөлийг хяналтад авсан амжилттайгаар Монгол Улс 21 дүгээр зуунтай золгож буй хэдий ч халдварт өвчинтэй тэмцэх ажил нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

Манай улсад сүүлийн 5 жилд буюу 1997-2001 онд халдварт өвчний 165700 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 140.6 өвчлөл ногдож, халдварт өвчний улмаас 772 хүн нас баржээ.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай" "Дархлаажуулалтын тухай" хуулиудын болон "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын үндсэн зорилтыг хангах таатай орчин бүрдүүлэх зорилгоор:

-Дэлхий нийтэд эмд тэсвэржсэн нянгийн тархалт нэмэгдэж, нянг биотеррозмд ашиглах хандлага өсч байгаас харгалзаж;

-Хүн амын дунд халдварт өвчнөөс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэжжүүлэх зорилгоор;

-Дархлаажуулалтын болон сүрьеэ дархлалын олдмол хомсдол, бруцеллёз өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын туршлага, сургамжид тулгуурлан;

-Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаа

халдварт өвчинтэй тэмцэх талаар дэвшүүлж байгаа зорилт, манай орны халдварт өвчний цаашдын хандлага, халдварт өвчнөөс сэргийлэх, гүүнтэй тэмцэх нэгдмэл бодлогын хүрээнд асуудалд цогцолбороор хандах шаардлагад нийцүүлэн "Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулав.

Хоёр. Халдварт өвчний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

2.1. Дархлаажуулалттай халдварт өвчин

Дархлаажуулалтын хөтөлбөрт багтдаг олоон өвчний эсрэг нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтын хамралт сүрьеэ 98.0 хувь, сахуу, хөхүүл ханиад, татран 95.4 хувь, полиомиелит 95.4 хувь, улаанбурхан 95.0 хувь, В вирус гепатит 95.1 хувьд тус тус хүрч, дархлаажуулалт хариуцсан эмнэлгийн байгууллагуудын 98.0 хувь нь хүйтэн хэлхээний оног техөөрөмжөөр бүрэн хангагдсанаар уг өвтөлбөрийн зорилтууд 1993-2001 онд амжилттай эрэгжсэн боловч сум, багийн түвшинд давтан дархлаажуулалтын хамралт зорилтот түвшинд үрэгүй байна.

Дэлхийн зарим орнуудад 1970 оноос эргийлэх вакцин хэрэглэж эхэлсэн боловч манай лсад нэвтрүүлээгүй байгаа дархлаажуулалт үхий халдварт өвчнүүд тухайлбал, гахай хавдар, лаануд өвчний өвчлөл, хүндрэл манай улсад үүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болж, эвхэн 2000 онд тууралттай халдварт өвчний 420 тохиолдол бүртгэгдсэнээс 48.1 хувь нь абораторийн шинжилгээгээр улаануud өвчин олох нь батлагджээ. 2001 онд гахай хавдар өвчний 795 тохиолдол бүртгэгдж 10.000 хүн ам тутмаас 2 хүн өвчилж, өнгөрсөн онтой харьцуулахад өвчлөл 3.2 дахин нэмэгдэж, 10.000 хүн амд 7.9 ромилээр өссөн байна.

2.2.Сүрьеэ

1995 оноос 21 аймаг, 8 дүүрэг, хүүхдийн эгдсэн эмнэлгийг хамруулан шууд хяналттай ргино хуғацааны курс эмчилгээг эвтрүүлж,сүрьеэгийн оношлогооны 31 аборатортай чанарын хяналтын нэгдсэн сүлжээнд роуулснаар сүрьеэгийн оношлогооны аталгаажилт 8 дахин, халдвартай хэлбэрийн үрьеэгийн бүрэн эдгэрэлттийн түвшин 2.5 дахин эмэгдэн боловч сүрьеэгийн өвчлөл 100.000 хүн амд 127.0 байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн орнуудын өвчлөлийн дунджаас даруй 2.5 дахин их байна.

Хоригдлуудын дунд 1999 онд хийсэн судалгаагаар тэдний өвчлөл нийт хүн амынхаас 26 дахин их байна.

2.3. Гэдэсний халдварт өвчин

Сүүлийн 5 жилд гэдэсний халдварт өвчин ихсэх хандлагатай болсны дотор цусан суулга өвчин 2 дахин нэмэгдэж, А вирус гепатитийн өвчлөл сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд гарах нь ихсэж байна.

Мөн ус, хүнсээр дамжин халдварладаг Е вирус гепатитийг бүрэн оношилж чадахгүй байна. Ус, хүнсний аюулгүй байдлын баталгаажилт хангалтгүй, хөрсний бохирдолт их байгаа нь гэдэсний халдварт өвчин тархах гол нөхцөл болж байна.

2.4 Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчин

1992-2001 онд 59 голомтод 85 хүн тарваган тахлаар өвчилсний 37 нь нас барж, өвчлөл өмнөх 10 жилийнхээс 22-оор өсч, нас баралтын хувь 43.5 болжээ.

Манай орны ойт хээр, хээрийн бүсэд орших 15 аймгийн 70 шахам сум боом өвчний байгалийн нутагшмал голомттойгоос жилд дунджаар 40 орчим хувь нь идэвхжиж мал, хүний өвчлөл ихсэж байна. 1999-2001 онд галзуу, боомоор өвчилсөн малын тоо 2.5 дахин өссөн нь хүний өвчлөл шууд нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд малын бруцеллёз нэмэгдсэнээс хүнд халдварлах, улмаар өвчлөх байдал ихсэж энэ нь хүүхэд, хөдөлмөрийн насныханд зонхилон тохиолдож байна.

2.5. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолын өвчин, бэлгийн замаар дамжих халдвар /цаашид ХДХВ/ ДОХ/БЗДХ гэнэ/.

Сүүлийн жилүүдэд манай оронд бэлгийн замаар дамжих халдвар эрс нэмэгдэж, 1998 онд тэмбүү, заг хүйтэн, трихомониаз өвчнүүд нийт

халдварт өвчний 36.0 хувийг эзэлж байсан бол 2000 онд 42.2 хувь болжээ.

1990-2001 онд төрөлхийн гэмбүүгээр 120 гаруй нярай өвчилсөн нь жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдалд тавих хяналт, холбогдох мэргэжлийн кабинетуудын хамтын ажиллагаа суларсан, хүн амын дунд БЗДХ-ын тархалт ихсэж байгааг харуулж байна. Мөн бэлгийн хөрпес, хламид зэрэг өвчнүүд сүүлийн үед шинээр илэрч, оношлогдоод байна.

БЗДХ-аар өвчлөгсдийн 50 орчим хувийг эрхэлсэн ажилгүй, тэнэмэл, орон гэргүй, төлбөрийн чадвар муутай хүмүүс эзэлж байна.

Манай оронд ХДХВ-ийн халдвар авсан 3 тохиолдол илэрснээс 2 иргэн өвчилж нас барсан байна. Дэлхий дахинд ХДХВ/ДОХ-ын цар тахал дэлгэрч, хөрш ОХУ, БНХАУ-д ХДХВ-ийн халдвар хурдацтайгаар тархаж байгаа нь манай улсад халдвар цаашид нэмэгдэх аюулыг улам ихэсгэж байгаа тул ХДХВ/ДОХ/БЗДХ-ыг тандах судалгаа, сэргийлэлтийг эрс сайжруулж, эмчилгээ, оношлогоог боловсронгуй болгох асуудал нэн тулгамдаж байна.

2.6.Бусад халдварт өвчин

1997-2001 оны байдлаар улсын хэмжээнд томуу, томуу төст өвчин 10.000 хүнд 665.8 тохиолдол бүртгэгдэж, 3 жил тутамд бага хэмжээний, 8 жил тутамд өргөн хэмжээний дэгдэлт ажиглагдаж байна.

XXI зуунд томуугийн 9 дэх цар тахал дэгдэж болзошгүйг дэлхийн хэвлэлүүд мэдээлж байгаатай уялдуулан томуу, томуу төст өвчнийг лабораториор эрт оношлох, бага насны хүүхэд, өндөр настанг тархвар зүйн заалтаар, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, иргэдийг сайн дурын үндсэн дээр дархлаажуулах асуудал шинээр тавигдаж байна.

Сүүлийн 5 жилд менингококкт халдварын 2181 тохиолдол бүртгэгдэж 185 хүн нас барсан байна. Менингококкт халдварын хэтийн хандлагаас үзэхэд Улаанбаатар хотод 2004, 2009, 2014, Дархан хотод 2005, 2011, 2016 онуудад, улсын хэмжээгээр 2014-2016 онуудад эзлэхит 4 дэх дэгдэлт тохиох магадлал байгааг харгалзан сэргийлэх арга хэмжээг дэгдэлтийг үгтуулан авч хэрэгжүүлэх асуудал тулгарч байна. Бактерт мэнэнгийн алаг цоог өвчлөлд зонхилох суурь эзэлдэг гэж дэлхий дахинд үзэж байгаа хэмофилюс нянгийн тархалт манай улсад аль түвшинд байгааг тогтоох, сэрүүлэх бүсийн зарим улс орнуудад амжилттай хэрэглэж эхлээд байгаа энэ халдварын эсрэг вакцины хэрэглээх эсэхийг судлан магадлах шаардлагатай байна.

Сүүлийн 4 жилийн байдлаар улсын хэмжээнд эмнэлгээс шалтгаалсан халдварын 128 тохиолдол бүртгэгдэж, өвчлөгсдийн 6.1 хувь нь нас баржээ. Нярайн болон В, С вируст гепатит, ХДХВ-ийн халдвар цус, цусан бүтээгдэхүүн, тарилгаа дамжихаас сэргийлэх нь анхаарал татсан асуудал болоод байна.

Гурав. Халдварт өвчинтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн нийтлэг зорилго,зорилт, дэд хөтөлбөрийн өөрчлөлт зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн нийтлэг зорилго

Үндэсний хөтөлбөрийн зорилго н халдварт өвчинтэй тэмцэхэд нийгмийн нөө болоцлоог үр дүнтэй дайчлан ашиглах замаар х амын дундах халдварт өвчний өвчлөл, эндэгдли бууруулахад оршино.

3.2. Хөтөлбөрийн нийтлэг зорилт

3.2.1. Халдварт өвчний оношлого эмчилгээ, сэргийлэлтэд лабораторийн арга ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвши ойртуулах

3.2.2. Халдварт өвчний тандалт, судалга мэдээллийн сүлжээг боловсронгуй болго урьдчилан сэргийлэлтэд ашиглах түвши нэмэгдүүлэх

3.2.3. Халдварт өвчнөөс сэргийлэх, эрү аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх сургал сурталчилгааг эрчимжүүлэх

3.2.4. Халдварт өвчинтэй тэмцэх үй ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллаг аж ахуйн нэгж, сумын болон өрхийн эмнэлгий оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагаан уялдаа холбоог сайжруулах.

3.3. Дэд хөтөлбөр

Халдварт өвчинтэй тэмцэх Үндэсни

хөтөлбөр нь дараахь дэд хөтөлбөрүүдтэй байна:

3.3.1. Дархлаажуулалттай халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.3.2. Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.3.3. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.3.4. Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.3.5. ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.3.6. Бусад халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр.

3.4. Дэд хөтөлбөрүүдийн өвөрмөц зорилго, зорилт:

3.4.1. Дархлаажуулалттай халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр;

3.4.1.1. Зорилго:

Дархлаажуулалттай халдварт өвчний өвчлөл, үхэлд хүргэдэг эрс бууруулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх.

3.4.1.2. Зорилт:

3.4.1.2.1. Дархлаажуулалттай халдварт өвчний лабораторийн шинжилгээнд суурилсан оношлогоог бүрэн дэлгэрэнгүй болгох;

3.4.1.2.2 Улаан бурхан өвчний гаралтыг бүрэн зогсоох, үлдэгдэл вирусыг устгах;

3.4.1.2.3. Шинэ болон хавсарсан өвчлөлийн үзүүлэлтүүдийг дархлаажуулалтад нэвтрүүлэх;

3.4.1.2.4. Сум, багийн түвшинд дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх;

3.4.2.Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

3.4.2.1. Зорилго:

Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ эрүүл мэндийн үйлчилгээний бүх шатанд нэвтрүүлснээр 2010 он гэхэд сүрьеэгийн тархалт, нас баралтыг бууруулах.

3.4.2.2. Зорилт:

3.4.2.1. Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэгийн оношийг баталгаажилтыг 75 хувьд хүргэх;

3.4.2.2. Уушигны халдвартай хэлбэрийн шинэ сүрьеэгийн эдгэрэлтийн түвшинг 90 хувьд хүргэх.

3.4.3. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

3.4.3.1. Зорилго:

Хүн амын дундах гэдэсний халдварт өвчний өвчлөл, эндэгдлийг бууруулах

3.4.3.2. Зорилт:

3.4.3.2.1. Гэдэсний халдварын лабораторийн оношлогоо, сэргийлэх үйл ажиллагаат сайжруулах;

3.4.3.2.2. Хүн амыг, нэн ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхнийг ариун цэвэр, эрүүл ахуйн дадал хэвшилд сургах;

3.4.3.2.3. Ахуйн шавьж, мэрэгчийн тархалтын зүй тогтлыг судалж, тэмцэх арга хэмжээг сайжруулах.

3.4.4. Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

3.4.4.1. Зорилго

Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчний өвчлөл, эндэгдлийг бууруулах.

3.4.4.2. Зорилт:

3.4.4.2.1. Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнүүдийн тохиолдол бүрийг лабораторийн аргаар баталгаажуулдаг болох;

3.4.4.2.2. Байгалийн голомтот халдварт өвчний

эпизоотыг судлан тогтоож, голомтын идэвхийг хяналтад авах бололцоог бүрдүүлэх.

3.4.5.ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

3.4.5.1. Зорилго

Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, БЗДХ-ыг бууруулах замаар ХДХВ-ийн халдварын тархалтыг хязгаарлах.

3.4.5.2. Зорилт:

3.4.5.2.1. БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх төв, орон нутгийн мэргэжлийн албадын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

3.4.5.2.2. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын харуулдан тандалтын тогтолцоог нэвтрүүлж, оношлогоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлж, үйлчлүүлэгчдэд зөлтэй орчин бүрдүүлэх;

3.4.5.2.3. Хүн амд БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх эрсдэл багатай зан үйл, дадал зуршлыг хэвшүүлэх;

3.4.5.2.4. ХДХВ зүү, тариураар дамжин халдварлах эрсдэлийг бууруулах.

3.4.6 Бусад халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

3.4.6.1. Зорилго

3.4.6.1.1. Эмнэлгээс шалтгаалсан халдварын түвшинг тогтоож, дэгдэлтийг бууруулах;

3.4.6.1.2. Антибиотикт тэсвэртэй нянгийн тандалтыг сайжруулах;

3.4.6.1.3. Шимэгчээр дамжих халдварт өвчний өвчлөл, тархалт, халдварлалтын түвшинг судлан тогтоох, сэргийлэх арга замыг боловсронгуй болгох;

3.4.6.1.4. Томуу, томуу төст өвчний лабораторид тушгиглэсэн тандалт, хяналтын сүлжээг нэвтрүүлж, дэгдэлтийн түвшинг тогтоох.

3.4.6.2. Зорилт:

3.4.6.2.1. Эмнэлгээс шалтгаалсан халдварын харуулдан тандалтын тогтолцоог нэвтрүүлэх;

3.4.6.2.2. Эмнэлгээс шалтгаалсан халдварын лабораторийн оношлогоо, антибиотикт тэсвэрэлсэн нянг илрүүлэх, тархалтыг хязгаарлах арга хэмжээний үр дүнг сайжруулах;

3.4.6.2.3. Томуу, томуу төст өвчний цар тахлын үед эрсдэл өндертэй бүлгийн дархлаажуулалтын түвшинг нэмэгдүүлэх;

3.4.6.2.4. Томуугийн лабораторийн тандалт хяналтын улирлын чанартай сүлжээг бий болгох.

Дерев. Үндэсний хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах, зохион байгуулах, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг Засгийн газарт тайлагнах, шаардлагатай асуудлаар холбогдох газарт санал оруулах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

4.1.2. Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орон, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтын ажиллагаа идэвхжүүлэх, халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх асуудалд төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн оролцоог дэмжих, чиглүүлэх үүргийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

4.1.3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар ханган халдварт өвчнөөс сэргийлэх, өвчлөлийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх арга, стандарт, сайжруулж дэлхийн дундаж түвшинд ойртуулах нийтэд мэдээлэх ажлыг Халдварт өвчин судлалын үндэсний төв хариуцан гүйцэтгэнэ.

4.1.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлд тайлагнах, мэдээлэх ажлы

ласаг даргаар ахлуулсан нийгмийн эрүүл мэндийн албар зөвлөл хариуцна.

4.2. Үндэсний хөтөлбөрийг эрэгжүүлэх хугацаа:

Халдварт өвчинтэй тэмцэх Үндэсний өтөлбөр 2002–2010 онд хэрэгжинэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хамт олны оролцоо, хүлээх үүрэг

5.1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

5.1.1. Багш нарыг бэлтгэх их, дээд сургууль, оллежийн сургалтын хөтөлбөрийн нийгмийн эрүүл эндийн боловсрол олгох хичээлийн агуулгыг цаг эйн шаардлагад нийцүүлэх, байнга боловсронгуй олгох арга хэмжээ авах;

5.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн лбан сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн ичээлийн агуулгад нөхөн үржихүйн эрүүл мэндийн оловсрол, халдварт өвчнөөс сэргийлэх асуудлыг ялхүү тусгах, албан бус сургалтын хүрээнд ариун эвэр, эрүүл ахуйн дадлыг хэвшүүлэх, халдварт ичнөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

5.1.3. Халдварт өвчний тандалт, ошлогоо, эмчилгээ, сэргийлэлтийн чиглэлээр одэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх;

5.1.4. Ерөнхий боловсролын сургууль, ицэрлэгт дархлаажуулалтын мэдээллийн сан бий олгож, харьяаллын эрүүл мэндийн айгууллагуудтай хамтран ажиллах зохион ийгуулалт хийх;

5.1.6. Хүүхдийн байгууллага, дотуур йрны бохир усны шугам, цооног, гар угаагуур, ıе засах газрын стандарт, эрүүл ахуйн хэм мжээг хангуулах, суралцагсдын халуун хоолны уудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.2. Хууль зүй, дотоод хэргийн яам:

5.2.1. Хорих ял эдлэгсдэд эрүүл мэндийн лэг, шинжилгээг зохих журмын дагуу хугацаанд хийлгэх, тэднийг эрүүлжүүлэх арга хэмжээний нарт тавих хяналтыг сайжруулах;

5.2.2. Хорих газрын орчин, хоол тэжээлийг эрүүл ахуйн зохистой норм хэмжээнд байлгах талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5.3. Санхүү, эдийн засгийн яам

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Эрүүл мэндийн даамны захиалга, тооцоог үндэслэн үлсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх.

5.4. Байгаль орчны яам:

5.4.1. Хот суурин газрын агаар, ус, хөрсний бохирдолтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл ахуулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.4.2. Төв суурин газрын ердийн болон ахуулгүй хатуу, шингэн хог хаягдлыг зайлуулах, устгах, цэвэрлэх байгууламжийг стандартын шаардлагын дагуу ажиллуулах, хог хаягдлыг тогтоосон цэгт зохих журмын дагуу зайлуулж, халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж зохион байгуулах;

5.4.3. Зөрлөг ан амьтны дотор байгалийн голомтот халдварт өвчний эпизоотыг судалж, голомт эрүүлжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

5.5. Хүнс, хөдөө аж ахуйн яам:

5.5.1. Мал, амьтнаас хүнд халдварладаг бруцеллёз, боом, бэтэг, сүрьеэ зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээр өвчинтэй тэмцэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

5.5.2. Хүн амын хоол хүнс, ундны усны хүрэлцээ хангамж, эрүүл ахуйн ахуулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

5.5.3. Хүнсний ахуулгүй байдал, мал, амьтдыг эрүүлжүүлэх асуудлаар малчид, үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

5.6. Батлан хамгаалах яам:

5.6.1. Зэвсэгт хүчний Эрүүл мэндийн хяналтын албаны халдварт өвчний эпошлогооны хүчин чадлыг нэмэгдүүлэх, лабораторийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тандалтын тогтолцоо нэвтрүүлэх;

5.6.2. Цэргийн албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;

5.6.3. Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөрт "Эрүүл мэндийн боловсрол олгох" хичээлийг оруулах.

5.7. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

5.7.1. Эмзэг бүлгийн хүмүүсийн халдварт өвчнөөр өвчлөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоож, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.7.2. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, нян тээгчдийн хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохицуулалт, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг судалж шийдвэрлэх.

5.8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

5.8.1. Нутаг дэвсгэрийн холбогдох байгууллагуудын хүчийг халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэхэд чиглүүлэн, уг ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий аймаг, дүүргийн салбар хороодыг байгуулан ажиллуулах;

5.8.2. Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх талаар гарсан хууль тогтоомж, шийдвэрүүдийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.8.3. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөөт тусгаж хугацаанд нь олгох, зарцуулалтын байдал, ажлын үр дүнд хяналт тавих;

5.8.4. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжих, хүчин чадлыг нь бэхжүүлэх, багш, эмч мэргэжилтний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

5.8.5. Нутаг дэвсгэрийн түвшинд халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх асуудлаар төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагатай хамт олон, иргэдийн идэвх санаачилгыг дэмжиж ажиллах.

5.9. Өрхийн ба сумын эмнэлэг:

5.9.1. Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд заавал хийх дархлаажуулалтын хамралтыг 95-аас дээш хувьд хүргэх;

5.9.2. Үйлчлэх хүрээний хүн амын дунд халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаанд ажлыг тогтмол зохион байгуулах;

5.9.3. Халдварт өвчний голомтын халдварын эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулах;

5.9.4. Халдварт өвчинд өртөх эрсдэлтэй болон эмзэг бүлгийн хүмүүсийг хяналтад авч үзлэг шинжилгээнд хамруулан, эрүүлжүүлэх арга хэмжээ авах;

5.9.5. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн агаар, ус, хөрсний бохирдолтын байдалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

5.10. Иргэд, хамт олон:

5.10.1. Өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийнхээ эрүүл мэндэд тавих анхаарал халамжийг нэмэгдүүлж, эмэнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа заавал орж байх;

5.11. Радио, телевизийн хэрэг эрхлэх газар:

Халдварт өвчнөөс сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаар мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран бэлтгэж үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр явуулж байх.

Зургаа. Хөтөлбөрийн үйл ажиллагаа

6.1 Дархлаажуулалттай халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах	Хамтран оролцох
1. Хүн амын дунд ялангуяа сум, багийн түвшинд сургалт, суртапчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа сайжруулах	-Сум, багийн эмч нарт дархлаажуулалттай халдварт өвчний асуудлаар бүсчилсэн сургалт зохион байгуулах, -Дархлаажуулалт хариуцсан эмнэлгийн ажилтны 10-аас доошгүй хувийг жил бүр сургалтад хамруулах, -Иргэдэд зориулсан зурагт хуудас, гарын авлага, зөвлөмж, товхимол хэвлүүлж алслагдсан орон нутагт хүргүүлэх, - Радио, телевизийн графикт нэвтрүүлгийг тогтмолжуулах.	Жил бүр	ЭМЯ	ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, Бүх шатны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар
2 Дархлаажуулалттай халдварт өвчний лабораторид суурилсан тандалт, бүртгэл, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох	- Дархлаажуулалттай халдварт өвчний бүртгэл, мэдээллийн сүлжээг сайжруулах арга хэмжээ авах, - Дархлаажуулалттай халдварт өвчний идэвхтэй тандалтын систем нэвтрүүлэх, - Дархлаажуулалттай халдварт өвчний тандалтын Үндэсний стандартыг боловсруулан батлах, шалгуур үзүүлэлтээр дүгнэж хэвших. - Дархлаажуулалтын дараахь урвал, хүндрэлийн тохиолдлыг мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх, - Вакцины хүйтэн хэлхээний хангалт, хадгалалт, зарцуулалтыг хяналтад авах , вакцины нөөцийн менежментийг сайжруулах.	2003-2010 2002 2003 2002-2004	ЭМЯ	ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, ЭМХУА,Бүх шатны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн ЭМГ
3. Мэргэжлийн арга зүйн удирдлага, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	-Дархлаажуулалтын тухай хууль, тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, -Сайн дурын дархлаажуулалтын вакцин, биобэлдмэлийн нэр төрөл, үйлчилгээг өргөтгөх замаар хүн амд үзүүлэх сайн дурын дархлаажуулалтын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах.	2002-2010 2002-2010	ЭМЯ	ХЗДХЯ, ЭМХУА
4. Дархлаажуулалтын ажилд төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, сум, өрхийн эмнэлгийн оролцоо, хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	-Дархлаажуулалтын тухай хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран гүйцэтгэх, - Дархлаажуулалтыг дэмжих хөдөлгөөнийг хүмүүнлэгийн болон ТББ, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор өрнүүлэх, - Дархлаажуулалтын ажилд орон нутгийн удирдах ажилтнуудыг татан оролцуулах, түдниг сургалтад хамруулах арга хэмжээ авах, -Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт дархлаажуулалтын асуудлыг тусгаж сургалт зохион байгуулах, -Бүртгэлүй хүүхдүүдийг дархлаажуулалтад бүрэн хамруулах зорилгоор дархлаажуулалтын 10 хоногийн ажлын хүрээнд хүүхдийн төлөө төрийн бус байгууллагуудтай хамтран ажилах, -Залуу эцэг, эхийн дархлаажуулалтын талаарх мэдлэг, хандлага дадлагын талаар судалгаа хийж , түдниг мэдлэг хандлагыг сайжруулах.	2002-2016	ЭМЯ	БСШУЯ, НХХЯ, ЭМХУА , Бүх шатны Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд

5. Дархлаажуулалттай халдварт өвчний оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтэд лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж , дэлхийн дундаж түвшинд ойртуулах	-Улаанбурханы үндэсний лабораторийг бэхжүүлэн өвчлөлийг тууштай буурууллах замаар дэгдэлтийг хязгаарлах нөхцөл бүрдүүлэх, -Улаанбурхан болон сэжигтэй бүх тохиолдлын оношийг лабораториор батлахын тулд тууралттай, халуунтай тохиолдол бүрийг бүртгэн мэдээлж, өвчний дэгдэлтийн үед түүвэр аргаар, цөөн өвчлөлтэй үед тохиолдол бүрээс цусны шинжилгээ авч хэвших, -Улаанбурханы идэвхтэй тандалтыг өргөжүүлэн цочмог сул саажилттын тандалттай хамтатган хийх, -Улаанбурхан өвчний эсрэг дархлал тогтоцын түвшинг судлан дархлаагүй болон дархлал суларсан хүн амыг нэмэлт дархлаажуулалтад хамруулах, - Дархлаажуулалтын хамралтын судалгааг жил бүр түүвэр аргаар сонгосон сум, багт хийх,	2002-2010 2002-2010 2004-2006 2006-2008 2003-2005	ЭМЯ	ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Вакцины Сан, ЭМХУА, бүх шатны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн ЭМГ
6.Шинэ болон хавсарсан вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх	- Дархлаажуулалт бүхий халдварт өвчний эсрэг хүн амын дархлалын түвшинг судлан тогтоох, - Шинэ вакцинуудыг нэвтрүүлэх судалгааны ажлыг үе шаттай хийх, - Хемофилюс нянгаар сэдэгдсэн өвчлөлийн байдлыг тогтоох судалгаа хийж, идэвхтэй тандалтын системийг нэвтрүүлэх, - Хемофилюсийн эсрэг вакциныг турших замаар дархлаажуулалтад үе шаттай нэвтрүүлэх, - Хемофилюсийн оношлуурааар лабораторийг хангаж, эмнэлгийн ажилчдыг сургалтад хамруулж, хүн амын дундахь сурталчилгааг эрчимжүүлэх, -В гепатит, сахуу, хөхүүл ханиад, татрангийн хавсарсан дэрвэт вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх, -Гахай хавдар, улаанбурхан, улаануудын хавсарсан гуравт вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, - Хавсарсан вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх замаар хатгалтын тоог бууруулах, -Дархлаажуулалтыг нэг удаагийн зүүг, тариураар хийх, цаашид өөрөө эвдэрдэг зүүг, тариурыг нэвтрүүлэх, хэрэглэсэн зүүг, тариурыг аюулгүй устгах тогог төхөөрөмжөөр үе шаттай хангах.	2002-2006 2002-2006 2004-2006 2003-2005 2004-2004 2004-2004 2004-2006 2002-2010	ЭМЯ	СЭЗЯ, ГХЯ, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Вакцины Сан, ЭМХУА, Бүх шатны Засаг даргын Тамгын газар, ЭМГ
7.Цэргийн албан хаагчдыг дархлаажуулалтад бүрэн хамруулах	-Жил бүр шинээр цэрэгт татагдсан залуучуудын дархлаажуулалтын талаархи бүртгэл судалгааг гаргах - Дархлаажуулалттай халдварт өвчин цэргийн ангийн бие бүрэлдэхүүн дотор гарсан үед нэмэлт дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах - Нэмэлт болон нөхөн дархлаажуулалтад цэргийн бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулах	2002-2010	БХЯ	ЭМЯ, Бүх шатны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн ЭМГ, Цэргийн анги, нэгтгэлүүд

6.2 Сурьеэтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах	Хамтран оролцох

1. Ушигны халдвартай хэлбэрийн шинэ сүрьеэгийн эдгээлтийн түвшинг 85 %-д хүргэх	- Хүн амын дунд зохион байгуулах сүрьеэгээс сэргийлэх энгийн арга, мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх, - Сүрьеэгийн илрүүлэлт, эмчилгээний талаар сурьеэгийн зохицуулагч эмч нарт сургалт явуулах, - Сүрьеэ евчний эдгэрэлтийн түвшин бага аймгуудад шалтгааныг тогтоох хяналт, шинжилгээ хийж, авах арга хэмжээний төлевлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, -Сүрьеэгийн эмчилгээг евчтэнд ойртуулах, чирагдэлгүй үйлчлэх зорилгоор сум, ерхийн эмчийн түвшинд үргэлжлэх шатны эмчилгээг хийх нөхцөлөөр хангах, - Сүрьеэгийн эмийн тасралтгүй хангамжийг бүрдүүлэх, эмийн түгээлтийг зохих журмын дагуу явуулах, үүнд тавих хяналтыг сайжруулах, - Хорих ангиас суллагдсан сүрьеэтэй иргэдийн эмчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх тогтолцоо бий болгох, - Олон эмэнд дасалтай сүрьеэтэй евчтөний талаар судалгаа хийх.	2001-2010	ЭМЯ	СЭЗЯ, ХЗДХЯ Бүх шатны Засаг дарга нар, Аймаг, нийслэлийн ЭМГ, ТБб, Хэвлэл мэдээллийн байгууллага
2. Ушигны халдвартай хэлбэрийн сурьеэгийн оношийн баталгаажилтыг 70%-д хүргэх	- Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс болон хоригдлуудын дунд хагас идэвхтэй илрүүлэлтийн аргаар сурьеэ илрүүлэх ажлыг төрийн бүс байгуулагуудтай хамтран зохион байгуулах, - Урьдчилсан хорих төвөөс хорих анги руу шилжүүлэхэд хүн бүрт хийх ёстой эрүүл мэндийн үзлэгийн чанарыг сайжруулах арга хэмжээ авах, - Сурьеэтэй тэмцэх ажилд бүх шатны шийдвэр гаргагчдын оролцоог дээшлүүлэх зорилгоор ХӨСҮ төв болон түхайн аймаг, дүүргийн Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллаж, явцыг жил тутам дүгнэж байх, - Өвчлөл ихтэй, алслагдсан дүүрэг, сумдад (Зүүнхараа, Хетөл, Багахангай г.м) сурьеэгийн оношлогоо, эмчилгээний цэг байгуулах.	2001-2010	ЭМЯ	ХЗДХЯ,НХХЯ Бүх шатны Засаг дарга , Аймаг, нийслэлийн ЭМГ, ТБб_ Хэвлэл мэдээллийн байгууллагууд
3. Сурьеэгийн нас баралтад нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлсийг багасгах	- Сурьеэгийн сэжигтэй хүмүүсийг илрүүлэх, оношлох талаар сум, багийн түвшний эрүүл мэндийн ажилтанд зориулсан гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж тараах, - Архаг халбэрийн сурьеэтэй евчтөний гэр бүлийн гишүүдийг жилд 2 удаа, сурьеэгээр евчилсен хүмүүсийн гэр бүлийнхнийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, - Жирэмсэн эмэгтэйн жирэмсний 26-28 дахь долоо хоногт гэр бүлийн гишүүдийн хамт цээжний зураг авах шинжилгээнд бүрэн хамруулж, шинээр төрөх нярайг эрүүл орчинд өсгөх нөхцөл бүрдүүлэх, - Сурьеэгийн үргэлжлэх шатны эмчилгээнд сайн дурын эрүүл мэндийг дэмжигч нарын үйл ажилагааг өргөжүүлэх тогтолцоо бий болгох, - Сурьеэгийн савханцрын мэдрэг байдлыг тодорхойлох аргыг төвийн түвшинд хийдэг болох, - Ушигны бус эрхтний сурьеэг оношлох дэвшилтэт оношлогооны аргыг эмнэлгийн практикт нэвтрүүлэх, - Сурьеэгийн бус микобактерийг ХӨСҮТ-ийн лабораторид оношлодог болох, - Гэрлийн шинжилгээгээр сурьеэг оношлох сургалтыг эмч нарын дунд явуулах, - Төрөх газрын дархлаажуулалтын сувилагчийн сургалтыг тогтмолжуулж, эвхэн сургалтад хамрагдсан сувилагч вакцин тарих тогтолцоо бий болгох, - 0-1 насны хүүхдүүдийн сурьеэ евчний эсрэг тарилын дараахь сорвижилтыг 1,3,12 сартайд нь хянан үзэх, дүгнэх тогтолцоог ерх, сумын эмчийн түвшинд тогтмолжуулах.	2001-2010	ЭМЯ	СЭЗЯ, ХЗДХЯ, ХХААЯ Бүх шатны Засаг дарга, Аймаг, нийслэлийн ЭМГ, ТБб

6.3 Гэдэсний халдварт евчинтэй тэмцэх дэд хөтөлбөр

Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах	Хамтран оролцох

1. Хүн амын дунд гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, суртальчилгаа сайжруулах	-Нийслэл Улаанбаатар хот болон өвчлөл өндертэй аймгуудын хүн ам, ялангуяа өртөмхий бүлгийн дунд гэдэсний халдвараас сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, суртальчилгаа тусгай хөтөлбөрөөр хийж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдлэг, хандлага, дадал бий болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, -Жил бүрийн 6 дугаар сарын 2 дахь 7 хоногт "Гэдэсний халдвараас сэргийлье" сэдэвт мэдээлэл, сургалт, суртальчилгааны ажлыг зохион явуулж хэвшүүлэх, - "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүнсний аюулгүй байдлын асуудлаар үхаалаг, соёлтой хэрэглээг хэвшүүлэх олон ниитийн оролцоог сайжруулах сургалт, суртальчилгаг зохион явуулах, -Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр Гэдэсний халдвараас сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг дүрын дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах, -Гэдэсний халдварын өвчний голомтод хавьтагсдыг хяналтад авч эрүүлжүүлэх, - Балнадын вакцин, нян залгиур хэрэглэх ажил, үйлчилгээний жагсаалтад орсон хүмүүсийг жил бүрийн 4-5 сард дархлаажуулах ажлыг зохион байгуулах, -Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын хүрээнд үндны ус, хүнсний хангамж, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах, хөрсний бохирдолтыг багасгах асуудалд холбогдох байгууллага, хамт олны оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, -Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын хүрээнд үндны ус, хүнсний хангамж, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах, хөрсний бохирдолтыг багасгах асуудалд холбогдох байгууллага, хамт олны оролцоо, хамтын ажиллагааг сайжруулж, үр асуудалд шийдэгч гаргагч нарын үйл ажиллагаа, анхаарлыг хандуулах арга хэмжээ авах, -Гэн, зуд, газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулд нэрвэгдсэн аймаг, хот, сум, дүүргийн хүн амыг гэдэсний халдвараас сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үзүүлэх сургалтыг зохион байгуулах, -Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гар угаах, бие засах газрын стандартыг хангуулах ажлыг зохион байгуулах.	2002-2010	ЭМЯ	БСШУЯ, ХХААЯ, МРТХЭГ, Бүх шатны Засаг дарга, Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллага, Хүнсэндийн холбоо сум, өрхийн эмнэлэг
2. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд улс, хувийн хэвшлийн ба төрийн бус байгууллага, сум, өрхийн эмнэлэг, хамт олны оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах	- Өвчлөл ихтэй аймгийн төв, сум, дүүргийн 2-5 насны хүүхдүүд болон голомтын хавьтагсдыг А вирүст гепатитын өвчлөл ихэсдэг улирал эхлэхийн өмнө сайн дурын дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах, -Гэдэсний балнад өвчний голомтод хавьтагсдыг хяналтад авч эрүүлжүүлэх, - Балнадын вакцин, нян залгиур хэрэглэх ажил, үйлчилгээний жагсаалтад орсон хүмүүсийг жил бүрийн 4-5 сард дархлаажуулах ажлыг зохион байгуулах, -Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын хүрээнд үндны ус, хүнсний хангамж, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах, хөрсний бохирдолтыг багасгах асуудалд холбогдох байгууллага, хамт олны оролцоо, хамтын ажиллагааг сайжруулж, үр асуудалд шийдэгч гаргагч нарын үйл ажиллагаа, анхаарлыг хандуулах арга хэмжээ авах, -Гэн, зуд, газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулд нэрвэгдсэн аймаг, хот, сум, дүүргийн хүн амыг гэдэсний халдвараас сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үзүүлэх сургалтыг зохион байгуулах, -Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гар угаах, бие засах газрын стандартыг хангуулах ажлыг зохион байгуулах.	2002 -2010	ЭМЯ	БСШУЯ, СЭЗЯ, ЭМХУА, ХХААЯ, ҮХЯ Бүх шатны Засаг дарга, МУЗН, сум, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдэл, өрхийн эмнэлэг аймаг, нийслэлийн Боловсролын газар
3. Ахуйн шавьж, мэрэгчийн тархалтыг судлан, тэмцэх арга барилыг сайжруулах	- Ахуйн шавьж судлал, био-туршилтын лаборатори байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, - Ахуйн шавьж судлал, био-туршилтын чиглэлээр мэрэгжилтэн бэлтгэж дадлагажуулах, - Хот, суурин газар тохиолдож буй ахуйн шавьж, мэрэгчийн тархалт, төрөл зүйл болон эдгээр нь гэдэсний халдварт өвчний гаралтад хэрхэн нөлөөлж байгааг судлан тогтоож, сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах.	2002-2010 2003-2004 2002-2010	ЭМЯ	БОЯ, бүх шатны Засаг дарга, МУИС, НЭМХ АУИС, ТББ

6.4 Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага

1. Бруцеллёз өвчний талаар хүн амын дунд мэдээлэл, сурталчилгаа / МСС/, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах	-Хүн, малын эмч, мэргэжилтнүүдэд бруцеллёз өвчний талаар сургалт явуулах, - Уг өвчний тандалт, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтийн талаархи гарын авлагаар хангах, -Хүн амын дунд бруцеллёз өвчнөөс сэргийлэх санамж, зөвлөмж тараах, хэвлэлээр сурталчлах ажлыг өргөжүүлэх, -Телевизийн сурталчилгаа, радиогийн зайны сургалт зохион байгуулах, богино хэмжээний кино хийх.	2002-2010	ЭМЯ	ХХАА Я, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн ЭМГ
2.Бруцеллёз өвчний тандалт судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох	-Бруцеллёзын тохиолдол бүрийг бүртгэж, мэдээллийн сан байгуулах, -Бруцеллёзын тандалт, оношлогоо,эмчилгээний стандарт боловсруулж, эрсдэл өндертэй бүлгийн дунд идэвхтэй тандалтыг нэвтрүүлэх, -Хүн, малын бруцеллёзын өвчлөлийг хүн, мал эмнэлэг харилцан мэдээлэх журам боловсруулан мөрдөх, голомт эрүүлжүүлэх үйл ажиллагааг хамтран хийдэг болох.	2002-2010	ЭМЯ	ХХАА Я, БОЯ, Улсын мал эмнэлгийн газар
3.Бруцеллёз өвчинтэй тэмцэхэд төрийн ба төрийн бус байгууллага, сум, өрхийн эмнэлгийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах.	-Бруцеллёзтой тэмцэх, сэргийлэх ажилд тухайн орон нутгийн удирдлагын оролцоог дэвэшлүүлэх сургалтад орон нутгийн удирдлагыг хамруулах, -Мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлагыг бруцеллёзын сургалт, сурталчилгаанд хамруулах, -Иргэдэд мал сургээ бруцеллёзын эсрэг вакцинд хамруулахын ач холбогдлын талаар байнгын сурталчилгаа зохион байгуулж хэвших, -Бруцеллёзын лабораторийн оношлогоог бүх шатны эрүүл мэндийн байгууллагад сайжруулах.	2002-2010	ЭМЯ	БСШУЯ, ХХАА Я, бүх шатны Засаг дарга аймаг, нийслэлийн ЭМГ
4.Байгалийн голомтот халдварт өвчин /БГХӨ/-өөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, МСС-г боловсронгуй болгох	-БГХӨ-өөс сэргийлэх чиглэлээр голомт бүхий 10 аймгийн халдварын аюулын А зэрэглэлийн сумдын хүн амд сургалт зохион явуулах, -Тарваган тахал, боом, галзуу өвчнөөс сэргийлэх асуудлаар хүн амд болон эмч нарт зориулсан видео кино хийх, гарын авлага, ном бэлтгэх, -Тарваган тахлын дархлаажуулалтыг оновчтой болгох, эмийн сэргийлэлтэд шилжих асуудлыг үе шаттайгаар шийдэх, -Галзуугийн эсрэг эсийн өсгөврийн вакцинийг нэвтрүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, -Тархвар судлалын өндөр эрсдэлтэй аймгуудад мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийх, -Галзуугийн вирус тээгч чоно, нохой устгах ажлыг зохион байгуулах.	Жил бүр	ЭМЯ	БОЯ, аймаг, нийслэлийн ЭМГ, бүх шатны Засаг дарга
5.БГХӨ-ий тандалт, судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох.	-Тарваган тахлын идэвхтэй голомтын байнгын хяналт, бэлэн байдлын хангалттай сайжруулах, -Тарваган тахал, боом, галзуу өвчний тандалтын стандарт боловсруулах, --Боом, урвах тахлын үүсгэгчийн гадаад орчны орчлыг илрүүлэх лабораторийн хяналтын шинжилгээг өргөжүүлэх.	Жил бүр	ЭМЯ	ХХАА Я , бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ЭМГ

6. БГХӨ-тэй тэмцэх ажлын арга зүйн удирдлага, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.	-Аймаг, сум, дүүргийн Засаг дарга нарын ажлын үзүүлэлтэд голомтот нутаг эрүүлжүүлсэн, хүний өвчлөл гарсан эсэхийг тооцож дүгнэх байх, -Тарваган тахлын голомтот нутгаас хот, сууринд халдвартай түүхий эд, бүтээгдэхүүн нэвтрэхэд тавих хяналтыг сайжруулах.	Жил бүр	ЭМЯ	Засгийн газрын ХЭГ, БОЯ, ХЗДХЯ, ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
7.БГХӨ-ий оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтэд лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвшинд ойртуулах.	-БГХӨ-ий чиглэлээр ажилладаг эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах, тараган тахлын голомтын "А,, зэрэглэлийн сум, дүүргийн эмч нарын тараган тахлал, боом, галзуугийн эмнэлэгийн оношлогооны мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах, - БГХӨЭС Тев болон орон нутгийн байгууллагуудыг үйл ажиллагаанд нь нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах арга хэмжээ авах, -БГХӨ-тэй тэмцэх мэргэжлийн байгууллагагүй 6 аймагт боомын бичил амь судлалын шинжилгээний аргыг нэвтрүүлэх, -Орчин үеийн шаардлагад нийцсэн оношлогоо, эмчилгээний шинэ стандарт боловсруулах, -Боом, галзуугийн иммуноглобулиныг дотооддоо үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлэх, -Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд БГХӨ-ий лабораторийн оношлогооны аргыг нэвтрүүлэх.	Жил бүр	ЭМЯ	СЭЗЯ, БОЯ, ХХААЯ, НЭМХ, ЭМХҮТ, бүх шатны Засаг дарга
8. Хачиг боррелиоз, хачиг энцефалитын МСС-г сайжруулж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох.	- Анагаах ухааны болон хөдөө аж ахуйн салбарын их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт хачиг боррелиоз, хачиг энцефалитын халдварын талаар оруулах, -Тухайн халдварын шалтгаан, тархвар судлал, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх асуудлаар нийт эмч, эмнэлгийн ажилчдад зориулсан сургалт зохион байгуулах, тэдэнд хачиг боррелиоз өвчний эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтийн талаар гарын авлага хэвлүүлж хүргэх, - Иргэдэд зориулсан энэ халдвараас сэргийлэх тухай санамж, зөвлөгөөг боловсруулах, хүргэх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах.	2002-2004 2003-2010 2002-2005	ЭМЯ	ХХААЯ, БСШУЯ, АУИС
9.Хачиг боррелиоз, хачиг энцефалитын тандалт, судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгож, урьдчилан сэргийлэх ажлын үндэс болгох.	-Хачиг боррелиоз, хачиг энцефалитын тандалтын судалгаа, оношлогоо, эмчилгээ, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох, сэргийлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах, - Хөвсгөл, Хангай, Хэнтийн нурууны ойн бүсийн нутагт хамтарсан экспедицийг ажиллуулж байгалийн голомтыг судлах,, - Хачиг боррелиоз, хачиг энцефалитын тандалт, оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулж хэрэгжүүлэх, уг өвчний тархалт ихтэй сум, багийн хүн амд хачиг энцефалитаас сэргийлэх вакцин, өвөрмөц иммуноглобулин, хачиг боррелиозоос эмээр сэргийлэх аргуудыг турших, үр дүнг тооцох.	2002-2010	ЭМЯ	ОХУ-ын Иркутск хотын Халдвар нян судлалын хүрээлэн, ХӨСҮТ, голомт бүхий аймгийн ЭМГ
10. Хачиг боррелиоз, хачиг энцефалитыг оношлох лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвшинд ойртуулах	- Хачиг боррелиоз, хачиг энцефалитын талаар мэргэжсэн эмч мэргэжилтэн бэлтгэх, - Хачиг боррелиоз, хачиг энцефалитын оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулж, хэрэгжүүлэх, шаардлагатай вакцин, эм, оношлуурын сантай болох, - ХӨСҮТ-ийн нэгдсэн лабораторийг зохих урвалж оношлуураар хангах, хачиг халдварын лабораторийн оношлогоог өөрийн оронд хийдэг болох.	2002-2004 2002-2010	ЭМЯ	БОЯ, ХХААЯ, АУИС

6.5 ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах	Хамтран оролцох
1. Мэргэжлийн арга зүйн удирдлага, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,	-Аймаг, дүүргүүдийн БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тэмцэх албадын удирдлага зохион байгуулалтыг нэг загварт оруулж боловсронгуй болгох, -Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, удирдах ажилтнуудын БЗДХ/ХДХВ/ДОХ-той тэмцэх ажлын талаархи мэдлэгийг өргөжүүлэх, ухуулга сурталчилгааг сайжруулах,	2002-2008	ЭМЯ	БСШУЯ, РТХЭГ
2. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тандалт, харууллан тандалтын тогтолцоог нэвтрүүлж, оношлогоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлэх, үйлчлүүлэгчдэд эзлэх орчин бүрдүүлэх	-БЗДХ/ХДХВ/ДОХ-ын харуулдан тандах судалгааны журам стандарт боловсруулан, харуулдан тандалтын тогтолцоог Улаанбаатар хотод болон сонгосон аймгуудад үе шаттайгаар нэвтрүүлэх, - БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх, хэрэглэгчдэд энгийн, ойлгомжтой мэдээллийн сан байгуулах, -БЗДХ/ХДХВ/ДОХ өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам, оношлогоо эмчилгээний стандартыг шатлал тус бүрээр шинэчлэн гарган мөрдөх, -Анагаах ухааны дипломын өмнөх сургалтын хөтөлбөрт БЗДХ-ын хам шинжээр оношлох, эмчлэх болон өвчтөнүүдэд зөвлөлгөө өгөх арга барил эзэмшүүлэх хичээлийг тусгах, төгсөлтийн дараахь гүнзгийрүүлсэн давтан сургалтуудыг зохион байгуулах, сум, багийн эмч нарт тусгай хөтөлбөрөөр сургалт явуулах, -Ховд, Дорнод, Өвөрхангай аймгуудад БЗДХ/ХДХВ-ын халдварыг оношлох бүсийн лаборатори байгуулах, -БЗДХ/ХДХВ/ДОХ өвчний тусламж, үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах үүднээс нэвтлттэй эмнэлгийг Улаанбаатар хотод болон өвчлөл ендэртэй 3 аймагт байгуулах, -Аймгийн төв, нийслэлийн эрүүл мэндийн төвүүдийн бичил амь судлалын болон нийдэс судлалын лабораториуд, цусны албадыг БЗДХ/ХДХВ-ын халдвар илрүүлэх, батлах шинжилгээний оношлуураар хангах, -ХДХВ-ын халдварын оношийг баталгаажуулах, явцыг хянах, оппортунист халдваруудыг илрүүлэх тоног төхөөрөмж, оношлуураар Халдварт өвчин судлалын үндэсний төвийг хангаж, чадавхийг нь сайжруулан нэгдсэн лабораторийг лавлагаа лабораторийн түвшинд хүргэх, -ХДХВ-ын халдварын явцыг хянах, оппортунист халдваруудыг илрүүлэх шинжилгээний чиглэлээр лабораторийн боловсон хүчнийг сургах, -Бэлгийн замын хламид, энгийн херпесийн лабораторийн оношлогоог сайжруулах.	2002-2010	ЭМЯ	БСШУЯ, НХХЯ, бүх шатны Засаг дарга, АУИС, аймаг, нийслэлийн ЭМГ
3.Хүн амд БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх эрсдэл багатай зан үйл, дадал зуршлыг хэвшүүлэх	-БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх эрсдэл багатай зан үйлийг хэвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны мэргэжилтнүүдийг сургах, арга зүйн гарын авлагыг боловсруулах, -Хүн амын БЗДХ/ХДХВ/ДОХ өвчний талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа хийх, -Хүн амын тодорхой бүлгүүдийн дундаас үе тэнгийн сургагч нар сонгон авч, сургалтад хамруулан, тэдгээр дамжуулан түхайн бүлгийнхэнд БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөс сэргийлэх талаар МСС явуулах үйл ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг сайжруулах, -Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг "100 хувь бэлгэвчийн хэрэглээ" төсөл хэрэгжүүлж эхлэх, цаашид өргөжүүлэх. - Мансуурууллах бодис тариагаар хэрэглэх замаар ХДХВ тархах эрсдлийг багасгах талаар сургалт, сурталчилгаа зохиох. - Мансуурууллах бодис тариагаар хэрэглэгчдийг ХДХВ илрүүлэх үзлэгт хамруулах, бүртгэл	2002-2010	ЭМЯ	БСШУЯ, ХЗДХЯ, РТХЭГ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ЭМГ, ТББ

	хяналтад авч зөвлөлгөө өгөх - Өсвөр залуу үеийхэнд хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгааг өргөжүүлэх			

6.6 Бусад халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Байгууллага	
			Хариуцах	Хамтрах
1. Мэдээлэл, сургалт, суртальчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах	-Эмнэлгийн ажилтны эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх мэдлэгийг үнэлэх, тусгай хөтөлбөрөөр сургалт хийх, гарын авлагын төрөл,хүртээмжийг нэмэгдүүлэх, -Үндэсний хэмжээнд сургагч багш бэлтгэх, -Төвлөрсөн ариутгалын тоног төхөөрөмжийн ажиллагааны чанарын байдалд аттестатчилал хийх, бүх сумдад болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд төвлөрсөн ариутгалын хэсэг ажиллуулах, -Эмнэлгийн давтан хэрэглэгдэг багаж, оношлогооны аппаратын угаалга, халдваргүйтгэл, ариутгалын чанарын шалгуурууддаар эрүүл мэндийн байгууллагыг хангах.	2002-2010	ЭМЯ	ЭМХУА, АУИС, аймаг, нийслэлийн ЭМГ
2. Тандалт, судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгож урьдчилан сэргийлэх ажлын үндэс болгох	-Улс,хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын халдварын эсрэг дэглэм, ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн байдалд судалгаа хийж, дүгнэлт гаргах, судалгааны мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, -Тандалтын системийг бэхжүүлэх, тандалтын стандарт боловсруулж, эмнэлгээс шалтгаалсан халдварын тохиолдол,нас баралтын бодит түвшинг тогтоох, -Мэс заслын шархны болон нярайн халдварыг харуулдан тандах журам боловсруулж, харуулдан тандалтын сүлжээг Улаанбаатар хот болон сонгосон аймгуудад үе шаттайгаар нэвтрүүлэх, -Нян судлалын лабораторид илэрч байгаа үүсгэгч, түүний антибиотикт мэдрэг байдалд тавьж байгаа тандалтыг "ДЭМБ-ын тандалтын стандарт зөвлөмж"-ийн дагуу боловсронгуй болгох.	2003-2004 2003-2010	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ, АУИС
3. Мэргэжлийн арга зүйн удирдлага, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	-Эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллага бүр эмнэлгээс шалтгаалсан халдвартай тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаанд удирдан зохион байгуулах зөвлөл байгуулах, үйл ажиллагаагаа сайжруулах. -Эмнэлгийн ердийн, аюултай хог хаягдлыг ялган ангилах, ариутгах, зайлуулах журмыг боловсруулж хэрэгжүүлэх, гарын авлага гаргах, - Эмчилгээ, үйлчилгээ хийлгэсний улмаас нэн ялангуяа мэс заслын шархны халдварын талаархи иргэдийн мэдээллийг тодорхой журмын дагуу авч, холбогдох арга хэмжээг авч хэвших.	2002-2010	ЭМЯ	АУИС, ЭМУХА аймаг, нийслэлийн ЭМГ
4.Эмнэлгээс шалтгаалсан халдварын оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтэд лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвшинд ойртуулах	-Эмнэлгээс шалтгаалсан халдварын үүсгэгч,түүний биологийн хэв шинж, антибиотикийн мэдрэг байдлыг Олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн стандарт аргаар тогтоох, -Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, -Антибиотикийн стандарт дискээр хангах, -В,С гепатит, ХДХВ-ийн халдвар эмнэлгээс шалтгаалсан халдвар хэлбэрээр гарсан, сэжигтэй тохиолдолд хэрэглэгдэх оношлуурааар хангах.	2003-2010	ЭМЯ	СЭЗЯ, аймаг нийслэлийн ЭМГ, ЭМХУА

5. Томуугийн МСС, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах	-Хүн амын дунд жил бүрийн 11, 12 , 2-4 сараруудад "Томуугаас сэргийлье"сургалт, бүсчилсэн сөвнаар, мэдээллийг зохион байгуулах, -Томуугийн дэгдэлтийн үед эрсдэл өндөр болон тархалт өндөр байгаа 0-15 нас, үүний дотор 1-4 насны хүүхдийн эцэг, эх, цэцэрлэг, сургууль, хамт олны дунд сургалтыг явуулах.	2002-2010	ЭМЯ	БСШУЯ, ЭМХҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ
6. Томуугийн тандалт, судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгож, цар тахлын үед авах арга хэмжээг сайжруулах	-Томуугийн тандалтын стандартыг боловсруулж мөрдүүлэх, -Дэгдэлтийн үед үлиралын чанартайгаар тэмцэх, сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, мэдээллийн сүлжээг бий болгох, -Томуугийн дэгдэлтийн үед авах арга хэмжээг урьдчилан төлөвлөж, үйл ажиллагаанг зохион байгуулах түр комисс, хороо ажилуулах, -Сайн дурын үндэсэн дээр тархвар судлалын зааланар дархлаажуулах ажлыг нийслэл болон өвчлөл ихтэй аймгийн төвд зохион байгуулах.	2002-2010	ЭМЯ	Аймаг, Нийслэлийн ЭМГ
7.Томуугийн лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвшинд ойртуулах	-Улсын хэмжээнд тархвар зүйн шинж байдалд дүгнэлт өгч, тухайн үед хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл тогтоох, -Томуугийн үүсгэгчийг илрүүлэх лабораторийн тоног төхөөрөмжийн хангамж, хүчин чадлыг нэмэгдүүлэх.	2002-2010 2002-2010	ЭМЯ	ДЭМБ, СЭЗЯ
8.Шимэгчээр үүсэх халдварт өвчний талаарх МСС, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах	-Төвийн шимэгч судлалын лабороторийг АУИС, сувилагчийн сургуулийн сургалтын бааз болгож, эмч нарын мэргэжил олгох, дээшлүүлэх дамжаат зохион байгуулах, -Шимэгчээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын материал, гарын авлага боловсруулж түгээх, -Хүүхдийн дунд өвчлөл өндөр байгаа хялгасан болон бусад хорхойтох өвчнөөс сэргийлэх санамж зөвлөмж, зураг хуудас гаргах, энэ өвчнийг буурруулах зан үйл, дадал, заншлын талаар сонин сэтгүүл, радио телевизээр сурталчилгаа нэвтрүүлэг хийх.	2003-2004 2002-2007 2002-2010	ЭМЯ	БСШУЯ, АУИС, НЭМХ, РТХЭГ
9. Шимэгчээр үүсэх халдварт өвчний талаархи тандалт, судалгааны тогтолцоог боловсронгуй болгох	- Шимэгчээр үүсэх халдварт өвчний тандалтын стандартыг боловсруулан гаргаж мөрдүүлэх. -Шимэгчээр үүсэх өвчний тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулах.	2002-2003	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ
10. Удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	-Зөөвөрлөгдөн халдварладаг спирохетоз, риккетсиоз зэрэг өвчнийг судлах, тэмцэх, сэргийлэх ажлыг БГХЭЭСТөвийн хот, хөдөөгийн салбаруудад сайжруулах, -Хүүхэд, хүнсний бүх обьектод ажиллагсдыг шимэгчийн шинжилгээнд тогтмол хамруулах, хянаалт тавих ажлыг сайжруулах.	2003-2010 2002-2003	ЭМЯ	ЭМХУА, аймаг, нийслэлийн ЭМГ
11. Төрийн болон төрийн бус байгууллага,аж ахуйн нэгж, иргэд, хамт олны оролцоог сайжруулах	-Шимэгчээр үүсэх өвчнийг судлан тэмцэхэд энэ чиглэлээр ажилладаг бусад байгууллагуудтай харилцан тохиролцож хамтран ажиллах гэрээ байгуулж, төлөвлөгөө гаргаж ажиллах, -Олон улсын шимэгч судлалын нийгэмлэгт элсэх бэлтгэлийг хангаж, хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх, уг асуудлаар бусад орны энэ чиглэлийн байгууллагуудтай холбоо тогтоож, хамтран ажиллах.	2002-2010 2003-2010	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМХ
12. Шимэгч судлалын лабораторийн аргын ашиглалтыг сайжруулж, дэлхийн дундаж түвшинд ойртуулах	-Хот хөдөөгийн клиникийн эмнэлгүүд, нэгдсэн эмнэлэг, хүүхдийн эмнэлгүүдэд хорхойтох өвчнийг эмчлэх кабинетуудыг байгуулах, -Хот хөдөөгийн эмнэлэг, амбулаторид үйлчлүүлэгсдээс асуумжийн аргаар судалгаа хийж, хорхойтой хүмүүсийг илрүүлэн эрүүлжүүлдэг журам боловсруулан хэрэжүүлэх, -Лабораторийн хүчин чадлыг сайжруулах, эм урвалж, оношлуураар хангах.	2003-2010	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ

ЗАРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 он, №33 (270)

Долоо. Хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлт.

7.1. Дархлаажуулалттай халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

7.1.1 Заавал хийх дархлаажуулалтын хамралт

Вакцины нэр	Аль түвшин	1997-2001 оны хамралтын дундаж түвшин	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	Магадлах эх үүсвэр
БЦЖ /сүрьеэгийн эсрэг вакцин/	Улс	95	95	95	95	96	96	96	96	97	97	Тайлан мэдээ, Түүвэр судалгааны дүн
	Аймаг	96	97	97	97	97	97	97	97	97	97	
	Сум	87	88	89	90	91	92	93	94	95	95	
В вирус гепатитийн эсрэг вакцин	Улс	92	93	94	94	94	95	95	96	96	97	
	Аймаг	91	92	92	93	93	94	94	95	95	96	
	Сум	87,5	88	89	90	90	91	91	92	93	94	
Сахуу,хөхүүл ханиад,татрангийн/СХТ/ эсрэг вакцин	Улс	93	93	94								
	Аймаг	91	92	92								
	Сум	88	88	89								
Улаанбурханы эсрэг вакцин	Улс	92	93	94	95	96						
	Аймаг	90	92	92	93	94						
	Сум	89	90	91	92	93						
Полиомиелитийн эсрэг вакцин	Улс	92	93	94	95	96	96	96				
	Аймаг	90	92	92	93	94	95	95				
	Сум	87	90	91	92	93	94	95				
СХТ, В вирус гепатитийн эсрэг дөрөвт вакцин	Улс				95	96	96	96	96	96	96	
	Аймаг				93	94	95	95	96	96	96	
	Сум				90	91	92	93	94	95	95	
Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг гуравт вакцин	Улс						96	96	96	96	96	
	Аймаг						95	95	96	96	96	
	Сум						92	93	94	95	95	

7.1.2.Дархлаажуулалттай халдварт өвчний бууралтын үзүүлэлт /10 000 хүн амд/

Өвчний нэр	Дархлаажуулалт эхлэхээс өмнөх 5 жилийн өвчлөлийн дундаж	2001 он	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	Магадлах эх үүсвэр

0- 15 насны хүүхдийн тархмал хэлбэрийн сүрьеэ	8.0	0,41	0,37	0,32	0,27	0,22	0,17	0,12	0,07	0,05	0,02	Тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээ
В вирус гепатит	34.2	3,4	3	2,6	2,2	1,8	1,4	1	0.6	0,2	0,2	
Сахуу	1.2	0,10	0,08	0,05	0,04	0,03	0,03	0,03	0,02	0,02	0,02	
Хөхүүл ханиад	63.9	0,01	0,01	0,01	0,01	0,01	0,01	0,01	0,01	0,01	0,01	
Улаанбурхан	102.2	44,9	10.2	3,2	2,7	2,2	1,7	1,2	0,7	0,2	0,2	
Полиомиелит	0,2	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	
Гахай хавдар	4.0	11.7	5.1	3.7	2.1	1.5	1.0	1.0	0.5	0.3	0.2	
Улаануул	2.9	7.8	5.5	3.5	2.5	2.3	2.1	1.9	1.7	1.5	1.00	

7.2.Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

Шалгуур үзүүлэлт	1996-2000	2002	2003	2004	2005	2006-2010	Магадлах эх үүсвэр
Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэгийн оношталгаажилт	57.7%	65.0%	67.0%	69.0%	70.0%	75.0%	Сар, улирлын тайлан / ТВ 07 /
Шинэ илэрсэн уушигны халдвартай сүрьеэгийн эдгэрэлт	76.2%	81.0%	83.0%	84.0%	85.0%	90.0%	Эмчилгээний үр дүнгийн тайлан / ТВ 08 /

7.3.Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

№	Өвчлөл /10 000 хүн амд/	1996-2000 оны дундаж	2002	2003	2004	2005	2006-2010	Магадлах эх үүсвэр
1.	Балнад	0.2	0.12	0.11	0.1	0.1	0.09	Жил, сар, улирлын тайлан мэдээ
	Цусан суулга	7.5	7.5	7.5	7.3	7.0	5.0	
	А вирус гепатит	34.2	32.0	32.0	30.0	29.0	25.0	
	Сальмонеллёз	1.1	1.1	1.1	1.0	1.0	0.5	

7.4. Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

№	Шалгуур үзүүлэлт	1996-2000 оны дундаж	2002	2003	2004	2005	2006-2010	Мэдээллийн эх үүсвэр
1	Хүний бруцеллёзын шинэ өвчлөл /10 000 хүн амд/	5.2	4.7	4.2	3.7	3.2	2.2	Жил, улирал, сарын тайлан мэдээ

2	Тарваган тахлын тохиолдлын тоо	8	7	7	6	5	4	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт

7.5. ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөр

№	Шалгуур үзүүлэлт	1996-2001оны дундаж	2002	2003	2004	2005	2006-2010	Магадлах эх үүсвэр
1	Тэмбүүгийн тархалт /10 000 хүн амд/	5.3	7.0	7.0	7.0	7.0	5.0	Статистик үзүүлэлт
2	Заг хүйтэн /10 000 хүн амд/	14.8	21.2	20.5	20.0	20.0	15.0	
3	Трихомониаз /10 000 хүн амд/	27.7	41.4	40.5	40.0	40.0	35.0	
4	Төрөлхийн тэмбүү / бодит тоо/	18	15	13	11	9	0	

Монгол улсын Засгийн газрын 2002 оны
129 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

Монгол улсад мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол

№	Сэргийлэх тарилгын нэр	Эхлэл дархлаажуулалт	Дархлал сэргээх/ давтан/ дархлаажуулалт
1.	Сүрьеэгийн эсрэг сэргийлэх тарилга (БЦЖ)	Төрсний дараа 24-48 цагийн дотор полиомиелит, В вирус гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг.	Найман насанд нь сахуу, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын дархлал сэргээх дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг.
2	Полиомиелитийн (Хүүхдийн тархи нугасны халдварт саа) эсрэг сэргийлэх тарилга	Нэгдэх тунг төрсний дараа 24-48 цагийн дотор сүрьеэгийн эсрэг, В вирус гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг, Хоёрдахь тунг хоёр сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тариягын эхлэл	

		дархлаажуулалтын нэгдэх тун. В гепатитын эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь туntай нэгэн зэрэг, Гуравдахь тунг гурван сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь туntай нэгэн зэрэг, Дөрөв дэх тунг дөрвөн сартайд нь нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын гурав дахь туntай нэгэн зэрэг.	
3.	В вирүст гепатитын эсрэг сэргийлэх тарилга	Нэг дэх тунг төрсний дараа 24-48 цагийн дотор сүрьеэгийн эсрэг болон полиомиелитын эсрэг вакцины эхлэл дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг, Хоёрдахь тунг хоёр сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын хоёрдох тун, сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг, Гуравдахь тунг наймаас арван нэгэн сартайд улаанбурханы эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын нэгдэх туntай нэгэн зэрэг.	
4.	Сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилга	Нэгдэх тунг хоёр сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилтын болон В гепатитын эсрэг сэргийлэх тарилтын хоёр дахь туntай нэгэн зэрэг, Хоёрдох тунг гурван сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилтын эхлэл дархлаажуулалтын гуравдах туntай нэгэн зэрэг, Гуравдах тунг дөрвөн сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилтын дөрөвдэх туntай нэгэн	Хоёр настайд нь дархлал сэргээх дархлаажуулалтын нэг тунг хийнэ.

		зэрэг.	
5.	Сахуу, татрангийн эсрэг сэргийлэх тарилга	Нэгдэх тунг, наймаас арван нэгэн сартайд нь В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гуравдах тунтай нэгэн зэрэг,	Нэгдэх тунг, найман насанд нь сүрьеэ гийн эсрэг сэргийлэх тарилгын дархлал сэргээх дархлаажуулалтын нэгдэх тунтай нэгэн зэрэг, Хоёрдох тунг арван таван насанд хийнэ.
6.	Улаанбурханы эсрэг сэргийлэх тарилга	Хоёрдох тунг, нэг насанд нь нэгдэх тунгаар дархлаажуулснаас хойш 6-10 сарын дараа хийнэ.	

Тайлбар: Вакцины тунгийн хэмжээ, хэрэглэх аргыг тухайн вакцины шинж чанар, үйлдвэрлэгчийн зааврыг үндэслэн Эрүүл Мэндийн Яам тухай бүр тогтоож байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 134 | Улаанбаатар хот

"МИАТ" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай

"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "МИАТ" ХК-ийн хувьчлалын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд тус компанийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, нислэгийн аюулгүй байдлыг хангах, санхүү, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, стратегийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах зорилгоор "МИАТ" ХК-ийн удирдах үйл ажиллагаанд менежментийн зэрэгээр гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй

Европийн сэргээн босголт хөгжлийн банкнаас давьсан саналыг судалж тодорхой нөхцлийг сохиролцсоны үндсэн дээр "МИАТ" ХК-ийн удирдах үйл ажиллагаанд менежментийн гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, энэ ажлын явцад шаардлагатай гэж үзвэл "МИАТ" ХК-ийн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн цалин хөлсийг тогтоох, "МИАТ" ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах, шинэ дүрэм батлах, "МИАТ" ХК-ийн хувьцааг худалдах, "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг бэлтгэх, "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг биелүүлэх, "МИАТ" ХК-ийн үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярт даалгасугай.

2. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярт "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, "МИАТ" ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах, шинэ дүрэм батлах, "МИАТ" ХК-ийн хувьцааг худалдах, "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг бэлтгэх, "МИАТ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг биелүүлэх, "МИАТ" ХК-ийн үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлыг шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд, Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Аймаг, нийслэлийн Засаг даргын нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолгоор батлагдсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтыг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 135 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 10, 11 дүгээр зүйл, Ариун цэврийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, аюулгүй болгох, хадгалах, устгах журам"-ыг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Хандивлагч орнуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх, төвлөрсөн болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрийг ашиглах замаар аюултай хог хаягдлыг устгах байгууламж байгуулах асуудлыг урьдалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд, Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, аймаг, нийслэлийн Засаг даргын нарт үүрэг болгосугай.

3. Төсвийн байгууллагуудын аюултай хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт 2003 оноос эхлэн төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн тухайн чиглэлийн аюултай хог хаягдлыг зайлуулах технологийн нарийвчилсан заавар гаргаж мөрдүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболд, Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт үүрэг болгосугай.

5. Аюултай хог хаягдал болон түүний хадгалалт, устгалын талаархи бүртгэл хөтлөх, мэдээ гаргах журам батлах мөрдүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2002 оны 135 дугаар тогтоолын хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ,ЦУГЛУУЛАХ, САВЛАХ,ТҮР БАЙРШУУЛАХ,ТЭЭВЭРЛЭХ,АЮУЛГҮЙ БОЛГОХ,ХАДГАЛАХ,УСТГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх,аюулгүй болгох, хадгалах, устгахад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хүн, мал, амьтан, ургамлыг өвчлүүлэх, тэдгээрт хор хөнөөл учруулах, үр удамд нь сөргөөр нөлөөлөх,агаар, ус,хөрсөнд тархах зэргээр байгаль орчны тэнцлийг алдагдуулахад хүргэх шатах, тэсрэх, хордуулах, зэврүүлэх, халдварлах шинж чанар бүхий хаягдлыг аюултай хог хаягдал гэнэ.

1.3. Аюултай хог хаягдлыг шинж чанараар нь химийн,халдвар үүсгэгч,цацраг идэвхт гэж ангилна.

1.4. "Химийн бодисын хаягдал" гэж ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн бодис, нэгдэл, тэдгээрийн хаягдлыг хэлнэ. Үндэсний ангиллын онцгой тэсрэмтгий, онцгой шатамхай,онцгой цочроомтгой,онцгой исэлдүүлэгч, исэлдүүлэгч, онцгой идэмхий,идэмхий,онцгой хортой,хортой, бага хортой бодисын хаягдлыг химийн аюултай хог хаягдалд хамруулан ойлгоно.

1.5. "Халдвар үүсгэгч хог хаягдал"гэж хүн,мал,амьтан,ургамалд халдварт өвчин тараах аюултай хаягдлыг хэлнэ.Энэ төрлийн хаягдалд хүн, амьтан, ургамлын халдвартай эд,хэсэг,малын сэг,зэм,бичил биетийн өсгөвөр, хор, цус, бусад ялгадас, халдварлагдсан хаягдал хамаарна.

1.6. "Цацраг идэвхт аюултай хаягдал"-д үйлдвэрлэл, судалгаа, шинжилгээ, оношилгоо, эмчилгээний болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, баяжуула үйлдвэрлэлийн явцад гарах хатуу, шингэн, хий байдалтай цацраг идэвхт хаягдлууд багтана

1.7. Монгол Улсын нутаг дэвсгэр дээ химийн бодис, бүтээгдэхүүн, бичил биетий өсгөвөр, цацраг идэвхт бодис, түүни нэгдлүүдийг хэрэглэх, хадгалах, тээвэрлэх дахин борлуулах, импортлох,худалдах үй ажиллагаа эрхэлдэг болон аюултай хог хаягда гаргагч байгууллага,аж ахуйн нэгж,иргэ цаашид "хариуцагч"гэнэ/ энэхүү журмыг дага мөрдөх үүрэгтэй.

1.8. Аюултай хог хаягдал гаргаг байгууллага тухайн чиглэлийн төрий захиргааны төв байгууллагаас аюултай хо хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, т байршуулах, тээвэрлэх ,аюулгү болгох,хадгалах,устгах талаар баталж гаргаса зааврыг мөрдөж ажиллана.

1.9. Аюултай хог хаягдлыг ангила цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэ аюулгүй болгох, хадгалах, устгаха шаардагдах зардлыг тухайн хаягдал гаргаса иргэн, аж ахуйн нэгж,байгууллага хариуцна.

1.10. Аюултай хог хаягдлыг тусгайла бэлтгэсэн талбай, зориулалтын төхөөрөмж эсхүл байгуулламж бүхий зөвшөөрөгдсөн цэ /цаашид "цэг"гэх/-т аюулгүй болгон устгана

1.11. Цацраг идэвхт бодисын хаягдлы ангилах, цуглуулах, савлах, түр байршуула тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устга үйл ажиллагаат тухайн ас/удлыг хариуцс төрийн захиргааны байгууллагаас тогтоосо журмаар зохицуулна.

Хоёр.Аюултай хог хаягдлыг ангилах,цуглуулах,савлах,түр байршуулахад хариуцагчийн хүлээх үүрэг

2.1. Аюултай хог хаягдлыг ахуйн гаралтай хог хаягдлаас тусад нь савлан цуглуулна.

2.2. Засгийн газраас шийдвэр гартал аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин,эрүүл мэндийн зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

2.3. Химийн аюултай хаягдлыг шинж чанар, онцлогоос нь хамааруулж төрөлжүүлэн ангилж,нэр хаягийг нь тодорхой бичиж,аюулгүй төхцөлд ачиж,буулгах,зөөж тээвэрлэхэд шохиромжтой тусгай сав, баглаа боодолд хийж цуглуулна.

2.4. Халдвар үүсгэгч аюултай хог хаягдлыг цуглуулахдаа эх үүсвэр дээр нь бусад хаягдлаас нь ялган, тусгай зориулалтын сав,баглаа,боодолд хийж,халдвартай хог хаягдлын олон улсын стандартын дагуу таних тэмдгийг байрлуулсан байна.

2.5. Аюултай хог хаягдлыг тухайн хог хаягдлын шинж чанар,онцлогоос хамаарч үний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхаар савлах шаардлагатай бөгөөд битүүмжлэгдсэн, аюулгүй байдлыг хангасан газар хадгална.

2.6. Аюулгүй хог хаягдлын хайрцаг,сав гээр аюулаас сэрэмжлүүлсэн тусгай таних тэмдэг,нэр хаягийг ил тод хадсан байна.

2.7. Аюулгүй хог хаягдлыг технологийн дагуу аюулгүй,халдваргүй болгосны дараа тусгай зориулалтын саванд хийж битүүмжлэн түр байршуулах буюу тээвэрлэнэ.

2.8. Хариуцагч аюултай хог хаягдлыг зайлуулсны дараа түүнийг цуглуулсан, хадгалсан газрыг хоргүй, халдваргүй болгож,хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байлгах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

2.9. Хариуцагч аюултай хог хаягдал түр хадгалах байр,түүнийг тээвэрлэх зам /маршрут/-ыг тогтоосон байх шаардлагатай.

2.10. Аюултай хог хаягдал хадгалах байр нь орчиндоо сөрөн нөлөө үзүүлэхгүй,бусдад ашиглагдахгүй байх нөхцлийг хангасан байна.

2.11. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байранд гал гарах, санамсаргүй тохиолдлоор хаягдал асгарах,ууршиж болон гэнэтийн бусад тохиолдлын үед аюулгүй,халдваргүй,хоргүй болгоход ашиглдах багаж,хэрэгсэл,бодис уусмалыг бэлэн байлгана

Гурав. Аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд хариуцагчийн хүлээх үүрэг

3.1. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагаат Аюултай хог хаягдлын импорт,хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох,экспортлох тухай хуулийн дагуу болон олон улсад мөрдөж буй гэрээ,хэлэлцээрийн шаардлагын дагуу хэрэгжүүлнэ.

3.2. Аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд,мал,амьтан,ургамал,байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр тусгайлан тоноглосон тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.3. Аюултай хог хаягдлыг зөвхөн дангаар тээвэрлэнэ.

3.4. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тусгай сэрэмжлүүлэх тэмдэгтэй байна.

3.5. Аюултай хог хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай урьдчилан тохиролцож, тогтоосон зам /маршрут/-аар тэдний хяналтын дор тээвэрлэнэ.

3.6. Аюултай хог хаягдлыг эх үүсвэрээс нь эцсийн газар хүртэл тээвэрлэх хугацаанд замын аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюулаас сэргийлэх,хамгаалах үүргийг хариуцагч хүлээнэ.

3.7. Аюултай хог хаягдлыг тээвэрлэж дууссан даруй тээврийн хэрэгслийг тухайн хариуцагч аюулгүй, хоргүй,халдваргүй болгох арга хэмжээ авна.

Дерев. Аюултай хог хаягдлыг аюулгүй болгох,хадгалах,устгахад хариуцагчийн хүлээх үүрэг

4.1. Аюултай хог хаягдлыг газрын хэвлийд хадгалах,устгах тохиолдолд уг асуудлыг газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.2. Аюултай хог хаягдлыг аюулгүй болгох,хадгалах,устгахад холбогдох хууль тогтоомж,эрх зүйн бусад баримт бичиг, стандарт, норм, нормативыг мөрдөнө.

4.3. Аюултай хог хаягдлыг устгах цэгийн орчинд хүн,мал,амьтан орохооргүй хашаа хийж,хил хязгаарыг тогтоон,таних тэмдэг,санамж байрлуулна.

4.4. Аюултай хог хаягдлыг устгахдаа түүний шинж чанар,ангиллаас хамааруулах

а/ булах,булшлах

б/ шатаах

в/ физик, химийн аргаар халдваргүйжүүлэх, хоргүйжүүлэх

г/ ууршуулах

д/ саармагжуулсны дараа бохир ус зайлуулах шугамд хаях:

е/ устгах боломж бүрдээгүй тохиолдолд тодорхой нөхцөлд удаан хугацаагаар хадгалах зэрэг аргуудыг аль тохирохыг хэрэглэнэ.

4.5. Аюултай хог хаягдлыг шатаахдаа цаг агаар,улирлын байдал,салхины чиглэлийг харгалзан хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, байгаль орчинд хор нөлөөгүй байх нөхцөлийг хангасан байна.

4.6. Аюултай хог хаягдлыг шинж чанар,овор хэмжээнээс хамаарч устгал хийхдээ дээр дурдсан аргуудыг дангаар болон хослон хэрэглэж болно.

4.7. Дараахь шинж чанар бүхий аюултай хог хаягдлыг булах аргаар устгахыг хориглоно

а/ хялбар шатамхай шингэн;

б/ хүчтэй исэлдүүлэгч;

в/ цохилт, доргилтод тэсрэх;

г/ хурц үнэртэй;

д/ хортой ууршимхай;

е/ус, хүчил, шүлттэй амархан урвалд орж хортой хий, үүсмал үүгэх концентрацтай хүчил, шүүлтийн үүсмал.

4.8. Аюултай хог хаягдлыг булах нүх нь 1,5-2м, түүнээс дээш гүнтэй байх бөгөөд ёроол хана нь хортой бодис хөрсөнд нэвчихээргүй тусгаарлалттай байна. Нүхний ам нь тагтаа байхаас гадна 10-15см зузаан элс буюу шороогоор өнгөлөн дарж нягтруулан өнгөн хэсгийг хөрсжүүлнэ.

4.9. Аюултай хог хаягдлын шинж чанар нь,аюулын зэрэглэлээс нь хамааруулж дараахь нөхцөлд шатаана:

а/ цементлэж бэлтгэсэн талбай бүхий зориулалтын нүхэнд ил;

б/ ердийн зууханд:

в/ бага, эсхүл өндөр хэмд шатдаг хийгээр үлээлгэх;

г/ шатамхай бодис ашиглан.

4.10. Аюултай хог хаягдлыг шатаахдаа түүний хялбар шатах хими,физик шинж чанарыг үндэс болгоно.

4.11. Аюултай хог хаягдлыг шатаахдаа агаарт аль болох ууршуулахгүй байх нөхцөл бүрдүүлэхийг анхаарна.

4.12. Дараахь шинж чанар бүхий хаягдлыг шатаах аргаар устгахыг хориглоно:

а/шатамхай биш;

б/хүнд металл;

в/тэсрэмтгий;

г/ шатаахад хортой хий,бодис ялгарах тухайлбал өндөр молекулт хуванцар гэх мэт/.

4.13. Шаталт дуусаны дараа дутуу шатсан аюултай хог хаягдал,савыг булж устгана.

4.14. физик, химийн аргаар халдваргүйжүүлэх, хоргүйжүүлэхэд дор дурдсан аргуудыг хэрэглэнэ:

а/ тундасжуулан саармагжуулах;

б/ химийн исэлдэх урвалд оруулах;

в/ хүчил, шүлтээр шингэрүүлэх / гидролизод оруулах/;

г/ шингээх /адсорбцилох/;

д/ нягтруулах;

е/ халдваргүйжүүлэх.

4.15. Шингэн байдалтай аюултай хог хаягдлыг химийн аргаар хатуу,эсхүл хагас хатуу болгосон тохиолдолд булж устгаж болно.

4.16. физик, химийн аргыг дор дурдсан шинж чанар бүхий хаягдалд хэрэглэхийг хориглоно:

а/маш хортой;

б/тэсрэмтгий;

в/дулаан их ялгаруулдаг.

4.17. Агаарт байх хорт бодис нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байх тохиолдолд баа хэмжээтэй, түргэн ууршдаг, бага хортой хаягдлыг ууршуулах аргаар устгаж болно.

4.18. Дараахь шинж чанар бүхий бодис,хаягдлыг ууршуулах аргаар устгахыг хориглоно:

а /онцгой хортой:

б/ ууршимтгай биш, эсхүл бага зэрэг ууршимтгай;

в / амьсгалахад их хортой;

г/ хялбар шатдаг буюу өөрөө асдаг;

д/ агаартай үйлчлэлцэж тэсрэлт үүсгэдэг;

е/ гаж эвгүй үнэртэй.

4.19. Аюултай хог хаягдлыг дараахь нөхцөлд бохир ус зайлуулах шугамд нийлүүлж болно:

а/биологийн шингэн, эсийн өсгөвөр,тэжээлт орчин, бичил биетийн өсгөвөр, биобэлдмэлийн хаягдлыг халдваргүйжүүлсний дараа;

б/ хаягдлыг урьдчилан усанд уусгаж, устөрөгчийн илтгэгч /PH/-ийг 5- 9 болтол сулруулсны дараа аажмаар буюу хэсэгчлэн урсгах замаар;

в/ органик бус бодис, түүний нэгдлийг энэ аргаар зайлуулж болох боловч өөр аргаар сулруулсан байх ёстой. Ингэхдээ ихэнх металл элементүүд нь бохирдлын шугамд тундас үүсгэхгүй байх нөхцлийг хангасан байна.

4.20. Дараахь шинж чанар бүхий химийн бодисыг бохирын шугамд хаяхыг хориглоно:

а/ органик уусгагчид уусдаггүй;

б/ ундны усны чанарт сөргөөр нөлөөлдөг;

в/ биологийн задрал явагддаггүй;

г/ бохир ус зайлуулах шугамд хортой, аюултай;

д/ хялбар шатдаг.

4.21. Аюултай хог хаягдал, түүний устгах нөхцөл бүрдээгүй тохиолдолд хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй тусгай нөхцөлд аюулгүй байдлыг чанд баримтлан хадгалж болно.

Тав. Бусад асуудал

5.1. Энэ журмын биелэлтэд бүх шатны засаг дарга, байгаль орчин, эрүүл мэнд, мал эмнэлэг, иргэний хамгаалалт, ургамал хамгаалалын хяналтын байцаагчид хяналт тавина.

5.2. Иргэд, төрийн бус байгууллага хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд энэхүү журмын биелэлтэд хөндлөнгийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах талаар санал хүсэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж болно.

5.3. Аюултай хог хаягдал гаргагч иргэн аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаандаа дотоодын хяналт тавьж тайлан, мэдээ тогтоосон хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагад гаргаж өгнө.

5.4. Энэ журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 1.5 ☎ 329487







ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (271)

МОНГОЛ УЛСЫН ЗАСИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай*
- *Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай*
- *Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны есдүгээр сарын 14 №34 (271)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

478. Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай Дугаар 138 1075

479. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 139 1084

480. Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай Дугаар 140 1088

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 138 Улаанбаатар хот

Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл,хороо,ажлын хэсгийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн тарифын тухай хуулийн 5 дугаар үйлийн 2 дахь хэсэг, Стандартчилал, чанарын ыталгаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эмийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, аялал жуулчлалын тухай хуулийн 15 дугаар үйл, Садар, самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дүгээр зүйлд заасныг үндэслэн Гаалийн тарифын өвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн үрэлдэхүүнийг 2 дугаар, Эмийн үндэсний өвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, Аялал уулчлалын бодлого зохицуулах үндэсний өвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Эротикийн урталчилгаанд хяналт тавих үндэсний зөвлөлийн үрэлдэхүүнийг 5 дугаар, Тогтвортой хөгжлийн ндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 6 дугаар, рхивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, ХУ-ын хамтарсан комиссын Монголын хэсгийн үрэлдэхүүнийг 7 дугаар, Улсын байгуль онцгой комиссын бүрэлдэхүүнийг 8 дугаар, "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Монгол, Хятадын Улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг 10 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлсугай.

2. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсэг болон тэдгээрийн даргыг 11 дүгээр хавсралт ёсоор батлсугай.

3. Холбогдох сайд болон агентлаг, байгууллагын даргатай тохиролцсоны үндэсэн дээр бүрэлдэхүүнээ шинэчлэн тогтоож ажиллахыг дээрх комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Цаашид Засгийн газраас шинээр байгуулах орон тооны бус комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн дарга болон

бүрэлдэхүүнийг батлахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 12 дугаар хавсралтад дурдсан Засгийн газрын тогтоол, тогтоолын заалт, хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө. ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Санхүү, эдийн засгийн сайд
Орлогч дарга -Үйлдвэр, худалдааны дэд сайд
Гишүүд: -Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);
-Үндэсний татварын ерөнхий газрын дэд дарга;
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;
-Гадаад хэргийн ямны Эрх зүй, консулын газрын дарга;
-Санхүү,эдийн засгийн ямны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Батлан хамгаалах ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Байгаль орчны ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны ямны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Дэд бүтцийн ямны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн ямны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;
-Хүнс, хөдөө аж ахуйн ямны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;
-Эрүүл мэндийн ямны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга.

Нарийн бичгийн дарга
-Үйлдвэр, худалдааны ямны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга
Дэд дарга -мөн төвийн дэд дарга
Гишүүд: -Дэд бүтцийн улсын хяналтын албаны дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн ямны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
-Байгаль орчны ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны ямны Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга;
-Хүнс, хөдөө аж ахуйн ямны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;
-Эрүүл мэндийн ямны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;
- Зэвсэгт хүчний ерөнхий хэмжил зүйч, хэмжил зүйн улсын байцаагч;
- Санхүү, эдийн засгийн ямны Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын мэргэжилтэн;
-Үйлдвэр, худалдааны ямны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн;
-Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
-Монголын хэрэглээгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор).

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЭМИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Гишүүд: -Эрүүл мэндийн ямны Төрийн нарийн бичгийн дарга;
-Эрүүл мэндийн улсын хяналтын албаны дарга;
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;
-Улсын мал эмнэлгийн газрын дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Үйлдвэр, худалдааны ямны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн;
- Хүнс, хөдөө аж ахуйн ямны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Эрүүл мэндийн ямны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;
- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал;
- Хүнсний аюулгүй байдал,хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны мал эмнэлгийн хяналтын улсын ерөнхий байцаагч;
- Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Эрүүл мэнд, химийн стандартчиллын техникийн хорооны нарийн бичгийн дарга;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга;
- Эм зүйн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын мал эмнэлгийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга
-Эрүүл мэндийн ямны эмийн бодлого хариуцсан мэргэжилтэн.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Дэд бүтцийн сайд

Дэд дарга -Байгаль орчны сайд

Гишүүд: -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Нийслэлийн Засаг даргын орлогч;
-Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Дэд бүтцийн яамны Зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын дарга;
-Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга;
-Аялал, жуулчлалын холбооны тэргүүн (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга -Аялал, жуулчлалын газрын дарга.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ЭРОТИКИЙН СУРТАЛЧИЛГААНД ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд: -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн;
-Төрийн соёрхолт зохиолч Б.Догмид;
-"Монгол кино" нэгтгэлийн ерөнхий захирал;
-Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;
-Нийслэлийн Соёлын газрын дарга;
-ДОХ-ын үндэсний төвийн захирал;
-Монголын мөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэлийн тэргүүлэгч (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга -Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд

Орлогч дарга -Санхүү, эдийн засгийн сайд
-Байгаль орчны сайд;
-Үйлдвэр, худалдааны сайд.

Гишүүд: -Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор);
-Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор);
-Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор);
-Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор);
-Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;
-Гадаад эрлийн сайд;
-Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;
-НҮБ-д суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгч, элчин сайд;
-Эрүүл мэндийн дэд сайд;
-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
-Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх, "Сайн засагчал" хөтөлбөрийн үндэсний зөвлөх;
-Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;
-Үндэсний статистикийн газрын Үндэсний тооцоо, аргачлал, судалгааны газрын дарга;
-Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга;
-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга;
-Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
-Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал;
-Монгол Улсын их сургуулийн Цөмийн энергийн төвийн захирал;
-Тогтвортой хөгжлийн Бизнесийн зөвлөлийн дарга;
-Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч;
-Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын сүлжээний тэргүүн;
-Монголын Байгаль орчны төрийн бус байгууллагуудын холбооны тэргүүн;
-Монголын залуучуудын холбооны дарга;
-Монголын хүүхдийн төлөө үндэсний хорооны дарга.
Нарийн бичгийн дарга -Тогтвортой хөгжлийн үндэсний зохицуулагч.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

АРХИВЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСЭГ

Дарга -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
Гишүүд: -Үндэсний архивын газрын дарга;
-Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
-Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн захирал;
-Үндэсний төв архивын захирал;
-Зэвсэгт хүчний төв архивын дарга;
-Засгийн газрын архивын эрхлэгч;
-Үндэсний архивын газрын судалгаа, арга зүй хяналтын хэлтсийн дарга;
-Үйлдвэр, худалдааны яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

УЛСЫН БАЙНГЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Батлан хамгаалахын сайд
Дэд дарга -Байгаль орчны сайд;
-Хүнс, хөдөө аж ахуйн сайд.
Гишүүд: -Дэд бүтцийн дэд сайд;
-Нийслэлийн Засаг дарга;
-Санхүү, эдийн засгийн дэд сайд;
-Эрүүл мэндийн дэд сайд;
-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
-Ниигмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;
-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Цагдаагийн ерөнхий газрын дарга;
-Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;
-Хилийн цэргийг удирдах газрын дарга;
-Зэвсэгт хүчний ерөнхий штабын нэгдүгээр орлогч дарга;
-Засгийн газрын ахлах референт;
-Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга;
-"НИК" ХК-ийн гүйцэтгэх захирал;
-Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор)
Нарийн бичгийн дарга -Улсын иргэний хамгаалалтын газрын орлогч дарга.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 9 дугаар хавсралт

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Дарга -Дэд бүтцийн сайд

Гишүүд: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
-Санхүү, эдийн засгийн дэд сайд;
-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
-Гадаад хэргийн дэд сайд;
-Батлан хамгаалахын дэд сайд;
-Байгаль орчны дэд сайд;
-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
-Дэд бүтцийн дэд сайд;
-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Авто замын газрын дарга;
-Авто тээврийн газрын дарга;
-Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга;
-Дэд бүтцийн яамны Зам, тээвэр, мэдээлэл, холбоо, аялал, жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Улаанбаатар хотын ерөнхий менежер, Нийслэлийн захиргаийн ажлын албаны дар
-Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН УЛСЫН ХИЛИЙН ШУГАМЫГ ШАЛГАХ ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Түсгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд (орон тооны)
Дэд дарга-Улсын геодези, зураг зүйн газрын дарга (хавсран);
-Хилийн цэргийг удирдах газрын дарга (хавсран).
-Гадаад хэргийн яамны Эрх зүй,консулын газрын Хилийн тасгийн дарга (хавсран);
-Санхүү, аж ахуй, захиргааны ажил эрхэлсэн дэд дарга (орон тооны).
Гишүүд: -Үйлдвэр, худалдааны яамны Геологи, эрдэс баялгийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
-Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын ажилтан;
-Зэвсэгт хүчний Ерөнхий штабын цэргийн байр зүйл, геодезийн мэргэжилтэн;
-Шинжлэх ухааны академийн Информатикийн хүрээлэнгийн геодези, геомэдээллийн асуудал эрхэлсэн эрдэм шинжилгээний ажилтан (хавсран);
-Байр зүйн мэргэжилтэн (орон тооны);
-Геодезийн мэргэжилтэн (орон тооны);
-Хилийн албаны мэргэжилтэн (орон тооны);
-Дорнод,Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор,Говь-Алтай,Ховд,Баян-Өлгий аймгийн Засаг дарга (хавсран).
Хариуцлагатай нарийн бичгийн дарга - Орон тоон

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ҮНДЭСНИЙ ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ ТЭДГЭЭРИЙН ДАРГА

1.	НҮБ-ын Хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллагын асуудал эрхэлсэн Монголын үндэсний комисс	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
2.	Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
3.	Монголын түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, хадгалан хамгаалах асуудлыг эрхлэх улсын комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
4.	Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
5.	БНМАУ, ЗСБНХУ (хуучин нэрээр)-ын хооронд үүссэн зээлийн өрийн асуудлыг зохицуулах талаар ОХУ-тай хэлэлцээ хийж, санал боловсруулах Монголын талын комисс	Санхүү, эдийн засгийн сайд
6.	Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл	Байгаль орчны сайд
7.	Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын Монголын хэсэг	Батлан хамгаалахын сайд
8.	Улсын ургацын комисс	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
9.	Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс	Байгаль орчны сайд
10.	Улсын нэр томъёоны комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
11.	Олон улсын хөдөлмөрийн харилцааны хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих үндэсний зөвлөлдөх хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
12.	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний хороо (гурван талт)	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
13.	Нийгмийн халамжийн үндэсний зөвлөл	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
14.	НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-ын Монголын үндэсний хороо	Үйлдвэр, худалдааны сайд

15	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
16	Улсын баяр наадмын төв комисс	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
17	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах Үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
18	Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын бодлого, зохицуулалтын үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
19	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих Үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
20	Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний хороо	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
21	"Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
22	"Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл	Үйлдвэр, худалдааны сайд
23	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах Улсын комисс	Санхүү, эдийн засгийн сайд
24	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
25	Уур амьсгалын Үндэсний хороо	Байгаль орчны сайд
26	Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хороо	Хууль зүй, дотоод хэргийн сайд
27	"Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих Үндэсний зөвлөл	Дэд бүтцийн сайд
28	Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд

29	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хороо	Ерөнхий сайд
30	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах бэлтгэлийг хангах ажлын хэсэг	Батлан хамгаалахын сайд
31	Засгийн газрын худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
32	Хүйсийн тэгш байдлын асуудлаархи үндэсний зөвлөл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
33	Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Үйлдвэр, худалдааны сайд
34	Залуучуудын асуудлаархи үндэсний зөвлөл	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
35	Монголын мэдээлэл холбооны технологийн үндэсний хороо	Ерөнхий сайд
36	Чингис хаан мэндэлсний 840 жилийн ой, Монгол улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үндэсний хороо	Ерөнхий сайд
37	2004 оны зуны олимпийн наадамд бэлтгэх үндэсний хороо	Ерөнхий сайд
38	Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо	Санхүү, эдийн засгийн сайд, МХАҮТ-ын дарга
39	Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагаа, худалдааны олон талт хэлэлцээнд Монгол Улсын баримтлах байр суурь, удирдамжийг боловсруулах, Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсэг	Үйлдвэр, худалдааны сайд
40	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл	Дэд бүтцийн сайд
41	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний хороо	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
42	Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үндэсний хороо	Байгаль орчны сайд
43	"Сонгодог урлаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зөвлөл	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоол.

2. "Төслийн Монголын талын эрх бүхий байгууллагын тухай" 1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 271 дүгээр тогтоол.

3. "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1996 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 283 дугаар тогтоол.

4. "Хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 64 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлээс бусад зүйл.

5. "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 1997 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 82 дугаар тогтоол.

6. "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 1997 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 96 дугаар тогтоол.

7. "Чингис хааны дурсгалын цогцолбор байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1997 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 115 дугаар тогтоол.

8. "Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай" 1997 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 122 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт.

9. "Хөтөлбөр батлах тухай" 1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 255 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

10. "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 101 дүгээр тогтоол.

11. "Эмийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай"" 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.

12. "Зөвлөл байгуулах, дүрэм батлах тухай" 1998 оны 10 дугаар сарын 14-ний өдрий дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

13. "Зөвлөлийн ажиллах ж бүрэлдэхүүнийг батлах тухай" 1998 оны 10 д сарын 14-ний өдрийн 193 дугаар тогтоо дугаар хавсралт.

14. "Тогтоолд өөрчлөлт оруулах 1999 оны 2 дугаар сарын 10-ны өдр дугаар тогтоол.

15. "Тогтвортой хөгжлийн үнд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах 1999 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 26 тогтоолын хавсралт.

16. "Хөтөлбөр батлах тухай" 1999 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогто дугаар хавсралт.

17. "Журам (хөтөлбөр), дүрэм, зөвл бүрэлдэхүүнийг батлах тухай" 1999 оны 5 сарын 19-ний өдрийн 79 дүгээр тогто дугаар хавсралт.

18. "Зөвлөлдөх хороо байгуулах 1999 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 86 тогтоол.

19. "Комиссын бүрэлдэхүүнийг б тухай" 1999 оны 8 дугаар сарын 11-ний 126 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

20. "Дайчилгааны тухай ху хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 19 11 дүгээр сарын 24-ний өдрийн 200 тогтоолын 2 дугаар зүйл.

21. "Хөтөлбөр батлах тухай" 1999 дугаар сарын 29-ний өдрийн 229 дүгээр тог 3 дугаар хавсралт.

22. "Хөтөлбөр, төлөвлөгөө батлах 2000 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 34 тогтоолын 3 дугаар хавсралт.

23. "Хөтөлбөр батлах тухай" 2000

гаар сарын 8-ны өдрийн 37 дугаар тогтоолын 3 гаар хавсралт.

24. "Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн тлах тухай" 2000 оны 8 дугаар сарын 23-ны рийн 130 дугаар тогтоол.

25. "Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг нэчлэн батлах тухай" 2000 оны 10 дугаар сарын ны өдрийн 163 дугаар тогтоол.

26. "Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах, эмд өөрчлөлт оруулах тухай" 2000 оны 10 аар сарын 25-ны өдрийн 166 дугаар тогтоол.

27. "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 0 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 168 аар тогтоол.

28. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний ай" 2000 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 170 аар тогтоол.

29. "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах ай" 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 174 эр тогтоол.

30. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх ай 2000 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 204 эр тогтоолын хавсралт.

31. "Хөтөлбөр батлах тухай" 2001 оны 1 эр сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 2 аар хавсралт.

32. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн пах тухай" 2001 оны 1 дүгээр сарын 31-ний ийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

33. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн эчлэн батлах тухай" 2001 оны 1 дүгээр сарын ний өдрийн 24 дүгээр тогтоол.

34. "Комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт улах тухай" 2001 оны 3 дугаар сарын 13-ны ийн 43 дугаар тогтоол.

35. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг эчлэн батлах тухай" 2001 оны 4 дүгээр сарын й өдрийн 73 дугаар тогтоол.

36. "Зөвлөл байгуулах тухай" 2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 74 дүгээр тогтоол.

37. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний тухай" 2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 76 дугаар тогтоол.

38. "Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг шалгах тухай" 2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.

39. "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 2001 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 103 дугаар тогтоол.

40. "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 159 дүгээр тогтоол.

41. "Зөвлөлдөх хороо байгуулах тухай" 2001 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 211 дүгээр тогтоол.

42. "Дүрэм батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2001 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 214 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл.

43. "Хөтөлберийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 219 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

44. "Ажлын хэсэг байгуулах тухай" 2001 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 231 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл.

45. "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2001 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 237 дугаар тогтоол.

46. "Хөтөлбөр батлах тухай" 2001 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 242 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

47. "Хөтөлбөр батлах тухай" 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 266 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

48. "Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай" 2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4-ны өдөр | Дугаар 139 | Улаанбаа хот

Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор батална уугай.

2. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны тодорхой хэсгийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх, дотоод эх үүсвэрээс шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанж Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, айм нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улс хэмжээнд хариуцан зохион байгуулж, явц, үр д жил бүрийн 1 дүгээр улиралд Засгийн газ танилцуулж байхыг Эрүүл мэндийн с П.Нямдавааг үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАА

Засгийн газрын 2002 оны 139 дүгээр тогтоолын хавсралт

ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫГ ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

1.1. Өнөөгийн байдал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүнийг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг багасгах, амьдрах орчинг сайжруулж, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ниймийн эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага идэвхтэй хөдөлгөөний хомсдол нь тахир дутуу болох, нас барах 10 гол шалтгааны нэг гэж үзэж байгаа юм.

1.2 Тулгамдсан асуудал

1.2.1. Монгол Улсын хүн амын нас баралтын шалтгаанд хөдөлгөөний хомсдолоос хамааралтай цусны эргэлтийн тогтолцооны эмгэг, хавдар, хоол шингээх эрхтэний өвчүүд зонхилж байгаа бөгөөд цусны эргэлтийн тогтолцооны өвчин жилээс жилд нэмэгдэж, 2001 онд нас баралтын шалтгааны 35,3%-ийг эзлэх болсон байна. Гэтэл цусны даралт ихтэй өвчтөний 82,2% нь биеийн тамираар огт хичээллэдэггүй ажээ.

1.2.2. Монгол Улсын хүн амын 31,8% нь илүү жинтэй, илүү жинтэй хүмүүсийн 51,1% нь Улаанбаатар хотод амьдардаг, 30,4%-ийг оюуны ба хөнгөн хөдөлмөр эрхлэгчид, 41,9%-ийг ажи хүмүүс эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 76,2% биеийн тамирын дасгал хийдэггүй нь судалгаа тогтоогджээ.

1.2.3. Хүн бүр биеийн тамир, чийрэгжил амьдралынхаа хэрэгцээ болговол бие бялдра тэгш хөгжүүлээд зогсохгүй аливаа өвчн урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улм хувь хүн болон нийгэмд эдийн засгийн хэмж гаргах нөхцөл бүрдэх юм.

1.2.4. 2000 оны "Хүн амын бие бялд хөгжилтийн түвшинг тодорхойлох сорил" дүнгээр судалгаанд хамрагдсан сургуулийн өм насны хүүхдийн 48.6%, өсвөр насны хүүхд 40.1%, насанд хүрсэн иргэдийн 42.6% нь тус бие бялдрын зохих түвшинд хүрээгүй, ц татлагын эрүүл мэндийн үзлэгт орсон залуучу 3 хүн тутмын нэг нь өвчний үчир, таван хүн тут нэг нь бие бялдрын хөгжил дутмагийн улм цэргийн албанд тэнцэхгүй гэсэн үнэлгээ а байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго

Хүн амын бие бялдрын боловсро дээшлүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжү замаар хөдөлгөөний хомсдолоос шалтгаа

өвлөл, эндэгдлийг бууруулах.

2.2 Хөтөлбөрийн зорилт:

2.2.1. Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг дэмжих орчин бүрдүүлэх;

2.2.2. Хүн амын дунд явуулах нийтийн биеийн тамирын мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;

2.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн оролцоо, идэвхи санаачлага, хамтын ажиллагааг өрнүүлэх, дэмжих замаар хүн амыг хөдөлгөөний хомсодолоос сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх;

2.2.4. Бие бялдрын хөгжил дутмаг, хөдөлгөөний хомсодолоос хамааралтай өвчтэй хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
3.1. Бүх түвшинд хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг дэмжих орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд			
3.1.1.	Биеийн тамир, чийрэгжилтийн арга хэмжээний удирдлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох	ЭМЯ,БСШУЯ СЭЗЯ,БТСҮТ	2003
3.1.2.	Байгууллага, хамт олны хүч хөрөнгөөр биеийн тамир, чийрэгжилтийн талбай, танхим байгуулах хөдөлгөөнийг өрнүүлж, дэмжлэг үзүүлэх	ЭМЯ,СЭЗЯ, БТСҮТ, аймаг,нийслэлийн ЗДТГ	2002-2008
3.1.3.	Биеийн тамир, чийрэгжилтийн байгууламжийг спортын тоног төхөөрөмж, хэрэглэлээр үе шаттай хангах арга хэмжээ авах	ЭМЯ,СЭЗЯ, БТСҮТ	2003-2008
3.1.4.	Нийтийн биеийн тамир, чийрэгжилтээр мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ, чадавхийг сайжруулах	СЭЗЯ,ЭМЯ, БСШУЯ,БТСҮТ	2002-2008
3.1.5.	Байгууллага, хамт олны ажлын үр дүнгийн үзүүлэлтэд биеийн тамир, чийрэгжилтийн талаар зохион байгуулсан ажлыг оруулан тооцож байх	Яамд, аймаг нийслэлийн ЗДТГ	2002-2008
3.2.Хүн амын дунд явуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах зорилтын хүрээнд			
3.2.1	Биеийн тамирын дасгал, хөдөлгөөнийг иргэн бүр эрүүл мэндээ бэхжүүлэх, бие бялдраа хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ болгох зан үйлийг хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны стратеги боловсруулж хэрэгжүүлэх	ЭМЯ,БСШУЯ, РТХЭГ,БТСҮТ	2002-2008
3.2.2	Хүн амд бие дааж өөрийн эрүүл мэндээ бэхжүүлэх, бие бялдраа хөгжүүлэх чадвар, дадал зэвшүүлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулах	ЭМЯ, РТХЭГ, БТСҮТ	2002-2008
3.2.3.	Биеийн тамир, чийрэгжилтийн арга зүйн зөвлөмж, гарын авлага, сурталчилгааны материал, хөдөлгөөний жорыг боловсруулж хэвлүүлэх, хүн амд түгээх арга хэмжээ авах	ЭМЯ,БТСҮТ	2002-2008

3.2.4.	Хүн амын эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжилтийн дасгал, хөдөлгөөнийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зааж сургах ажлыг өргөжүүлэх	ЭМЯ, РТХЭГ, БТСҮТ	2002-2008
3.2.5.	Биеийн тамир, чийрэгжилтийн арга зүйч, багш, эмч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулах	ЭМЯ,БСШУЯ БТСҮТ	2002-2008
3.2.6.	Биеийн тамир, чийрэгжилтийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, тегсөлтийн дараахь сургалтад хамруулах	БСШУЯ,ЭМЯ, БТСҮТ	2002-2008
3.2.7.	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тодорхойлох сорил, үнэлгээг шинэчилж мөрдүүлэх	ЭМЯ, БСШУЯ, БХЯ,БТСҮТ	2002-2008
3.2.8.	Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшинг хянах, бие бялдрын хөгжлийг тодорхойлох үзлэгийг улсын хэмжээнд жил тутам зохион байгуулах	ЭМЯ, БСШУЯ, БХЯ,БТСҮТ, холбогдох төрийн бус байгууллага	2002-2008
3.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн оролцоо, идэвхи санаачлага, хамтын ажиллагаа өрнүүлэх, дэмжих замаар хүн амыг хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх арга хэмжээг зөрчимжүүлэх зорилтын хүрээнд			
3.3.1.	Зөвсөгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүний биеийн тамир, чийрэгжилтийн ажлыг зөрчимжүүлэн цэргийн албан хаагчдын бие бялдрын хөгжилтийн түвшинг дээшлүүлж, бэлтгэлжилтийг сайжруулах арга хэмжээ авах	БХЯ,ХЗДХЯ	2002-2008
3.3.2.	Хоригдол, урьдчилан хорих төвд саатуулагдаж буй сэжигтний эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн биеийн тамир, чийрэгжилтийн шаардлагатай арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх	ХЗДХЯ	2002-2008
3.3.3.	Байгууллага, аж ахуйн нэгж бүр хамт олны ажил мэргэжлийн онцлогт тохирсон биеийн тамир, чийрэгжилтийн арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Байгууллага, аж ахуйн нэгж бүр	2002-2008 улирал тутам
3.3.4.	Биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хамт олон, хувь хүнийг сурталчилах, урамшуулах ажлыг тогтмолжуулах	БТСҮТ, бүх шатны ЗДТГ, аж ахуйн нэгж, байгууллага	2003-2008
3.3.5.	Боловсролын байгууллагын биеийн тамирын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	БСШУЯ, ЭМЯ,БТСҮТ	2002, 2003
3.3.6.	Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, хүүхэд, залуучууд бие бялдраа бие даан хөгжүүлэх албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	БСШУЯ,ЭМЯ, БТСҮТ	2002-2008

3.3.7.	Хөдөлгөөний жорыг өвчнөөс урьдчилан сэргийлэх хэрэглүүр болгоход чиглэсэн сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх	ЭМЯ,БСШУЯ	2002-2008
3.3.8.	Суралцагсдын бие бялдрыг хөгжүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спортын арга хэмжээг бүх шатны боловсролын байгуул-лагуудад өргөнөөр зохион байгуулах	БСШУЯ,БТСҮТ	2002-2008
3.4. Бие бялдрын хөгжил дутмаг, хөдөлгөөний хомсдолоос хамааралтай евчтэй хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд			
3.4.1.	Хөдөлгөөний хомсдолоос хамааралтай евчний бүлэг бүрт тохирсон хөдөлгөөний болон эмийн бус эмчилгээний жорыг боловсруулж мөрдөх	ЭМЯ,БТСҮТ	2002-2008
3.4.2.	Эмчилгээнд биеийн тамирын дасгал, хөдөлгөөний жорыг ашиглах сургалтад өрхийн болон сум, дүүргийн эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулах	ЭМЯ, аймаг,нийс-лэлийн ЗДТГ	2003 2008
3.4.3.	Анагаах ухааны болон биеийн тамирын дээд сургууль, коллежуудын сургалтын хөтөлберт биеийн тамир, чийрэгжилтийн арга зүйн хичээлийг оруулах	БСШУЯ,ЭМЯ	2003-2008

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,санхүүжилт, хугацаа

4.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат улсын хэмжээнд мэргэжлийн түвшинд зохион байгуулах, удирдлага зохицуулалт, мэдээллээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэнд, биеийн тамир, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгуллага холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэнэ.

4.1.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих асуудлыг бүх шатны Засаг дарга, түүний Тамгын газар холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, ажлын үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллагад тайлагнана.

4.1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл, Засгийн газарт жил бүр тайлагнаж байна.

4.2 Хөтөлбөрийн санхүүжилт

Үндэсний хөтөлбөрийн санхүүжилт нь улсын төсөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, олон улсын байгууллагын хандив, тусламж, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгуллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

4.3 Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2002–2008 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлберийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	2001 оны түвшин (хувиар)	2008 оны түвшин (хувиар)
1.	Хүн амын бие бялдрын, хөгжилтийн зохих түвшинд хүрсэн байдал: -сургуулийн өмнөх нас -өсвөр нас -насанд хүрэгчид	 51.4 49.9 47.4	 60.0 70.0 60.0
2.	Биеийн тамираар тогтмол хичээллэгсдийн хувь /өдөрт 30 минутаас доошгүй идэвхитэй хөдөлгөөн хийдэг хүн/	6.1	50.0
3.	Чийрэгжилтийн танхим, төвийн тоо	135	250
4.	Илүүдэл жинтэй хүний хувь	31.8	20.0
5.	10000 хүнд оногдох цусны эргэлтийн тогтолцооны өвчин, эмгэгээр нас барагсдын тоо	21.1	14.7

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 4-ны өдөр Дугаар 140 Улаанбаатар хот

Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралт, "Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл"-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. "Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн төсөвт дэс дараатай тусгах, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнууд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг тат оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ а хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн са Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүр болгосугай.

3."Монгол Улсын эрчим хүчний тогтворт хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө"-н биелэлтэд байнгын хяналт тавьж ажилл хэрэгжилтийн явцыг 2 жилд нэг удаа Засгийн газ танилцуулж байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБА**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖ**

Засгийн газрын 2002 оны 140 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2002-2010/

Нэг. Стратеги төлөвлөгөөний үндэслэл, арах хүрээ, үндсэн зарчим, хэрэгжүүлэх хугацаа

1. Зорилго

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой жлийн /2002-2010 он/ стратеги төлөвлөгөө"-ний эм зорилго нь эрчим хүчний салбарын твортой хөгжлийг ханган, үр ашигтай эрчим нний ханган жийг бий болгоносоор хувийн шил, иргэний ийгмийн оролцоог нэмэгдүүлж, : нутгийн эрчм хүчний хамтын ажиллагааны гуулраж, шинэ дэвшилтэт техник, технологийн олтыг нэвтрүүлснээр эрчим хүчний салбарт йн засгийн үр ашгийг дэвшлүүлж, ядуурлыг руулах, байгаль орчны тогтвортой байдлыг гахад оршино.

2. Үндэслэл

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой клийн /2002-2010 он/ стратеги төлөвлөгөө" нь им хүчний салбарт ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг багтаах бөгөөд нгол Улсын засгийн газар энэхүү стратеги өвлөгөөг эрчим хүчний салбарт хэрэгжүүлж гаа үйл ажиллагаандаа удирдлага болгон ллана.

3. Хамрах хүрээ

Стратеги төлөвлөгөөг эрчим хүчний асуудал иулсан төрийн захиргааны төв байгууллага дан зохион байгуулж, Монгол Улсын Засгийн р, олон улсын банк, санхүүгийн байгууллага, дивлагчид, гадаад, дотоодын төрийн бус гуулагa, эрчим хүчний үйл ажиллагааг элдэг аж ахуйн нэгжүүдийн хамтын плагаанд тулгуурлана.

4. Үндсэн зарчим

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой :лийн /2002-2010 он/ стратеги" нь 5 үндсэн им дээр тулгуурлана:

4.1. Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангах;

4.2. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг бүрэн төгс хэрэгжүүлэх;

4.3. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх;

4.4. Эрчим хүчний салбарын бүтцийн чадавхийг дээшлүүлэх;

4.5. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, улмаар хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизмыг нэвтрүүлэх.

5. Хэрэгжүүлэх хугацаа

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө /2002-2010 он/"-г ойрын болон дунд шатанд буюу 2002 оноос 2010 онд хэрэгжүүлнэ.

Хоёр. Стратеги төлөвлөгөөний зорилт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

6. Зорилт

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн /2002-2010 он/ стратеги төлөвлөгөө"-ний зорилт нь эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийг ханган, бие даасан эрчим хүчний салбарыг бий болгоход оршино.

7. Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:

7.1. Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой, бие даасан байдал хангагдаж, эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийд нь санхүүгийн хувьд бие даан ажиллах чадвартай болж, үүссэн өр, авлагын дарамтаас ангижирч, өмнө авсан гадаадын зээл, хүүгийн дарамтыг арилгасан;

7.2. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг бүрэн төгс хэрэгжүүлж, зах зээлийн эдийн засагт тохирсон эрчим хүчний салбарын зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлснээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, гадаад, дотоодын компаниудыг ерөнлөөх чадвартай аж ахуйн нэгжүүд эрчим хүчний зах зээлд үйлчилгээ үзүүлэх

боломжийг бүрдүүлж, эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын зарим хэсгийг үе шаттайгаар хувьчилсан;

7.3. Эрчим хүчний хэмнэлтийн үр өгөөжийг бүх нийтийн хүртээл болгох зорилгоор эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэн эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хэмнэлтийн үйл ажиллагаанд эрчим хүчний үйлчилгээг эрхэлдэг компани, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулсан;

7.4. Эрчим хүчний салбарын бодлого боловсруулах, зохицуулах, эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаат хангах, зах зээлийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвартай мэргэжлийн боловсон хүчний сургаж бэлтгэсэн;

7.5. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулж, сэргэзгдэх эрчим хүчний эх үүсвэрийг өргөнөөр ашиглаж, улмаар хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизмыг нэвтрүүлснээр эрчим хүчний ижил тэгш хангамжийг бий болгосон.

Гурав. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ

8. Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангах.

Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар тус салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын зах зээлд бие даан ажиллах чадварыг сайжруулж, эрчим хүчний компани болон хэрэглэгчийн хооронд санхүүгийн хариуцлагын тогтолцоо бий болгосноор төсөвт үзүүлэх дарамтыг бууруулж, эрчим хүчний салбарыг санхүүгийн хувьд бие даалгана.

8.1. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1.1. Засгийн газрын зээл шингээх чадварыг бодитойгоор тооцож, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчаар авч байгаа зээлийн үр ашгийг нь нарийн тооцсоны үндэсэн дээр авах;

8.1.2. Эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулагчын төслийг хэрэгжүүлэхдээ хөрөнгийн өгөөжийг тооцсоны үндэсэн дээр хийх;

8.1.3. Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчаар хэрэгжүүлэх төслүүдэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг хувийн хөрөнгө оруулагчын татан оруулснаар шийдвэрлэх;

8.1.4. Өр, авлагыг шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгож эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа цахилгаан станцууд нүүрсний уурхай, түгээх сүлжээ, хэрэглэгчдийн хоорондын өр, авлагыг шийдвэрлэх.

8.2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа алдагдалгүй байх механизмыг бүрдүүлнэ:

8.2.1. Үнэ, тарифын зохистой бодлогы хэрэгжүүлэх:

а/ үнэ, тарифын аргачлалыг боловсронгуй болгох;

б/ бүтээгдэхүүний өртөгт тулгуурласан эрчим хүч худалдаж авах механизмыг нэвтрүүлэх

в/ өртгөө бүрэн нөхөх үнэ, тарифын механизмыг нэвтрүүлэх.

8.2.2. Арилжааны хэлбэрт шилжүүлэх.

8.3 Орлого цуглуулалтыг сайжруулна:

8.3.1. Тооллуржуулах;

8.3.2. Орлого цуглуулах системий сайжруулах.

8.4. Түгээх сүлжээний үр ашгий дээшлүүлж, алдагдлыг 33 хувиас 15 хувь хүртэ бууруулна.

8.5. Компани хоорондын өр авлагы шийдвэрлэнэ.

9. Эрчим хүчний салбарын бүтций өөрчлөтийг нэвтрүүлэх

Эрчим хүчний салбарын бүтций өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрчи хүчний харааг бус, бие даасан зах зээлий зохицуулалтын механизмыг бий болгож арилжааны хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлснээр эрчим хүчний үйлдвэрүүдиг ша дараатай хувьчилна.

9.1 Дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1.1. Эрчим хүчний төрийн өмчит үйлдвэрийн газруудыг компанийн хэлбэрээр зохион байгуулах;

9.1.2. Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг арилжааны хэлбэрт шилжүүлэх:

а/ олон улсын нягтлан бодох бүртгэлийн системийг нэвтрүүлж, аудит тогтмол хийлгэх;

б/ удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх;

в/ компанийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх;

г/ түгээх сүлжээний хэмжих хэрэгслийг боловсронгуй болгох;

д/ түгээх сүлжээнд төлбөрийн тэсэмжлэлийн болон орлого цуглуулалтын үйлшилтэт систем нэвтрүүлэх;

е/ санхүүгийн мэдээллийн систем нэвтрүүлэх;

ж/ компани хоорондын харилцааны эрх үйн орчинг боловсронгуй болгох.

9.1.3. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат ompaниудыг шат дараатай хувьчилна:

а/ зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа жил тестэй орнуудын хувьчлалын туршлагаас удлах;

б/ эрчим хүчний салбарын хувьчлалын тратегийг боловсруулж, зохих хууль тогтоомжийн агуу хувьчлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

10. Эрчим хүчийг хэмнэж, үр ашгийг ээшлүүлэх

Үндэсний эрчим хүчний хэмнэлтийн өтөлбөр (УЭХХХ)-ийг боловсруулж эрэгжүүлснээр агаарын бохирдлыг багасган үлэмжийн хийн ялгарлыг бууруулж, эрчим хүчний йлчилгээний компаниуд (ESCO) –ыг хөгжүүлэн эчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлнэ.

10.1.1. Эрчим хүчний хэмнэлтийн хууль эрх үйн орчныг бүрдүүлж, эрчим хүчний йлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлнэ:

а/ Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг оловсруулж батлуулах;

б/ Үндэсний эрчим хүчний хэмнэлтийн өтөлбөр (УЭХХХ)-ийг боловсруулж хэрэгжүүлэх;

в/ цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөж, шинэчлэн сайжруулах;

г/ дулааны станцууд болон халаалтын зуухуудад техник технологийн шинэчлэлт хийж, үр ашгийг дээшлүүлэх;

д/ хот, суурин газрын гэр хорооллын зуухуудыг сайжруулснаар агаарын бохирдлыг багасгах;

е/ эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үнэ тарифыг батлахдаа үр ашгийн үзүүлэлтийг шалгуур болгох.

10.1.2. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлснээр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ:

а/ эрчим хүчний үйлчилгээний компаниуд (ESCO)-ын үйл ажиллагааг дэмжих;

б/ эрчим хүчний хэмнэлттэй халаалтын зуух, цахилгаан хэрэгсэл, хөдөлгүүрийг нэвтрүүлэх.

10.1.3. Агаарын бохирдлыг багасгана:

а/ сумдын дизель цахилгаан станцыг шинэчлэх;

б/ шингэрүүлсэн хий, нүүрсний давхаргын метан, нүүрсний брикет зэрэг түлшийг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх.

11. Эрчим хүчний салбарын бүтцийн чадавхийг дээшлүүлэх

Эрчим хүчний салбарын бодлого боловсруулах, зохицуулах, эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа хангах, зах зээлийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвартай мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэнэ.

11.1. Дараахь чиглэлээр сургалт явуулна:

11.1.1. Эрчим хүчний үйлдвэрлэлийн санхүү болон үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

а/ бизнесийн удирдлага;

б/ дулааны цахилгаан станцын хослон үйлдвэрлэлийн зардлын тооцоо;

в/ хэрэглэгчдэд үзүүлэх урамшуулал, үнийн хямдрал, цагийн ялгаартай тарифын механизм.

11.1.2. Эрчим хүчний салбарын зохицуулалтын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

а/ үйл ажиллагааны зардлын тооцоо;

б/ үнэ тариф;

в/ тусгай зөвшөөрөл;

г/ хэрэглэгчийн зэрэглэл;

д/ төлбөр хийх чадварын талаархи судалгаа;

е/ эрчим хүчний хэтийн хэрэглээнд хийх дүн шинжгээ.

11.1.3. Эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

а/ гадаадын зээл, хүү, валютын ханшны зөрүүг тооцох механизм;

б/ эрчим хүчний салбарын бодлого, хэтийн төлөв, орон нутгийн эрчим хүчний хангамжийн бүтцийг боловсронгуй болгох, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт егөх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага, зарим аж ахуйн нэгжид явуулах сургалт;

в/ Зүүн Хойд Азийн болон бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, бусад орны эрчим хүчний байгууллагатай хамтран ажиллах;

г/ эрчим хүчний салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах боломж, шаардлагатай эрх зүйн орчин, шууд хөрөнгө оруулах нөхцөлийг судлах.

12. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг өргөнөөр ашиглаж, улмаар хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизм, эрчим хүчний татаасын шинэ системийг нэвтрүүлснээр эрчим хүчний ижил төгш хангамжийг бий болгоно.

12.1. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

12.1.1. Төвийн бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах чиглэлээр:

а/төлбөрийн чадварын талаархи судалгаа хийх, амьжиргааны түвшинтэй уялдсан тариф нэвтрүүлэх;

б/ цахилгаан хангамжийг сайжруулах арга замыг судалж шийдвэрлэх.

12.1.2. Төвлөрсөн эрчим хүчний системд холбогдоогүй аймаг, сумдын төвийн цахилгаан хангамжийг сайжруулах чиглэлээр:

а/ эрчим хүчний хангамжийг хямд, найдвартай болгох зорилгоор аймаг, сумдын төв, бусад хэрэглэгчдийг төвлөрсөн эрчим хүчний системд холбох;

б/ техникийн болон техникийн бус алдагдыг бууруулах;

в/ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус/-т түшиглэсэн цахилгаан хангамжийг хөгжүүлэх;

г/ аймаг, сумын төвийн эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх;

д/ татаасыг багасгаж, улмаар татаасгүй ажиллах санхүүгийн чадвартай бий болгох;

е/ амьжиргааны түвшинтэй уялдсан үнэ тариф нэвтрүүлэх.

12.1.3. Хөдөөгийн цахилгаан хангамжийг сайжруулах талаар:

а/ "10000 нарны гэр" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, хөтөлбөрийг санхүүжүүлэх сан байгуулах;

б/ салхины эрчим хүчийг ашиглаж хөдөөгийн цахилгаан хангамжийг сайжруулах;

в/ олон улсын байгаль орчныг хамгаалах байгууллагатай салхины эрчим хүчийг өргөнөөр нэвтрүүлэх талаар хамтран ажиллах.

12.1.4. Дулаан хангамжийг боловсронгуй болгож, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр:

а/ хүн амын орлого багатай хэсгийн халаалтын зардлын талаар:

- хэрэглэгчдийн хүрээг нэмэх боломжийг судлах;

- халаалтын үнэ тариф болон төлбөрийн чадварын талаар судалгаа явуулах;

- амьжиргааны түвшинтэй уялдсан дулааны үнэ тариф нэвтрүүлэх;

б/ аймаг, сумын төвд ашиглаж байгаа дулааны станц, орон нутгийн нам даралтын зуухуудыг боловсронгуй болгож, шинэчлэх.

- аймаг, сумын төвд ашиглаж байгаа дулааны станц, нам даралтын зуухуудын үр ашгийг тооцох, байгаль орчинд үзүүлэх байгаа нөлөөллийг үнэлэх;

- татаасын талаар судалж, үр ашиг багатай зуухуудыг шинэчилж солих;

в/ ахуйн халаалтыг боловсронгуй болгох

чиглэлээр:

- гэр хорооллын зуухыг боловсронгуй болгох;

- Улаанбаатар хотод агаарын бохирдлын дүн шинжилгээ хийдэг шинэ төхөөрөмжийг суурилуулах;

- Аймаг, сумдын түвшинд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаа багатай, шинэ загварын зуух нэвтрүүлэх;

- Хөдөө орон нутагт хүн амын орлого багатай хэсгийг боловсронгуй зуухаар хангах боломжийг судалж шийдвэрлэх.

12.1.5 Хяналт, дүн шинжилгээ:

а/ хөдөөгийн цахилгаан болон дулаан хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж байгаа арга хэмжээнд дүн шинжилгээ хийх арга чаглалыг боловсронгуй болгох;

б/ хүн амын хэрэглээтэй уялдсан эрчим хүчний хангамжийн талаархи мэдээлэл цуглуулалтыг боловсронгуй болгох.

Дөрөв. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, шаардагдах санхүүжилт, үр дүн

13. Стратеги төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох байгууллагатай хамтран удирдан зохион байгуулж, хэрэгжилтийг жилд нэг удаа Засгийн газарт тайлагнана.

14. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр.

14.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараахь эх үүсвэрийг ашиглана:

14.1.1. Төвлөрсөн болон орон нутгийн төсөв;

14.1.2. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт;

14.1.3. Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгө;

14.1.4. Эрчим хүчний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хөрөнгө;

14.1.6. Бусад эх үүсвэр.

15. Стратеги төлөвлөгөөний үр дүн

"Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн /2002-2010 он/ стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлснээр эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийг хангаж, бие даасан эрчим хүчний салбарыг бий болгосноор дараахь үр дүн гарна:

15.1. Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой, бие даасан байдал хангагдаж, салбарын төрийн өмчит хувьцаат компануид санхүүгийн хувьд бие даан ажиллах чадвартай болсон;

15.2. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлт бүрэн төгс хэрэгжиж, зах зээлийн эдийн засагт нийцсэн эрчим хүчний салбарын зохицуулалтын орчин бүрдсэн;

15.3. Өндөр үр ашигтай, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийн дотоод, гадаадын компануид эрчим хүчний зах зээлд үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн;

15.4. Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат зарим компануид хувьчлагдсан;

15.5. Эрчим хүчний салбарын боловсон хүчний чадавхи сайжирснаар бодлого боловсруулах, зохицуулах, эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаат хангах механизм боловсронгуй болсон;

15.6. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, усны/-ийг өргөнөөр нэвтрүүлсэн;

15.7. Хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизмыг боловсруулж нэвтрүүлсэн;

15.8. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдсэн;

15.9. Эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрүүдийг шат дараатай хэрэгжүүлсэн;

15.10. Эрчим хүчний үйлчилгээ эрхэлдэг компануид (ESCO)-ын үйл ажиллагаат хөгжүүлж, хэмнэлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулсан.

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2002-2010 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангах

- Төсөвт үзүүлэх дарамтыг бууруулах
- Эрчим хүчний компаниуд болон хэрэглэгчдийн хооронд санхүүгийн хариуцлагын тогтолцоо бий болгох
- Санхүүгийн хувьд бие даасан эрчим хүчний салбарыг бэхжүүлэх
- Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх

Эрхэм зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Засгийн газрын зээл шингээх чадвар	• Хөрөнгө оруулалтаар авч байгаа зээлийн үр ашгийг нарийн тооцсоны үндсэн дээр зээл авах;	ДБЯ, СЭЗЯ	2002-2010 он
	• Хувийн хөрөнгө оруулалтыг татан оруулснаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	Засгийн газар, /ДБЯ, ТӨХ, СЭЗЯ/ компаниуд	2003-2005 он
Компани хоорондын өр, авлагыг шийдвэрлэх	• Үнэ, тарифын зохистой өөрчлөлтийг хийх • үнэ, тарифын аргачлалыг боловсронгуй болгох • бүтээгдэхүүний өртөгт тулгуурласан эрчим хүч худалдан авах механизмыг нэвтрүүлэх; • өртгөө бүрэн нөхөх үнэ, тарифын механизмыг нэвтрүүлэх.	Эрчим хүчний зохицуулах газар /ЭХЗГ/	2002-2005 он

	механизмыг нэвтрүүлэх.	Эрчим хүчний компаниуд, хэрэглэгчид	2002-2005 он
	• Орлого цуглуулалтыг сайжруулах тоолууржуулах;	Эрчим хүчний компаниуд	2002-2005 он
	• орлого цуглуулах системийг сайжруулах; • Түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлж, алдагдлыг 33 хувиас 15 хувь хүртэл бууруулах	Эрчим хүчний компаниуд, ДБЯ, СЭЗЯ, ТӨХ	2002-2004 он
	• Компани хоорондын өр авлагыг шийдвэрлэх		

1096

2. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх

Арилжааны хэлбэрт шилжүүлэх

Эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх

Арилжааны хэлбэрт шилжүүлэх зохицуулалтын орчинг боловсронгуй болгох

Үе шаттайгаар хувьчлах

Эрхэм зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Компанийн хэлбэрт оруулах	• Эрчим хүчний төрийн өмчит үйлдвэрийн газруудыг компанийн хэлбэрээр зохион байгуулах	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ	2001 онд хэрэгжүүлж дууссан
Арилжааны хэлбэрт шилжүүлэх	• Олон улсын нягтлан бодох бүртгэлийг нэвтрүүлж, аудит тогтмол хийлгэх; • Удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх; • Компанийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх; • Түгээх сүлжээний хэмжих хэрэгслийг боловсронгуй болгох; • Түгээх сүлжээнд төлбөрийн нэхэмжлэлийн болон орлого цуглуулалтын дэвшилтэт систем нэвтрүүлэх; • Санхүүгийн мэдээллийн систем нэвтрүүлэх; • Компани хоорондын харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Эрчим хүчний компануид, хандивлагчид	2001-2010 он
Хувьчлах	• Зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа ижил тестэй орнуудын хувьчлалын туршлагаас судлах; • Эрчим хүчний салбарын хувьчлалын стратегийг боловсруулж, зохих хууль тогтоомжийн дагуу хувьчлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Засгийн газар /ДБЯ, ТӨХ, СЭЗЯ/, хандивалгчид	2002-2004 он

3. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх

Үндэсний эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр (ҮЭХХХ)-ийг боловсруулж хэрэгжүүлэх

Эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх

Эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлснээр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх

Агаарын бохирдлыг багасгаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

Эрчим хүчний үйлчилгээний компаниуд (ESCO)-ыг хөгжүүлэх

Эрхэм зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх	• Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг боловсруулж батлуулах; • Үндэсний эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр (ҮЭХХХ)-ийг боловсруулж хэрэгжүүлэх; • цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөж, шинэчлэн сайжруулах; • дулааны станцууд болон халаалтын зуухуудад техник технологийн шинэчлэлт хийж, үр ашгийг дээшлүүлэх; • хот, суурин газрын гэр хорооллын зуухуудыг сайжруулснаар агаарын бохирдлыг багасгах; • эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үнэ тарифыг батлахдаа үр ашгийн үзүүлэлтийг шалгуур болгох; • эрчим хүчний үйлчилгээний компаниуд (ESCO)-ын үйл ажиллагааг дэмжих; • Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын зуух	ДБЯ Аж ахуйн нэгж, байгууллагууд	2002-2010 он 2002-2010 он

Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлснээр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх	цахилгаан хэрэгсэл, хөдөлгүүрийг нэвтрүүлэх;		
Агаарын бохирдлыг багасгах	• Сумдын дизель цахилгаан станцыг шинэчлэх; • Шингэрүүлсэн байгалийн хий, нүүрсний давхаргын метан, нүүрсний брикет зэрэг нэвтрүүлэх	ДБЯ ДБЯ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага	2002-2010 он 2002-2010 он

4. эрчим хүчний салбарын бүтцийн чадавхийг дээшлүүлэх

Зах зээлийн шаардлагад нийцсэн боловсон хүчнийг бэлтгэх

Эрчим хүчний салбарын бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох

Эрчим хүчний компаниудын чадавхийг дээшлүүлэх

Эрхэм зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Эрчим хүчний үйлдвэрийн санхүү болон үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах	• Бизнесийн удирдлага; • Дулааны цахилгаан станцын хослон үйлдвэрлэлийн зардлын тооцоо;	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ Дулааны цахилгаан станцууд, хандивлагчид	2002-2010 он 2002-2004 он

Эрчим хүчний салбарын зохицуулалтын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах	• Хэрэглэгчдэд үзүүлэх урамшуулал, үнийн хямдрал, цагийн ялгавартай тарифын механизм • Үйл ажиллагааны зардлын тооцоо; • үнэ тариф; • тусгай зөвшөөрөл; • хэрэглэгчдийн зэрэглэл; • төлбөр хийх чадварын талаар судалгаа; • эрчим хүчний хэтийн хэрэглээнд хийх дүн шинжилгээ	Түгээх компаниуд, хандивлагчид ЭХЗГ, эрчим хүчний компаниуд, хандивлагчид	2002-2010 он 2001-2010 он
Эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах	• гадаадын зээл, хүү, валютын ханшны зөрүүг тооцох механизм; • эрчим хүчний салбарын бодлого, хэтийн төлөв, аймаг, орон нутгийн эрчим хүчний хангамжийн бүтцийг боловсронгуй болгох, үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага, зарим аж ахуйн нэгжид явуулах сургалт; • Зүүн Хойд Азийн болон бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаанд оролцох, бусад орны эрчим хүчний хамтын ажиллагаа; • Эрчим хүчний салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах боломж, шаардлагатай эрх зүйн орчин, шууд хөрөнгө оруулах нөхцөл	ДБЯ, ТӨХ, хандивлагчид ДБЯ, ЭХЗГ, хандивлагчид ДБЯ, ГХЯ, хандивлагчид Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг	

5. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулж, улмаар хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизмыг нэвтрүүлэх

Эрчим хүчний /цахилгаан, дулаан/ хангамжийг сайжруулах

Хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын тогтолцоог бий болгох

Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, татаасын шинэ системийг нэвтрүүлэх


Эрхэм зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
1. Төвийн бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах чиглэлээр	• Төлбөрийн чадварын талаарх судалгаа хийх, амьжиргааны түвшинтэй уялдсан тариф нэвтрүүлэх; • Цахилгаан хангамжийг сайжруулах арга замыг судалж шийдвэрлэх;	ЭХЗГ, "Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ХК, хандивлагчид, цахилгаан түгээх компаниуд	2002-2004 он
2. Цахилгаан хангамж-системд холбогдоогүй аймаг, сумдын төвүүд			
Системд холбогдоогүй айгийн төв болон сумдын цахилгаан хангамжийг сайжруулж, амьжиргааны түвшинтэй уялдсан үнэ, тарифыг нэвтрүүлэх	• Эрчим хүчний хангамжийг хямд, найдвартай болгох зорилгоор аймг, сумдын төв, бусад хэрэглэгчдийг төвлөрсөн эрчим хүчний системд холбох; • Техникийн болон технологийн бус алдагдлыг бууруулах; • Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус/-т түшиглэсэн цахилгаан хангамжийг хөгжүүлэх; • Аймаг, сумдын төвийн эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх; • Татаасыг боловсронгуй болгож улмаар татаасгүй ажиллах санхүүгийн чадварыг бий болгох;	ДБЯ, ТӨХ, хандивлагчид	2002-2008 он

	• Амьжиргааны түвшинтэй уялдсан үнэ тариф нэвтрүүлэх;		
3. Хөдөөгийн цахилгаан хангамжийг сайжруулах талаар			
"100000 нарны гэр" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	• Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, хөтөлбөрийг санхүүжүүлэх сан байгуулах;	ДБЯ, СЭЗЯ, банк, болон төрийн бус байгууллага, хандивлагчид	2002-2006 он
	• Салхины эрчим хүчийг ашиглаж хөдөөгийн цахилгаан хангамжийг сайжруулах; • Олон улсын байгаль орчныг хамгаалах байгууллагуудтай салхины эрчим хүчийг өргөнөөр нэвтрүүлэх	ДБЯ, олон улсын санхүүгийн болон төрийн бус байгууллага, хандивлагчид, аж ахуйн нэгж, байгууллага	2002-2010 он
4. Дулаан хангамжийг боловсронгуй болгож, үр ашгийг дээшлүүлэх талаар			
Хүн амын орлого багатай хэсгийн халааптын зардлын талаар	• Хэрэглэгчдийн хүрээг нэмэх боломжийг судлах; • Халааптын үнэ, тариф болон төлбөрийн чадварын талаар судалгаа явуулах; • Амьжиргааны түвшинтэй уялдсан дулааны үнэ, тариф нэвтрүүлэх;	ДБЯ, СЭЗЯ, ЭХЗГ, дулааны сүлжээ компаниуд	2002-2004 он

	Ахуйн хэрэглээний боловсронгуй болгох чиглэлээр	• Гэр хороололын айлуудын эхуухыг боловсронгуй болгох • Улаанбаатарт агаарын бохирдлын дүн шинжилгээ хийдэг шинэ техөөрөмжийг суурилуулах; • Аймаг, сумдын түвшинд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаа багатай, шинэ загварын эуух нэвтрүүлэх; • Хэдэн орон нутагт хүн амын орлого багатай хэсгийг боловсронгуй эуухаар хангах боломжийг судалж, нэвтрүүлэх;	БОЯ, НХХЯ, ДБЯ, Хандивлагчид	2002-2010 он
	5. Хяналт, дүн шинжилгээ	• Хөдөөгийн цахилгаан болон дулаан хангамжийн боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж буй ажлуудад дүн шинжилгээ хийх арга-лалыг боловсронгуй болгох; • Хүн амын нийгмийн байдалтай уялдсан эрчим хүчний хангамжийн талаар мэдээлэл цуглуулалтыг боловсронгуй болгох	СЭЗЯ, ДБЯ, хандивлагчид	2002-2010 он

лын Тамгын газраас гаргав.
элэл» эмхтгэлийн эөвлөл
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 3.2 ☎ 329487



Аймаг, сумдын төвөд ашиглаж буй дулаацны станцууд, орон нутгийн нам дараалтын зуухнуудыг боловсронгуй болгож, шинэчлэх	• Хэрэглэгчдийн хүрэгт нэмэх боломжийг судлах; • Халаалтын үнэ, тариф болон төлбөрийн чадварын талаар судалгаа явуулах; • Аньжиргааны түвшинтэй уялдсан дулааны үнэ, тариф нэвтрүүлэх;	ДБЯ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, хандивлагчид, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага	2002-2007 он
Ахуйн халаалтыг боловсронгуй болгох чиглэлээр	• Гэр хороололын айлуудын зуухыг боловсронгуй болгох • Улаанбаатарт агаарын бохирдлын дүн шинжилгээ хийдэг шинэ техеөрөмжийг суурилуулах; • Аймаг, сумдын түвшинд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаа багатай, шинэ загварын зуух нэвтрүүлэх; • Хөдөө орон нутагт хүн амын орлого багатай хэсгийг боловсронгуй зуухаар хангах боломжийг судалж, нэвтрүүлэх;	БОЯ, НХХЯ, ДБЯ, Хандивлагчид	2002-2010 он
5. Хяналт, дүн шинжилгээ	• Хөдөгийн цахилгаан болон дулаан хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж буй ажлуудад дүн шинжилгээ хийж, аргачлалыг боловсронгуй болгох; • Хүн амын нийгмийн байдалтай уялдсан эрчим хүчний хангамжийн талаар мэдээлэл цуглуулалтыг боловсронгуй болгох	СЭЗЯ, ДБЯ, хандивлагчид	2002-2010 он

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 3.2 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (272)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай*
- *Зарим зарлигийн заалтад өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай*
- *Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах ураалдаант шалгаруулалтын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны есдүгээр сарын 21 №35 (272)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

481. Журам батлах тухай Дугаар 125 1103
482. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай Дугаар 126 1104
483. Зарим зарлигийн заалтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 127 1104

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

484. Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай Дугаар 141 1105
485. Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах уралдаант шалгаруулалтын тухай Дугаар 142 1111
486. Эрдэнэт-Мөрөнгийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам барих тухай Дугаар 143 1125
487. Нөөцөөс хөрөнгө гаргах тухай Дугаар 144 1125
488. Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай Дугаар 145 1126
489. Хөтөлбөр батлах тухай Дугаар 146 1127

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

02 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 125 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Прокурорын байгууллагын тухай Монгол Улсын хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

"Прокурорын тангараг өргөх ёслолын журам"-ыг хавсралтын ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 125 дугаар зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

1. Монгол Улсын иргэн прокурорын албан тушаалд томилогдохдоо Прокурорын байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан прокурорын тангараг /цаашид "тангараг" гэх/-ийг ёс төртэйгээр өргөнө.

2. Тангараг өргөх газар, хугацаа /өдөр, цаг/ Улсын ерөнхий прокурор эсхүл аймаг, нийслэлийн анхан дагнасан прокурор тогтоох бөгөөд тухайн прокурорын газар тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангаж зохион байгуулна.

3. Тангараг өргөх ёслолын ажиллагааны байрыг ёс төртэйгээр тусгайлан бэлтгэж Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбаа, прокурорын байгууллагын бэлгэдлийг хүндэтгэлтэйгээр байрлуулсан байна.

4. Тангараг өргөх ёслолын ажиллагааг тухайн прокурорын газрын прокурорууд байлцуулна. Түүнчлэн тухайн нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллага, хууль, хяналтын байгууллагын удирдлагыг урьж оролцуулж болно.

5. Тангараг өргөх ёслолын ажиллагаа

тухайн шатны ахлах прокурорын тусгайлан томилсон албан тушаалтан удирдан явуулна.

6. Тангараг өргөх ёслолын ажиллагаат удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагаат нээж, прокурорын албан тушаалд томилогдсон хүмүүсийг танилцуулан, тангаргийн бичгийг тангараг өргөгч нэг бүрт гардуулна.

7. Тангараг өргөх прокурор тогтоосон цагт тусгайлан бэлтгэсэн байранд хүрэлцэн ирж Монгол Улсын төрийн сүлд рүү эгц харж зогсоно.

8. Тангараг өргөх үед уг ёслолын ажиллагаанд оролцогчид босч хүндэтгэнэ.

9. Тангаргийг хамтаар буюу дангаар өргөж болно. Хамтаар өргөж байгаа тохиолдолд хамгийн ахмад прокурор нь прокурорын тангаргийг цээжээр дээдлэн дуудаж, бусад нь дагалдана.

10. Тангаргийг цээжээр дуудаж дууссаны дараа тангараг өргөгч Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёсолж, зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна.

11. Тангараг өргөсөн прокурор нь Монгол Улсын төрийн сүлд бүхий "Прокурорын тангараг"-ийн үг бүрэн эхээр бичигдсэн бичвэр бүхи тангаргийн тусгайлан бэлтгэсэн бичгэт тангара өргөсөн он, сар, өдөр, байгууллагын нэр, овог, эцэ өөрийн нэрийг тус тус гараар бичиж гарын үсэг зур баталгаажуулна.

12. Тангараг өргөсөн ажилтнууд тангаргий бичигт гарын үсэг зурж дууссаны дараа төрий дуулал эгшиглэнэ.

13. Тангараг өргөх ёслолын ажиллагаа удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөсө хүмүүст баяр хүргэж, тангараг өргөх ёслолы ажиллагаат хаана.

14. Тангаргийн бичгийг тухайн прокурор хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

15. Тангараг өргөх ёслолын ажиллагаан талаарх дэс дарааллыг тодорхой тусгаса тэмдэглэл хөтөлнө.

16. Прокурорын тангараг өргөсөн ажилта нь төрийн бусад байгууллагад шилжин ажилласн дараа прокурорын албан тушаалд эргэ томилогдвол дахин тангараг өргөхгүй.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Дугаар 126 Улаанбаатар хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 61 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Шаравдоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлий гишүүний үүргээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Дугаар 127 Улаанбаата хот

Зарим зарлигийн заалтад өөрчлөлт оруулах тухай

Зэвсэгт хүчний тухай хууль батлагдсантай холбогдуулан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигийн 4, 153 дугаар зарлигийн 2, 216 дугаар зарлигийн 2, 2001 оны 92 дугаар зарлигийн 1, 128 дугаар зарлигийн 2 дахь заалт, дээрх зарлигуудаар батлагдсан "Цэргийн цол олгох журам", "Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам", "Цэргийн нийтлэг дүрмүүд", "Монгол Улсын Зэвсэгт хүчний ашигла номлол", 1998 оны 29 дүгээр зарлигаар баталгаа "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргий цолны зэрэглэл"-д Зэвсэгт хүчний Ерөнхий шта гэсний Зэвсэгт хүчний Жанжин штаб болго өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 141 | Улаанбаатар хот

Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Шилмэл хэзлтүүлэгч" дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор батална.

2. Шилмэл хэзлтүүлэгч дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлж байхыг Санхүү,эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох нь:

а/малын үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн цэм сүргийн биологийн нөөцийг бүрэн ашиглах, үржил-селекцийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд явуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд цэм сүргийн мал бүхий сумдад үржлийн ажил, үйлчилгээг улсийн хэвшлийн нэгжид тулгуурлан зохион байгуулах арга хэмжээ авч ажилласугай;

б/үржлийн шилмэл хэзлтүүлэгч бойжуулах, борлуулах чиглэлтэй цэм сүрэг бүхий аж ахуйн нэгж, малчдын хоршоо, хамтлаг, бийгэмлэгийн үйл ажиллагаат бүх талаар дэмжин хамшуулах, гэрээ, захиалгын дагуу үржлийн мал борлуулах арга хэмжээг энэ оноос эхлэн авч хэрэгжүүлсүгэй.

4. Мах арвинтай, түргэн өсөлттэй үхэр, хонь бойжуулэх туршилт, судалгааг ергөтгөх, цэм сүргээс шилмэл хэзлтүүлэгч бойжуулах төсөл боловсруулан шинжлэх ухааны төслийн шалгаруулалтад оруулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/мал аж ахуйг эрчимжүүлэх, малын чанарыг сайжруулах ажлыг тодорхой чиглэл зорилготой, шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг мэргэжлийн алба, мэргэшсэн ажилтны удирдлага, үйлчилгээний дор зохион байгуулж байсугай;

б/малчдын боловсрол,зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх, аж ахуйг эрхлэн хөтлөх, шинжлэх ухааны ололт, дэвшилт технологи болон мал маллагааны уламжлалт туршлага зэмшүүлэх сургалтыг 2002 оноос эхлэн сум, багийн хэмжээнд жил бүр зохион байгуулах, мэдээллээр хангах арга хэмжээ авсугай;

6. Шилмэл хэзлтүүлэгч дэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг 2002-2005 онд үе шаттайгаар хэрэгжүүлж, өөрийн аймаг, сум, багийн байгаль, цаг уурын онцлог, бэлчээрийн даац, багтаамжид тулгуурлан малын төрөл, зүйлийн зохистой харьцаа, сүргийн зөв бүтэц бүрдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, хэзлтүүлэгчийн чанар, хангамжийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

ШИЛМЭЛ ХЭЭЛТҮҮЛЭГЧ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Өнөөгийн байдал

1. 2001 оны улсын хэмжээний мал тооллогын дүнгээс үзэхэд буур 3.9, азарга 99.7, бух 28.4, хуц 83.4, ухна 64.2 мянга, бүгд 279.7 мянган хэлтүүлэгч байгаа нь нэг хэлтүүлэгчид ингэ 22, гүү 7, үнээ 30, эм хонь, ямаа 65-67 ногдож хэлтэгч, хэлтүүлэгчийн тохироо алдагдсан байна. Өнгөрсөн онд явуулсан үзлэг, аттестатчиллаар хэлтүүлэгчийн 17.2 хувь нь жишигт тэнцээгүйн дотор бухны 28.0 хувь, хуц, ухны 18.0-15.7 хувь нь стандартын бус байсан нь хэлтүүлэгч мал дутагдалтайн зэрэгцээ чанарын хувьд ч өнөөгийн эрэлт хэрэгцээг ханган чадахгүй байна. Улсын хэмжээгээр 110-аад мянган хэлтүүлэгч нэмж сүрэг сэлбэх шаардлагатайгаас 2001 онд 37.3 мянган хэлтүүлэгч шинээр тавьсан нь хэрэгцээний 34,5 хувьтай тэнцэж байна. Улсын хэмжээнд сүрэг сэлбэх хэлтүүлэгч бойжуулахад 815.0 мянгаас доошгүй тооны цем сүргийн хэлтэгч шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар 160 гаруй мянга дутуу байна. Нийт малд өндөр ашигт малын эзлэх хувийн жин буурч, нутгийн үүлдрийн малын ашиг шим багасах хандлагатай байна.

2. Засгийн газрын 1997 оны 105 дугаар тогтоолоор батална Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэлээд ажил хийгдэж байгаа ч хөтөлберт заагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэргэжлийн албадын бүтэц, тогтолцоо бүрдэж чадаагүй, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр байхгүйгээс тавьсан зорилгоо бүрэн биелүүлж чадахгүй байна.

Хоёр. Хэлтүүлэгчийн чанар, хангамжийг сайжруулах боломж

3. Хэлтүүлэгч малын чанар, хангамжийг сайжруулах дараахь боломжууд байна:

3.1. Малын төрөл, ашиг шимийн чиглэлээр өөр хоорондоо ялгаатай 40 гаруй үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн малын генофонд бүхий 650.0 гаруй мянган хэлтэгч байна;

3.2. Үржлийн өсвөр мал бойжуулан зах зээлд нийлүүлэх үүрэг бүхий 50 шахам үржлийн аж ахуй, ферм ажиллаж жилд дунджаар 20.0-25.0 мянган үржлийн хэлтэгч, хэлтүүлэгч бойжуулан борлуулж байсан туршлага бий;

3.3. Үржлийн ажлыг зохион байгуулах дадлага, туршлагатай мэргэжилтэй боловсон хүчний зохих нөөцтэй;

3.4. Малын удмын сангийн үндэсний төв арвин ашиг шимт хэлтүүлэгчийн 400 гаруй мянга тун үрийн сан байгаагаас гадна 6.0 мянга гаруй гой ашиг шимт малын генефондын нөөцийг ашигла боломж байна.

Гурав. Хэлтүүлэгч малын чанар, хангамжид нөлөөлж байгаа зарим сөрөг хүчин зүйл, бэрхшээл

4. Хэлтүүлэгч малын чанар, хангамжи дараахь сөрөг хүчин зүйл нөлөөлж байна:

4.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлий технологи, үржлийн ажил, үйлчилгээг гарда хэрэгжүүлэх мэргэжлийн үйлчилгээ, зохицуулал эзэнгүйдсэн;

4.2. Малчид хэлтүүлэгч малын чана тохирооны ач холбогдлыг дутуу үнэлж, хайһ хандаж байгаа;

4.3. Төв, орон нутгийн төрийн захиргаан байгууллагууд малын чанар, үржлийн ажи үйлчилгээний талаар гарсан хууль тогтоомжи заасан үүргээ биелүүлэхгүй байгаа;

4.4. Хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн эрэ хэрэгцээ, нөөц, боломжийн талаархи мэдээллий нэгдсэн тогтолцоо бүрдээгүй.

Дөрөв. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

5. Мэргэжлийн байгууллага, эрдэмтэд ма сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруула үндэсэн нөхцөл нь цем сүргээс жишигт тэнцс хэлтүүлэгч бойжуулан хэлтэгч, хэлтүүлэгчий зохистой тохироог бүрдүүлэх явдал гэж дүгнэ байгааг үндэслэн энэхүү дэд хөтөлбөри боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагата гэж үзсэн болно.

Тав. Хөтөлбөрийн зорилго

6. Улсын хэмжээнд мал бүхий иргэн, а ахуйн нэгж, байгууллага хүрэлцэхүйц тооны жиши тэнцсэн хэлтүүлэгчийг ашиглаж нийт малы чанар, үржил-ашиг шим, удамшлын чадавхи сайжруулах нөхцөлийг бүрдүүлэхэд д хөтөлбөрийн зорилго оршино.

Зургаа. Хөтөлбөрийн зорилт

7. Хөтөлбөрийн зорилгыг дараа зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр зорилт: Малын төрөл, ашиг ...имийн чиглэлийн онцлогт тохирсон хээлтэгч, ...элтүүлэгчийн зохистой тохироог улсын хэмжээнд ...урдүүлэх;

Хоёрдугаар зорилт: Цэм сүргийг бүрдүүлэн ...ишигт тэнцсэн хээлтүүлэгч бойжуулж үржилд ...шиглах замаар нийт мал сүргийн чанар, үүлдэрлэг ...айдлыг дээшлүүлэх;

Гуравдугаар зорилт: Төрөл, зүйл, үүлдэр, ...гийн хувьд мөхөхөд хүрч байгаа мал, амьтны үр, ...өврөл үрийг авч генийн санд нөөцлөх, хээлтүүлэгч ...ал, үр, хөврөл үрийг импортлох замаар удмын ...нг хамгаалах, малын ашит шимийг сайжруулахад ...слалцаа дэмжлэг үзүүлэх.

Долоо. Хөтөлберийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8. Нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ...иллагаагаа хэрэгжүүлнэ:

8.1. 2005 онд улсын дунджаар өрдийн ...элтүүлгийн нөхцөлд 1 хээлтүүлэгчид оногдох ингэ ..., гүү 9, үнээ 20, эм хонь, ямаа 35 болгож хээлтэгч, ...элтүүлэгчийн хэвийн тохироог бүрдүүлэх;

8.2. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог 8.1-...аасан хэмжээнд хүргэх тооцоог бүс нутаг, аймаг, ...м бүр жил бүр хийж зохион байгуулалтын арга ...мжээ авч хэрэгжүүлэх.

9. Хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь ...л ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

9.1. Аймгийн малын үржлийн албад болон ... сум (хавсралт 1)-д цэм сүргийн үржлийн мал ...йжуулах өрх, фермерийг сонгон гэрээний үндсэн ...эр ажиллуулах;

9.2. Аймгийн малын үржлийн албаны цэм ...ргээс шилмэл хээлтүүлэгч бойжуулж үүлдэр, ...ог, хэвшлийн малын цэм сүрэг бүхий 51 сумын ...элтүүлэгчийг нөхөн сэлбэх;

9.3. 51 сумын цэм сүргээс хээлтүүлэгч ...йжуулж бусад сумын цэм сүргийн хээлтүүлэгчийг ...көн сэлбэж байх;

9.4. Удмын сангийн сүрэгт сайжруулагчаар ...иглах хээлтүүлэгч бойжуулах мал бүхий иргэд, ...ахуйн нэгжийг шалгаруулж сумын мэргэжлийн ...ил, үйлчилгээний нэгжийн захиалгын дагуу ...ээгээр өсвөр хээлтүүлэгч бойжуулах.

10. Гуравдугаар зорилтын хүрээнд дараахь ... ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

10.1. Тооны хувьд цөөрч удмын сан нь алдагдах хэмжээнд хүрээд байгаа зарим үүлдэр, омог, хэвшлийн мал, амьтны удмын санг хамгаалах, сэргээхтэй холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэх;

10.2. Сүүний үүлдрийн үхэр, каракул, нарийн, нарийвтар ноост хонь, Онжүл ямаа, цаа бугын удмын санг хамгаалах, сэргээхтэй холбогдсон арга хэмжээг гадаадаас хээлтүүлэгч импортлох замаар хэрэгжүүлэх;

10.3. Саалийн чиглэлийн цэвэр үүлдрийн үнээг зохиомол болон гардан аргаар хээлтүүлж өсвөр хээлтүүлэгч бойжуулан борлуулах;

10.4. Төв, суурингийн ойролцоох малчдын үнээнд арвин ашигт шимт бухны үр хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг явуулах.

11. Мал бүхий иргэд, малчид дараахь үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

11.1. Ердийн нийлүүлгийн үед нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн тоог энэ хөтөлберийн 8.1-д зааснаас доошгүй хэмжээнд хүргэж жил бүр сэлбэж байх;

11.2. Малчид шаардагдах хээлтүүлэгчээ сумын мал үржлийн ажил, үйлчилгээ хариуцсан нэгж, мэргэжилтэнд захиалж, гэрээний дагуу стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч авах;

11.3. Цэм сүрэг бүхий малчин гэрээ, захиалгын дагуу жишигт тэнцсэн өсвөр хээлтүүлэгч бойжуулан борлуулах;

11.4. Малын жин, ноос, ноолуур, сүүний гарцыг тодорхойлж үржил, ашиг шимийн бүртгэл хөтлөх;

11.5. Охин хурга, ишгийг нийлүүлгийн үед эх сүргээс тусгаарлан маллаж, цаг бусаар мал төллөх, нас гүйцээгүй мал хээлтүүлэгт оруулахаас сэргийлэх;

11.6. Хээлтүүлгийн зохистой хугацааг мөрдөх, хээлтүүлэгчийг айл хооронд сольж ашиглан, сүргийг цус ойртохоос сэргийлэх ажлыг мэргэжилтний заавар зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх.

12. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар дараахь үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

12.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж дутагдах хээлтүүлэгчийг цэм сүрэг бүхий иргэд, аж ахуйн нэгжээр бойжуулуулах, бусад аймаг, сум, багаас олж нийлүүлэх ажлыг зохион байгуулах;

12.2. Жишигт тэнцсэн хээлтүүлэгч бойжуулах цэм сургийг тухайн нутаг дэвсгэртээ шилж сонгон баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

12.3. Сумын хэмжээнд хээлтүүлэгчийн үзлэг, ангиллалт явуулж шаардагдах шилмэл хээлтүүлэгчийн хэрэгцээг жил бүр төлөвлөж ажиллах, 2005 он гэхэд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог хэвийн хэмжээнд хүргэсэн байх;

12.4. Жишигт тэнцсэн өсвөр насны хээлтүүлэгч бойжуулан зах зээлд борлуулах цэм сүрэг бүхий аж ахуйн нэгж, айл өрхтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллах;

12.5. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үржлийн шилмэл хээлтүүлэгчийн үзэсгэлэн, дуудлага худалдаа тогтмол зохион байгуулж сурталчлах, мал сүргийн чанарыг сайжруулах хөдөлгөөнийг өрнүүлэх.

13. Аймаг, сумын малын үржлийн алба, нэгж нь дараахь үйл ажиллагаа хэрэгжүүлнэ:

13.1. Аймаг, сумын хэмжээнд дутагдах болон зах зээлд нийлүүлэх хээлтүүлэгчийн тооцоог малын төрөл, ашиг шимийн чиглэлээр нарийвчлан тооцож, аймаг, бүс нутаг, улсын хэмжээнд мэдээлж, эрэлт-хэрэгцээ-нийлүүлэлтийн нэгдсэн сүлжээ бий болгон ажиллах;

13.2. Цэм сүрэг, үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч, гойд ашиг шимт малын ашиг шим, үржлийн чанарыг тодорхойлж гэрчилгээ олгон баталгаажуулах, үржил, ашиг шимийн бүртгэл хөтлүүлэх, ашиг шимийн гарц, чанарын мэдээллийн сан бүрдүүлэх;

13.3. Гойд ашиг шимт хээлтүүлэгчийг шалгаруулах, үнэ хаялцуулан худалдах ажлыг зохион байгуулах;

13.4. Цэм сүргийн малтай сум, баг, өрхөөс сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгч бойжуулах захиалгыг жил бүр авч, гэрээтэй ажиллах;

13.5. Өөрийн хээмшилд байгаа цэм сүрэгт үржлийн ажил, үйлчилгээ явуулан хээлтүүлэгч бойжуулж бүс нутаг, сумын цэм сүргийн хээлтүүлэгчийг сэлбэх.

14. Улсын мал эмнэлэг, үржлийн газар дараахь үйл ажиллагаог хэрэгжүүлнэ:

14.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсөл боловсруулах, захиалга хэрэгжүүлэх;

14.2. Малын ашиг шимийн мэдээллийн сүлжээ болон санг ажиллуулж, мэдээллээр ханга

14.3. Үржлийн ажлын чиглэлээр бүс нута аймаг, сумдад сургалт, семинар зохион байгуула

14.4. Улсын хэмжээнд гойд ашиг шим малыг шалгаруулах, үржлийн малын үзэсгэлэ дуудлага худалдаа зохион байгуулах;

14.5. Сүмбэр, Жаргалант, Орхон, Ерө Хангай, Талын цагаан хонь, Алатау, Семминта Хар тарлан, Сэлэнгэ үхэр, Өнжүүл ямаа, Цаа бу зэрэг төрөл, зүйл, үүлдэр, омгийн хувьд мөхөхө хүрч байгаа мал, амьтны удмын санг хамгаала арга хэмжээг зохион байгуулах.

15. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хөтөлбө хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь үй ажиллагааг явуулна:

15.1. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагда зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгий төсөвт тусгуулах, дотоод, гадаадын зээ тусламжид хамруулах ажлыг зохион байгуулах;

15.2. Цэм сүргийн хээлтүүлэгч бойжуула талаар ирүүлсэн төслийг шалгаруулж эргэн төл нөхцөлтэй зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүл асуудлыг судалж хэрэгжүүлэх;

15.3. Гадаад орноос арвин ашиг шимт ма амьтан, тэдгээрийн үр, көврөл үр, мал хээлтүүлгий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг импортлохо албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлы судалж шийдвэрлүүлэх.

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

16. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг улсы хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуула хяналт тавих үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яа хариуцна.

17. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгө Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймаг, нийслэл, су дүүрэг бүр боловсруулж мөрдөн үр дүнг жил б тооцож ажиллана.

18. Хөтөлбөрийн хэрэгжилтийг су дүүргийн Засаг даргын Тамгын газар айма нийслэлийн Засаг даргын Тамгын газарт жи бүрийн 1 дүгээр сард багтаан, аймаг, нийслэлий Засаг даргын Тамгын газар 2 дугаар сарын 15-н дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тус т тайлагнана. Хүнс, хөдөө аж ахуйн яам тайла нэгтгэн жил бүрийн эхний улиралд багтаан Засги газарт танилцуулна.

Ес. Хөтөлбөрийн санхүүжилт

19. Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

19.1. Улсын төвөрсөн болон орон нутгийн өсвөөс хөтөлбөр хэрэгжүүлэхэд олгох хөрөнгө;

19.2. Мал хамгаалах сангаас хөтөлбөр хэрэгжүүлэхэд хуваарилах хөрөнгө;

19.3. Гадаад орон, олон улсын байгууллагаас малын үржлийн арга хэмжээ, удмын санг хамгаалахтай холбогдуулан олгож байгаа төл, тусламж;

19.4. Иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын хандив тусламж;

19.5. Эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох өсвийн зээлийн хөрөнгө;

19.6. Мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө.

20. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд нийтдээ 180.7 сая төгрөг шаардагдана.

Арав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

21. Энэхүү хөтөлбөрийг 2002-2005 оныг хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

Арван нэг. Хөтөлбөр хэрэгжсэнээр гарах үр дүн

22. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

22.1. Улсын хэмжээгээр хээлтэгч, хээлтүүлэгчийн зохистой тохиролцоо бүрдэж, жишигт тэнцсэн сайн чанарын хээлтүүлэгч малтай болно;

22.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн ялангуяа, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх биологийн баталгаа сайжирна;

22.3. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүний эдэд түшиглэсэн үндэсний үйлдвэр сэргэж мах, ноос, ноолуур зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэх боломж дээшилнэ;

22.4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа "Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах", "Ноолуур", "Ноос," "Цагаан хувьсгал", "Хүнсний хангамж, ахуулгүй байдал-хоол тэжээл" хөтөлбөрүүд хэрэгжих баталгаа сайжирна;

22.5. Малын чанар, үржил, ашиг шим, удамшлын чадавхийн талаар улсын хэмжээний бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болж үйл ажиллагаа нь тогтмолжино;

22.6. Малчин өрхийн орлого нэмэгдэнэ.

Арван хоёр. Хөтөлбөрийн шалгуур, үзүүлэлт

23. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тавьсан зорилт, үйл ажиллагаа нэг бүр хэрэгжсэн байх шалгуураар, хөтөлбөрт дэвшүүлсэн болон жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрийн тоо, чанарын үзүүлэлтээр үнэлнэ. Хөтөлбөрийн хавсралтад заасан үзүүлэлт хэрэгжсэн байна.

24. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур, хүрэх түвшин буюу үзүүлэлтийг жил бүр оны эхэнд Хүнс, хөдөө аж ахуйн яам тогтоон явцад нь хяналт-шинжилгээ хийж, жилийн эцэст үнэлж байна.

Хөтөлбөрийн хавсралт

ЦӨМ СҮРЭГ БҮРДҮҮЛЖ ХЭЭЛТҮҮЛЭГЧ БОЙЖУУЛАХ АЙМАГ, СУМ

Бүс нутаг	Аймаг	Сумын нэр	Үржүүлэх үүлдэр, омог	Хээлтэгчийн тоо	Бойжуулах хээлтүүлэгч			Бүгд
					2003	2004	2005	
Цөм сүрэг бүрдүүлж хуц бойжуулах аймаг, сум								
Баруун бүс	Увс	Малчин	Баяд	7.8	1.6	1.7	1.8	5.1
		Зүүнговь	Баяд	6.8	1.4	1.5	1.6	4.5
	Баян-Өлгий	Дэлүүн	Керей	13.5	2.7	2.8	2.9	8.4
	Ховд	Булган	Торгууд	4.5	0.9	1.0	1.1	3.0
		Дарви	Сутай	8.6	1.7	1.8	1.9	5.4
	Завхан	Эрдэнэ-хайрхан	Сартуул	7.3	1.5	1.6	1.7	4.8
		Алдархаан	Сартуул	5.5	1.1	1.2	1.3	3.6
	Говь-Алтай	Бугат	Говь-Алтай	6.8	1.4	1.5	1.6	4.5
		Цээл	Говь-Алтай	7.5	1.5	1.6	1.7	4.8
	Бүгд			68.3	13.8	14.7	15.6	44.1
	Хөвсгөл	Рэнчинлхүмбэ	Дархад	4.0	0.8	0.9	1.0	2.7
		Цагаан-Уул	Цагаан-уул	4.5	0.9	1.0	1.1	3.0

Хангайн бүс	Архангай	Хотонт	Монгол	5.0	1.0	1.1	1.2	3.3
		Цахир	Тамир	1.5	0.3	0.4	0.5	1.2
	Бүгд			15.0	3.0	3.4	3.8	10.2
Төвийн бүс	Сэлэнгэ	Цагаannуур	Хангай*	0.2	0.04	0.05	0.06	0.15
		Орхон	Орхон*	0.2	0.04	0.05	0.06	0.15
		Ерөө	Ерөө*	0.3	0.06	0.07	0.08	0.21
	Төв	Баянцагаан	Монгол	6.0	1.2	1.3	1.4	3.9
		Жаргалант	Жаргалант*	0.2	0.04	0.05	0.06	0.15
	Бүгд			6.9	1.38	1.52	1.66	4.56
Зүүн бүс	Хэнтий	Хэрлэн	ТНЦ*	0.3	0.06	0.07	0.08	0.21
	Дорнод	Хөлөнбуйр	Барга	3.0	0.6	0.7	0.8	2.1
		Сэргэлэн	Үзэмчин	8.0	1.6	1.7	1.8	5.1
	Сүхбаатар	Эрдэнцагаан	Үзэмчин	8.0	1.6	1.7	1.8	5.1
	Бүгд			19.3	3.86	4.17	4.48	12.51
Нийт дүн				109.5	22.04	23.79	25.54	71.37

Цэм сүрэг бүрдүүлж ухна бойжуулах аймаг, сум

Баруун бүс	Увс	Өлгий	Өлгийн улаан	6.0	1.1	1.2	1.2	3.5
	Баян-Өлгий	Баяннуур	Улгын бор	0.8	0.1	0.1	0.1	0.3
	Ховд	Алтай	Алтайн улаан	6.0	1.1	1.1	1.2	3.4
	Завхан	Дөрвөлжин	Завханы бууралт	9.0	1.6	1.7	1.8	5.1
	Говь-Алтай	Бугат	Монгол	2.3	0.4	0.5	0.6	1.5
		Алтай	Монгол	2.6	0.5	0.6	0.6	1.7
		Цээл	Монгол	3.0	0.5	0.6	0.6	1.7
	Бүгд			29.7	5.3	5.8	6.1	17.2
Хангайн бүс	Хөвсгөл	Төмөрбулаг	Эрмийн хар	7.8	1.4	1.5	1.6	4.5
	Баянхонгор	Шинжинст	Залаа жинс-тийн цагаан	8.0	1.4	1.5	1.6	4.5
		Бөмбөгөр	Монгол	2.4	0.4	0.5	0.6	1.5
		Баацагаан	Монгол	2.0	0.4	0.5	0.6	1.5
	Бүгд			20.2	3.6	4.0	4.4	12.0
Төвийн бүс	Төв	Заамар	Монгол	0.3	0.1	0.1	0.1	0.3
		МААЭШХ	Монгол	0.3	0.1	0.1	0.1	0.3
		Нөхөрлөл	Монгол	0.2	0.1	0.1	0.1	0.3
	Өмнөговь	Булган	Говь гурван-сайхан	1.0	0.2	0.3	0.3	0.8
		Ханхонгор	Монгол	0.8	0.2	0.2	0.2	0.6
		Цогт-Овоо	Монгол	0.8	0.2	0.2	0.2	0.6
		Баяндалай	Монгол	0.8	0.2	0.2	0.2	0.6
	Бүгд			4.2	1.1	1.2	1.2	3.5
Зүүн бүс	Хэнтий	Галшар	Монгол	2.0	0.4	0.5	0.5	1.4
	Сүхбаатар	Баяндэлгэр	Баяндэл-гэрийн улаан	8.0	1.4	1.5	1.6	4.5
	Бүгд			10.0	1.8	2.0	2.1	5.9
Нийт дүн				64.1	11.8	13.0	13.8	38.6

Цэм сүрэг бүрдүүлж бух бойжуулах аймаг, сум

Баруун бүс	Увс	Тэс	монгол	2.0	0.24	0.3	0.3	0.84
	Завхан	Их-Уул	Монгол	2.0	0.3	0.3	0.3	0.9
	Бүгд			4.0	0.54	0.6	0.6	1.74
Хангайн бүс	Хөвсгөл	Цагаан-Уул	Монгол	2.2	0.26	0.26	0.75	1.27
	Булган	Сэлэнгэ	Сэлэнгэ	1.7	0.2	0.3	0.5	1.0
	Архангай	Тариат	Сарлаг	3.0	0.3	0.3	0.3	0.9
	Өвөрхангай	Уянга	Сарлаг	8.9	1.0	1.0	1.0	3.0
	Бүгд			15.8	1.76	1.86	2.55	6.17
Төв бүс	Сэлэнгэ	Орхонтуул	Сэлэнгэ	2.3	0.27	0.27	0.27	0.81
	Бүгд			2.3	0.27	0.27	0.27	0.81
Зүүн бүс	Дорнод	Чойбалсан	Дорнод талын улаан	4.5	0.5	0.5	0.5	1.5
	Сүхбаатар	Түмэнцогт	Дорнод талын улаан	2.7	0.3	0.4	0.5	1.2
	Бүгд			7.2	0.8	0.9	1.0	2.7
Нийт дүн				29.3	3.37	3.63	4.42	11.42

Цэм сүрэг бүрдүүлж буур бойжуулах аймаг, сум

Баруун	Говь-Алтай	Төгрөг	Хөх зогдорт	0.2	0.014	0.014	0.014	0.042

Говийн бүс	Өмнөговь	Мандал-Овоо	Ханын хэцийн хүрэн	1.2	0.08	0.08	0.08	0.24
		Ханбогд	Галбын говийн уламж	0.6	0.042	0.042	0.042	0.126
Нийт дүн				2.0	0.136	0.136	0.136	0.408
Цөм сүрэг бүрдүүлж азрага бойжуулах аймаг, сум								
Баруун	Увс	Тэс	Тэс	0.3	0.05	0.05	0.05	0.15
Зүүн	Хэнтий	Галшар	Галшар	0.6	0.1	0.1	0.1	0.3
Төв бүс	Төв	МААЭШХ	Хүрдан удмын ядуу	0.1	0.02	0.02	0.02	0.06
Нийт дүн				1.0	0.17	0.17	0.17	0.51
Ерөнхий дүн				205.9	37.516	40.726	44.066	122.308

*-нарийн, нарийвтар ноост хонь

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 142** **Улаанбаатар хот**

Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах үралдаант шалгаруулалтын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 46-54 дүгээр зүйл, Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах Үралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-гийн 1 дүгээр, "Үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах ажлыг удалдах/ доод үнийг 3280000 ам.доллараар тогтоосугай.

3. Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-д даалгах нь:

а/Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах Үралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г батлагдсан /тендер/-ын журам"-ын дагуу зохион байгуулан явуулсугай;

б/Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах үралдаант шалгаруулалтыг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ын дагуу зохион байгуулан явуулсугай;

в/Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах үралдаант шалгаруулалт /тендер/-д ялсан худалдан авагчтай "Үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2002 оны 1 дугаар сарын 1-ний өдрийн 76 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын "Хөдөө аж ахуйн банк" ХХК /цаашид "ХААН банк" гэх/-ийн төрийн мэдлийн 100 хувийг худалдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/-ын журмаар хувьчлах үйл ажиллагаанд оролцох эдаадын болон дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын Засгийн газар урьж байна.

Тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 142 дугаар тогтоолоор батлагдсан "Үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д тусгагдсан нөхцөл, болзлын дагуу Төрийн өмчийн хорооноос зохион байгуулж явуулна. Засгийн газрын шийдвэрээр банкны төрийн мэдлийн 100 хувийг худалдах доод үнийг 3,280,000 /Гурван сая хоёр зуун наян мянга/ ам. доллараар тогтоов.

ХААН банкыг хувьчлах ажилд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай байгуулсан гэрээний дагуу "КПМЖ консалтинг" компанийн "Баренц бүлэг" нь Төрийн өмчийн хорооны зөвлөхөөр ажиллаж байгаа болно.

Азийн хөгжлийн банк /цаашид "АХБ" гэх/ нь банкны хувьчлалд оролцохтой холбогдуулан хувьцааны цөөн хувийг худалдаж авах, эсвэл бусад хэлбэрээр хөрөнгө оруулах зэрэг хөрөнгө оруулалтын аль хэлбэрийг сонгох талаар судалгаа хийж байна. АХБ-наас оруулах хөрөнгө оруулалт нь дэлгэрэнгүй дүн шинжилгээ, үнэлгээ, Монгол Улсын Засгийн газраас хувьчлалын талаар баримталж буй чиглэл, ХААН банкыг хувьчлах тухай тендерийн зар мэдээ, тендерийн журмын дагуу тус банкыг амжилттай хувьчилсан эсэх, АХБ, Монгол Улсын Засгийн газар ба тендерт ялагчийн харилцан хэлэлцэх тохирох хөрөнгө оруулалтын бүтэц, АХБ-ны ажлын дотоод журмын дагуу авбал зохих АХБ-ны удирдлага болон Захирлуудын зөвлөлийн зөвшөөрөл болон бусад хүчин зүйлээс хамаарах юм.

АХБ-ны хувьчлалд оролцох сонирхлыг тус байгууллага ХААН банкинд хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн байдлаар ойлгож болохгүй. Боломжит хөрөнгө оруулагчид АХБ-наас илэрхийлж буй сонирхлыг харгалзахгүйгээр ХААН банкны талаар өөрийн бие даасан судалгаа хийх нь зүйтэй. АХБ нь ХААН банкны талаарх Ерөнхий мэдээлэл болон тендерийн явцад гаргаж өгөх бусад аль ч мэдээллийн үнэн зөв, бүрэн дүүрэн эсэх талаархи хариуцлагыг хүлээхгүй.

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Банк буюу санхүүгийн байгууллага, эсвэл тэдгээрийн оролцоотой консорциум зэрэг тодорхой хэмжээнд шаардлага хангасан стратегийн хөрөнгө оруулагчдыг сонирхлоо ирүүлэхийг урьж байна.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй эттээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг англи эсвэл монгол хэл дээр дараахь материалын хамт Төрийн өмчийн хороонд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;
2. Өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;
3. Бүцаж төлөгдөхгүй нөхцөлтэй 1000 / нэг мянган/ ам. долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт;
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд түүнд зохих журмын дагуу олгосон итгэмжлэл;
5. Өргөдөл гаргагчийн танилцуулга. Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай:

- Тендерт оролцох компанийн албан ёсны нэр, хаяг болон үйл ажиллагааны танилцуулга / консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,
- Дотоодын болон олон улсын банкны болон санхүүгийн үйлчилгээний салбарт туршлага хуримтлуулсныг батлах чадавхийн талаарх мэдэгдэл,
- Тендерт оролцож буй компанийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд,
- Санхүүгийн сүүлийн жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл буюу нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан /энэхүү мэдээллийг консорциумд оролцож буй компани тус бүрээр гаргаж өгнө/,
- Тендерт оролцох хүсэлтээ ирүүлсэн өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны 5 / тав/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,
- Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн баталгаа.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Төрийн өмчийн хорооны www.spc.gov.mn вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар авч болно.

Тендерийн хураамжийг Монгол Улсын Монголбанкин дахь Төрийн өмчийн хорооны дараахь дансанд төлнө:

Банкны нэр:	Монгол Улсын Монголбанк
SWIFT код:	BOMUMNUB
Дансны нэр:	Төрийн өмчийн хороо
Дансны дугаар:	3332404
Монголбанкны харилцагч банк:	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код:	FRNYUS33
Дансны нэр:	Монголбанк
Дансны дугаар:	021088506

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилвол түүний төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр нотолно. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд тэдгээвэн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдлийг 2002 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн

(Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулалтын шалгуур

Өргөдөл гаргагч нь тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд банк буюу санхүүгийн байгуллагатай, эсвэл тэдгээрийн оролцоотой консорциум байхын зэрэгцүүз дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Дотоодын буюу олон улсын банкны болон санхүүгийн үйлчилгээний салбарт 10-аас доошгүй жил ажилласан байх;
2. 20 /хорин/ сая ам. доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;
3. Санхүүгийн байдал нь тогтвортой, үйл ажиллагааны баялаг туршлагатай байх / үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/.

Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдэгдэх

Төрийн өмчийн хороо өргөдөл хүлээн эвснаас хойш ажлын 10 /арван/ өдөрт багтаан урьдчилан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг авах болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг бичгээр үйлдэн буухиа шуудан, баталгаат шуудан, факс буюу электрон шуудангаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцогчдод тендерийн баримт бичгүүдийг мэдэгдлийн хамт буухиа шуудангаар хүргүүлнэ.

Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичгүүд гэдэгт:

1. Компанийн тухай ерөнхий мэдээлэл
2. Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам
3. Худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

Зөвьчлалын зорилго

ХААН банкыг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас дэвшүүлэх дор дурдсан зорилгыг ханган бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай.Үүнд:

- ХААН банкны орон нутаг дахь салбаруудын үйл ажиллагаа хадгалж, орон нутагт банкны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- Банкны хөрөнгийг нэмэгдүүлэх, түүний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн чадавхийг сайжруулах, банкны зохистой практикт нийцсэн зээлийн үйл ажиллагаа орон нутагт өргөжүүлэх,
- Банкны болон санхүүгийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх,
- Монгол Улсын санхүүгийн салбарт урт хугацаат хөрөнгө оруулалт хийх.

Тендерийн ажиллагаа

Тендерт оролцогчид техникийн болон санхүүгийн саналаас бүрдэх тендерийн саналаа Төрийн өмчийн хороонд 2002 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө,тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт ирүүлнэ.

Тендерийн дэнчин гэж 100,000 (нэг зуун мянган) ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын Монголбанкин дахь Төрийн өмчийн хорооны 3332404 дугаартай валютын дансанд төлнө.

Тендерийн саналыг үнэлсний дараа тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг /дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заасан/ тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоо/ хоногт багтаан бүрэн бүцаан олгоно.

Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон банкны удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана. Тендерт оролцогчдыг худалдах, худалдан авах гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах бололцоогоор хангана.

Техникийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр шалгаруулна:

1. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн ур чадвар (0-40 оноо),
2. Санал болгож буй бизнесийн стратеги/ үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлэх

хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо),

3. Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн зээлийн практикийг хэрэгжүүлэх (0-10 оноо),
4. Ажилтнуудыг сургах, хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтын хүрээ, төрөл зэргийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан оролцогчийн техникийн саналыг шалгаруулна.

Санхүүгийн санал нь тендерээр худалдахаар санал болгож буй банкыг худалдан авахаар ирүүлсэн үнээс бүрдэнэ.

Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

"ХААН банк" ХХК-ийн тухай

ХААН банк нь Монголын уудам нутагт тархан байрлах 352 салбар бүхий сүлжээтэй, энэ үзүүлэлтээр өөрийн дараа орох банкнаас даруй 14 дахин том болно. Иймээс давуу байдлаараа ХААН банк нь өнөөдөр монголын хөдөөгийн хүн амын 98 хувьд хүрч үйлчилж байна. Энэ нь тус банкинд хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, монголын хот, хөдөөг холбох санхүүгийн гол гүүр болох зэрэг хүчтэй өрсөлдөх давуу талыг олгож байна.

ХААН банк нь 1991 онд хувийн банкны хэлбэрээр байгуулагдсан боловч Засгийн газраас тус банкинд бүтцийн өөрчлөлт хийх дахин хөрөнгөжүүлэх болон гадны удирдлагын бүрэлдэхүүнээ сэргээн төлөвлөгөөг тусгасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүртэл ашигтай ажилласан чадаагүй юм. Өнөөдөр ХААН банк нь 100 хувь төрийн өмч бөгөөд өөрийн шинэ менежерүүдийн удирдлага дор хөдөөгийн хүн амд банкны жинхэнэ үйлчилгээг дахин хүргэх болсон огцом өсөлтэй хүрсэн билээ.

ХААН банк нь Засгийн газрын байгууллагын жижиг бизнес эрхлэгчид болон малчид, төтгөвөрийн хүмүүс, жижиг дэлгүүр ба жижиг үйлдвэрлэлийн эзэд зэрэг хэрэглэгчдэд зээл, хадгаламж, дотоодын гадаад гүйлгээ зэрэг үйлчилгээ үзүүлж байна.

ХААН банкны төв бөгөөд бүх гүйцэтгэх удирдлага болон захиргааны байгууллагууд нь нийслэлийн Улаанбаатарт байрладаг. Түүнчлэн тус хотод банкны 11 салбар байрлах ба цаашид банкны эзэмшүүлэх чухал зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна. Мөн нийслэлээс гадна бүх аймгийн чухал төвүүд, бүсийн төвүүдэд болон зарим нэгийг эс тооцвол жижиг хот, тосгон бүрт өөрийн салбартай. Эдгээр газрын 90 хувьд нь бусад банкуудын салбар байхгүй болно.

ХААН банк нь жижиг болон бичил зээлдэгчдэд чиглэсэн өөрийн зээл олгох хөтөлбөрөөрөө бахархдаг юм. Энэхүү зээлийн хөтөлбөрийн эргэн төлөлтийн хувь нь их эзэнд байгаа болно. Сүүлийн 18 сард олгосон 20000 гаруй зээлийн 0.5 хувь нь чанаргүй зээлд тооцогдож байна. Энэ амжилтын ихэнх нь үйлчүүлэгчидийн дунд эрэлт хэрэгцээтэй бай банкны хамт олны хувь оролцох харьцангуй хялбар, оновчтой зохион байгуулсан, зөв хэрэгжүүлсэн, нарийвчлан хянасан зээлийн багцыг хэрэгжүүлснээс үүдэлтэй юм.

2002 он 5 дугаар сарын 31-ний байдлаархи зээлийн үлдэгдэл:

Зээлдэгчийн төрөл	Зээлийн тоо	Үлдэгдэл
Бичил бизнес	9,505	$ 7,862,000
Малчид	2,890	$ 1,938,000
Тэтгэврийн хүмүүс	49,059	$ 1,396,000
Хэрэглэгчид	17,083	$ 1,904,000
ХААН үйлдвэрлэгчид болон худалдаачид	161	$ 90,000
Үйлдвэрлэлийн бизнесийн хугацаат зээл	15	$ 100,000
Ажилчдын орон сууц болон хэрэглээ	500	$ 232,000
Нийт	79,213	$13,522,000

ХААН банк сүүлийн хэдэн жилийн турш маш эрчимтэй хөгжиж ирсэн. Энэ нь гол төлөв зах зээл хөгжөөгүй хөдөө орон нутагт банк санхүүгийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлж чадсантай холбоотой. ХААН банк хэрэглэгчидтэйгээ тулан ажиллаж, маркетингийн шинэчтой стратеги хэрэглэсний үр дүнд урьд өмнө нь банкны үйлчилгээг огт ашиглаж байгаагүй буюу хөдөө ашиглаж байсан аж ахуйн нэгж, хувь хүмүүс өнөөдөр ХААН банкны тогтмол харилцагчид

болсон юм. Тус банк өөрийнхөө бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлийн бусад давхаргад нэвтрүүлэхээр зорьж буй тул энэ хандлага цаашид үргэлжлэх төлөвтэй байна.

1999, 2000, 2001 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр аудит хийгдсэн санхүүгийн тайлангууд гарсан. Артур Андерсен ХХК нь 2000, 2001 оны санхүүгийн тайлангуудыг хянасан болно. Санхүүгийн гол үзүүлэлтийг дурдвал:

2002 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар:

- Нийт хөрөнгө 36 сая ам. долларт хүрсэн,
- Нийт зээл 13.5 сая ам. долларт хүрч зээлийн болзошгүй алдагдлын санг 173,000 ам. доллараар байгуулсан,
- Бэлэн мөнгө болон богино хугацаат хөрөнгө оруулалт 18.5 сая ам. долларт хүрсэн,
- Өөрийн хөрөнгө 2.4 сая ам. доллар байна.

2001 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар:

- Татварын өмнөх ашиг 1.3 сая ам. долларт хүрсэн
- Татвар төлсний дараахь ашиг 802,000 ам. долларт хүрсэн
- Нийт хөрөнгийн өгөөж 4.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 472 хувь байжээ.

ХААН банк Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар биелүүлсэн байна. Үүнд:

Харьцаа	2002 оны 5 дугаар сар	2001	2000
Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа > 18%	48.0%	54.75%	39.1%
Зээлийн төвлөрлийн эрсдэл < 20%	0.2%	0.3%	3.0%
Заавал байлгах нөөц > 14%	19.3%	26.5%	16.5%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ > 10%	13.0%	13.77%	-3.95%

ХААН банк өөрийн төв байр болон 207 салбарын барилгыг өмчилдөг. Бусад 143 салбарын байрыг бага хэмжээний түрээс буюу огт төлбөргүйгээр түрээслэж байна. Тус бүр жилд 1010 ам. доллар байсан байрны түрээсийн төлбөр сард ойролцоогоор 75 ам. доллар болж буурч байна.

2002 оны бизнесийн төлөвлөгөөний дагуу ХААН банк хадгаламж, зээл болон ашгийнхаа хэмжээг өсгөхөөр төлөвлөж байна. 2002 онд тус банкны зээлийн хэмжээ 70 хувь, хадгаламжийн хэмжээ дор хаяж 65 хувиар өсөхөөр төлөвлөгдөж байна.

ХААН банкны санхүүгийн сүүлийн 2 жилийн болон 2002 оны 3 дугаар сарын 31-ний байдлаархи санхүүгийн зарим үзүүлэлтүүдийг дор харуулав. Үүнд:

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН БАНК

АШИГ АЛДАГДЛЫН ТАЙЛАН

12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон 2001 ба 2000 он

(мянган ам. доллар)

	2001	2000
Хүүгийн орлого	2,6	512
Хүүгийн зардал	4	155
Хүүгийн цэвэр орлого	2,2	357
Зээлийн болзошгүй алдагдлын сангийн бууцаалтын орлого	1	16
Зээлийн болзошгүй алдагдлын сангийн бууцаалтын орлогын дараахь хүүгийн цэвэр орлого	2,3	373
Шимтгэл ба үйлчилгээний хураамж	81	389
Бусад	1	38
Нийт хүүгийн бус орлого	9	427
Үйл ажиллагааны зардал	2,0	1,100
Бусад болзошгүй алдагдлын сангийн зардал (сангийн бууцаалтын орлого)	(69)	9
Хүүгийн бус зардал	2,0	1,109
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	1,310	(309)
Орлогын татварын зардал	508	-
Цэвэр ашиг (алдагдал)	8	(309)

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН БАНК

ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ
12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон 2001 ба 2000 он

(мянган ам. доллар)

	2001	2000
ХӨРӨНГӨ		
Мөнгөн хөрөнгө болон богино хугацаат сангууд	1,758	1,028
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	872	915
Монголбанкны үнэт цаас	9,617	2,722
Монголбанкинд олгосон зээл	-	884
Зээл ба урьдчилгаа, цэвэр дүнгээр	9,070	179
Санхүү, эдийн засгийн яамнаас авах авлага	-	273
Засгийн газрын бонд	-	3,986
Холбогдох талуудаас авах авлага, цэврээр	55	6
Үндсэн хөрөнгө, цэвэр дүнгээр	2,533	1,184
Бусад хөрөнгө, цэвэр дүнгээр	266	311
НИЙТ ХӨРӨНГӨ	**24,171**	**11,488**
ӨР ТӨЛБӨР		
Харилцагчдын харилцах, хадгаламж	15,281	7,704
Төсвийн харилцах, хадгаламж	6,831	3,999
Бусад өр төлбөр	503	247
НИЙТ ӨР ТӨЛБӨР	**22,615**	**11,950**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Дүрмийн сан	4,151	1,815
Нэмж төлөгдсөн капитал	-	1,996
Дахин үнэлгээгээр нэмэгдсэн капитал	876	-
Хуримтлагдсан алдагдал	(3,471)	(4,273)
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (-ИЙН ХОМСДОЛ)	**1,556**	**(462)**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	**24,171**	**11,488**
САНХҮҮГИЙН ҮҮРЭГ, БОЛЗОШГҮЙ БАЙДАЛ БА \БАЛАНСЫН ГАДУУРХИ ЗҮЙЛС	**9,004**	3,346

Санхүүгийн зарим үзүүлэлтүүд (аудитаар баталгаажаагүй)
3 дугаар сарын 31-ний байдлаар, 2002 ба 2001 он

(мян. ам. доллар)*

	2002 оны 3 дугаар сарын 31	2001 оны 3 дугаар сарын 31
Хүүгийн цэвэр орлого	548	89
Хүүгийн бус орлого	93	97
Татварын өмнөх ашиг	333	30
Цэвэр ашиг	201	30
Нийт хөрөнгө	29,438	12,812
Зээл, цэвэр дүнгээр	12,345	804
Нийт өр төлбөр	27,318	13,195
Хэрэглэгчдээс хуримтлагдсан хадгаламж	26,605	12,100
Нийт өөрийн хөрөнгө	2,120	(383)
* Төгрөг/ам. долларын харьцаа (хугацааны эцэст)	1,103	1,100

Тендерт оролцох албан ёсны ергедел болон тендерийн саналуудыг дараахь хаягаар ирүүлнэ үү:

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын 4 дүгээр байр, 410 тоот өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Нэмэлт мэдээллийн талаар Төрийн өмчийн хорооны дээр дурдсан хаягаар болон Төрийн өмчийн хорооны зөвлөх "КПМЖ консалтинг" компанийн Барентс бүлэгт дараахь хаягуудаар хандана уу:

Жеймс Двайер E-mail: jbd35238@aol.com
Живко Ненов E-mail: znenov@magicnet.mn
Тереза Слазас E-mail: tslazas@kpmg.com

Хаяг:

"КПМЖ консалтинг" компанийн "Баренц бүлэг"
Засгийн газрын 11 дүгээр байр, 301 тоот өрөө
Улаанбаатар-38
Монгол Улс
Утас: 976-11-324149
Факс: 976-11-324149
E-mail: barents@magicnet.mn

эсвэл

Teresa Slazas
Barents Group of KPMG Consulting, Inc.
1676 International Drive
McLean, VA 22102, USA
Tel: +1 703-747-7698
Fax: +1 703-747-3919
E-mail: tslazas@kpmg.com

Компанитай холбоотой мэдээлэл болон зарлалыг **www.spc.gov.mn** вэбсайтаас үзнэ үү.

Түүнчлэн нэмэлт мэдээллийг банкны **www.agbank.mn** гэсэн вэбсайтаас авна уу.

Засгийн газрын 2002 оны 142 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 76 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Хөдөө аж ахуйн банк /цаашид "банк" гэх/-ны төрийн эзэмшлийн 100 хувийг уралдаант шалгаруулалт /тендер/-ын аргаар гадаадын болон дотоодын стратегийн хөрөнгө оруулагчид худалдахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

1.2 Төрийн өмчийн хороо нь зөвлөхүүдийн туслалцаатайгаар тендерийг зохион байгуулж явуулна.

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1 ***"Банк"*** гэж Монгол Улсын Хөдөө аж ахуйн банкыг хэлнэ.

2.2 ***"Стратегийн хөрөнгө оруулагч"*** гэж дотоодын буюу олон улсын банкны болон /буюу санхүүгийн үйлчилгээний салбарт 10-аас доошгүй жил ажилласан; 20 /хорин/ сая ам. Доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй; санхүүгийн тогтвортой байдалтай, үйл ажиллагааны баялаг туршлагатай/ үүнийг аудитаар батлагаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/ банк буюу санхүүгийн байгууллага, эсвэл тэдгээрийн оролцоотой консорциумыг хэлнэ.

2.3 ***"Ерөнхий мэдээлэл"*** гэж тендерт оролцогч тус бүрт хүргэх банк болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаархи мэдээллийн баримт бичгийг хэлнэ.

2.4 ***"Дэнчин"*** гэж худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах амлалт, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 100000 /нэг зуун мянган/ ам. Доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Дэнчинг Монголбанк дахь Төрийн өмчийн хорооны валютын дансанд төлнө.

2.5 ***"Зар мэдээ"*** гэж Төрийн өмчийн хорооноос тендер явуулах тухай нийтэд сонордуулсан албан ёсны зар мэдээллийг хэлнэ.

2.6 ***"Зөвлөх"*** гэж Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Төрийн өмчийн хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж

буй "КПМЖ Консалтинг" ХК-ийн Баренц бүлгийн зөвлөх /зөвлөхүүд/-ийг хэлнэ.

2.7 ***"Нууцыг хадгалах тухай гэрээ"*** гэж банк, Төрийн өмчийн хороо, Монгол Улсын Засгийн газар болон зөвлөхүүдээс өгөх банктай холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.8 ***"Өргөдөл"*** гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх өргөдөл, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын иж бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг бичгээр үйлдэж, өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргагч тендерт оролцохын тулд урьдчилсан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаарх мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

2.9 ***"Тендерийн баримт бичиг"*** гэдэгт:

1) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,

2) Ерөнхий мэдээлэл,

3) Худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

2.10 ***"Тендерт оролцогч"*** гэж тендерт оролцохоор өргөдөл гаргасан, урьдчилан шалгаруулалтын шатанд Төрийн өмчийн хороо өргөдлийг нь хүлээн авч шалгаруулсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

2.11 ***"Тендерийн санал"*** гэж тендерт оролцогчоос тендерт оролцохоор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн санал нь техникийн ба санхүүгийн саналаас бүрдсэн байна.

2.12 ***"Тендерийн хураамж"*** гэж тендерийн баримт бичгээр хангах үйлчилгээний хураамж болгон тендерт оролцогчоос Төрийн өмчийн хороонд төлөх 1000 /нэг мянган/ ам. Долларын бүцааж төлөгдөхгүй төлбөрийг хэлнэ.

2.13 ***"Уралдаант шалгаруулалт / цаашид "тендер" гэх"*** гэж тендерт оролцогдоос ирүүлсэн тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулах үйл ажиллагаат хэлнэ.

2.14 ***"Худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл"*** гэж Төрийн өмчийн хорооноос санал болгож буй, тендерт оролцогчдод тэдний саналыг авахаар хүргүүлэх худалдах худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.15 ***"Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл"*** гэж худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.16 ***"Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл"*** гэж худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохүйц саналуудыг тусган Төрийн өмчийн хорооноос эцэслэн батлэгч гаргах төслийг хэлнэ.

2.17 ***"Худалдан авах үнэ"*** гэж уралдаант шалгаруулалтын аргаар худалдаж буй банкны төрд ногдох хувь хөрөнгийг худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнийн дүнг хэлнэ.

ГУРАВ. ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

3.1 Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.

ДӨРӨВ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ

4.1 Тендерт оролцогчийн эрх зүйн байдал

4.1.1 Урьдчилан шалгаруулалтад тэнцсэн, Монгол Улсын болон гадаад улсын банк буюу санхүүгийн байгууллага, эсвэл тэдгээрийн оролцоотой консорциум зэрэг тодорхой хэмжээнд шаардлага хангасан бүх боломжит хөрөнгө оруулагчид тендерт оролцож болно.

4.1.2 Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.3 Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд эвөхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.2 Тендерт оролцогчийн эрх

4.2.1 Тендерт оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд Төрийн өмчийн хорооноос баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгийг иж бүрэн нэг багцыг авах эрхээр хангагдана.

4.2.2 Тендерт оролцогч нь дараахь эрх эдэлнэ:

1) Мэдээллийн танхимд тавигдсан мэдээллийг ашиглах,

2) Төрийн өмчийн хорооноос батална хугацаарийн дагуу банктай танилцах, дүн шинжилгээ, уулзалт хийх, банкны удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх,

3) Төрийн өмчийн хорооноос бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтантай уулзах,

4) Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар, тодруулга авах зорилгоор банкны хувьчлалыг хариуцсан Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах,

Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ.

Л. Пүрэвдорж

Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IV байр, 410-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Төрийн өмчийн хороо ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариулт өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендерт оролцогч бүрт тэдний өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат захиа, факс, эсвэл электрон шуудангаар ашиглаж болно. Тендерийн санал авах хугацаа дуусахаас ажлын 58 (тав)-аас доош өдерт ирүүлсэн тайлбар, тодруулга авах хүсэлтийг ТӨХ хүлээж авахгүй байж болно.

5) Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан бусад эрх эдлэх.

4.3 Тендерт оролцогчийн үүрэг

Тендерт оролцогч нь дараахь үүргээ гүйцэтгэнэ:

4.3.1 Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх,

4.3.2 Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гаргасан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд нэн даруй мэдээлэх,

4.3.3 Банкны төрд ногдох хувь хөрөнгө худалдан авах талаар тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо болон хэлэлцээрийн аливаа хэлбэрт орохгүй байх,

4.3.4 Банктай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх,

4.3.5 Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах,

4.3.6 Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

ТАВ. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

5.1 Тендерт оролцогч тус бүрт Тендерийн журам, Ерөнхий мэдээлэл, Худалдах, худалдан авах тухай гэрээний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгийг нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2 Төрийн өмчийн хорооноос олгох тендерийн баримт бичигт Төрийн өмчийн хорооны тэмдэг дарсан байна.

5.3 Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулна. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

ЗУРГАА. ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

6.1 Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон банкны удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах боломжоогоор хангана.

6.2 Тендерт оролцогчдыг тендерийн саналаа ирүүлэхээс нь өмнө банк дээр очиж банкны хөренгө, ер төлберийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг Төрийн өмчийн хорооны холбогдох албан тушаалтан болон зөвлөхүүдтэй хэлэлцэх, санал өгөх бололцоогоор хангана. Төрийн өмчийн хороо тендерт оролцогч тус бүрт банк дээр очиж банкны үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зориулж ойролцоогоор 2 /хоёр/ долоо хоногийн хугацаа олгоно. Оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд Төрийн өмчийн хороо өөрийн үзэмжээр нэмэлт хугацаа олгож болно. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид банкны удирдлага, ажилтнуудтай уулзах ерөн боломжоор хангагдах бөгөөд санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнчлэн компьютерийн систем, конторын болон бусад барилга байгууламжийн байдал болон өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлах эрхээр хангагдана.

6.3 Төрийн өмчийн хороо нь банк дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дараалаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4 Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр банкны байдал, үйл ажилгагаат судлан зөвшөөрч, здгээр нөхцөл байдал болон Төрийн өмчийн хороонооос буюу түүний өмнөөс банкны талаар гаргаж өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг боловсруулах үүргээс чөлөөлегдөхгүй. Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, банк, здгээрийн төлөөлегчдөөс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, шинжээчдийн баг, банк, здгээрийн төлөөлегчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5 Тендерт оролцогч дүн шинжилгээ хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

ДОЛОО. ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЭЦЭЛСЭН БОЛОВСРУУЛАХ

7.1 Тендерт оролцогчдоос 2002 оны 10 дугаар сарын 21-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо худалдах, худалдан авх тухай гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2 Төрийн өмчийн хороо худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2002 оны 11 дүгээр сарын 4-ний дотор тараана.

7.3 Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2002 оны 11 дүгээр сарын 11-ний дотор ирүүлэхийг тендерт оролцогчдод санал болгоно. Энэ өдөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4 Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2002 оны 11 дүгээр сарын 25-ны дотор тараана.

НАЙМ. ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭХ, САНАЛ ИРҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

8.1 Бүх менген дүнг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2 Тендерт оролцогчид тендерийн саналыг англи буюу монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлнэ. Харин худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарыг англи, монол хэл дээр ирүүлнэ.

8.3 Тендерт оролцогчид тендерийн саналыг нэг эх хувь болон таван хуулбарыг ирүүлнэ.

8.4 Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтлана.

8.5 Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналд гарын үсэг зурж, хуудас бүрт хар буюу хөх өнгийн бэхээр нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна. Итгэмжлэгдсэн төлөөлегчид олгосон эрхийг бичгээр гаргаж,

тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6 Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах бүюу эсвэл нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна.

8.7 Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороон дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8 Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцох тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дуттуйн дээрх хаягаар юмуу тендерт оролцогчийн Төрийн өмчийн хорооны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9 Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсвэл татан авах эрхтэй.

ЕС. ДЭНЧИН

9.1 Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид Төрийн өмчийн хорооны дор дурдсан валютын харилцах дансанд 100000 /нэг зуун мянган/ америк долларын дэнчин төлөө. Үүнд:

Банкны нэр: Монгол Улсын "Монголбанк"
SWIFT код: BOMUNUB
Дансны нэр: Төрийн өмчийн хороо
Дансны дугаар: 3332404

Харилцагч банк: Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код: FRNYUS33
Дансны нэр: Монголбанк
Дансны дугаар: 021088506

Дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.2 Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3 Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг худалдан авах үнэ оруулан тооцно.

9.4 Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоон/ өдөрт багтаан бүрэн бүцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5 Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1) Ялагч нь санхүүгийн саналтайгаа хамт англи, монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарыг ирүүлээгүй бөгөөс түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан.

2) Ялагч нь худалдах, худалдан авах тухай гэрээний нөхцөлд, болзлын дагуу худалдан авах үнийн төлбөрийг хийгээгүй бүюу худалдах, худалдан авах тухай гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгаа, тохиролцоогоо материаллаг байдлаар зөрчсөн.

9.6 Дэнчинд хүү төлөхгүй.

9.7 Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

АРАВ. ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ

10.1 Банкыг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид дараахь нөхцөлийг хангах шаардлагатай:

10.1.1 Засгийн газраас дэвшүүлэх дор дурдсан зорилгыг хангах бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх. Үүнд:

- ХААН банкны орон нутаг дахь салбаруудын өнөөгийн үйл ажиллагааг хадгалж, орон нутагт банкны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- Банкны хөрөнгийг нэмэгдүүлэх, түүний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн чадавхийг сайжруулах, банкны зохистой практикт нийцсэн зээлийн үйл ажиллагааг орон нутагт өргөжүүлэх,

· Банкны болон санхүүгийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх,

· Монгол Улсын санхүүгийн салбарт урт хугацаат хөрөнгө оруулалт хийх.

10.1.2 Бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны стратегийн хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ирүүлэх.

10.2 Тендерийн санал дараахь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

· Техникийн санал /бизнес төлөвлөгөөний хамт/,

· Санхүүгийн санал.

10.3 Техникийн болон санхүүгийн саналын эх хувь болон хуулбаруудыг "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР", "ТЕХНИКИЙН САНАЛ", "САНХҮҮГИЙН САНАЛ" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дугтуйлна. Эдгээр дугтуйг өөр дугтуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднахь дугтуйн дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"Монгол Улсын Хөдөө аж ахуйн банкны төрд ногдох хувь хөрөнгийг худалдан авах нууц санал-Тендерийн Санал.
ШИНЖЭЭЧДИЙН БАГИЙГ БАЙЛЦУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэглэл хийнэ."

Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны дараахь хаягаар 2002 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ.

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IV байр, 410-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

10.4 Техникийн санал
Техникийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Тендерт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

(1) Тендерт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, арилжааны банкны салбар дахь (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компаниудын) үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга,

(2) Сүүлийн гурван жилийн байдлаар гаргаж аудитаар батлагаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (нэлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан),

(3) Тендерт оролцогчийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн жагсаалт (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компани тус бүрийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг энэхүү жагсаалтад оруулна),

(4) Тендерт оролцогчоос санал болгож буй тендерт холбогдолтой байж болох бусад нэмэлт мэдээлэл.

Б. Бизнесийн стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөө

Бизнесийн стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөөнд банкыг цаашид хөгжүүлэх бизнесийн стратегийг тодорхойлно. Хөөрөөс доошгүй жилийг хамарсан энэхүү төлөвлөгөөнд дор дурдсан арга хэмжээг тусгасан байвал зохино. Үүнд:

(1) Банкны бизнесийн үндсэн чиглэлийг хэвээр хадгалж, цаашид хөрөнгө оруулалт хийх талаар санал болгож буй ерөнхий стратегийн зорилго,

(2) Санал болгож, сонгож буй зах зээлийн хүрээ,

(3) Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны хөгжил,

(4) Төлөвлөж буй санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд /активын өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, г.м./, хоёр жилийн санхүүгийн прогноз /орлого, үр дүнгийн тайлан, үлдэгдлийн тэнцэл, менгөн урсгалын тайлан/,

(5) Банкны мэдээллийн технологи болон дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, өртөг зардлын бүтэц,

(6) Банкны ажилтнуудыг сургах сургалтын хөтөлбөр, удирдлага, зохион байгуулалтын хөгжил, гадаадын удирдлагын бүрэлдэхүүн, тоо, албан тушаал зэргийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө,

(7) Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн зээлийн практикийг хэрэгжүүлэх амлалт.

В. Дэнчин төлснийг нотлох баримт,

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендерт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөж, түүнд тусгасан бүх нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас тендерт оролцохыг зөвшөөрч гаргасан шийдвэр).

10.5 Санхүүгийн санал

Санхүүгийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Хөдөө аж ахуйн банкны төрийн эзэмшлийн 100 хувийг худалдан авах үнэ ба энэ нь 3.280.000 (гурван сая хоёр зуун наян мянган) ам. Доллараас доошгүй байх.

Б. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зохих ёсоор гарын үсэг зурсан худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн англи болон монгол хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь. Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарын гарын үсэг зурсан хоёр эх хувийг санхүүгийн саналын эх хувьд хавсаргасан байх шаардлагатай. Тендерт оролцогоор беглүүлэхээр зориуд хоосон үлдээсэн хэсгийг бөглөхөөс өөрөөр худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт дараахь зүйлийг хавсаргана:

1. Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагын шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр),

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:
Гэрээнд гарын үсэг зурах,
Санхүүгийн саналыг нээх ажиллагаанд Тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийн өргөдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

АРВАН НЭГ. ТЕНДЕРИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ

11.1 Төрийн өмчийн хороо тендерийн саналыг үнэлүүлэх зорилгоор шинжээчдийн багийг томилоно. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- Техникийн саналын үнэлгээ,
- Санхүүгийн саналын үнэлгээ.

11.2 Шинжээчдийн баг нь техникийн саналыг дор дурдсан шалгаруулах үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ. Үүнд:

1) Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн ур чадвар (0-40 оноо),

2) Санал болгож буй бизнесийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар. Засгийн газраас дэвшүүлэх хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо)

Дэд үзүүлэлт:

Бизнесийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо)

Төлөвлөгөө, стратеги нь Засгийн газраас дэвшүүлэх хувьчлалын зорилгод нийцсэн байдал (0-30 оноо)

3) Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн зээлийн практикийг

хэрэгжүүлэх амлалт (0-10 оноо)

4) Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

11.3 Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан техникийн саналыг шалгаруулна.

11.4 Техникийн саналыг үнэлэх үйл ажиллагааг дуусгасны дараа шинжээчдийн баг нь техникийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.5 Техникийн үнэлгээ дууссаны дараа Төрийн өмчийн хороо техникийн санал нь тэнцсэн оролцогчдод техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангасан тухай болон санхүүгийн саналыг нээхээр товлосон газар, цагийг мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ Төрийн өмчийн хороо техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангаагүй оролцогчдод энэ тухай болон дэнчинг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.6 Санхүүгийн саналыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан нийтийн өмнө тендерийн хуваарьт заасны дагуу 2002 оны 12 дугаар сарын 19-ний өдөр задална.

11.7 Техникийн саналын үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

11.8 Тендерт оролцогчийн нэр болон Хөдөө аж ахуйн банкны төрийн мэдлийн 100 хувийг хувилдан авахаар санал болгож буй хувилдан авах үнийг чангаар уншиж, бүртгэнэ. Шинжээчдийн баг санхүүгийн санал болгонд худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг хавсаргаж, зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах ба санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.

11.9 Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

11.10 Хоёр буюу түүнээс олон тендерт оролцогчид ижил үнийн санал ирүүлсэн тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцэж байвал худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч бүсдаасаа илүү өндөр үнийн санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.11 Санхүүгийн саналыг албан ёсоор нээж үнэлсэн өдрөө шинжээчдийн баг нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-ийн төслийг бэлтгэж, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулах зорилгоор нээлттэй хуралдааны ажиллагааг түр завсарлана.

11.12 Шинжээчдийн баг, Төрийн өмчийн хорооны гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурсан тендерийн нэгдсэн мэдэгдэл / тэмдэглэл/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.13 Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл / тэмдэглэл/-д гарын үсэг зурахыг урих бөгөөд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг Төрийн өмчийн хорооны дарга хуудас бүр дээр гарын үсэг зурсан худалдах, худалдан авах тухай гэрээний эх хувьтай олгоно.

АРВАН ХОЁР. ТЕНДЕРИЙГ ЯВГДААГҮЙД БОЛОН ХҮЧИНГҮЙД ТООЦОХ, ӨРГӨДӨЛ, САНАЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦААГ СУНГАХ

12.1 Төрийн өмчийн хороо өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн санаачилгаар эсвэл тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу тендерийн хуваарийг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2 Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилсан мэдэгдэлгүйгээр уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороо бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

Тендерт оролцогчийн гарын үсэг _____

Он, сар, өдөр _____

ХАВСРАЛТ 1

ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Огноо/Эцсийн хугацаа
Тендерийн зар мэдээ	2002 оны 7 дугаар сарын 9
Тендерийн оролцох сонирхлоо илэрхийлэх	2002 оны 7 дугаар сарын 9-2002 оны 9 дүгээр сарын 13
Урьдчилан шалгаруулалт/Тендерийн баримт бичгийг хүргүүлэх	2002 оны 7 дугаар сарын 22-2002 оны 9 дүгээр сарын 27
Банк дээр дүн шинжилгээ хийх/санал, дүгнэлт гаргах хугацаа	2002 оны 9 дүгээр сарын 13
Банктай танилцаж, уулзалт хийх хүсэлтээ ирүүлэх	2002 оны 7 дугаар сарын 22-2002 оны 11 дүгээр сарын 29
ХХАГ-ний төслийн талаар санал авах	2002 оны 10 дугаар сарын 21
ХХАГ-ний шинэчилсэн төслийг боловсруулан гаргах	2002 оны 11 дүгээр сарын 4
ХХАГ-ний шинэчилсэн төслийн талаар санал авах	2002 оын 11 дүгээр сарын 11
ХХАГ-ний эцсийн төслийг бэлтгэн гаргах	2002 оны 11 дүгээр сарын 25
Тендерийн санал ирүүлэх	2002 оны 12 дугаар сарын 10
Техникийн саналыг үнэлэх	2002 оны 12 дугаар сарын 11-2002 оны 12 дугаар сарын 16
Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнэлэх /Тендэрийн үр дүнг нийтэд мэдээлэх	2002 оны 12 дугаар сарын 19
Гэрээнд гарын үсэг зурах	2002 оны 12 дугаар сарын 19

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 143** **Улаанбаатар хот**

Эрдэнэт-Мөрөнгийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам барих тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чаргайтын усан цахилгаан станцыг хүчдэлийн хувьд 110 кв-оор ажиллуулах, Эрдэнэт-Мөрөнгийн 220 кв-ын дэд станцтай холбох, 110 кв-ын 2 хэлхээтэй, 2 х 240 мм2 утастай, 2 х 70 км урттай цахилгаан дамжуулах шугам барих, Эрдэнэт-Мөрөнгийн 220 кв-ын дэд станцын 110 кв-ын хуваарилах төхөөрөмжийг өргөтгөх ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 143 дугаар тогтоолоор батлагдсан Эрдэнэт-Мөрөнгийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам барих хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь үүсвэр хүндрэлтэй байгаа, одоогоор Усан цахилгаан станцын хүчин чадлыг бүрэн ашиглах нөхцөл бүрдээгүй болон хөрөнгө харьцангуй бага шаардагдах зэргийг харгалзан тус Усан цахилгаан станцаас хангахаар төлөвлөж байсан хэрэглэгчдийг Эрдэнэт-Мөрөнгийн 220 кв-ын шугамыг барих замаар цахилгаан эрчим хүчээр хангах арга хэмжээ авахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

2. Эрдэнэт-Мөрөнгийн 220 кв-ын шугамыг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжид тулгуурлан санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 144** **Улаанбаатар хот**

Нөөцөөс хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Дадал сумын нутагт орших Онон, Балжийн байгалийн цогцолборт газрын 3000 гаруй га талбайн нарсан ойд тархсан гоц аюултай халдварт шүтте өвчин болон ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилд зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 33,0 /гучин гурав/ сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд

зевшөөрсүгэй.

2. Ойн өвчин, хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг технологийн дагуу шуурхай зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хэнтий аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 145** **Улаанбаатар хот**

Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

Ардын хувьсгалын 81 жилийн ойг

1. Жаргалсайханы Энхсайхан	Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд;
2. Дашдондовын Баярсайхан	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;
3. Цэрэндашийн Дамдин	Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
4. Ням-Осорын Дагвадорж	Үйлдвэр, худалдааны яамны газрын орлогч дарга;
5. Ойдовданзангийн Энх-Ариунаа	Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын орлогч дарга;
6. Сандагийн Чойнзон	Тагнуулын ерөнхий газрын Цагаатгалын тасагт мөрдөн байцаагч;
7. Галиндэвийн Баттөр	Шуудан, цахилгаан холбооны газрын дарга;
8. Тэгшмэндийн Болдбаатар	Увс аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга;
9. Осорын Шагдарсүрэн	Монгол Улсын Их Сургуулийн багш;
10. Төмөрийн Жагай	Дундговь аймгийн Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн хүүхдийн эмч;
11. Дугарын Тунгалаг	"Бенедакт" компанийн захирал;
12. Норовын Цэрэндулам	"Бөртэ" төрийн өмчит үйлдвэрийн газарт оёдолчин, чанар шалгагч;
13. Баасангийн Ичинхорлоо	Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн протез ортопедийн үйлдвэрийн оёдолчин;
14. Нэргүйн Бат-Эрдэнэ	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын албаны дарга.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 146 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Үндэсний хэмжээнд цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын чадавхийг нэмэгдүүлэх, чанарын удирдлагын (ИСО 9000) болон байгаль орчны удирдлагын (ИСО 14000) шинэ тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Чанарын болон байгаль орчны удирдлага (менежмент)-ыг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавин ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

Засгийн газрын 2002 оны 146 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЧАНАРЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА (МЕНЕЖМЕНТ)-ЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өнөөгийн байдал

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2.4.7)-т "...аж ахуйн нэгжийн удирдлагын чадавхийг сайжруулах хөтөлбөр, теслийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанарыг сайжруулна" гэж заасан билээ.

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлж, сайжруулахын тулд түүнийг шинжлэх ухааны үндэстэй удирдаж сурах хэрэгтэй юм. Удирдлагын ийм арга зүйн үндсийг олон улсын байгууллагуудаас хүлээн зөвшөөрч, стандарт хэлбэрээр гарган, дэлхийн олон оронд хэрэжүүлж, бага зардлаар удирдлагын чадавхиа сайжруулан, өрсөлдөөнд давуу байдал олж, тодорхой үр дүнд хүрч байна. Эдгээр нь хоёр бүлэг стандарт хэлбэрээр гарсан менежментийн шинэ арга хэлбэрүүд бөгөөд тус бүртээ өөр өөрийн зарчим, тогтолцоотой юм. Тэдгээрийн нэг бүлэг нь чанарын удирдлага (менежмент)-ийн тухай ИСО 9000, нөгөө нь байгаль орчны менежментийн тухай ИСО 14000 бүлэг стандарт юм.

Аливаа аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд тэдгээрийн зохион байгуулалт, хэрэгжилтийг уялдаатай, нэгдмэл байдлаар авч үзэх нь олон талын ашигтай. Түүнчлэн эдгээр удирдлагын тогтолцооны тухай стандартад менежментийн өөрчлөн сайжруулах, үйл ажиллагааны шаардлагыг тодорхойлон заасан бөгөөд үйлдвэрлэлийн өөрчлөлт менежментийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх ёстой билээ.

Олон улсын стандартчиллын байгууллага (ОУСБ)-ын 2001 оны мэдээнээс үзвэл чанарын удирдлагын тухай ИСО 9000 стандартыг дэлхийн 150-иад орны 408,6 гаруй мянган аж ахуйн нэгж, байгууллагад, байгаль орчны менежментийг 70-аад орны 22,9 мянган аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлж, гэрчилгээ авсан буюу бүртгүүлсэн дүн гарчээ. Манай улсын хувьд эдгээр стандартыг хэрэгжүүлэх ажил хангалттүйгээс зах зээлд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ хомс байна.

Хэдийгээр бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, өрсөлдөх чадвартай болох, тогтвортой хөгжих нь хувийн хэвшлийнхний идэвхи санаачилга, үйл ажиллагаатай холбоотой ч, менежментийн талаас бүхэлд нь дэмжиж, улс орны эдийн засагт түүний гүйцэтгэх үүрэг, хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал бол Засгийн газрын стратегийн бодлого мөн.

Энэхүү хөтөлбөр нь юуны өмнө аж ахуйн нэгж, байгууллагын чанарын болон байгаль орчны удирдлагыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тогтолцоотой нийцүүлэх, улмаар улс

орны худалдаа, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг дэмжих, экологийн цэвэр үйлдвэрлэл, орчинг хөхиүлэн дэмжих, тогтвортой хөгжлийг хангах, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад стандартчилалын үүргийг дэзэллүүлэх, тохирлын баталгаажуулалт, менежментийг боловсронгуй болгоход чиглэж байна.

Манай улс үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүн, ялангуяа экспортын зориулалттай түүний эд, материал, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаар 1930-аад оны үеэс анхаарч эхэлсэн түүхтэй. Энэ нь хамрах хүрээ, үйл ажиллагааны хувьд явцуу, харилцан уялдаагүй, удирдлага зохион байгуулалт, техникийн бодлого, түвшин харьцангуй доогуур, арга технологийн талаасаа үчир дутагдалтай тогтолцоо байсан. Чанарын удирдлагын талаар ойлгож сайнгүй бөгөөд түүний иж бүрэн хандлагын талаасаа цаг хугацаа, нөхцөл боллоцооны зайшлүүд бэрхшээлтэй цаг үе байжээ. Харин 1972 оноос чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх талаар зарчмын шинжтэй шийдвэр гарч, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн байна. Түүнээс хойш энэ асуудлаар тер, засгийн түвшинд олон шийдвэр гарган хэрэгжүүлж иржээ.

Зах зээлийн эдийн засагт шилжиж, удирдлагын арга барил, эрх зүйн үндсийг шинээр боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсан. Үүнтэй уялдуулан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай", "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай" болон тодорхой салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдсон Монгол Улсын олон хууль батлагдан гарч хэрэгжиж байна.

Улс орны эдийн засагт хувийн хэвшлийнхний гүйцэтгэх үүрэг, эзлэх байр улам давамгайлах болсон өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, түүний удирдлагын арга барилыг улам боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрэлт хүсэлт, таашаалд нийцүүлэхэд чиглэсэн таатай нөхцөл бий болж, зарим байгууллага газарт ахиц дэвшил гарч байна. Соёлтой, дэвшилтэт үйлчилгээний зарим арга хэлбэр өргөжиж байна. Манай улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэж, бизнесийн үйл ажиллагаанд хөнгөлөлтийн давуу эрхийг эдлэх нөхцөл бүрэлдэж байна.

Даяаршлалын үед чанарын болон байгаль орчны удирдлагыг эрчимтэй хөгжүүлж, тодорхой ур дүнд хүрэх нь дэлхийн улс орнуудын үйлдвэрлэл, худалдаа, бусад бизнесийнхний өрсөлдөх чадварыг тодорхойлох, тогтвортой хөгжлийн түлхүүр гол асуудлын нэг болж байна.

Энэхүү олон улсын жиших, манай улсад үйлчилж буй зохих хуулиудын хүрээнд бүтээгдэхүүний чанарыг үнэлэх, тохирлын баталгаажуулалтын талаар арга хэмжээ авч явуулснаар 1995 оноос хойш зөвхөн 28 аж ахуйн нэгж, байгууллагын 170 гаруй бүтээгдэхүүнд үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх эрх олгоод байна.

Чанарын удирдлагын тогтолцооны тухай олон улсын ИСО 9000 бүлэг стандарт батлагдаад 14 жил өнгөрч байгаа бөгөөд манайд түүнийг үндэсний стандарт болгон цөөхөн компанид туршиж, нэвтрүүлсэн юм. Гэвч наашталй дүн зөвхөн "Говь" ХК-д гарсан нь энэ ажлын явц, хөгжил удаашралтай, хамарч бүй цар хүрээ бага байгааг харуулж байна. Өнөөдөр олон улсын худалдаа, хэрэглээ "нэг стандарт, нэг тохирлын үнэлгээ, нэг сориллтын дүн" гэсэн зарчим дээр тулгуурлан явагдаж байна.

Байгаль орчны удирдлагын тухай (ИСО 14000) стандартчиллын ажил эхлэлтийн тедий, денгеж дэд тогтолцоо бүрдүүлэхэд чиглэж байна. Бүтээгдэхүүн, сав, баглаа боодлын боломжтойг нь дахин ашиглах, хог хаягдлыг боловсруулах, бүрэн гүйцэд журамлах талаар менежментийн тогтолцоо бүрдээгүй бөгөөд үндэсний хэмжээнд эко-тэмдэг хэрэглэх журам тогтоогүй байна.

Зах зээлийн харилцааны шинэ нөхцөлтэй холбогдуулан чанарын удирдлага, түүний хөгжлийг бүх талаар дэмжих тухай бодлогын чанартай, эрх зүйн шинэ баримт бичиг гараагүй байна.

Байгаль орчны талаар бие даасан 24 хууль батлагдан гарч үйлчилж байна. Харин байгаль орчны удирдлагын холбогдолтой олон улсын стандарт шинэ тутам батлагдаж байгаа учраас дээрх хуулиуд, стандарт хоорондын харилцан уялдаа, үр дүнтэй хэрэглэх арга хэлбэр нь өнөөгийн тавьж буй шаардлагаас хоцорч байна.

Манай улсад хувийн хэвшлийн шинэ шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ бий болж байгаа нь чанар шалгагч, чанарын менежер, аудитор, үнэлгэчдийг тусгайлан шинээр сургах, давтан мэргэшүүлэх тогтолцоог бүрдүүлэхийг шаардаж байна. Өөрөөр хэлбэл, чанар сайжруулах, чанарын удирдлагыг боловсронгуй болгох мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн боловсон хүчин өнөөгийн удирдлагын аль ч шатанд дутагдалтай байна. Экологийн дээд сургууль байгуулагдаад удаагүй байгаа бөгөөд тэр

нь стандартчилал дахь байгаль орчны менежментийн онол, арга зүйгээс хол хөндий байна.

Сүүлийн үед улс орнууд аюулгүй байдлаа хангах, байгаль орчноо хамгаалахад улам их анхаарч байна. Энэ асуудлыг эввэхэн нэг улс орны үйл хэрэг биш, даяарчлалын хүрээнд хамтын хүчин чармайлтын дүнд шийдвэрлэх бүх нийтийн үйлс, аливаа улс гүрний нийгмийн хэрэгцээ, захиалгат асуудал болон тавигдаж байна. Энэ нь цэвэр орчин, цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэмлэн, аюулгүй, энх амгалан аж төрөх, тогтвортой хөгжихийн үндэс суурь болж байгааг оршино.

Хэдийгээр экологийн хувьд цэвэр, өндөр чанарын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэн чухал болохыг манай ихэнх аж ахуйн нэгж, байгууллагууд хэдийнээ хүлээн эввшөөрсөн ч чанарын болон экологийн бодлого, зорилтуудаа тодорхойлон хэрэгжүүлж чадаагүй, удирдлагын шинэлэг арга барилын талаар ойлголт, мэдээлэл хомс, сургалт дутмаг, үйл ажиллагаанд нь эдгээр асуудлаар туслалцаа дэмжлэг үзүүлэх, ололт амжилтыг үнэлэх, хөхиүлэн урамшуулах арга боловсронгуй бус зэргээс ажил үйлс нь бусад орныхоос хоцорч байна.

1.2. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага

Чанарын болон байгаль орчны удирдлага бол бүх салбарт хамааралтай буюу салбар хоорондын асуудал бөгөөд эдгээр дэвшилт удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбогдуулан өнөөгийн ажлын явцыг зрчимжүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх, үр нөлөөг нь бүх талаар дээшлүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох шаардлага хурцаар тавигдаж байна.

Хөгжингүй орнуудын хүрээнд худалдааны гэрээ хэлцлийн талаар тавьж буй шаардлагын нэг бол тухайн нийлүүлж буй бүтээгдэхүүний чанар ань хэр тогтвортой, аюулгүй эсэхэд нотолгоо баталгаа гаргуулахдаа нийлүүлэгч-үйлдвэрлэгчид чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн үү, үгүй юу гэдэг ерөнхий шалгуураар хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй эсэхийг тодорхойлох үзүүлэлтийн нэг болгож байна.

Цаашдаа гадаад худалдаа, хамтын ажиллагааны явцад иймэ шахалт шаардлага манай үйлдвэрлэгчид, юуны өмнө экспортлогч-бизнесменүүдэд тулгарч болзошгүй учраас өмчийн хэвшил үл харгалзан, эдгээр тогтолцоог бүтээлчээр хэрэгжүүлэх, зохих журмын дагуу үнэлэлт дүгнэлт гаргуулж байх явдал хойшлуулшгүй зорилт болж байна. Энэ талаар манай аж ахуйн нэгж, байгууллагуудаас тедийлэн анхаарахгүй, ниитийг хамарсан хөдөлгөөн өрнүүлэхгүй, эрч хүч муу байгаа нь идэвхи санаачлагагүй, ерөнхий менежмент сул доройгоос гадна чанарын болон байгаль орчны удирдлагын талаар өндөр түвшинд ажиллах чадвартай менежерүүд сургаж бэлтгэдэг тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна.

Түүнчлэн чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн талаарх ажлыг шинэ шатанд гаргах шаардлага гарч байгаа нь үг тогтолцооны хөгжлийн хандлагыг бүхэлд нь сайжруулах, эрчимжүүлэх үйл явцад бодит нөлөөтэй гэж үзэж байна.

Энэ байдалд дүгнэлт хийж, юуны өмнө бүх аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, ажил олгогч эздийн анхаарлын төвд "хэрэглэгчийн таашаалд нийцүүлэх" хийгээд "байгаль орчныг хамгаалах" асуудлыг ямагт байлгаж, ерөнхий удирдлагын хүрээнд өөрдийн санаачлагаараа чанарын болон байгаль орчны удирдлагын дэвшилт арга хэлбэрийг олон улсын стандарттай ижилтгэсэн үндэсний стандартад тулгуурлан хэрэгжүүлэх үндсэн дээр бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, цэвэр орчинг бүрдүүлэх, цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг туушгай хөгжүүлэх замаар эдийн засаг, экспортод дэмжлэг үзүүлэх, хүний эрүүл мэндийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах явдлыг Монгол Улсын Засгийн газраас чанар, байгаль орчны удирдлагын талаархи нэгдмэл бодлого болгон тодорхойлж байна.

Иймд чанарын болон байгаль орчны удирдлагыг төгөлдөржүүлж, үр нөлөөг улам дээшлүүлэх тер, засгийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс "Чанарын болон байгаль орчны удирдлага (менежмент)-ыг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг (цаашид "Хөтөлбөр" гэх) Засгийн газраас батлан гаргаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, ач холбогдол

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь улсын хэмжээнд чанарын болон байгаль орчны удирдлагын талаархи нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын тогтолцоог улам төгөлдөржүүлэхэд оршино.

2.2. Ач холбогдол:

а/дахин давтагдах техникийн асуудлыг

двэрлэх тохиромжтой, эдийн засгийн
олно;

туймэр. дэлбэрэлт тэсрэлт, химийн
т, цахилгаан, бичил биет зэрэг хими,
икийн аюулаас хүний эрүүл мэнд, өмч
гаалах, экологийн цэвэр үйлдвэрлэл,
й холбогдсон техник, технологи
ололцоог бүрдүүлнэ;

илцан орлолт, хамтран ашиглалтыг

алдаанд экологийн цэвэр
ийг эрхэмлэж гэрээлэх, чанарыг
суурь болно;

нарын болон байгаль орчны
тгогцолцоог бэхжүүлэх гол удирдамж

ын ажлын үялдаа холбоог сайжруулах,
энгөвчлөх боломж олгоно.

в. Хөтөлберийн зорилт

хөтөлберийн хүрээнд дараахь
эшүүлж байна:

Чанар болон байгаль орчны удирдлага
т)-ын тогтолцоог боловсронгуй
мэл бодлогын хүрээнд үе шаттайгаар

Байгаль орчин болон хүн, мал, амьтны
д хоргүй технологийг нэвтрүүлэх, цэвэр
пийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн,
й чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн
хангах замаар тэдгээрийн өрсөлдөх
эшлүүлэх;

Чанарын болон байгаль орчны
тогтолцооны үндэс, мэдээллийн сан,
повсронгуй болгож хөгжүүлэх;

Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг
, байгаль орчин болон хүн, мал, амьтны
ндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг
ад техник, технологийн бодлогын
жлэг үзүүлэх, хөгжлийг хурдасгах.

ев. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Чанарын болон байгаль орчны
(менежмент)-ын тогтолцоог үе
хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

а/чанарын (ИСО 9000) болон байгаль орчны (ИСО 14000) менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн орчинг боловсронгуй болгоно;

б/чанарын (ИСО 9000) болон байгаль орчны (ИСО 14000) удирдлагын тухай олон улсын бүлэг стандартыг үндэсний болгох, үүнтэй уялдуулан холбогдох арга зүйн баримт бичиг гаргаж, хэрэгжүүлнэ;

в/экспортын үйлдвэрлэл болон аялал жуулчлал, зочид буудал, банк, санхүү, холбоо, эрүүл мэнд, агаарын болон төмөр зам, олон улсын тээвэр зуучлалын зэрэг үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад ИСО 9000, ИСО 14000 бүлэг стандартын дэвшилт аргыг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ;

г/аж ахуйн нэгж, байгууллагуудын онцлогт тохируулан олон улсын ИСО 9000 стандартын шаардлага болон чанарын удирдлагын тогтолцооны загварыг боловсруулан гаргана;

д/ИСО 9001-ийн чанарын удирдлагын тогтолцоотой хүчсний үйлдвэрлэлийн эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо(НАССР)-г уялдуулан хөгжүүлэх арга зүйн заавар холбогдох олон улсын стандартыг үндэсний стандарт болгон боловсруулж хэрэгжүүлнэ;

е/хүнсний үйлдвэрүүдэд чанарын удирдлагыг эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР)-той хослуулан хэрэгжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлнэ;

ж/аж ахуйн нэгж, байгууллагын чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоо (үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал, НАССР)-г хэрэгжүүлсэн байдлыг үнэлж, баталгаажуулна;

з/технологи дамжуулалт, үйлдвэрлэл, чанарын суурь болон олон улсын стандарт, баримт бичигт үндэсний онцлогт тохируулан хэрэглэнэ;

и/чанарын болон байгаль орчны удирдлагын асуудлаар сургалт явуулах, зөвлөлгөө өгөх хөндлөнгийн байгууллагуудыг бий болгож, хөгжүүлнэ;

к/чанарын удирдлагын тогтолцооны үндэсний баталгаажуулалт, бүртгэлийн тогтолцоог олон улсын жишгийн дагуу үүсгэн бий болгож хөгжүүлнэ.

4.2. Цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

а/цэвэр үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн орчинг бүрдүүлнэ;

б/байгаль орчны эко-тэмдэг, мэдэгдэл, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсынхтай ижилтгэн бий болгож хэрэгжүүлнэ;

в/төрийн үйлчилгээний чанар, шуурхай байдалд тавих өөрчлөлт шаардлагыг тогтоосон цуврал стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ.

г/салбар, орон нутгийн хэмжээнд бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх зорилт тавьж хэрэгжүүлнэ;

д/экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон улс, бүс нутаг, гадаад орны нэр хүндтэй байгууллагаар чанарын (9000) болон байгаль орчны (14000) удирдлагын тогтолцоо, бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хийлгэх боломжийг судалж, хэрэгжүүлж эхэлнэ.

4.3. Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны үндэс, холбогдох мэдээллийн сан, сүлжээг боловсронгуй болгож хөгжүүлэх зорилтын хүрээнд:

а/стандартчилал, тохирлын үнэлгээний тогтолцоог шинэчлэн ОУСБ, ДХБ болон олон улсын бусад байгууллагын зөвлөмжид нийцүүлэх арга хэмжээ авна;

б/аж ахуйн нэгж, байгууллагуудад чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны олон улсын цуврал стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий шагнал бий болгож хэрэгжүүлнэ;

в/баталгаажуулалтын үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, холбогдох мэргэжилтнүүдийг дотоод, гадаадад сургах ажлыг зохион байгуулна;

г/чанарын болон эко-мэдээллийн сан бүрдүүлж, сүлжээ бий болгож ажиллуулна;

д/их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт чанарын болон байгаль орчны удирдлагын талаархи хичээлийг өргөжүүлнэ;

е/чанарын болон байгаль орчны удирдлагын асуудлаар шинэ технологийн төсөл хэрэгжүүлнэ;

ж/жил бүрийн "Дэлхийн чанарын өдөр"-ийг долоо хоног, сарын арга хэмжээ тэй ажлын үр дүнг үнэлж дүгнэн, шагнал ололт, туршлага, тэргүүний арга нийтэд сурталчлан дэлгэрүүлэх, тогтмол хэрэгжүүлдэг болно;

з/чанарын болон байгаль орчны (менежмент), тохирлын үнэлгээний болгоход чиглэсэн техникийн хөтөлбөрийг олон улс, хандивлагч шийдвэрлүүлнэ;

и/орон нутгийн хэмжээнд чанарын талаар амжилт гаргасан аж ахуйн байгууллага, хувуүс, чанар сайтай үйлчилгээг шалгаруулан урамшуулах, туршлагыг нийтийн хүртээл болгох зохион байгуулна.

4.4. Бүтээгдэхүүний өрсөлдөх сайжруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад техник хүрээнд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх зорилтын хүрээнд:

а/бүх нэр төрлийн бүтээгдэхүүний үйлчилгээний стандартчиллын үндсэн зориулалт-хэрэглээний шинж чанар, байдал, цацраг, эрүүл ахуй, чанар бусад холбогдолтой хэм хэмжээ, шаардлага стандартчилахад түлхүү анхаарна;

б/ерөнхий нэр томъёо, тодорхойлолт, ангилал, удирдлага-зохион байгуулалтын зүй, арга зүй, хог хаягдалд хамаарах хоорондын шинжтэй суурь стандартуудыг хөгжүүлнэ;

в/үндэсний нийт стандартын тогтолцоог улсын стандартын эзлэх жүвийн жилийн хүргэж, чанар, техникийн түвшинтэй чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

г/олон улсын болон бүсийн туршлагаар үндэсний хэмжээнд бүтээгдэхүүний баталгаажуулалтын талаар дор дурдсан салбар, чиглэлээр хөтөлбөрийн хүрээ

тогтолцооны удирдлагын зохион байгуулалт, холбогдох лаборатори, арга зүй, дүрэм журмыг бий болгож хэрэгжүүлнэ:

- бүх төрлийн цахилгаан техник хэрэгсэл, техеөремж;
- цахим техник, компьютер, түүний бүрэлдэхүүн хэсэг, холболтын хэрэгсэл болон бусад материал;
- мэдээллийн технологи, харилцаа холбоо, компьютерийн программ хангамж;
- үйлчилгээний салбар (аялал жуулчлал, зочид буудал, тээврийн хэрэгсэл, бөөний худалдаа);
- жонш, гянт болд, зэсийн баяжмал;
- нефть, шатахуун тосолгооны материал;
- төмөрлегийн салбар;
- бордоо, тэсрэх бодис болон химийн салбар;
- мал эмнэлгийн эм, эмийн зүйл;
- байгаль орчны талаархи үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож, эко-тэмдэг хэрэглэх журам нэвтрүүлэх;
- сав, баглаа боодол;
- газар тариалангийн салбар.

д/одоогийн мөрдөж буй чанарын баталгаажуулалтын дараахь дэд тогтолцоог боловсронгуй болгоно:

- хүнсний бүтээгдэхүүн;
- барилгын болон замын материал;
- хүн, малын эм, эмийн зүйл, гоо сайхны болон аппарат хэрэгсэл, протезийн бүтээгдэхүүн.

е/стандартчилал, чанарын болон байгаль орчны удирдлага, тохирлын үнэлгээний чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлж, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2002-2015 оны хугацаанд дараахь 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

а/эхний үе шат: 2002-2006 он;

б/хоердугаар үе шат: 2007-2011 он;

в/гуравдугаар үе шат: 2012-2016 он.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам хамтран зохион байгуулна;

5.3. Хөтөлбөрт тусгасан зорилтуудыг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

5.4. Хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагуудын зээл, тусламж болон бусад эх үүсвэрт тусган зохицуулж байна.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоо нь арга зүй, зохион байгуулалтын хувьд олон улсын жишигт хүрсэн байна;

б/хэрэглэгчийн таашаалд нийцсэн, экологийн хувьд цэвэр үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэнэ;

в/үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч олон улсын стандартыг хэрэглэснээр ерөнхдөх чадвар дээшилнэ;

г/цэвэр үйлдвэрлэлийн зарчмыг нэвтрүүлж экэлснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурна;

д/байгаль орчныг хамгаалах, чанарыг сайжруулах талаар сургалт, сурталчилгаа явуулснаар энэ талаархи олон нийтийн мэдлэг, боловсролын түвшин дээшилж, бүтээлч хамтын ажиллагаа өргөжинэ.

6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

а/чанар, стандартчиллын ажлын цар хүрээ, энэ чиглэлийн итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллага, ажилтны тоо;

б/чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны тухай (ИСО 9000 ба ИСО 14000) бүлэг стандартад заасан тэргүүний арга туршлагыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо;

в/чанар сайтай, цэвэр (тохирлын болон эко-тэмдэг, гэрчилгээтэй зэрэг) бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо;

г/цэвэр үйлдвэрлэлийн зарчмыг нэвтрүүлснээс олох ашиг орлогын хэмжээ, түүний өсөлт.

"ЧАНАРЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА (МЕНЕЖМЕНТ)-ЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ зхний шатны АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт, хийх ажлын үндсэн чиглэл (юу хийх)	Хэрэгжүүлэх арга хэмжээ (тодорхой ямар асуудлыг яаж хийх)	Хариуцах байгууллага (хэн хийх)	Хугацаа (оноор) (хэзээ хийх)	Санхүүжилт, оноор (сая. төг) (ямар зардлаар хийх)					Эх үүсвэр (хаанаас зардал)	Гарах үр дүн
				2002	2003	2004	2005	2006		
1. Чанарын болон байгаль орчны удирдлага (менежмент)-ын тогтолцоог нэгдмэл бодлогын хүрээнд үе шаттай хэрэгжүүлэх 1.1 Чанарын (ИСО 9000) удирдлагыг хөгжүүлэх, боловсрон-гуй болгох бодлого явуулна.	1.1.1. Эрх зүйн орчинг дараахь чиглэлээр боловсронгуй болгоно: 1.1.1.1 Тохирлын үнэлгээний үндэсний тогтолцоог дараахь чиглэлээр өргөжүүлэн олон улсын жишигтэй нийцүүлэх: - чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны баталгаажуулалт; - сорилтын лабораторн; - бүтээгдэхүүн; - үйлчилгээний баталгаажуулалт. 1.1.1.2 Олон улсын жишгийн дагуу баталгаажуулалтын бусад хэлбэрийг боловсронгуй болгон хөгжүүлэх; 1.1.1.3. Чанарыг дэмжих арга механизм бий болгох.	УХЯ, СХҮТ	2002-2003	-	-	-	-	-	-	Итгэмжлэл, чанар, баталгаажуулалтын эрх зүйн орчин олон улсын жишигт нийцнэ
	1.1.2. Чанарын удирдлагын тухай олон улсын (ИСО 9000) бүлэг стандартыг үндэсний стандарт болгох, холбогдох арга зүйн баримт бичиг гаргах, хэрэгжүүлэх: а/ үндэсний хэл дээр орчуулах, найруулан боловсруулах, батлуулах; б/ удирдлагын тогтолцооны шаардлагын болон бусад нэн чухал стандартыг гадаад худалдаа, хамтын ажиллагаанд ашиглахад дөхөмтэй болгон монгол-англи хэлээр гаргах, хэвлэх; в/ хэвлэлийн эх бэлтгэж, хэвлэн гаргах.	УХЯ, СХҮТ, ДБЯ	2002-2006	3,0	3,0	3,0	3,0	3,0	Стандарт-чилал, чанарын баталгаа-жуулалт-ын сан (СЧБСан)	Олон улсын ИСО 9000 шинэ бүлэг стандарт манай улсын хэрэглэгч-дэд тухай бүр бүрэн хүрэх боломжтой болно
	1.1.3. Экспортын үйлдвэрлэл эрхлэдэг болон аялал жуулчлал, зочид буудал, банк, санхүү, холбоо, эрүүл мэнд, тээвэрийн зэрэг үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагад ИСО 9000 тоот стандартын дэвшилт аргыг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх:	УХЯ, ДБЯ, ЭМЯ, ХХААЯ, СХҮТ	2002-2005	-	-	-	-	-	-	ИСО 9000 салбаруудад нэвтэрч эхлэн сайн менежмен-тийн бодит

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 он, №35 (272)

а/ Сонгосон ажлын гүйцэтгэлийн график төлөвлөгөө								
б/ шаардлага арга зүй, зөвлөмж, гарын авлага боловсруулах, туслалцаа үзүүлэх;								
в/ сургалт явуулах, зөвлөлгөө өгөх.								
г/ чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоог олон улсын ИСО 9000, ИСО 14000 стандартын дагуу хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нэгж, байгууллагыг баталгаажуулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тогтолцоо, зэрэг, бүх төрлийн, засгийн бусад хөшүүргээр дэмжих ажуулын судалгаа, шийдвэрлүүлэх;	СЭЗЯ, УХЯ, СХҮТ	2002-2003	-	-	-	-	-	ААН-ийн удирдах чадварыг бага зэрэгдээр дэмжлүүлнэ
д/ жижиг, дунд үйлдвэрүүдэд чанарын удирдлагын тогтолцоог олон улсын ИСО 9000 стандартын дагуу боловсруулах, хэрэгжүүлж, баталгаажуулахад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан болон бусад эх үүсвэрээс хөрөнгийн дэмжлэг үзүүлэх;	УХЯ, СХҮТ, ДБЯ	2002 оноос	30.0	30.0	30.0	30.0	30.0	ЖДҮ-ийн удирдах чадвар дэмжигдэнэ
е/ монгол орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний /экопоинт/ цэвэр бүтээгдэхүүн гэдэг ойлголт талаас нь авч үзэн ИСО 9000,ИСО 14000 стандартаа уялдуулах; түүнийг сургалчлах	УХЯ, ХААҮЯ, БСЯ	2003 оноос						Түхайн бүтээг-дэхүүний өрсөлдөх чадвар дэмжигдэнэ.
1.1.4. Энэхүү төлөвлөгөөний 1.1.3-т дурдсан сайбар чиглэлд хэрэгжих хэлбэр бүхий олон улсын стандартын чанарын удирдлагын тогтолцоонд заавартай олон улсын (ИСО 9000) стандартын шаардлагын хүрээнд боловсруулан гаргах. Үүнд:							СЧБСан болон бусад эх үүсвэр	Экспортын зэрэг тэргүүлэх салбарын ААН-үүдэд зориулсан сайн мэнэжмэнт-ийн болон экологийн стандартуудтай болно
а/ нөөс, нооллуур, арьс шир боловсруулах;	УХЯ	2003	5.0					
б/ аялал, жуулчлалын;	ДБЯ	2003	6.0					
в/ зочид буудлын үйлчилгээ;	ДБЯ	2003	6.0					

г)зоогийн газрын үйлчилгээ:	ДБЯ	2004			5.0				
д/ нисэх болон тээвэр замын тээврийн үйлчилгээ;	ДБЯ	2003		4.0					
е/ банкны үйлчилгээ	СЭЗЯ	2004			7.0				
ж/ эрүүл мэндийн үйлчилгээ	ЭМЯ	2004			8.0				
з/холбооны байгууллагын үйлчилгээ;	ДБЯ	2004			4.0				
и/хүүл үүрхайн салбар.	ҮХЯ	2004			15.0				
к/газар тариалангийн салбар.	ХХААЯ	2004							
1.1.5. Хүнсний үйлдвэрлэлийн эзэмшэл цэвэр хэнагтын тогтолцоо(HACCP)г ИСО 9001-ийн чанарын удирдлагын тогтолцоотой уялдуулан жижүүлэх арга зүйн заавар, холбогдох олон улсын стандартыг үндэсний стандарт болгон боловсруулж хэрэжүүлэх	ҮХЯ, ЭМЯ, ХХААЯ, СХҮТ	2002-2003	3.0	2.0	-	-	СЧБСан болон бусад эх үүсвэр	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах арга зүйн заавар бий болно
1.1.6. Хүнсний үйлдвэрүүдэд чанарын удирдлагын тогтолцоо (ИСО 9000)-г эзэмшэх цэгийн хэнагтын тогтолцоо (HACCP), үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP), эрүүл ахуйн зохистой дадал (GHP)-тай хослуулан хэрэжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх	СХҮТ, ЭМЯ, ХХААЯ, Төрийн бус байгууллагууд	2002 оноос	-	-	-	-	-	ААН-ийн зардал	Хүнсний үйлдвэрүүдэд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал дээшлэнэ
1.1.7. Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд чанарын удирдлагын тогтолцоог хэрэжүүлсэн байдлыг үнэлэх, батлагажуулах:	СХҮТ, ҮХЯ	2002-2004	3.0	3.0	3.0	-	СЧБСан болон бусад эх үүсвэр	ААН-ийн чанарын удирдлагын тогтолцоонд олон улсын жишиг дагуу батлагажуулалт явуулах нөхцөл бүрдэнэ
1.1.7.1 ОУСБ-ын шаардлагатай арга зүйн удирдамжуудад үндэсэлсэн гарын авлага, жүрэм болон холбогдох бусад бичиг баримт ин бүрэлдэн ньболовсруулан гаргана:									
- чанарын удирдлагын тогтолцоог хэрэжүүлэх, батлагажуулах тухай гарын авлага									
- тэрүүчний туршлагын тухай видео-кино;									
- "ИСО 9000", "Үндэсний тохиолын тэмдэг" зэрэг сурагчийлэнэ плакат, календарь									
ИСО 9000-ын тухай суралцуулах									

	1.1.7.2 Олон [illegible] зөвлөмж, туршлагыг [illegible] чанарын удирдлагын тогтолцооны талаар аудитор, үнэлгээний мэргэжилтний [illegible] нэвтрүүлж, хэрэгжүүлнэ: - Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны чиглэлээр зөвлөлгөө өгөх, сургалт явуулах мэргэшсэн алба, байгууллагуудыг тендер зарлаж шалгаруулах, итгэмжилж, бүртгэх ажлыг зохион байгуулах;									
	- Уг албаны сургалтын хөтөлбөр, бусад бүх нөхцөлийг хангасны үндсэн дээр холбогдох хуулийн дагуу түүнд эрх олгож ажиллуулах; - Уг албаны төгсөгчдийг тогтоосон журмын дагуу итгэмжилж, тэдгээрт гэрчилгээ олгох; - Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбогдуулан аудитор, үнэлгээний мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэх талаар журам тогтоож, мөрдүүлэх.									
	1.1.7.3 Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалт/бүртгэлийн журам гаргаж мөрдүүлнэ. 1.1.7.4 Чанарын удирдлагын тогтолцооны асуудлаар хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна 1.1.7.5 Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалт явуулж, бүртгэн, мэдээлнэ.									
	1.1.7.6. Олон улсын стандартчиллын байгууллагын "Чанарын менежмент"–ийн асуудал хариуцсан 176 дугаар техникийн хороо, түүний дэд хороод, ажлын хэсгүүдийн хуралдаан, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцоно.	ҮХЯ, СХҮТ	2002-2006	-	-	-	-	*	-	-

1.1.7.7 Ази Номхон Далайн орнуудын чанарын байгууллага (APQO), зэрэг бус байгууллагын үүп эжилгаанд идэвхитэй оролцоно	УХЯ СХҮТ	2002-2006	-	-	-	-	-	-	-
1.1.8 Технологи дамжуулалт, үйлдвэрлэл чанарын сууль болох олон улсын стандарт баримт бичгийг үндэсний болгон орчуулж хэрэглэх. а/ Чанарын холбогдолтой статистик арга үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд, орчин үеийн технологийг үдирдагад хэрэглэхэд чиглэсэн чанарын талаарх статистикийн сууль ойлголт, нэр томьёо, тайлбар толь б/ Сонгомол тоо зэрэг технологи, хэмжилтийн сууль стандарт	СХҮТ, УХЯ	2002-2006	3.0	3.0	3.0	3.0	3.0	СЧБСан	Дурдсан асуудлаар олон улсын сууль баримт бичиг хэрэглэх боломжтой болно
1.1.9 Дараахь арга хэлбэрийг ашигласан чанарын болон байгаль орчны удирдлагын асуудлаар тогтоосон журмын дагуу сургалт явуулах, зөвлөлгөө өгөх сайн дурын байгууллагуудыг бий болгож, хөгжүүлнэ. а/ Төрийн бус болон холбогдох байгууллагуудтай тогтоосон журмын дагуу хамтран ажиллах. б/ Гадаад орны болон олон улс, бус нутгийн байгууллагууд дээрх чиг үүргээр хэрэв хамтрах хүсэлтэй бол тухай бүр тохиролцож байх.	СХҮТ, УХЯ	2002-2004	-	-	-	-	-	-	Эко чигээлийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна

	1.1.10 Нарийн даарсан [illegible] баталгаажуулалт, бүртгэлийн үнэлэгч тогтолцоог олон улсын жишгийн дагуу үүсгэн бий болгон, хөгжүүлнэ: а/ баталгаажуулалт, бүртгэлийн байгууллагад тавих олон улсын шаардлагыг тогтоож хэрэгжүүлэх б/ баталгаажуулалтын байгууллагуудыг итгэмжлэх; в/ холбогдох мэргэжилтний мэргэшлийг гадаадад дээшлүүлэх, аудиторын үнэмлэх олгуулах; г/ баталгаажуулалтын байгууллагуудын олон улс, бүс нутгийн сүлжээнд нэгдэн орох.	СХҮЯ УХЯ	2002-2010	-	-	-	-	-	Стандарт, тодорхойлолтын тусламж	Үндэсний баталгаажуулалтын үр дүн, ИСО 9000-ын гэрчилгээг гадаад орон, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх боломж нэмэгдэнэ
1.2 Байгаль орчны удирдлага (менежмент)-ыг бий болгож, олон улсынхтай ижилтгэн хөгжүүлнэ	1.2.1 Эрх зүйн орчинг дараахь гол чиглэлээр боловсронгуй болгож хөгжүүлнэ: 1.2.1.1 Баталгаажуулалтын тогтолцоог олон улсын жишигтэй нийцүүлэх арга хэмжээ авах: а/ ИСО 14000 тогтолцооны баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх; б/ эко-тэмдгийн баталгаажуулалт явуулах асуудлыг шийдвэрлүүлэх; в/ эко-үнэлгээний аж ахуйн нэгж, байгууллагыг тогтоосон журмын дагуу үнэлэх эрх олгох арга хэмжээг зохион байгуулах.	БОЯ, СХҮТ	2002-2005	-	-	-	-	-	-	Энэ үйл ажиллагааны эрх зүйн орчин сайжирч, олон улсын жишигт нийцсэн тогтолцоо бүрдэнэ

	1.2.1.2 Байгаль орчны удирдлагын тухай олон улсын бүлэг (ИСО 14000) стандартыг үндэсний стандарт болгож хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ: а/ боловсруулах, батлуулах; б/ стандарт бүрийг зориулалтаар нь хэвлэж нийтийн хүртээл болгоно; в/ баталгаажуулалтын үр дүнд эко-тэмдэг хэрэглэх эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох6	БОЯ, СХҮТ	2002-2006	3,0	3,0	3,0	3,0	3,0	СЧБСан, бусад эх үүсвэр	Олон улсын ИСО 14000 шинэ бүлэг стандарт манай улсын хэрэглэгч-дэд тухай бүр бүрэн хүрэх боломжтой болно
	1.2.1.3 Байгаль орчны удирдлагын тухай стандартуудыг нийт хэрэглэгчдэд зориулан хэвлэх, сурталчилгааны бүтээгдэхүүн, материал бэлтгэж гаргах. Үүнд: а/ стандартын эмхэтгэл (цуврал дэвтэр) байдлаар хэвлэн гаргана; б/ эко-тэмдгийн талаар хураангуйлсан гарын авлага, зөвлөмж гаргана; в/ эко-тэмдгийн талаар плакатын эх бэлтгэх, хэвлэх; г/ "эко" уриатай сав, баглаа боодол, түүний материал үйлдвэрлэн гаргах;	БОЯ, СХҮТ	2003-2004	-	2,1	2,1	-	*	БОХСан	БОҮТ-ны талаар олон нийтийн мэдлэг дээшлэж, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.
	д/ "ногоон –бүтээгдэхүүн" гэсэн ойлголтын талаар хэрэглэгчид, сонирхогчдод өргөн таниулга, сурталчилгаа явуулж, тийм үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дэмжих.									

	1.2.1.4. Гадаад орчны болон олон улсын арга зүйн зөвлөмж, тушлагыг үндэслэн тохирлын үнэлгээний хэлбэрүүдийг шинээр бий болгож хэрэгжүүлэх: а/үндэсний "эко-тэмдэг" зохиож, түүнд улсын стандарт боловсруулах, батлуулж хэрэглэх; б/эко-ангилалд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгуур боловсруулах, тогтоосон журмын дагуу батлаж мөрдүүлэх; в/ эко-тэмдэг, мэдэгдэл хэрэглэх талаар журам тогтоож, хэрэгжүүлэх;	БОЯ, СХҮТ	2003-2006	-	2	2	2	2	БОХСан	Хэрэглэгчид байгаль хамгаалах талаар зохих мэдлэгтэй болно.
	г/ИСО 14000 тогтолцооны тохирлын батлагаажуулалтыг/үйлдлийн журам тогтоож, хэрэгжүүлэх;	СХҮТ	2003-2006							
	1.2.2. Аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн байдлыг үнэлж, батлагаажуулахын тулд дараахь ажлыг хэрэгжүүлэх: а/байгаль орчны холбогдолтой стандартчилсан суурь нэр томъёо – Тайлбар толь гаргах;	БОЯ, СХҮТ	2003-2005		3.0	3.0	3.0		3 дахь жилээс эхлэн жил бүр	Байгаль орчны удирдлагын тогтолцоонд олон улсын жишгийн дагуу батлагаажуулалт явуулах нөхцөл бүрдэнэ
	б/байгаль орчны удирдлагын тогтолцоо, шаардлага болон аудитын аргачлалд хамаарах олон улсын суурь стандартыг үндэсний болгон батлуулж хэрэглэх.									

	1.2.3 Байгаль орчны удирдлагын тогтолцооны хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах: а/тохирлын гэрчилгээний загвар зохиох, хэвлэх ажлыг гүйцэтгэх; б/эко-тэмдгийн загвар зохиох талаар уралдаан зарлах, шалгаруулан дүнг гаргах; в/эко-тэмдэг хэрэглэх тухай дүрэм журам гаргаж мөрдүүлэх.	БОЯ, СХҮТ	2002-2004	-	-	-	-	*	-	-
	1.2.4 Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбогдуулан аудитор, үнэлгээний мэргэжилтний сургах, мэргэжил дээшлүүлэх талаар журам тогтоож мөрдүүлэх.	БОЯ, СХҮТ	2002-2004	-	-	-	-	*	-	-
	1.2.5.Олон улсын стандартчиллын байгууллагын "Байгаль орчны удирдлага"-ын асуудал хариуцсан 207 дугаар техникийн хороо, түүний дэд хороод, ажлын хэсгүүдийн хуралдаан, үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцох.	БОЯ, СХҮТ	2002-2006	-	-	-	-	*	-	-
	1.2.6. Бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ази, Номхон Далайн орнуудын мэдээллийн сүлжээнд холбогдох.	БОЯ, СХҮТ	2002-2006	-	-	-	-	*	-	-
2. Цэвэр үйлдвэрлэл-лийг хөгжүүлэх,	2.1. Цэвэр үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн орчинг бүрдүүлэх	БОЯ, ҮХЯ	2002-2003	-	-	-	-	-	-	-

бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, аюулгүй байдал зэрүүл ахуйн шаардлагыг хангах замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	2.2. Цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах 2.2.1. Шинээр орох гэж буй үйлдвэрлэл, үйлчилгээний объектод халгүй технологи нэвтрүүлэх, эзэмшихэд нь илүү анхаарч, тогтоосон журмын дагуу үнэлгээ, дүгнэлтийг тогтмол гаргадаг болох 2.2.2. Цэвэр үйлдвэрлэлийг бүх талаар дэмжихтэй холбогдуулан байгаль орчны удирдлагын стандартчиллын хороог өргөтгөн зохион байгуулж, түүний чиг үүрэгт мэдээлэл, арга зүй болон бусад хэлбэрийн зөвлөмж үзүүлэх асуудлыг тусгаж хэрэгжүүлэх; 2.2.3. Хаягдлыг эрс бууруулсан аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн болон эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, бусад оновчтой арга механизмыг боловсруулж хэрэгжүүлэх;	БОЯ, ҮХЯ, ХХААЯ, ДБЯ, ЭМЯ, СХҮТ	2002-2005	-	-	-	-	-	-	-	-
	2.2.4. Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр болон сургалтын дамжаанд цэвэр үйлдвэрлэлийн талаархи хичээл (кредит цаг) оруулах; 2.2.5. Үг асуудлыг тогтоосон журмын дагуу Олон улсын байгууллагуудын төсөөр дэмжих ажлыг зохион байгуулах.										
	2.3. Салбар, орон нутгийн хэмжээнд бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын болон эко-тэмдэг хэрэглэх зорилт тавьж, хэрэгжүүлэх	Салбарын яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2001 оноос	-	-	-	-	-	-	-	-
	2.4. Экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон улс, бүс нутаг, гадаад орны нэр хүндтэй байгууллагаар ИСО 9000, ИСО 14000 тогтолцооны баталгаажуулалт хийлгэх боломжийг судалж, хэрэгжүүлнэ:	ҮХЯ, ДБЯ, ЭМЯ, ХХААЯ, БОЯ, СХҮТ	2002-2004	-	-	-	-	-	-	-	-
	а/ судалгаа явуулж, сонголт хийх; б/ боломжтой байгууллагуудтай гэрээ хэлцэл байгуулж, шаардлагатай бол тэдгээрийн төлөөлөгчөөр мэргэшсэн хүмүүсийг ажиллуулах; в/ шаардлагатай бусад арга хэмжээ.										

3 Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны үндэс: холбогдох мэдээллийн сан, сүлжээг боловсронгуй болгох хөжүүлэх	3.1 Стандартчилал, тохирлын үнэлгээний бүтэц, үйл ажиллагаг ОУСБ, Дэлхийн худалдаань байгуулага (ДХБ) болон олон улсын бусад байгууллагын зөвлөмжид нийцүүлэх арга хэмжээ авна. 3.1.1 ОУСБ-ын холбогдох арга зүйн удирдамжийг үнэлэн болгоно. Үүнд: -тохирлын үнэлгээ. Ерөнхий тайлбар толь. -тохирлын үнэлгээнд зориулан ашилхахаар тохирлын үнэлгээний практик ажилгааны дүрэм; -тохирлын үнэлгээний байгууллагын пер үнэлгээнд тавих ерөнхий шаардлага. -тохирлын марк (тэмдэг), тэдгээрийг ашилах. -нийлүүлэгчийн үүсгэл тохирлын мэдэгдлийн загвар бэлтгэх бичиг болон тохирлын ажилгааны байгууллагад тавих ерөнхий шаардлага. -сорилтын үүсгэл болон шинжилгээний лабораторийнд тавих ерөнхий шаардлага. - бүтээгдэхүүний батлагаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох зөвлөмж. -чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцооны батлагаажуулалтыг боловсронгуй болгох, үнэлгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага. -батлагаажуулалтын ажилтнудыг аттестатчилах, тэдгээрт тавих ерөнхий шаардлага. -бусад.	УҮЯ, СХҮТ, БОЯ	2002-2004	2.0	10.0	61.2	43.0			Дурдсан чиглэлийн үйл ажиллагааны хамгаалах сан	Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилгааг байгуулалт, авга зүй олон улсын жишиг хурч сайжирна.
	3.1.2 Холбогдох хуулийн хүрээнд итгэмжлэлийн үндэсн дүрэм, дагалдах бусад бичиг баримт бичгийг гаргаж мөрдүүлнэ	УҮЯ, СХҮТ	2002-2003								
	3.2 Аж ахуйн нэгж байгууллагуудад чанар, байгаль орчны удирдлагын тогтолцооны олон улсын ИСО 9000, ИСО 14000 цуврал стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий үндэсний шагнал бий болгох, хэрэгжүүлэх.	УҮЯ, БОЯ, СХҮТ	2002 оноос жил бүр								

	а/ шагналын дэлгэрэнгүй [illegible] зарлан мэдээлэх, эрсдэлийн төлбөрийн хэмжээ зэрэг Ажлын аппаратаас боловсруулж, батлах, нийтлэх; б/ шагналын загвар гаргаж шийдвэрлэх, хийлгэх, нийтлэх.		2002 2002	- 1,7	1,1	1,1	1,1	1,1	Төвлөрсөн төсөв	ахуйн хэрэг, байгууллагын тоо бөөмөс, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэнэ.
	3.3. Тохирлын үнэлгээний байгууллагуудын үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, гадаад хамтын ажиллагаагаг хөгжүүлэх, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг дотоод, гадаадад мэргэшүүлэх	ЗГХЭГ, ГХЯ, УХЯ, БОЯ, СХҮТ	2002-2004	-	-	-	-	-	Гадны тусламж	Мэргэшсэн хүмүүсийн хүрэлцээ дээшилнэ
	3.4. Чанарын болон эко-мэдээллийн сан бүрдүүлж, сулжээ бий болгох: а/сулжээний бодлого, чиглэл, арга зүй, зураг төслийг боловсруулах; б/үндэсний мэдээллийн сүлжээнд шаардагдах ажилтнууд бэлтгэх,техник хэрэгслээр хангах; в/үндэсний мэдээллийн төвд нэн тэргүүнд шаардагдах хэвлэл, мэдээлэл авч сан бүрдүүлэх; г/дээрх хэвлэл, мэдээллээс зарим үндсэн хэсгийг орчуулах, монгол, англи хэл дээр хэвлэх;	УХЯ, БОЯ, СХҮТ	2002-2004	20,0	20,0	20,0	-	-	СЧБСан, БОХСан	Энэ талын олон улсын болон үндэсний мэдээллийн хэрэгцээг хангаж эхэлнэ
	д/үндэсний мэдээллийн сүлжээ байгуулах, олон улс, бүс нутгийн ижил төсөөтэй сулжээтэй түүнийг нийцүүлэх арга хэмжээ авах; е/чанарын болон байгаль орчны мэдээллийн олон улс, бүс нутгийн сулжээнд холбогдох.									
4. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, байгаль	4.1. Салбар, орон нутгийнхаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх талаар хөдөлгөөн орнуулж, бодитой, үе шаттай зорилт тавин хэрэгжүүлэх	Холбогдох яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар	2002 оноос	-	-	-	-	-	-	Чанар, аюулгүй

орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад техникийн бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх, хөгжлийг хурдасгах	4.2. Бүх нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартчиллын үйл ажилллагаат зориулалт, хэрэглээний шинж чанар, ажлүлгүй байдал, цацраг эрүүл ахуй, хоруу чанар, экологийн болон мэдээллийн технологийн холбогдолтой хэм хэмжээ, шаардлагыг тогтоож стандартчилахад түлхүү анхаарах	Нийт үйлдвэр-пэл, үйлчилгээ эрхлэгчид буюу ажил олгогчээд	2002-2005							байдлыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэлт өсөнө.
	4.3. Ерөнхий нэр томъёо, тайлбар толь, ангилал, удирдлага-зохион байгуулалт, хэмжил зүй, арга зүй, хог хаягдалд хамаарах салбар хоорондын шинжтэй суурь стандартчиллын ажлыг хөгжүүлэх	СХҮТ, холбогдох байгууллагууд	2002-2006	3,0	3,0	3,0	3,0	3,0	СЧБСан	Хэрэглэгчдэд нэгдмэл ойлголт өгнө.
	4.4. Үндэсний нийт стандартын дотор олон улсын стандартын эзлэх хувийн жинг 40 хувьд хүргэж, чанар, техникийн түвшингээр өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	ҮХЯ, СХҮТ, холбогдох яам, агент-лагууд	2002-2006 ба цаашид үргэлж-лэх	10,0	10,0	10,0	10,0	10,0	СЧБСан, холбогдох байгууллагуудын хөрөнгө	Стандартын түвшин дээшилж өрсөлдөх чадвар сайжирна.
	4.5. Дор дурдсан чиглэлээр дэд тогтолцоог бий болгох шаардлагатай арга зүйн удирдамж, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэх. Үүнд: - бүх төрлийн цахилгаан техник хэрэгсэл, төхөөрөмж, цахим техник, компьютер, түүний бүрэлдэхүүн хэсэг, холболтын хэрэгсэл болон бусад материал;	ҮХЯ, СХҮТ	2002-2004 2003	-	-	-	-	*	Гадны тусламж, ШҮТ-ийн сан	Чанар, өрсөлдөх чадвар сайжирна.
	- мэдээллийн технологи, харилцаа холбоо, компьютерийн программ хангамж; - үйлчилгээний салбар (аялал жуулчлал, зочид буудал); - нүүрсний салбар;	ЗГХЭГ, ДБЯ, СХҮТ ДБЯ, СХҮТ ДБЯ, СХҮТ	2003 2003 2003							

.....	.....	.....	2003						
.....	.....	УХЯ, БОЯ, СХҮТ							
- бордоо, тэсрэх бодис болон химийн салбар (химийн технологи орно);		УХЯ, БОЯ, СХҮТ	2003						
- мэл эмнэлгийн эм, эмийн үйл. аппарат хэрэгсэл.		УХЯ, СХҮТ, ХХААЯ	2003						
4.6. Одоогийн мөрдөж буй бүтээгдэхүүний батлагаажуулалтын дараалыг дэд тогтолцоог боловсронгуй болгох:		УХЯ,ДЕЯ, ЭМЯ, ХХААЯ, СХҮТ	2002-2004	-	-	*	-	-	-
- хүнсний бүтээгдэхүүн;									
- бариltын болон эмын материал;									
- хүн эмнэлгийн эм, эмийн үйл. гоо сайхны болон аппарат хэрэгсэл, протезийн бүтээгдэхүүн.									
4.7. Стандартчилал, чанарын болон байгаль орчны удирдлага, тохиролын үнэлгээний холбогдолтой судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах, бүтээц зохион байгуулалтын өөрчлөлт хийх талаар холбогдох арга хэмжээ авах		БОЯ, СХҮТ	2003-2004	-	-	-	-	-	-

ТАЙЛБАР: 2006 оны Еагаад * тэмдэг тавьсан арга хэмжээний зардал, тэдгээрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх арга хэлбэрийг тухай бүр тодотгон боловсруулж шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 9 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (273)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Украйн Улсын зарит иргэнийг шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөр батлах тухай*
- *Хөрөнгө шилжүүлэх тухай*
- *Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ:

- *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны есдүгээр сарын 28 №36 (273)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

490. Украйн Улсын зарим иргэнийг шагнах тухай Дугаар 128 1148

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

491. Хөтөлбөр батлах тухай Дугаар 137 1148

492. Хөрөнгө шилжүүлэх тухай Дугаар 147 1155

493. Ул хөдлөх хөрөнгө худалдах тухай Дугаар 148 1155

494. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 149 1155

495. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 150 1158

496. Хэлэлцээр батлах тухай Дугаар 151 1159

497. Зарим элчин сайдын яаманд консулын хэлтэс байгуулах тухай Дугаар 152 1159

498. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 153 1159

499. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 155 1159

500. Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний зөвлөл батлах тухай Дугаар 156 1163

501. Нөөцөөс хөрөнгө гаргах тухай Дугаар 157 1169

502. Улсын Ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Дугаар 158 1170

503. Археологийн хүрээлэн байгуулах тухай Дугаар 159 1170

504. Хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоох тухай Дугаар 160 1171

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

505. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Дугаар 263 1172

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Дугаар 128 **Улаанбаатар хот**

Украин Улсын зарим иргэнийг шагнах тухай

Монгол, Украины хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсад мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж ирсэн хувь нэмрийг нь үнэлж Украин улсын Одесса хотын Хүнсний технологийн академийн захирал Николай Дмитриевич Захаровыг "Алтан гадас" одонгоор, академийн орлогч захирал Георгий Витальевич Ангелов, профессор Евгений Георгиевич Кротов нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 137 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг 1 дүгээр, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөтөлбөрийн зөвлөлийн дарга Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц. Мөнх-Оргилд даалгасугай.

3. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг эрхэлсэн асуудлынхаа хүрээнд зохион байгуулан ажиллахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон нутгийн салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц. НЯМДОРЖ

Засгийн газрын 2002 оны 137 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

Засгийн газрын 1997 оны 122 дугаар тогтоолоор 1997-2001 онд хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөө батлан ажилласнаар хулгайн гэмт хэргийн өсөлтийг бууруулж, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, хохирол нөхөн төлөлт жил бүр нэмэгдэж байна. Гэвч хулгайн гэмт хэргийн гаралт туушгай буурахгүй нийт гэмт хэргийн 50 орчим хувийг эзэлж байна.

Төв, суурин газарт орон байрны, хөдөө орон нутагт малын хулгайн гэмт хэрэг зонхилон гарч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулах хохирлын хэмжээ өсөж, тэдний амгалан тайван амьдарч, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулсаар байна. Хулгайн эд зүйл гар дамжин худалдагдах сүлжээ бий болж, хулгайч, борлуулагч нар зохион байгуулалтад орсон нь энэ төрлийн гэмт хэргийг шалгах, илрүүлэх ажилд ихээхэн түвэг учруулж байна.

Иймд хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх ажлыг төр, засгийн анхаарлын төвд байлган, тодорхой бодлого чиглэлтэй хэрэгжүүлэх явдал нэн чухлаар тавигдаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

2.1. Энэхүү хөтөлбөр нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөх эрхийг хамгаалан,

амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн улсын хэмжээнд хулгайн гэмт хэргийг сааруулах, ийнт гэмт хэргийн дотор энэ төрлийн гэмт хэргийн эзлэх хувийг бууруулж, илрүүлэлтийг дээшлүүлэх.

2.2. Иргэд, аж ахуйн нэгж,байгууллагуудад өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах сэтгэлгээ төлөвшүүлэхийн зэрэгцүүэ хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг жигд татан оролцуулах, тэдний санал санаачилгыг дэмжих.

2.3. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, хохирол нөхөн төлүүлэх ажлыг сайжруулах, хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй цагдаагийн байгууллагын алба, нэгжүүдийн уналга, холбоо болон ажиллах бусад нөхцөлийг дээшлүүлэх.

2.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эохиогдож байгаа хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан хөтөлбөрийн Зөвлөл удирдан зохион байгуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална.

3.2. Нийслэл, аймаг, сум, дүүрэгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж ажиллана.

3.3. Хөтөлбөрийн зөвлөл, аймаг, нийслэлийн ажлын хэсэг нь доод шатныхаа ажлын хэсгийг удирдан, хяналт шалгалт хийж, дутагдлыг арилган, хариуцлага тооцож, дүнг мэдээлж ажиллана.

3.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар жил бүр батлуулан мөрдөж ажиллана.

3.5. Аймаг, нийслэлийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохиосон ажлын мэдээ, тайланг сум, дүүргээс улирал тутам нэгтгэн авч Хөтөлбөрийн зөвлөлд мрүүлж байна.

3.6. Хөтөлбөрийн зөвлөлийн ажиллах журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батална.Зөвлөл нь хөтөлбөр хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын мэдээг аймаг, нийслэлийн ажлын хэсгээс авч нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газарт хагас жил тутам танилцуулна.

3.7. Хөтөлбөрийн зөвлөлийн мэдээ, тайлан гаргах, хяналт шалгалт хийх, хулгайн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлын арга замыг судлан, мэдээлэл, аргачлал, зөвлөмж боловсруулан, бодлого тодорхойлж байх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх алба хэрэгжүүлнэ.

3.8. Зөвлөл нь хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийн дагуу жил бүр төлөвлөгөө гарган Зөвлөлийн хурлаар батлуулж ажиллана. Зөвлөлийн үлирлын ажлын төлөвлөгөөг зөвлөлийн дарга батална.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

4.1. Зөвлөлийн ажилд шаардагдах хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусгана.

4.2. Аймаг,нийслэл, сум, дүүрэг нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгахын зэрэгцүээ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн зохих хувийг энэ ажилд зарцуулна.

4.3. Хөтөлбөрийн зөвлөл, бүх шатны ажлын хэсэг нь хандив тусламж болон бусад нөөц бололцоо, эх үүсвэрийг ашиглан сан байгуулж хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд зарцуулж болно.

4.4. Энэ хөтөлбөрийг 2002-2005 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1.Урьдчилан сэргийлэх ажлын талаар

5.1.1. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах арга хэлбэрийг боловсронгуй болгохын зэрэгцээ тэдний үүсгэл санаачилгыг дэмжин ажиллах талаар бүх шатны Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг чиглүүлэх.

5.1.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдөө өмч хөрөнгөө хамгаалах, урьдчилан

сэргийлэх сэтгэлгээг хөгжүүлэх, хулгайн гэмт хэрэг үйлдэгсдийг олон нийтэд жигшүүлэх чиглэлээр радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчилгааны ажлыг дэс дараатай хийх.

5.1.3. Орц, байрны жижүүр, гэр хороололд гудамжны эргүүл ажиллах жүрмыг сууц өмчлөгчдийн холбоо, орон сууцны байгууллага, дүүрэг, хороо, сум, баг хамтран боловсруулж, үр дүнийг нийтийн эргүүлд татан оролцуулах арга хэлбэрийг боловсронгуй болгох.

5.1.4. Төвлөрсөн зах, шаардлагатай зарим гудамж талбайг телекамерийн хяналтад авах бүрэлдэхүүн хот, дүүргийн холбогдох байгууллагуудтай хамтран судалж хэрэгжүүлэх.

5.1.5. Үнэт зүйл хадгалдаг үйлчилгээ, дэлгүүлэг, хамгаалалт, найдвартай хаалга, цонхны бэхэлгээний ач холбогдлыг нийтэд сурталчлах.

5.1.6. Төв, суурин газарт хөршийн холбоо, хөдөлгөөн мал сүрэг хамгаалах нөхөрлөл зэрэг олон нийтийн үүсгэл санаачилгыг үр ашигтай зохион байгуулах ажлыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага хамтран зохион байгуулж байх.

5.1.7. Шинээр баригдах орон сууцны барилга байгууламжийн зураг төсөлд цахилгаан тооллуурыг хулгайд алдахгүй болгон байрлуулах, дохиоллын систем, жижүрээс айл бүртэй харьцах холбооны хэрэгсэл, теле хяналтын систем байрлуулах зэрэг асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.

5.1.8. Байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээл хамгаалалтын хариуцлага, сонор өрнөжийг дээшлүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.

5.1.9. Орон нутгаас мал, мах, түүхий эдийг үхэж мал эмнэлгээс олгосон ариун цэврийн гэртификат, бар, сумын Засаг даргын зөвшөөрөлтэй үндэслэн төв, суурин газарт очуулж байх журмыг холбогдох яам, агентлаг, шийдүүлагатай хамтран боловсруулан зэрэгжүүлэх.

5.1.10. Аймаг, сумын төв, бусад суурин газарт амьдардаг мал бүхий иргэдийн малыг хаанын хариулга маллагаатай болгох ажлыг бат, өрөнө Засаг дарга нар зохион байгуулах.

5.1.11. Аймаг, сум бүр индекс бүхий эмэг, малгайтай болж, адууг тамгалан бусад бод малыг ялгатай болгох, бат, сум бүр өөрсдийн өрхийн им, тамга, эмэгний судалгаа гаргаж, орон нутгийн цагдаагийн байгууллага, Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэгт хүргүүлэх ажлыг бүх шатны Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулах.

2.Хулгайн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны чиглэлээр

5.2.1. Хулгайн гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулахын тулд цагдаагийн албадын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ажилтнуудыг дадлагажуулж мэргэшүүлэх сургалт, семинар, зөвлөлгөөнийг үе шаттайгаар орон нутаг, бүсийн хэмжээнд зохион байгуулах, гадаад орнуудад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа арга туршлагыг судлах. Гэмт хэргийг бүрэн илрүүлэхэд шүүх, прокурор, цагдаа, хорих байгууллагын хамтын ажиллагаа чиглүүлэх.

5.2.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй байгаа хулгайн гэмт хэргийг нөхөн илрүүлэх, хулгайн эд зүйл борлуулагдаж байгаа арга замыг илрүүлэхийн тулд гүйцэтгэх ажлын арга хэмжээг шуурхай зохион байгуулах бэлтгэлтэй байх.

5.2.3. Папилон систем, туслах тоо бүртгэлд тулгуурлан хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийн талаарх мэдээллийн сан байгуулж, орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдээлэл солилцож байх,аймаг, дүүргийг төвтэй холбосон компьютерийн сүлжээ байгуулах асуудлыг шийдвэрлэх.

5.2.4. Хулгайн гэмт хэргийн гаврын үзэгийг мэргэжлийн өндөр түвшинд хийх нь гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой тул жижүүрийн шинжээч, мөрдөн байцаагч, төлөөлөгчөөр нарын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг гадаад, дотоодод зохион байгуулж байх.

5.2.5. Зарим хулгайн гэмт хэрэг үйлдэгсэд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албадыг дамжин шалгагдахдаа таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэн даалтад гарч, дахин хулгай хийх явдал олонтаа гарч байгаар харгалзан тэдэнд таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой зөв хэрэглэх цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөхдөө нутаг дэвсэрийн цагдаагийн байгууллагын хяналтад байлгах журмыг хэрэгжүүлэх.

5.2.6. Хулгайн гэмт хэргийн шалтгааныг арилгах талаар бичсэн мөрдөн байцаагчийн мэдэгдлийн чанарыг сайжруулах.

5.2.7. Цагдаагийн газар, хэлтсүүдэд хулгайн гэмт хэргийг шуурхай шалгадаг мэргэшсэн ажлын хэсэг байгуулан техник хэрэгсэл, унаагаар хангаж ажиллуулах.

5.2.8. Хэрэг буртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хулгайн гэмт хэргийн зохих хувийг нөхөн төлүүлсэн, нуугдмал хөөнгө илрүүлсэн, хөөнгө хамгаалах арга хэмжээ авсан хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч нарыг шагнаж урамшуулах.

5.2.9. Олон үйлдэлтэй, хэд хэдэн холбогдоктой, бүлэг зохион байгуулалттай хулгайн хэргүүдийн талаар цагдаа, шүүх, прокурорын байгууллага хамтран хэлэлцэж, шуурхай шийдвэрлэх талаар хамтран ажиллах.

3.Бусад ажлын чиглэлээр

5.3.1. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг орон нутагт идэвхжүүлэх, энэ ажилд олон нийтийг татан оролцуулахад нутгийн захиргааны байгууллага анхаарч, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай ажлаа уялдуулан тэдгээрт дэмжлэг туслалцаа үзүүлэх.

5.3.2. Хариуцсан нутаг дэвсгэрт нь хулгайн гэмт хэрэг ихээхэн гардаг сум, дүүрэг, хороо, аж ахуйн нэгжийн удирдлагатай хамтран хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх, хулгай гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, арилгах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх.

5.3.3. Тев. суурин газрууд, тухайлбал Улаанбаатар хот болон Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт орон байрны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, бусад аймагт малын хулгайтай тэмцэх нэгдсэн арга хэмжээг гүйцэтгэх ажил, урьдчилан сэргийлэх ажилтай хослуулан зэрэгцүүлэх аймаг, дүүргийг бүсчлэн зохион байгуулах.

5.3.4. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр орон нутгийн захиргаа, хууль хяналтын болон төрийн бус байгууллагуудын хамтарсан зөвлөлгөөнийг шаардлагатай аймаг, сумдад зохион байгуулах.

5.3.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн зохих хэсгийг энэхүү хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулж байх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

5.3.6. Цас, бороо, шууранд урудаж алдагдсан, бэлчээрээс хөлөөр нь алдсан, бэлчээр чөтгэлсэн алга болсон малыг буртгэх, зарлан мэдээлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран журам боловсруулан орон нутагт мөрдүүлэх.

5.3.7. Хулгайн гэмт хэрэг үйлдэгсдэд унаагаар үйлчилдэг жолооч, хулгайн эд зүйл авч борлуулдаг ломбард, чөнжийг хяналтад авах тэдний олсон хууль бус орлогыг хураан үлэсэн орлого болгож, үйл ажиллагаат нь зогсоох, эд мөрийн баримтыг нуун далдалсан, хуулийн байгууллагад гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд албадлага хэрэглэн хураан авах, хариуцлага тооцох талаар холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.

5.3.8. Хил дамнасан малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд Хилийн цэргийг удирдах газар Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан түүнийг таслан зогсоохоо чиглэсэн дэс дараалал арга хэмжээ авч хэрэгжүүлэх

6.Хөтөлбөрийн үр дүн

1.Үр дүн

6.1.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж хулгайн гэмт хэргэтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулснаар хулгайн гэмт хэргийн гаралтыг сааруулан, нийт гэмт хэргийн түүний эзлэх хувийг бууруулан, илрүүлэлт, хохирлын нөхөн төлөтийг өөдөгийн түвшингээс дээшлүүлэн байна.

6.1.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өөрөнгийн хамгаалалтаа сайжруулан хүлээдэг эртэхгүй байх арга хэмжээ авдаг болсон байх

6.1.3. Нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллага хамтран иргэд, төрийн бус байгууллагыг хулгайн гэмт хэргэтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд зохион байгуулах оролцуулж, тэдгээрийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих.

6.1.4. Хулгайн гэмт хэргэтэй тэмцдэг цагдаагийн албадыг мэдээллийн техник, холбоо, унаагаар зохих түвшинд хангаж, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлнэ.

2. Хяналт мониторинг

6.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хууль зүйн дотоод хэргийн яам тухай бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, сайд, Засгийн газарт танилцуулж байна.

ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ,УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ 2002-2005 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

№	Хийх ажил	Хариуцах байгууллага	Хэрэгжих хугацаа
	Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар		
1	Хөтөлберийг хэрэгжүүлэх зөвлөлийг хуралдуулж, ажлын хэсгүүдийг байгуулан, гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан, зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлэх, зөвлөлийг хагас, бүтэн жилээр хуралдуулан хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын явц байдал,тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх	ЦЕГ,Зөвлөл	2002 оноос жил бүр
2	Хөтөлберийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан мөрдөж ажиллах	Зөвлөл	2002 онд
3	Аймаг, нийслэлд хөтөлбөр, төлөвлөгөөг хүргүүлэн ажлын хэсэг байгуулан хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг нь батлуулж ажлыг эхлүүлэх	ХЗДХЯ, Зөвлөл	2002 онд
4	Аймаг, нийслэлийн ажлын хэсгүүдийн ажлыг дүгнэх, мэдээ тайлан авах тухай журам боловсруулан Зөвлөлийн даргаар батлуулан хүргүүлэх	Зөвлөл	2002 онд
5	Зөвлөлийн ажилд шаардагдах хөрөнгийн тооцоо хийж шийдвэрлүүлэх	ХЗДХЯ, СЭЗЯ, Зөвлөл	Жил бүр
6	Зөвлөлийн ажлын тайлан мэдээ гарган судалгаа, мэдээлэл, зөвлөмж, боловсруулах	ЦЕГ,Зөвлөл	2002 онд
	Хоёр.Урьдчилан сэргийлэх ажлын талаар		
7	Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн оролцоог идэвхжүүлж, тэдний үүсгэл санаачилгыг дэмжин, үр дүнд хүрч байгаа аймаг, дүүрэг, сум, хорооны түршлагыг судлан нийтийн хүртээл болгох	Бүх шатны Засаг дарга, Зөвлөл,ажлын хэсгүүд	Жил бүр
8	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цуврал сурталчилгаа өмч хөрөнгөө хамгаалах, сэрэмжлүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөөний дагуу хийж байх	Бүх шатны Засаг дарга, Зөвлөл, Монголын үндэсний радио,телевиз	Жил бүр
9	Сууц өмчлөгчдийн холбоо, орон сууцны байгууллага, хороодтой хамтран орц байрны жижүүр, гэр хорооллоод гудамжны болон нийтийн эргүүл ажиллуулах журам боловсруулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх,орц байрны жижүүрээр ажиллах хүмүүсийг цагдаагийн байгууллагаар судлуулсны үндсэн дээр авч ажиллуулах	Зөвлөл,ЦЕГ, дүүрэг, хороод	2002 онд
10	Төвлөрсөн томоохон захууд, дэлгүүр, үйлчилгээний газруудад төлө камер суурилуулан хяналт тавих талаар холбогдох компани, нийслэлийн байгууллагуудад санал, зөвлөмж тавих	Зөвлөл, нийслэлийн ажлын хэсгүүд	2002-2003 онд
11	Дохиолол хамгаалалтын болон хадгаламжийн үйлчилгээ, найдвартай хаалга, цонхны бэхэлгээний ач холбогдлын талаар сурталчилгаа хийх	Зөвлөл,ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх хэлтэс	Жил бүр
12	Төв суурин газарт хөршийн холбоо байгуулах, хөдөөд мал сүрэг хамгаалах нөхөрлөл байгуулах зэрэг иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих ажлыг зохион байгуулах	Бүх шатны ажлын хэсгүүд	2002-2003 онд

13	Нийслэлийн хот байгуулалт, барилгын зураг төслийн албадад цахилгаан тоолуурыг далд байрлуулах, орцны теле хяналтын болон орцны жижүүр, айл өрхтэй харьцах хэрэгсэл байрлуулах талаар санал тавьж шийдвэрлүүлэх	ДБЯ, ЦЕГ	2003 онд
14	Цагдаагийн академийг түшиглэн харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх дамжаа байгуулах боломжийг судлан шийдвэрлэх, харуул, жижүүрийн сонор сэрэмжийг дээшлүүлэх нэгдсэн арга хэмжээг жил бүр улсын хэмжээнд зохион байгуулах	ЦЕГ, Цагдаагийн академи, Зөвлөл	2002-2003 онд
15	Орон нутгаас төв суурин газарт оруулж байгаа мал, мах, түүхий эдийг бэлтгэсэн орон нутгийн баг, сумын Засаг даргын тодорхойлолт, мал эмнэлгийн ариун цэврийн сертификатыг үндэслэн тээврийн шалган буртгэх товчоод, байгууллагын постоор оруулж байх журмын төсөл боловсруулах, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах санал боловсруулж уламжлах	ХХААЯ, ХЗДХЯ	2003 онд
16	Төв суурин газарт амьдарч байгаа мал бүхий иргэд малаа эзлэхээр болон гэрээний үндсэн дээр хариулах зэргээр байнгын хариулгатай болгох ажлыг баг, хороодод зохион байгуулах талаар нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах	Баг, хорооны Засаг дарга	2003-2005 онд
17	Аймаг, сумын индекстэй тамгаар адуу тамгалдаг, бусад малыг эзэмэгтэй болгох ажлыг Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэгтэй хамтран зохион байгуулах, эзэмэг, тамга, имний бүртгэл, мэдээллийн сангаймаг бүрт байгуулах	ХХААЯ, Зөвлөл, МСГХХМН	2004 онд
18	Хамгаалалт нь хангалттүйгээс удаа дараа хулгайд өртөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хаалга, цонхоо найдвартай бэхлэх болон дохиолол, теле камер зэргэлэх тоноглох чиглэлээр мэдэгдэл, шаардлага өгч байх	Бүх шатны Засаг дарга,ажлын хэсэг	2002-2005 онд
19	Түүх, соёлын дурсгалт зүйлс, бусад үнэт зүйлс болон өмч хөрөнгө, бэлэн мөнгө ихээр төвлөрсөн объект, газруудын харуул хамгаалалтыг шалгаж, хамгаалалтын найдвартай байдлыг бий болгох	ЦЕГ-ын хэв журмын алба	2002-2005 онд
20	Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, энэ ажилд идэвх санаачилгатай оролцдог иргэдийн ажлын уулзалт, зөвлөлгөөн, семинарыг нийслэл,дүүрэг, аймаг, сумдад зохион байгуулж байх	Бүх шатны Засаг дарга, ажлын хэсэг	2002-2005 онд
21	Хулгайлах явдлыг жигшүүлэх үзэл санаагаар бага,өсвөр насны хүүхдийг хүмүүжүүлэх талаар цэцэрлэг, сургуулийн сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөрт туссан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	БСШУЯ	Жил бүр
	Гурав.Хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах,хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны чиглэлээр		
22	Шинээр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хулгайн гэмт хэрэгтэй тэмцэг албадын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болох	ЦЕГ	2002-2005 онд
23	Бүсчилсэн сургалт, зөвлөлгөөн, семинарыг малын хулгайтай тэмцэх, хамтран ажиллах, мэдээлэл солилцох хэлбэрээр 5 бүс болгон зохиох	Зөвлөл, ЦЕГ	2002-2005 онд
24	ОХУ, БНХАУ, Турк зэрэг улсад хулгайн гэмт хэрэгтэй тэмцдэг арга туршлагыг төлөөлөгч, мөрдөн байцаагч, шинжээч нараар судлуулах арга хэмжээ авах	ХЗДХЯ,ЦЕГ	2002-2005 онд
25	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөлгөөнд хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилт, хамтын ажиллагааны талаар мэдээлэл хийх	Зөвлөл,ЦЕГ	2003-2005 онд

26	Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй хулгайн хэргийг нөхөн илрүүлэх, хулгайн эд зүйл дамжин бүрлогдож байгаа сүлжээг илрүүлэх, гүйцэтгэх ажлын тодорхой арга хэмжээ авах талаар төлөвлөгөө гарган ажиллах	ЦЕГ	2003-2005 онд
27	Хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийн тухай мэдээллийн сан байгуулж, аймаг, дүүрэг,орон нутгаас мэдээлэл авч, тэдэнд мэдээлж байх	ЦЕГ,Зөвлөл	2003 онд
28	Цагдаагийн төв орон нутгийн албадыг холбосон компьютерийн сүлжээ байгуулах ажлыг эхлүүлэх	ХЗДХЯ, ЦЕГ	2002-2004 онд
29	Хэргийн газрын үзлэгийн талаар үзүүлэх сургуулийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт зохион байгуулах	ЦЕГ, Зөвлөл	2003 онд
30	Хулгайн гэмт хэргийг шуурхай илрүүлэх мэргэшсэн ажлын хэсгийг ажиллуулан туршиж, үр дүнг тооцох	ЦЕГ	2004 онд
31	Олон холбогдогчтой, аймаг, дүүрэг дамжсан олон үйлдэлтэй удаан хугацаанд шалгагдаж байгаа хэргийн талаар цагдаа, шүүх, прокурорын байгуллага хамтран хэлэлцэж, шуурхай шийдвэрлэж байх	ЦЕГ, Зөвлөл	Жил бүр
	Дөрөв. Бусад ажлын талаар		
32	Сум, багийн Засаг дарга Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэгтэй хамтран малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар зөвлөмж гаргаж аймгийн салбар зөвлөлүүдэд хүргэх	Зөвлөл, МСГХХМН	2003-2004 онд
33	Хулгайн гэмт хэрэг ихээхэн үйлдэгддэг сум, дүүрэг, хороо, аж ахуйн нэгж, байгуллагын удирдлагуудын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээний талаархи сонсголыг шат шатны хурлаар хэлэлцэж байх	Аймаг, дүүрэг, сумдын ажлын хэсэг	Жил бүр
34	Нийслэл, Орхон, Дархан-Уул зэрэг аймгуудтай хамтран орон байр, автомашины хулгайтай тэмцэх нэгдсэн арга хэмжээг цаг үеийн байдалтай уялдуулан зохиох	ЦЕГ, Зөвлөл	Жил бүр
35	Аймаг, орон нутагтай тохиролцон малын хулгайтай тэмцэх бүсчилсэн арга хэмжээг зохион байгуулан дүнг бүсийн зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэх	ЦЕГ, Зөвлөл	Жил бүр
36	Шуурганд уруудаж алдагдсан, бэлчээрээс хөлөөр нь алдсан, бэлчээр нутгаасаа алга болсон малыг буртгэх, зарлаж мэдээлэх талаар орон нутгийн Засаг дарга, төрийн бус байгуллага, Хүнс, хөдөө аж ахуйн яамны холбогдох албадтай хамтран журам боловсруулах	Зөвлөл, ХХААЯ	2003-2004 онд
37	Улсын хил зөрчин мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, Хилийн цэргийг удирдах газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллах	ЦЕГ, ТЕГ, ХЦУГ	2002-2005 онд
38	Авто тээврийн шалган буртгэх товчоод дээр хулгайн мал, мах тээвэрлэж байгаа явдлыг илрүүлэх үүрэгтэйгээр цагдаа ажиллуулах боломжийг судлах, туршилтын журмаар ажиллуулах	ЦЕГ, НЦГ	2002-2004 онд
39	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын явц байдлыг аймаг, дүүргийн хэмжээнд шалган мэргэжлийн удирдлагаар хангаж байх	ЦЕГ, Зөвлөл, ГХУСАЗЗ	Жил бүр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 147 Улаанбаатар хот

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 3, 6 дахь заалтууд, Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй туслamжаар Өвөрхангай аймгийн Хархорин суманд 1997 онд байгуулагдсан 10000 тн-ын багтаамжтай элеваторын байгууламжийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны "Буудайн сан"-д шилжүүлсүгэй.

2. 10000 тн-ын багтаамжтай элеваторын байгууламжийг ашиглахад эхний ээлжинд шаардагдах 52.5 (тавин хоёр сая таван зуун мянган) сая төгрөгийн үнэ бүхий техник хэрэгсэл, хашаа, байрыг хүнсний хангамжийг нэмэгдүүлэх КР-1 төслийн санд "Ган тээрэм" хувьцаат компаниас төлөх төлбөрт тооцон тус компаниас гаргуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Төрийн өмчийн хороо /Л.ТҮРЭВДОРЖ/-нд тус тус даалгасугай.

3. 10000 тн-ын багтаамжтай элеваторын байгууламжийг цаашид үр ашигтай ашиглах, Хархорины бүс нутгийн үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх чиглэлээр тодорхой тесел боловсруулан хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Батмөнх, Архангай аймгийн Засаг дарга Ж.Нэргүй нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 148 Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Биеийн тамир, спортын үндэсний төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Сөгнөгөр амралтыг цогцолбороор нь нийтийн дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Сөгнөгөр амралтыг цогцолбороор худалдах нийтийн дуудлага худалдаог холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /Л.ТҮРЭВДОРЖ/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 149 Улаанбаатар хот

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлахтухай

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах, нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд салбар дундын зөрөлцоог ханган, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, түүнчлэйг хөгжүүлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтыг ханган үүрэг бүхий нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн үндэсний зөвлөлийг батлуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сураг, өсвөр үеийнхний эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 80 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Үндэсний хороог шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 187 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П. НЯМДАВАА

Засгийн газрын 2002 оны 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд

Орлогч дарга - Эрүүл мэндийн сайд

Гишүүд - Байгаль орчны сайд;

- Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
- Эрүүл мэндийн дэд сайд, Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн дарга;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;
- Үйлдвэр, худалдааны дэд сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
- Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын орлогч;
- Ерөнхийлөгчийн нийгмийн бодлогын зөвлөх (зөвшилцөөнөөр);
- Ерөнхий сайдын нийгмийн бодлогын зөвлөх;
- Үндэсний статистикийн газрын дарга (зөвшилцөөнөөр);
- Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;
- Эмийн үндэсний зөвлөлийн дарга;
- Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал;
- Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний Ерөнхий штабын ар талын газрын дарга;
- Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга;
- Анагаах ухааны их сургуулийн захирал;
- Монголын улаан загалмай нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын хэрэглээгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- Эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний холбооны тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга

- Эрүүл мэндийн яамны тухайн асуудал хариуцсан ажилтан.

Засгийн газрын 2002 оны 149 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл (цаашид "үндэсний зөвлөл" гэнэ)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, нийгмийн эрүүл мэндийн талаархи үндэсний хөтөлбөрүүдийг удирдлага болгон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг улсын хэмжээнд хариуцна.

1.3. Үндэсний зөвлөл нь Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд төрүүлэх бөгөөд орлогч дарга нь Эрүүл мэндийн сайд байна. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Эрүүл мэндийн яамны тухайн асуудлыг хариуцсан ажилтан байна.

2.2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яам, Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын ажлын алба, төрийн бус байгууллагуудын төлөөлөл байна.

2.3. Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

2.4. Үндэсний зөвлөл нь аймаг, нийслэлд салбар зөвлөлтэй байх бөгөөд салбар зөвлөлийн дарга нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна. Орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг Үндэсний зөвлөлөөс баталж өгнө.

2.5. Зөвлөлийн даргын шийдвэрээр үндэсний зөвлөлийн гишүүд тухайлсан асуудлаар ажлын бүлэг байгуулан ажиллуулж болно.

2.6. Ажлын бүлэг нь Үндэсний зөвлөлд ажлаа тайлагнана.

2.7. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна. Үндэсний зөвлөл хэлэлцэн асуудлаараа зөвлөмж гаргана.

2.8. Хуралдааны дэгийг Үндэсний зөвлөл батална. Үндэсний зөвлөл улиралд 1-ээс доошгүй хуралдах бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулж болно.

2.9. Үндэсний зөвлөлийн хуралдаан гишүүдийн ердийн олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.10. Үндэсний болон салбар зөвлөл нь гоготоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.11. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн яамны жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Гурав. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Үндэсний Зөвлөл дараахь эрх эдэлнэ:

3.1.1. Ажлын бүлгийн илтгэл, сонсголыг хэлэлцэж, удирдамж, чиглэл өгөх;

3.1.2. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар холбогдох байгууллагуудаас ажлын тайлан, мэдээ, судалгаа, дүгнэлт гаргуулах;

3.1.3. Холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж чиглэл, зөвлөлгөө өгөх;

3.1.4. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгө санхүүгийн нөөцийг дайчлах;

3.1.5. Нийгмийн эрүүл мэндийн талаархи Засгийн газрын төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт,дүгнэлт өгөх, холбогдох тодотгол, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

3.1.6. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийг чиглүүлэн зохицуулах, гэрээ, хэлэлцээрийн төсөлд санал өгөх, салбарын яамдын бодлоготой үйл ажиллагаагаа уялдуулах;

3.1.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оңцгой амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг шагнаж урамшуулах талаар эрх бүхий байгууллагад санал гаргах;

3.1.8. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд эрдэмтэн, мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.9. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар олон улс, орон нутгийн чанартай хурал зөвлөгөөн, семинар, ярилцлага зохион байгуулах.

3.2. Үндэсний зөвлөл дараахь үүрэг хүлээнэ:

3.2.1. Ажлын бүлгүүдийн үйл ажиллагаар удирдан чиглүүлэх;

3.2.2. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээний санхүүжилтийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Нийгмийн эрүүл мэндийн талаар

төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг жил бүр дүгнэн хэлэлцэж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

3.2.4. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн талаархи тайланг жил бүрийн IY улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид ергөн мэдүүлэх;

3.2.5. Нийгмийн эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх, шуурхай удирдлагаар хангах;

3.2.6. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн хамтын ажиллагаагаг дэмжих;

3.2.7. Нийгмийн эрүүл мэндийн талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаг өргөжүүлж, харилцан мэдээ мэдээлэл солилцох;

3.2.8. Орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаагаг бодлогын удирдамжаар хангах, дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн дарга, орлогч даргын үйл ажиллагааны чиглэл

4.1. Үндэсний зөвлөлийн дарга нь зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон хуралдаанаас гарсан бодлогын удирдамжийг баталж шаардлагатай гэж үзсэн зарим асуудлыг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх, чиглэл өгнө.

4.2. Үндэсний зөвлөлийн дарга зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж, хуралдааныг удирдана.

4.3. Үндэсний зөвлөлийн дарга гишүүдэд үүрэг, даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавина.

4.4. Үндэсний зөвлөлийн даргын эзгүйд Зөвлөлийн орлогч дарга түүнийг орлон ажиллана.

4.5. Үндэсний зөвлөлийн орлогч дарга ажлын албаны үйл ажиллагааг удирдан зохицуулна.

4.6. Ажлын алба нь үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулна.

Тав. Нарийн бичгийн даргын үйл ажиллаганы чиглэл

5.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан зөвлөлийн даргаар батлуулж, хуралдааны бэлтгэлийг хангана.

5.2. Хуралдааны тэмдэглэл хөтөлж гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

5.3. Салбар зөвлөлийн тайланг нэгтгэн Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

5.4. Үндэсний зөвлөлийн архив, бичиг хэргийг хөтлөн явуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 150** **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Банкны ер барагдуулах газрыг улсын үйлдвэрийн газар болгосонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Зээлийн ерийг төлүүлэх ажлыг зрчимжүүлэх тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 115 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Банкны ер барагдуулахтай холбогдсон хууль, эрх зүйн актуудыг боловсронгуй болгохыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 151 | Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: хэлэлцээр"-ийг баталсугай.

Улаанбаатар хотноо 2002 оны 6 дугаар сарын 27-нд гарын үсэг зурсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хооронд цэргийн тусламж үзүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 152 | Улаанбаатар хот

Зарим Элчин сайдын яаманд консулын хэлтэс байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас БНСУ, БНХАУ, БНКазУ, ХБНГУ, Япон, АНУ-д суугаа Элчин сайдын яамны бүтцэд консулын хэлтэс байгуулсугай.

2. Консулын хэлтсийн орон тоог консул, дэд консул, техник ажилтан гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр батална.

3. Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа Ерөнхий консулын газрын Эрээн дэх салбарт 1 техник ажилтны орон тоо нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 153 | Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2002 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2002 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын XIY хэсгийн 3-т "...Тээлийн суман." гэснийг "...Хатуугийн боом дахь застав." гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 155 | Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2002 оны 3 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа жирийн дэглэмтэй Архангай аймгийн 447, Баян-Өлгий аймгийн 449, Баянхонгор аймгийн 455, Говь-Алтай аймгийн 441, Дорнод аймгийн 445, Завхан аймгийн 451, Орхон аймгийн 437, Сүхбаатар аймгийн 459, Увс аймгийн 453 дугаар хорих анги,удыг баривчлах байр болгон өөрчилсүгэй.

2. Булган, Дархан-Уул, Говьсүмбэр, Өверхангай, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Нийслэлийн "Хонхор" хороонд баривчлах байрыг шинээр байгуулсугай.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Булган аймгийн 439, Дархан-Уул аймгийн 435, Ховд аймгийн 457 дугаар хорих ангиудыг жирийн дэглэмтэй төвөрсөн хорих анги болгон т/с тус өөрчлөн зохион байгуулсугай.

4. Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданг ийн амьдралын болон үйлдвэрлэлийн бусийн ,адна,х дохиолол, харуул хамгаалалтыг дотоодын цэргийн харьяалагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяалалд шилжүүлсүгэй.

5. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, албадан саатуулах байрыг ажилтан болон орон тоо, төсөв хуяглан хүргэлтийн автомашин, бусад хөрөнгийн хамт Цагдаагийн ерөнхий газрын харьяалагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд балансаас балансад шилжүүлсүгэй.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа жирийн болон чанга дэглэмтэй төвлөрөн хорих ангийг орон нутгийн байршлаар бүсчлэн зохион байгуулж, түүний нутаг дэвсгэрийн байрши,ал эдлүүлэх харьяалал, үйлдвэрлэлийн чиглэлийг хавсралт ёсоор батална.

7. Шинээр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулыг нийцүүлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тоо, бүтэц болон цалин, сольд заасан холбогдох бусад дүрэм, журмыг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний дотор батлаж мөрдүүлэх, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах өөрчлөн өөрчлөлтийг тооцоог хянаж жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээ авч байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

9. "Хорих ангиудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 173 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн "...аймгийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт..." гэснийг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргад," гэж, "Хорих байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 37 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн "Цагдаагийн ерөнхий газар" гэснийг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар", "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 139 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "д"-гийн "-Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар" гэснийг "-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар" гэж тус тус өөрчилсүгэй.

10. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1990 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 153 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн "б" заалтаас бусад зүйл, заалт, "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтын "Нэг"-ийн 3 дахь хэсэгт "Цагдаагийн ерөнхий газрын Цагдан хорих төв" гэснийг, "Хорих ангиудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 173 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, "Хорих байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 37 дугаар тогтоолын 7 дугаар зүйлээс "... холбогдох аймгийн Засаг дарга..." гэснийг, 8 дугаар зүйлийн "б" заалтаас "...Дээрх аймгийн Засаг дарга нартай хамтран..." гэснийг, "Тусгай хэрэгцээний газарт хамаарууллах тухай" Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 113 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХОРИХ АНГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙРШИЛ, ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ХАРЬЯАЛАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛ

№	Хорих ангийн нэр, нутаг дэвсгэрийн байршил	Ял эдлүүлэх харьяалал	Хорих ял эдлүүлэх дэглэм	Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл
1	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлах Амгалангийн хорих 421 дүгээр анги	Улаанбаатар хотын харьяат ялтанг	Жирийн	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, тахианы аж ахуй
2	Төв аймгийн Мөнгөнморьт сумын хорих 417 дугаар анги	Төв, Өмнөговь, Дундговь аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Ойжуулалт, мод үржүүлэг, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэл
3	Булган аймгийн Булган суманд байрлах хорих 439 дүгээр анги	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Шохойн олборлолт, шохой үйлдвэрлэл
4	Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах хорих 435 дугаар анги	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хадлан бэлтгэл
5	Ховд аймгийн Ховд суманд байрлах хорих 457 дугаар анги	Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай,Завхан, Увс аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Төмс, хүнсний ногоо, тариалалт, барилга, барилгын материалын үйлдвэрлэл
6	Өвөрхангай аймгийн Хархорин суманд байрлах хорих 423 дугаар анги	Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, ойн цэвэрлэгээ
7	Хэнтий аймгийн Өндөрхаан суманд байрлах хорих 419 дүгээр анги	Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн	Ойжуулалт, мод үржүүлэг, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэл
8	Хөвсгөл аймгийн Мөрөн суманд байрлах хорих 443 дугаар анги	Хөвсгөл, Баян-Өлгий, Булган, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд зэрэг 7 аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	Шохойн чулуу олборлолт, шохой үйлдвэрлэл
9	Говьсүмбэр аймгийн Чойрт байрлах хорих 425 дугаар анги	Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн харьяат ялтанг	Чанга	Эсгий, эсгий гутал, ясны гурилын үйлдвэрлэл

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2002 оны 36 (273)

10	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дарьт дахь 443 дугаар хорих анги	Булган, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн харьяат ялтанг	Чанга	Төмс, хүнсний ногоо, тариалалт, мод бэлтгэл, бусад боловсруулах үйлдвэрлэл, үр тариа, гурилын үйлдвэрлэл
11	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дарьт дахь 433 дугаар хорих анги	Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгийн харьяат ялтанг	Чанга	Төмс, хүнсний ногоо, тариалалт, мод бэлтгэл болон боловсруулах үйлдвэрлэл, үр тариа, гурилын үйлдвэрлэл
12	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлах Ганц худаг дахь хорих 409 дүгээр анги	Улаанбаатар хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	Тоосгоны үйлдвэрлэл
13	Төв аймгийн Баян суманд байрлах Маанэт дахь хорих 415 дугаар анги	Төв аймгийн харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	Шохойн чулуу олборлолт, шохой үйлдвэрлэл
14	Төв аймгийн Баяндэлгэр сум, Улаанбаатарын Багануур дахь хорих 427 дугаар анги	Улаанбаатар хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	Төмс, хүнсний ногоо, тариалалт, барилгын материалын үйлдвэрлэл, хадлан бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэл
15	Төв аймгийн Лүн суманд байрлах Авдрантын хорих 403 дугаар анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Онцгой	Ногоон боржин чулуу олборлолт, боловсруулалт
16	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлах эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн, чанга	Төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл
17	Улаанбаатар хотын Тахир сөөт дахь хорих 405 дугаар анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Гяндан	
18	Улаанбаатар хотын Зайсан дахь насанд хүрээгүйчүүдийн хорих 411 дүгээр анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Жирийн, чанга	
19	Нэгдсэн эмнэлэг, дамжин өнгөрүүлэх хорих 401 дүгээр анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	
20	Сурьеэгийн эмнэлэг, хорих 429 дүгээр анги	Аймаг, хотын харьяат ялтанг ял эдлүүлэх	Чанга	

2002 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 156 Улаанбаатар хот

Осол,гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор батална уга.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх, санхүүгийн бусад эх үүсвэрээс гаргахаар тооцож хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жил бүрийн I улиралд Засгийн газарт мэдээлж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2002 оны 156 дугаар тогтоолын хавсралт

ОСОЛ, ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Осол, гэмтлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

1.1. Өнөөгийн байдал.

Дэлхий нийтэд жил бүр 5 сая гаруй, өдерт дунджаар 16000 хүн осол, гэмтлийн улмаас амь насаа алдаж, үүнээс хэдэн мянга дахин олон хүн үүрдийн тахир дутуу болж байна.

Манай улсад осол, гэмтлээр нас барсан хүний тоо 1990 онд 792 байсан бол 1995 онд 1406, 1999 онд 1862 болж эрс өсчээ. Нийт хүн амын нас баралтын дотор осол, гэмтлийн улмаас нас барсан тохиолдлын эзлэх хувийн жин байнга өсөн нэмэгдэх болов.

Сүүлийн жилүүдийн судалгааны дүнгээс үзэхэд манай улсад 100000 хүн ам тутамд 2880 осол, гэмтлийн тохиолдол ногдож, ертөгдийн ихэнх хувийг хүүхэд, залуучууд эзэлж байна. Осол, гэмтэлд ертөгсөд шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг тухайд нь авч чадахгүй, хожуу оношлогдсоноос хөдөлмөрийн чадвар бүрэн алдах, тахир дутуу болох тохиолдол улам ихсэх хандлагатай байгаагаас гадна хөдөө орон нутгаас ирж байгаа эмнэлгийн яаралтай дуудлагын 40 орчим хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

1.2. Тулгамдсан асуудал

Осол, гэмтлээс сэргийлэх асуудлын удирдлага, зохион байгуулалт, сургалт сайжираагүй нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, осол, гэмтлээс сэргийлэх хүн амын мэдлэг, дадал бололцоо нь асуудлаархи байгууллага, аж ахуйн нэгжийнхний хариуцлага, оролцоо хангалттүй, осол гэмтлийн чөдөр үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж муу байгаагаас:

- Осол, гэмтэл нь хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгаануудын нэг болсон;
- Осол, гэмтэлд ихэвчлэн ид хөдлөлийн насны хүмүүс илүү ертөж, нас барах тохиолдлуу болох эрсдэл өссөн;
- Осол, гэмтлийн улмаас улс нийгэмд хүч хүнд учрах эдийн засгийн хохирол эрс нэмэгдэж байгаа зэрэг нь осол, гэмтлээс сэргийлэн хамгаалах үйл ажиллагаа нийгмийн шийдвэрлэвэл зохих чухал асуудлын нэг болсныг харуулж байна.

1.3. Хөтөлбөр боловсруулах шаардлага үндэслэл

"Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль", "Хүн амын эрүүл мэндийн баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх, осол, гэмтлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бодлого, зөвлөмжтэй нийцүүлэн "Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулж,

Хоёр. Хөтөлберийн зорилго, зорилт, стратеги

2.1. Хөтөлберийн зорилго

Үндэсний хөтөлберийн зорилго нь хүн ам осол, гэмтлийн улмаас тахир дутуу болох, хөдөлмерийн чадвар алдах, нас барах явдлыг бууруулахад оршино.

2.2. Хөтөлберийн зорилт

2.2.1. Осол, гэмтлийн тандалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, осол, гэмтлийн тархалт, шалтгааныг судалгаагаар тогтоож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.2.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, хамт олны осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх хариуцлага, хамтын ажиллагаат сайжруулах замаар осол, гэмтлийг бууруулах;

2.2.3. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрөлжсөн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.2.4. Осол, гэмтэлд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

2.3. Хөтөлберийг хэрэгжүүлэх стратеги

2.3.1. Хүн амыг осол, гэмтлээс сэргийлэх арга хэмжээ нь нийгмийн эрүүл мэндийн талаар тереөс баримтлах бодлого, чиглэлтэй нягт уялдсан байх;

2.3.2. Хөтөлберийн үйл ажиллагаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, осол, гэмтэл судлалын олон улсын холбооны бодлого, чиглэлтэй нийцсэн байх;

2.3.3. Хүн амыг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулах;

2.3.4. Осол, гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хамт олны үүрэг, хариуцлагыг өндержүүлэхэд чиглэсэн байх;

2.3.5. Осол, гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаа нь осол, гэмтлийн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлийн судалгаанд үндэслэгдсэн энгийн, үр ашигтай байх.

Гурав. Хөтөлберийн үйл ажиллагаа

3.1 Осол, гэмтлийн тандалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, осол, гэмтлийн тархалт, шалтгааныг судалгаагаар тогтоож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. Осол, гэмтлээс сэргийлэх сургалт, судалгааны төвийг Гэмтэл согог, сэргээн засалтын клиникийн эмнэлгийг түшиглэн байгуулна;

3.1.2. Осол, гэмтлээс сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх эрдэм шинжилгээ, судалгааны төслүүдийг хэрэгжүүлнэ;

3.1.3. Осол, гэмтлийн тархвар судлалын чиглэлээр өндөр хөгжилтэй оронд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэнэ;

3.1.4. Осол, гэмтлийн хэлбэрүүд, түүний шалтгаан, тархалтыг холбогдох байгууллагатай хамтран судалсны үндсэн дээр авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ;

3.1.5. Хүчирхийллээс шалтгаалсан осол, гэмтлийн хэлбэрүүд, түүний шалтгаан, тархалтыг холбогдох байгууллагатай хамтран судалж, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ;

3.1.6. Үйлдвэр, хөдөө аж ахуйн осол, гэмтлийн шалтгаан, төрөл, тархалтын судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хамт олны осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх хариуцлага, хамтын ажиллагаат сайжруулах замаар осол, гэмтлийг бууруулах зорилтын хүрээнд:

3.2.1. Осол, гэмтлээс сэргийлэх хүн амын мэдлэг, хандлага, дадлын түвшин тогтоох суурь судалгаа хийнэ;

3.2.2. Хүн амд осол, гэмтлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох албан болон албан бус сургалтыг уе шаттайгаар явуулна;

3.2.3. Осол, гэмтлээс сэргийлэх талаар мэдлэг, дадал олгох сурталчилгаанд төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр оролцуулна;

3.2.4. Ажлын байранд үүсч болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, сургалчилгааны үр ашигтай хэлбэрийг ашиглаж, үйлдвэрлэлийн аюулгүй орчин бий болгоно;

3.2.5. Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр өөрийн эзэмшил нутаг дэвсгэрт халтиргаа, гулгаа үүсэх, бүрэн бус цахилгааны шугам, утас, задгай нүх, шуудуу үлдээх зэргээр осол, гэмтэл хүргэж болзошгүй нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, ийм байдал үүссэн үед нь арилгах, засч тохижуулах арга хэмжээ авах, осол гарсан тохиолдолд түхайн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, хувь хүн хариуцлага хүлээх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулна;

3.2.6. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлөө сайжруулж, 5 жил дараалан осол, гэмтэл гаргаагүй ажил олгогчийг урамшуулах журам гаргаж мөрдүүлнэ;

3.2.7 Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрийн осол, хөдөлмөр хамгааллыг судлах зөвлөлийн ажилтныг осол, гэмтэл, хордлогын бүртгэл, мэдээллийн чиглэлээр сургалтад хамруулна;

3.2.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хандивлагч орон болон олон улсын бусад байгууллагатай хамтын ажиллагаа өргөжүүлнэ;

3.2.9. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлагын биелэлтийг аж ахуйн нэгж, байгууллагад жилд нэгээс доошгүй удаа шалгаж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрөлжсөн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Хүүхдийн гэмтлийн дотор нэгдүгээрт ордог ахуйн гэмтлийн шалтгаан, нөхцөл, түүнээс сэргийлэх талаар эцэг, эх, хүүхдийн дунд сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулна;

3.3.2. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэхэд эцэг,эх,сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ;

3.3.3. Улсын хэмжээнд золбин нохой устгах нэгдсэн арга хэмжээг жил бүрийн хавар, намарт зохион байгуулна;

3.3.4. Гэр, хашааны нохойн бүртгэлийг сайжруулах, тэдгээрийг гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газарт хошуувчгүй, оосоргүй, зээнгүй сул явуулахгүй байх асуудлаар журам боловсруулж хэрэгжүүлнэ;

3.3.5. Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх өөрийн эзэмшил нутаг дэвсгэрт халтиргаа, гулгаа, нүх, шуудуу зэрэг осол, гэмтэлд хүргэж болох хүчин зүйлээс сэргийлж, аюулгүй орчин бүрдүүлэх, осол гарсан тохиолдолд түхайн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх хүлээх үүрэг, хариуцлагыг гүйцэтгэх ажлыг зааглан тогтоох асуудлаар тусгай журам боловсруулж хэрэгжүүлнэ;

3.3.6. Хүн амын дунд түгээмэл тохиолдож байгаа осол, гэмтлийн шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар холбогдох байгууллагуудын уялзалт, ярилцлагыг жил бүр зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж, даалгавар гаргаж хэрэгжүүлэх арга хэмжээ авна;

3.3.7. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөний дүрмийн хичээл оруулж, хүүхэд, өсвөр үеийнхнийг хөдөлгөөний аюулгүй байдлын осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал заншил эзэмшүүлэх албан болон албан бус зайны сургалт явуулна;

3.3.8. Аж ахуйн нэгж, байгууллага бүр ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангасан байх шаардлагыг өндөржүүлэх арга хэмжээ авна;

3.3.9. Замын хөдөлгөөнд оролцогч жолооч, зорчин явагчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, сахилга, соёлыг сайжруулах, осол, гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг чадвар олгоход чиглэсэн арга хэмжээ авна.

3.4. Осол, гэмтэлд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:

3.4.1. Хүн амын эмзэг бүлгийн хэсэг хүмүүс болон жолооч, малчид, тариаланчид зэрэг онцлог ажил мэргэжлийн хүмүүст эмнэлгийн анхны тусламжийн мэдлэг, дадал зэзэмшүүлэх сургалт зохион байгуулж, жолооч, малчин өрхийг эмнэлгийн анхны туслажийн бүрдэлтэй болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ;

3.4.2. Сум, баг, өрх, үйлдвэр, сургууль,

албан байгууллагын эмч, эмнэлгийн ажилтныг осол, гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламжийн шаталсан сургалтад хамруулна;

3.4.3. Цагдаагийн болон галын албаа хаагчдад зориулсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх чадвар олгох, мэдлэг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна;

3.4.4. Үйлдвэр, бүх шатны сургууль, албан байгууллагыг түгээмэл осол, гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх сайн дурын ажилтантай болгож, тэдэнд мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.

Дерев. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,
санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1. Удирдлага, зохион байгуулалт

4.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, холбогдох бусад хөтөлбөр, төсөлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газарт тайлагнах, шаардлагатай асуудлаар холбогдох газарт санал оруулах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл хариуцна;

4.1.2. Аймаг, нийслэлийн хэмжээнд хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх, шаардлагатай тайлан мэдээ гаргах ажлыг аймаг, хотын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл хариуцна.

4.2. Санхүүжилт

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь жил бүрийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, шинжлэх ухаан, технологийн сан, байгууллага, иргэд, хамт олны хандив, тусламжаас бүрдэнэ.

4.3. Хэрэгжүүлэх хугацаа

Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг 2002–2008 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ,
шалгуур үзүүлэлт

5.1. Хяналт, үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт, дүгнэлт өгөх, хөтөлбөрийг боловсронгуй болгох,эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулах ажлыг холбогдох яамдын мэдээлэл,хяналт-шинжилгээ, үнэлгээний газрууд хамтран гүйцэтгэнэ.

Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүн шинжилгээ хийх ажлыг бүх шатны Засаг дарга аймаг, нийслэлийн нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	2002 оны түвшин	2004 онд хүрэх түвшин	2008 онд хүрэх түвшин
1. Осол, гэмтлээс шалтгаалсан хүн амын өвчлөл 10000 хүн амд	Улс-274.55 УБ-632.47	240.0 532.0	205.9 474.35
2. 10000 хүн тутмаас осол, гэмтлийн улмаас хэвтэн эмчлүүлэгчид	Улс-86.22 УБ-149.84	80.2 138.60	73.3 127.37
3. Осол, гэмтлээс шалтгаалсан нас баралт 100000 хүн амд	76.6	68.0	57.0
4. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх мэдлэг олгох сургалтад хамрагдсан: -өрхийн эмч -хүүхэд, эмэгтэйчүүдийн эмч -баг, сумын эмч	 25% 0% 10%	 80.0% 50.0% 50.0%	 100% 100% 100%

Зургаа. Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний
хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл
ажиллагааны төлөвлөгөө

Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран оролцох байгууллага
6.1 Осол, гэмтлийн тандалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, осол гэмтлийн тархалт, шалтгааныг судалгаагаар тогтоож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:			
6.1.1. Осол, гэмтлээс сэргийлэх сургалт, судалгааны төвийг гэмтэл согог, сэргээн засалтын клиникийн эмнэлгийг түшиглэн байгуулах	2002-2003	ЭМЯ	ХЗДХЯ, БСШУЯ, ДБЯ, ЭМХҮТ, НЭМХ
6.1.2. Осол, гэмтлээс сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх эрдэм шинжилгээ, судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх	2003-2008	ЭМЯ	ЭМХҮТ, БСШУЯ, ЗЦГ, ЦЕГ, НЭМХ
6.1.3. Гадаад оронд магистрантурт сургах сонгон шалгаруулалтад тэнцэгчдээс өндөр мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах арга хэмжээ авах	2003-2005	БСШУЯ	ЭМЯ, СЭЗЯ
6.1.4. Осол, гэмтлийн хэлбэрүүд, түүний шалтгаан, тархалтыг холбогдох байгууллагатай хамтран судалж сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2002-2008	ЭМЯ	ХЗДХЯ, БСШУЯ, ДБЯ, ҮХЯ, ХХААЯ, ЭМХҮТ
6.1.5. Осол, гэмтэлтэй холбогдсон хүчирхийллийн хэлбэрүүд, түүний шалтгаан, тархалтыг холбогдох байгууллагатай хамтран судалж авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2002 оны IY улирлаас 2003	ЭМЯ	ХЗДХЯ, ЗЦГ, ЦЕГ, ХЭҮТ, ХХУА
6.1.6. Үйлдвэр, хөдөө аж ахуйн осол, гэмтлийн шалтгаан, төрөл, тархалтын судалгаанд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2003-2008	ЭМЯ	НХХЯ, ХХААЯ, ҮХЯ
6.2 Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж,байгууллага, иргэд, хамт олны осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх хариуцлага, хамтын ажиллагаат сайжруулах замаар осол, гэмтлийг бууруулах зорилтын хүрээнд:			
6.2.1. Боловсгүй ажуул, осол, гэмтлээс сэргийлэх талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлын түвшин тогтоох суурь судалгаа хийх	2002, 2004, 2008	ЭМЯ	БСШУЯ, ЭМХҮТ, НЭМХ
6.2.2. Хүн амд осол, гэмтлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох албан ба албан бус сургалтыг үе шаттайгаар явуулах	2002-2008	БСШУЯ	ЭМЯ, ЭМХҮТ, НЭМХ, ТББ
6.2.3. Осол, гэмтлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох мэдээлэл сурталчилгаанд төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ергөнөөр ашиглах	2002-2008	ЭМЯ	БСШУЯ, ХЗДХЯ, ҮХЯ, ДБЯ, ХХААЯ, Бүх шатны ЗДТГ, ТББ
6.2.4. Үйлдвэрлэлийн аюулгүй орчныг бүрдүүлэх, ажлын байранд үүсч болзошгүй осол, гэмтлээс сэргийлэхэд чиглэсэн сургалтын үр ашигтай хэлбэрийг хэрэгжүүлэх	2003-2008	НХХЯ	ЭМЯ, ДБЯ, ҮХЯ, ХХААЯ
6.2.5. Ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн нөлөөллөөс үүсэх мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	2002-2008	НХХЯ	ҮХЯ, ХХААЯ, ЭМЯ, ДБЯ, ХЗДХЯ
6.2.6. Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих болон тодорхой хугацаанд осол гэмтэл гаргаагүй ажил олгогчийг урамшуулах журам гаргаж мөрдүүлэх	2003	НХХЯ	Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, салбар холбоод

6.2.7. Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрийн осол, хөдөлмөр хамгааллыг судлах зөвлөлийн ажилтныг осол, гэмтэл, хордлого, бүртгэл, мэдээллийн чиглэлээр сургалтад хамруулах	2003-2004	НХХЯ	ҮХЯ, ХХААЯ
6.2.8.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хандивлагч орон болон олон улсын бусад байгууллагатай хамтын ажиллагаа өргөжүүлэх.	2003-2008	ГХЯ	ЭМЯ, НХХЯ, ДБЯ, ХХААЯ
6.3 Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрөлжсөн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:			
6.3.1. Хүүхдийн гэмтлийн дотор нэгдүгээрт ордог ахуйн гэмтлийн шалтгаан, нөхцөл, сэргийлэлтийн талаар эцэг, эх, хүүхдийн дунд зохиох мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх арга хэмжээ авах	2003-2008	ЭМЯ	БСШУЯ, ЭМХҮТ, ТББ
6.3.2. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэхэд эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2002-2008	БСШУЯ	НЭМХ, ЭМХҮТ, ТББ
6.3.3. Еренхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөний дүрмийн хичээлийг оруулах	2003	БСШУЯ	ХЗДХЯ, ЗЦГ
6.3.4. Улсын хэмжээнд золбин нохой устгах нэгдсэн арга хэмжээг жил бүрийн хавар, намар зохион байгуулах	2002-2008	Бүх шатны ЗДТГ	
6.3.5. Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх өөрийн эзэмшил нутаг дэвсгэрт осол, гэмтэлд хүргэж болох хүчин зүйлээс сэргийлж, аюулгүй орчин бүрдүүлэх, осол гарсан тохиолдолд тухайн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох журам боловсруулж хэрэгжүүлэх	2002-2003	Бүх шатны ЗДТГ	Мэргэжлийн хяналтын албад
6.3.6. Хүн амын дунд түгээмэл тохиолдож буй осол, гэмтлийн шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар холбогдох байгууллагуудын уулзалт ярилцлагыг жил бүр зохиож дүгнэлт, зөвлөмж, чиглэл гаргаж байх	2003-2008	Бүх шатны ЗДТГ	-
6.3.7. Хүүхэд, өсвөр үеийнхнийг замын хөдөлгөөний осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд хөдөлгөөний аюулгүй байдлын мэдлэг, дадал заншил эзэмшүүлэх албан ба албан бус алсын зайны сургалт явуулах	2003-2008	БСШУЯ	ХЗДХЯ, ЭМЯ, ТББ
6.3.8. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээ авах	2003-2004	НХХЯ	НЭМХ, ЭМХҮТ
6.3.9. Замын хөдөлгөөнийг бүрдүүлж байгаа жолооч, зорчин явагчдын хөдөлгөөнд оролцох дүрмийн мэдлэг, сахилга, соёлыг сайжруулах арга хэмжээ авах	2003-2008	ХЗДХЯ	ЗЦГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ

6.4 Осол, гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:			
6.4.1 Эмзэг бүлгийн хүмүүс, жолооч, малчид, тариаланчид зэрэг онцлог ажил мэргэжлийн хүмүүст эмнэлгийн анхны тусламжийн мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, жолооч, малчин өрхийг эмнэлгийн анхны тусламжийн бүрдэлтэй болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх	2003-2008	ЭМЯ	МУЗН, аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ
6.4.2. Сум, баг, өрх, үйлдвэр, сургууль, албан байгууллагын эмч, эмнэлгийн ажилтанд осол, гэмтлийн үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх шаталсан сургалт явуулах	2003-2008	ЭМЯ	ЦЕГ, ЭМХҮТ, ТББ
6.4.3. Цагдаагийн болон галын ажилтанд осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар олгох, мэдлэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	2003-2004	ХЗДХЯ	ЭМЯ, ЦЕГ, ЭМХҮТ
6.4.4. Үйлдвэр, бүх шатны сургууль, албан байгууллагыг осол, гэмтлийн үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сайн дурын ажилтантай болгож, тэдэнд мэдлэг, дадлага эзэмшүүлэх арга хэмжээ авах	2003-2004	Үйлдвэр, албан байгууллага	НХХЯ, ЭМЯ, БСШУЯ, ҮХЯ, МУЗН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 157** **Улаанбаатар хот**

Нөөцөөс хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ховд, Баян-Өлгий аймагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний халдварын тархалтаас сэргийлэх, голомтыг устгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эхний ээлжинд иргэний хамгаалалтын зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардалд 28638.5 (хорин найман сая зургаан зуун гучин найман мянга таван зуун) мянган төгрөг, мал сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний голомтыг устгах арга хэмжээний зардалд 110320.6 (нэг зуун арван сая гурван зуун хорин мянга зургаан зуун) мянган төгрөг, бүгд 138959.1 (нэг зуун гучин найман сая есөн зуун тавин есөн мянга нэг зуун) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Улсын байнгын онцгой комиссын мэдэлд шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд, уг хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, зарцуулалтыг Санхүү, эдийн засгийн яаманд тайлагнахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан бараа, ажлын хувцас, ариутгах бодис, хэрэслийг шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээнд зориулан улсын нөөцөөс гаргаж, энэ оны Ш улиралд багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгаж, нөхөн бүрдүүлэхэд шаардагдах 41881 (дөчин нэгэн сая найман зуун наян нэгэн мянга) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 157 дугаар тогтоолын хавсралт

ХОВД, БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ ГАРСАН МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТЫГ АРИЛГАХАД ЗОРИУЛАН УЛСЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үүнээс	
				Ховд	Баян-Өлгий
1.	Формалин	тонн	20	10	10
2.	Автомакс	ширхэг	4	2	2
3.	Хлормин	тонн	0.2	0.1	0.1
4.	Хлорын шохой	тонн	2	1	1
5.	Тариурын зүү №16	ширхэг	2000	1000	1000
6.	Эсгий	метр	280	140	140
7.	Ажлын хувцас	хос	120	50	70
8.	Ажлын гутал	хос	50	20	30
9.	Усны гутал	хос	50	20	30
10.	Денатурат спирт	литр	10	5	5
11.	Цэвэр спирт	литр	20	10	10

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 158** **Улаанбаатар хот**

Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, "Иргэний нисэхийн улсын хяналтын дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга Дааданхүүгийн Батчулуунд Иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 159** **Улаанбаатар хот**

Археологийн хүрээлэн байгуулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх Археологийн судалгааны төвийг Археологийн хүрээлэн болгон өргөтгөж Шинжлэх ухааны академийн харьяанд байгуулсугай.

2. Археологийн хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нарийвчлан тогтоож ажиллуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 8 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 160 | Улаанбаатар хот

Хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын 2003 онд дагаж мердех нормативыг хавсралт ёсоор батална.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хоолны зардлын хэмжээг 36000 (гучин зургаан мянган) төгрөгөөр тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны (8 дугаар анги төгсөөд элссэн) ангиас дотуур байранд амьдрах нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 110950 (нэг зуун арван мянга есөн зуун тавин) төгрөгөөр тус тус тогтоож улсын төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, сурагчдын дотуур байрны цахилгаан, дулаан,ус, тээврийн зардлыг тухайн цэцэрлэг, сургуулийн байршил, хэв шинжийг харгалзан орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байсугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж,холбогдох заавар, журмаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймаг, нийслэлийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн болон дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 182 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 160 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

№	Аймаг, хот	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал /төгрөг/	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал /төгрөг/			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал /төгрөг/
			Бага анги	Дунд анги	Ахлах анги	
1	Архангай	90079	61675	75181	83145	144264
2	Баян-Өлгий	95389	65641	82244	85599	152873
3	Баянхонгор	92728	61965	75470	83434	148568
4	Булган	90079	61675	75181	83145	144264
5	Говь-Алтай	95389	62468	75974	83938	151718
6	Дорноговь	90079	61729	78611	83198	144264
7	Дорнод	92729	61965	75470	83434	148568

8	Дундговь	90079	61311	78193	82770	144264
9	Завхан	95389	62468	75974	83938	148568
10	Өвөрхангай	90079	61311	74806	82770	144264
11	Өмнөговь	92728	61911	78793	83381	148568
12	Сүхбаатар	90079	61965	78847	83434	-
13	Сэлэнгэ	92728	61375	74881	82845	144264
14	Тэв	90101	60979	74484	82448	143844
15	Увс	95389	62812	79693	84270	152873
16	Ховд	95389	62812	79693	84270	152873
17	Хөвсгөл	92728	62008	75513	83466	148568
18	Хэнтий	90079	61547	75052	83005	148568
19	Дархан-Уул	85718	60346	73648	81494	143949
20	Улаанбаатар	85686	59564	72866	80712	143004
21	Орхон	85665	60528	73830	81666	143949
22	Говьсүмбэр	90079	61225	74731	82695	-

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн эзлэх хувь цэцэрлэгт 73.6, өрөнхий боловсролын сургуульд 76.7, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 68.3 хувь байна.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2002 оны 7 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 263 | Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ,ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай "Монгол Улсын 2002 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуулийн зарим зүйл,хэсэг,заалтыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдлыг ханган зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт,Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид Хуулийн гэх/ 8.2 дахь заалтын "Хэргийн нотлох баримт,эсхүл үйл явдал төр,байгууллага,хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн бүюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно"гэсэн заалтыг тухайн хэргийн ихэнх нотлох баримт бүюу үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой бол шүүх хуралдааныг бүхэлд нь хаалттай, хэрэв зарим нотлох баримт тэдний нууцтай холбоотой бол зөвхөн тэдгээр нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааг хаалттай явуулахыг ойлгоно. Шүүх хуралдааныг бүхэлд нь бүюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулах асуудлыг хэргийн оролцогчдын хүсэлтийг үндэслэн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.

2. Хуулийн 8.4 дэх заалтын "төр ,байгууллага, хувь хүний нууц" гэдгийг төр, байгууллага,хувь хүний нууцын тухай Монгол Улсын хуулиудад заасан байдлаар ойлгож хэрэглэнэ.

3. Хуулийн 10.1 дэх заалтын "Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль,түүнд нийцүүлэн гаргасан,албан ёсоор нийтлэгдсэн,хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ"гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуулиар шууд зохицуулагдсан нийгмийн харилцаанаас үүссэн маргааныг шүүх шийдвэрлэхдээ Үндсэн

хуулийг,Үндсэн хуулиар шууд зохицуулагдаагүй харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуульд нийцсэн, тэгэхдээ албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр болсон, өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52,53 дугаар зүйлд заасны дагуу уул хууль хүчин төгөлдөр болох тухай үг хуульд заасан ёдөөс,уг хуульд тусгайлан заагаагүй бол зөвхөн "Төрийн мэдээлэл"сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш 10 хоног өнгөрснөөр хүчин төгөлдөр болсон хуулийг хэрэглэхийг ойлгоно. Харин хууль хүчин төгөлдөр болох өдрийг тухайн хуульд заасан болговч уул хууль "Төрийн мэдээлэл"-д албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэх эрхгүй.

4. Хуулийн 10.2 дахь заалтын "Хэргийн хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж,Улсын Дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана"гэсэн заалтыг шүүх хэрэглэхдээ тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль,эсхүл түүний зүйл, хэсэг, заалт нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч үзвэл тэр үндэслэлээ тодорхой заажүул хууль, зүйл, хэсэг,заалтыг Үндсэн хуульд нийцэхгүй байгаа талаархи үндэслэлийг тусгасан,хэрэг шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тогтоол,захирамж гаргаж Дээд шүүхэд ирүүлэхийг ойлгоно.Улсын Дээд шүүх саналыг хүлдаанаараа хэлэлцэж шүүхийн санал үндэслэлгүй гэж үзвэл тогтоол,захирамжийг хүчингүй болгож, саналыг хэрэгсэхгүй болгох ба саналыг үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд оруулах тухай тогтоол гаргана.

5. Хуулийн 24.2 дахь заалтын "Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн өөрийн эрх,эрх чөлөө,хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд хамгаалах эрхтэй"гэдгийг насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны иргэн нь Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн хөдөлмөрийн хөлс,оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг зарцуулсантай холбогдсон болон эдгээр орлогыг банк,зээлийн байгуулламгад хадгалуулсан хийгээд тэдгээрийн хоршооны гишүүний эрх,үүрэгтэй холбогдох маргаан,өөртөө хохиролгүй,хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл зэрэг тэдгээрт хуулиар олгосон эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх явцад үүссэн маргааныг шүүхээс хянан шийдвэрлэхэд эрх зүйн бүрэн чадамжтай нэхэмжлэгч,харилцагч,гуравдагч этгээдийн нэгэн адил оролцож,хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийг ойлгоно.

6. Хуулийн 24.3 дахь заалтын "Шүүх энэ хуулийн 24.2-т заасан иргэнд хамаарагдах хэрэгт түүний эцэг,эх,харгалзан дэмжигчийг татан оролцуулах үүрэгтэй. Харин насанд хүрээгүй иргэнтэй холбоотой хэргийг Иргэний хуулийн 16.3-т заасан үндэслэлээр хянан шийдвэрлэхдээ түүний эцэг,эх,харгалзан дэмжигчийг оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ"гэдгийг зөвхөн хуульд заасан энэ тохиолдолд шүүх насанд хүрээгүй хүмүүсийн эцэг,эх,харгалзан дэмжигчийг шүүх хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэх, харин бусад бүх тохиолдолд тэдний эцэг,эх,харгалзан дэмжигчийг шүүх заавал татан оролцуулна гэж ойлгоно. Харин насанд хүрээгүй хүн нь хариуцагчаар оролцож байгаа бол тэрээр Иргэний хуулийн 503.5-д заасанаар тэдгээр нь өөрөө хариуцах бөгөөд ажил эрхэлж олсон цалин хөлс,орлого,түүнчлэн хууль ёсны төлөөлөгчөөс үзэмжээрээ захиран зарцуулах эрхэд нь байгаа эд хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Харин дээр дурьдсан цалин орлого,эд хөрөнгө нь хүрэлцэхгүй бол үлдэж байгаа хэсгийг нь хууль ёсны төлөөлөгчийг нь татан оролцуулж гаргуулна.

7. Хуулийн 31.1 дэх заалтын "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ... төрийн нэрийн өмнөөс оролцоно"гэснийг "төрийн байгууллагын хүсэлт"-эд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон тэдгээрээс эрх олгосон байгууллагаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлүүлж прокурорыг оролцуулах хүсэлтийг бичгээр гаргасныг хамаарууланолгоно.Прокурор төрийг төлөөлж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хуулийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчийн эрх,үүргийг хэрэгжүүлнэ.Энэ заалтын "прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх"үндэслэлд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар нь хүрээлэн байгаа орчныг хамгалах,байгалийн баялгийг зүй зохистой ашиглах,нөхөн сэргээх,төрийн өмчийн зүйлийг ээзэмших,ашиглах,захиран зарцуулах,төрөөс төлөх нөхөн төлбөр,олговор зэрэг асуудлаар Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, иргэний эрх зүйн харилцаанд оролцох явцад маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага,албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй,тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан,эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон,эрхийг

түүгэлзүүлсэн,зогсооосн зэрэг/байхыг ойлгоно.

8. Хуулийн 33.1 дэх заалтын "хууль ёсны төлөөлөгч"-ийн төлөөлөх эрх нь иргэний үнэмлэх,гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ,асран хамгаалах,харгалзан дэмжих бичгуудлагын шийдвэрээр, сайн дурын төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлээр,гэрээгээр төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгч төлөөлөгчийн хоронд хийгдсэн бичгийн гэрээгээр тодорхойлогдоно.Хууль ёсны төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн хуульд заасан бүх эрх,үүргийг,харин итгэмжлэлээр болон гэрээгээр төлөөлж буй этгээд нь итгэмжлэл ба гэрээнд заасан эрх,үүргийг хүлээнэ.

9. Хуулийн 38.1 дэх заалтын "Зохигч,түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч,гуравдагч этгээд өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа өөрийн талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх,цуглуулах үүрэгтэй"гэдгийг нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч,гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн шаардлагаа, хариуцагч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч,гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж байгаа үндэслэлээ нотолсон тайлбар гаргах, бичмэл ба д мөрийн баримт,кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, үл мөрнөөс буулгаж авсан зэ,хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд олдохий гэж үзэгдсэн үйл баримтын тухай шүүхийн шийдвэр, мэдээ ээрийг эрж олж,шүүхэд гаргаж өгөх, тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй бол шүүхэд хандаж гэрчийг байцаалгах, шинжээч томилуулан дүгнэлт гаргуулах,үзлэг,туршилт, ганьж олуулах ажилгаа хийлгэх хүсэлт гаргахыг ойлгоно.

10. Хуулийн 38.3 дахь заалтын "Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болно"гэдгийг зохигчийн аль нэг нь шүүхэд гаргавал зохих нотлох баримтаа гаргаж өгөөгүй тохиолдолд эсрэг тал нь уг нотлох баримтыг гаргуулах хүсэлт тавьбал, тухайн нотлох баримтыг шүүх албадан гаргуулж болно.Иймхүү албадан гаргуулахдаа үзлэг, туршилт, шинжилгээ хийлгэх зэрэг хуулийн 38.6-д заасан үйл ажиллагаа явуулж болно.

11. Хуулийн 38.5 дахь заалтын "Нотлох баримтыг гаргах,цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн"гэдэгт гэрчийг байцаахдаа хууль санкуулагуй,гарын үсгийг зуруулагуй болон гэрчийг байцаах эрхгүй этгээд байцаасан,гэрчээр өөрөөр нь тодорхойлолт бичүүлж авсан, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулахдаа хөндлөнгийн 2 гэрч,хэргийн оролцогчдыг оролцуулаагүй, тэмдэглэл хөтлөөгүй,тэд нараар гарын үсэг зуруулаагүй,бичмэл нотлох баримтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлээгүй,дүгнэлт гаргах эрхгүй /шүүхээс томилогдоогүй эсвэл тухайн төрлийн мэдлэгтэй/ этгээдээр дүгнэлт гаргуулсан, тэмдэглэл,"справка"зэрэг хууль заагаагүй хэлбэрийн баримт бичиг бүрдүүлсэн зэргийг хамааруулан ойлгоно.

12. Хуулийн 38.8 дахь заалтын "Шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал татгалзсан ч эсрэг тал нь түүнийг иш татах эрхтэй"гэдэгт зохигч өөрийн гаргасан болон хэргийн бусад оролцогчийн гаргасан нотлох баримтаас нэг тал татгалзсан тохиолдолд нөгөө тал нь уг нотлох баримтанд ач холбогдол өгч, түүнийг иш татан мэтгэлцэж болно гэж ойлгоно.

13. Хуулийн 40.3 дахь заалтын "Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй "гэдэг нь хэргийн оролцогчоос гаргасан нотлох баримтыг шүүгч урьдчилан үнэлэхгүй бөгөөд гагцхүү шүүх хуралдаан дээр нотлох баримтыг тал бүрээс нь хэргийн байдалтай бодитойгоор харьцуулан үзсэний үндэсэн дээр шүүгч дотоод итгэлээрээ үнэлнэ гэж ойлгоно.

14. Хуулийн 40.5 дахь заалтын "Анхан шатны шүүхэд гаргагдий нотлох баримтыг давж заалдах болон хяналтын журмаар гаргасан тохиолдолд шүүх түүнийг үнэлэхгүй "гэдэг нь хэргийн оролцогчоос хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бух нотлох баримтаа анхан шатны шүүх хуралдааны өмнө гаргах үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогч нь нотлох баримт бүрдүүлэх эрх,үүргийг нь шүүх тайлбарласаар байтал энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд давж заалдах болон хяналтын шатанд шинээр гаргасан нотлох баримт анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх,хүчингүй болгох үндэслэл болохгүй гэж ойлгож хэрэглэнэ. Харин шүүгч нь хуулийн 67.1.1дэх заалтын дагуу зохигч,тэдгээрийн төлөөлөгч,өмгөөлөгч ба гуравдагч этгээдэд шаардлага,татгалзалаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж,эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх,түүнчлэн тэдгээрээс хүсэлт гаргасан тохиолдолд шүүх нотлох баримтыг албадан гаргуулах ба хуулийн 38.6-д заасны дагуу нотлох баримтыг бүрдүүлэх үүрэгтэй.

15. Хуулийн 43.8.1 дэх заалтын "үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон

зохигчийн төлөөлөгч"гэдэг нь иргэний болон захиргааны хэрэгт зохигчыг төлөөлөн захиргааны байгууллага бa шүүх, Арбитрын байгууллагад төлөөлөгч буюу хуулийн эвлэгчөөр оролцож байсан хийгээд зохигчтой холбоотой эрх зүйн бусад маргаанд түүнийг төлөөлөн оролцож байсны улмаас хэргийн байдлыг мэдэх болсон этгээдийг хамаарууллан ойлгоно.

16. Хуулийн 47.10 дахь заалтын"хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал"гэдэг нь шинжээч дүгнэлт гаргах явцдаа шүүгчийн тавьсан асуултаас гадна хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдолтой зүйлийг шинжлэн тогтоосныг хэлнэ. Иймхүү олж тогтоосон зүйлээ шүүхээс асуулт тавиагүй байсан ч дүгнэлтдээ оруулах эрхтэй.

17. Хуулийн 48.2-т зааснаар "... Хөндлөнгийн гэрч тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэй" бөгөөд тийнхүү "санал гаргахаа"бичгийн хэлбэрээр илэрхийлэх бүюу үг тэмдэглэлд саналаа тусгуулж,түүнээ баталж гарын үсэг зурсан байна.

18. Хуулийн 49.1 дэх заалтын "... Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч,хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхийг хориглоно"гэдэгт хуулийн 26 дугаар зүйлд заасан хэргийн зохигч бa гуравдагч этгээд тэдгээрийн өмгөөлөгч,төлөөлөгч,мөн хуулийн 85 дугаар зүйлд тодорхойлсон хэргийн оролцогч, шинжээч, гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгчийг хамаарууллан ойлгоно.

19. Хуулийн 50.1 дэх заалтын "зайлшгүй шаардлагатай нотлох баримт"гэдэгт шүүх хэргийг хянан хэлэлцэж,нотлох гүнзгий тогтоон шийдэр гаргахад нөлөөлөх бүх төрлийн нотлох баримтууд хамаарна.

20. Хуулийн 76.1.1 дэх заалтын "хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн"гэдгийг шүүгч хэргийн бодит байдлыг тогтооход зохих хэлбэрт орсон,ач холбогдол бүхий нотлох баримт хангалттай цугларсан гэж үзэж хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргасныг; "энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан"гэдгийг зохигчид өөрсдөө нотлох баримтаа гаргаж өгөх, цуглуулах үүргээ биелүүлсэн эсэх буюу шүүхэд нотлох баримт нотлох баримт бүрдүүлэх хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран 60 хоногийн хугацаа өнгөрснийг;"шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд"гэдгийг зохигчид хүсэлт гаргаагүй, хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн хугацаа өнгөрөөгүй ч шүүх тухайн хэргийг хэлэлцэн шийдвэрлэхэд зохих хэлбэрт орсон,ач холбогдол бүхий нотлох баримтуудыг хангалттай цугларсан гэж шүүх үзсэнийг тус тус ойлгоно.

21. Хуулийн 78.4 дэх заалтын "Ерөнхий шүүгч бусад шүүчтэй адил ... хуваарийн дагуу хэрэг-хянан шийдвэрлэнэ"гэдэг нь тухайн шүүхэд хэрэг-хувиварилах,хянан шийдвэрлэх шүүгчдийн эвлэлгөөнөөс тогтоосон журмыг бусад шүүгчидийн адил хэрэгжүүлэх бөгөөд Ерөнхий шүүгчийн хувьд тусгайлсан хөнгөлөлт,давуу эрх эдлэхгүй гэж ойлгоно.

22. Хуулийн 80.1.5 дахь заалтын "зохигч-хүнд өвчний учир эмчлүүлж байгаа" гэдэг нь зохигч-өвчний учир эмнэлэг хэвтэж эмчлүүлж байгаа болон гэрийн нөхцөлд хэвтрийн дэглэмд эмчилгээ-сувилгаа хийлгэж байхыг хэлэх бөгөөд энэ нь эмнэлгийн болон эмчийн дүгнэлт магадлагаагаар тогтоогдсон байвал зохино.

23. Хуулийн 91.1.2 дахь заалтын "уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн төрөл, садан" гэдэгт, шүүгч нь зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн бусдын эрх, эрх чөлөө,ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлсэн эрх бүхий иргэн,хуулийн этгээдийн төлөөлөгчийн аль нэгний эхнэр,нөхөр,тэдэнтэй хамтын амьдралтай гэр бүлийн гишүүн буюу нэг гэр бүлд амьдардаггүй гэр бүлийн гишүүн бус эцэг,эх,өвөг эцэг,эмэг эх,төрсөн дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач, зээ гуа-жич, төрсөн ах,эгч,дүү,авга,нагац,тэдгээрийн хүүхэд хайхыг;"... шүүх бүрэлдэхүүнд хооронд-оо төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон..."гэдэг-тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн дэх шүүгч хоорондоо дээр дурьдсан төрөл садангийн холбоотой байхыг тус тус ойлгоно.

24. Хуулийн 161.3 дахь заалтын "... хэргийг бүхэлд нь хянана"гэдэг нь зохигч талын нэг нь давж заалдсан,мэтгэлцэх байгаа нөгөө тал нь хянаалтын журмаар гомдол гаргасан тохиолдолд давж заалдах журмаар хянан шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ уг хэргийн нотлох баримт хийгээд үйл баримт,түүнд үнэлэлт дүгнэлт өгсөн байдал,шүүхийн шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүхэлд нь хянан шийдвэрлэхийг хэлнэ.Түүнчлэн хуулийн 166.4-т зааснаар давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх гомдолд дурьдсан үндэслэлээр хязгаарлахгүйгээр шүүхийн шийдвэр үндэслэлттэй гарсан эсэх талаар хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

25. Хуулийн 161.5 дахь заалтын "шинэ нотлох баримт"гэдэгт хэргийг анхан шатны шүүхээ

хянан хэлэлцэхэд зохигчид мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан,шүүхэд гаргах ба мэдүүлэх боломлоотой байсан боловч хуулийн 38.1 дэх хэсэгт заасан нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх,цуглуулах үүргээ гүйцэтгээгүйн улмаас анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа дээд шүүхэд нөхөн ирүүлсэн нотлох баримтыг ойлгоно.

26. Хуулийн 163.1 дэх заалтын "Давж заалдах гомдлыг ... хүлээн авч,зохигч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ гомдлын өргөдлийг хүлээн авсан шүүгч буюу нарийн бичгийн дарга гомдол гаргах, бичих эрх бүхий этгээд гаргасан буюу бичсэн эсэх,улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх,хуульд заасан давж заалдах хугацаанд гарсан эсэхийг нарийн шалган хүлээн авч зохигчид буюу тэдний төлөөлөгч,өмгөөлөгчид заавал танилцуулж, үүнийгээ баталгаажуулан гарын үсэг зурууллан байвал зохино. Харин зохигчид буюу тэдний төлөөлөгч, өмгөөлөгч хариу тайлбар гаргах эсэх нь тэдний эрх үүнд заавал тайлбар гаргуулахаар шаардахгүй. Харин ийм эрхтэй болохыг тайлбарлаж өгнө. Мөн зүйл, хэсгийн "...шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулна" гэдгийг давж заалдах гомдол нь шүүхийн шийдвэрт заасан гуравдагч этгээдийн эрх, үүргийг хөндсөн тохиолдолд түүнийг гуравдагч этгээдэд зохигчийн нэгэн адил танилцуулж, өөрийн тайлбарыг гаргах эрхтэйг тайлбарлахыг ойлгоно.

27. Хуулийн 165.1 дэх заалтын "...давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохыг бичгээр хүсвэл..."гэдэгт давж заалдах шатны хуралдаанд биечлэн оролцох хүсэлтэй хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх буюу давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол, өргөдөл, захидал, албан бичиг, утас, цахилгаан, телекс, телефаксаар болон биечлэн ирж мэдэгдсэн байхын аль аль нь хамаарна. Энэ нөхцөлд давж заалдах шатны шүүх, шүүх хуралдаан хэзээ, хаана, болохыг энэ хуульд заасан жүрмын дагуу хүсэлт гаргагчид заавал мэдэгдэнэ.

28. Хуулийн 168.1.2 дахь заалтын "зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалтгүй хэргийг хянан шийдвэрлэсэн" гэдэгт шүүх хуралдаан хэзээ, хаана, болохыг тэдэнд хуульд заасан жүрмыг дагуу мэдэгдээгүй, мэдэгдсэн ч хүрэлцэн ирэх боломжтой хугацаанд хэргалзахгүй,шүүх хуралдаанд ирээгүй нь хүндэтгэн үзэх /өвчлөх, хорио цээрийн дэглэмд орох гэх мэт/ шалтгаантайг мэдэгдсээр байхад шүүх хуралдааныг хойшлуулах асуудлыг авч хэлэлцээгүй зэрэг тохиолдол хамаарна.

29. Хуулийн 168.1.4 дэх заалтын "хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн" гэдэгт шүүгч оролцож болохгүй, дахин ороолцох болохгүй тухай хуулийн заалтыг зөрчсөн, хуульд заасан хамтын зарчмаар шийдвэрлэх хэргийг шүүгч дангаараа хянан хэлэлцсэн буюу бүрэн бус бүрэлдэхүүнээр,эсхүл шүүн таслах эрх олгогдоогүй буюу эрх нь дуусгавар болсон,шүүн таслах эрхийг түдгэлзүүлсэн хүнийг шүүгчээр оролцуулан хэлэлцсэнийг ойлгоно. Түүнчлэн хууль зөрчиж шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарын аль нэгийг татгалзан гаргах хуульд заасан үндэслэл байхад тэд татгалзан гараагүй, татгалзан гаргах хүсэлт гарсан боловч хууль бусаар хүлээн аваагүй бол хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэсэнтэй адилтгаж үзнэ.

30. Хуулийн 168.1.5 дахь заалтын "шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй,эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан"гэдэг нь шүүхийн шийдвэр /тогтоол/-т хэрэг шийдвэрлэхэд оролцсон шүүх бүрэлдэхүүн бүгд гарын үсэг зурах бөгөөд түүнд шүүх бүрэлдэхүүн бүхэлдээ буюу аль нэг шүүгч нь гарын үсэг зураагүй,шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан,түүнчлэн шүүх бүрэлдэхүүнд оролцсон шүүгчийн гарын үсгийг өөр шүүгч орлож зурсан байхыг хэлнэ. Шүүх бүрэлдэхүүний гарын үсэг шийдвэрийн албан ёсны эх хувьд зурагдана.Энэ журам давж заалдах жүрмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлалд нэгэн адил хамаарна.

31. Хуулийн 168.1.6 дахь заалтын "хуурамч нотлох баримт"-д анхан шатны шүүхээр хэргийг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлсэн,хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг баталсан буюу үгүйсгэсэн нотлох баримт хуурамч болох нь тогтоогдсон, өөрөөр хэлбэл худал гэрчилсэн, шинжээч худал дүгнэлт гаргасан, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, эд мөрийн баримтыг сольсон, хүний, гэмтэсэн,худал орчуулсан зэргийг хамаруулан ойлгоно.

32. Хуулийн 171.1 дэх хэсгийн"...магадлал гаргана"гэснийг хэргийг анхан шатны жүрмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийн 170.1–д заасан зүйлүүдэд зааснаар шүүхийн тогтоол,шүүгчийн захирамж,шийтгэврийн талаар гаргасан гомдлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүх хянан хэлэлцээд 171.1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргахдаа хуулийн 170.2 дахь хэсэгт заасны дагуу"тогтоол гаргана"гэж

ойлгож хэрэглэнэ.

33. Хуулийн 173.1 дэх заалтын"Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авна" гэснийг хэрэгжүүлэхдээ хэргийг хянуулах тухай гомдол өргөдлийг эвэхэн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүхэд өгөх бөгөөд Дээд шүүх болон бусад байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан тохиолдолд хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлэхээр өргөдлийг буцаах буюу анхан шатны шүүхэд нь хүргүүлнэ гэж ойлгож хэрэглэнэ. Гомдлыг хүлээн авсан шүүгч буюу нарийн бичгийн дарга зохигч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид танилцуулж, тайлбар гаргах эсэхийг тодруулж гарын үсэг зуруулах ба улсын төмдэгтийн хураамж төлүүлнэ.

Харин энэ заалтыг "хяналтын журмаар гаргасан гомдол" гэдэгт хуулийн 172.1-д заасан гомдол гаргах эрх бүхий буюу тухайн хэргийн зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гуравдагч этгээдээс гаргасан гомдлыг хамаарууллна.

34. Хуулийн 176.6 дахь заалтын дагуу "Танхимын шүүх хуралдааны тогтоолд гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч хэргийн хамт Улсын Дээд шүүхэд ирүүлэх"-дээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 163.1 ба 173.2 дахь заалтын дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, бусад өмгөөлөгч, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулан, тэдгээрээс хүсэвэл зохих тайлбарыг авч хавсаргана. Харин улсын төмдэгтийн хураамж авахгүй.

35. Хуулийн 179.1.1 дэх заалтын "шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл" гэдгийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх үед зохигч, гуравдагч этгээд буюу тэдний төлөөлөгчид, өмгөөлөгчид мэдээгүй, мэдэх боломжгүй байсны улмаас шүүхэд гаргаж өгөөгүй, түүнийг бүрдүүлэх талаар хүсэлт тавиагүйн улмаас шүүх хуульд заасны дагуу гаргуулж авааагүйгээс шалтгаалан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд мэдэгдээгүй бөгөөд мэдэгдэх боломжгүй байсан, тухайн хэргийн хувьд шинэ нөхцөл байдал тогтоосон нотлох баримт шүүхийн шийдвэр гарсны дараа илэрч мэдэгдсэнийг ойлгоно. Энэ нотлох баримт нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой, анхан шатны журмаар зайлшгүй дахин хянан хэлэлцэхэд хүргэхээр шинжтэй байна.

Харин хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь тэр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой, өөр улс, орон нутагт байгаа учир зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй байсны улмаас болон туршилт, үзлэг, шинжилгээ хийлгэх, гэрчийг байцаалгах зэрэг зохигчийн хүсэлтээр шүүх бүрдүүлбэл зохих үүргээ биелүүлээгүйгээс шүүхийн шийдвэр гарсны дараа уг нотлох баримтыг гаргаж ирүүлсэн, шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, хууль бруу хэрэглэсэн нь шинэвр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл болохгүй бөгөөд түүнийг давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэж болно.

36. Хуулийн 179.1.2 дахь заалтын "шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон нотлох баримт хуурамч . . ." гэдэгт шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт хуурамч байсан, орчуулга худал ташаа байсан, эд мерийн баримт болон бичгийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн болох нь зохих журмын дагуу шалгагдан тогтоогдож гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийтгэх тогтоол гарч хүчин төгөлдөр болсон байхыг; мөн энэ заалтын ". . . шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн үг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогоолоор тогтоогдсон" гэдэг нь шүүгч, зохигч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч шинжээч, орчуулагч, хэргийн бусад оролцогчын тухайн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/ хууль бус байсны улмаас хууль бус буюу үндэслэлгүй шийдвэр гаргасан нь тогтоогдож, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсныг тус тус хамаарууллан ойлгоно. Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, өршөөл үзүүлсэн зэргээс гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй болсон бол тэдний гэм буруутай үйлдлийг мөрдөн байцаалтаар тогтоосноор шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэж болно.

37. Хуулийн 179.1.3 дахь заалтын "шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл тэр, зарлигааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон" гэдэгт шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, захирамж, шийтгэвэр, төр, захиргаа болон бусад байгууллагын тогтоол, захирамж, тушаал зэрэг шийдвэр эвэхэн хууль бус байсны улмаас түүнийг хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан зохих журмын дагуу хүчингүй болгосон байхыг ойлгоно.

38. Хуулийн 181.1 дэх заалтын "Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт"-эд шүүхийн нэр, хүсэлт гаргагчийн нэр, хаяг, шийдвэрийг нь хянуулах шүүхийн нэр, шүүхийн шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, шинээр илэрсэн нөхцөл байдлыг нотолсон нотлох баримтуудыг хавсаргасан буюу тэдгээрийн байгаа газар, илэрсэн хугацаг заасан байвал зохино.

39. Хуулийн 195.2 дахь заалтын "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааанд байгаа хэргийг тухайн шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд энэ хуулийг буцаан хэрэглэхгүй" гэсэн заалтыг дараах байдлаар ойлгож хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл анхан шатны шүүхэд хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны хуулийг хэрэглэнэ.

б/ 2002 оын 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд аймаг, нийслэлийн шүүх хүлээн авсан давж заалдах гомдолтой иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны хуулийг хэрэглэнэ.

в/ аймаг, нийслэлийн шүүх 2002 оны 9 дүгээр сарын 1-ээс өмнө хяналтын журмаар хүлээн авсан өргөдөл, эсэргүүцэлтэй иргэний хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны хуулийг шийдвэрлэж дуусгана.

г/ 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө шийдвэр, магадлал нь хүчин төгөлдөр болсон Дээд шүүхийн хяналтын шатанд анх удаа гомдол гаргаж ирүүлсэн иргэний хэргийг танхимын хуралдаанаар хянан хэлэлцэж тогтоол гаргана. Энэ тохиолдолд гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч, улсын тэмдэгтийн хураамж төлүүлж хуулийн 173.2-т заасан журмын дагуу Улсын Дээд шүүхэд ирүүлнэ. Харин энэ гомдолд хуулийн 120.2 дахь хэсэгт заасан 30 хоногийн хугацаа хамаарахгүй.

д/ Мөн хугацааны өмнө шийдвэр, магадлал нь хүчинтөгөлдөр болсон, Дээд шүүхийн хяналтын шатанд урьд өмнө нь гомдол гаргаж хянагдсан хэргийн талаар дахиж гомдол гарвал Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч танилцаж шийдвэрлэнэ. Уг хэргийг хянахдаа хууль зөрчсөн гэж үзвэл Ерөнхий шүүгч дүгнэлт бичиж Улсын Дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ. Энэ тохиолдолд гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч, зохигчид мэдэгдэн хэргийг Улсын Дээд шүүхэд хүргүүлэх боловч улсын тэмдэгтийн хураамж төлүүлэхгүй. Энэ талаар гарсан гомдолд Хуулийн 120.2 ба 176.3 дахь заалтын 30 хоногийн хугацаа хамаарахгүй.

40. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн дараахь тогтоолыг хүчингүй болсонд тооцож 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш үүссэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаанд үйлчлэхгүй байхаар тогтоосугай. Үүнд:

1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн анхан шатны шүүхийн үйл ажиллагаат зохицуулсан зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай 1995 оны 3 дугаар сарын 17-ний өдрийн 80 дугаар тогтоол,

2/ Давж заалтах болон хяналтын журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай 1995 оын 3 дугаар сарын 29-ний өдрийн 95 дугаар тогтоолын 9-өөс бусад заалт,

3/ Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" 1998 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 318 дугаар тогтоолын 13 дахь заалтаас бусад заалт.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **Ч. ГАНБАТ**

ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ **Р. ЖАМЪЯНЧОЙЖИЛ**

ШҮҮГЧ **А. ДОРЖГОТОВ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 8 ☎ 39487